



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ ХVI БОТЬ

(2023 онд хийж гүйцэтгэсэн судалгаа)

Улаанбаатар хот
2024 он

ННА 67.400.1

ДАА 342

Ү-223

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛСЫН ХАРАА

*Олон улсын жишигт нийцсэн эрдэм, шинжилгээ, сургалт мэдээллийн
үндэсний хүрээлэн болон хөгжинө.*

© Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Зохиогч болон нийтлэгчийн зөвшөөрөлгүйгээр тус номын агуулгыг хэсэгчлэн болон бүтнээр хэвлэх, электрон аливаа хэлбэрээр хувилах, бичлэг хийх, хайлтын системд оруулах, хэвлэн олшруулахыг хориглоно. Хууль зүйн үндэсний хүрээлэн.

Хянан тохиолдуулсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.) Х.Эрдэм-Ундрах

Эмхэтгэсэн: Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын
эрхлэгч Б.Энх-Амгалан
Эрдэм шинжилгээний ажилтан М.Ганди

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч,
дизайнер Б.Заяа

Хавтасны гэрэл зураг: Х.Буянбат

Цаасны хэмжээ: 176/250

Хэвлэлийн хуудас: 33 х.х

“Тоонот принт” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-9142-2-6

ӨМНӨХ ҮГ



Эрхэм хүндэт уншигч та бүхний амар амгаланг айлтган мэндчилье. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд заасан эрх зүйн салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх зорилтын хүрээнд бид 2023 онд хийж гүйцэтгэсэн судалгааны тайланг эмхэтгэн “Үндсэн хуулийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XVI боть)”, “Эрүүгийн эрх зүй болон Зөрчлийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XVII боть)”, “Хувийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XVIII боть)” хэмээх гурван ботиор уншигч Танаа толилуулж байна.

Үндсэн хуулийн эрх зүйд холбогдох судалгааны тайланг эмхэтгэсэн энэхүү XVI боть нь төрийн нэрийн хуудас болсон Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль болон Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэрэгцээнд зориулсан судалгаанууд багтсанаараа онцлог бөгөөд ач холбогдолтой.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн, Улсын Их Хурлын 2022 оны 34, 54 дүгээр тогтоол, “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжийг баримтлан сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, УИХ-ын гишүүдийн тоог нэмэх, Цэцийн хяналт, Цэцэд хүсэлт гаргах субъект, Цэцийн гишүүний томилгоог тусгах, хөдөөгийн сэргэлтийг дэмжих, нийслэлийн төвлөрлийг сааруулах болон эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангах чиглэлээр Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл боловсруулахтай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу, Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалуудыг ашиглан “Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа”, “Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үр нөлөөний үнэлгээ” -г тус тус хийж гүйцэтгэсэн.

Тухайлбал, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлага болон төслийн үр нөлөөг судалж, сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуулиар баталгаажуулснаар мажоритар тогтолцооны хүрээнд үүсэж буй сонгогчдын санал гээгдэх асуудлыг бууруулах, улс төрийн цөөнхийн төлөөллийг парламентад оруулснаар улс төрийн олон ургалч үзлийг төлөвшүүлэх, гишүүдийн тойргийн ашиг сонирхлоос илүүтэйгээр улс орны эрх ашгийг чухалчлах үзлийг бий болгох боломж нээгдэнэ; УИХ-ын гишүүний тоог нэмснээр тэдний эрх мэдэл болон ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хууль тогтоох явц дахь эрх мэдлийн харилцан хяналтыг сайжруулснаар ардчиллын төлөөллийн зарчимд нийцнэ гэж дүгнэсэн. Харин УИХ-ын гишүүний зохист тоо хэмжээг “Куб язгуурын зарчим”-д тулгуурлан тогтоохдоо нийт хүн амын тооноос бус, сонгуулийн насны нийт иргэдийн тоонд тулгуурлан

тогтоох нь төлөөллийн зарчмын хувьд хүлээн зөвшөөрөгдөнө гэсэн зөвлөмж дэвшүүлсэн байна.

Мөн “Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл ба Монгол Улсын олон улсын гэрээний нийцэл” сэдвээр харьцуулсан судалгаа хийсэн бөгөөд энэ нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн зөрчил үүсэхээс сэргийлж, дотоодын ба олон улсын эрх зүйн уялдаа холбоог шинжлэн дүгнэж, судалгаагаар дэмжлэг үзүүлсэн бүтээлч хандлага юм.

Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль болон Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэрэгцээнд зориулж “Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, “Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн үр нөлөөний үнэлгээ”, “Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, “Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” сэдвээр тус тус судалгаа гүйцэтгэсэн.

Цэцийн гишүүний томилгоо, Цэцийн гишүүнд тавигдах шаардлага, Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх, Цэцийн дарга, түүний эрх хэмжээ, Цэцийн үйл ажиллагааны нөхцөл, Цэцийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлдэг ажлын албаны эрх зүйн байдал, Цэцийн эдийн засгийн баталгаа, тэр дундаа ажлын албаны алба хаагчид, Цэцийн гишүүдийн цалин хангамж, нийгмийн баталгаа гэсэн асуудлын хүрээнд эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг судалж, үр дагаврыг үнэлсэн бөгөөд боловсронгуй болгох хувилбар дэвшүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй хэмээн үзсэн.

Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн үр нөлөөг судалж, Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журам, Цэцийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт, маргааны хуваарилалт, Цэцийн гишүүний хариуцлага, Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгаа, Цэцийн үйл ажиллагааны баталгаа, Цэцийн төсөв санхүүгийн бие даасан байдалд хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь зорилгод нийцэж буй эсэх, мөн хуулийн төслийн маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх дүгнэлт гаргаж, дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргах үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх тухай, Цэцийн гишүүнд тавих болзол шаардлагын тухай, Цэцийн гишүүнийг зөвхөн нэг удаа томилох тухай, Цэцийн даргын бүрэн эрх, Цэцийн тамгын газар, Тамгын газрын даргын бүрэн эрх болон Цэцийн чадавхыг сайжруулах, нөлөөллийн мэдүүлэгтэй холбогдолтой эрх зүйн хэм хэмжээ практикт хэрэгжих боломжтой эсэх, түүнчлэн хуулийн төсөл бүхэлдээ ойлгомжтой эсэх, харилцан уялдаатай эсэхэд дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөхийн зэрэгцээ, хуулийн төслийг сайжруулахад чиглэсэн зөвлөмж дэвшүүлсэн.

Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгаагаар, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ, Цэцэд хандах арга, хэлбэр, Цэцэд маргаан үүсгэх ажиллагаа, маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн, хэргийн харьяалал тогтоох Цэцийн оролцооны асуудлыг хөндөж, дүгнэлт хийсэн.


Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль одоогоос 26 жилийн өмнө батлагдсанаас хойш дорвитой шинэчлэгдээгүй учир хэт ерөнхий зохицуулалттай, Цэцэд хандах эрх, арга, хэлбэр хязгаарлагдмал, тодорхой бус, өргөдөл, мэдээлэл, хүсэлт хүлээн авах болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр гаргах оролцоог оновчтой, нарийвчилж журамлаагүй зэрэг дутагдлын улмаас тус хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсч, улмаар хүний эрх хамгааллын үндэсний механизмд сөрөг нөлөө үзүүлж байгааг тодруулж, цаашид эрх зүйн орчинг боловсронгуй болгох хувилбар бүхий дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулсан.

Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үр нөлөөг судалж, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль болон бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн туршлага, олон улсын жишиг, Үндсэн хуулийн эрх зүйн судлаачдын бүтээлтэй харьцуулж дүн шинжилгээ хийсэн. Тухайлбал, Цэцэд хандах хэлбэр, маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт, хуралдааны хэлбэртэй холбоотой зохицуулалтууд нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн эсэх, маргаан шийдвэрлэх хугацаа, маргаан хянан шийдвэрлэх зардал, Цэцэд хандах хугацаа, өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах зохицуулалт нь практикт нийцсэн эсэх, Хуулийн төсөлд тусгагдсан нэр томъёонууд ойлгомжтой эсэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавигдах шаардлага, маргааны оролцогчийн эрх зүйн байдал, өргөдөл, мэдээлэл, хүсэлт, маргааныг хуваарилах болон холбогдох бусад журам, Цэцийн даалгаврыг биелүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, Цэцийн шийдвэр гаргах, түүнийг мэдээлэх, тусгай журамтай холбоотой зохицуулалт нь шинээр орж ирж буй зохицуулалт учраас хүлээн зөвшөөрөгдөх эсэх, хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэхийг нягталж үнэлгээ хийснээс гадна төслийг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж дэвшүүлсэн.

Уг ботид эмхэтгэсэн бидний судалгаа нь Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, түүний дотор Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлагыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зохих хувь нэмэр оруулахаас гадна цаашдын судалгаа, шинжилгээний ажилд ашиглах эх сурвалж болно гэдэгт итгэж байна.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай

ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ

ГАРЧИГ

Өмнөх үг	III
Товчилсон үгийн жагсаалт	VII
Хүснэгтийн жагсаалт	VIII
Графикийн жагсаалт	XI
Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа	1
Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үр нөлөөний үнэлгээ	59
Гурав. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл ба Монгол Улсын олон улсын гэрээний нийцэл	109
Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	121
Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ	161
Зургаа. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	203
Долоо. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн үр нөлөөний үнэлгээ	235
Хавсралт 1: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл	313
Хавсралт 2: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төсөл	314
Хавсралт 3: Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл	329

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЭсУ	Бүгд Найрамдах Эстони Улс
Венецийн комисс	Хуулиар Ардчилал тогтоох Европын комисс
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИТБАТГӨГШТХ	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МУҮндХ	Монгол Улсын Үндсэн хууль
МУҮХЦтХ	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
ОХУ	Оросын Холбооны Улс
УИХ	Улсын Их Хурал
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ҮХЦтХ	Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
ҮХЦМХШтХ	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль
ҮХЦМХШАтХ	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
Цэц	Үндсэн хуулийн шүүх; Үндсэн хуулийн цэц

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 МУ-ын Үндсэн хуулийн цэцийн хяналтад хамаарах шийдвэр	6
Хүснэгт 1.2. МУ-ын намын бүртгэл.	17
Хүснэгт 1.3. Сонгуулийн тогтолцооны эерэг ба сөрөг тал	20
Хүснэгт 1.4. УИХ-ийн 11 байнгын хороодын хуваарилалт	23
Хүснэгт 1.5. УИХ-ын гишүүдийн байнгын хороонд ажиллах давхцал	24
Хүснэгт 1.6. Хуульд заасны дагуу батлуулсан МУ-ын Засгийн газрын бүрэлдэхүүн	25
Хүснэгт 1.7. БНСУ-ын сонгогчдын жагсаалтад бүртгэгдсэн иргэдийн тоо.	34
Хүснэгт 1.8. Сэжон хот байгуулагдсанаас хойших өөрчлөлт	36
Хүснэгт 1.9. Өмнөх хэсгүүдэд тодорхойлсон зохицуулалтын хувилбарууд	44
Хүснэгт 1.10. Хүний эрхэд үзүүлэх нөлөө	44
Хүснэгт 1.11. Эдийн засагт үзүүлэх нөлөө	46
Хүснэгт 1.12. Нийгэмд үзүүлэх нөлөө.	49
Хүснэгт 1.13. Байгаль орчинд үзүүлэх нөлөө	51
Хүснэгт 2.1. Үр нөлөөг үнэлэх шалгуур	63
Хүснэгт 2.2. Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэн батлах явц дахь улсын нийслэлийг тодорхойлж байсан хувилбарууд.	77
Хүснэгт 2.3. БНСУ-ын Сэжон хот байгуулагдсанаас хойших өөрчлөлт	80
Хүснэгт 2.4. Хүний Эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэг	87
Хүснэгт 2.5. “Харилцан уялдаа” шалгуурыг Өөрчлөлтийн төслийн хүрээнд нэгтгэн үнэлсэн нь	93
Хүснэгт 2.6. Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлтөд өгсөн судлаач, иргэдийн санал	97
Хүснэгт 2.7. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлтөд өгсөн иргэдийн санал	98
Хүснэгт 2.8. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлтөд өгсөн иргэдийн санал.	99
Хүснэгт 2.9. Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн өөрчлөлтөд өгсөн санал	100
Хүснэгт 4.1. Шалгуур үзүүлэлтийн томьёо	127
Хүснэгт 4.2. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа зохицуулсан байдал	142
Хүснэгт 4.3. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн шүүхийн дарга	147
/ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, томилох	147
Хүснэгт 4.4. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн шүүхийн ажлын алба	149
Хүснэгт 4.5. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн шүүхийн төсөв, санхүү	154
Хүснэгт 5.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт	165

Хүснэгт 5.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт	166
Хүснэгт 5.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт	166
Хүснэгт 5.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл заалт	167
Хүснэгт 5.5. Шалгуур үзүүлэлт ба тохирох шалгах хэрэгсэл	168
Хүснэгт 5.6. Үр нөлөөг үнэлэх хэсэг	168
Хүснэгт 5.7. Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн тухайд	169
Хүснэгт 5.8. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн тухай	172
Хүснэгт 5.9. Хэрэг хуваарилалт	175
Хүснэгт 5.10. Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн тухайд	176
Хүснэгт 5.11. Хуулийн төслийн 14,16 дугаар зүйлийн тухайд	177
Хүснэгт 5.12. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн тухай	179
Хүснэгт 5.13. МУ-ын ҮХЦ-ийн бүрэн эрхийн баталгаа	180
Хүснэгт 5.14. Хуулийн төслийн 20,21 дүгээр зүйлийн тухай	182
Хүснэгт 5.15. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн тухайд	184
Хүснэгт 5.16. Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн тухай	188
Хүснэгт 5.17. Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн тухай	190
Хүснэгт 5.18. Хуулийн төслийн 11,12 дугаар зүйлийн тухай	192
Хүснэгт 5.19. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн тухай	194
Хүснэгт 5.20. Мэдүүлэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулалт	194
Хүснэгт 6.1. Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	210
Хүснэгт 6.2. Шалгуур үзүүлэлтийн томъёолол	215
Хүснэгт 6.3. Маргаан хянан шийдэрлэх Цэцийн бүрэлдэхүүн	225
Хүснэгт 7.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт	240
Хүснэгт 7.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт	241
Хүснэгт 7.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт	241
Хүснэгт 7.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт	241
Хүснэгт 7.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт	242
Хүснэгт 7.6. Шалгуур үзүүлэлт ба тохирох шалгах хэрэгсэл	243
Хүснэгт 7.7. Тохирох шалгах хэрэгсэл	243
Хүснэгт 7.8. МУ-ын ҮХЦМХША-ны 30 жилийн тоон үзүүлэлт	253
Хүснэгт 7.9. 2023 оны ҮХЦМХШтХ болон 1997 оны ҮХЦМХШАтХ харьцуулалт	259
Хүснэгт 7.10. 2023 оны ҮХЦМХШтХ болон 1997 оны ҮХЦМХШАтХ-ийн ялгаа	268
Хүснэгт 7.11. 2023 оны ҮХЦМХШтХ-ийн төсөл болон 1997 оны ҮХЦМХШАтХ-ийн өөрчлөлт	269
Хүснэгт 7.12. 2023 оны ҮХЦМХШтХ-ийн төслийн 17 дугаар зүйл	273

Хүснэгт 7.13. Өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлтийн тодорхойлолт	279
Хүснэгт 7.14. Маргаан шийдвэрлэх хүрээтэй холбоотой зохицуулалтын өөрчлөлт	282
Хүснэгт 7.15. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага.	303

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 7.1. МУ-ын ҮХЦМХША-ны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/ . . .	254
График 7.2. Цэцэд хандсан тохиолдлын тоо /1992-2021 он/	256
График 7.3. МУ-ын ҮХЦ-д “хүсэлт” ирсэн 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/	258

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАЛААРХ ТАНДАН СУДАЛГАА

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
Г.Давааням	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Хууль зүйн ухааны доктор (LL.D.)

Судалгааны багийн бусад гишүүд:

Б.Түмэндэмбэрэл	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ажилтан
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
Э.Сэлэнгэ	Эрдэм шинжилгээний ажилтан
С.Мягмарсүрэн	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.04.25.

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
I. ҮНДСЭН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТАНДАН СУДЛАХ НЬ	4
1.1. Үндсэн хуулийн цэцийн хяналттай холбогдох зүйл, заалтын хүрээнд	4
1.2. Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангах хүрээнд	14
1.3. Сонгуулийн тогтолцоо болон парламентын төлөөллийг сайжруулах хүрээнд /21.1./	18
1.4. Хөдөөгийн сэргэлтийг дэмжих, хэт төвлөрлийг сааруулж, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах хүрээнд /13.1./	27
II. ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	30
2.1. БНСУ	30
2.2. ХБНГУ	36
III. ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ	44
3.1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө	44
3.2. Эдийн засагт үзүүлэх нөлөө	46
3.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	49
3.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	51
IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	54
НОМ ЗҮЙ	56

УДИРТГАЛ

Энэхүү судалгаагаар Монгол Улсын Үндсэн хуулийн зарим зүйл, заалтад өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлахыг зорилоо. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг эрх зүй, бодлогын хэмжээнд хангах, хүний үндсэн эрхийн хамгаалалт, түүний бодитой хэрэгжилтийг хангах үүрэг төрд бий. Энэхүү үүргээ төрөөс биелүүлэх үүднээс дараах бодлогын баримт бичгийг боловсруулсан байна.

Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)-ын 2022 оны 34 дүгээр тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтийн саналыг судлах ажлын хүрээг тогтоож үүндээ хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн хамгаалалтыг бэхжүүлэх, парламентын ард түмнийг төлөөлөх чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлэх, дэмжих зэрэг асуудлыг багтаасан байдаг.

Мөн “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” УИХ-ын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт-тэнцлийг хангах хүрээнд төрийн эрх барих дээд байгууллагад ард түмнийг төлөөлөх УИХ-ын гишүүний тоог шинэчлэн тодорхойлох, УИХ-ын сонгуулийн дэвшилтэд тогтолцооны зарчмыг Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхийг Засгийн газар (цаашид “ЗГ” гэх)-т даалгажээ.

УИХ-аас 2023 оны 1, 2 дугаар сард зохион байгуулсан “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын дүнг үндэслэн гаргасан Зөвлөмжид иргэдийг төлөөлөх парламентын чадварыг нэмэгдүүлж, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх талаар УИХ-ын сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх асуудлыг тус тус дэмжсэн дүн гарчээ.

Гэсэн хэдий ч эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилт бодит байдал дээр сул байгаа нь эрх зүйн орчин дутмаг байгаатай холбоотой. Иймд дээрх асуудлын хүрээнд Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тандан судалж, ХБНГУ, БНСУ-ын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд харьцуулан судаллаа. Үүнд:

1. Хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн хамгаалалтыг бэхжүүлэх асуудал;
2. Улс төрийн нам байгуулахад тавигдах шаардлага;
3. Сонгуулийн тогтолцоо болон парламентын гишүүдийн тоог нэмэхтэй холбоотой асуудал;
4. Хөдөө, орон нутгийн сэргэлтийг дэмжих, төвлөрлийг бууруулах асуудлын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасныг үндэслэн ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлал”-ын дагуу энэхүү судалгааг гүйцэтгэв.

I. ҮНДСЭН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТАНДАН СУДЛАХ НЬ

1.1. Үндсэн хуулийн цэцийн хяналттай холбогдох зүйл, заалтын хүрээнд

Үндсэн хуулийн цэц (цаашид Цэц гэх) нь Үндсэн хуулийн биелэлтэд хууль-шүүхийн дээд хяналт тавьж, түүнийг зөрчсөн тухай маргааныг хянаад хууль хэрэглэж эцэслэн шийдвэр гаргадаг Үндсэн хуульд заасан мэргэжлийн бүрэлдэхүүнтэй шүүх юм.¹ Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих бөгөөд төлөөлөн удирдах болон хүний эрхийг хамгаалах тогтолцооны хэлбэр юм.²

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” хэмээн заасан байдаг. Үндсэн хуулийн дээрх зохицуулалт нь Цэцийн чиг үүргийг “Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих” гэж тогтоож уг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ 1/ дүгнэлт гаргах, 2/ маргааныг магадлан шийдвэрлэх гэсэн хоёр арга замаар хэрэгжүүлнэ гэдгийг тодорхойлсон.³ Энэхүү Үндсэн хуулийн хяналт нь хууль тогтоомж, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах зорилготой.⁴

Иймд Цэцтэй холбогдох дараах гурван агуулгын хүрээнд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага бий эсэхийг тандан судалъя.

1.1.1. Цэцээс иргэний үндсэн эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэх талаар /66.1./

Үндсэн хуулийн хяналтын хувьд: Үндсэн хуулийн шүүхийн хяналт нь хууль тогтоомж, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа нь Үндсэн хуульд нийцэж буй талаар хянахыг зорьдог. Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг хийсвэр хяналт, тодорхой хяналт гэх мэтээр ангилдаг.

Хийсвэр хяналт: Амьдралын тодорхой нэг зөрчил буюу маргаанаас ангид байдлаар эрх бүхий субъектүүдийн хүсэлтээр хэрэгждэг хэм хэмжээний хяналтын хэлбэр. Энэ нь байнга хэрэгждэг бөгөөд Үндсэн хуулийн төрөлжсөн байгууллагад эрх бүхий субъектээс хүсэлт ирүүлснээр үүсдэг тул ямар нэг тодорхой хэрэг, маргаан эсхүл үндэслэлийг шаарддаггүй⁵.

Тодорхой хяналт: Ердийн болон дагнасан шүүхээс өөрийн харьяаллын хэрэг, маргааныг шийдвэрлэх явцад хэрэглэж буй хуулиа Үндсэн хууль зөрчиж байна гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд хандах хэм хэмжээний хяналтын хэлбэр. Өөрөөр хэлбэл зөвхөн эрх зүйн тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх үед хэрэгждэг. Энэ загвар нь Үндсэн хуулийн биелэлтэд шүүхээс хяналт тавьдаг тогтолцоотой оронд

1 Б.Чимид, *Үндсэн хуулийн мэдлэг*, (УБ, 2008), 400 дахь тал.

2 성낙인, *헌법학*, (법문사, 2021), 767면.

3 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, (Адмон принт, 2022), 955 дахь тал.

4 Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, (МУИС пресс, 2016), 138 дахь тал.

5 Ч.Энхбаатар, *Үндсэн хуулийн эрх зүй*, (УБ, 2007), 280 дахь тал.

байдаг⁶.

Урьдчилсан хяналт: Эрх зүйн актыг хүчин төгөлдөр болохоос нь өмнө хянах хэм хэмжээний хяналтын хэлбэр юм.

Негатив хяналт: Тодорхой асуудлаар хууль гаргахаар Үндсэн хуульд заасан атал хууль тогтоогчоос тэрхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд хэрэгждэг хэм хэмжээний хяналтын хэлбэр юм⁷. Хэм хэмжээний тодорхой хяналтын хувьд хэрэг, маргааныг шийдвэрлэх явцад Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг тул хүний субъектив эрхийг буюу үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэдэг байна.

Цэцийн шийдвэрлэх маргааны хувьд:

Үндсэн хуулийн Жаран зургадугаар дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.” хэмээн заасан. Ингэхдээ Цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- ➔ Хууль, зарлиг, УИХ, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн ЗГ-ын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- ➔ Ард нийтийн санал асуулга, УИХ, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- ➔ Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, гишүүн, Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;
- ➔ Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх;
- ➔ Үүнийг тодорхойлбол, Цэц нь 1 дүгээрт, шийдвэрийг, хоёрдугаарт, албан тушаалтны үйл ажиллагааг хянадаг бөгөөд иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг хэлэлцэх эрх зүйн орчин байхгүй.

6 Ч.Энхбаатар, *Үндсэн хуулийн эрх зүй*, (УБ, 2007), 280 дахь тал.

7 “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл, Үндсэн хуулийн процессын эрх зүй” оюутны гарын авлага, (УБ, 2011), ХЗДХЯ, Дэлхийн банк, 11-12 дахь тал.

Хүснэгт 1.1. МУ-ын Үндсэн хуулийн цэцийн хяналтад хамаарах шийдвэр

Шийдвэр	Олон улсын гэрээ	Албан тушаалтны үйл ажиллагааг хянах
<ul style="list-style-type: none"> Хууль, УИХ-ын бусад шийдвэр; Зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр; ЗГ-ын тогтоол, бусад шийдвэр; Ард нийтийн санал асуулгын талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр УИХ, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр 	МУ-ын нэгдсэн орсон олон улсын гэрээ	<ul style="list-style-type: none"> Ерөнхийлөгч; УИХ-ын дарга, гишүүн; Ерөнхий сайд; ЗГ-ын гишүүн; Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч; Улсын ерөнхий прокурорын Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянахаас гадна Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах хуульд заасан үндэслэл байгаа эсэхийг мөн хэлэлцэн шийдвэрлэнэ⁸.

Дээрхээс дүгнэхэд, Цэц субъектив үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхгүй. Цэц хийсвэр хяналтыг хэрэгжүүлдэг тул иргэн Үндсэн хуульд заасан үндсэн эрхээ сэргээлгэхээр Цэцэд өргөдөл гаргах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, иргэн Цэцэд өөрт шууд хамааралгүй асуудлаар, тухайлбал аль нэг эрх зүйн акт Үндсэн хууль зөрчиж байгаа эсхүл хуульд заасан хэн нэг албан тушаалтан Үндсэн хууль зөрчиж байгаа эсэх асуудлаар хандах боломжтой бөгөөд иргэн Үндсэн хуульд заасан цөөн тооны объектоор Цэцэд хандах эрхтэй байдаг.⁹ Иймээс Цэц үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаарх өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх чиг үүрэг, бүрэн эрхгүй байх тул хүний эрхийн гол зөрчил шийдвэрлэгдэхгүй байна.¹⁰

Цэц нь 1992-2020 оны хооронд 296 маргааныг хянан шийдвэрлэсний дотор дийлэнх хувьд нь Үндсэн хуулийн зөрчлийг тогтоосон, мөн тэдгээрийн дийлэнх нь үндсэн эрх, эрх чөлөө, төрийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг гаргасан байна. Үндсэн хуулийн шүүхийн гол чиг үүрэг бол Үндсэн хуулийг, ялангуяа үндсэн эрхийг хамгаалах байдаг. Гэвч Цэцээс тухайн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлж чадахгүй байгаа шалтгаан нь үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаар Цэц хянан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүй, Цэцээс ихэнх шийдвэртээ хангалттай сайн үндэслэгээ хийж Үндсэн хуулийг тайлбарладаггүй, Цэцийн хараат бус, бие даасан байдал хангагдаагүйтэй холбоотой талаар эрдэмтэд дурдсан байдаг.

Монгол Улсад үүсэж буй хүний эрхийн зөрчил нь хийсвэр байдлаар бус, харин шүүх, төрийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны явцад гарах нь нийтлэг байна. Тухайлбал, Шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцдаа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт протоколыг хэрэглэлгүйгээр цаазаар авах ял оногдуулж хүний амьд явах эрх зөрчигдсөн; эрүү шүүлтийн хохирогч болж өөрт учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зөрчигдсөн; Эрүүгийн хуульд үзэн ядалтаас үүссэн гэмт хэргийг хуульчлаагүйн улмаас энэ гэмт хэргийн хохирогч болж тэгш эрх нь зөрчигдсөн; Иргэдийн төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх)-ын тогтоолоор шударга нөхөх

8 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 87 дахь тал.

9 Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” *Эрдэм шинжилгээний нийтлэл*, (2002) Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

10 О.Мөнхсайхан, Р.Очирбал, *Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал*, (УБ, 2021), 479 дэх тал.

олговоргүйгээр хувийн өмчийг дайчлан авсан; Засаг даргын захирамж болон шүүхийн шийдвэрээр хүний үндсэн эрх болох үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зөрчигдсөн тохиолдолд Цэцэд хандах боломжгүй байна. Цэцээс УДШ-ийн болон ИТХ-ын шийдвэр нь хүний эрх зөрчигдсөн гэдгийг тогтоосон боловч, хүчингүй болгохоос татгалзаж байсан бөгөөд ийм төрлийн маргааныг хүлээн авдаггүй.¹¹ Иймээс иргэний өргөдөл, мэдээллийг илүү өргөн хүрээтэй тодорхойлох шаардлагатай байна.

Гаднын зарим орны туршлагаас үзвэл, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээдийн үйлдэл, эс үйлдлээр зөрчигдсөн эрх, шүүхийн шийдвэрээр үндсэн эрх сэргээгдээгүй тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гарган шийдвэрлүүлэх эрхтэй байдаг. Энэ жишгийг нутагшуулбал, Цэц иргэний өргөдлөөр үүсгэсэн үндсэн эрхийн маргааныг эцэслэн шийдвэрлэх боломжтой болох бөгөөд тухайн шийдвэрийг УИХ батламжлах шаардлагагүй болно.

Түүнчлэн судлаач О.Мөнхсайхан Цэц иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхдээ дараах үзэл баримтлалыг баримталдаг¹² талаар авч үзсэн.

“Нэг. ҮХЦТХ болон Цэцийн практикт тогтсон. Цэцээс хууль тогтоомж болон бусад холбогдох шийдвэрт абстракт хяналт хэрэгжүүлдэг боловч, ердийн шүүхийн шийдвэрт Үндсэн хууль зөрчигдсөн эсэх асуудлыг шийдвэрлэдэггүй. Мөн, төрийн өндөр албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянадаг. Зөвхөн эрх бүхий этгээд төдийгүй иргэн цэцийн харьяаллын аль ч асуудлаар мэдээлэл гаргах эрхтэй (*actio popularis*). Хууль тогтоомж болон ҮХЦТХ-д заасан бусад шийдвэрээр үндсэн эрхээ зөрчигдсөн гэж үзвэл иргэн Цэцэд өргөдөл гаргах боломжтой. Гэвч, иргэн шүүхийн шийдвэрээр үндсэн эрх нь зөрчигдсөн эсхүл хамгаалагдаж чадаагүй гэж үзвэл энэ асуудлаар Цэцэд хандах боломжгүй. Тодорхой тохиолдолд зөрчигдсөн үндсэн эрхийн маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй байгаа нь Монгол Улс дахь хүний эрхийн хамгаалалт сул буйн шалтгаан болж байна.

Хоёр. Үзэл баримтлалын хувьд иргэний өргөдөл нь Европын Үндсэн хуулийн шүүхэд байдаг Үндсэн хуулийн гомдолтой адилхан агуулгаар хэрэгжих нь зохимжтой. Энэ үзэл баримтлал бол нэг дэх үзэл баримтлалтай өрсөлдөхүйц төдийгүй Цэцийн үндсэн эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх, Үндсэн хуулийн нэр томьёо, логикт илүү тохирох, Үндсэн хуулийг боловсруулж баталсан түүхээр дэмжигдэж болохуйц, олон улсын сайн туршлагад нийцнэ. Иргэний өргөдлийг Үндсэн хуулийн гомдлоор тодорхойлж, түүнд хүсэлттэй адилхан дүгнэлт гаргах, уг дүгнэлтийг УИХ-аар дахин хянуулах хоёр шатлалтай процедураар шийдвэрлэж болохгүй. Өөрөөр хэлбэл, Цэц өргөдлөөр үүсгэсэн маргааныг нэг удаа эцэслэн шийдвэрлэж, уг шийдвэрээ УИХ-аар явуулахгүй байхаар хуульчлах нь оновчтой хэмээн үзсэн.

Мөн, иргэний мэдээлэл гэдгийг үндсэн хуулийн маргааныг үүсгэх үндэслэл гэж үзэхгүй харин “*amicus curiae*” гэсэн агуулгаар ойлгож, нэгэнт үүсгэсэн маргааныг зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой үндэслэл, судалгааг маргааны тал биш иргэнээс авах суваг болгох нь илүү зохистой. Иргэний өргөдөл, мэдээллийн талаар хоёр дахь

11 Мөн тэнд,

12 О.Мөнхсайхан, Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015), 68-80 дахь тал.

үзэл баримтлалын дагуу Цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчилбэл Монгол Улс дахь үндсэн эрхийн зөрчил Үндсэн хуулийн болон олон улсын стандартын дагуу шийдвэрлэгдэх боломжтой болно.¹³

Иймд Үндсэн хуульд зааснаар Цэцэд иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг хүлээн авч шийдвэрлэх боломжийг нээж, Цэцийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхийг баталгаажуулан, иргэн субъектив үндсэн эрхээ хамгаалуулах Үндсэн хуулийн механизмыг бий болгох шаардлагатай байна.

Ийнхүү Цэц нь иргэний үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэснээр Үндсэн хуульд ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг хангах юм. Түүнчлэн хүний субъектив үндсэн эрхийг Цэц хамгаалах явдал нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болно. Энэ нь үндсэн хуулийн шүүхийн хяналтад харьяалагдах субъектийн үйл ажиллагаанд Үндсэн хуулийн заалт нэг бүрийг хэрэгжүүлэхийг шаардах, зөрчил гаргасан тохиолдолд арилгуулах чиг үүрэг гүйцэтгэх явдал юм¹⁴. Тодруулбал, Цэцээс Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх нь Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих улмаар хүний эрхийг хамгаалах хэрэгсэл болно. Зарчмын хувьд иргэний өргөдөл, мэдээлэл нь Үндсэн хуульд заасан субъектив үндсэн эрх хэрэгжих баталгаа байх ёстой.

Гадны зарим орны жишээнээс үзвэл, иргэн нь үндсэн эрхээ нийтийн эрх зүйн аливаа субъектийн үйлдэл, эс үйлдэхүйгээр зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байдаг. Гэхдээ иргэн, хуулийн этгээд нь Үндсэн хуулийн шүүхэд хандахын өмнө тухайн маргааныг хуульд заасан бусад бүх шүүхийн шат дамжлагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг урьдчилан авсны дараа Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой болдог.

Үндсэн эрх нь иргэн өөрт нь хамааралтай байдлаар зөрчигдсөн тохиолдолд л тухайн иргэн Үндсэн хуулийн шүүхэд ханддаг нийтлэг зарчим үйлчилдэг.¹⁵ Өөрөөр хэлбэл, иргэн Цэцэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шууд хандах боломжийг олгохдоо Цэцийн ачаалал, хэрэг маргаан шийдвэрлэлтийн чанарын асуудлыг анхаарах нь зүйтэй бөгөөд өргөдөл, мэдээлэл гаргах тодорхой “босго” тогтоох ёстой.

Дээрх үндэслэлд тулгуурлан тандан судалгааны энэхүү хэсгийн үр дүнд, “Цэцээс иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхийг Үндсэн хуулиар баталгаажуулах” зохицуулалт оруулах хувилбарыг санал болгож байна. Ингэхдээ, Цэцийн ачаалал, ердийн шүүхийн хяналтын давхардлаас урьдчилан сэргийлэх үүднээс Цэцэд хандахын өмнө гурван шатны шүүхийн урьдчилсан хяналтыг хэрэгжүүлсэн байх шаардлагыг тавьж болно.

13 Мөн тэнд, 64-81 дэх тал.

14 Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй, (УБ, 2007), 287 дахь тал.

15 Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 119 дэх тал.

1.1.2. Цэцэд хандах субъект /66.1/

Үндсэн хуулийн Жаран зургадугаар дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу УИХ-ын, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.” гэснээр Цэцэд хандах субъектийг иргэн, тодорхой нэгэн албан тушаалтан байхыг тодорхойлж, эдгээр субъект нь өргөдөл, мэдээлэл, хүсэлт гэсэн хэрэгслийг ашиглан хүсэл зорилгоо илэрхийлэн Цэцэд хандана. Дээрх арга хэрэгслийн төрлөөс үл хамааран Цэцээс бүхэлд нь хянан хэлэлцэхээр заасан боловч, иргэний гаргасан өргөдөл, мэдээллийг Цэцийн маргааны зүйл мөн эсэхийг хууль, журамд заасны дагуу урьдчилан шалгаж, маргаан үүсгэх эсэхийг тогтоодог ч төрийн өндөр албан тушаалтан, эрх бүхий байгууллагын хүсэлтийг шууд хэлэлцэхээр ялгавартай үзсэн нь Үндсэн хууль дахь хууль, шүүхийн өмнө хүн бүр тэгш байх зарчимд үл нийцэх тул адил процедурыг тогтоож өгөх нь оновчтой байж болох юм.¹⁶

Цэцэд хандах субъектийн хувьд одоогоор үүсээд байгаа асуудлыг авч үзвэл парламент буюу УИХ болон Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид “Комисс” гэх) Цэцэд хандах асуудал хамаарч байна. Тиймээс үүнийг дараах байдлаар задлан авч үзье.

УИХ-аас Цэцэд хандах талаар

УИХ нь Үндсэн хуульд зааснаар Цэцэд хандаж хүсэлт гарган Үндсэн хууль зөрчсөн талаарх маргааныг шийдвэрлүүлэх боломжтой. Гэвч өнөөгийн байдлаар Цэцээс ийм төрлийн маргааныг шийдвэрлээгүй байна. УИХ нь Цэцэд хүсэлт гаргахдаа нэгдсэн чуулганы гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэсний дагуу Цэцэд хүсэлт гаргах боломжтой бөгөөд цөөн тооны гишүүд Цэцэд хандах боломжгүй нөхцөл үүсэж байна. Тухайлбал, 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдөр УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан, Д.Оюунхорол, Д.Ганболд, С.Бямбацогт нар Монгол Улсын ЗГ Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн эсэх асуудлыг шалгуулахаар Цэцэд хандсан. Ийнхүү хандахдаа дээрх гишүүд нь УИХ-ын зүгээс бус Монгол Улсын иргэний хувьд Үндсэн хуулиар олгосон эрхийн дагуу Цэцэд хандсан байна.¹⁷ Учир нь УИХ-ын тодорхой тооны гишүүн Цэцэд хандах эрх эдлэх зохицуулалт одоогоор байхгүй бөгөөд эдүгээ үйлчилж буй Монгол Улсын Үндсэн хууль батлагдаж, Цэц анх байгуулагдсанаас хойш өнөөг хүртэл УИХ нь дээрх болон эрх хэмжээнийхээ бусад асуудлаар Цэцэд хандаагүй байна.

Энэ талаар судлаач Ц.Сарантуяа үзэхдээ “Аливаа парламент Үндсэн хуулийг сахиулахын төлөө ажилладаг байгууллага болохын хувьд Үндсэн хуулийн шүүхэд хандах гол субъектийн нэг байх учиртай. УИХ-ын хамтын удирдлагын улс төрийн шинжтэй байгууллага, шийдвэрээ хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналаар гаргадаг. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад, Нэгдсэн хуралдаан хуралдаж асуудал нэг бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан асуудлаар Цэцэд хүсэлт гаргахыг зөвшөөрсөн гэж үзэхээр заасан. Гэтэл УИХ өөрийнхөө батлан гаргасан

16 Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, (Адмон принт, 2022), 990 дэх тал.

17 УИХ-ын гишүүд, “УИХ-ын нэр бүхий дөрвөн гишүүн Цэцэд ханджээ”, 2018.12.13, Холбоос: <https://www.parliament.mn/nn/4216/>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

хууль болон эрх зүйн бусад актын талаар Цэцэд олонхын саналаар хандах шаардлагагүй, түүнийгээ өөрөө хүчингүй болгох буюу өөрчлөх боломжтой байдаг.¹⁸

Мөн түүнчлэн үүнтэй холбоотой хүсэлтийг Цэц шийдвэрлэсэн байдаг. 1997 оны Цэцийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын өмнөх хувилбар үйлчилж байх үед буюу 1995 оны 1 дүгээр сарын 18-нд Цэц, Цэцийн тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргасан.

Мэдээлэл гаргагч нь Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т холбогдуулан мэдээлэл гаргахдаа:

“Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т: УИХ... хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналд үндэслэж гаргана гэсэн заалт Үндсэн хууль... зөрчиж байна. Учир нь УИХ шийдвэрээ олонхоор гаргадаг бөгөөд гаргасан шийдвэрээ хамгаалах зүй ёсны сонирхол тухайн шийдвэрийг гаргасан олонход бий. Гэтэл Үндсэн хууль зөрчсөн шийдвэр гарч болох ба энэхүү зөрчлийг шийдвэр гаргасан олонх ямар нэг шалтгаанаар (...тухайн үеийн улс төрийнхөө сонирхолд хөтлөгдөх) олж харанхуй, нэгэнт гаргасан шийдвэрээ цэцээр хянуулаад олох юмгүй тул Цэцэд хүсэлт гаргах сонирхол төрөхгүй. Ийнхүү хуулийн энэ заалт нь Үндсэн хуулийн ... үйлчилгээг хаасан байна. Энэ нь Үндсэн хуулийг дээдлэх хэвийн үйл ажиллагаанд ч муугаар нөлөөлж болно: Төрийн ардчилсан тогтолцоотой улсуудад харьцангуй цөөн тооны гишүүн хамтран эсвэл намын бүлэг Үндсэн хууль зөрчигдсөн тухай маргаан үүсгэж Үндсэн хуулийн шүүхдээ хандах эрхийг хуулиар олсон байдаг нь парламент алдаагаа өөрөө засах, хууль тогтоох үйл ажиллагаанд нямбай хандах, төрийн тогтвортой байдлыг хангах хөшүүрэг болж өгдөг байна. Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалтыг намын бүлэг, аль эсвэл УИХ-ын тодорхой тооны гишүүн хамтран УИХ-ын хүсэлтийг гаргаж байхаар өргөтгөвөл Үндсэн хуулийн тодорхой заалтын үйлчилгээг хааж байгаа дээрх зөрчил арилна. Ийм боломж нээгдсэнээр УИХ-ын үйл ажиллагаанд хууль дээдлэх хамтран ажиллах явдалд ахиц гарах, төрийн эрхийн төлөө намуудын хооронд улс төрийн тэмцэл илүү соёлтой болох нь дамжиггүй”

... хэмээн тодорхойлжээ.

Цэц үүнийг шийдвэрлэхдээ Цэцийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг УИХ-ын баталсан хуулиуд хийгээд түүний бусад шийдвэрүүдтэй холбон явцууруулж ойлгох нь учир дутагдалтай тул энэ хэсгийн заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй бөгөөд уг хүсэлтийг хангах боломжгүй хэмээн дүгнэсэн байна.¹⁹

1995 онд шийдвэрлэсэн дээрх Цэцийн тухай хуулийн “УИХ... хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналд үндэслэж гаргана” гэх заалтыг 1997 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон байна. Гэхдээ энэхүү агуулга бүхий зохицуулалт нь бусад хуульд байх бөгөөд одоогийн байдлаар УИХ нь нийт гишүүний олонхын саналд үндэслэж Цэцэд хүсэлт гаргахаар байна.

Тухайлбал, 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 86 дугаар зүйлд зааснаар УИХ Цэцэд дараах байдлаар хүсэлт гаргадаг. Үүнд:

- Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүн Цэцэд хүсэлт гаргах саналыг УИХ-ын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг Хууль зүйн байнгын хороо ажлын 14 өдрийн дотор хэлэлцэж саналд дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ оруулна.

18 Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 143-144 дэх тал.

19 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дугаар 02 дүгнэлт, 1995.01.18.

- Нэгдсэн хуралдаан санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор хуралдаж асуудал нэг бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулах бөгөөд санал хураалтаар олонхын дэмжлэг авсан асуудлаар Цэцэд хүсэлт гаргахыг зөвшөөрсөн гэж үзнэ;
- УИХ-ын дарга уг асуудлаар хүсэлт гаргах тухай албан бичгийг Цэцэд хүргүүлнэ.

Үүнээс үзвэл, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар олонхын саналаар Цэцэд хүсэлт гаргах эсэхийг шийдвэрлэх зохицуулалт одоог хүртэл байсаар байна. Өмнө дурдсанчлан УИХ өөрөө тухайн хууль болон эрх зүйн актыг хүчингүй болгох, өөрчлөх эрх мэдэлтэй учраас Цэцэд хандахгүй байгаа ба цөөнх буюу тодорхой тооны гишүүдийн болон намын бүлгийн эрх ашиг хөндөгдөж байна.

Ийнхүү олонхоороо шийдвэрлэх нь парламентын буюу УИХ-ын зарчим бөгөөд үүнийг буруутгах аргагүй. Энэ тухай 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан УИХ-ын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “УИХ-ын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчимд нийцсэн, бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.” гэж тусгасан байдаг. Ийнхүү УИХ-ын тухай хуулиар цөөнх буюу тодорхой тооны гишүүдийн болон намын бүлгийн Цэцэд хандах боломжийг бий болгоход хүндрэл учрах юм. Тиймээс Үндсэн хуульд тусган Цэцэд хандах боломжийг нээж өгөх нь зүйтэй.

УИХ-аас батлагдсан хууль, тогтоолоос гадна Цэцийн харьяалан шийдвэрлэх бусад маргааны хувьд:

- Ерөнхийлөгчийн зарлиг, бусад шийдвэр, ЗГ-ын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, ард нийтийн санал асуулга, УИХ, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх;
- Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, гишүүн, Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;
- Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар ч Цэцэд хүсэлт гаргах хууль зүйн боломжийг бий болгох хэрэгтэй.

Иймд дээрх байдлаар Цэцэд хандахад УИХ-ын тодорхой гишүүд гэх ойлголтыг тодорхойлон, зохистой байдлаар зохицуулах шаардлагатай.

Комиссоос Цэцэд хандах талаар

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1-т заасан Цэцэд хандах субъектэд Комиссыг хамааруулаагүй байна. Комисс²⁰ нь 2020 оны Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3.1.1-т зааснаар “Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага.” юм.

Комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх;

- Хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах;

- Хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх;

- Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;

- Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх;

- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;

- Хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

20 1991 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зохион байгуулсан шинжээчдийн зөвлөгөөнөөс “Хүний эрхийг дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын эрх зүйн зарчмууд” батлагдсан. Парисын зарчмууд нэршлээр түгсэн энэ баримт бичгийг хожим нь НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993/48/134 тогтоолоор батламжилжээ. “Парисын зарчмууд”-аар хүний эрхийг хангах, түүнийг сахин хамгаалах үндэсний байгууллагуудын бүрэн эрх, үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх наад захын хэм хэмжээг тогтоосон. 1993 онд Вена хотноо зохион байгуулагдсан Хүний эрхийн дэлхийн бага хурлаар олон улсын гэрээ, конвенцод заасан хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийг хүлээн зөвшөөрч, түүнийг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг бүхий хүний эрхийн үндэсний байгууллагыг Парисын зарчмуудад нийцүүлэн байгуулахыг гишүүн улс орнууддаа уриалсан билээ. Хүний эрхийн үндэсний байгууллага нь хараат бус, өргөн хүрээтэй бүрэн эрх олгогдсон, байнгын ажиллагаатай, олон ургалч төлөөллийг хангасан бүрэлдэхүүнтэй, олон нийтэд ойр дөт, үйл ажиллагаагаа явуулах санхүүгийн чадавхтай байх ёстой. Хуулийг дээдлэх, хараат бус, бие даасан байх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг тууштай хамгаалах, ил тод, шударга ажиллах нь хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааны зарчим юм. Эдгээр үзүүлэлтүүдээр нь хүний эрхийн үндэсний байгууллагын үр нөлөөг хэмждэг. УИХ-аас 2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, 2001 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Комиссын анхны гишүүдийг томилсноор Парисын зарчимд нийцсэн хүний эрхийн үндэсний байгууллага Монгол Улсад үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага юм. Энэхүү Комисс нь Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хороонд 2003, 2008, 2014, 2021 онуудад “А” статусаар магадлан итгэмжлэгдсэн, Ази Номхон Далайн Бүс Нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагын Чуулганы бүрэн эрхт гишүүн юм. УИХ-аас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталснаар Комиссын чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, дарга, гишүүний бүрэн эрх, зохион байгуулалт, хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаа болон хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэсний механизмыг байгуулсан зэрэг томоохон өөрчлөлтийг хийсэн.

- Шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийн хэрэгжилтэд энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих;
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулж, УИХ-д хүргүүлэх.

Комисс нь эрх бүхий байгууллага албан тушаалтанд санал, зөвлөмж, дүгнэлт гаргах, мэдээлэл хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд хяналт тавих, шалгалт хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна. Тодруулбал, Комисс нь Цэцэд хандах эрх бүхий субъектэд хамаардаггүй. Ийнхүү тус байгууллагын Цэцэд хандах эрхийг хааж байгаа нь Үндсэн хуульд заасан хүний эрхийг хамгаалах механизмын хэрэгжилтэд сөрөг үр дагаврыг учруулж байна. Иймд Комисс нь Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих байгууллага болохын хувьд хүний эрхийн баталгааг хангах үүднээс Комисс Цэцэд хүсэлт гаргах эрх зүйн үндэслэлийг бий болгох шаардлагатай.

Дээрхээс дүгнэвэл, Цэцэд хандах субъектийг нарийвчлан тодорхойлох буюу Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн тухайд УИХ-ын тодорхой гишүүд болон Комиссын Цэцэд хандах эрх зүйн орчныг бий болгох асуудал үүсжээ.

Мөн УИХ-ын хувьд Монгол Улсын Үндсэн хууль, УИХ-ын хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зааснаар УИХ-ын нэгдсэн хуралдааны олонхын саналаар Цэцэд хүсэлт гаргахаар зохицуулсан нь тодорхой тооны гишүүний Цэцэд хандах эрхийг хязгаарлаж байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан цэцэд хандах субъектэд УИХ-ын цөөнх гишүүн Цэцэд хүсэлт гаргах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй.

Түүнчлэн Комисс нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллага болохын хувьд хүний эрхийг зөрчсөн хууль, эрх зүйн акт, эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийг Цэцэд хандан шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй.

Дээрх үндэслэлд тулгуурлан тандан судалгааны энэхүү хэсгийн үр дүнд “УИХ-ын тодорхой тооны гишүүн болон Хүний эрхийн үндэсний комисс Цэцэд хандах” эрх зүйн зохицуулалтын хувилбарыг дэвшүүлж байна.

1.1.3. Цэцийн гишүүний томилгоо /65.1/

Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг УИХ, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор УИХ зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасан. Тодруулбал, Цэцийн гишүүний тоо, тэдгээрийг томилуулахаар санал болгох эрх бүхий этгээд, байгууллагыг тодорхойлохын сацуу бүрэн эрхийн хугацааг Үндсэн хуульд тусгажээ. Цэцийн гишүүний томилгоог хууль тогтоох байгууллагын дураар шийдвэрлэхээс урьдчилан хамгаалсан, хоёрт, Гишүүний бүрэн эрхийн хугацааг хуульчилснаар цэцийн гишүүн дахин томилогдохгүй бөгөөд ганц л удаа цэцийн

гишүүний албан үүргийг гүйцэтгэх хязгаарыг тогтоосон²¹ гэж тайлбарладаг эрдэмтэд байдаг ч ихэнх тохиолдолд Үндсэн хуулийн дээрх заалт нь “улируулан томилох”-ыг хориглосон заалт биш Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жил байхаар тодорхойлсон заалт гэж ойлгодог.

1992 оны Үндсэн хуулийг боловсруулах явцад Цэцийн гишүүнийг улируулан томилохыг хориглох заалт оруулах талаар гаднын эрдэмтдийн дүгнэлт гарч байсан боловч улируулан томилох асуудлыг илэрхий хориглосон заалт ороогүй учир өдийг хүртэл улируулан томилогдсоор иржээ. 1992-2021 оны хооронд Цэцийн гишүүнээр нийт 37 хүн томилогдон ажилласнаар дөрвөн удаа улиран ажилласан 1 гишүүн, гурван удаа улиран ажилласан 1 гишүүн, хоёр удаа улиран ажилласан 4 гишүүн байна.

Үндсэн хуулийн хяналт сайн хөгжсөн гадаадын зарим орны жишээг үзвэл, ихэнхдээ шүүгчийг улируулан томилохыг хязгаарласан байдаг. Учир нь Цэцийн гишүүн улиран томилогдохын тулд өөрийг нь нэр дэвшүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны ашиг сонирхлын дагуу шийдвэр гаргах магадлалтай тул “улиран томилогдох” талаар хязгаарлалт тавьж гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангадаг. Тодруулбал, улиран томилогдох боломжийг хуулиар олгох явдал нь шүүгчийн хараат бус байдалд харшилна.²²

Манай Үндсэн хуульд Цэцийн гишүүний бүрэн эрхийг 6 жилээр тогтоосон бөгөөд улируулан томилохыг хуулиар хязгаарлах боломж нээлттэй. 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр УИХ Цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “... цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.” гэж зааснаар цэцийн гишүүнийг дахин томилох эрх зүйн үндэслэл бий болсон ч тус зүйл заалтыг Цэц хүчингүй болгосон байна.²³ Цэцийн гишүүнийг улируулан томилж болох эсэх талаар Үндсэн хуульд дурдаагүй нь үүнтэй холбоотой хязгаарлалтыг Цэцийн тухай хуулиар хийхийг хориглосон гэсэн үг бус, харин хуулиар зохицуулах боломжтойг илэрхийлдэг.

Хүн ам цөөнтэй манай улсын хувьд Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жилээр тогтоон нэг удаа томилох тохиолдолд шаардлага хангасан хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэл үүснэ. Тиймээс Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилохыг зөвшөөрч бүрэн эрхийн хугацааг 12 жил байхаар зохицуулбал хүний нөөцийн хомсдолоос сэргийлэхийн зэрэгцээ Цэцийн гишүүний хараат бус байдлыг баталгаажуулах боломжтой. Иймд Цэцийн гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангаснаар Үндсэн хуульд тавих дээд хяналт сайжруулахын сацуу хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах боломж бүрдэнэ. Тиймээс Цэцийн гишүүний томилгоог хязгаарлах зохицуулалтыг Үндсэн хуульд тусгах хувилбарыг дэвшүүлж байна.

1.2. Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангах хүрээнд

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.10 дахь хэсэгт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.” гэж зааснаар

21 Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, (Адмон принт, 2022), 970 дахь тал.

22 Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 73-74 дэх тал.

23 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр тогтоол, 2016.06.02.

Монгол Улсын иргэд нийгмийн болон өөрийн ашиг сонирхлын үүднээс “Улс төрийн нам” байгуулах эрхтэй. Улс төрийн нам гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдлийг хэлнэ.²⁴ Тодруулбал, нам бол иргэд үзэл бодол, эрх ашгийн төлөө сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, нийгэмд тухайн үзэл бодол, эрх ашгаа хамгаалах, олон нийтэд нөлөөлөхийн тулд төрийн эрх мэдэлд хүрэх явдлыг шууд зорилгоо болгосон иргэднийн нэгдэл гэж болно.

Улс төрийн намын онцлог шинжийг авч үзвэл:

- ➔ Төрийн эрх мэдэлд хүрэх эсхүл түүнд оролцох зорилготой, үүний тулд сонгогчоор дэмжүүлэх эрмэлзэлтэй;
- ➔ Нийгмийн томоохон бүлэглэлүүдийн эрх ашгийг илэрхийлсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилготой, үүний тулд намынхаа нийгмийн баазыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого явуулдаг;
- ➔ Өөрийн удирдах болон орон нутгийн байгууллагыг багтаасан зохион байгуулалтын бүтэцтэй;
- ➔ Нэгэн үзэл суртлын үндсэн дээр сайн дураараа эвлэлдэн нэгдэж зохион байгуулалтад орсон нэгдэл холбоо байгуулах явдал юм.

Дээрхээс үзвэл, намын туйлын зорилго бол өөрсдийн үзэл бодол, ашиг сонирхлоо хамгаалах, нийгэмд нөлөөлөл үзүүлэхийн тулд сонгуулийн үр дүнд тулгуурлан төрийн эрх мэдэлд хүрэх эсхүл төр, засгаас гарах шийдвэрт нөлөөлөх явдал юм.

Нам үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгэх, өөрчлөн байгуулах, намын үйл ажиллагааг зогсоох, намыг тараах, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох зэрэг асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулдаг.²⁵

Улс төрийн нам нь дараах зарчмыг хэрэгжүүлнэ. Үүнд:²⁶

- Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх;
- Үйл ажиллагаагаа ил тод явуулах;
- Гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох;

24 Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг.

25 Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй, (УБ, 2007), 102-103 дахь тал.

26 Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль, 5 дугаар зүйл.

- Дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхын саналаар шийдвэрлэх;
- Бусад намын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс үл оролцох, өөрийн үзэл баримтлалыг тулган шаардахгүй байх;
- Үйл ажиллагаагаа нутаг дэвсгэрийн зарчмаар явуулах;
- Монгол Улсаас гадаад улстай тогтоосон найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг эрхэмлэн хүндэтгэх.

Улс төрийн нам нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Үндсэн хуулиар баталгаажсан эрхийн дагуу эвлэлдэн нэгдсэний төлөө гишүүнийх нь хувьд түүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Энэ нь Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг, ялангуяа нам байгуулах эрхийг баталгаажуулсан зохицуулалт юм. 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэгт ч мөн энэхүү эрхийг оролцогч улсууд баталгаатай эдлэхээр зохицуулсан байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.” Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй.” гэж тус тус заажээ.

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нам байгуулах, түүнд элсэх эрхтэй холбоотой хэд хэдэн зохицуулалтыг хийсэн. Үүнд:²⁷

- ➔ Нам Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана;
- ➔ Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна;
- ➔ Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.

Мөн улс төрийн нам байгуулахдаа сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд тодорхой нэгэн хүсэл зорилгын дагуу эвлэлдэн нэгдсэн байх шаардлагыг оруулсан. 2020 оны УИХ-ын сонгуулиар 2,000,624; 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар 2,040,556 сонгуулийн насны иргэн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн байна. Дээрх Үндсэн хуулийн холбогдох заалтын дагуу сонгуулийн насны 20 мянган сонгогч нэгдсэн тохиолдолд улс төрийн нам байгуулах босгыг давах юм.

УДШ-ийн бүртгэлээс үзвэл, Монгол Улсад нийт 36 нам бүртгэлтэй байх бөгөөд гишүүнчлэлийн тоог дэлгэрүүлэн авч үзье:

27 Монгол Улсын Үндсэн хууль, 19 дүгээр зүйл.

Хүснэгт 1.2. МУ-ын намын бүртгэл

№	Намын нэр	Гишүүдийн тоо	№	Намын нэр	Гишүүдийн тоо	№	Намын нэр	Гишүүдийн тоо
1	Монгол ардын нам	161,300	13	Монгол Үндэсний ардчилсан нам	26,000	25	Үнэн ба зөв нам	2,100
2	Ардчилсан нам	150,000	14	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	1,600	26	Зон олны нам	2,022
3	Монголын ногоон нам	2,100	15	Иргэний хөдөлгөөний нам	815	27	Дэлхийн Монголчууд Нам	1800
4	Иргэний зориг ногоон нам	35,000	16	Хөгжлийн Хөтөлбөрийн нам	933	28	Ард түмний олонхын засаглал нам	1080
5	Монголын уламжлалын нэгдсэн нам	1,503	17	Монголын Ардчилсан Хөдөлгөөний нам	850	29	Их эв нам	1056
6	Монголын либерал ардчилсан нам	863	18	Монгол Ардын Хувьсгалт нам	35,000	30	Гэр хороолол хөгжлийн нам	1023
7	Эх орон нам	160,000	19	Хамуг монголын хөдөлмөрийн нам	2,000	31	Миний Монгол нам	979
8	Монголын либерал нам	1300	20	Эх орончдын нэгдсэн нам	2,150	32	Монгол шинэчлэлт нам	1023
9	Бүгд найрамдах нам	50,000	21	Монгол консерватив нам	959	33	Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам	913
10	Монголын эмэгтэйчүүдийн үндэсний нам	1,069	22	Тусгаар тогтнол, эв нэгдлийн нам	3,131	34	Зүй ёс нам	1533
11	Монголын социал демократ нам	3,000	23	Ард түмнээ хайрлая нам	1,388	35	Ардчилал шинэчлэлийн нам	893
12	Ард түмний нам	11,859	24	Монголын хүний төлөө нам	1,135	36	Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам	4040

Дээрхээс дүгнэхэд, Үндсэн хуулийн холбогдох заалтад заасан шаардлагыг хангасан 7 нам байх бөгөөд бусад 29 улс төрийн нам намын гишүүний тоонд тавигдах шаардлага хангаагүй байна. 2028 оноос хэрэгжиж эхлэх Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтаар оруулсан босго нь бусад улсуудтай харьцуулахад хамгийн өндөрт тооцогдож байгаа юм.²⁸

Эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангахын тулд улс төрийн нам байгуулахад өндөр босго тавихгүй, бүртгэгдсэн намын үйл ажиллагаа, нийгэмд хүлээх үүрэг,

28 “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, Монгол Улсын Их Хурал (УБ, 2023), 79 дэх тал.

хариуцлага талаас нь өндөр шаардлага тавих нь оновчтой.²⁹ Иймд “Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлд тусгасан шаардлагыг хасаж, улс төрийн нам бүртгүүлэх шаардлагыг уян хатан байдлаар зохицуулах, иргэдийн улс төрийн намын гишүүн болох эрхийг хангах³⁰, баталгаажуулахыг судлаачдын хувьд ч дэмждэг байна.

Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалт нь улс төрийн олон ургалч үзлийг алдагдуулах, төлөөллийн ардчиллыг сулруулах, нийгмийн цөөнхийн төлөөллийг үгүйсгэх тэгш бус байдлыг үүсгэхээр байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн нам байгуулахад өндөр шаардлага тавих нь төлөөлөн удирдах засаглал дахь цөөнхийн төлөөллийг үгүйсгэх магадлалтай. Иймд, Үндсэн хуульд заасан холбогдох заалтыг хүчингүй болгох хувилбарыг санал болгож байна.

1.3. Сонгуулийн тогтолцоо болон парламентын төлөөллийг сайжруулах хүрээнд /21.1./

1.3.1. Сонгуулийн тогтолцоо

Ардчилсан улсад сонгууль нь улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх сонгогчдын оролцоо, төлөөллийг хангах нийгмийн зөвшилцөл хэмээн ойлгож болно. Харин сонгуулийн тогтолцоо гэж сонгуулиар иргэдийн өгсөн саналд үндэслэн нам, нэр дэвшигчдэд парламентад суудал хуваарилах аргыг хэлнэ. Сонгууль нь парламентад ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл, тэдний төлөөлөл болохыг нотлохын тулд тодорхой хугацаанд тогтмол явагддаг, парламентын цөөнхөд олонх болох боломж олгох, иргэд өөрсдийн парламентын гишүүн, өөрсдийн төлөөлөлтэй хариуцлага тооцох боломжийг бүрдүүлэх зорилготой ардчиллын үндсэн элементийн нэг юм.³¹ Өөрөөр хэлбэл, тухайн улсын улс төрийн тогтолцоо, парламент, намын тогтолцоо, сонгогчдын сэтгэл зүй зэрэгт шууд нөлөөлдөг тул сонгуулийн тойрог ямар байх, сонгогч хэдэн саналтай байх, саналаа хэнд өгөх, саналын дүнг парламентад ямар аргаар суудалд шилжүүлэн хуваарилах зэргийг багтаадаг арга юм.³²

Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасныг үндэслэн УИХ-ын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль, Орон нутгийн сонгууль тус тус зохион байгуулагддаг.

Мөн Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “УИХ-ын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. УИХ-ын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор УИХ-ын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэж УИХ-ын сонгуулийн эрх зүйн үндэслэлийг тогтоосон. Үүнээс гадна Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “УИХ-ын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.” гэж сонгуулийн зарчмыг тогтоосон.

29 Мөн тэнд, 78 дахь тал.

30 Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн төслийн тухай төсөлд өгсөн дүгнэлт, ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар, (2022).

31 Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, (МУИС пресс, 2016), 190 дэх тал.

32 Electoral system, Britannica encyclopedia, 2009, Холбооц: <https://www.britannica.com/topic/electoral-system>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25..

1990 оноос хойш сонгуулийн мажоритар тогтолцоог ашиглаж байгаа боловч, уг тогтолцооны сул тал болох сонгогчдын санал гээгдэх, улс төрийн жижиг нам парламентад суудал авч чадахгүй байх, улмаар улс төрийн цөөнхийн оролцоог хангаж чадахгүйд хүрэх гэх мэт тогтолцооны гажуудал гарсаар байна. УИХ-ын 2000 оны ээлжит сонгуульд нийт 16 хувь буюу 190 мянган сонгогчийн санал гээгдсэн нь 10 тойргийн сонгогчийн тоотой тэнцэх юм. Мөн бусад оронтой харьцуулахад суудал-саналын харьцааны алдагдал маш өндөр байгаа бөгөөд УИХ дахь намуудын харьцааг тэнцвэргүй байдалд хүргэж байна.³³ УИХ-ын сонгуулийг нийт 8 удаа зохион байгуулсан бөгөөд үүний 7 нь мажоритар /1996, 2000, 2004, 2016 онуудад 1 мандаттай 76 тойрог, 1992, 2008, 2020 онуудад олон мандаттай томсгосон тойргоор/ тогтолцоогоор, 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор /48 мандаттай 28 тойрог, 28 мандаттай пропорциональ/ тус тус зохион байгуулсан.

Өнгөрсөн 30 жилд УИХ-ын ээлжит 8 сонгуульд хэрэглэсэн сонгуулийн олонхын тогтолцооноос бид дараах сургамжийг шууд болон шууд бусаар авчээ. Шууд сургамжийг дурдвал:³⁴

1. Улс төрийн 36 нам байгаа ч УИХ-ын сонгуульд 20 хүрэхгүй нам нь өрсөлддөг. Сонгогчдын 1-ээс дээш хувийн дэмжлэгийг ердөө 2-6 улс төрийн нам авдаг;
2. Нийт 8 удаагийн сонгуулиас 6 сонгуульд нь нэг нам (МАН) УИХ-д олонх болж дангаараа болон хамтран ЗГ-аа байгуулдаг;
3. АН 2 удаа УИХ-д олон суудал авсан. 1996-2000 оны бүрэн эрхийг эс тооцвол дангаараа ЗГ-аа байгуулж байгаагүй;
4. МАН нийт 8 удаагийн УИХ-ын сонгуулийн дөрөвт нь буюу 1992 онд 70, 2000 онд 72, 2016 онд 65, 2020 онд 62 суудал авч хэт олонхын УИХ-ыг бүрдүүлсэн;
5. Гуравдагч хүчний орон зай хаалттай. ИЗН, МАХН, ХҮН намууд цөөн суудлаар сонгогдож байсан ч сонгогчдын дэмжлэг тогтворгүй;
6. 1992, 2000, 2016, 2020 оны УИХ-ын сонгуулиар авсан сонгогчдын санал УИХ-д дунджаар 23-43 хувь гээгдсэн;
7. УИХ-ын сонгогчдыг төлөөлөх чадвар буурч байгаа бөгөөд 2008 оноос хойш 4 удаагийн УИХ тус бүрийн сонгогдсон гишүүдийн авсан санал нийт сонгогчдын саналын 50 хувьд хүрээгүй;
8. Гадаадад байгаа иргэд сонгуульд оролцож саналаа өгөх эрхгүй. 2012 оны УИХ-ын сонгуулиар 1 л удаа гадаадад амьдарч байгаа иргэдийн санал өгөх эрх нээгдсэн;
9. Сонгогчдын улс төрийн оролцоо буурч байгаа;
10. Нэр дэвшигчид нь сонгогчдын тойргийн хэрэгцээг харж сонголтоо хийдэг болсон;

33 О.Мөнхсайхан, *Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал, тулгамдсан асуудал шийдэл*, (УБ, 2020), 161 дэх тал.

34 УИХ, “л” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын асуултын лавлагаа, танилцуулга”, (УБ, 2023), 66-67 дахь тал.

11. Нийслэлийн сонгогчдын тоо нэмэгдсэн. Улаанбаатар хотод нийт иргэдийн 46 хувь амьдарч байгаа ч, УИХ-ын 76 суудлын 24 нь буюу 31 хувь нь л Нийслэлийн сонгогчдыг төлөөлж байгаа;
12. УИХ-д жендэрийн тэгш байдал алдагдсан. УИХ-д 13 эмэгтэй гишүүн сонгогдсон нь дөнгөж 17 хувь байна. Энэ үзүүлэлтээр дэлхийн дунджаас 9, Азийн дунджаас 5 хувиар бага;
13. Сонгогчдын 40 хувь 35-аас доош насны залуучууд байдаг боловч, өнөөгийн байдлаар УИХ-д 35-аас доош насны залуучуудын төлөөлөл байхгүй.

Хүснэгт 1.3. Сонгуулийн тогтолцооны эерэг ба сөрөг тал³⁵

Олонхыг төлөөлөх (мажоритар) тогтолцоо	Эерэг тал	-Том намуудад давуу тал үүсгэдэг. Төрийн эрхийг том намууд тогтвортой барих нөхцөл бүрдүүлнэ.
	Сөрөг тал	- Сонгогчдын саналын багагүй хэсэг парламентад тусгалаа олохгүй байх сул талтай. - Намууд хоорондын бус харин нэг нам доторх өрсөлдөөнийг гааруулдаг. - Нэр дэвшигчийн бүтэц алдагддаг: - Сонгуулийн нүсэр санхүүжилт шаарддаг. - Парламент дахь намын бүлгийн бүтцэд сөргөөр нөлөөлдөг. - Санал тоолоход хүндрэлтэй.
Хувь тэнцүүлэн (пропорциональ) хуваарилах тогтолцоо	Эерэг тал	- Парламент олон нам суудал авах нөхцөл бүрдүүлнэ. - Аливаа үзэл бодол, үнэт зүйл нэг танхимд хэлэлцэгдэх боломж бүрдүүлнэ.
	Сөрөг тал	- ЗГ-аа намууд нэгдэж байгуулах, хариуцлага хүлээх эзэн тодорхойгүй болох, ЗГ огцрох магадлал өснө.
Холимог тогтолцоо	Эерэг тал ³⁶	- Олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны давуу талуудыг товойлгох, дутагдалтай талуудыг хязгаарлах бололцоо бүрдүүлнэ. Том улсуудад болон үндэсний асуудал тавигддаг улсуудад тохиромжтой. - Сонгогчдын санал гээгдэх үзэгдэл багасна. - Улс төрийн нэг намын эрх мэдлийн давамгайл байдлыг хязгаарладаг. - Сонгогчдын ирц нэмэгдэх боломжтой. - Цөөнхийн төлөөлөл хангагдана /эмэгтэйчүүд, залуучууд/. - Гадаадад амьдарч буй иргэдийн сонгох эрх баталгаажна - Сонгуулийн зардал буурна.
	Сөрөг тал ³⁷	- Бүс нутгийн болон үндэсний хэмжээний асуудлын зааг ялгарч, парламентад өөр өөр ашиг сонирхол зөрчилдөх магадлалтай. - Парламентад суудалтай намын тоо нэмэгдэнэ. - Бие даан нэр дэвшихэд халгаатай. - Сонгогчоос зарим гишүүнд хариуцлага тооцох чадамж буурна. - Эвслийн ЗГ байгуулагдах магадлалтай.

Мажоритар тогтолцооны сөрөг тал нь сонгогчдын санал гээгдэх, тойргийн явцуу ашиг сонирхол үүсэх, улс төрийн жижиг нам улс төрд төлөөлөл болоход бэрхшээл

35 Парламентын судалгааны хүрээлэн, “Парламент судалгааны эмхэтгэл” боть 40, 2022, 229 дэх тал.

36 “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, Монгол Улсын Их Хурал (УБ, 2023), 69 дэх тал.

37 Мөн тэнд.

үүсгэх явдал юм. Үүнээс үүдэн улс төрийн цөөнхийн үзэл санаа үгүйсгэгддэг тул төлөөлөн удирдах ардчиллын зарчимд нийцдэггүй. Үүнийг шийдвэрлэхийн тулд сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх хувилбарыг дэвшүүлж байна. Сонгуулийн холимог тогтолцоо нь мажоритар болон пропорциональ тогтолцооны аль алиных нь шинжийг агуулдаг. Сонгуулийн холимог тогтолцооны эерэг талыг дурдвал:

- Сонгогч саналаа шууд, нууц гаргах эрхийн үндсийг бүрэн хангах боломжтой.
- Сонгуульд нэр дэвшигчийн талаас авч үзвэл нам, эвсэл, нам, эвслээс гаргасан нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт, тухайлсан нэр дэвшигчийн аль нь ч байж болохоор байна;
- 1 сонгогч - 1 санал гэсэн саналын хувийн жин тэнцүү байх боломжийг бүрдүүлнэ.

Сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэхдээ анхаарах зүйл нь пропорциональ тогтолцоогоор сонгогдох саналын босгыг оновчтой тодорхойлох явдал юм. Босгыг хэт өндөр тогтоох нь парламент дахь цөөнхийн төлөөллийн тоог хязгаарлаж, олонхыг төлөөлөх тогтолцооноос нэг их ялгаагүй болгодог бөгөөд хэт доогуур тогтоовол олонхын төлөөлөл тогтохгүй, хамтарсан ЗГ байгуулахад хүргэдэг сөрөг талтай учир энэ босгыг оновчтой тогтоохоос парламентын ардчиллын хувь заяа шийдэгдэнэ.³⁸ Монгол Улс анх удаа 2012 онд сонгуулийн холимог тогтолцоонд тулгуурлан УИХ-ын сонгуулийг зохион байгуулж гадаад улсад оршин суугаа иргэд сонгох эрхээ хэрэгжүүлсэн байна. Гадаад улсад оршин суугаа иргэд улс төрийн үйл явцад сонирхол ихээхэн хандуулдаг субъект бөгөөд тэд сонгуульд оролцох, сонгох эрхээ чөлөөтэй эдлэх сонирхол өндөр байдаг. “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын дүнд гадаад улсад оршин суудаг иргэд сонгуулийг холимог тогтолцоонд тулгуурлан зохион байгуулахыг 46.5-48.8 хувь нь дэмжсэн байна.

Эндээс дүгнэвэл, пропорциональ болон мажоритар тогтолцооны эерэг шинжийг зэрэг агуулсан холимог тогтолцоог сонгох, сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх явдал нь одоо үүсээд байгаа асуудлыг шийдвэрлэх боломжийг олгож байна. Өөрөөр хэлбэл, УИХ-ын сонгуулийг олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулан хэрэглэх нь парламентын чадавх сайжрах, улс төрийн намын тогтолцоо төлөвших, гадаадад сурч, ажиллаж байгаа сонгогчдын эрхийг баталгаажуулах, нийгмийн цөөнхийн төлөөлөл нэмэгдэх ач холбогдолтой. Иймээс сонгуулийн холимог тогтолцоог Монгол Улсын Үндсэн хуульд тусгах хувилбарыг санал болгож байна.

1.3.2. Парламентын гишүүдийн тооны талаар

А. Иргэдийг төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх

Парламент бол иргэд өөрсдийгөө төлөөлүүлэн эрх ашгаа даатгаж, сонгосон итгэмжит төлөөлөгчдийн байгууллага бөгөөд бүх нийтийн хяналтад байдаг хууль тогтоох дээд байгууллага юм.³⁹ Өөрөөр хэлбэл, парламентын гишүүний тоо нь

38 “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа”, Монгол Улсын Их Хурал, (УБ, 2017), 132 дахь тал.

39 “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, Монгол Улсын Их Хурал (УБ, 2023), 58 дахь тал.

иргэдийн төлөөллийг илтгэнэ. Парламентын гишүүний тоог тогтоох зарчим болох Куб язгуурын томьёо (Cube root formula)-г Эстонийн улс төр судлаач Рейн Таагепера анх томьёолсон байна. Парламентын гишүүдийн тоо нь хүн амын тооноос куб язгуур гаргасан тоотой ойролцоо байвал зохимжтой гэсэн үзэл санаа юм. Улс орон бүрийн нийгмийн бүлгийн эрх, ашиг сонирхлыг бүрэн илэрхийлэх төлөөллийн тоог оновчтой тодорхойлохын тулд хүн амын тоог голчлох боловч түүнээс гадна хүн амын нягтаршил, газар нутгийн байдал, уламжлал, парламентын хэлбэр зэрэг хүчин зүйлийг харгалздаг байна. Түүнчлэн нийт хүн амын тоог бус тухайн улсын идэвхтэй хүн ам (хүн амын бичиг үсэгт тайлагдсан хувь болон хүн амын хөдөлмөрийн насны хувь)-ын тоог тооцон гаргах нь зүйтэй гэж аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад үздэг.

Монгол Улсын хувьд ч мөн адил “төлөөлөгч”-ийн тоог тогтоохдоо хүн амын тоог харгалзан тогтоож байсан түүхтэй. Жишээ нь 1924 оны Монгол Улсын Үндсэн хуульд “УИХ бол олон аймаг ба хот, жич ардын цэргийн төлөөлөгчид хуралдах бөгөөд тоог төлөөлөгчид сонгох газрын хүн амын олон, цөөнийг үзэж нэгэн жилийн хугацаагаар сонговол зохино” гэж хуульчилсан бол 1940 оны Үндсэн хуульд “хүн амын 1500 хүн тутамд нэг төлөөлөгч сонгон...”, 1957 оны Үндсэн хуульд “3500 хүн ам тутмаас нэгжгээд депутатаар бодож...”, 1960 оны Үндсэн хуульд “4000 хүн ам тутамд 1 депутат байхаар...” тус тус тооцон төлөөллийн тоог тогтоож байсан. Харин 1992 оны Үндсэн хуулиар УИХ-ын гишүүний тоог тухайн үеийн хүн амын тоонд үндэслэн нэг гишүүн дунджаар 27,000 иргэнийг төлөөлөхөөр тооцоолон 76 гишүүнтэй байхаар хуульчилсан.

1992 онд УИХ-ын нэг гишүүн 29,145 иргэнийг төлөөлж байсан бол 2020 онд УИХ-ын нэг гишүүн 46,178 иргэнийг төлөөлөх болсон бөгөөд тэдний төлөөлөх чадвар сулрах магадлал үүсээд байна. Хэрвээ өмнө дурдсан куб язгуурын томьёонд үндэслэн Монгол Улсын нийт иргэдийг төлөөлөх гишүүний тоог тодорхойлбол, ойролцоогоор 152 гишүүн байхаар байна. Харин аж үйлдвэржсэн гадны улсын жишгээр нийт хүн амын тоонд бус 2,125,000⁴⁰ хөдөлмөрийн насны иргэний тооноос куб язгуур авбал ойролцоогоор 130 гишүүн байхаар байна.

Б. УИХ-ын гишүүдийн ачааллыг тэнцвэржүүлэх

УИХ-ын тухай хуулийн 8.1.2-т зааснаар УИХ-ын гишүүн нь “Байнгын хороонд заавал харьяалагдах” үүрэгтэй. Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, УИХ-ын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй. Одоогийн байдлаар УИХ-ын гишүүд 11 Байнгын хороодод хуваарилагдан ажиллаж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

40 Ажиллах хүчний судалгааны 2022 оны I улирлын товч танилцуулга, Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, (УБ, 2022), Холбоос: <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Labour%20force%202022%20I.pdf&ln=Mn>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

Хүснэгт 1.4. УИХ-ийн 11 байнгын хороодын хуваарилалт

№	Байнгын хороод	Дарга	Гишүүдийн тоо	Гишүүд
1	Нийгмийн бодлогын байнгын хороо	П.Анужин	15	Д.Батлут, Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Ц.Туваан, Ж.Чинбүрэн, С.Чинзориг
2	Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо	Б.Баттөмөр	8	Ш.Адьяашаа, Х.Баделхан, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Бямбацогт, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр, Н.Энхболд
3	Инновац, цахим бодлогын байнгын хороо	Э.Батшугар	10	Э.Бат-Амгалан, Н.Ганибал, Х.Ганхуяг, Т.Доржханд, Ц. Идэрбат, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн, Ч.Ундрам, Н.Учрал, Ж.Чинбүрэн
4	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо	Г.Мөнхцэцэг	15	А.Адьяасүрэн, П.Анужин, Т.Аубакир, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Жаргалмаа, Ц.Мөнхцэцэг, Ч.Ундрам, Н.Учрал, Ж.Чинбүрэн, С.Чинзориг, Л.Энх-Амгалан
5	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Б.Саранчимэг	18	Ц.Анандбазар, Т.Аубакир, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Х.Болорчулуун, Г.Ганболд, Н.Ганибал, Г.Дамдинням, Ц.Идэрбат, Г.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, Д.Өнөрболд, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, Т.Энхтүвшин
6	Төсвийн байнгын хороо	Г.Тэмүүлэн	18	Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Х.Баделхан, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Д.Тогтохсүрэн, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн
7	Эдийн засгийн байнгын хороо	Ц.Цэрэнпунцаг	16	Д.Батлут, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Ч.Ундрам, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, С.Чинзориг, Т.Энхтүвшин
8	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	Б.Энх-Амгалан	15	Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, П.Анужин, Х.Баделхан, Э.Бат-Амгалан, С.Батболд, Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Н.Наранбаатар, Ц.Сэргэлэн, Д.Цогтбаатар, Н.Энхболд
9	Хууль зүйн байнгын хороо	Б.Энхбаяр	18	Ш.Адьяашаа, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Ц.Сэргэлэн, Н.Учрал, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан
10	Төрийн байгуулалтын байнгын хороо	Н.Энхболд	18	А.Адьяасүрэн, С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Ж.Батсуурь, С.Бямбацогт, Г.Ганболд, Т.Доржханд, Г.Занданшатар, Ц.Мөнх-оргил, Ц.Мөнхцэцэг, Х.Нямбаатар, М.Оюунчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар, Д.Тогтохсүрэн, Ж.Эрдэнэбат

11	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо	Т.Энхтүвшин	17	А.Адъяасүрэн, Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Т.Аубакир, Ж.Батжаргал, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Г.Ганболд, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Д.Өнөрболор, Ш.Раднаасэд, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Ж.Эрдэнэбат
----	---------------------------------------	-------------	----	--

Хүснэгт 1.5. УИХ-ын гишүүдийн байнгын хороонд ажиллах давхцал⁴¹

3 байнгын хороонд харьяалагдсан гишүүд	2 байнгын хороонд харьяалагдсан гишүүд	1 байнгын хороонд харьяалагдсан гишүүд
Ц.Мөнх-Оргил, Д.Батлут, Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Ганбаатар, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, Ж.Чинбүрэн, С.Чинзориг, Х.Баделхан, С.Бямбацогт, Н.Энхболд, Э.Бат-Амгалан, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Сэргэлэн, Н.Учрал, А.Адъяасүрэн, П.Анужин, Т.Аубакир, Г.Дамдинням, Ц.Мөнхцэцэг, Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Н.Ганибал, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн, Г.Амартүвшин, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Г.Ганболд, Д.Өнөрболор, Ц.Идэрбат, Ч.Ундрэм	Б.Жаргалмаа, С.Одонтуяа, Ц.Сарангэрэл, Ш.Адъяаа, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр, Т.Доржханд, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Г.Мөнхцэцэг, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин, Ц.Цэрэнпунцаг, Ж.Эрдэнэбат, Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар, Д.Ганбат, Ж.Батсуурь, Л.Мөнхбаатар, Д.Тогтохсүрэн, Н.Алтанхуяг, Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан	Ж.Ганбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Б.Чойжилсүрэн, С.Батболд, С.Амарсайхан, Г.Занданшатар, Х.Болорчулуун

Үүнээс үзвэл, 3 байнгын хороонд харьяалагдсан 37 гишүүн, 2 байнгын хороонд харьяалагдан ажиллаж буй 29 гишүүн, 1 байнгын хороонд гишүүнээр ажиллаж байгаа 7 гишүүн байна.

2020 оноос өмнө УИХ-ын гишүүн хоёроос илүүгүй байнгын хороонд ажиллахыг зөвшөөрдөг байсан бол 2020 онд УИХ-ын тухай хуулийн 26.1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулан Байнгын хороо нь 19 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүн нэгэн зэрэг гурваас илүүгүй Байнгын хороонд харьяалагдан ажиллах болсноор тэдний ажлын ачааллын тэнцвэргүй байдлыг үүсгэлээ.

Түүнчлэн УИХ-ын гишүүдийн олонх нь оролцооноор нэгдсэн чуулганы хуралдаан хүчинтэйд тооцогдож, нийт гишүүний олонхоор буюу 39 гишүүний саналаар хууль баталдаг. Харин УИХ-ын тухай хуулийн 26.1 дэх хэсгийн дагуу Байнгын хороо 19 гишүүнээс бүрдсэн бөгөөд тэдгээр гишүүд санал нэгтэй байх тохиолдолд дээрх асуудал УИХ-ын нэгдсэн чуулганаар батлагдах магадлал өндөртэй бөгөөд УИХ-аас ЗГ-ыг хянах чиг үүрэгт сөрөг нөлөө үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, ЗГ-аас өргөн барьсан хуулийн төслийн батлагдах магадлал ихэсэх юм. Тиймээс УИХ-ын гишүүний тоог нэмэх тохиолдолд УИХ-аас ЗГ-ын үйл ажиллагаанд тавих хяналтын чиг үүрэг сайжрах боломжтой.⁴²

41 УИХ-ын байнгын хороод, Холбоос: <https://www.parliament.mn/cv/?appointmentId=105>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

42 “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, Монгол Улсын Их Хурал (УБ, 2023), 61 дэх тал.

В. Гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн харилцан хяналтыг тэнцвэржүүлэх

Хүснэгт 1.6. Хуульд заасны дагуу батлуулсан МУ-ын Засгийн газрын бүрэлдэхүүн

№	ЗГ-ын бүрэлдэхүүн	Тухайн албан тушаалыг давхар хашдаг УИХ-ын гишүүн
1	Монгол Улсын Ерөнхий сайд	Л.Оюун-Эрдэнэ
2	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Монгол Улсын Шадар сайд	С.Амарсайхан
3	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Монгол Улсын сайд, ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга;	Д.Амарбаясгалан
4	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга;	Х.Булгантуяа
5	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга;	Ж.Сүхбаатар
6	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга;	Б.Бат-Эрдэнэ
7	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;	Ч.Хүрэлбаатар
8	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Гадаад харилцааны сайд;	Б.Батцэцэг
9	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Сангийн сайд;	Д.Жавхлан
10	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд;	Х.Нямбаатар
11	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;	Б.Бат-Эрдэнэ
12	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Батлан хамгаалахын сайд;	Г.Сайханбаяр
13	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайд;	Ц.Даваасүрэн
14	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Боловсрол, шинжлэх ухааны сайд;	Л.Энх-Амгалан
15	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайд;	С.Бямбацогт
16	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Соёлын сайд;	Ч.Номин
17	/Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд;	Ж.Ганбаатар
18	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;	Д.Сарангэрэл
19	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;	Х.Болорчулуун
20	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Цахим хөгжил, харилцаа холбооны сайд;	Н.Учрал
21	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Эрчим хүчний сайд;	Б.Чойжилсүрэн
22	Монгол Улсын ЗГ-ын гишүүн-Эрүүл мэндийн сайд.	Ч.Чинзориг

Дээрхээс үзвэл, ЗГ-ыг 22 сайд бүрдүүлэх бөгөөд тэдгээрийн 16 нь УИХ-ын гишүүний чиг үүргийг давхар хашиж байна. 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “УИХ-ын гишүүн нь Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.” гэх өөрчлөлт оруулснаар УИХ-ын гишүүн ямар нэгэн хязгаарлалтгүйгээр ЗГ-ын гишүүнээр ажиллах боломжтой болсон. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд болон ЗГ-ын дөрвөөс илүүгүй гишүүн УИХ-ын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэх өөрчлөлтийг хийсэн боловч 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Цэцээс дээрх өөрчлөлтийг Үндсэн хуульд нийцэхгүй гэж үзсэн. Цэцийн үндэслэлийг тодруулбал:

“Монгол УИХ-аас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалтаар Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулахдаа “... ЗГ-ын дөрвөөс илүүгүй гишүүн УИХ-ын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэж заасан нь ард түмний сонгосон парламентын тогтолцоог сулруулах, улмаар засаглалын тодорхойгүй байдалд хүргэх эрсдэлийг бий болгон Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд харшилж, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтад тус тус нийцээгүй байна.”

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Энхболд тайлбартаа:

“Дэлхийн улсуудын хууль тогтоомж, туршлагаас харахад парламентын гишүүн нь цөөн тоотой бол хавсран гүйцэтгэхийг хориглох хандлагатай байна. Харьцангуй цөөн гишүүнтэй, нэг танхимтай парламент бүхий Монгол Улсын хувьд парламентын гишүүн ЗГ-ын гишүүнийг хавсран ажиллахыг хатуу хориглох, эсхүл бүрэн нээлттэй байлгах нь онолын хувьд ч, туулж ирсэн туршлагаас үзэхэд ч тохирохгүй нь илэрхий болсон гэж үзэн уг хоёр албан тушаалыг хавсарч болох зохистой заагийг тогтоох үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг «... ЗГ-ын дөрвөөс илүүгүй гишүүн УИХ-ын гишүүний албан тушаалыг хавсарч болно.» гэж өөрчлөн найруулсан. Ингэснээр УИХ, ЗГ-ын чиг үүргийн давхцал арилж, тэдгээрийн чиг үүргийн ялгаа илүү тодорхой болох, бие биеэсээ хараат бусаар Үндсэн хуулиар тогтоосон бүрэн эрхээ гадны ямар нэг нөлөөгүй хэрэгжүүлэх боломж бүрдэнэ, хууль тогтоох-гүйцэтгэх эрх мэдлийн хооронд хяналт-тэнцэл сонгодог утгаараа хэрэгжинэ гэж үзсэн” гэжээ.

Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах үүднээс үүрэг хавсран гүйцэтгэхэд хязгаарлалт тавьсан зохицуулалтыг Үндсэн хуульд нийцэхгүй гэж дүгнэхдээ Цэцээс дараах дүгнэлтийг мөн хийжээ. Үүнд:

“Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу парламентын засаглалыг төгөлдөршүүлэх зорилгоор хүн амын тоонд үндэслэн парламентын гишүүдийн тоог нэмж өөрчлөх, сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох замаар хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн тэнцвэр болон төлөөллийн чадварыг бүрэн хангах асуудлыг шийдвэрлэдэг хандлага парламентын засаглал бүхий улс орнуудад нэгэнт тогтсон байна.”

УИХ-ын гишүүний тоо цөөн байгаа нь дараах үр дагаврыг үүсгэж болно.⁴³

1. УИХ-ын нэг гишүүнд ногдох ачаалал хэт өндөр тул УИХ-аар чанаргүй хууль батлагдах эрсдэлтэй.
2. УИХ-ын нэг гишүүний саналын /кнопын/ эрх хэт хүчтэй байгаа нь УИХ-аас гарах хууль тогтоомж цөөн хүний үзэмжээр батлагдах эрсдэлийг дагуулна.
3. УИХ-ын гишүүдийн тоо хэт цөөн байх нь УИХ-ын хяналт шалгалтын чиг үүргийг бүдгэрүүлж байна.

Иймд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх нэг гарц нь УИХ-ын гишүүдийн тоог нэмэх хувилбар байж болох юм. УИХ-ын гишүүний тоог нэмснээр:

1. УИХ-ын гишүүдийн төлөөлөх чадварыг сайжруулах,
2. Төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангах,
3. УИХ-ын гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх;
4. УИХ-аас баталсан хуулийн чанар, үр нөлөө сайжрах эерэг үр дүнд хүрэх боломжтой гэж үзэж байна.

43 “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, Монгол Улсын Их Хурал (УБ, 2023), 59-63 дахь тал.

Анхаарах зүйл нь УИХ-ын гишүүний тоог хэт ихээр тогтоох тохиолдолд хууль тогтоомж батлах процесс удаашрах, нэгдсэн шийдэлд хүрэхэд бэрх, парламентын болон ажлын албаны зардал нэмэгдэх сөрөг үр дагавар гардаг.⁴⁴

1.4. Хөдөөгийн сэргэлтийг дэмжих, хэт төвлөрлийг сааруулж, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах хүрээнд /13.1./

Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн” гэж тодорхойлсон.

“Төрийн дээд байгууллагууд” гэдэгт:

1. Үндсэн хуулийн 20.1 дүгээр зүйлд зааснаар УИХ⁴⁵;
2. Үндсэн хуулийн 38.1 дүгээр зүйлд зааснаар ЗГ^{46, 47};
3. Үндсэн хуулийн 50.1 дүгээр зүйлд зааснаар Улсын дээд шүүх⁴⁸;
4. Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн тамгын газар;
5. Цэц зэргийг ойлгохоор байна.

Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.2-т “Нийслэл хот нь дараах тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ” гээд 8.2.1-д “УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, УДШ, Цэц, төрийн захиргааны болон төрийн бусад байгууллага, гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх” гэж тусган эдгээр байгууллагыг хэвийн үйл ажиллагааны нөхцөлөөр хангах, тээврийн дэд бүтэц, үндэсний болон олон улсын уулзалт, арга хэмжээ зохион байгуулах, мэдээлэл өгөх зэрэг дотоод чиг үүрэг хэрэгжүүлдэг⁴⁹ ч уг чиг үүргийг хуульд тусгайлан зохицуулах эсэх нь төрийн бодлоготой салшгүй холбоотой байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд нийслэлд суурьшин амьдрах хүн амын тоо эрс нэмэгдэж байна. Энэ байдлаар 2040 он гэхэд Улаанбаатар хотын хүн амын тоо 2.5 сая болж, Монгол Улсын нийт хүн амын 56 хувь нь нийслэл хотод төвлөрч, нэг га талбайд ногдох хүний нягтаршлаар одоо дэлхийд тэргүүлж буй Япон улсын Токио-Ёкохамагийн бүс, 13 дугаарт орж буй БНХАУ-ын Бээжин хотын түвшинд хүрэх төлөвтэй байна. Төвлөрөл эдийн засгийн хувьд эерэг нөлөөтэй гэж үздэг ч Улаанбаатар хотын хувьд хөрс, агаар, усны бохирдол, замын түгжрэл зэрэг сөрөг үр

44 조소영, 국회의원 정수에 관한 헌법적 고찰, 한국비교공법학회, 공법연구 제13권, 2012, 39면.

45 Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг. “УИХ бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгална”.

46 Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг. “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”.

47 ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульд зааснаар 16 яамнаас бүрдэнэ.

48 Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн”.

49 Congress of local and regional authorities of europe, Recommendation 133 (2003) on management of capital cities, <https://rm.coe.int/management-of-capital-cities-rapporteur-mrs-n-shymanska/168071a20e>

дагаврыг бий болгож байна.⁵⁰ Олон улсын жишгийг харахад, дагуул хотыг хөгжүүлж, хэт төвлөрлийг сааруулсан тохиолдол цөөнгүй байна.

Дээр дурдсанаар хот, суурин газрыг чиглэсэн шилжилт, хөдөлгөөн тасралтгүй үргэлжилж байгаа учир нь боловсрол, эрүүл мэнд зэрэг нийтийн үйлчилгээний хүртээмжтэй шууд холбоотой. Мөн ажлын байрны хүртээмж, орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх боломж нь хөдөөгөөс хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнд шууд хамааралтай бөгөөд хөдөө орон нутагт эдийн засгийн чадавх бүрдээгүй байна.⁵¹

Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд “Алсын хараа 2050” бодлогын баримт бичигт “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ”, “олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлэх”, “Дагуул, хаяа хот, тосгоныг тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Уг зорилтын хүрээнд их дээд сургууль, хотын захиргааны байгууллага зэргийг хотын зах руу шилжүүлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байна.

Гэвч зөвхөн Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлэх бус, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хөдөө орон нутгийн сэргэлтийг дэмжих үүднээс Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх”, “Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд төсөв, санхүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх” зэрэг арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Иймд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуй нэгжид төрийн үйлчилгээг ойртуулах, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах үүднээс төрийн эрх барих байгууллагыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалт шаардлагатай.

Явцын дүгнэлт

Цэцийн гол чиг үүрэг нь Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих явдал бөгөөд иргэний үндсэн эрхийг хамгаалах гол хэрэглүүр болдог. Гаднын зарим улсын жишгийг харахад иргэн өөрийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд хандаж эрхээ сэргээлгэх зарчим нийтлэг үйлчилдэг.⁵²

Гэвч Монгол Улсад Цэцээс үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаарх маргааныг хянан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна. Иймд Цэцийн хяналтын загварыг өөрчилж, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэний өргөдлийг хянан шийдвэрлэх эрх зүйн орчныг бий болгох, ингэхдээ Цэцийн ачаалал, хэрэг маргаан

50 ММСГ, “Хот хөдөөгийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах арга хэмжээний санал боловсруулах ажлыг гүйцэтгэлээ”, 2021.04.11, Холбоос: <https://mmcg.mn/%D1%85%D0%BE%D1%82-%D1%85%D3%A9%D0%B4%D3%A9%D3%A9%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D1%8D%D0%BD%D1%86%D0%B2%D1%8D%D1%80%D0%B8%D0%B9%D0%B3-%D1%85%D0%B0%D0%BD%D0%B3%D0%B0%D1%85-%D1%82%D3%A9%D0%B2%D0%BB/>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

51 “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, Монгол Улсын Их Хурал (УБ, 2023), 107 дахь тал.

52 Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 119 дэх тал.

шийдвэрлэлтийн чанарын асуудлыг анхаарч, өргөдөл гаргах тодорхой “босго” тогтоох шаардлага байна гэж үзлээ.

Түүнчлэн, УИХ дахь цөөнх гишүүдийн болон Комиссын Цэцэд хүсэлт гаргах эрх зүйн боломжийг бүрдүүлэх нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөх тохиолдолд түүнд дээд хяналтыг тавих Цэцийн үндсэн чиг үүрэгт нийцнэ. Мөн Цэцийн гишүүний хараат бус байдлыг хангах, улс төрийн нөлөөллөөс ангид байлгах зорилгоор Цэцийн гишүүний дахин томилгоог хязгаарлах, холбогдох зохицуулалтыг тодорхой болгох шаардлага байна.

Иргэд Үндсэн хуульд заасан эвлэлдэн нэгдэх эрхийнхээ хүрээнд улс төрийн нам байгуулж болох боловч, сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд буюу 20,000 сонгогч нэгдсэн тохиолдолд улс төрийн намыг бүртгэх урьдчилсан нөхцөл бүрдэнэ. Энэ нь улс төрийн олон ургалч үзлийг алдагдуулах, төлөөллийн ардчиллыг сулруулах, нийгмийн цөөнхийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах тэдний төлөөллийг үгүйсгэх тэгш бус байдлыг үүсгэх сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй.

Сонгуулийн тогтолцооны хувьд Монгол Улс сонгуулийн мажоритар тогтолцоог хэрэгжүүлж байгаа нь сонгогчдын санал гээгдэх, улс төрчид улсын ашиг сонирхлоос илүүтэй тойргийн ашиг сонирхлыг өндөрт тавигдах зэрэг сөрөг үр дагавар үүсэж байгаа тул сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэн сонгогчдын санал гээгдэх, улс төрийн тойргийн үзэл суртлаас ангижрах, цөөнхийн төлөөллийг улс төрд оруулах эрх зүйн орчин бүрдүүлэх нь зүйтэй. Үүний зэрэгцээ парламентын гишүүний тоог тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж оновчтой тодорхойлон парламентын гишүүдийн төлөөлөх чадварыг сайжруулах, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангах, УИХ-ын гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, УИХ-аас баталсан хуулийн чанар, үр нөлөөг сайжруулах хэрэгцээ байна. Парламентын гишүүний тоог нэмэгдүүлэхдээ төлөөллийн чадварыг харгалзан оновчтой тодорхойлох хэрэгтэй. Учир нь парламентын гишүүний тоог хэт ихээр тогтоох тохиолдолд хууль тогтоомж батлах процесс удаашрах, нэгдсэн шийдэлд хүрэхэд бэрх, парламентын болон ажлын албаны зардал нэмэгдэх сөрөг үр дагавар үүсэж болзошгүй.

Мөн сүүлийн үед нийгэмд шүүмжлэл дагуулж буй хотын байгаль орчны бохирдол, хот, хөдөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцвэргүй байдлыг шийдвэрлэхийн тулд төрийн эрх барих байгууллагыг нийслэлээс гарган Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.

II. ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлахдаа тус хуулийн 13.2.6-д заасны дагуу шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаар судалгаа хийхээр тусгасан байна.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлахдаа дараах 3 улсыг сонгон судаллаа.

2.1. БНСУ

БНСУ-ын Үндсэн хуулийн Зургадугаар бүлэгт Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудал, гишүүний томилгоо, шийдвэр гаргах процесс болон Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар тусгасан бөгөөд энэхүү зохицуулалтыг үндэслэн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна.

2.1.1. Үндсэн хуулийн шүүхэд холбогдох зүйл заалтын хүрээнд

А. Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн эрхийн зөрчлийг хянах нь

Үндсэн эрхэд халдах магадлалтай субъект нь төр байдаг. Учир нь аливаа захирамжилсан шийдвэр нь үндсэн эрхэд чиглэдэг ба үүнийг төр, албан тушаалтан л гаргах боломжтой тул үндсэн эрхийг гагцхүү эдгээр шийдвэрээр зөрчих магадлал байдаг, иймд улс орнуудад хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагаас гарч байгаа аливаа шийдвэр /халдлага/-ийг үндсэн эрх зөрчсөн эсэхийг хянах боломж бүрдсэн байх ёстой.⁵³ Одоо ч иргэн Үндсэн хуулийн эрхээ хамгаалуулахаар хандах олон боломжийг нээх шаардлага байсаар байгааг судлаачид дурдсан байдаг.⁵⁴ Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлээс харахад цөөн тооны л шийдвэр хянах боломжтой бөгөөд хохирсон иргэн нь энэхүү хуульд заасан эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн эсэхийг хянуулах боломж хумигдмал тул иргэдийн үндсэн эрх хамгаалах чиглэлд Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээг дутмаг гэж судлаачид үздэг.⁵⁵

Харин Солонгос Улсын Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаанд “Нун-Ма” буюу Үндсэн эрх зөрчигдсөн талаарх иргэний гомдол, “Нун-Ва” буюу шүүхийн хэрэглэж буй хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх иргэний гомдол зэрэг багтдаг байна.

Үндсэн хуулийн 111 дүгээр зүйлд зааснаар Үндсэн хуулийн шүүхийн чиг үүрэгт дараах чиг үүргүүд хамаарах үүнд:

- Ердийн хууль Үндсэн хуультай нийцэж буй эсэх;
- Албан тушаалаас огцруулах (Импичмент);

53 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн хяналтын Монгол загвар Үндсэн эрхийн хамгаалал ба эрх мэдлийн тэнцвэр*, “Үндсэн хуулийн эхийн баригч - Б.Чимид, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл”, (УБ, 2020), 75 дахь тал.

54 Арне Мавбич, *“Үндсэн хуулийн хяналт”*, Орч. Г.Баясгалан, Д.Одбаяр, Д.Сугар, (УБ, Мэргэн Их Монгол, 2014), 61 дэх тал.

55 Мөн тэнд, 78-79, 83 дахь тал.

- Улс төрийн намыг татан буулгах;

Төрийн байгууллага, төрийн байгууллага, орон нутгийн байгууллага хоорондын, болон орон нутаг хоорондын эрх мэдлийг хянах;

Иргэдээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх зэрэг асуудал багтдаг.

Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн эрх мэдлийн үйлчлэл, эс үйлчлэлээс үүдэн Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд шүүхийн процедур дамжлагагүйгээр Үндсэн хуулийн шүүхэд шууд хандаж болно. Гэхдээ бусад хуульд зөрчигдсөн эрхийг сэргээх процесс байгаа тохиолдолд тухайн шүүх процессыг дуусгасны дараа гомдол гаргаж болно.”, 68.2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 41.1 дэх хэсэгт⁵⁶ заасан хууль Үндсэн хуультай нийцэж буй эсэх маргааныг хүлээн аваагүй тохиолдолд эрх нь зөрчигдсөн тухайн этгээд Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргаж болно.” гэж заажээ.

Түүнчлэн ердийн шүүх Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд иргэн Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах эрхтэй байдаг нь тус улсын Үндсэн хуулийн шүүхийн бусад улсын шүүхээс ялгагдах онцлогийн нэг юм.⁵⁷

Иргэн бичгээр гомдол гаргахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Гомдол гаргагч болон түүний өмгөөлөгчийн талаарх мэдээлэл;
2. Зөрчигдсөн эрх;
3. Эрх зөрчихөд хүргэсэн төрийн эрх мэдлийн үйлчлэл, эс үйлчлэл;
4. Хүсэлт гаргах болсон шалтгаан;
5. Шаардлагатай бусад асуудал зэрэг багтана.⁵⁸

Б. Үндсэн хуулийн шүүхэд хандах субъект

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхэд иргэн, нэр бүхий байгууллага, албан тушаалтан хүсэлт гаргаж болдог. Гэхдээ эдгээрийг Үндсэн хуулиар нэг бүрчлэн тодорхойлоогүй бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааны хүрээг тодорхойлох замаар заасан байдаг. Эдгээрийг дор дэлгэрүүлэн авч үзье.

1. Ердийн хууль Үндсэн хуультай нийцэж буй эсэх

Хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлыг Үндсэн хуулийн шүүхэд гурван аргаар гаргаж болно.⁵⁹ Нэгд, ердийн шүүх хууль тогтоомжийн аливаа заалтыг Үндсэн хууль зөрчсөн байх магадлалтай гэж үзсэнээр Үндсэн хуулийн шүүхэд шийдвэрлүүлэхээр өөрийн шийдвэрээр, шууд хүсэлт гаргаж болно. Мөн тухайн

56 Constitutional Court law, Article 41.1. If the constitutionality of a statute is precondition of the judgment of a case, the ordinary court which takes charge of the case (including the military court; hereinafter the same shall apply) shall request adjudication on the constitutionality of the statute to the Constitutional Court, ex officio or by its decision upon a motion of a party.

57 Г.Билгүүн, “Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх харьяалал (Харьцуулсан судалгаа)”, *Эрх зүй” сэтгүүл* №4, (2020), 345 дахь тал.

58 Constitutional court act of the Republic of Korea, 2018, Article 71.

59 Hyowon Lee, A Constitutional Review Model: The Case of Korea, (2020), 42 дахь таль, Холбоос: https://nagoya.repo.nii.ac.jp/record/30824/files/caledp_19_37.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

хэргийн оролцогч талуудаас гаргасан дуудлагыг (call) шүүх үндэслэл бүхий гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд хандан ердийн шүүхээс хүсэлт гаргадаг байна. Харин ердийн шүүх талуудын дуудлагыг үндэслэлтэй гэж үзээгүй, татгалзсан тохиолдолд тухайн талууд Үндсэн хуулийн шүүхэд шууд гомдол гаргаж болно. Мөн энэ гомдлыг шүүхийн шийдвэрийн эсрэг бус, зөвхөн хуулийн эсрэг гаргасан байх ёстой.

2. Албан тушаалаас татан буулгах (Импичмент)

Үндсэн хуулийн 65.2-т зааснаар Ерөнхийлөгчөөс бусад 65.1-д заасан төрийн албан тушаалтнуудыг огцруулах саналыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн гуравны нэг буюу түүнээс дээш нь санал болгож, Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхын саналаар нэгэн зэрэг санал өгч батална. Харин Ерөнхийлөгчийг огцруулах саналыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхын санал болгосноор, Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн гуравны хоёр буюу түүнээс дээш хувийн саналаар дэмжинэ. Харин энэхүү асуудлыг албан тушаалаас татан буулгах тухай тогтоолын хүчин төгөлдөр хуулбараар Үндсэн хуулийн шүүх хянан шийдвэрлэх эрхтэй юм.⁶⁰

3. Улс төрийн намыг татан буулгах

Хэрэв улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нь ардчиллын үндсэн зарчимд харшлах юм бол Засгийн газар Төрийн зөвлөлөөр хэлэлцсэний үндсэн дээр улс төрийн намыг татан буулгах тухай хүсэлтийг Үндсэн хуулийн шүүхэд гаргаж болно.⁶¹ Хууль зүйн яам нь Гүйцэтгэх засаглалын нэрийн өмнөөс улс төрийн намыг татан буулгах өргөдлөө гаргадаг.⁶²

4. Төрийн байгууллага хоорондын, төрийн байгууллага ба орон нутгийн байгууллага хоорондын, орон нутаг хоорондын эрх мэдлийг хянах

Төрийн байгууллага хоорондын, төрийн байгууллага ба орон нутгийн засаг захиргаа, эсхүл орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын бүрэн эрхийн талаар маргаан гарсан тохиолдолд, төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаа бүрэн эрхийн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж болно.

5. Иргэдээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх

Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой маргааныг өмнөх хэсгээс дэлгэрүүлж үзэх боломжтой.

Харин БНСУ-ын Хүний эрхийг хамгаалах комиссоос Хүний эрхийг хамгаалах, сайжруулахад нөлөөлөхүйц хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа тохиолдолд шүүх, Үндсэн хуулийн шүүхийн хүсэлтээр буюу Комисс шаардлагатай гэж үзвэл de jure буюу хуулийн дагуу гаргасан дүгнэлтээ эрх бүхий шүүхэд эсвэл Үндсэн хуулийн шүүхэд танилцуулж болохоор байна.

Дүгнэвэл, БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхэд маргааны төрлөөс хамаараад ердийн шүүх, хэргийн оролцогч талууд, Үндэсний ассамблей (төрийн албан

60 Constitutional court act of the Republic of Korea, Article 26.1.

61 Constitutional court act of the Republic of Korea, Article 55.

62 Hyowon Lee, A Constitutional Review Model: The Case of Korea, (2020), 45 дахь тал, Холбоос: https://nagoya.repo.nii.ac.jp/record/30824/files/caledp_19_37.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

тушаалаас огцруулах тухайд нийт гишүүдийн 1/3 -ийн санал болгосноор нийт гишүүдийн олонх, ерөнхийлөгчийн хувьд нийт гишүүдийн олонхын санал болгосноор 2/3 нь батална.) Засгийн газар (Хууль зүйн яам), төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаа, иргэн зэрэг субъектүүд хүсэлт гарган хандах эрхтэй байна. Харин Хүний эрхийн үндэсний комисс нь дээр дурсан таван асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гарган хандах тохиолдлыг Үндсэн хууль болон бусад хуулиар тухайлан зохицуулаагүй байна.

В. Үндсэн хуулийн шүүхийн гишүүний томилгоо

Үндсэн хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу Үндсэн хуулийн шүүх нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд гурвыг нь Ерөнхийлөгч, гурвыг нь Үндэсний ассамблейгаас, гурвыг нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нэр дэвшүүлж Ерөнхийлөгч томилдог. Ийнхүү томилохдоо БНСУ-ын Үндсэн хуулийн шүүгч нь шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр эсхүл Төрийн байгууллагын удирдлагын тухай хуульд заасны дагуу төрийн байгууллага, төрийн болон нийтийн өмчит байгууллага болон бусад аж ахуйн нэгжид хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байсан, эсхүл магадлан итгэмжлэгдсэн коллеж, их дээд сургуулийн хуулийн туслах профессортой тэнцэх буюу түүнээс дээш албан тушаалын аль нэгийг 15 ба түүнээс дээш жил хашсан, 40 ба түүнээс дээш насны иргэнийг Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр томилно.⁶³

Мөн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа нь 6 жил бөгөөд улируулан томилох боломжтой.⁶⁴ Ийнхүү Үндсэн хуулийн шүүхийн гишүүнийг улируулан ажиллуулж болохоор зохицуулж байгаа нь шүүгчдийн насжилт өндөрсөх, хараат бус байдал алдагдах сул талтай.⁶⁵

2.1.2. Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангах хүрээнд

БНСУ-ын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлд улс төрийн нам байгуулахтай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

Наймдугаар зүйл. Улс төрийн нам

- Намыг сайн дураар байгуулах бөгөөд олон намын тогтолцоотой байна.
- Намын зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан зарчимд тулгуурласан байх бөгөөд иргэн улс төрийн үйл хэрэгт оролцоход дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын хэлбэртэй байна.
- Нам нь хуульд заасны дагуу улсын хамгаалалтад байх ба улсаас хуульд заасан үндэслэлээр үйл ажиллагааны төсвийн туслалцаа үзүүлж болно.
- Намын зорилго, үйл ажиллагаа нь ардчиллын үндсэн зарчимд харшилж байвал ЗГ-аас Үндсэн хуулийн шүүхэд тараах тухай шаардлага гаргаж, нам нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр тарна.

63 Constitutional court act of the Republic of Korea, 2018, Article 5.

64 Constitution of the Republic of Korea, Article 112.

65 김종일, 미국 연방대법관의 종신제에 관한 검토, 우리나라 헌법재판관의 임기와 관련하여, 한국공법학회, (공법연구, 2014), 72면.

Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг үндэслэн Улс төрийн намын тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна. Уг хуулийн 2 дугаар зүйлд зааснаар намыг нийслэл /Сөүл/-д байрлах “төв нам” болон тусгай хот, аймгийн зэрэглэлтэй хот, аймаг/орон нутаг/-т байрлах хот, аймгийн нам гэж ангилна. “Төв нам” нь Үндэсний Сонгуулийн хороонд бүртгүүлснээр байгуулагдана. Энэ тохиолдолд Сонгуулийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу нам нь 5-аас дээш хот, аймагт намын төлөөлөлтэй байна. Хот, аймгийн нам нь 1.000-аас дээш намын гишүүнтэй байх /Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйл/ бөгөөд тухайн хот, аймагт харьяалагддаг байна /Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйл/. Нам байгуулах зөвлөл нь төв намын хувьд 200-аас дээш гишүүн, хот, аймагт 100-аас дээш гишүүнээс бүрдэнэ /Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйл/.

Дээрхээс үзвэл, Үндсэн хуульд нам байгуулахад гишүүдийн тооны талаар тусгайлан тусгаагүй бөгөөд үүнийг Улс төрийн намын тухай хуулиар нарийвчлан зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, Улс төрийн намын тухай хуулиар нам байгуулахад гишүүдийн тоонд шаардлага тавигддаг бөгөөд багадаа орон нутгийн намын 5000, төв намын 200, нийтдээ 5200 гишүүнтэй байхыг шаардана. Түүнчлэн улс төрийн намыг үүсгэн байгуулах ажлыг хариуцах урьдчилсан зөвлөл нь багадаа 700 гишүүнээс бүрдэнэ.

БНСУ нь 52 сая орчим иргэдтэй бөгөөд үүнээс сонгуулийн насанд хүрсэн буюу сонгогчдын нэгдсэн жагсаалтад бүртгэгдсэн иргэдийн тоо дунджаар 42,247,491 байна.

Хүснэгт 1.7. БНСУ-ын сонгогчдын жагсаалтад бүртгэгдсэн иргэдийн тоо

№	Сонгууль	Огноо	Бүртгэгдсэн иргэдийн тоо
1	South Korean Presidency	3/9/2022	44,197,692
2	South Korean National Assembly	4/15/2020	43,994,247
3	South Korean Presidency	5/9/2017	42,479,710
4	South Korean National Assembly	4/13/2016	42,100,398
5	South Korean Presidency	12/19/2012	40,507,842
6	South Korean National Assembly	4/11/2012	40,205,055

Дээрх тооны сонгуулийн насанд хүрсэн иргэдтэй гэж үзвэл улс төрийн нам байгуулахад 5200 гишүүнтэй байх шаардлага нь сонгуулийн эрх бүхий иргэдийн 0.012 хувьтай тэнцүү байгаа юм.

2.1.3. Сонгуулийн тогтолцоо болон парламентын төлөөллийг сайжруулах хүрээнд

А. Сонгуулийн тогтолцоо

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн албаны сонгуулийн тухай хуулийн дагуу Үндэсний Ассамблейн нийт 300 гаруй гишүүний 253 нь орон нутгийн тойргийн төлөөлөгчдийн саналын хуудсаар, үлдсэн 47 нь хувь тэнцүүлсэн санал хураалтаар сонгогддог. Эдгээр суудлыг улс төрийн намуудад санал өгсөн нийт хүчинтэй саналын гурваас доошгүй хувийг авсан, эсвэл тойрогт тав ба түүнээс дээш мандат авсан тохиолдолд тойрогт авсан саналаар нь хувь тэнцүүлэн хуваарилна.

Б. Парламентын гишүүдийн тооны талаар

Тухайн улсын хувьд жижиг парламенттай байх нь хууль тогтоогчид хоорондын харилцааны сувгийг багасгаж, улмаар хууль тогтоох чиг үүргийг хялбарчлах боловч сонгогчидтой харилцах сувгийг нэмэгдүүлдэг.⁶⁶ Эсрэгээрээ том парламенттай байх нь сонгогчидтой харилцах сувгийг хумих ба төлөөллийг сайжруулах боловч бусад хууль тогтоогчидтой харилцах сувгийг нэмэгдүүлэх замаар хууль боловсруулах үйл явцыг үр ашиггүй болгодог.⁶⁷

БНСУ-ын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн (2) дахь хэсэгт Үндэсний Ассамблейн гишүүдийн тоог хуулиар тогтоох бөгөөд 200-аас доошгүй байхаар зааж өгсөн. Өнөөгийн байдлаар Үндэсний Ассамблей нь 300 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. БНСУ-ын нийт хүн ам 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 51,392,090⁶⁸ байх бөгөөд хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулж үзвэл нэг гишүүний төлөөлөх иргэдийн тоо ойролцоогоор 171,307 болж байна. Солонгос улсын парламентын гишүүдийн тоо сонгууль бүрээр харилцан адилгүй өөрчлөгдөж ирсэн бөгөөд Үндэсний ассамблейн 4 дүгээр сонгуулиар сонгуулийн холимог тогтолцоонд шилжиж, гишүүдийн тоо сонгуулийн тойргоос хамаарч өөрчлөгдөх болсон байна. Тухайлбал 6, 7 дугаар сонгуульд гишүүдийн тоо 175 хүртэл буурч байсан ба дараагийн сонгуулиас эхлэн тасралтгүй өсөж 299-300 гишүүний тоогоор тогтворжсон байна.⁶⁹

2.1.4. Хэт төвлөрлийг сааруулахад Үндсэн хуулийн зохицуулалтын нөлөө

БНСУ-ын Үндсэн хуульд тус улсын нийслэлийн эрх зүйн байдлыг зохицуулаагүй бөгөөд заншлын хэм хэмжээгээр тодорхойлогдож байна. Тус харилцааг “Орон нутгийн удирдлагын тухай хууль”⁷⁰ болон “Нийслэл болох Сөүл хотын захиргааны тухай хууль”-иар зохицуулдаг.⁷¹ 1975 онд Сөүл хотын хүн амын тоо 6.9 сая болж, орон сууцны хомсдол, замын түгжрэл, орчны бохирдол, нийтийн үйлчилгээний ачаалал үүссэнээр төвлөрлийг сааруулах зохицуулалтыг 1970 оноос эхлэн хийж эхэлсэн. Тухайлбал, шилжилт хөдөлгөөнийг хориглох, Сөүл хотын оршин суугчдад оршин суух татвар ногдуулах тухай хууль баталж, үйлдвэр барихад торгуулийн татвар ногдуулах, их сургуульд суралцах үндэслэлээр Сөүл хот уруу шилжин суурьшихыг хориглох, сургалтын төлбөрийг ялгаатай тогтоох, бүс нутгийн их сургуулиудын үнэлэмж, ялгааг бууруулах зорилгоор үндэсний их сургуулиудын хооронд багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдыг орон нутагт шилжин ажиллахыг дэмжих бодлого хэрэгжүүлсний үр дүнд Сөүл хотод төвлөрөх хандлага эрс буурч, 1990-ээд онд шилжих хөдөлгөөн бараг зогссон. Нөгөө талдаа Инчон зэрэг дагуул хотуудад татварын таатай нөхцөл бүрдүүлж, аж ахуйн нэгжүүдийг

66 Г.Билгээ, Д.Халиун, *Парламентын сонгуулийн тогтолцоо, парламентын гишүүдийн тоо ба түүнийг тогтоох, тооцох зарчим* (СТ-22/405), “Парламент” судалгааны эмхэтгэл, боть 40, 383 дахь тал.

67 Г.Билгээ, Д.Халиун, *Парламентын сонгуулийн тогтолцоо, парламентын гишүүдийн тоо ба түүнийг тогтоох, тооцох зарчим* (СТ-22/405), “Парламент” судалгааны эмхэтгэл, боть 40, 383 дахь тал.

68 South Korea population, <https://www.worldometers.info/world-population/south-korea-population/>.

69 조소영, 국회의원 정수에 관한 헌법적 고찰, 한국비교공법학회, 공법연구 제13권, 2012, 43면.

70 Local Authority Act of Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44511&lang=ENG

71 Act on special cases concerning the administration of seoul special metropolitan city, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=47153&type=sogan&key=15, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

дэмжин хөгжүүлж эхэлсэн байдаг.⁷²

Мөн төрийн захиргааны байгууллагын төвлөрлийг бууруулах үүднээс 2010 онд “Сэжон бие даасан тусгай хот байгуулах тухай хууль”-ийг баталсан. Уг хуулийн 1 дүгээр зүйлд “Захиргааны нэгдсэн хот болох Сэжон бие даасан тусгай хотыг байгуулснаар нийслэл дэх төвлөрлөөс үүсэх сөрөг үр дагаврыг бууруулж орон нутгийн хөгжил, улсын тэнцвэрт хөгжил, улсын өрсөлдөөний чадамжийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорино.” хэмээн хуулийн зорилгыг тусгажээ. Сэжон хотыг байгуулснаас хойш 1 жилийн үр дүнг үзвэл газар нутгийн хувьд Сөүл хотын газар нутгийн 2/3 хэмжээнд хүрсэн бөгөөд 20,000 гаруй оршин суугч төвлөрсөнтэй уялдан эдийн засгийн өсөлт 10 хувиар, төрийн албан хаагчдын тоо 1,072 болж өссөн байна. Үүнийг хүснэгтээр тодруулбал:

Хүснэгт 1.8. Сэжон хот байгуулагдсанаас хойших өөрчлөлт⁷³

	Байгуулагдахаас өмнө	Байгуулагдсаны хойш 1 жилийн дараа	Байгуулагдсаны хойш 3 жилийн дараа
Захиргааны нэгж	1 иеп /읍/ 7 мёон /면/	1 иеп /읍/ 9 мёон /면/ 1 дун /동/	1 иеп /읍/ 9 мёон /면/ 3 дун /동/
Газар нутаг	361.41 км	464.8 км	465 км
Төсөв	3,351 тэрбум вон	6,715 тэрбум вон	9,676 тэрбум вон
Эдийн засгийн бие даасан байдал	29.1%	38.8%	43.91%
Төрийн албан хаагчийн тоо	625 хүн	1,072 хүн	1,415 хүн
Оршин суугчдын тоо	100,946	116,842	197,379
Өрхийн тоо	42,606	47,902	75,849
Боловсролын байгууллага	Бага сургууль 17, дунд сургууль 7, ахлах сургууль 4	Бага сургууль 22, дунд сургууль 10, ахлах сургууль 7	Бага сургууль 26, дунд сургууль 13, ахлах сургууль 8
Авто машины бүртгэл	37,002	50,400	67,880
Аж ахуй эрхлэгч	472	632	761
Үйлдвэрлэлийн бүс	7	10	13

Төрийн байгууллагыг нийслэлээс гарган шинээр захиргааны хот байгуулсны дүнд орон нутгийн хөгжилд түлхэц үзүүлэхийн сацуу нийслэл хот Сөүлийн төвлөрлийг шийдэхэд тодорхой хэмжээний түлхэц үзүүлсэн байна.

2.2. ХБНГУ

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийг эрх зүйн онол, практик хэрэглээ талаас нь тайлбарлаж, тодорхой хэрэг маргаанд хэрэглэдгээрээ онцлогтой.⁷⁴ Түүнчлэн ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх хүний үндсэн эрхийн хязгаарлалтын асуудлыг нарийвчлан хэлэлцэж шийдвэрлэдэг байна.

72 Хот хөдөөгийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах арга хэмжээний санал боловсруулах ажлыг гүйцэтгэлээ, 2021.04.11, www.mmcg.mn, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

73 최진혁, 지방분권과 지역균형발전에 따른 세종특별자치시의 발전과제: 정부부처 이전을 중심으로, 충남대학교 사회과학연구소, 사회과학연구 제26권, 2015, 153면.

74 Т.Алтангэрэл, “Үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх нь: ХБНГУ-ын туршлага”, Эрдэм шинжилгээний нийтлэл, (УБ, 2022) Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?fbclid=IwAR2qdimLTBOVAI16ipMZPiDjm4>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

2.2.1. Үндсэн хуулийн шүүхтэй холбогдох зүйл заалтын хүрээнд

А. Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн эрхийн зөрчлийг хянах нь

Үндсэн хуулийн 93 дугаар зүйлд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн чиг үүргийг зохицуулсан байдаг. 93.1.4а дугаар зүйлд хүний субъектив үндсэн эрхийг Үндсэн хуулийн шүүх хамгаалах талаар тусгажээ. Үүний дагуу Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг⁷⁵, 33⁷⁶, 38⁷⁷, 101⁷⁸, 103⁷⁹ болон 104⁸⁰ дүгээр зүйлд заасан эрхийг эсхүл эрх бүхий төрийн байгууллагын үйл ажиллагаа, эс үйлдлээс үндсэн эрх нь зөрчигдсөн этгээд үндсэн хуулийн гомдол гаргаж болно. Хуульд заасны дагуу Үндсэн хуулийн гомдлыг гаргасан тохиолдолд Холбооны Үндсэн хуулийн шүүх нь гомдлын Үндсэн хуулийн зөрчлийг хянахаас гадна Үндсэн хуулийн эрх зүйн бусад зөрчил байгаа эсэхийг давхар хянадаг байна.⁸¹

Б. Үндсэн хуулийн шүүхэд хандах субъект

ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх бүхий субъектийг хуулиар багцлан тодорхойлоогүй. Харин Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг ерөнхийлөн томъёолох зарчмаар заасан байдаг.⁸² Холбооны Үндсэн хуулиар Үндсэн хуулийн шүүхийн гол чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. 93 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар Холбооны улсын Үндсэн хуулийн шүүх нь Холбооны улсын дээд байгууллагын эсвэл Үндсэн хуулиар болон Холбооны улсын төрийн дээд байгууллагын дэгээр бие даасан эрхээр хангагдсан бусад оролцогчдын эрх мэдлийн маргааныг Үндсэн хуулийг тайлбарлах замаар хянан шийдвэрлэдэг. Үүний дагуу Холбооны Ерөнхийлөгч, Бундестаг, Бундесрат, Холбооны ЗГ, Холбооны канцлер болон Бундестагийн гишүүдийн хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэх бөгөөд эдгээр субъектүүд уг асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй.
2. 93 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасны дагуу Холбооны улсын хууль тогтоомж эсвэл муж улсын хууль тогтоомж Үндсэн хуультай агуулгын болон хэлбэрийн хувьд нийцэж байгаа эсэх, түүнчлэн муж улсын хууль тогтоомж Холбооны улсын бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаарх аливаа маргаантай асуудлыг Холбооны ЗГ-ын, муж улсын ЗГ-ын эсхүл Бундестагийн гишүүдийн дөрөвний нэгийн гаргасан хүсэлтээр; Мөн зүйлийн 2а-д 72 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн шаардлагыг тухайн хууль хангасан эсэх талаар үүссэн маргааныг Бундесратын эсвэл аль нэг муж улсын ЗГ-ын эсвэл Муж улсын ард түмний төлөөллийн байгууллагын хүсэлтээр холбогдох маргааныг хянан шийдвэрлэхээр тус тус заасан байна.

75 Улсын бүх эрх мэдэл ард түмнээс эх үндэстэй байхтай холбоотой зохицуулалт.

76 Үндсэн эрхийг тэгш эдлүүлэх болон нийтийн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зохицуулалт.

77 Сонгох, сонгогдох үндсэн эрхийн зохицуулалт.

78 Хуулиас гадуур шүүх байгуулахыг хориглохтой холбоотой зохицуулалт.

79 Шударгаар шүүлгэх эрх болон эрүүгийн эрх зүйн шударга ёсны зохицуулалт.

80 Халдашгүй байх үндсэн эрхийн зохицуулалт.

81 Г.Билгүүн, *Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх харьяалал (Харьцуулсан судалгаа)*, “Эрх зүй” сэтгүүл №4, (УБ, 2020), 342 дахь тал.

82 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 149 дэх тал.

3. Үндсэн хуулийн 100.1 дүгээр зүйлд зааснаар ердийн шүүх хэрэг шийдвэрлэх явцад хэрэглэгдэх гол хууль нь Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн хэргийг түдгэлзүүлэх ба үүнд муж улсын Үндсэн хуулийг зөрчсөн тухай асуудал тавигдсан бол тухайн муж улсын Үндсэн хуулийн шүүхэд, харин энэхүү Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг Холбооны улсын Үндсэн хуулийн шүүхэд тус тус хандан шийдвэрлүүлэхээр заасан. Үүнээс үзэхэд шүүх Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх бүхий субъект болж байна.
4. Өмнөх хэсэгт авч үзсэнчлэн Үндсэн хуулийн 93.1.4 дэх хэсэгт заасны дагуу иргэд (үүнд гадаадын харьяат мөн орно.) Үндсэн хуулийн шүүхэд зөрчигдсэн субъектив эрхээ сэргээлгэхээр хандах боломжтой.
5. Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуульд харш нам⁸³-ын талаар, 21.3 дугаар зүйлд намд төрийн санхүүжилт олгохгүй байх тухай тодорхойлсон байдаг ба 21.4 дүгээр зүйлд заасны дагуу эдгээр асуудлыг Холбооны Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэх чиг үүрэгтэй. Харин эдгээр асуудлын талаар Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх бүхий субъект нь Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 43.1-д зааснаар Бундестаг, Бундесрат болон Холбооны ЗГ байна.

ХБНГУ-ын Хүний Эрхийн Хүрээлэн (GIHR) нь хүний эрхийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд голчлон бодлогын талаас зөвлөгөө өгөх, дотоод болон олон улсын хэмжээний хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх замаар хүний эрхийг хамгаалдаг.⁸⁴ GIHR нь ХБНГУ-ын холбооны бүтцийн бүх түвшний бодлого, хууль тогтоогчид, иргэний нийгмийн оролцогчдод бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн дүн шинжилгээ, мониторингийн тайлан, семинар, хүний эрхийн боловсрол, сургалтын хөтөлбөр бэлтгэх зэрэг олон хэлбэрээр хүрдэг.⁸⁵ Цаашилбал, GIHR нь ХБНГУ болон олон улсын хэмжээнд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад чухал ач холбогдолтой шүүхийн маргаанд гуравдагч этгээдээр хөндлөнгөөс оролцдог (*amicus curiae*).⁸⁶ Мөн Холбооны ЗГ-т Хүний эрхийн бодлого, хүмүүнлэгийн тусламжийн асуудал эрхэлсэн комиссарын албан тушаал байдаг бөгөөд энэ нь эдгээр салбар дахь шинээр гарч буй улс төрийн үйл явцтай холбогдох ХБНГУ-ын баримтлах бодлогын талаар Холбооны Гадаад хэргийн сайдад санал хүргүүлэх эрхтэй.⁸⁷ Гэхдээ эдгээр этгээдээс Үндсэн хуулийн шүүхэд хандах талаар тодорхой зохицуулалт Үндсэн хууль болон бусад хуульд тодорхой тусгагдаагүй байна.

Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт тавих Парламентын гишүүдийн квот

Үндсэн хуулийн 93 дугаар зүйлийн 1-ийн 2 болон Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 13.6 дахь хэсэгт заасны дагуу холбооны болон муж улсуудын хуулиуд Үндсэн хуульд нийцэж буй эсэх, эсхүл муж улсуудын эрх зүйн акт Холбооны эрх зүйн бусад хэм хэмжээнд нийцэж буй эсэх маргааныг Холбооны ЗГ, Муж

83 Үндсэн хуульд харш нам гэж зорилгоороо эсвэл дэмжигчдийнхээ зан байдлаар чөлөөт ардчилсан үндсэн дэг журамд хохирол учруулах эсвэл түүнийг устгахаар, эсвэл ХБНГУ-ын оршин тогтнолд харшил учруулахаар үйл ажиллагаа явуулсан намыг хэлнэ.

84 German Institute for Human Rights, Холбоос: <https://ennhri.org/our-members/germany/>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

85 Мөн тэнд.

86 Мөн тэнд.

87 The Commissioner for Human Rights Policy and Humanitarian Assistance, Холбоос: <https://www.auswaertiges-amt.de/en/about-us/coordinators/hr-commissioner>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

улсын ЗГ, эсхүл Бундестагийн нийт гишүүдийн дөрөвний нэгийн хүсэлтээр хянан шалгадаг. Ингэснээр ХБНГУ-ын Бундестагт одоогийн байдлаар 736 гишүүн байгаа бөгөөд үүний $\frac{1}{4}$ нь болох 184 гишүүн Үндсэн хуулийн шүүхэд хууль заасан төрлөөр хүсэлт гаргах эрхтэй. Уг ажиллагааг сөрөг хүчнийхэн өөрсдийнх нь санаачилсан хуулийг дэмжээгүй шийдвэрийг Үндсэн хуулийн шүүхийн тусламжтайгаар унагаах зорилгод олонтоо ашигладаг.⁸⁸ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн 50 жилийн ойн эмхэтгэлд тусгасан статистикаас харвал, Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа явуулсан эхний 50 жилийн хугацаанд нийтдээ 141 удаа хэм хэмжээний хийсвэр хяналт хийсэн байна.⁸⁹ Дээрх байдлаар парламентын цөөнх нь хэм хэмжээний хийсвэр хяналт хэрэгжүүлэх хүрээнд Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт тавих эрхтэй байгаа нь ардчилсан нийгэм дэх олонх, цөөнхийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилготой.⁹⁰ Тухайлбал, парламентаас олонхын санал авч батлагдсан хуулийг цөөнх Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзвэл Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй гэсэн үг юм.⁹¹

В. Үндсэн хуулийн шүүхийн гишүүний томилгоо

Холбооны Үндсэн хуулийн шүүх нь Бундестаг болон Бундесратаас тэнцүү тоогоор сонгогдсон 16 шүүгчээс бүрддэг. Энэ хоёр байгууллагаас шүүгчдийг сонгоход өөр өөр журам үйлчилдэг. Эхлээд Бундестагт улс төрийн хүчний харьцааг харгалзан байгуулсан 12 гишүүнтэй сонгогчдын коллеги нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг сонгодог бол Бундесрат нь тэдгээр шүүгчдийг дийлэнх олонхын ($\frac{2}{3}$) саналаар шууд сонгодог.⁹²

Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуулийн шүүгчийг 12 жилийн хугацаатайгаар парламентын хоёр танхимын гишүүд сонгон томилох бөгөөд улируулан томилохыг хориглоно. Гэхдээ Үндсэн хуулийн шүүгчээр ажиллах бүрэн эрхийн хугацаа дуусаагүй байхад 68 нас хүрсэн бол заавал тэтгэвэрт гарах ёстой.⁹³ Ийнхүү Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг улируулан томилохыг хориглож буй шалтгаан нь шүүгчийн хараат бус байдлыг хангадаг тул тус улсад Үндсэн хуулийн хяналт амжилттай хэрэгждэг байна.⁹⁴

2.2.2. Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангах хүрээнд

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд улс төрийн намд холбогдох зохицуулалтыг тусгажээ. Үүнд:

88 Юрген Харбих, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх эрх зүй, улс төр, нийгмийн хөгжлийн зөрчилдөөний уулзвар дээр, Монголын төр эрх зүй сэтгүүл, №4(78), (УБ, 2014), 7 дахь тал.

89 Юрген Харбих, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх эрх зүй, улс төр, нийгмийн хөгжлийн зөрчилдөөний уулзвар дээр, Монголын төр эрх зүй сэтгүүл, №4(78), (УБ, 2014), 6-7 дахь тал.

90 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 144 дэх тал.

91 Мөн тэнд.

92 Т.Доохүү, Ч.Энхбаатар, *"Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй тусгай анги"*, (УБ, 2009), 148-149 дэх тал.

93 "Federal Constitutional Court Act in the version of 11 August 1993 (Federal Law Gazette I p. 1473), last amended by Article 4 of the Act of 20 November 2019 (Federal Law Gazette I p. 1724), Article 4.

94 О.Мөнхсайхан, "Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь", *Эрх зүй сэтгүүл* №4, (УБ, 2016), 15 дахь тал.

21 дугаар зүйл. Улс төрийн нам

Ард түмний улс төрийн хүсэл зориг бүрэлдэхэд намууд оролцоно. Улс төрийн намыг чөлөөтэй байгуулж болно. Намын дотоод зохион байгуулалт, журам нь ардчилсан зарчимд нийцсэн байна. Нам нь өөрийн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл, түүний зарцуулалт болон өөрийн өмч хөрөнгийн тухай олон нийтэд тайлагнах үүрэгтэй.

Нам нь өөрийн зорилго, эсхүл үзэл баримтлалынхаа хүрээнд чөлөөт ардчиллын суурь үнэт зүйлийг үл хайхрах, устгах эсхүл Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын оршин тогтнолд аюул учруулах бол тус намыг Үндсэн хуулийн бус гэж үзнэ. Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг Холбооны Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэнэ.

Нам нь өөрийн зорилго, эсхүл үзэл баримтлалынхаа хүрээнд чөлөөт ардчиллын суурь үнэт зүйлийг үл хайхрах, устгах эсхүл Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын оршин тогтнолд аюул учруулах бол түүнийг улсын санхүүжилтээс хасна. Ийнхүү хассан тохиолдолд уг намд олгох төсвийн таатай нөхцөл болон тэдгээрт олгосон төлбөрийг цуцалсанд тооцно.

Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүх нь 2 дахь хэсэг заасан Үндсэн хуульд харшилсан эсэх болон 3 дугаар хэсэгт заасан улсын төсвийн санхүүжилтээс хасах эсэх маргааныг хянан шийдвэрлэнэ.

Нарийвчилсан зүйлийг Холбооны хуулиар зохицуулна.

Эндээс үзвэл, ХБНГУ-ын Үндсэн хуульд нам байгуулах иргэдийн тоог мөн тусгаагүй байна. Түүнчлэн тус улсын Улс төрийн намын тухай Холбооны хуульд⁹⁵ намын гишүүдийн тоонд тавигдах доод хязгаарыг тусгайлан зохицуулаагүй байна. Иймд улс төрийн нам байгуулахад төрөөс зөвшөөрөл авах, бүртгүүлэх шаардлагагүй ба харин дээрх 21.1.3-т заасанчлан намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчмуудад нийцсэн байх шаардлагатай.

2.2.3. Сонгуулийн тогтолцоо болон парламентын төлөөллийг сайжруулах хүрээнд

А. Сонгуулийн тогтолцоо

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Германы Бундестагийн гишүүнийг нийтээрээ, шууд, чөлөөтэй, тэгш, нууц санал хураалтаар сонгоно. Гишүүн нь ард түмнээ төлөөлж, аливаа тушаал, даалгавраас ангид байж зөвхөн итгэл үнэмшилдээ захирагдана.” гэж сонгуулийн зарчим, гишүүний ёс зүйн хэм хэмжээг тогтоожээ. Мөн хуулийн 50 дугаар зүйлд “Муж нь Европын Холбооны асуудал болон Холбооны засаг захиргаа, хууль тогтоох эрх мэдлийн асуудалд Бундестратаар уламжлан оролцоно.” гэж заажээ.

Ийнхүү ХБНГУ-ын хууль тогтоох эрх мэдлийг хууль тогтоох дээд байгууллага (Бундестаг), мужийн төлөөллийн дээд байгууллага (Бундесрат) хэрэгжүүлдэг. Бундестаг нь Холбооны сонгуулийн хуулийн дагуу холимог тогтолцоогоор ХБНГУ-ын ард түмнээс 4 жилээр сонгогддог байна. Ингэхдээ Бундестагийн 299 депатутыг нэг мандаттай сонгуулийн тойргоос, үлдсэн 299 депатутыг улс төрийн намуудын нэрсийн жагсаалтаар сонгодог.

Сонгуулийн энэхүү тогтолцоогоор сонгогч харилцан үл хамаарах, бие даасан хоёр саналыг гаргах ба эхний санал нь сонгуулийн тойргоос сонгогдож байгаа нэр дэвшигчид өгөх бол дараагийн саналыг Холбооны 16 муж улс тус бүрийн улс төрийн

95 Political Parties Act, 2009, Холбооц: https://www.bmi.bund.de/SharedDocs/downloads/DE/gesetzestexte/Parteiengesetz_PartG_engl_042009.pdf?__blob=publicationFile&v=2, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

намын нэрсийн жагсаалтад байгаа намыг сонгоно.⁹⁶ Холбооны сонгуулийн комисс сонгогчдын намд өгсөн саналыг үндэслэн сонгуульд орсон улс төрийн намуудад Германы Бундестагийн суудлыг хуваарилна.⁹⁷

Харин Бундесратын гишүүнийг томилдог байна. Өөрөөр хэлбэл Бундесрат нь муж улсууд өөрөө томилох, эргүүлэн татах эрхтэй тухайн муж улсын ЗГ-ын гишүүдээс бүрддэг бөгөөд муж улс бүр өөрт нь ногдох саналын тоогоор Бундесратад гишүүн томилон илгээдэг (Муж улс бүр Бундесратад гурваас доошгүй саналын эрхтэй байна). Харин томилогдсон гишүүнийг тухайн муж улсын ЗГ-ын гишүүнээр төлөөлүүлж болно.⁹⁸

Б. Парламентын гишүүдийн тооны талаар

Холбооны Сонгуулийн тухай хуульд Бундестагийн гишүүний тоог 598-аас дээш байхаар заасан ч суудлыг тэгшитгэх, дээшлүүлэх тогтолцооны улмаас одоогийн 20 дугаар Бундестаг нийт 736 гишүүнтэй. Харин Бундесратын гишүүдийн тоо нь харилцан адилгүй бөгөөд үүнийг хүн амын төлөөллийн байдлыг харгалзан тогтоож байна. Жишээ нь 2 саяас дээш хүн амтай муж улс бүрийг 4 гишүүн, 6 саяас дээш хүн амтай муж улс бүрийг 5 гишүүн, 7 саяас дээш хүн амтай муж улс бүрийг 6 гишүүн төлөөлөхөөр зохицуулсан ба өнөөгийн байдлаар 69 гишүүнтэй байна. 2023 оны 4 дүгээр сарын байдлаар ХБНГУ-ын нийт хүн амын тоо 84,531,101 бөгөөд Бундестагийн гишүүдийн нийт тоог нийт хүн амын тоонд харьцуулан үзвэл Бундестагийн нэг гишүүн ойролцоогоор 114,852 иргэнийг төлөөлж байна гэж үзэж болох юм. Гэхдээ Герман Улс нь Холбооны улс учир 16 Land-аас бүрддэг тул муж улс бүр өөр өөрийн хууль тогтоох байгууллага (Landtag)-тай. Жишээ нь Бавари муж улс нь 13 сая хүн амтай, ард нийтийн төлөөллийн байгууллага нь 205 суудалтай байна. Энэ нь ойролцоогоор 1 гишүүн 63,415 иргэнийг төлөөлж буй юм. Ийнхүү ХБНГУ нь ард нийтийн төлөөллийг шат дараалалтай, хүртээмжтэй байдлаар хангасан байна.

2.2.4. Хэт төвлөрлийг сааруулах ба Үндсэн хуулийн зохицуулалтын нөлөө

Герман Улс Үндсэн хуулийн 22 дугаар зүйлдээ “Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын нийслэл нь Берлин байна.” гэж заагаад харин Берлиний Үндсэн хуульд Берлин нь хот болон муж улс (Land) байна гэж зааснаас өөр зохицуулалт тусгаагүй. Өөрөөр хэлбэл, ХБНГУ Үндсэн хуулиараа төрийн дээд байгууллагууд байнга оршин байх газрыг нийслэл гэж тогтоогоогүй. Ингэснээр бусад хуулиар төрийн байгууллагуудын байршлыг тодорхойлох боломжийг олгож байгаа юм. Тухайлбал, 1994 онд батлагдсан Берлин/Бонны хууль⁹⁹ (Герман: Berlin/Bonn-Gesetz)-аар Бундестаг болон ХБНГУ-ын ЗГ-ын зарим байгууллагыг Бонноос Берлин рүү нүүхийг, мөн Холбооны зарим агентлагууд болон Германы холбооны бусад байгууламжуудыг Бонн руу нүүлгэх үйл ажиллагааг хийсэн байдаг. Берлин/Бонны хууль нь холбооны аль яамыг нийслэл рүү нүүлгэн шилжүүлэхийг тодорхойлсноос гадна Бонн хотыг улс төрийн захиргааны үйл ажиллагаа явагдах байршил болгох зорилт тавьсан. Уг хуулийн дагуу Бонн хот нь боловсрол, шинжлэх ухаан, соёл,

96 Д.Халиун, Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагуудын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306), “Парламент” судалгааны эмхэтгэл, боть 40, 224 дэх тал.

97 Мөн тэнд.

98 ХБНГУ-ын Үндсэн хууль 51-р зүйл.

99 Албан ёсны нэршил: Германы эв нэгдлийг баталгаажуулах тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хууль (1991).

судалгаа, технологи, харилцаа холбоо, байгаль орчин, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, хөгжлийн бодлого, батлан хамгаалах зэрэг салбарт төрийн үйл ажиллагаа явуулдаг. Өнөөгийн байдлаар Холбооны 14 яамнаас Хүнс, хөдөө аж ахуй, хэрэглэгчийг хамгаалах яам, Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам, Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдлын яам, Боловсрол, судалгааны яам, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам зэрэг 6 яам Бонн хотод анхдагч суудалтай байна.

Мөн Холбооны 20 гаруй төрийн байгууллагаас, Герман Улсын аудитын асуудлыг хариуцсан Bundesrechnungshof болон өрсөлдөөний зохицуулалтыг хариуцдаг Холбооны Картелийн газар зэрэг томоохон байгууллагууд сайдын ажлын алдагдлыг хэсэгчлэн нөхөх зорилгоор Берлин, Франкфуртаас Бонн руу нүүсэн байна. Ийнхүү Бонн хот нь Бүгд Найрамдах Герман улсын хүчирхэг холбооны төрийн захиргааны хоёр дахь төв болж байна.¹⁰⁰

Явцын дүгнэлт

БНСУ болон ХБНГУ-ын иргэн Үндсэн хуульд заасан үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд уг зөрчлийг хянуулахаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй. Тухайлбал, ХБНГУ иргэний Үндсэн хуулийн шүүхэд хандах тодорхой эрхийн төрлийг тоочсон бол БНСУ-ын Үндсэн хуульд иргэн Үндсэн эрх зөрчигдсөн талаарх гомдлоос гадна шүүхийн хэрэглэж буй хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх гомдлыг мөн гаргах эрхтэй байна.

БНСУ болон ХБНГУ нь Үндсэн хуульдаа Монгол Улсын адил Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх бүхий субъектийг тоочин зохицуулаагүй, харин Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг ерөнхийлөн томъёолох зарчмаар тусгасан байна. Нийтлэг байдлаар авч үзвэл хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалыг хэрэгжүүлэгч байгууллага, эрх бүхий албан тушаалтан болон иргэн Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байна. Парламентын гишүүд Үндсэн хуулийн шүүхэд хандахдаа БНСУ-ын хувьд Үндэсний ассамблей албан тушаалтныг огцруулах тухайд нийт гишүүдийн 1/3 -ийн санал болгосноор нийт гишүүдийн олонх, ерөнхийлөгчийн хувьд нийт гишүүдийн олонхын санал болгосноор 2/3-ын саналаар баталснаар Үндсэн хуулийн шүүхэд хандах бол ХБНГУ нь хууль Үндсэн хуульд нийцэж буй эсэх эсхүл Муж улсуудын эрх зүйн акт Холбооны эрх зүйн бусад хэм хэмжээнд нийцэж буй эсэхэд Бундестагийн нийт гишүүдийн 1/4-ийн хүсэлтээр хэм хэмжээний хийсвэр хяналт хэрэгжүүлдэг.

Үндсэн хуулийн шүүхийн гишүүнийг БНСУ-ын Үндсэн хуульд 6 жилийн хугацаатай 1 удаа улируулан томилж болохоор тусгасан бол ХБНГУ бүрэн эрхийн хугацааг 12 жилээр тогтоосноор улируулан томилдоггүй байна. Үндсэн хуулийн шүүхийн гишүүнийг улируулан томилох нь шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг алдагдуулах сул талтай.

Улс төрийн нам байгуулахад тавигдах шаардлагыг улс бүр харилцан адилгүй байдлаар зохицуулж байна. Тухайлбал, БНСУ-д Үндсэн хуульд тодорхой зүйл заалт оруулаагүй ч Сонгуулийн тухай хуульд улс төрийн нам байгуулахад гишүүнчлэлийн квот /5,000-с дээш сонгогч/ тогтоосон бол ХБНГУ-д улс төрийн намын гишүүнчлэлийн

100 Bonn's new profile, Холбоос: <https://www.bonn.de/microsite/en/services/information-for-media/bonns-new-profile.php>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

квот тусгаагүй байна. БНСУ-ын хувьд, улс төрийн намын гишүүнчлэлийн квотод тавигдах шаардлага нь тус улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн 0.012 хувьтай тэнцэж байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасан сонгуулийн эрх бүхий иргэдийн 1 хувийн шаардлагаас ойролцоогоор 100 дахин бага байна.

Сонгуулийн тогтолцооны хувьд хоёр улс аль аль нь холимог тогтолцоотой. БНСУ-ын хувьд дийлэнх буюу 300 гишүүний 253 нь орон нутгийн тойргийн төлөөлөгчдийн саналын хуудсаар, үлдсэн 47 нь хувь тэнцүүлсэн санал хураалтаар сонгогддог бол Бундестагийн гишүүдийн тал хувь нь буюу 299 депатуыг нэг мандаттай сонгуулийн тойргоос, үлдсэн 299 депатуыг улс төрийн намын нэрсийн жагсаалтаар сонгодог. Харин парламентын гишүүдийн тооны талаар авч үзэхэд сонгон судалсан хоёр улс хоёул куб язгуурын томъёог ашиглаж гишүүдийн тоог тодорхойлоогүй, гишүүний төлөөллийн чадварыг харгалзан парламентын гишүүний тоог тогтоодог байна.

Харин орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хотын төвлөрлийг сааруулах зорилгоор төрийн байгууллагыг нүүлгэх, сэлгэн суурьшуулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна. Жишээлбэл, БНСУ нийслэл Сөүлийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс Сэжон хотыг захиргааны төв хот болгон хөгжүүлсэн.

III. ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Энэхүү хэсэгт өмнөх үе шатанд тодорхойлсон хувилбарын үр нөлөөг хүний эрхэд үзүүлэх нөлөө, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, нийгэмд үзүүлэх үр нөлөө, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөтэй холбоотой ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа.

Хүснэгт 1.9. Өмнөх хэсгүүдэд тодорхойлсон зохицуулалтын хувилбарууд

№	Агуулга	Дэвшүүлсэн хувилбар
1	Цэцийн хяналттай холбогдох зүйл, заалтын хүрээнд	1. Цэц иргэний үндсэн эрхийн зөрчлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг Үндсэн хуулиар баталгаажуулах; 2. УИХ-ын тодорхой тооны гишүүн болон Комисс Цэцэд хандах боломж; 3. Цэцийн гишүүнийг улируулан томилох талаарх зохицуулалтыг Үндсэн хуульд, эсвэл Цэцийн тухай хуульд тусгах, дахин томилохыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлэх;
2	Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангах хүрээнд	Улс төрийн нам байгуулахад өндөр шаардлага тавих нь төлөөлөн удирдах засаглал дахь цөөнхийн төлөөллийг үгүйсгэх магадлалтай учир Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн нам байгуулах хязгаарлалтыг хуулиас хасах
3	Сонгуулийн тогтолцоо болон парламентын төлөөллийг сайжруулах хүрээнд	1. УИХ-ын сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд тусгах; 2. Үндсэн хуульд парламентын гишүүдийн тоог нэмэхээр тусгах;
4	Хөдөөгийн сэргэлтийг дэмжих, хэт төвлөрлийг сааруулж, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах хүрээнд	Төрийн дээд байгууллагыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хуульд тусгах

3.1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Хүснэгт 1.10. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхахыг хориглох тухай зохицуулалт байхгүй.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхах зохицуулалт байхгүй бөгөөд иргэн зөрчигдсөн эрхээ сэргээх зорилгоор, УИХ-ын гишүүдийн цөөнх гишүүд Цэцэд хандах боломжтой.
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилготой хувилбар байхгүй.
	1.2. Оролцоог хангах			

	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	УИХ-ын гишүүдийн цөөнх буюу тодорхой гишүүд болон сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доош тооны иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангана.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйгээс үүдэн эрх нь зөрчигдсөн иргэн, гадаад улсад оршин суудаг сонгуулийн насны иргэд гэж тодорхойлсон байна.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйгээс үүдэн эрх нь зөрчигдсөн иргэд Цэцэд өргөдөл гаргах, гадаад улсад оршин суугаа иргэд сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Тус хувилбаруудад хариуцлага хүлээлгэх талаар агуулга бүхий хувилбар байхгүй.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байх хувилбарын хувьд төрийн дээд байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрх зөрчигдөх магадлалтай. Гэхдээ үр дүнтэй зохицуулалтыг хийснээр залруулж болно.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Төвлөрлийг бууруулах арга хэмжээнд энэхүү хувилбар нь тохиромжтой болохыг судалгааны явцад авч үзсэн.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	· УИХ-ын тодорхой тооны гишүүд, · Цэцэд зөрчигдсөн эрхийн талаар өргөдөл гаргах иргэд, · Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд, · Цэцийн гишүүд · ХЭҮК
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлоогүй

	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилготой хувилбар байхгүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилготой хувилбар байхгүй. Эрх агуулагч субъект бүрийн эрх хангагдана.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Цэц (Бусад хувилбарт үүрэг хүлээгчийг тусгаагүй)
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендэрийн үзэл баримтлалтай холбогдох хувилбар байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлсэн.

3.2. Эдийн засагт үзүүлэх нөлөө

Хүснэгт 1.11. Эдийн засагт үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Тухайн хувилбарууд нь шууд утгаараа хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Дээрх хувилбарууд нь зах зээлд нөлөөлөх нөлөөлөл байхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.

3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
6. Инновац болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	7.3. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.
	7.4. Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хувилбаруудад энэ талаар тусгаагүй.

8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байх хувилбарын хувьд орон нутагт ажлын байрыг шинээр бий болгох ач холбогдолтой. Мөн УИХ-ын гишүүдийн тоог нэмэх, Цэц бодит хяналтыг хэрэгжүүлэхэд албан хаагчдын ажлын байр шинээр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байх, УИХ-ын гишүүдийн тоог нэмэх, иргэн үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд Цэцэд хандах, сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх хувилбаруудын хувьд улсын төсөвт нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байх, УИХ-ын гишүүдийн тоог нэмэх, иргэн үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд Цэцэд хандах, сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх хувилбаруудын хувьд төрийн байгууллагын бүтцэд өөрчлөлт орно.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Цэц нь иргэний үндсэн эрхийн маргаан болон УИХ, ХЭҮК-оос гаргасан маргааныг шийдвэрлэх чиг үүргийг шинээр хүлээнэ.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулснаар зах зээлийн эргэлт хурдасаж эдийн засагт сайн нөлөө үзүүлэхийн зэрэгцээ, хот хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангана.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хот хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлснээр хөдөөг чиглэх хөрөнгө оруулалт сайжирч зах зээл тэлнэ.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын олон улсын гэрээнд харшлах зүйлгүй.

3.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 1.12. Нийгэмд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	УИХ-ын гишүүний тоо нэмэгдэх, Цэцийн хяналтын хэлбэрт өөрчлөлт орсноор тодорхой ажлын байр нэмэгдэнэ. Мөн хөдөөг чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдэж орон нутгийн ажлын байр ихэснэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байрны цомхотгол үүсэхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Цэц болон УИХ-ын тамгын газрын албан хаагчдын ачаалал нэмэгдэх нөлөө үзүүлэх бөгөөд орон нутагт хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд ажлын байр нэмэгдэх, зах зээлийн эргэлт эрчимжих давуу талтай.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Цэц нь иргэний үндсэн эрхийн маргаан болон УИХ, Хүний эрхийн Үндэсний Комиссын маргааныг шийдвэрлэхтэй холбоотойгоор Цэцийн гишүүд болон бусад албан хаагчийн эрх, үүрэг өөрчлөгдөнө. УИХ-ын хувьд мөн гишүүдийн тоонд өөрчлөлт орсноор эрх, үүрэгт өөрчлөлт орно. Сонгуулийн холимог тогтолцоог бий болгосноор Сонгуулийн ерөнхий хорооны чиг үүрэгт өөрчлөлт орно.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Цэцэд маргаан шийдвэрлэхтэй холбоотой болон УИХ, УИХ-ын сонгуулийн тухай журамд өөрчлөлт орно.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Шинэ чиг үүрэг, бүтэц, тогтолцоотой холбоотойгоор технологийн шинэчлэлт бий болно.

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Бүх хувилбарын хувьд засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөл үзүүлнэ.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Бүх хувилбарын хувьд төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлнө.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Бүх хувилбарын хувьд төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлнө.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэд зөрчигдсөн эрхээ ердийн шүүхээс гадна Цэцэд хандаж сэргээлгэх боломж бий болно.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Улс төрийн нам байгуулах шаардлагыг багасгаснаар иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх баталгаажна.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохихцуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагуудыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор хүмүүсийн амьдралын хэв маягт нөлөөлнө.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын тогтолцоо	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагуудыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор тус нөхцөл байдалд өөрчлөлт орно.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 1.13. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагуудыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор төвлөрөл буурч агаарын бохирдол багасна.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагуудыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор түлшний хэрэглээ ихэснэ.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагуудыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор нийслэл дэх хөрсний бохирдол багасна.
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Төрийн дээд байгууллагуудыг Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор орон нутагт ашиглагдаагүй байсан газрыг эдийн засгийн эргэлтэд оруулна.
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Дээрх судалгаанд үндэслэн тухайн хувилбаруудын хувьд дараах эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Хүлээж болох эерэг үр дүн

- Цэцээс субъектив эрхийн зөрчлийг хянах боломжтой болсноор Цэцийн Үндсэн хуульд тавих дээд хяналт сайжирч, хүний үндсэн эрхийг хамгаалах тогтолцоо бэхжих;
- Цэцэд хандах эрх бүхий субьектийн тооны хязгаарлалтыг сулруулснаар Үндсэн хуулийн зөрчлийг илүү өргөн хүрээнд хянах, шийдвэрлэх;

- Цэцийн гишүүний бүрэн эрхт хугацаа, тэдний улиран томилогдох явдалд хязгаарлалт хийснээр Цэцийн гишүүний бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх;
- Улс төрийн нам байгуулах шаардлагыг сулруулснаар Үндсэн хуульд заасан эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангах;
- Сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд тусгаснаар сонгогчдын санал гээгдэх асуудлыг шийдвэрлэж, улс төрийн олон ургалч үзлийг төлөвшүүлэх;
- УИХ-ын гишүүний тоог нэмэгдүүлснээр УИХ-ын гишүүний төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, хууль батлах явц дахь үзэмжийн асуудлыг шийдвэрлэж хууль тогтоомжийн чанар сайжрах;
- УИХ-ын гишүүний тоог нэмэгдүүлснээр УИХ болон ЗГ хоорондын хяналт-тэнцэл сайжрах;
- Нийслэлийг тодорхойлох шалгуураас төрийн дээд байгууллагууд байрлах шалгуурыг хассанаар Нийслэлийн төвлөрлийг сааруулж, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зэрэг үр нөлөөтэй.

Үүсэж болох сөрөг үр дагавар

- Цэцийн хяналтын хүрээг тэлснээр Цэцийн болон гишүүний ажлын ачаалал, холбогдох зардал нэмэгдэх;
- Улс төрийн олон нам парламентад суудал авснаар улс төрийн шийдэлд хүрэхэд хүндрэл үүсэх;
- УИХ-ын гишүүдийн тоог нэмснээр холбогдох зардал нэмэгдэх болон УИХ-ын шийдвэр гаргах хугацаа удаашрах;
- Төрийн дээд байгууллагыг орон нутаг руу шилжүүлснээр хүний нөөцийн болон захиргааны зохион байгуулалт, шийдвэр гаргах явц удаашрах асуудал үүснэ.

IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг дараах хүрээнд тандан судалж, ХБНГУ болон БНСУ-ын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд харьцуулж дүгнэлт гаргалаа. Үүнд:

1. Хүний эрхийг хамгаалах Цэцийн хяналтын хүрээнд;
2. Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулах хүрээнд;
3. Парламентын ардчиллыг бэхжүүлэх, УИХ-ын төлөөлөх чадварыг сайжруулах хүрээнд;
4. Хөдөө, орон нутгийн сэргэлтийг дэмжих, төвлөрлийг бууруулах хүрээнд.

А. Хүний эрхийг хамгаалах Цэцийн хяналтын хүрээнд

Цэцийн гол чиг үүрэг нь Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих явдал бөгөөд хүний үндсэн эрхийг хамгаалах гол хэрэглүүр болдог. Гадны зарим улсын жишгийг харахад иргэн өөрийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд хандаж эрхээ сэргээлгэх зарчим нийтлэг үйлчилдэг.¹⁰¹ Гэвч Монгол Улсад Цэц үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаарх маргааныг хянан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна. Харин БНСУ болон ХБНГУ-д үндсэн эрхийн зөрчлийг хянан шийдвэрлэж, сэргээх механизм төлөвшсөн байна. Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийн зөрчлийг хянан, үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн иргэний гомдлыг Цэцэд хянан шийдвэрлэх эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй. Ингэхдээ Цэцийн ачаалал, хэрэг маргаан шийдвэрлэлтийн чанарын асуудлыг анхаарч, ердийн шүүхийн урьдчилсан хяналтын механизмыг бүрдүүлэх нь зохистой.

Түүнчлэн, Цэцэд УИХ дахь цөөнх гишүүд болон Комисс хүсэлт гаргах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөх тохиолдолд дээд хяналтыг тавих Цэцийн үндсэн чиг үүрэгт нийцнэ. Мөн Цэцийн гишүүний хараат бус байдлыг хангах, улс төрийн нөлөөллөөс ангид байх баталгааг хангах үүднээс Цэцийн гишүүний дахин томилгоог хязгаарлах, холбогдох зохицуулалтыг тодорхой болгох хэрэгцээ, шаардлага байна.

Б. Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулах хүрээнд

Үндсэн хуульд заасны дагуу иргэд эвлэлдэн нэгдэх эрхийнхээ хүрээнд улс төрийн нам байгуулах эрхтэй ч, сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд буюу 20,000 сонгогч нэгдсэн тохиолдолд улс төрийн намыг бүртгэх урьдчилсан нөхцөл бүрдүүлэхээр хуульчилжээ. Энэ нь улс төрийн олон ургалч үзлийг алдагдуулах, төлөөллийн ардчиллыг сулруулах, нийгмийн цөөнхийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах, тэдний төлөөллийг үгүйсгэх, тэгш бус байдлыг үүсгэх сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй тул энэхүү хязгаарлалт нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үл нийцнэ. Харьцуулсан судалгааны дүнг харвал, БНСУ-д Үндсэн хуульд тодорхой зүйл заалт оруулаагүй ч Сонгуулийн тухай хуульд улс төрийн нам байгуулахад гишүүнчлэлийн квотыг тогтоосон бол ХБНГУ-д улс төрийн намын гишүүнчлэлийн квотын хязгаарлалтыг хуульчлаагүй байгааг анхаарах нь зүйтэй.

101 Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 119 дэх тал.

В. Парламентын ардчиллыг бэхжүүлэх, УИХ-ын төлөөлөх чадварыг сайжруулах хүрээнд

Монгол Улс сонгуулийн мажоритар тогтолцоог хэрэгжүүлснээр иргэдийн санал гээгдэх, улс төрчдийн хувьд улсын ашиг сонирхлоос илүүтэй тойргийн ашиг сонирхол өндөрт тавигдах зэрэг сөрөг үр дагавар үүсэж байгаа тул сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлж эдгээр сөрөг үр дагавраас зайлсхийх боломжтой гэж үзлээ. Харин сонгон судалсан улсуудын хувьд холимог тогтолцоотой байх боловч, мажоритар болон пропорциональ тогтолцоог харилцан адилгүй байдлаар хослуулан хэрэглэж байна. Үүний зэрэгцээ парламентын гишүүний тоог тогтоохдоо тодорхой нэг томьёо ашиглахаас илүүтэй гишүүний төлөөлөх чадварыг харгалзан үздэг болохыг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын хувьд парламентын гишүүний эрх мэдлийн тэнцвэртэй байдал, төлөөлөх чадвар суларч буйг анхаарч, тодорхой хэмжээгээр УИХ-ын гишүүний тоог нэмэх шаардлага байна. УИХ-ын гишүүдийн тоо нэмэгдсэнээр гишүүдийн төлөөлөх чадвар сайжрах, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцэл хангагдах, УИХ-ын гишүүдийн ажлын ачаалал буурч тэнцвэржих, УИХ-аас баталсан хуулийн чанар, үр нөлөө сайжрах зэрэг эерэг үр дагавар бий болно.

Г. Хөдөө, орон нутгийн сэргэлтийг дэмжих, төвлөрлийг бууруулах хүрээнд

Сүүлийн үед нийгэмд шүүмжлэл дагуулж буй хотын байгаль орчны бохирдол, хот, хөдөөгийн нийгэм, эдийн засгийн тэнцвэргүй хөгжлийг шийдвэрлэхийн тулд төрийн эрх барих байгууллагыг нийслэлээс гарган Улаанбаатар хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.

Судалгааны хүрээнд авч үзсэн БНСУ-ын хувьд Үндсэн хуульд “төрийн дээд байгууллагын байнгын оршин байх хотыг нийслэл гэнэ.” зэрэг нарийн зохицуулалтыг тусгаагүй буюу заншлын хэм хэмжээгээр тогтоож байгаа нь орон нутгийн тэнцвэртэй хөгжил, нийслэлийн төвлөрлийг сааруулахад түлхэц үзүүлж байна. Тодруулбал, нийслэл Сөүлийн төвлөрлийг сааруулах зорилгоор Сэжон бие даасан тусгай хот байгуулах тухай хуулийг батлан захиргааны нэгдсэн хот байгуулсан байна. Нийслэлд төвлөрсөн төрийн байгууллагуудыг орон нутагт гаргаснаар нийслэлийн төвлөрлийг сааруулж, Сэжон хот байрлах Кёнги аймгийн хүн ам, нийгэм, соёл, эдийн засгийн хөгжилд түлхэц болж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагыг орон нутагт шилжүүлэх үйл ажиллагаа нь нийслэлийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангахад түлхэц болж байна.

Манай улсын хувьд хот, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, нийслэлийн төвлөрлөөс үүдэлтэй сөрөг үр дагаврыг шийдвэрлэхийн тулд төрийн байгууллагыг орон нутагт нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нь тодорхой үр дүнд хүрэх боломжтой гэж үзлээ.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992)
2. Улс төрийн намын тухай хууль, (2005)
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар дүгнэлт, (1995)

Гадаад хэлээр:

1. Constitutional court act of Korea
2. Local Authority Act of Korea
3. Act on special cases concerning the administration of Seoul special metropolitan city
4. Federal Constitutional Court Act of Germany, (1993).
5. Political Parties Act, (2009).

Ном, өгүүлэл, нийтлэл

Монгол хэлээр:

1. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, (Адмон, 2012).
2. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, (МУИС пресс, 2016).
3. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, (УБ, 2008).
4. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, (Адмон принт, 2022).
5. Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй, (УБ, 2007).
6. ХЗДХЯ, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”, “Үндсэн хуулийн процессын эрх зүй” оюутны гарын авлага, (УБ, 2011).
7. Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй” Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021).
8. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, (УБ, 2021).
9. О.Мөнхсайхан, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал, тулгамдсан асуудал шийдэл, (УБ, 2020).
10. Парламентын судалгааны хүрээлэн, “Парламент судалгааны эмхэтгэл” боть 40, (УБ, 2022).
11. Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа”, (УБ, 2017).
12. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн хяналтын Монгол загвар Үндсэн эрхийн хамгаалал ба эрх мэдлийн тэнцвэр, “Үндсэн хуулийн эхийн баригч - Б.Чимид, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл”, (УБ, 2020).

13. Арне Мавбич, “Үндсэн хуулийн хяналт”, Мэргэн Их Монгол, Г.Баясгалан, Д.Одбаяр, Д.Сугар нарын орчуулга, (УБ, 2014).
14. Г.Билгүүн, Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх харьяалал (Харьцуулсан судалгаа), “Эрх зүй” сэтгүүл, №4 (УБ, 2020).
15. Г.Билгээ, Д.Халиун, Парламентын сонгуулийн тогтолцоо, парламентын гишүүдийн тоо ба түүнийг тогтоох, тооцох зарчим (СТ-22/405), “Парламент” судалгааны эмхэтгэл, боть 40.
16. Юрген Харбих, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх эрх зүй, улс төр, нийгмийн хөгжлийн зөрчилдөөний уулзвар дээр, “Монголын төр эрх зүй” сэтгүүл, 2014, №4 (78)
17. Т.Доохүү, Ч.Энхбаатар, “Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй тусгай анги”, (УБ, 2009).
18. О.Мөнхсайхан, Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний араат бус, хариуцлагатай байдлыг хангах нь, “Эрх зүй” сэтгүүл, №4 (УБ, 2016).
19. Д.Халиун, Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагуудын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306), “Парламент” судалгааны эмхэтгэл, боть 40.
20. О. Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015).
21. “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, Монгол Улсын Их Хурал (УБ, 2023).

Гадаад хэлээр:

1. 성낙인, 헌법학, 법문사, 2021
2. 조소영, 국회의원 정수에 관한 헌법적 고찰, 한국비교공법학회, 공법연구 제13권, 2012
3. 헌법 제
4. 김종일, 미국 연방대법관의 종신제에 관한 검토, 우리나라 헌법재판관의 임기와 관련하여, 한국공법학회, 공법연구, 2014
5. 최진혁, 지방분권과 지역균형발전에 따른 세종특별자치시의 발전과제: 정부부처 이전을 중심으로, 충남대학교 사회과학연구소, 사회과학연구 제26권, 2015

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” Эрдэм шинжилгээний нийтлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
2. “УИХ-ын нэр бүхий дөрвөн гишүүн Үндсэн хуулийн цэцэд ханджээ”, 2018.12.13, <https://www.parliament.mn/nn/4216/>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

3. 2022 оны 1-р улирлын байдлаар, <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Labour%20force%202022%201.pdf&In=Mn>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
4. “Улсын Их Хурлын байнгын хороод”, <https://www.parliament.mn/cv/?appointmentId=105>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
5. “Хот хөдөөгийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах арга хэмжээний санал боловсруулах ажлыг гүйцэтгэлээ”, 2021.04.11, www.mmcg.mn, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
6. Т.Алтангэрэл, “Үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх нь: ХБНГУ-ын туршлага” Эрдэм шинжилгээний нийтлэл, https://legaldata.mn/buteel/pdf?fbclid=IwAR2qdimLTBOVA116ipMZPiDjm4_OoKR2OWccXNo9l04qtGcf2VkoJoFKO7w&id=1411, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

Гадаад хэлээр:

1. Congress of local and regional authorities of Europe, Recommendation 133 (2003) on the management of capital cities, <https://rm.coe.int/management-of-capital-cities-rapporteur-mrs-n-shymanska/168071a20e>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
2. Hyowon Lee, A Constitutional Review Model: The Case of Korea, 2020, 42 дахь тал, https://nagoya.repo.nii.ac.jp/record/30824/files/caledp_19_37.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
3. South Korea population, <https://www.worldometers.info/world-population/south-korea-population/>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
4. German Institute for Human Rights, <https://ennhri.org/our-members/germany/>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
5. The Commissioner for Human Rights Policy and Humanitarian Assistance, <https://www.auswaertiges-amt.de/en/about-us/coordinators/hr-commissioner>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
6. Bonn's new profile, <https://www.bonn.de/microsite/en/services/information-for-media/bonns-new-profile.php>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ
ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
	Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
Г.Давааням	Эрдэмтэн нарийн бичгийн дарга
	Хууль зүйн ухааны доктор (LL.D.)

Судалгааны багийн бусад гишүүд:

Б.Түмэндэмбэрэл	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
	Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)
Б.Энх-Амгалан	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Х.Буянбат	Эрдэм шинжилгээний ажилтан
Р.Хатансайхан	Эрдэм шинжилгээний ажилтан
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.04.25.

АГУУЛГА

УДИРТГАЛ	61
I. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	62
II. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	63
III. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУРЫН ДАГУУ ҮНЭЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ	64
3.1. Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг	64
3.2. Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг	68
3.3. Арван гуравдугаар зүйлийн нэг дэх хэсэгт оруулах өөрчлөлт	76
3.4. Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг	82
3.5. Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг	85
3.6. Арван ес ¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	89
3.7. “Харилцан уялдаа” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал /Өөрчлөлтийн төслийн хүрээнд нэгтгэн үнэлсэн нь/	93
3.8. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”	96
IV. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	102
НОМ ЗҮЙ	105

УДИРТГАЛ

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт-тэнцлийг хангах үүднээс Улсын Их Хурлын гишүүний тоог шинэчлэн тогтоох, УИХ-ын сонгуулийн дэвшилтэт тогтолцоог Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлан Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурлын 2022 оны 34, 54 дүгээр тогтоол, “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжийг баримтлан Засгийн газраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төслийг /цаашид “Өөрчлөлтийн төсөл” гэх/ боловсруулжээ.

Уг төсөлд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”/цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу “Зорилгод хүрэх байдал”, “Ойлгомжтой байдал”, “Харилцан уялдаа” болон “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийв.

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь “Үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэнэ.

I. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Өөрчлөлтийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалын дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгож төслийн үр нөлөөг үнэллээ.

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлт багтана.

Эдгээр шалгуурыг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн болно. Үүнд:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуурын хүрээнд, тухайн төслөөр тавьж байгаа зорилгод хүрч чадах эсэхийг тооцож, өөрчлөлтийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь уг төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлнэ.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуурын хүрээнд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төслийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик уялдаатай боловсруулагдсан эсэхийг шалгана.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуурын хүрээнд тухайн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг үнэлнэ.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуурын хүрээнд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэхийг нягтална.

Харин Аргачлалын 6 шалгуураас “Практикт хэрэгжих байдал” болон “Зардал” гэх хоёр шалгуур үзүүлэлтийг энэхүү үнэлгээнд сонгож аваагүй болно.

Төсөлд хийх зардлын тооцоог “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь хийсэн. Иймд холбогдох зардлын тооцоог ХЗҮХ-ийн гүйцэтгэсэн “Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн зардлын тооцоо” сэдэвт судалгааны тайлан, (2023)-аас үзнэ үү.

Төслийн зохицуулалтууд нь төслийн үзэл баримтлал, төсөлд тусгасан зорилгод хүрэхэд чиглэгдсэн, тус зорилгод хүрэх боломжтой эсэх болон хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагыг хангах боломжтой эсэх талаар голчлон анхаарч, төслийн үр нөлөөг үнэлэх ажлыг гүйцэтгэв. Иймээс энэхүү тайлан нь уг ажлын хүрээнд үнэлгээ хийсэн шалгуур үзүүлэлт болон хуулийн төслийн үр нөлөөг тооцох хүрээгээр хязгаарлагдана.

II. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг дараах байдлаар боловсруулсан байна. Үүнд:

Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ системээр сонгоно.” гэж өөрчлөн найруулах;

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана” гэж өөрчлөн найруулах;

Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “томилно” гэснийг “томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно” гэж, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр” гэснийг “Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай” гэж тус тус өөрчлөх;

Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох өөрчлөлт тус тус багтсан.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг бүхэлд нь хамруулж, Аргачлалын “Зорилгод хүрэх байдал”, “Ойлгомжтой байдал”, “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “Харилцан уялдаа” гэсэн 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөний үнэлгээ хийв.

Хүснэгт 2.1. Үр нөлөөг үнэлэх шалгуур

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг
1.	Зорилгод хүрэх байдал	“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төсөл бүхэлдээ
2.	Ойлгомжтой байдал	“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төсөл бүхэлдээ
3.	Харилцан уялдаа	“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төсөл бүхэлдээ
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төсөл бүхэлдээ

Дээр дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу өөрчлөлтийн төслийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хамрах хүрээ, төслийн бүтцийг харгалзан дараах дэд хэсгүүдэд хуваан авч үзсэн. Харин “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн үр дүнг тус тайлангийн дөрөвдүгээр бүлгийн 4.8 дахь хэсэгт нэгдсэн байдлаар тусгасан болно.

III. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУРЫН ДАГУУ ҮНЭЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

3.1. Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	21.1.Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл заалт	21.1.Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.

Үндсэн Хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.” гэж заасан. Энэхүү өөрчлөлтийн төслөөр сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэн улс төрийн жижиг намын төлөөллийг парламентад оруулж улс төрийн олон ургалч үзлийг төлөвшүүлэх, хууль батлах явц дахь хяналтыг сайжруулах үүднээс УИХ-ын гишүүдийн тоог нэмэхээр төсөлд тусгасан байна.

3.1.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Үндсэн хуулиар сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлж буй тухайд

Ардчилсан сонгууль нь улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх сонгогчдын оролцоо, төлөөллийг хангах нийгмийн зөвшилцлийн дээд хэлбэр байдаг. Улмаар сонгуулийн тогтолцоо нь нийтээрээ, чөлөөтэй сонгох сонгуулийн зарчмын дагуу иргэдийн өгсөн саналд үндэслэн нам, нэр дэвшигчдэд парламентын суудал хуваарилах аргыг хэлнэ.¹ Өөрөөр хэлбэл, сонгууль нь парламентад ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл, тэдний төлөөлөл болохыг нотлохын тулд тодорхой хугацаанд тогтмол явагддаг, парламентын цөөнхөд олонх болох боломж олгох, иргэд өөрсдийн парламентын гишүүн, өөрсдийн төлөөлөлтэй хариуцлага тооцох боломжийг бүрдүүлэх зорилготой ардчиллын үндсэн элементийн нэг юм.² Өнөөгийн байдлаар Монгол Улсад хэрэгжүүлж байгаа сонгуулийн мажоритар тогтолцоо нь сонгогчдын санал гээгдэх, парламентын гишүүн улс орны эрх ашгаас илүүтэйгээр тойргийн эрх ашгийг чухалчлах сөрөг үр дагавар үүсгэж байна. УИХ-ын 2000 оны ээлжит сонгуульд нийт 16% буюу 190.000 сонгогчийн санал гээгдсэн нь 10 тойргийн сонгогчийн тоотой тэнцэх юм. Мөн бусад оронтой харьцуулахад суудал-саналын харьцааны алдагдал маш өндөр байгаа бөгөөд энэ нь УИХ дахь намуудын харьцааг тэнцвэргүй байдалд хүргэсэн.³

Сонгуулийн холимог тогтолцоо нь сонгогчдын санал гээгдэхгүй байх, цөөнхийн төлөөллийг хангах, улс төрийн намын ардчиллыг төлөвшүүлэх зэрэг давуу талтай. Иймд уг төслийн хүрээнд мажоритар болон пропорциональ тогтолцооны давуу талыг тусгасан сонгуулийн тогтолцоо гэж үзэж, холбогдох зохицуулалтыг Үндсэн хуульд тусгаж, сонгуулийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгыг дэвшүүлжээ.⁴

1 Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (УБ, 2023), ХЗҮХ, 17 дахь тал.

2 Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй, (УБ, 2016), 190 дэх тал.

3 О.Мөнхсайхан, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал, тулгамдсан асуудал шийдэл, (УБ, 2020), 161 дэх тал.

4 Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, 3 дахь тал.

Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог хуульчлаагүй бөгөөд суурь зарчмыг баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг бие даасан хуулиар зохицуулж ирсэн. 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш УИХ-ын ээлжит 8 сонгууль зохион байгуулагдсан. Эдгээр 8 удаагийн сонгуулийн 7 сонгуулийг /1992, 1996, 2000, 2004, 2008, 2016, 2020/ мажоритар тогтолцоогоор, харин 1 /2012/ сонгуулийг холимог тогтолцоогоор зохион байгуулсан. Өмнөх жилүүдэд хэрэглэсэн 7 удаагийн мажоритар тогтолцоогоор зохион байгуулсан сонгуулийн дүнд сонгогчдын санал гээгдсээр иржээ. Тодруулбал, УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн 26 дугаар тойрогт нэр дэвшигч нийт сонгогчийн 26.16% хувийн санал, УИХ-ын 2020 оны ээлжит 29 дүгээр тойрогт нэр дэвшигч нийт сонгогчийн 27.47% хувийн саналаар УИХ-ын гишүүн болсон. Өөрөөр хэлбэл, УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн 26 дугаар тойрогт 73.000 санал, 29 дүгээр тойрогт 72.000 сонгогчийн санал гээгджээ.⁵ Мөн УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд сонгуулийн эрх бүхий 2.309.069 сонгогч сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэнээс 1.475.780 сонгогч нь буюу сонгогчдын 73.6% нь сонгуульд оролцож санал өгсөн. Түүнчлэн УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нийт сонгогчдын 45%-ийн саналыг авсан улс төрийн нам парламентын суудлын 81.6%ийг авчээ. УИХ-ын 2016 оны ээлжит сонгуулиар нийт сонгогчдын 44% орчим нь МАН-ын, 33% нь АН-ын нэр дэвшигчдийг дэмжсэн гэсэн дүн гарсан боловч УИХ-ын суудал хуваарилахад МАН 65, АН 9 суудал авчээ. Энэ байдлаас үүдэн судлаачид мажоритар тогтолцоог пропорциональ тогтолцоотой уялдуулан сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх шаардлагыг дурдсаар ирсэн.

Сүүлийн жилүүдэд сонгуулийн мажоритар тогтолцооны дээр дурдсан сул талаас үүдэн төлөөллийн байгууллагад итгэх иргэдийн итгэл сулрах, иргэдийн санал гээгдэх үзэгдэл түгээмэл байна. Улмаар сонгуулийн мажоритар тогтолцоог дангаар нь ашиглахаас татгалзаж сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх нь зүйтэй.

Ийнхүү сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд тусгах нь улс төрийн цөөнхийн оролцоог хангах, сонгогчдын саналыг үнэгүйдүүлэхгүй байх, тойргийн үзэл суртлаас илүүтэй улсын нийтлэг ашиг сонирхлыг чухалчлах, мөн сонгуулийн тогтолцоог нэг мөр ойлгон хэрэглэснээр сонгуулийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгод нийцэж байна.

Улсын Их Хурлын гишүүний тоог нэмэгдүүлэх тухайд

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хуулийн төсөлд УИХ-ын гишүүний 76-н гишүүнийг мажоритар, үлдсэн 76-г пропорциональ тогтолцоогоор сонгон нийт гишүүний тоог 152 байхаар тусгасан. Ийнхүү нэмэгдүүлэх зорилго нь 1991-1992 онд Үндсэн хуулийг хэлэлцэж батлах үед УИХ-ын гишүүний тоог тухайн үеийн нийт хүн амын тоонд үндэслэн нэг гишүүн дунджаар 27 мянган иргэнийг төлөөлөхөөр тооцоолж, 76 гишүүнтэй байхаар хуульчилсантай холбоотой. Харин өнөөгийн байдлаар хүн амын өсөлттэй холбоотойгоор өнөөдөр 1-г гишүүн дунджаар 44.7 мянган иргэнийг төлөөлөх болжээ. Энэ нь 1 гишүүний төлөөлөх иргэдийн тоо бараг хоёр дахин нэмэгдэж, гишүүний төлөөлөх чадвар бууруулсныг илэрхийлж байна.

Мөн УИХ-ын гишүүний тоо цөөн учир хууль тогтоомж батлах үйл явцад зүй бус нөлөөлөл орох, нэг гишүүнд эрх мэдэл төвлөрөх, хуулийн биелэлтэд тавих хяналт сулрах сөрөг үр дагавар үүсэх магадлалтай. Парламентын засаглалтай гадны

⁵ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн, (УБ, 2022), Сонгуулийн Ерөнхий Хороо.

улсад парламент дунджаар 150-аас доошгүй гишүүнтэй байдаг нь хууль тогтоомж болон гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангахад чиглэдэг байна. Тиймээс парламентын иргэдийг төлөөлөх чадварыг сайжруулах зорилгоор УИХ-ын гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлэх зорилгоор төсөлд тусгасан.⁶

Ийнхүү гишүүдийн тоог нэмэгдүүлснээр парламентын төлөөлөх чадварыг сайжруулах, УИХ-ын гишүүдийн ажлыг жигд хуваарилах, ачааллыг бууруулан, гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн харилцан хяналтыг тэнцвэржүүлэх боломж бодитоор бүрдэхээр байна.⁷

Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.2-т зааснаар УИХ-ын гишүүн нь “байнгын хороонд заавал харьяалагдах” үүрэгтэй. Одоогийн байдлаар 3 байнгын хороонд харьяалагдсан 37 гишүүн, 2 байнгын хороонд харьяалагдан ажиллаж буй 29 гишүүн, 1 байнгын хороонд гишүүнээр ажиллаж байгаа 7 гишүүн байна. 2020 оноос өмнө Улсын Их Хурлын гишүүн хоёроос илүүгүй байнгын хороонд ажиллахыг зөвшөөрдөг байсан бол 2020 онд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26.1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулан “Байнгын хороо нь 19 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүн нэгэн зэрэг гурваас илүүгүй Байнгын хороонд харьяалагдан ажиллаж болох”-оор зохицуулсан. Өөрөөр хэлбэл, гишүүд хэд хэдэн байнгын хороонд харьяалагдан, тэдний ажлын ачаалал тэнцвэртэй бус байна.⁸

Мөн гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн харилцан хяналтыг тэнцвэржүүлэх хүрээнд ҮХЦ-ийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02 тоот тогтоолын 8 дахь үндэслэлд “...Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу парламентын засаглалыг төгөлдөршүүлэх зорилгоор хүн амын тоонд үндэслэн парламентын гишүүдийн тоог нэмж өөрчлөх, сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох замаар хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн тэнцвэр болон төлөөллийн чадварыг бүрэн хангах асуудлыг шийдвэрлэдэг хандлага парламентын засаглал бүхий улс орнуудад нэгэнт тогтсон байна. Иймд дэлхий нийтийн чиг хандлага, Үндсэн хуулиар баталгаажсан дээрх үзэл баримтлалын хүрээнд Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцүүлэн УИХ-ын гишүүний тоог нэмэх нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарах асуудал болно.” гэжээ.⁹

Иймд гишүүдийн тоог нэмэгдүүлэх нь УИХ-ын төлөөлөх чадварыг сайжруулах, УИХ-ын гишүүдийн ачааллыг жигд хуваарилах, гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн харилцан хяналтыг тэнцвэржүүлэх зорилгод нийцсэн гэж үзлээ.

6 Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, 3 дахь тал.

7 Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (УБ, 2023), ХЗҮХ, 30 дахь тал.

8 Мөн тэнд

9 Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт монгол улсын үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн Тогтоол Дугаар 02, (УБ, 2022), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?Lawid=16530977997941>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

Харин парламентын гишүүний тоог тогтоохдоо Куб язгуурын томьёог хэрэглэсэн боловч, олон улсын жишгээс ялгаатай нь нийт амын тоонд үндэслэн тооцсон байна. Аж үйлдвэржсэн улсуудын туршлагаас үзэхэд парламентыг гишүүдийн тоог тооцох хүрээнд Куб язгуурыг хэрэглэхдээ нийт хүн амын тоонд бус, хөдөлмөрийн насны иргэний тоонд үндэслэх бий. Улмаар Монгол Улсын хөдөлмөрийн насны иргэдийг 2,125,000¹⁰ хэмээн Куб язгуураар тооцвол 130 гишүүн гэсэн тоо гарахаар байгааг анхаарах нь зүйтэй.

Явцын дүгнэлт

Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.” гэж өөрчлөх тухайд Зорилгод нийцэж буй шалгуурын дагуу дараах дүгнэлтийг хийлээ.

Нэг. Сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлснээр улс төрийн жижиг нам парламентад суудал авах боломж бүрдэж, улс төрийн цөөнхийн төлөөллийг бүрдүүлэх нөхцөл хангагдана. Мөн сонгуулийн мажоритар тогтолцооны сул тал болох сонгогчдын санал гээгдэх үзэгдлийг хязгаарлах, улс төрийн олон ургалч үзлийг төлөвшүүлж төлөөллийн ардчиллыг хангах боломжтой.

Хоёр. УИХ-ын гишүүний тоог нэмэх нь парламентын төлөөлөх чадварыг сайжруулах, УИХ-ын гишүүний эрх мэдэл, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хууль тогтоох эрх мэдлийн харилцан хяналтыг хангах зорилгод нийцнэ. Харин гишүүний тоог тогтоохдоо дээр дурдсан Куб язгуурын аргыг ашиглах тохиолдолд улсын нийт хүн амын тоонд үндэслэх бус, бусад улсын туршлагад тулгуурлан нийт хөдөлмөрийн насны иргэдийн тоо эсхүл сонгуулийн насны иргэдийн тоог үндэслэн тогтоох нь төлөөлөн удирдах зарчмын үүднээс үндэслэлтэй гэж үзлээ.

3.1.2. “Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд “... Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.” гэж тусгажээ.

Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн.” хэмээн заасан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дах хэсэгт “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих”, тус зүйлийн 30.5.1 дэх хэсэгт “үг нэр томьёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол гадаад нэр томьёог хэрэглэж болно.” гэж хуулийн төслийн хэл зүйн найруулгад тавих нийтлэг шаардлагыг тусгасан байна.

Дээрх зүйл заалтад оруулсан “мажоритар”, “пропорциональ” гэх нэршлийг Үндсэн хуульд шууд тусгах нь Үндсэн хуулийн 8 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зүйл заалтын агуулгад харшилж болох юм. Иймд мажоритар болон пропорциональ гэсэн нэршлийг сонгуулийн олонхын

10 Ажиллах хүчний судалгааны 2022 оны I улирлын товч танилцуулга, (УБ, 2023), Үндэсний статистикийн хороо, 4 дэх тал

болон хувь тэнцүүлэх тогтолцоо гэж монгол хэлэнд хөрвүүлэн хэвшсэн¹¹ байдлыг харгалзан төсөл дэх нэршлийг өөрчлөх нь ойлгомжтой байдлыг нэмэгдүүлнэ.

Явцын дүгнэлт

Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно” гэж өөрчлөх нь “Ойлгомжтой байдал шалгуурт агуулгын хувьд нийцэж байна. Харин УИХ-ын сонгуулийн тогтолцоог тодорхойлохдоо “мажоритар”, “пропорциональ” гэх нэршлийг хэрэглэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуульд харшлахаас гадна монгол хэлэнд хэрэглэж тогтсон нэр томъёог галигласан шинжтэй байх тул ойлгомжгүй байна.

Иймд дээрх нэр томъёог “мажоритар” гэснийг “олонхын тогтолцоо” гэж, “пропорциональ” гэснийг “хувь тэнцүүлэх тогтолцоо” гэж, сонгуулийн эдгээр тогтолцоог нэгтгэснийг “холимог тогтолцоо” хэмээн монгол хэлний оноосон нэрээр бичих нь Үндсэн хуулийн 8 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зүйл заалтад нийцнэ.

3.2. Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	66.1.Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	66.1.Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.

Төслийн танилцуулгад дээрх өөрчлөлтийн зорилго болон тийнхүү өөрчлөх үндэслэлийг дараах байдлаар тодорхойлжээ:

ҮХЦ нь Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийн зөрчлийг авч хэлэлцэх эрх зүйн орчин байхгүй. Үүнээс үүдэн Монгол Улсад хүний үндсэн эрхийг зөрчсөн тохиолдлууд шийдвэрлэгдэх боломжгүй байна.

Иймд шүүхэд хандсан, эсхүл хуулийн бусад аргыг хэрэглэсэн ч үндсэн эрх нь сэргээгдээгүй гэж үзсэн бол иргэн ҮХЦ-д өргөдөл гаргах зохицуулалтыг тодорхой болгохоор төслийг боловсруулжээ. Энэ заалт батлагдсанаар ҮХЦ үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хууль хэрэглэж шийдвэрлэх, улмаар хүний эрхийн баталгааг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

3.2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Үндсэн хуулийн өөрчлөлтийн төсөлд Жаран зургадугаар дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр

11 Б.Чимид, “Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу”, (УБ, 2011), 56-57 дахь тал

гаргана.” гэж өөрчлөхөөр тусгажээ. Энэ хэсэгт тухайн зохицуулалтыг хийснээр тус өөрчлөлтийн төслийн зорилгод хүрэх эсэх, мөн Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэх эсэхийг дүгнэх юм.

Төсөл зорилгодоо хүрэх эсэх

2023 онд батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал”-ын 1 дэх хэсгийн 2-т “...иргэн үндсэн эрхээ хуульд заасан хязгаарын хүрээнд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргаж хамгаалуулах боломжтой болох...” гэж, мөн 2 дахь хэсгийн 1-д “Үндсэн хуулийн цэц нь Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэгтэйн хувьд иргэний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэх боломжтой байхаар Үндсэн хуульд тусгасан ч уул маргааныг ҮХЦ-ийн хяналтын объект болгон хуульд шууд зааж өгөөгүй, явцууруулан ойлгож ирсэн. ҮХЦ нь иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг авч хэлэлцэхгүй байгаагаас Монгол Улсад иргэний үндсэн эрхийг зөрчсөн тохиолдолд тухайн эрхийг сэргээн эдлүүлэх боломжгүй байна.

Үндсэн хуулийн өөрчлөлтийн төсөлд “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.” гэж заасан нь тус өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалтай зарчмын хувьд нийцэж байгаа бөгөөд иргэн ҮХЦ-д өөрийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх чухал ач холбогдолтой. Гэвч ҮХЦ-д өргөдөл гаргах хязгаарлалтыг тусгах шаардлага байна.

Тухайлбал, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг авч хэлэлцэх талаар болон шүүхэд хандсан, эсхүл хуулийн бусад аргыг хэрэглэсэн ч үндсэн эрх нь сэргээгдээгүй гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргах талаар тусгасныг өөрчлөлтийн төсөлд оруулаагүй байна.

Энэ тухай хууль зүйн ухааны доктор, судлаач Ц.Сарантуяа “Сонгодог утгаараа иргэдийн өргөдөл, мэдээлэл нь Үндсэн хуульд заасан индивидуаль буюу субъектив үндсэн эрх хэрэгжих баталгаа байх ёстой. Иргэн, хуулийн этгээд нь үндсэн эрхээ нийтийн эрх зүйн аливаа субъектын шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйгээр зөрчигдсөн гэж үзвэл үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байдаг. Гэхдээ иргэн, хуулийн этгээд нь үндсэн хуулийн шүүхэд хандахын өмнө тухайн маргааныг хуульд заасан бусад бүх шат дамжлагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг урьдчилан авсан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эрхээ хамгаалуулахаар үндэсний эрх зүйн бүх механизмыг эхлээд гүйцээсэн байна. Зөвхөн үүний дараагаар л үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой болдог. Учир нь өргөдөл нь үндсэн хуулийн шүүхийн практикт анхдагч бус үүсмэл (субсидиар) шинж чанартай юм.¹²” гэж мөн чанарыг тодорхойлсон.

Мөн шүүхэд хандсан, эсхүл хуулийн бусад аргыг хэрэглэсэн ч үндсэн эрх нь сэргээгдээгүй гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргах нь судлаачдын байр сууриас гадна бусад улсын туршлагад тулгуурлан авч үзсэн ч хүлээн зөвшөөрөгдөж байна.

Тухайлбал, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 97 дугаар зүйлд зааснаар “Шүүх эсхүл хууль хэрэглэдэг өөр байгууллага тухайн хуулийг хэрэглэж

12 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй хоёр дахь хэвлэл*, (Уб, 2021), 119 дэх тал.

хэрэг шийдвэрлэсэн бол ОХУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргах боломжтой байна.”¹³ гэж үүнийг тодорхойлсон байна.

Мөн БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлд “Төрийн эрх мэдлээ хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлээгүйн улмаас Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх нь зөрчигдсөн аливаа этгээд шүүхээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргаж болно. Гагцхүү бусад хуулиар шийдвэрлэх журам байгаа тохиолдолд бүх шатны журмаар шийдвэрлүүлсний дараа гомдол гаргах боломжтой. Шүүхээр шийдвэрлэснээс бусад тохиолдол гэдэгт Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн хуулийг шүүх хэрэглэсний улмаас үндсэн эрх зөрчсөн тохиолдлыг хамааруулахгүй.”¹⁴ гэж зохицуулсан байна.

Ийнхүү, гадаад зарим улс үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хуулийн шүүхээс харьяалан шийдвэрлэх боловч, тодорхой хязгаарлалтыг тавьдаг байна. Өөрөөр хэлбэл, Иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчилд хамаарах маргааны хязгаарлалтын хувьд гадаад орнуудад мөн тодорхой хязгаарлалт хийх тохиолдлууд байдаг. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн 4а дугаар зүйлд хүний дараах субъектив үндсэн эрхийг Үндсэн хуулийн шүүх хамгаалах талаар тусгажээ.¹⁵ Үүнд:

- Улсын бүх эрх мэдэл ард түмнээс эх үндэстэй байхтай холбоотой зохицуулалт /20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг/
- Үндсэн эрхийг тэгш эдлүүлэх болон нийтийн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зохицуулалт /33 дугаар зүйл/
- Сонгох, сонгогдох үндсэн эрхийн зохицуулалт /38 дугаар зүйл/
- Хуулиас гадуур шүүх байгуулахыг хориглохтой холбоотой зохицуулалт /101 дүгээр зүйл/
- Шударгаар шүүлгэх эрх болон эрүүгийн эрх зүйн шударга ёсны зохицуулалт /103 дугаар зүйл/
- Халдашгүй байх үндсэн эрхийн зохицуулалт /104 дүгээр зүйл/

Иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг авч хэлэлцэх талаар болон шүүхэд хандсан, эсхүл хуулийн бусад аргыг хэрэглэсэн ч үндсэн эрх нь сэргээгдээгүй гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргах хязгаарлалт нь дээрх байдлаар тодорхойлогдож байх ба үүнийг төслийн үзэл баримтлалд оруулсны дагуу нэмж оруулах нь зохистой байж болох юм. Гэхдээ Үндсэн хуулиар зохицуулаагүй байсан ч, органик хуулиар зохицуулах боломжийг уг өөрчлөлтийн төслөөр нээсэн боловч тухайн хязгаарлалтын хүрээ тодорхойгүй байна.

13 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй хоёр дахь хэвлэл*, (УБ, 2021), 120 дахь тал.

14 헌법재판소법 ([시행 2022. 2. 3.] [법률 제18836호, 2022. 2. 3., 일부개정]), Холбоос: https://www.law.go.kr/%EВ%B2%95%EB%A0%B9/%ED%97%8C%EB%B2%95%EC%9E%AC%ED%8C%90%EC%86%8C%EB%B2%95?Fbclid=iwar3jwwhw36mp4zdc-0Hy3kzinbxWJJ8HJXur1WLSGsjAQ2o-DE_t3a3aqrq. Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

15 *Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль*, (УБ, 2020), ХЗҮХ.

Явцын дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд “66.1.Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.” хэмээн заасан байна. Гэсэн хэдий ч төслийн үзэл баримтлалд тусгасан шүүхэд хандсан, эсхүл хуулийн бусад аргыг хэрэглэсэн ч үндсэн эрх нь сэргээгдээгүй гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргах талаар болон иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчилд хамаарах маргааны хязгаарлалтын талаар тусгаагүй байгаа нь анхаарал татаж байна. Эдгээр нь иргэний үндсэн эрхийг ҮХЦ-ээс шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой учраас Үндсэн хуульд тусгах эсвэл органик хуулиар зохицуулах хүрээг нарийвчлан тогтоох нь зүйтэй.

Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн эсэх

Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж тодорхойлсон.

Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт заасан хүний эрхийг хамгаалах буюу тухайн зохицуулалтын хэрэгжилтэд дээд хяналт тавих, шийдвэрлэх нь ҮХЦ-ийн үүрэг юм. Үндсэн хуулийн цэц нь 1992 онд Үндсэн хуульд батлагдсанаас хойш дээрх үүргээ хэрэгжүүлээгүй буюу иргэний үндсэн эрхийн зөрчлийн тодорхой маргааныг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт¹⁶ заасан ҮХЦ-ийн харьяалан шийдвэрлэх маргаанд иргэний үндсэн эрхийн зөрчлийг шийдвэрлэх агуулга тусаагүйтэй холбоотой. Үүнийг судлаачид шүүмжилж Үндсэн хуулийн үзэл баримтлал, зорилготой нийцээгүй хэмээн үздэг.

Энэ тухай хууль зүйн ухааны доктор, судлаач Ц.Сарантуяа “Өмчлөх, хуульд заасан тохиолдолд эд, мөнгөний тусламж авах зэрэг аль нэг эрх нь нийтийн засгийн аливаа актаар зөрчигдлөө хэмээн үзээд иргэн хүн Үндсэн хуулийн цэцэд хандвал Цэц маргааныг шийдвэрлүүлэхээр бүрэн эрхийнхээ дагуу холбогдох байгууллага, тухайлбал ердийн шүүхэд шилжүүлж энэ тухай өргөдөл мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ. Монголд иргэн хүн Үндсэн хуулийн 66-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгайлан заасан объектуудаар УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын, өөрөөр хэлбэл хүсэлт гаргагчийн нэгэн адил өөрийнх нь үндсэн эрх зөрчигдөөгүй байхаар хуульд туссан учир Үндсэн хуулийн цэц иргэн хүний индивидуаль үндсэн эрх бодит байдал дээр зөрчигдсэн тохиолдолд түүнийг шүүхийн журмаар Үндсэн хуулийг хэрэглэн сэргээх боломжгүй байдаг. Зөрчигдсэн

16 -хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
-ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
-Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;
-Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.

эрхийг манайд ч гэсэн ердийн шүүх сэргээдэг, харин үндсэн эрх зөрчигдвөл түүнийг ҮХЦ Үндсэн хуулийн нэрийн өмнөөс сэргээх боломж хараахан бүрдээгүй байна. Монголд иргэн хүн Үндсэн хуулийн цэцэд өөрт нь шууд хамааралгүй асуудлаар, тухайлбал аль нэг эрх зүйн акт үндсэн хууль зөрчиж байгаа эсхүл хуульд заасан хэн нэг албан тушаалтан үндсэн хууль зөрчиж байгаа эсэх асуудлаар хандах боломжтой. Ийнхүү иргэн хүн Үндсэн хуульд заасан цөөн тооны объектоор Цэцэд хандах эрхтэй бөгөөд үндсэн эрх энэхүү объектод ордоггүй. Иймд Үндсэн хуулийн “Хүний эрх” бүлгийн хэрэгжилт бодит байдалд хамгаалалтгүй орхигджээ. Харин иргэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан объектоор цэцэд өргөдөл, мэдээлэл ирүүлэхэд түүнд үндсэн эрхийн тухай асуудал агуулагдсан байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ аливаа шүүхийн зориулалт амьдралын тухайн нөхцөл байдалд эрхийг сэргээхэд Үндсэн хуулийн шүүхийн зориулалт үндсэн эрхийг сэргээхэд оршдог гэдэг нийтлэг зарчмаас Цэцийн эрх хэмжээ ихээхэн ялгагдаж буйг тэмдэглэе¹⁷.” гэж өөрийн байр суурийг илэрхийлжээ.

Мөн Үндсэн хуулийг батлах явцад БНМАУ-ын Ардын Их хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар чуулганы 1991 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурал дээр 9-р тойргийн депутат С.Зориг “Бид нар Үндсэн хуульдаа хүний эрхийг баталгаажуулах талаар асар олон заалт оруулсан. Өмнө нь зөрчиж байсан, одоо ер нь зөрчихгүй тийшээгээ хандъя. Тэрийгээ нийгмийнхээ суурь болгоё гэж үзсэн. Гэхдээ энэ хүний эрхийг хамгаалах тэр арга хэрэгслүүдээ бараг өгөөгүй, зөвхөн шүүхэд гомдол гаргах, ганц механизмыг оруулж. Энийг хангахад гурван механизмыг хийж болох юм аа Үндсэн хуульд. Нэгдүгээрт, шүүхэд өөрийнхөө гомдлыг гаргах, хоёрдугаар Их цаазын цэцэд Үндсэн хуулийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа юм бол хувь хүн гомдлоо гаргах эрхтэй. Гуравдугаарт, шүүхийн бус нэг механизм болох хүний эрхийн үндэсний комисс байгуулах гэж ийм гурван янзын механизмтай бид нар тэр Үндсэн хуульдаа заасан хүний эрхийг хамгаалах бололцоотой болно. Тэгээгүй тохиолдолд одоо шүүхдээ итгэл итгэл нь буурсан ийм үед тэр механизмуудаа хийж өгөхгүй бол бид нар баталгааг нь гаргаж чадахгүй байх”¹⁸ гэж хэлж энэхүү санааг дэмжиж байсан.

Түүнчлэн хууль зүйн ухааны доктор, судлаач О.Мөнхсайхан нь иргэний үндсэн эрхийн маргааныг ҮХЦ шийдвэрлэх талаар 2 үзэл баримтлал гаргаж, дараах байдлаар судалсан байна.

“Нэгдүгээр үзэл баримтлал бол ҮХЦТХ болон Цэцийн практикт тогтсон. Цэц хууль тогтоомж болон бусад холбогдох шийдвэрт абстракт хяналт хэрэгжүүлдэг боловч ердийн шүүхийн шийдвэрт Үндсэн хууль зөрчигдсөн эсэх асуудлыг шийдвэрлэдэггүй. Мөн, төрийн өндөр албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянадаг. Зөвхөн эрх бүхий этгээд төдийгүй иргэн цэцийн харьяаллын аль ч асуудлаар мэдээлэл гаргах эрхтэй (actio popularis). Хууль тогтоомж болон ҮХЦТХ-д заасан бусад шийдвэрээр үндсэн эрхээ зөрчүүлсэн гэж иргэн гэж үзвэл цэцэд өргөдөл гаргах боломжтой. Гэвч, иргэн шүүхийн шийдвэрээр үндсэн эрх нь зөрчигдсөн эсхүл хамгаалагдаж чадаагүй гэж үзвэл энэ асуудлаар цэцэд хандах боломжгүй. Тодорхой тохиолдолд зөрчигдсөн үндсэн эрхийн маргааныг цэц харьяалан шийдвэрлэхгүй байгаа нь Монгол Улс дахь хүний эрхийн сүл хамгаалалтын нэг шалтгаан болж байна.

17 Ц.Сарантуяа, *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт*, Эрдэм шинжилгээний өгүүлэл, (УБ, 2002), Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

18 “Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж” Боть VI, (УБ 2022), МУИХТГ, 696 дахь тал.

Хоёрдугаар үзэл баримтлалын дагуу иргэний өргөдөл бол Европын Үндсэн хуулийн шүүхүүдэд байдаг үндсэн хуулийн гомдолтой адилхан агуулгаар хэрэгжих хэрэгтэй. Энэ үзэл баримтлал бол нэгдүгээр үзэл баримтлалтай өрсөлдөхүйц төдийгүй цэцийг үндсэн эрхийн хамгаалагч гэсэн зорилгод нь хүргэх, Үндсэн хуулийн шүүхийн утгаар нь хөгжүүлэх, Үндсэн хуулийн нэр томьёо, логикт илүү тохирох, Үндсэн хуулийг боловсруулж баталсан түүхээр дэмжигдэж болохуйц, олон улсын шилдэг туршлагад нийцэх боломжтойгоороо илүү дээр юм. Өргөдлийг үндсэн хуулийн гомдлоор ойлговол түүнийг хүсэлттэй адилхан дүгнэлт гаргах, дахин хянан үзэх хоёр шатлалтай процедураар шийдвэрлэж болохгүй. Цэц өргөдлөөр үүсгэсэн маргааныг нэг удаа эцэслэн шийдвэрлэж, уг шийдвэрээ УИХ-руу явуулахгүй байхаар хуульчлах хэрэгтэй. Мөн, иргэний мэдээлэл гэдгийг үндсэн хуулийн маргааныг үүсгэх үндэслэл гэж үзэхгүй харин *amicus curiae* гэсэн агуулгаар ойлгож, нэгэнт үүсгэсэн маргааныг зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой үндэслэл, судалгааг маргааны тал биш иргэнээс авах суваг болгох нь илүү зохистой. Иргэний өргөдөл, мэдээллийн талаар хоёрдугаар үзэл баримтлалын дагуу Цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчилбэл Монгол Улс дахь үндсэн эрхийн зөрчил Үндсэн хуулийн болон олон улсын стандартын дагуу шийдвэрлэгдэх боломжтой болно. Улмаар иргэний үндсэн эрх зүгээр нэг тунхаг төдий биш харин бодитой хэрэгждэг эрх зүй болно.”¹⁹

Ийнхүү ҮХЦ нь иргэний үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэснээр Үндсэн хуульт ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг хангах юм. Түүнчлэн хүний субъектив үндсэн эрхийг Үндсэн хуулийн цэц хамгаалах явдал нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болно. Энэ нь хяналтад харьяалагдах субъектын үйл ажиллагаанд Үндсэн хуулийн заалт нэг бүрийг хэрэгжүүлэхийг шаардах, зөрчил гаргасан тохиолдолд арилгуулах чиг үүрэг гүйцэтгэх явдал юм.²⁰

Иймд Үндсэн хуульд зааснаар ҮХЦ-д иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг хүлээн авч шийдвэрлэх боломжийг нээж, ҮХЦ-ийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, иргэд субъектив үндсэн эрхээ хамгаалуулах Үндсэн хуулийн механизмыг бий болгосон энэхүү төслийн зохицуулалт нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэж байна.

Гэхдээ тус төсөлд “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.” гээд иргэн зөвхөн өөрийн үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд тухайн эрхээ сэргээлгэхээр өргөдөл гаргахаар тодорхойлсон нь “хуулийн хэрэгжилт дэх иргэний хяналт”-ыг хязгаарласан байна.

Тодруулбал, сүүлийн 23 жилд цэцийн шийдвэрлэсэн маргааны дийлэнх нь иргэдийн өргөдөл, мэдээллээр үүссэн байдаг. 1992 оноос 2007 онд иргэд 1000 гаран өргөдөл, мэдээлэл гаргасан. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тавигдсан цэцийн шийдвэрүүдийг судалж үзэхэд 1992-2015 оны хооронд цэцийн дунд суудлын

19 О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015), 64-81 дэх тал.

20 Ч.Энхбаатар, *Үндсэн хуулийн эрх зүй*, (УБ, 2007), 287 дахь тал.

хуралдаанаар нийт 164 маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж шийдвэрлэжээ. Эдгээрийн 159 маргаан буюу 97 хувь нь иргэний мэдээллээр үүссэн. Эндээс Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэхэд мэдээлэл чухал үүрэгтэй гэдэг нь харагдаж байна²¹.

Тиймээс ҮХЦ-д иргэн энэхүү төсөлд зааснаар иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийн улмаас хандахаас гадна хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх мэдээллийн дагуу ҮХЦ-ийн харьяалан шийдвэрлэх маргаан буюу объектоор хандах нь зохистой байж болно.

Явцын дүгнэлт

Тус өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуульд зааснаар ҮХЦ-д иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг хүлээн авч шийдвэрлэх боломжийг нээж, ҮХЦ-ийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхийг баталгаажуулан Үндсэн хуулийн зорилгод нийцэж буй хэдий ч, одоогийн Үндсэн хуульд байгаа иргэн мэдээлэл гаргаж ҮХЦ-д хандах зохицуулалтыг хассан нь Үндсэн хуулийн хяналтыг хязгаарласан шинжтэй болжээ.

3.2.2. “Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Тус өөрчлөлтийн төсөлд “Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.” гэж заасан байна. Тус зохицуулалт нь нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байна.

3.2.3. “Харилцан уялдаа” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” гэсэн шалгуурын хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуурын хүрээнд зохицуулалт бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгана.

1. “Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байх”, “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх” гэсэн Үндсэн хуулийн зохицуулалттай нийцэж буй эсэх

Тус өөрчлөлтийн төсөлд “Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.” гэж заасан байна.

Үүнээс “эцсийн шийдвэр гаргана” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.”, Үндсэн хуулийн

21 О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (Уб, 2015), 69 дэх тал.

Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасантай зөрчилдөх эсэх талаар маргаан үүсэж болох юм²².

Гэсэн хэдий ч, ҮХЦ буюу Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн бүлэгт хамааралгүй буюу Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргийнхээ хувьд Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй учир тухайн зохицуулалтын хувьд зөрчил үүсэхгүй гэж үзэж болно.

Мөн ҮХЦ-ийн иргэний үндсэн эрх зөрчигдсөн маргааныг шийдвэрлэхдээ хуулиар шийдвэрлэх журам байгаа тохиолдолд бүх шатны журмаар шийдвэрлүүлсний дараа цэцэд хандах зарчимтай нийцнэ. Энэ тухай хууль зүйн ухааны доктор, судлаач Ц.Сарантуяа “..Гэхдээ иргэн, хуулийн этгээд нь үндсэн хуулийн шүүхэд хандахын өмнө тухайн маргааныг хуульд заасан бусад бүх шат дамжлагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг урьдчилан авсан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эрхээ хамгаалуулахаар үндэсний эрх зүйн бүх механизмыг эхлээд гүйцээсэн байна...”²³ гэж тодорхойлсон байдаг бөгөөд эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улсад ч ийм жишиг бий.

Ийм учраас ҮХЦ болон Шүүх эрх мэдлийн байгууллагуудын хоорондын эрх мэдлийн болон чиг үүргийг ялгаатай байдлыг танин мэдэж, үндсэн хуулийн эрх зүйн харьцуулсан судалгааны үүднээс ул сууртай хандах шаардлагатай.

2. Өөрчлөлтийн төсөл нь ҮХЦ-д хамаарах буюу тавдугаар бүлгийн зохицуулалтуудтай нийцэх эсэх

Өөрчлөлтийн төслийн 66.1-д “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.” гэж зааснаас гадна 66.2-т “Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн” гэж өөрчлөлт оруулахаар тусгажээ.

Энэ нь одоо хэрэгжиж байгаа Үндсэн хуулийн зохицуулалт болох 66 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт бүхэлд нь өөрчлөлт оруулах ба дараах сөрөг үр дагаврыг бий болгож болох юм.

(1) хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, (2) ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, (3) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх, (4) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн

22 С.Нарангэрэл, “Монгол Улсын үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаарх академич С.Нарангэрэлийн бичмэл санал”, (Уб, 2023.04.24), Холбоос: <https://ip.ac.mn/c/1013593?Content=3707277>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

23 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй хоёр дахь хэвлэл*, (Уб, 2021), 119 дэх тал.

татах талаарх хүсэлтийг эрх бүхий албан тушаалтан гаргаж болно. Улмаар иргэн өргөдөл, мэдээлэл гаргаж ҮХЦ-д тухайн маргаантай асуудлаар хандах эрхийг хязгаарласан байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар “...Иргэд хууль тогтоомж дахь хүний эрхийн зөрчлийн асуудлаар шүүхэд хандахаас илүү Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол, мэдээлэл гаргахад хялбар, нээлттэй байдаг. Иймд уг комисс иргэдийн гомдол, мэдээллийг мэргэжлийн үүднээс хянаж, хууль тогтоомж хүний эрх зөрчсөн асуудлыг Үндсэн хуулийн цэцэд өгч (абстракт хяналт) шийдвэрлүүлдэг байх бүрэн эрхийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст олгохоор төсөлд заана...” гэж тусгаснаар ХЭҮК-оор дамжуулан иргэд мэдээллээ гаргах эрхтэй болжээ.

Явцын дүгнэлт

Тус өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуулийн “Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байх”, “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх” гэсэн зохицуулалттай зөрчилдөх магадлалтай бөгөөд ҮХЦ үндсэн эрх зөрчигдсөн тухай маргааныг шийдвэрлэхдээ органик хуулиар тухайн эрхийг сэргээн эдлүүлэх боломж байгаа тохиолдолд бүх шатны шүүхээр шийдвэрлүүлсний дараа ҮХЦ-д хандах байдлаар хязгаарлах нь зүйтэй. Гэхдээ органик хуульд тухайн зөрчигдсэн эрхийг сэргээх эрх зүйн зохицуулалт байхгүй тохиолдолд ҮХЦ-д шууд хандах эрхийг мөн хангах шаардлагатай. Ийнхүү хязгаарлалт тавих нь ҮХЦ-ээс Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих тэнцвэртэй байдлыг хангах үндэслэл болно.

Түүнчлэн тус төслийн дагуу Үндсэн хуулийн зохицуулалт болох Жаран зургадугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт бүхэлд нь өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуульд заасан ҮХЦ-д иргэн мэдээлэл гаргах эрхийг орхигдуулсан нь хуулийн хэрэгжилт дэх иргэний хяналтыг хязгаарласан шинжтэй байна.

3.3. Арван гуравдугаар зүйлийн нэг дэх хэсэгт оруулах өөрчлөлт

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл заалт	13.1.Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	13.1.Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.”

Хөдөөгийн сэргэлтийг дэмжих, нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор Үндсэн хуулийн арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн эрх барих байгууллага байнга оршдог хотыг нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар хот мөн.” гэж заасныг “...төрийн эрх барих дээд байгууллага байнга оршдог хотыг нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар хот мөн” гэж өөрчлөхөөр заажээ.

3.3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслөөр “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж өөрчлөх нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд хэрхэн нийцэх талаар уг төслийн үзэл баримтлалд тусгаагүй байна. Харин тус өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагыг төрийн дээд байгууллагуудыг

улсын нийслэлд заавал байх зохицуулалтыг өөрчилж, төрийн зарим байгууллагыг нийслэлээс нүүлгэн шилжүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгохын²⁴ сацуу хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хөдөөгийн сэргэлтийг дэмжих гэж тодорхойлсон.

Түүхэн эх сурвалжийг судалж үзвэл Үндсэн хуулийг хэлэлцэн батлах явцад улсын нийслэлийг хэрхэн томьёолох талаар хэд хэдэн хувилбарыг хэлэлцэж байжээ.²⁵ Үүнийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2.2. Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэн батлах явц дахь улсын нийслэлийг тодорхойлж байсан хувилбарууд

Төслийн нэр	Агуулга
1. Улсын Бага Хуралд өргөн барьсан 1991 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Монгол Улсын Их Цааз /Үндсэн хууль/-ын төсөл	12 дугаар зүйлд “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэлд тооцож түүний онцгой байр суурийг хуулиар бататгана. Монгол Улсын нийслэл бол Улаанбаатар хот мөн.
2. Монгол Улсын Их Цааз /Үндсэн хууль/-ийн төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн 1991 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн төсөл	“Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэлд тооцож түүний онцгой байр суурийг хуулиар бататгана. Монгол Улсын нийслэл бол Улаанбаатар хот мөн.”
3. Монгол Улсын Үндсэн хууль (Их цааз)-ийн төсөл буюу 1991 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн төсөл	Арван гуравдугаар зүйлд “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэл гэнэ”
4. 1991 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн барих төсөл	Арван гуравдугаар зүйлд “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэл гэнэ”
5. 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль	Арван гуравдугаар зүйлд “Монгол Улсын төрийн эрх барих байгууллага байнга оршдог хотыг нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар хот мөн”

Үндсэн хуулийг батлахаар хэлэлцэх үеийн дээр дурдсан 4 төслийн эхний хоёр төсөлд нийслэл хотын нэрийг тухайлан нэрлэж заасан бол дараагийн хоёр төсөлд нийслэл хотын нэрийг тодорхой тусгалгүйгээр төслийг хэлэлцэж байсан. Үүний шалтгааныг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:²⁶

Нийслэл гэдэгт юуг хэлэх вэ гэдгийг тодорхойлсон тул уг шаардлагыг хангасан хотыг нийслэл гэж үзэх, хотын нэрийг нэрлэн заах нь нийслэлийг шилжүүлэх үед төвөг учруулна;

Улсын нийслэлийг юу гэж нэрлэж Үндсэн хуульд оруулахыг Ардын Их Хурал дээр шийдвэрлэнэ;

24 Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, Холбоос: <https://d.parliament.mn/tusul/81df9e9a-3243-4a24-b9bf-6d0e571d7c21>., Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

25 “Парламент судалгааны эмхэтгэл” ХХ боть, (УБ, 2015), Парламентын судалгааны хүрээлэн 110 дахь тал.

26 Хамгийн гол асуудал бол юуг нийслэл гэж хэлэх вэ гэдгийг заачихсан байгаа., Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж, Боть II, 432 дахь тал, 13-р зүйл маань үндсэн хоёр юмыг тогтоож өгч байгаа юм. Нэгдүгээрт бид улсын нийслэл гэж юуг ойлгох, Үндсэн хуулийн ойлголт юу байхаа, хоёрдугаарт нийслэлийн нэр, орших газар, эрх зүйн үндсийг юугаар тогтоох вэ гэдгийг зааж өгч байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж, Боть II, 518 дахь тал,

Улсын нийслэлийн нэрийг ард нийтийн санал асуулгаар шийднэ гэж үзсэн тул нийслэлийн нэрийг төслөөс хасан Ардын Их Хуралд өргөн барьсан байна.

Үүнийг Ардын Их Хурлаар хэлэлцэж “БНМУ-ын нийслэл Улаанбаатар хот мөн.” гэсэн томъёоллыг нийт төлөөлөгчийн 70% нь, ажлын хэсэгт шилжүүлэхийг нийт төлөөлөгчийн 74 хувь нь тус тус дэмжсэн.²⁷ Үндсэн хуулийг хэлэлцэх үеийн Улсын Бага Хурал болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлээс үзвэл, нийслэл хотын шинжээс илүүтэй, нийслэл хотын нэрийг Улаанбаатар гэж оруулах эсэх дээр маргаж, эцэст нь арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийслэлийн шинж, 2 дахь хэсэгт уг шинжийг хангасан хотын нэрийг тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн гэнэ.” гээд төрийн дээд байгууллагууд байнга оршдог газрыг нийслэл гэж тодорхойлсон байна.

Төрийн дээд байгууллага гэдэгт Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх зэрэг шийдвэр үйл ажиллагаа нь улс орон даяар нэг мөр хэрэгждэг төрийн байгууллагыг хамруулан ойлгоно.²⁸ Харин Засгийн газраас өргөн мэдүүлсэн тус хуулийн төсөлд “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж өөрчлөхөөр тусгажээ. Уг өөрчлөлтийг оруулах шалтгаан нь төрийн зарим дээд байгууллагуудыг Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлснээр төвлөрлийг сааруулах, хот, хөдөөгийн хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангахад чиглэнэ.²⁹ Тодруулбал, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуй нэгжид төрийн үйлчилгээг ойртуулах, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах үүднээс төрийн эрх барих байгууллагыг Улаанбаатарт хотод төвлөрүүлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.³⁰

Төвлөрлийг бууруулах бодлого нь хөдөөгийн хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой байдаг.³¹ Энэ хүрээнд төвлөрлийг бууруулах онолын талаарх судлаачдын байр суурийг нэгтгэн үзвэл төвлөрлийг бууруулах нь “тодорхой чиг үүргийг төв засгийн газраас буюу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас түүний орон нутаг дахь салбар, эсхүл доод шатны засаг захиргааны нэгж, хот, тосгон, төрийн бус байгууллагад тодорхой эрх мэдлийг шилжүүлэх цогц ойлголт” хэмээн тодорхойлжээ.³²

Төвлөрлийг сааруулахад дараах аргыг хэрэглэнэ.³³

27 “Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж” Боть VI, (УБ 2022), МУИХТГ, 540 дэх тал.

28 Г.Совд нар, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, (УБ, 2000), 71 дэх тал

29 Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, Холбоос: <https://d.parliament.mn/tusul/81df9e9a-3243-4a24-b9bf-6d0e571d7c21>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

30 Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (УБ, 2023), ХЗҮХ, 29 дэх тал.

31 World Bank Decentralization Thematic Team, “What is Decentralization?, The online Source Book on Decentralization and Local Development”, Холбоос: http://www.ciesin.org/decentralization/English/General/history_fao.htm, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

32 Р.Хатансайхан, Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн зохицуулалт магистрын зэрэг горилсон судалгааны ажил, (УБ, 2023), Холбогдох тал.

33 World Bank Decentralization Thematic Team, “What is Decentralization?, The online Source Book on Decentralization and Local Development”, Холбоос: http://www.ciesin.org/decentralization/English/General/history_fao.htm, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

1. төвлөрлийг сааруулах /de-concentration/,
2. эрх шилжүүлэх /devolution/,
3. төлөөлөн гүйцэтгүүлэх /delegation/,
4. хувьчлах /privatization/

Төвлөрлийг сааруулах /De-concentration/ аргыг төвлөрлийг сааруулахад нөлөөлөл багатай гэж үздэг бөгөөд төв засгийн газраас засаг захиргааны нэгжид эрх мэдэл шилжүүлэх, санхүүгийн удирдлага болон хариуцлагыг дахин хуваарилах агуулгатай.³⁴ Төвлөрлийг бууруулах эрх шилжүүлэх /devolution/ аргын хувьд шийдвэр гаргах, санхүү, удирдлагын чиг үүргээс гадна улс төрийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлдэг. Өөрөөр хэлбэл, Засгийн газраас гаргасан шийдвэрийг орон нутагт тухайн нутгийн иргэдээс сонгогдсон орон нутгийн захиргааны байгууллага гүйцэтгэдэг бөгөөд энэхүү аргыг холбооны улсад түлхүү хэрэглэдэг.

Харин төлөөлөн гүйцэтгүүлэх /delegation/ арга нь Засгийн газар шийдвэр гаргах чиг үүрэг, хариуцлагыг Засгийн газраас бүрэн хянадаггүй хагас бие даасан байгууллагад шилжүүлдэг.³⁵ Өөрөөр хэлбэл, орон нутгаас байгууллагын удирдлагыг сонгох боловч тэрхүү удирдлага нь Засгийн газарт ажлаа хариуцдаг онцлогтой. Хувьчлах /privatization/ аргыг зах зээлийн хүрээнд баримтална. Жишээ нь УИХ-ын “Өмч хувьчлалын тухай” 1995 оны 11 дүгээр тогтоолыг дурдаж болно.³⁶

Одоогийн байдлаар Улаанбаатар хотод гүйцэтгэх эрх мэдэлд хамаарах 16 яам³⁷, Засгийн газрын тохируулагч 9, хэрэгжүүлэгч 29 агентлаг, нийт 54 байгууллага³⁸ үйл ажиллагаа явуулж байна. Мөн нийт хүн амын 47.6 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 63 хувь, нийт их дээд сургуулийн 90 хувь, худалдаа үйлчилгээний 84.2 хувь, нийт хадгаламжийн 76.5 хувь, бүртгэлтэй машины 84 хувь тус тус бүртгэлтэй байна.³⁹ Энэ байдлаар 2040 он гэхэд Улаанбаатар хотын хүн амын тоо 2.5 сая болж, Монгол Улсын нийт хүн амын 56 хувь нь нийслэл хотод төвлөрч, нэг га талбайд ногдох хүний нягтаршлаар одоо дэлхийд тэргүүлж буй Япон улсын Токио-Ёкохамагийн бүс, 13 дугаарт орж буй БНХАУ-ын Бээжин хотын түвшинд хүрэх төлөвтэй байна. Төвлөрөл эдийн засгийн хувьд эерэг нөлөөтэй гэж үздэг ч Улаанбаатар хотын хувьд хөрс, агаар, усны бохирдол, замын түгжрэл зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.⁴⁰ Ийнхүү үүсээд буй нөхцөл байдлын талаар Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч Улаанбаатар хот дахь төвлөрлийг сааруулахад бодлогын шинэчлэл шаардлагатай гэж үзжээ.⁴¹

34 Мөн тэнд.

35 Мөн тэнд.

36 “Өмч хувьчлалын тухай”, Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 11, (УБ, 1995), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/7026>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

37 Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль, (1993), Холбоос <https://legalinfo.mn/mn/detail/344>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

38 Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай, Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 07, (2020), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/15488>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

39 Хөдөөгийн сэргэлт, Ерөнхий сайдын илтгэл, (2022.03.10), Холбоос: <https://gazar.gov.mn/blog/today/h-d-gijn-sergelt-ndesnij-chuulgan-zohion-bajjuulagdlaa>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

40 Хот хөдөөгийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах арга хэмжээний санал боловсруулах ажлыг гүйцэтгэлээ, 2021.04.11.

41 Нутгийн удирдлага сорилт ба шийдэл үндэсний чуулганы эмхэтгэл, Төвлөрлийг сааруулах, нутгийн удирдлагыг бэхжүүлэх чиглэлээр Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн бодлого, (УБ, 2016), 35 дахь тал.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл дэх уг заалт нь төрийн эрх барих дээд байгууллагаас бусад төрийн дээд байгууллагыг Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэхээр байна. Уг хуулийн төсөл батлагдсанаар нийслэлийн төвлөрлийг сааруулж, хот, хөдөөгийн нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах боломж бүрдэх юм.

Харин байгууллагыг шилжүүлэх байршлын тухайд, БНСУ-ын захиргааны нэгдсэн хот болох Сэжоныг жишээ татаж болно. Энэхүү хот нь нийслэл Сөүл хотоос 70 км зайтай, төрийн захиргааны байгууллагыг төвлөрүүлсэн засаг захиргааны тусгай нэгж юм. Тус улс тусгай захиргааны хот байгуулснаар нийслэлийн Сөүлийн төвлөрлийг сааруулж, орон нутгийн өрсөлдөх чадварыг сайжруулсан туршлага байна. Сэжон хот байгуулагдсанаас хойших өөрчлөлтийг доорх хүснэгтэд харуулав.⁴²

Хүснэгт 2.3. БНСУ-ын Сэжон хот байгуулагдсанаас хойших өөрчлөлт

Утга	Байгуулагдахаас өмнө	Байгуулагдсаны хойш 1 жилийн дараа	Байгуулагдсаны хойш 3 жилийн дараа
Захиргааны нэгж	1 иеп /읍/ 7 мёон /면/	1 иеп /읍/ 9 мёон /면/ 1 дун /동/	1 иеп /읍/ 9 мёон /면/ 3 дун /동/
Газар нутаг	361.41 км	464.8 км	465 км
Төсөв	3,351 тэрбум вон	6,715 тэрбум вон	9,676 тэрбум вон
Эдийн засгийн бие даасан байдал	29.1%	38.8%	43.91%
Төрийн албан хаагчийн тоо	625 хүн	1,072 хүн	1,415 хүн
Оршин суугчдын тоо	100,946	116,842	197,379
Өрхийн тоо	42,606	47,902	75,849
Боловсролын байгууллага	Бага сургууль 17 дунд сургууль 7 ахлах сургууль 4	Бага сургууль 22 дунд сургууль 10 ахлах сургууль 7	Бага сургууль 26 дунд сургууль 13 ахлах сургууль 8
Авто машины бүртгэл	37,002	50,400	67,880
Аж ахуй эрхлэгч	472	632	761
Үйлдвэрлэлийн бүс	7	10	13

Ийнхүү, БНСУ-ын туршлагаас авч үзвэл Улаанбаатар хотын ойролцоо дэд бүтэц хөгжсөн төв суурин газарт төрийн зарим байгууллагыг нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд тухайн орон нутагт хотжилт бий болж хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах нөхцөл бүрдэх боломж бий. Ингэхдээ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Тавиндолдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох бусад суурь судалгаатай уялдуулан асуудлыг цогцоор шийдвэрлэх нь зохистой юм.

42 최진혁, 지방분권과 지역균형발전에 따른 세종특별자치시의 발전과제: 정부부처 이전을 중심으로, 충남대학교 사회과학연구소, 사회과학연구 제26권, (2015), 153면.

Явцын дүгнэлт

Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж өөрчлөх нь нийслэлийн төвлөрлийг сааруулах, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгод нийцсэн байна.

Үүнээс гадна тус төсөлд “төрийн эрх барих дээд байгууллага” гэх нэр томъёоноос гадна “Монгол Улсын Их Хурал” гэсэн нэр томъёог ашиглах байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулах боломж бий.

3.3.2. “Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

“Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн зохицуулалт, түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн Хоёрдугаар зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж өөрчлөхөөр тусгажээ.

Энэхүү өөрчлөлтөд хэрэглэсэн нэр томъёо болох “төрийн эрх барих дээд байгууллага”, “төрийн эрх барих байгууллага”-ын талаар өмнөх бүлэгт тодорхойлсон.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн уг заалтын хувьд “төрийн эрх барих дээд байгууллага байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.” гэж тусгасан. Энэхүү заалтыг агуулгын хувьд тайлбарлавал, нэгдүгээрт төрийн эрх барих дээд байгууллага орон нутаг руу нүүх тохиолдолд түүнийг даган нийслэлийн байршил солигдож болохоор байна. Хоёрдугаарт төрийн эрх барих дээд байгууллага шилжин суурьшсан газрын оноосон нэр “нийслэл Улаанбаатар” гэж нэрлэгдэх байдлаар бичигдсэн байна. Ингэхээр Хархорум хотын талаар яригдаж буй өнөө үед цаашид ойлгомжгүй байдал үүсгэх эрсдэл байна.

Иймд уг зохицуулалтаар төрийн дээд байгууллага байнга оршдог гэх үндэслэлээр нийслэлийг тодорхойлох бус, газар нутгийн байршлаар нийслэлийг тодорхойлж нийслэлд төрийн эрх барих дээд байгууллага байнга орших агуулгаар тусгах нь оновчтой байж болно.

Явцын дүгнэлт

Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж өөрчлөхөөр заасан нь “Ойлгомжтой байдал” шалгуурт нийцэж байна. Гэхдээ тус төсөлд төрийн эрх барих дээд байгууллага орон нутаг руу нүүх тохиолдолд түүнийг даган нийслэлийн байршил солигдох эсэхийг харгалзах нь зүйтэй.

3.4. Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	65.1.Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	65.1.Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно.

3.4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Өөрчлөлтийн төслийг батлан хэрэгжүүлснээр буюу ҮХЦ-ийн гишүүний бүрэн эрхийг хязгаарлах зоицуулалт үйлчилснээр гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангах, Үндсэн хуулийн дээд хяналтыг баталгаажуулах зорилготой.

Өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар тухайн өөрчлөлтийг оруулах үндэслэл нь ҮХЦ-ийн гишүүнээр дахин томилоход ямар нэгэн хязгаарлалт байхгүйгээс үүдэн олон удаа томилогдон ҮХЦ-ийн гишүүний албан үүргийг улиран гүйцэтгэж тэдний хараат бус байдал алдагдаж буйтай холбоотой бөгөөд уг нөхцөл байдлыг арилгахын тулд ҮХЦ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жил хэвээр үлдээж нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох заалтыг Үндсэн хуульд оруулж байна. Ингэснээр ҮХЦ-ийн гишүүнээр хэт удаан ажиллахыг хязгаарлах, ҮХЦ-ийн гишүүний хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг нэгээс илүү удаа дахин томилохыг хориглодог эрх зүйт төртэй улсуудын сайн туршлагыг өөрийн улсын Үндсэн хуульд нэвтрүүлэх ач холбогдолтой гэжээ.

Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасан. Тодруулбал, ҮХЦ-ийн гишүүний тоо, тэдгээрийг томилуулахаар санал болгох эрх бүхий этгээд, байгууллагыг тодорхойлохын сацуу бүрэн эрхийн хугацааг Үндсэн хуульд тусгажээ. ҮХЦ-ийн гишүүний томилгоог хууль тогтоох байгууллагын дураар шийдвэрлэхээс урьдчилан хамгаалсан, хоёр. Гишүүний бүрэн эрхийн хугацааг хуульчилснаар цэцийн гишүүн дахин томилогдохгүй бөгөөд ганц удаа цэцийн гишүүний албан үүргийг гүйцэх хязгаарыг тогтоосон⁴³ гэж тайлбарладаг эрдэмтэд байдаг ч ихэнх тохиолдолд дээрх Үндсэн хуулийн заалт нь “улируулан томилох”-ыг хориглосон заалт биш цэцийн гишүүний бүрэн эрхт хугацааг 6 жил байхаар тодорхойлсон заалт гэж ойлгодог. Энэ нь Үндсэн хуульд дээрх өөрчлөлт оруулах шалтгаан хэмээн үзэх бас боломжтой юм.

ҮХЦ-ийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглосноор гишүүний хараат бус байдал дээшлэх эсэх тухайд

Үндсэн хуулийн хяналт сайн хөгжсөн гадаадын зарим орны жишээг харвал, ихэнхдээ шүүгчийг дахин томилохыг хязгаарласан байдаг. Учир нь ҮХЦ-ийн гишүүн дахин томилогдохын тулд өөрийг нь нэр дэвшүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны ашиг сонирхлын дагуу шийдвэр гаргах магадлалтай тул “дахин

43 Н.Лүндэндорж, “Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар”, (УБ, 2022), 970 дахь тал.

томилогдох” талаар хязгаарлалт тавьж гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангадаг. Тодруулбал, дахин томилогдох боломжийг хуулиар олгох явдал нь шүүгчийн хараат бус байдалд харшилна.⁴⁴

1992 оны Үндсэн хуулийг боловсруулах явцад ҮХЦ-ийн гишүүнийг улируулан томилохыг хориглох заалт оруулах талаар гадны эрдэмтдийн дүгнэлт гарч байсан боловч дахин томилох асуудлыг илэрхий хориглосон заалт ороогүй учир өдийг хүртэл дахин томилогдсоор иржээ. 1992-2021 оны хооронд ҮХЦ-ийн гишүүнээр нийт 37 хүн томилогдон ажиллаж байснаас дөрвөн удаа улиран ажилласан 1 гишүүн, гурван удаа ажилласан 1 гишүүн, хоёр удаа улиран ажилласан 4 гишүүн байна.

Хүн ам цөөтэй Монгол Улсын хувьд ҮХЦ-ийн гишүүнийн бүрэн эрхт хугацааг 6 жилээр тогтоон нэг удаа томилох тохиолдолд шалгуур хангасан хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй. Тиймээс ҮХЦ-ийн гишүүнийг нэг удаа улируулан томилохыг зөвшөөрч бүрэн эрхийн хугацааг 12 жил байхаар зохицуулбал хүний нөөцийн хомсдолоос сэргийлэхийн зэрэгцээ цэцийн гишүүний хараат бус байдлыг баталгаажуулах боломжтой⁴⁵ хэмээн судлаачид санал нийлдэг.

ҮХЦ-ийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглосноор гишүүний хариуцлагыг дээшлүүлэх зорилгын тухайд

Төслөөр ҮХЦ-ийн гишүүний дахин томилогдох боломжийг бүрмөсөн хязгаарлаагүй. Зөвхөн 1 удаа дахин томилогдох боломжтойгоор зохицуулсан. Энэ нь ҮХЦ-ийн гишүүнд дахин 6 жил ажиллах боломжийг олгохын зэрэгцээ эхний бүрэн эрхийн хугацаан дахь үйл ажиллагааг үнэлүүлэх шаардлагыг бий болгож, үүгээр дамжуулж хариуцлагыг дээшлүүлэх зорилгыг хангаж байна. Нөгөө талаар энэхүү зохицуулалт нь цэцийн гишүүний хариуцлагыг дээшлүүлэхээс гадна илүүтэй хараат бус байдлыг дээшлүүлэхэд ач холбогдолтой зохицуулалт байж болох юм.

Түүнчлэн уг өөрчлөлт нь тухайн зорилгынхоо эсрэг үр дүнг үзүүлэх эрсдэлтэй хэмээн үзэж буй судлаачид бас байна. Тухайлбал “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хариуцлагатай өндөр албан тушаалыг нэг, хоёр удаагийн “түр зуурын олдосгүй” боломж мэт болгож, хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах “хоноцын” сэтгэхүйг Үндсэн хуулиар хөхиүлэн өөгшүүлж болохгүй бөгөөд харин Цэцийн гишүүнийг Монгол Улсын Үндсэн хуулиа хамгаалахын төлөө шударгаар, тууштай, нэр төртэй хүчин зүтгэж, улам бүр мэдлэг, туршлага хуримтлуулан тогтвор суурьшилтай мэргэшин ажиллуулахыг тэргүүн зэрэгт тавихыг эрхэмлэх нь эх орон, ард түмний язгуур эрх ашигт илүү нийцтэй байх болов уу...”⁴⁶ гэжээ.

ҮХЦ-ийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох өөрчлөлт нь “Зорилгод хүрэх байдал” шалгуурыг хангаж гэж үзлээ.

44 Ц.Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй хоёр дахь хэвлэл*, (УБ, 2021), 73-74 дэх тал.

45 О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь”, Эрх зүй сэтгүүл цуврал 36, (УБ, 2016), 12-16 дахь тал.

46 С.Нарангэрэл, “Монгол Улсын үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаарх академич С.Нарангэрэлийн бичмэл санал”, (УБ, 2023.04.24), Холбоос: <https://ip.ac.mn/c/1013593?Content=3707277>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

3.4.2. “Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Хуульд өөрчлөлт оруулах төслийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн холбогдох зүйл, заалтад заасан шалгуурыг хангасан эсэхийг шалгах ёстой.

Өөрчлөлтийн төсөлд зааснаар Үндсэн хуулийн 65.1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөхөөр болсон: “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно.”

Энэ хэсэгт орсон гол өөрчлөлт нь цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг нэг мөр тогтоохыг зорьсон. Өөрөөр хэлбэл, нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно гэсэн нь дахин томилогдох хязгаарыг тогтоосон агуулгатай. Тодруулбал, ҮХЦ-ийн гишүүн нь нэг удаа дахин томилогдож болох ба дахин томилогдсон бүрэн эрхийн хугацаа нь анх томилогдсон бүрэн эрхийн хугацаатай тэнцүү буюу зургаан жил байх бөгөөд ингэснээр ҮХЦ-ийн гишүүн нь дахин томилогдсон тохиолдолд нийтдээ 12 жил цэцийн гишүүнээр ажиллах юм. ҮХЦ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа, хэдэн удаа дахин томилогдох, дахин томилогдоход бүрэн эрхийн хугацаа хэдэн жил байхыг тус тус тодорхой заасан нь агуулгын хувьд ойлгомжтой байна. Мөн ХТХ-ийн 29.1 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн агуулгын нийтлэг шаардлагыг хангасан байна. Иймд төслийн Үндсэн хуулийн 65.1 дэх хэсгийг өөрчлөн найруулсан төслийн эх бичвэр нь “Ойлгомжтой байдал” шалгуурыг хангасан байна.

3.4.3. “Харилцан уялдаа” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Өөрчлөлтийн төслийн зорилго нь ҮХЦ-ийн гишүүний хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлж хүний эрхийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх бөгөөд энэхүү зорилгод хүрэх үүднээс ҮХЦ-ийн гишүүний дахин томилогдохтой холбоотой зохицуулалтыг нэг мөр хуульчилсан нь үндсэн хуулийн оршил хэсэг дэх зорилгод нийцсэн.

Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлд ҮХЦ-ийн бүрэлдэхүүн, гишүүний бүрэн эрхийн хугацаа, томилгоо, шаардлагын талаар тухайлан зохицуулсан.

Жаран тавдугаар зүйл.

1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.

3. Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно.

4. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.

5. Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно.

Дээрх Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг нь ҮХЦ-ийн гишүүний томилгоо, бүрэн эрхийн хугацааг тодорхойлсон бөгөөд цэцийн гишүүний дахин томилохтой холбоотой өөрчлөлтийг тус хэсэгт оруулах нь харилцан уялдааг хангаж буй хэрэг юм. Иймд төслийн Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулсан нь “Харилцан уялдаа” шалгуурыг хангасан байна.

Явцын дүгнэлт

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёрдугаар зүйлд зааснаар Монгол Улсын Үндсэн хуулийн 65.1 дэх хэсгийг өөрчлөн найруулсан нь “Ойлгомжтой байдал”, “Харилцан уялдаа” шалгуурыг бүрэн хангасан байна. Харин “Зорилгод хүрэх байдал” шалгуурыг тодорхой хэмжээнд хангаж байна.

3.5. Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг

<p>Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл заалт</p>	<p>66.2.Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:</p> <p>1/хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;</p> <p>2/ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;</p> <p>3/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;</p> <p>4/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.</p>
<p>Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл заалт</p>	<p>66.2.Үндсэн хуулийн цэц нь Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.</p>

3.5.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн дагуу УИХ, түүний нийт гишүүний 1/10-ээс доошгүй гишүүн, ХЭҮК-оос ҮХЦ-д хүсэлт гаргах боломжтой болно.

УИХ, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн хүсэлт гаргах тухайд

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд УИХ цэцэд хандаж хүсэлт гарган Үндсэн хууль зөрчсөн талаар маргааныг шийдвэрлүүлдэг. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т “Улсын Их Хурал, Улсын дээд шүүх хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналд үндэслэж гаргана.” гэж хуульчилсан.⁴⁷ УИХ-ын тодорхой тооны гишүүн ҮХЦ-д хандах эрхийн зохицуулалт одоогоор байхгүй.

47 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл №3, (УБ, 1992), Холбоос: <https://www.parliament.mn/nn/12604/>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

Аливаа парламент Үндсэн хуулийг сахиулахын төлөө ажилладаг байгууллага болохын хувьд Үндсэн хуулийн шүүхэд хандах гол субъектийн нэг байх учиртай. УИХ нь шийдвэрээ хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналаар гаргадаг. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад, Нэгдсэн хуралдаан хуралдаж асуудал нэг бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан асуудлаар ҮХЦ-д хүсэлт гаргахыг зөвшөөрсөн.

Гэвч УИХ нь ҮХЦ-д хүсэлт гаргах бүрэн эрхээ өнгөрсөн 31 жилийн хугацаанд нэг ч удаа хэрэгжүүлээгүй байна. УИХ дахь олонх Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн хуулийг бүрэн эрхийнхээ хүрээнд өөрчлөх, хүчингүй болгох боломжтой тул ҮХЦ-д хандах шаардлага үүсдэггүй. Иймд парламентын олонхын баталсан хууль нь Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд цөөнх ҮХЦ-д хүсэлт гаргаж маргаан үүсгэх эрх зүйн үндэслэлийг төсөлд тусгажээ.⁴⁸

1995 онд тус заалт Үндсэн хууль зөрчсөн талаарх маргаан өрнөсөн. Тодруулбал, "...Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурал ... хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналд үндэслэж гаргана." гэж заасан нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг Улсын Их Хурлын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ." гэж заасныг зөрчсөн талаар мэдээлэл гаргасан. ҮХЦ-ээс уг заалтыг Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж шийдвэрлэсэн ч 1997 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн "Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар уг заалтыг хүчингүй болгожээ. Тус эрх зүйн зохицуулалтын сөрөг талыг "...цэцийн тухай хуулийн уг заалт нь зарим үед парламент дахь улс төрийн тэмцлийг гудамжинд түлхэн гаргах өдөөн хатгалгын үүрэг гүйцэтгэж ч мэдэх юм..." гэж тайлбарлах нь бий.⁴⁹

УИХ олонхын саналаар шийдвэр гаргадаг бөгөөд гаргасан шийдвэрээ хамгаалах зүй ёсны сонирхолтой байна. Ардчилсан тогтолцоотой улсуудад харьцангуй цөөн тооны гишүүд хамтран эсхүл намын бүлэг Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байдаг нь парламент алдаагаа өөрөө засах, хууль тогтоох үйл ажиллагаанд хянуур хандах, төрийн тогтвортой байдлыг хангах хөшүүрэг болдог байна.

Иймд Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд тусгагдсан УИХ-ын нийт гишүүний 1/10-ээс доошгүй гишүүн цэцэд хандах зохицуулалт зорилгод нийцэж байна. Гэхдээ УИХ-ын гишүүн ҮХЦ-д хүсэлт гаргахад "уг тогтоолыг эсэргүүцсэн байх" гэсэн шаардлага тавих нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, УИХ-ын шийдвэрийг дэмжсэн гишүүн ҮХЦ-д хүсэлт гаргах нь өөрийн шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй адил агуулгыг илэрхийлнэ.

48 Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, 2 дахь тал.

49 "Цэцийн тухай хууль үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар", Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, (УБ, 1995.01.18), Холбоос: <https://old.legalinfo.mn/law/details/1129?Lawid=1129>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

ХЭҮК-оос ҮХЦ-д хандах тухайд

ХЭҮК⁵⁰ нь 2020 оны Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3.1.1-т зааснаар “Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага.” гэж тусгасан. ХЭҮК нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

Хүснэгт 2.4. Хүний Эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэг

<p>-Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх;</p> <p>- Хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах;</p> <p>- Хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх;-</p> <p>- Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;</p>
--

50 1991 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зохион байгуулсан шинжээчдийн зөвлөгөөнөөс “Хүний эрхийг дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын эрх зүйн зарчмууд” батлагдсан. Парисын зарчмууд нэршлээр түгсэн энэ баримт бичгийг хожим нь НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993/48/134 тогтоолоор батламжилжээ. “Парисын зарчмууд”-аар хүний эрхийг хангах, түүнийг сахин хамгаалах үндэсний байгууллагуудын бүрэн эрх, үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх наад захын хэм хэмжээг тогтоосон. 1993 онд Вена хотноо зохион байгуулагдсан Хүний эрхийн дэлхийн бага хурлаар олон улсын гэрээ, конвенцод заасан хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийг хүлээн зөвшөөрч, түүнийг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг бүхий хүний эрхийн үндэсний байгууллагыг Парисын зарчмуудад нийцүүлэн байгуулахыг гишүүн улс орнууддаа уриалсан билээ. Хүний эрхийн үндэсний байгууллага нь хараат бус, өргөн хүрээтэй бүрэн эрх олгогдсон, байнгын ажиллагаатай, олон ургальч төлөөллийг хангасан бүрэлдэхүүнтэй, олон нийтэд ойр дөт, үйл ажиллагаагаа явуулах санхүүгийн чадавхтай байх ёстой. Хуулийг дээдлэх, хараат бус, бие даасан байх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг тууштай хамгаалах, ил тод, шударга ажиллах нь хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааны зарчим юм. Эдгээр үзүүлэлтүүдээр нь хүний эрхийн үндэсний байгууллагын үр нөлөөг хэмждэг. УИХ-аас 2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, 2001 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Комиссын анхны гишүүдийг томилсноор Парисын зарчимд нийцсэн хүний эрхийн үндэсний байгууллага Монгол Улсад үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага юм. Энэхүү Комисс нь Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хороонд 2003, 2008, 2014, 2021 онуудад “А” статусаар магадлан итгэмжлэгдсэн, Ази Номхон Далайн Бүс Нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагын Чуулганы бүрэн эрхт гишүүн юм. УИХ-аас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталснаар Комиссын чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, дарга, гишүүний бүрэн эрх, зохион байгуулалт, хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол мэдээллийг шийдвэрлэх ажиллагаа болон хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэсний механизмыг байгуулсан зэрэг томоохон өөрчлөлтийг хийсэн.

- Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх;
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- Хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- Шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийн хэрэгжилтэд энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих;
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулж, УИХ-д хүргүүлэх.

ХЭҮК нь эрх бүхий байгууллага албан тушаалтанд хүний эрх зөрчигдсөн эсэх талаар санал, зөвлөмж, дүгнэлт гаргах, мэдээлэл хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд хяналт тавих, шалгалт хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг хүний эрхийг хамгаалах чухал субъект юм.⁵¹ Гэвч Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1-т заасан ҮХЦ-д хандах субьектэд ХЭҮК-ыг хамааруулаагүй байгаа нь хүний эрхийн чиглэлээр голчилж үйл ажиллагаа явуулдаг байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлагдмал байдлаар зохицуулж ирсэн. Иймд ХЭҮК нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллага болохын хувьд хүний эрхийг зөрчсөн хууль, эрх зүйн акт, эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийг ҮХЦ-д хандан шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Уг өөрчлөлтийн төслөөр ХЭҮК-оос Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлаар ҮХЦ-д хүсэлт гарган шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж буй явдал нь Үндсэн хуулийн үзэл баримтлал болон өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд бүрэн нийцсэн гэж үзлээ. Иймд ХЭҮК-оос хүний эрхийн зөрчлийн талаар ҮХЦ-д хүсэлт гаргах зхицуулалт нь Үндсэн хуулийн хяналтын агуулгад бүрэн нийцэж байх бөгөөд "Зорилгод хүрсэн байх" шалгуурыг хангаж байна.

Явцын дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг "Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хууль зөрчсөн тухай" гэх өөрчлөлтийг "Зорилгод нийцсэн байдал" шалгуураар үнэлж, дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

Нэг. УИХ-ын 1/10-ээс доошгүй гишүүн ҮХЦ-д хүсэлт гаргах нь Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд цөөнх энэ талаар ҮХЦ-д хүсэлт гаргаж маргаан үүсгэх боломжийг нээх, олонхын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэхэд тавих хяналтыг үр өгөөжтэй болгох зорилгод нийцэж байна. УИХ-ын гишүүн ҮХЦ-д хүсэлт гаргахад "уг тогтоолыг эсэргүүцсэн байх" гэсэн шаардлага тавих нь зүйтэй.

51 Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (УБ, 2023), ХЗҮХ, 11 дэх тал.

Хоёр. ХЭҮК нь хүний эрх зөрчсөн асуудлыг ҮХЦ-д хүсэлт гарган шийдвэрлүүлэх заалт нь Үндсэн хуулийн хяналтад бүрэн нийцэж буй тул өөрчлөлтийн төслийн зорилгод нийцэж байна.

3.5.2. “Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь заалтыг “Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.” гэж өөрчилсөн нь түүнийг хэрэгжүүлэх субъектийг тодорхой болгож, “Ойлгомжтой байдал” шалгуурыг хангасан хэмээн үзлээ. Учир нь энэхүү өөрчлөлтөөр УИХ-ын нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, ХЭҮК хүсэлт гаргахаар тодорхой заасан бөгөөд тус заалтыг нэгдмэл утгаар ойлгох нь зүйтэй юм.

Явцын дүгнэлт

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг “Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хууль зөрчсөн тухай” гэсэн өөрчлөлт “ойлгомжтой байдал” шалгуурт нийцэж байна.

3.6. Арван ес¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл заалт	2.Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл заалт	Тухайн хэсгийг хасаж буй. “19 ¹ .2.Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.” гэснийг хасах.

3.6.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Үндсэн хуулийн 19¹.2 дугаар зүйлийг бүхэлд нь хасаж өөрчлөлт оруулах нь төслийг батлан хэрэгжүүлснээр хууль тогтоомжийн төслөөр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Үндсэн хуулийн 19¹.2 дугаар зүйлийг бүхэлд нь хасаж Үндсэн хуульд өөрчлөлт оруулах зорилгыг төсөл боловсруулагч иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангахад оршино хэмээн тодорхойлжээ. Тодруулбал, төсөл батлагдан хэрэгжсэнээр Монгол Улсад иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангах нөхцөл бүрдэнэ гэсэн үг. Үүнийг шалгуур болгон үнэлнэ.

Өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар, улс төрийн нам байгуулахад хэт өндөр босго тогтоосон нь иргэний эвлэлдэн нэгдэх, төрийн үйл хэрэгт оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Энэ нь улс төрийн олон ургалч байдлыг алдагдуулах, төлөөллийн ардчиллыг сулруулах, нийгмийн тодорхой бүлгийг ялгаварлан гадуурхах, тэгш бус байдлыг бий болгохоор байна. Түүнчлэн өмнө

байгуулагдсан намуудад давуу боломжийг олгох нь ардчиллын зарчимд үл нийцнэ⁵² хэмээн үзжээ. Гэвч уг хэсгийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нэмж оруулсан учир тухайн үеийн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн үзэл баримтлалын талаар авч үзэх нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтийн /Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн/ үзэл баримтлалд 19¹ дүгээр зүйлийг нэмэх үндэслэлийг нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах, намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байх, хөрөнгө, орлогын эх үүсвэр болон зарцуулалтаа нийтэд байнга ил тод байлгах үүрэг хүлээх, намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, ил тод байдал, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх болзлыг хуулиар тогтоох⁵³ хэмээн дурджээ. Эндээс нам байгуулах гишүүдийн тоог Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн байхаар тогтоосон нь намыг улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах шаардлагыг хангахад шууд чиглэсэн байна. Тус хэсэг практикт хэрэгжиж зорилгодоо хүрэхэд тодорхой хугацаа зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж хэрэгжих хугацааг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр хуульчилсан.⁵⁴ Гэвч практикт хэрэгжихэд тус хугацаа ч хангалтгүй нөхцөл байдал өдгөө бий болоод буйг Зөвлөлдөх санал асуулгын дүн харуулж байна. Тус санал асуулгад “2028 оноос хэрэгжиж эхлэх Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтаар оруулсан босго нь бусад улсуудтай харьцуулахад хамгийн өндөрт тооцогдож байгаа юм.”⁵⁵ хэмээн дурджээ.

Өөрчлөлтийн төслийн тандан судалгаанд УДШ-д бүртгэлтэй улс төрийн намуудын гишүүний тоо болон сонгуулийн насны иргэдийн тоог тухайлан авч үзсэн байна.

Судалгаанд дурдсанаар 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулиар 2,000,624, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар 2,040,556 сонгуулийн насны иргэн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн байх⁵⁶ бөгөөд эндээс сонгуулийн насны 20 мянга буюу түүнээс олон сонгогч нэгдсэн тохиолдолд улс төрийн нам байгуулах боломжтой болохоор байна. Энэ нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг өдгөө мөн тооны гишүүн бүхий нам бий эсэхээр шалгаж болох юм. Тус судалгаанд дурдсанаар УДШ-д 36 улс төрийн нам бүртгэлтэй байх бөгөөд тэдгээрийн нийт гишүүний тоог гаргажээ. Дээрхээс үзвэл, Үндсэн хуулийн холбогдох заалтад заасан шаардлагыг хангасан 7 улс төрийн нам байх бөгөөд бусад 29 улс төрийн нам нь тус шаардлагыг хангаагүй⁵⁷ байх ажээ. Эндээс Үндсэн хуулийн 19^{1.2} дугаар зүйлд заасан нам байгуулахад тавигдах гишүүний тооны шалгуур нь өндөр буюу хэрэгжвэл эрхийн хязгаарлалт бий болгох эрсдэлтэй байгаа нь харагдаж байна.

52 Ардчиллыг хуулиар бэхжүүлэх Европын Комисс (Венецийн Комисс), ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба (ЕАБХАБ/АИХЭГ) Монгол Улс, Улс төрийн намын тухай хуулийн төслийн тухай судалгааны тайлан.

53 Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн танилцуулга, Холбоос: <file:///C:/Users/pc/Downloads/4.%D0%A2%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0.2019.06.06.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

54 Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль, (2019.11.14). Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/14776>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

55 “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, (УБ, 2023), 79 дэх тал.

56 Үндсэн хуулийн зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагад холбогдох тандан судалгаа, (УБ, 2023), ХЗҮХ, 15 дахь тал.

57 Мөн тэнд, 16 дахь тал.

Дээр дурдсанчлан Үндсэн хуулийн 19^{1.2} дугаар зүйлийн үйлчлэл одоогоор эхлээгүй байгаа. Үйлчилж эхэлснээр сөрөг үр дагавар бий болгох зохицуулалтыг бүхэлд нь хүчингүй болгосноор өөрчлөлтийн төслийн зорилго биелэх нь тодорхой юм. Иймд өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн 19^{1.2} дугаар зүйлийг бүхэлд нь хүчингүйд тооцсоноор иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангах зорилго хангагдах боломжтой байна.

3.6.2. “Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Хуульд өөрчлөлт оруулах төслийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн холбогдох зүйл, заалтад заасан шалгуурыг хангасан эсэхийг шалгах ёстой.

Үндсэн хуулийн 19^{1.2} дугаар зүйлийг хүчингүй болгож өөрчлөлт оруулж байгаа тул ХТТХ-ийн 24.10-т зааснаар хүчингүй болсонд тооцож байгаа хуулийн төслийн заалтад тухайн хуулийн хүчингүй болсонд тооцох бүх зүйл, хэсэг, заалтыг тусгасан байх ёстой.

Энэхүү өөрчлөлтийн төслийн хувьд Үндсэн хуулийн 19^{1.2} дугаар зүйлийг хүчингүй болгож буй бөгөөд тус төслийн хувьд зөвхөн тухайн хэсгийг л бүхэлд нь хүчингүй болгож буй тул дээрх шалгуур хангагдсан байна.

Мөн тус хуулийн 24.9 дүгээр зүйлд заасанчлан тухайн өөрчлөлт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтын зарим нэр томьёо, үг хэллэгийг өөрчилсөн буюу хассанаар түүний утга агуулга нэг мөр ойлгогдохооргүй байвал түүнийг өөрчлөн найруулах ёстой.

Үндсэн хуулийн 19¹ дүгээр зүйл нь дараах 3 хэсэгтэй. Үүнд

Арван ес¹ дүгээр зүйл.

1.Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.

2.Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.

3.Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.

Нэгдүгээр хэсэг нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгтэй шууд холбогдох бөгөөд улс төрийн намыг тус заалтын дагуу байгуулах тухай, мөн улс төрийн нам нь улсын хэмжээнд бодлого дэвшүүлж ажиллах тухай заажээ. Харин тус зүйлийн 3 дахь хэсэг нь намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байх тухай шалгуур болон намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтоох тухай зохицуулалтыг тусгасан байна.

Эдгээр хоёр хэсэг нь улс төрийн намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулах тухай буюу улс төрийн нам байгуулахад шаардах иргэний тоог тогтоосон Үндсэн хуулийн 19^{1.2}

дугаар зүйлийн 2-той утга агуулгын хувьд шууд холбогдохгүй байна. Иймд тус хэсгийг хасан бусад хэсгийг өөрчлөн найруулаагүй нь ХТТХ-ийн 24.9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Үндсэн хуулийн 19^{1.2} дугаар зүйлийг бүхэлд нь хасаж өөрчлөлт оруулж буй нь “Ойлгомжтой байдал” шалгуурыг хангаж байна гэж үзэв.

3.6.3. “Харилцан уялдаа” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал

Үндсэн хуулийн 19^{1.2} дугаар зүйлийг хүчингүй болгож өөрчилж байгаа нь ьус хуулийн бусад хүчингүй зүйл, заалтын харилцан уялдаатай байдал алдагдах эсэхийг шалгах нь зүйтэй.

19^{1.2} дугаар зүйлийн 1 болон 3 дахь хэсэг нь намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулах тухай буюу нам байгуулахад шаардах иргэний тоог тогтоосон Үндсэн хуулийн 19^{1.12} дугаар зүйлийн 2-той утга агуулгын хувьд шууд холбогдохгүй байгаа тухай “Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн хэсэгт дурдсан билээ.

Үндсэн хуульд намын тухай зохицуулсан Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэг нь Монгол Улсын иргэн эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөтэй, энэ эрх, эрх чөлөөг ёс бусаар хөндсөн, дордуулсан, хязгаарласан хууль тогтоохгүй, эдгээр эрх, эрх чөлөөтэй холбоотой хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэхдээ гүйцэтгэх болон шүүх эрх мэдэл мөн тийм зарчим баримтална гэдгийг баталгаажуулсан⁵⁸ заалт юм. Өөрөөр хэлбэл, тус хэсэг нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг тодорхойлсон үндсэн зохицуулалт. Харин 19¹ зүйл нь дээрх үндсэн зохицуулалтад үндэслэн нам байгуулагдах тухай, намын бодлогын шинж, цар хүрээ, намын гишүүдийн тоо, намын дотоод зохион байгуулалт, намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт мөн төрөөс намд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай тус тус зохицуулсан. Эндээс Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэг, 19¹ зүйл нь харилцан уялдаатай болох нь харагдаж байна.

Гэвч 19^{1.2} дугаар хэсэг нь зөвхөн нам байгуулахад шаардагдах намын гишүүдийн тооны шалгуурыг тогтоосон хэсэг юм. Өөрөөр хэлбэл харьцангуй бие даасан үйлчлэлтэй зохицуулалт юм. Хэдийгээр 19^{1.1} дэх хэсэгтэй агуулгын хувьд хамааралтай мэт боловч хууль зүйн техникийн хувьд ийнхүү харьцангуй бие даасан байдлаар бичигджээ. Иймд Үндсэн хуулийн 19^{1.2} дугаар зүйлийг хүчингүй болгож өөрчлөлт оруулж байгаа тул тус зүйл хүчингүй болсноор “Харилцан уялдаатай байдал” алдагдахгүй хэмээн дүгнэж байна.

Харин Хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн холбогдох зохицуулалттай хэрхэн уялдах талаар авч үзэх шаардлагатай юм. Учир нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах харилцааг Үндсэн хууль болон дээрх хуулиар л зохицуулсан байдаг.

Үндсэн хуулийн 19¹ дүгээр зүйлийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн ба тус нэмэлт өөрчлөлтийг оруулснаас хойш өдгөө 3 жил 5 сарын хугацаа өнгөрч буй. Төслийн дагуу 19^{1.2} дугаар зүйлийг хүчингүй болгож өөрчлөлт оруулах нь Монгол

58 Н.Лүндэндорж, “Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар”, (УБ, 2022), 226 дахь тал.

Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг нэгэнт оруулсан бол уг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш найман жилийн дотор уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт дахин оруулахыг хориглоно.” гэж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавигдсан хугацааны хязгаарлалтыг зөрчсөн явдал болохоор байна. Гэвч дээр дурдсанчлан Үндсэн хууль дахь холбогдох хязгаарласан зохицуулалтыг авч үзэх нь зүйтэй.

Үндсэн хуулийн Арван зургадугаар бүлгийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно” гэж заасан ба үүнээс өөр хязгаарлалт тусгаагүй байна. Тодруулбал, хууль санаачлах эрх бүхий субъект УИХ-ын ээлжит сонгууль явуулахаас 6 сараас өмнө байвал хэдийд ч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг гаргах эрхтэй байна. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг нэгэнт оруулсан бол уг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш найман жилийн дотор уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт дахин оруулахыг хориглоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн үзэл санаанд харшлах эрсдэл үүснэ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг өөрчлөн найруулах байдлаар 8 жилийн хугацааны хязгаарлалтыг эргэн харах шаардлага зүй ёсоор тавигдана. Ингэснээр төсөл болон Монгол Улсын Үндсэн Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн уялдаа хангагдах юм.

3.7. “Харилцан уялдаа” шалгуурын хүрээнд үнэлсэн байдал /Өөрчлөлтийн төслийн хүрээнд нэгтгэн үнэлсэн нь/

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.8 дугаар зүйлд заасны дагуу “Харилцан уялдаа” гэсэн шалгуурын хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт хоорондын болон бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгадаг. Үүний дагуу доорх хүснэгт дэх асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоосон болно.

Хүснэгт 2.5. “Харилцан уялдаа” шалгуурыг Өөрчлөлтийн төслийн хүрээнд нэгтгэн үнэлсэн нь

№	Шалгах хэрэгсэл	Тайлбар
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	1.Хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн хамгаалалтыг бэхжүүлэх; 2.Улс төрийн нам байгуулахад тавигдах шаардлага; 3.Сонгуулийн тогтолцоо болон парламентын гишүүдийн тоог нэмэхтэй холбоотой асуудал; 4.Хөдөө, орон нутгийн сэргэлтийг дэмжих, төвлөрлийг бууруулахтай холбогдсон заалтууд нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд бүрэн нийцэж байна.

2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Өөрчлөлтийн төсөлд “хууль тогтоомж” гэсэн хэсэг байхгүй болно.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Өөрчлөлтийн төсөлд УИХ-ын сонгуулийн тогтолцоог тусгахдаа “мажоритар”, “пропорциональ” гэх нэршлийг хэрэглэсэн байна. Харин “мажоритар” гэснийг “олонхын тогтолцоо” гэж, “пропорциональ” гэснийг “хувь тэнцүүлсэн тогтолцоо” гэж, сонгуулийн энэ хоёр тогтолцоог нэгтгэснийг “сонгуулийн холимог тогтолцоо” гэх зэргээр монгол хэлний оноосон нэрээр өөрчлөх нь Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн” гэж заасантай бүрнээ нийцэх юм.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Өөрчлөлтийн төслийн зүйл, заалт тухайн төсөл болон бусад хуулийн заалттай зөрчилдөхгүй байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Өөрчлөлтийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан заалт байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Өөрчлөлтийн төсөлд Үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий субъект нь ҮХЦ байхаар тусгасан. Мөн Цэцэд хандах этгээдэд УИХ-ын нийт гишүүдийн 1/10 болон Хүний эрхийн үндэсний комисс багтаж байгаагаас үзэхэд хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан гэж үзлээ.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Өөрчлөлтийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй байна.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжгүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Өөрчлөлийн төсөлд албан татвар, төлбөр, хураамжийн талаар эрх зүйн зохицуулалт тусгаагүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Өөрчлөлтийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг тусгаагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1993 оны 48/134-р тогтоолоор баталсан Хүний эрхийн үндэсний байгууллагын нөхцөл байдлын талаарх зарчим /Парисын зарчим/-д нийцэхээр байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Өөрчлөлийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг алдагдуулахгүй.

14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Өөрчлөлийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Өөрчлөлтийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Өөрчлөлтийн төсөлд хориглосон хэм хэмжээг тусгаагүй.

Явцын дүгнэлт

"Харилцан уялдаа" шалгуурын хүрээнд Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван ес¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох бүлэгт судалгаа хийсэн болно.

Энэхүү хэсэгт аргачлалд заасан 16 асуултын хүрээнд хүснэгт хэлбэрт оруулан төслийн заалтын "Харилцаа уялдаа" хэсгийг бүхэлд нь шалгаж, дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Үндсэн Хуульд өөрчлөлт оруулах төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байна.
- Үндсэн Хуульд өөрчлөлт оруулах төсөлд Үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий субъект нь ҮХЦ байхаар тусгасан. Мөн Цэцэд хандах этгээдэд УИХ-ын нийт гишүүдийн 1/10 болон ХЭҮК багтаж байгаагаас үзэхэд хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
- Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэх үүднээс Монгол Улсын Үндсэн Хуульд өөрчлөлт оруулах төсөлд хэрэглэсэн гадаад нэр томъёо буюу "мажоритар" болон "пропорциональ" гэсэн нэршлийг хэвшиж тогтсон монгол үгээр шууд бичих нь зүйтэй.
- Үндсэн Хуульд өөрчлөлт оруулах төсөлд тусгагдсан "иргэн өөрийн зөрчигдсэн субъектив эрхийг сэргээлгэхээр Цэцэд хандах" талаарх зохицуулалт Үндсэн хуулийн 47.1, 50.2-д заасан зохицуулалттай давхцах эрсдэлтэй.

3.8. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал"

Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэхдээ хууль тогтоомжийг хэрэглэх этгээд, мэргэжлийн холбоодоос өөрчлөлтийн төсөлд бичгээр санал авах, санал асуулга явуулах, холбогдох байгууллага, этгээдүүдийн хүрээнд хэлэлцүүлэг явуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж, тэдгээр этгээдүүд уг хуулийн төслийн зохицуулалтыг ямар хэмжээнд хүлээн авч байгааг судалдаг. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн зохицуулалтаар тодорхой эрх, үүрэг хүлээх этгээдүүдийн санаа бодлыг тандах зорилготой.

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуурын хувьд төсөл боловсруулахаас өмнө болон дараах шатанд иргэд болон холбогдох байгууллагуудыг хамруулан зөвлөлдөх үйл ажиллагаа зохион байгуулж, үр дүнг нэгтгэх ажил хийгдэж буйг харгалзан үзэх шаардлага байна.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуульд орох өөрчлөлт буюу төр, ард түмэн хоорондын харилцааны үндэс болсон “нийгмийн гэрээ” болохын учир бусад хууль тогтоомжоос онцлог байдлаар хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэх нь зүйтэй. Иймд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэх гол шалгуур нь тухайн төслийг иргэд, тэр дундаа холбогдох салбарын судлаачид хэрхэн ойлгож, хүлээн авч буй байдлыг тодруулах, хүлээн зөвшөөрч буй эсэхийг шалгах нь тохиромжтой хэмээн үзлээ.

3.8.1. “Зөвлөлдөж шийдье” зөвлөлдөх санал асуулга

Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолын дагуу “Зөвлөлдөж шийдье” зөвлөлдөх санал асуулгыг хоёр үе шаттай зохион байгуулсан.

Эхний шатны санал асуулга 2023 оны 01 дүгээр сарын 26-наас 02 сарын 02-ныг дуустал үргэлжилсэн ба тус санал асуулгад түүвэрт сонгогдсон 157 нэгжийн 1570 иргэн хамрагдсан ба статистикийн байгууллагаас тусгайлан бэлтгэсэн 77 мэдээлэл цуглуулагч ажилласан байна. Хоёр дахь шат мөн оны 02 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулагджээ. Үндэсний статистикийн хороо 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолын дагуу зохион байгуулсан зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн тайлан”-г боловсруулан Зөвлөлдөх зөвлөлд хүргүүлсэн байна.

Зөвлөлдөх зөвлөл дээрх Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн тайланг хэлэлцэж, 02 дугаар сарын 17-ны өдөр нэг ба хоёрдугаар шатны санал асуулгын дүнгээр оролцогчдын олонхын саналаар дэмжигдсэн асуудлуудыг Монгол Улсын Их Хурал шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлж, харгалзан үзэх нь зүйтэй хэмээн үзэж 4 бүлэг зөвлөмжийг гаргасан. Тус зөвлөмжийн 2.3-т “Иргэдийг төлөөлөх парламентын чадавхыг нэмэгдүүлж, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх”, 2.4-т “Монгол Улсын Их Хурлын сонгуулийг олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулан явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх”, 2.6-д Улс төрийн хатуу намын хатуу гишүүнчлэлээс татгалзаж, бодлогын нам болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх”, 3.6-т “Засгийн газар засаг захиргааны шинэчлэл хийх саналыг боловсруулж УИХ-д оруулж шийдвэрлүүлэх” хэмээн тус тус заасан нь Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн агуулга болон үндсэн үзэл баримтлалын хувьд нийцсэн байна.

3.8.2. “D-Parliament” цахим системд иргэд, судлаач, хуульчдын гаргасан санал

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹ дүгээр зүйлд Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Тодруулбал, тус 39¹ дүгээр зүйлийн 39^{1.1}-д Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэхдээ тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар асуулт асуух, санал өгөх эрхээ Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим хуудас, гар утас, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан Улсын Их Хурлын албан ёсны программ хангамж /цаашид “цахим хуудас” гэх/-аар дамжуулан хэрэгжүүлж болно гэжээ.⁵⁹

59 Монгол Улсын Их Хурлын тухай хууль, (УБ, 2020)

Энэхүү заалтад үндэслэн Улсын Их Хурлын үндсэн үйл ажиллагаа болох хууль тогтоох үйл хэрэгт иргэд, олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн “D.PARLAMENT.MN”-д Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хуулийн төслийг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр байршуулж иргэдийн саналыг авч эхэлсэн байна.

2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар тус цахим системд иргэдийн өгсөн санал болон бидэнд ирүүлсэн саналуудыг Өөрчлөлтийн төслийн зүйл тус бүрээр ангилан авч үзье.⁶⁰

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг: “1.Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.”

Хүснэгт 2.6. Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлтөд өгсөн судлаач, иргэдийн санал

№	Санал өгсөн	Агуулга
1.	Судлаач 1	Тухайн парламентын гишүүдийн тоо оновчтой байгаа эсэхийг үнэлэхдээ нэг талаас тухайн улсын иргэдийн төлөөллийг бүрэн хангаж байгаа эсэх, нөгөө талаас зорилго, чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхийг гол шалгуур болгох ёстой. Судлаачийн нүдээр, бусад орны туршлагын өнцгөөс харвал Монгол Улсын Их Хурлын гишүүдийн тоог 100- 120 орчим байлгахад тохирмоор байна гэж үзнэ. Сонгуулийн мажоритар ба пропорциональ тогтолцооны аль аль нь давуу ба сул талтай, иймд эдгээрийг хослон хэрэглэх нь сул талыг сааруулж, давуу талыг нь ашиглах бололцоо олгох тул зөв алхам гэж үзэж дэмжиж байна.
2.	Судлаач 2	Улс төрийн тогтолцооны томоохон өөрчлөлт нь гишүүдийн тоотой шууд хамааралтай. Сонгуулийн хууль, Намын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүд ҮХНӨ-тэй салшгүй холбоотой гэж хувьдаа үзэж байна. Гишүүдийн тоо нь парламентын засаглалын бодит баталгаа, илрэл, чадамж нь байна.
3.	Судлаач 3	Парламентын засаглалыг төгөлдөржүүлэхэд тоог нэмэгдүүлэх нь өөрөө төлөөллийн оролцоог хангах хамгийн зөв алхам л гэж харж байна. Гол нь УИХ-ын одоогийн төсөв нэмэгдэхгүй байх хэрэгтэй байна.
4.	Иргэн 1	Монголын улс төр эрх мэдэл, эд баялаг, найз нөхөд, худ ургийн сүлжээндээ идэгдэж буй энэ цаг үед зоригтойгоор парламентын шинэчлэл хийх хэрэгтэй. Ард түмэн “хулгайчдын тоог нэмэх гэлээ” гэж байгаа нь төр засагтаа итгэх итгэл ямар их унасныг харуулж байгаа хэлбэр. Энэ унасан итгэлийг шинжлэх ухаанчаар эрүүлээр сэргээх нэг арга нь Үндсэн хуулийн өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга мөнөөс мөн.
5.	Иргэн 2	Өнөөдөр УИХ-ын нэг гишүүн 3 хүртэл байнгын хороонд харьяалагдах, нэг байнгын хорооны гишүүдийн тоо 12-19 хүртэл байна. Байнгын хороо нь хуулийн судалгаа хийх, хуулийн төслийг хэлэлцүүлэх зэрэг хууль боловсруулах үйл явцыг бүгдийг хариуцан гүйцэтгэж эцэст нь батлуулдаг. Улмаар батлуулсан хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах ёстой. Өнөөгийн байдлаар энэхүү үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх чадамж “давжаа парламентад” их бага байна. Парламентын нэг гишүүний хүн амыг төлөөлөх төлөөллийн чадамж нэмэгдэж иргэдэд илүү хүртээмжтэй улс төрийн шийдвэр гаргалтууд хийдэг болохын төлөө бид гишүүдийн тоог 152 болгож өөрчлөх зайлшгүй шаардлага байна

60 Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, Холбоос: <https://d.parliament.mn/tusul/81df9e9a-3243-4a24-b9bf-6d0e571d7c21>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25

6.	Иргэн 3	Хүн ам 1992 оноос хойш 1.5 дахин өссөн байтал 76 төлөөлөл байгаа нь иргэн бүрийн санал гээгддэг, иргэн бүрийг төлөөлдөг тогтолцоог халах цаг болсон. Холимог элемент оруулж ирж байгааг маш зөв гэж үзэж байна
7.	Иргэн 4	УИХ-ын хууль батлах үйл явцыг сайжруулах, ард иргэдийн эрх ашиг, дуу хоолойг парламентын түвшинд тусгах боломж нөхцөл улам сайжрах, иргэдийн улс төрийн оролцоо нэмэгдэх зэрэг давуу талтай юм.
8.	Иргэн 5	Гишүүдийн тоо цөөн байгаа нь УИХ-д чанаргүй хууль батлагдах, авлига албан тушаалын хэрэг гарах эрсдэлийн бий болгож байгаа тул гишүүдийн тоог нэмэх хэрэгтэй.
9.	Иргэн 6	Өнөөдрийн өөхнөөс, маргаашийн уушги” гэж.. Алс хэтээ харсан, үр хүүхдээ бодсон, улс орноо гэсэн хэн боловч гишүүдийн тоог нэмэгдүүлэхийг дэмжих байлгүй дээ. Одоогийн 76 гишүүн 2-3 байнгын хороонд харьяалагддаг, хууль чанаргүй батлагддаг, эрх мэдлийн хэт төвлөрөл гээд асуудал их байна
10.	Иргэн 7	76-хан гишүүнтэй байх нь ганц хоёрхон хүний нөлөөлөлд автах өндөр эрсдэлтэй. Өнгөрсөн 30 жил бэлхнээ харуулж байна. Ер нь тоог нэмэхгүй бол цаашид хэмжээгүй мэдэлтэй хэдхэн хүнийг бий болгосоор л байх болно. Тэгэхээр гишүүдийн тоог 152-оос бүр ч олон болгох ёстой. Ер нь онолын хүрээнд нэг хүн 50 орчим хүнтэй ойр харилцаатай байж чаддаг. /Theory of Dunbar's number/ Тэгэхээр Их Хурлыг 2 хүн атгах боломжтой. Парламентын ардчилсан манай оронд ийм зүйл байх нь утгагүй хэрэг. Сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд шууд тусгаж өгөх нь сонгууль бүрийн өмнө дүрмээ өөрчилдөг байдлыг засах томоохон дэвшил болно гэж бодож байна.
11.	Иргэн 8	Манайх шиг цөөн хүн амтай оронд 76 гишүүн хангалттай. Ямар ч санаачилга, бүтээмж гардаггүй энэ орон тоог нэмэх шаардлага байхгүй
12.	Иргэн 9	Гишүүдийн тоог 100% буюу 2 дахин нэмэгдүүлж буйг дэмжихгүй. Харин 50% буюу 38-аар нэмэгдүүлж 114 гишүүнтэй болох.
13.	Иргэн 10	Дэмжихгүй байна. Нэг танхимтай хяналтгүй парламент манайд тохирохгүй нь сүүлийн 30 жилд батлагдлаа. Одоо өөрсдийгөө бодолгүй зоригтой шийдвэр гаргаж хоёр танхимтай парламенттай болмоор байна Сонгодог хэсгээс нь санал аваад сонгодог жирийн иргэдээс санал авах хэрэгтэй

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг: “1.Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.”

Хүснэгт 2.7. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлтөд өгсөн иргэдийн санал

№	Санал өгсөн	Агуулга
1.	Судлаач 1	Иргэд Цэцэд хандах үндэслэлийг хумихад хүргэнэ. Хүний эрхийн үүднээс дүгнэвэл боломжийн заалт юм шиг. Нөгөө талаас, нэгд, ердийн шүүхийн, үүний дотор Дээд шүүхийн шийдвэрийг үл зөвшөөрсөн тохиолдолд үндсэн эрх зөрчигдсэн гэсэн үндэслэлээр иргэдээс Цэцэд хандах үүд хаалга нээгдэнэ. Энэ нь Цэц ба Дээд шүүхийн хооронд сөргөлдөөн үүсгэх, хэргийн харьяалал булаацалдаж байгаа юм шиг ойлгомжгүй байдал бий болгох, шүүх эцсийн шийдвэр гаргах зарчимтай зөрчилдөх аюултай. Түүнчлэн ийм маргаан хэр олон гарах бол, энэ талаар судалгаа, тооцоо хийсэн юмуу? Бусад орны жишгээс харвал иргэдээс Цэцэд хандах нь эрс багасна, гэтэл өнөөгийн практикаас харвал иргэдийн өргөдөл, мэдээлэлд үндэслэн үүсгэсэн маргаан зонхилдог.

2.	Судлаач 2	Иргэний субъектив эрхийг Үндсэн хуулийн цэц хамгаалахыг хууль зүйн салбарын олон олон судлаачид, хуульчид олон жил дэмжиж ирсэн учир энэхүү өөрчлөлт нь дэмжвэл зохих өөрчлөлт даруй мөн билээ. Харин иргэний зүгээс Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргах явдлыг хассаныг эргэж харууштай. Мөн энэхүү өөрчлөлт нь өдгөөгийн Үндсэн хуулийн цэцийн хүний нөөцийн байдлыг нэлээд өөрчлөх үр дагавартай байгааг анхаарах нь зүйтэй. Тодруулбал, Үндсэн хуулийн цэцэд эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульчид ажиллах зүй ёсны шаардлага үүсэх нь тодорхой байна.
3.	Хуульч 1	Улс төрийн тогтолцооны томоохон өөрчлөлт нь гишүүдийн тоотой шууд хамааралтай. Сонгуулийн хууль, Намын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүд ҮХНӨ-тэй салшгүй холбоотой гэж хувьдаа үзэж байна. Гишүүдийн тоо нь парламентын засаглалын бодит баталгаа, илрэл, чадамж нь байна.
4.	Иргэн 1	Үндсэн хуулийн цэц хүний субъектив эрхийн маргааныг ийнхүү хянан шийдвэрлэхээр төсөлд тусгагдаж байгаа нь маш сайшаалтай. Ийнхүү Үндсэн хуулийн цэц нь үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэж буй нь шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгэн хэлбэр болох учир Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх шаардлагатай.
5.	Иргэн 2.	Цэц үндсэн эрхийн маргааныг шүүх нь зүйтэй. Үндсэн хуулийн цэц гэдэг бол үндсэн хуулийн хэм хэмжээг сахиулах чиг үүрэг бүхий байгууллага. Монгол Улсын Үндсэн хууль дахь хүний эрх, эрх чөлөөний заалтуудад хяналт тавих, иргэдийн зөрчигдсэн эрхээ сэргээлгэх боломжоор хангах нь зүйтэй.

Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “томилно” гэснийг “томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно” гэж өөрчилсөн тухайд

Хүснэгт 2.8. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлтөд өгсөн иргэдийн санал

№	Санал өгсөн	Агуулга
1.	Судлаач 1	65 дугаар зүйлийн 1-ийн өөрчлөлтийг дэмжиж байна. Бусад орны туршлагаас харвал үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг ахиухан хугацаагаар [9-12 жил] томилдог бөгөөд тэдгээрийг улираах журам үндсэндээ байдаггүй. Учир нь төрийн бодлогын асуудалтай хэт удаан зууралдвал аль нэг улс төрийн хүчинд үйлчлэх, мөн бүрэн эрхийн хугацаа дуусах дөхөөд ирэхлээр анх томилсон субьекттэй тал засах эрсдэлтэй гэж үздэг. Нэмэлт, өөрчлөлт орсноор Цэцийн гишүүн улирсантайгаа нийлээд дээд тал нь 12 жил Цэцэд ажиллах юм байна.
2.	Иргэн 1	“томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно” гэснийг “томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дахин нэг удаа томилж болно” гэж найруулах. Төслийн найруулгыг уншвал 2-оос дээш томилохгүй шүү гэх агуулга байгаа боловч нэг удаа бол заавал томилох мэтээр уншигдаж байна.
3.	Иргэн 2	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно” гэж заасан улс төрийн өндөр мэргэшилтэй гэдгээ нэг мөр болгохгүй бол аймгийн намын хорооны дарга цэцийн гишүүн болдог үзэгдэл сум багийн улс төрийн ажилтнууд ч очоод суух боломжтой гэсэн үг.

Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр” гэснийг “Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай” гэж өөрчилсөн тухайд.

Хүснэгт 2.9. Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн өөрчлөлтөд өгсөн санал

№	Санал өгсөн	Агуулга
1.	Судлаач 1	66 дугаар зүйлийн 2-т орж байгаа өөрчлөлт нь дээрх өөрчлөлттэй уялдаж байгаа бөгөөд Хүний эрхийн үндэсний комиссыг Цэцэд хандах субъектын тоонд оруулж байгааг дэмжинэ.
2.	Иргэн 1	Цэцийн үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлт байгаа учир Цэцийн шийдвэрийн биелэлтийг хангахтай холбоотой асуудлыг нэг мөр хуульчлах. Цэцийн шийдвэрийн дагуу Үндсэн хуулийн зөрчлийг арилгах нэрийдлээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг ч тэр нь тухайн хуулийнхаа анхны үзэл баримтлал, бусад зүйл, заалт дахь хэм хэмжээтэй уялдахгүй зөрчилдөх, хийдэл үүсгэх байдал их байгааг анхаарах. Мөн Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, ..." гэсэн төслийн найруулгыг "Улсын Их Хурлын нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн ..." найруулгыг өөрчлөх. Мөн УИХ-ын гишүүн ганцаараа иргэний хувиар Цэцэд мэдээлэл, хүсэлт гаргах тохиолдолд дээрх зохицуулалт хэрхэн үйлчлэхийг анхаарах.

Явцын дүгнэлт

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуурын хувьд, иргэд болоод судлаачдын өгсөн саналыг нэгтгэн дүгнэвэл, төсөлд тусгагдсан өөрчлөлтийг зорилго, Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зарчмын хувьд хүлээн зөвшөөрөхөөр байна.

Дээрхээс гадна, Засгийн газар УИХ-ын 2022 оны 34 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах, зорилгоор олон нийтийн саналыг судлах сэдвийн хүрээ" болон "Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" УИХ-ын 2022 оны 54 дүгээр тогтоолын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд иргэдийн саналыг авах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд аймгуудын санал асуулгын нэгтгэлийн урьдчилсан дүнг үзвэл, тухайн төслийн заалтууд санал өгсөн иргэдийн 61.9 хувийн дэмжлэгийг авсан байна.

Цаашид өөрчлөлтийн төслийг санаачлагчийн зүгээс өдгөө хийж буй бүхий л түвшний хэлэлцүүлэг, санал авах ажиллагааг улам илүү өргөжүүлж, эрчимжүүлснээр өөрчлөлтийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлээд зогсохгүй өөрчлөлтийн төслийг боловсронгуй болгоход зохих ёсоор дэмжлэг болж Үндсэн хуульд өөрчлөлт хийх болсон хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангах боломжийг нэмэгдүүлэх болохыг анхаарах нь зүйтэй юм.

Дээр дурдсан байдлаас дүгнэвэл, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуурыг хангасан хэмээн үзэж болохоор байна.

IV. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэллээ. Ийнхүү Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг зүйл, заалт тус бүрээр нэгтгэн дүгнэвэл:

Нэг. Сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, УИХ-ын гишүүний тоог нэмэх тухайд

Сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуулиар баталгаажуулснаар мажоритар тогтолцооны хүрээнд үүсэж буй сонгогчдын санал гээгдэх асуудлыг бууруулах, улс төрийн цөөнхийн төлөөллийг парламентад оруулснаар улс төрийн олон ургалч үзлийг төлөвшүүлэх, гишүүдийн тойргийн ашиг сонирхлоос илүүтэйгээр улс орны эрх ашгийг чухалчлах үзлийг бий болгох боломж нээгдэнэ. Мөн УИХ-ын гишүүний тоог нэмснээр тэдний эрх мэдэл болон ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хууль тогтоох явц дахь эрх мэдлийн харилцан хяналтыг сайжруулснаар ардчиллын төлөөллийн зарчимд нийцнэ. Гэхдээ УИХ-ын гишүүний тоог Куб язгуурт тулгуурлан тогтоохдоо нийт хүн амын тооноос бус, сонгуулийн насны нийт иргэдийн тоонд тулгуурлан тогтоох нь төлөөллийн зарчмын хувьд хүлээн зөвшөөрөгдөнө. Мөн УИХ-ын сонгуулийн тогтолцоог тусгахдаа “мажоритар”, “пропорциональ” гэх нэршлийг хэрэглэх нь Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцэхгүй байна. Иймд “мажоритар” болон “пропорциональ” гэсэн нэршлийг сонгуулийн “олонхын” болон “хувь тэнцүүлэх тогтолцоо” гэж өөрчлөх нь хуулийн төслийн ойлгомжтой байдлыг нэмэгдүүлнэ гэж үзлээ.

Хоёр. ҮХЦ-ийн хяналтын тухайд

Тус өөрчлөлтийн төсөлд Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн зөрчлийн тухай гомдлыг ҮХЦ-ээс хүлээн авч шийдвэрлэхээр тусгасан байна. Уг төсөлд Үндсэн хуульд зааснаар ҮХЦ иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийн тухай гомдлыг хүлээн авч шийдвэрлэх боломжийг нээж, ҮХЦ-ийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхийг баталгаажуулсан нь Үндсэн хуулийн зорилгод нийцэж байна. ҮХЦ иргэний зөрчигдсэн эрхийг сэргээхдээ хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн шатыг дуусгасан байх шаардлагыг тавих, мөн дотоодын эрх зүйн зохицуулалтаар тухайн эрхийг сэргээх боломжгүй тохиолдолд ҮХЦ-д шууд өргөдөл гаргах баталгааг хангах асуудал чухлаар тавигдана.

Үүнээс гадна хууль, бусад эрх зүйн акт Үндсэн хууль зөрчсөн талаарх иргэний мэдээллийг ҮХЦ хүлээн авч шийдвэрлэх боломжийг хэвээр үлдээх нь зүйтэй юм. Энэ нь хуулийн хэрэгжилт дэх иргэний хяналтыг хангах үндэслэл болно. “Ойлгомжтой байдал” шалгуурын хүрээнд үнэлсэн байдлыг дүгнэвэл, хуулийн төслийн эх бичвэр нь нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой, иргэд, байгууллагууд нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой байна.

Гурав. ҮХЦ-д хүсэлт гаргах субъектын тухайд

УИХ-ын 1/10-ээс доошгүй гишүүн ҮХЦ-д хүсэлт гаргах зохицуулалт нь Үндсэн хууль зөрчсөн талаар цөөнх ҮХЦ-д хүсэлт гаргаж маргаан үүсгэх боломжийг нээх, олонхын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэхэд тавих хяналт үр өгөөжтэй болгох

зорилгод нийцэж байна. Харин УИХ-ын шийдвэрийг дэмжсэн гишүүн ҮХЦ-д хүсэлт гаргах нь өөрийн шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй ижил ойлголт тул УИХ-ын гишүүн ҮХЦ-д хүсэлт гаргахад “тухайн тогтоолыг эсэргүүцсэн байх” гэсэн шаардлага тавих нь зүйтэй.

Мөн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1-т заасан ҮХЦ-д хандах субъектэд ХЭҮК-ыг хамааруулаагүй байгаа нь хүний эрхийн чиглэлээр голчилж үйл ажиллагаа явуулдаг байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байдлаар зохицуулж буй нь эрх зүйн сөрөг үр дагавар үүсгэжээ. Уг өөрчлөлтийн төслөөр ХЭҮК хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын хувьд хүний эрхийг зөрчсөн хууль, эрх зүйн акт, эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийг ҮХЦ-д хандан шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь Үндсэн хуулийн үзэл баримтлал болон өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд бүрэн нийцсэн гэж үзлээ.

Дөрөв. ҮХЦ-ийн гишүүний томилгооны тухайд

Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт ҮХЦ-ийн гишүүний тоо, тэдний томилгоо болон бүрэн эрхийн хугацааг заасан байдаг. Уг өөрчлөлтийн төслөөр ҮХЦ-ийн гишүүний бүрэн эрхийг 6 жил хэвээр үлдээн нэгээс илүү удаа дахин томилохыг хориглосон байна. ҮХЦ-ийн гишүүнийг эрх бүхий байгууллага, албан тушаалтны санал болгосноор УИХ томилдог бөгөөд ҮХЦ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа болон дахин томилогдох нөхцөлийг хуулиар хориглоогүй тохиолдолд тухайн гишүүн дахин томилогдохын тулд өөрийг нь нэр дэвшүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны ашиг сонирхлын дагуу шийдвэр гаргах эрсдэл үүсэх магадлалтай.

Иймд ҮХЦ-ийн гишүүнийг дахин томилох тухайд хязгаарлалт тавьж, гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангах нь зохистой. Улмаар ҮХЦ-ийн гишүүний бүрэн эрхийг 6 жилээр тогтоон нэг удаа дахин ажиллах боломж олгосон явдал нь дахин ажиллах боломж олгохын зэрэгцээ эхний бүрэн эрхийн хугацаан дахь ажлын үр дүнгээ үнэлүүлэх шаардлагыг бий болгож, үүгээр дамжуулан хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлж буй нь оновчтой байна.

Тав. Хөдөөгийн сэргэлтийг дэмжих, Нийслэлийн төвлөрлийг сааруулах хүрээнд

Нийслэл Улаанбаатар хотод үүсээд буй төвлөрлийг сааруулах, орчны бохирдлыг арилгаж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, түүнчлэн хот, хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлэх шаардлага үүсээд байна. Уг өөрчлөлтийн төсөлд Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж өөрчлөн, нийслэл Улаанбаатар хотод орших төрийн эрх барих дээд байгууллагаас бусад төрийн байгууллагыг орон нутагт нүүлгэн шилжүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгожээ. Иймд тус зохицуулалт нь нийслэлийн төвлөрлийг сааруулах, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгод нийцсэн байна. Гэсэн хэдий ч, нийслэл хотыг Хархорумд шилжүүлэх зэрэг асуудал яригдах болсон өнөө үед нийслэлийг Улаанбаатар хот байхаар шууд заасан төслийн зохицуулалтын оновчтой байдлыг эргэн харах шаардлагатай.

Зургаа. Эвлэлдэн нэгдэх эрхийг баталгааг хангах хүрээнд

Үндсэн хуулийн 19^{1.2} хэсэгт заасан улс төрийн нам байгуулах зохицуулалт нь гишүүнчлэлийн тоог өндөр тогтоосноор иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлах сөрөг үр дагавартай байна. Иймд тус хэсгийг уг өөрчлөлтийн төслийн хүрээнд эргэн харж байгаа нь иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангахыг зорьжээ.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль, (2019).
3. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, (2010).
4. Улс төрийн намын тухай хууль, (2005).
5. Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль, (1993).
6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар дүгнэлт, (1995).
7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт монгол улсын үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 02 дугаар тогтоол, (2022).
8. Хууль тогтоомжийн тухай хууль, (2015).
9. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, (2020).
10. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, “Өмч хувьчлалын тухай”, Дугаар 11, (1995).
11. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай, Дугаар 07, (2020).

Гадаад хэлээр:

1. Constitutional court act of Korea
2. Local Authority Act of Korea
3. Act on special cases concerning the administration of Seoul special metropolitan city
4. Federal Constitutional Court Act of Germany, (1993)
5. Political Parties Act, (2009)

Ном, өгүүлэл, нийтлэл

Монгол хэлээр:

1. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, (УБ, 2012).
2. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, (УБ, 2016).
3. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, (УБ, 2008).
4. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, (УБ, 2022) он.
5. Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, (УБ, 2007).

6. ХЗДХЯ, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”, “Үндсэн хуулийн процессын эрх зүй” оюутны гарын авлага, (УБ, 2011).
7. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй хоёр дахь хэвлэл, (УБ, 2021).
8. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, (УБ, 2021).
9. О.Мөнхсайхан, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал, тулгамдсан асуудал шийдэл, (УБ, 2020).
10. Парламентын судалгааны хүрээлэн, “Парламент судалгааны эмхэтгэл” боть 40, (УБ, 2022).
11. Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа”, (УБ, 2017).
12. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн хяналтын Монгол загвар Үндсэн эрхийн хамгаалал ба эрх мэдлийн тэнцвэр, “Үндсэн хуулийн эхийн баригч - Б.Чимид, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл”, (УБ, 2020).
13. Арне Мавбич, “Үндсэн хуулийн хяналт”, Мэргэн Их Монгол, Г.Баясгалан, Д.Одбаяр, Д.Сугар нарын орчуулга, (УБ, 2014).
14. Г.Билгүүн, Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх харьяалал (Харьцуулсан судалгаа), “Эрх зүй” сэтгүүл, 2020, №4, (УБ, 2020)
15. Г.Билгээ, Д.Халиун, Парламентын сонгуулийн тогтолцоо, парламентын гишүүдийн тоо ба түүнийг тогтоох, тооцох зарчим (СТ-22/405), “Парламент” судалгааны эмхэтгэл, боть 40.
16. Юрген Харбих, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх эрх зүй, улс төр, нийгмийн хөгжлийн зөрчилдөөний уулзвар дээр, “Монголын төр эрх зүй” сэтгүүл, 2014, №4 (78), (УБ, 2014)
17. Т.Доохүү, Ч.Энхбаатар, “Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй тусгай анги”, (УБ, 2009).
18. О.Мөнхсайхан, Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний араат бус, хариуцлагатай байдлыг хангах нь, “Эрх зүй” сэтгүүл, 2016, №4, (УБ, 2016)
19. Д.Халиун, Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагуудын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306), “Парламент” судалгааны эмхэтгэл, боть 40.
20. О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015).
21. УИХ, Зөвлөлдөх санал асуулга асуултын лавлагаа, танилцуулга, (УБ, 2023).
22. Хөдөөгийн сэргэлт, Ерөнхий сайдын илтгэл, 2022.03.10 <https://gazar.gov.mn/blog/today/h-d-gijn-sergelt-ndesnij-chuulgan-zohion-bajguulagdlaa>

23. Хот хөдөөгийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах арга хэмжээний санал боловсруулах ажлыг гүйцэтгэлээ, (Уб, 2021.04.11).
24. Нутгийн удирдлага сорилт ба шийдэл үндэсний чуулганы эмхэтгэл, Төвлөрлийг сааруулах, нутгийн удирдлагыг бэхжүүлэх чиглэлээр Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн бодлого, (Уб, 2016).
25. С.Нарангэрэл, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаарх Академич С.Нарангэрэлийн бичмэл санал”, 2023.04.24, Холбоос: <https://ip.ac.mn/c/1013593?Content=3707277>
26. МУИХТГ, “Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж” Боть I-XII, (Уб, 2022).
27. Г.Совд нар, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, (Уб, 2000).
28. Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, ХЗҮХ, (Уб, 2023).
29. Р.Хатансайхан, “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн зохицуулалт” магистрын зэрэг горилсон судалгааны ажил, (Уб, 2023).
30. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн, Сонгуулийн Ерөнхий Хороо, (Уб, 2022).
31. Үндэсний статистикийн хороо, “Ажиллах хүчний судалгааны 2022 оны I улирлын товч танилцуулга”, (Уб, 2022).
32. Ардчиллыг хуулиар бэхжүүлэх Европын Комисс (Венецийн Комисс), ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба (ЕАБХАБ/АИХЭГ) Монгол Улс, Улс төрийн намын тухай хуулийн төслийн тухай судалгааны тайлан.

Гадаад хэлээр:

1. 성낙인, 헌법학, 법문사, 2021
2. 조소영, 국회의원 정수에 관한 헌법적 고찰, 한국비교공법학회, 공법연구 제13권, 2012
3. 헌법 제
4. 김종일, 미국 연방대법관의 종신제에 관한 검토, 우리나라 헌법재판관의 임기와 관련하여, 한국공법학회, 공법연구, 2014
5. 최진혁, 지방분권과 지역균형발전에 따른 세종특별자치시의 발전과제: 정부부처 이전을 중심으로, 충남대학교 사회과학연구소, 사회과학연구 제26권, 2015

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” Эрдэм шинжилгээний өгүүлэл, (2002), <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
2. “УИХ-ын нэр бүхий дөрвөн гишүүн Үндсэн хуулийн цэцэд ханджээ”, 2018.12.13, <https://www.parliament.mn/nn/4216/>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
3. 2022 оны 1-р улирлын байдлаар, <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Labour%20force%202022%201.pdf&In=Mn>,

Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

4. Улсын Их Хурлын байнгын хороод, <https://www.parliament.mn/cv/?appointmentId=105>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
5. Хот хөдөөгийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах арга хэмжээний санал боловсруулах ажлыг гүйцэтгэлээ, 2021.04.11, www.mmcg.mn, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
6. Т.Алтангэрэл, “Үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх нь: ХБНГУ-ын туршлага” Эрдэм шинжилгээний нийтлэл, https://legaldata.mn/buteel/pdf?fbclid=IwAR2qdimLTBOVA116ipMZPiDjm4_OoKR2OWccXNo9l04qtGcf2VkJ0jFKO7w&id=1411, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

Гадаад хэлээр:

1. Congress of local and regional authorities of Europe, Recommendation 133 (2003) on the management of capital cities, <https://rm.coe.int/management-of-capital-cities-rapporteur-mrs-n-shymanska/168071a20e>.
2. Hyowon Lee, A Constitutional Review Model: The Case of Korea, 2020, 42 дахь тал, https://nagoya.repo.nii.ac.jp/record/30824/files/caledp_19_37.pdf.
3. South Korea population, <https://www.worldometers.info/world-population/south-korea-population/>.
4. German Institute for Human Rights, <https://ennhri.org/our-members/germany/>.
5. The Commissioner for Human Rights Policy and Humanitarian Assistance, <https://www.auswaertiges-amt.de/en/about-us/coordinators/hr-commissioner>.
6. Bonn's new profile, <https://www.bonn.de/microsite/en/services/information-for-media/bonns-new-profile.php>.
7. World Bank Decentralization Thematic Team, “What is Decentralization?, The online Source Book on Decentralization and Local Development”, Холбоос: http://www.ciesin.org/decentralization/English/General/history_fao.htm.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ
ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ БА МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН
ГЭРЭЭНИЙ НИЙЦЭЛ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
Г.Давааням	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Хууль зүйн ухааны доктор (LL.D.)

Судалгааны багийн бусад гишүүд:

Б.Түмэндэмбэрэл	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)
Э.Сэлэнгэ	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.04.25.

АГУУЛГА

УДИРТГАЛ	111
I. ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД НИЙЦСЭН ЭСЭХ	113
1.1. Парламентын төлөөлөх чадвар	113
1.2 Бүх нийтээр тэгш эрхийн үндсэн дээр сонгох зарчим	114
1.3. Үндсэн хуулийн цэц иргэний үндсэн эрхийг сэргээх нь	115
1.4. Эвлэлдэн нэгдэх эрх	117
1.5 Хот, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах байдал	118
II. ДҮГНЭЛТ	119
НОМ ЗҮЙ	120

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын 2022 оны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 54 дүгээр тогтоол болон Улсын Их Хурлын 2022 оны 34, 54 дүгээр тогтоол, “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжийг баримтлан Монгол Улсын Засгийн газраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг дараах агуулгын дагуу боловсруулсан байна. Үүнд:

Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ системээр сонгоно” гэж өөрчлөх;

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана” гэж өөрчлөх;

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж, Жаран 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “томилно” гэснийг “томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно” гэж, Жаран 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр” гэснийг “Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай” гэж өөрчлөх;

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр¹ зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох;

Монгол Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх заалтыг “Монгол Улсын төрийн эрх барих байгууллага байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн” гэж өөрчлөхөөр тусгажээ.

Энэхүү судалгаа нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд аливаа байдлаар харшилсан эсэх, хэрэв Монгол Улсын олон улсын гэрээтэй зөрчилдөхөөр байвал түүнээс гарах арга замыг тус тус тодорхойлсон байхад чиглэнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн зүйл, заалт нь Монгол Улсын нэгдэн орсон дараах олон улсын гэрээнд нийцэж буй эсэхийг дүгнэсэн болно. Үүнд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт²
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
- НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1993 оны 48/134-р тогтоолоор баталсан Хүний эрхийн үндэсний байгууллагын нөхцөл байдлын талаарх зарчим / Парисын зарчим/.

1 Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/12718>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

2 Иргэний Болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пакт, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/1257>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

I. ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД НИЙЦСЭН ЭСЭХ

1.1. Парламентын төлөөлөх чадвар

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн нэг болох УИХ-ын гишүүдийн тоог нэмэх зохицуулалт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй зөрчилдөж буй эсэхийг тогтоох зорилгоор Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын зохицуулалттай нийцэж буй эсэхийг дараах байдлаар дүгнэлээ. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 1 дэх хэсэгт “Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу тэд улс төрийн статусаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлоо чөлөөтэй хөгжүүлнэ” гэж, 25 дугаар зүйлийн (а) хэсэгт “Төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөрөө уламжлан оролцох эрхтэй” гэж баталгаажуулсан. Парламентын гишүүдийн тоог нэмэх нь төрийн үйл хэрэгт төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох иргэний эрхийг зөрчих эсэхийг товч авч үзье.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 1 дүгээр зүйлд заасан ард түмний “өөрөө засан тохинох эрх” нь тухайн ард түмний үндсэн хуулиа батлах, төр, засгаа байгуулахтай холбогдох бол, тус пактын 25 дугаар зүйлийн (а) хэсэг дэх “төрийн хэрэг” гэсэн ойлголт нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, ялангуяа хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотой өргөн ойлголт юм. Энэ нь олон улсын, үндэсний, бүс, орон нутгийн түвшинд төрийн удирдлагын бодлого, чиглэл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамардаг. 25 дугаар зүйлд тусгагдсан төрийн үйл хэрэгт оролцох иргэний эрхийг үндсэн хууль болон бусад хуулиар тогтоож, баталгаажуулна.³ Өөрөөр хэлбэл, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагын хэлбэр, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг тухайн улс өөрийн онцлогт тохируулан дотооддоо батлах бүрэн эрхийг эдэлнэ.

Ард иргэдийг төлөөлөн төрийн үйл хэргийг хэрэгжүүлэх төлөөлөгчид нь тэднийг төлөөлөх чадвартай байх учиртай. Дэлхийн улс орнууд нийгмийн бүлгийн эрх, ашиг сонирхлыг бүрэн илэрхийлэх төлөөллийн тоог оновчтой тодорхойлохын тулд хүн амын тоог чухалчилдаг байна. Монгол Улсын хувьд ч мөн адил “төлөөлөгч”-ийн тоог тогтоохдоо хүн амын тоог харгалзан тогтоож байсан түүхтэй. 1992 оны Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүний тоог тухайн үеийн хүн амын тоонд үндэслэн 1 гишүүн дунджаар 27,000 иргэнийг төлөөлөхөөр тооцоолон 76 гишүүнтэй байхаар хуульчилсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар 3,457,548 болж 66 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, 2020 онд УИХ-ын 1 гишүүн 46,178 иргэнийг төлөөлөх болсон бөгөөд энэ нь парламентын төлөөлөх чадварыг бууруулж, цаашлаад иргэд төлөөлөгчөөрөө дамжуулан төрийн үйл хэрэгт оролцох эрхэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Түүнчлэн, Монгол Улсын хувьд сонгуулийн тогтолцоо, улс төрийн намын төлөвшил, УИХ-ын гишүүдийн тоо цөөн байгаа зэрэг хүчин зүйлээс хамааран УИХ-д цөөнхийн төлөөлөл хангагдаж чадахгүй байна. УИХ-ын 76 гишүүний 17%-ийг эмэгтэй гишүүд эзэлж байгаа бол нийт сонгогчдын олонхыг эзэлж буй 35 хүртэлх

3 General comment adopted by the human rights committee under article 40, paragraph 4, of the International Covenant on civil and political rights, Холбоос: https://tbinternet.ohchr.org/_layouts/15/TreatyBodyExternal/Download.aspx?symbolno=CCPR/C/21/Re_v.1/Add.7&Lang=en, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

насны залуусын төлөөлөл байхгүй.⁴

Парламентын гишүүний тоог нэмснээр парламентын төлөөлөх чадварыг сайжруулах, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангах, УИХ-ын гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, УИХ-аас баталсан хуулийн чанар, үр нөлөө сайжрах эерэг үр дүнд хүрэх боломжтой. Гэхдээ парламентын гишүүний тоог нэмэхдээ ямар арга, тооцооллоор нэмэхийг анхаарч, улмаар тойргийн тэнцвэртэй байдлыг хангах, намаас гаргах нэр дэвшигчдийн жагсаалтын ил тод байдлыг хангах, суудал хуваарилахад тавигдах шалгуурыг тодорхой болгох зэрэг арга хэмжээг холбогдох хуулиар нарийвчлан зохицуулах нь парламентын төлөөлөх чадварыг дээшлүүлэх зорилгод нийцнэ.

Иймд Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хүрээнд тавигдаж буй УИХ-ын гишүүдийн тоог нэмэх зохицуулалт нь Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээнд харшлаагүй байна гэж үзэв.

1.2. Бүх нийтээр тэгш эрхийн үндсэн дээр сонгох зарчим

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлийн b хэсэгт “сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох” эрхтэй хэмээн тусгасан.

Хэдийгээр Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад сонгуулийн тогтолцоог тодорхойлоогүй ч, гишүүн улс бүрийн тогтоосон сонгуулийн тогтолцоо нь иргэдийн тэгш эрхийн үндсэн дээр, бүх нийтээр, нууцаар, чөлөөтэй саналаа өгөх эрхийг баталгаажуулсан байх шаардлагатай. “Нэг хүн, нэг санал” гэдэг зарчим үйлчлэх ёстой бөгөөд гишүүн улсын сонгуулийн тогтолцооны хүрээнд нэг сонгогчийн санал нөгөө сонгогчийн саналтай тэнцүү үнэ цэнтэй байх ёстой. Энэ хүрээнд сонгуулийн тойргийг тогтоох, санал хуваарилах арга нь сонгогчдын хуваарилалтыг гажуудуулж, аль нэг бүлгийг ялгаварлан гадуурхах, иргэний төлөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг үгүйсгэх, үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх асуудал чухлаар тавигдана.⁵

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслөөр Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ системээр сонгоно.” гэж өөрчлөхөөр тусгажээ. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүний тоо нэмэгдэхээс гадна сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд тусгахаар зохицуулжээ. Холимог тогтолцоогоор парламентын сонгуулийг зохион байгуулдаг цөөнгүй орнууд байдаг бөгөөд уг тогтолцоо нь иргэний сонгох, сонгогдох эрх, эрх чөлөөг хангах арга замуудын нэг болохыг дурдах нь зүйтэй.

4 “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, Монгол Улсын Их Хурал (УБ, 2023), 2023, 68 дахь тал.

5 General Comment No. 25: The right to participate in public affairs, voting rights and the right of equal access to public service (Art. 25) 12/07/96. CCPR/C/21/Rev.1/Add.7, General Comment No. 25. (General Comments), Холбоос: <https://www.equalrightstrust.org/ertdocumentbank/general%20comment%2025.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

Ард иргэд сонгуулиар дамжуулан Засгийн газар, эрх баригч намыг дэмжих эсхүл эсэргүүцэх замаар өөрсдийн үзэл бодол, хүсэл тэмүүлээ илэрхийлдэг.⁶ Сонгуулийн эрхийг хязгаарлах тохиолдолд тухайн үндэслэл нь зайлшгүй байх ёстой. Өөрөөр хэлбэл, иргэдийн сонгох эрхийг тэдний боловсрол, оршин суугаа газар, удам угсаа, улс төрийн харъяалал зэргээр нь ялгаварлан хязгаарлаж болохгүй.⁷

Монгол Улсын Үндсэн хуулийн 21.2 дахь хэсэгт сонгуулийн бүх нийтийн, тэгш, нууц, чөлөөтэй байх зарчмыг тусгасан байдаг. Нийтээр сонгох эрхийн тогтсон, нийтлэг агуулга бол сонгуулийн эрх бүхий бүх иргэнд сонгох эрхийг эдлүүлэх явдал юм.⁸ Үүнийг гадаад улсад оршин сууж байгаа иргэдийн сонгох эрхийг хангах зарчмын хүрээнд авч үздэг. Гадаад улсад оршин сууж буй иргэдийн УИХ-ын сонгуульд оролцох эрхийг хязгаарлаж байгаа явдал нь сонгууль бүх нийтийн байх зарчмын зөрчиж байна.⁹ 2007 оны байдлаар 214 орны 110 нь гадаад улсад оршин сууж буй иргэдийн сонгох эрхийг хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалттай ба тус заалтаа бодитоор хэрэгжүүлж байжээ. Харин 2011 оны Венецийн комиссын судалгаагаар тус комиссын гишүүн 57 улсаас Албани, Армен, Чили, Кипр, Грек, Ирланд, Израил, Мальта, Монтенегро, Сан Марино, Туркээс бусад 45 улс нь гадаад улсад оршин сууж буй иргэдийнхээ сонгуульд санал өгөх эрхийг хангадаг гэжээ.¹⁰ Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийг хангах механизмд гадаад улсад оршин сууж буй иргэдийн сонгох эрхийг хангахыг удаа дараа зөвлөсөөр байна.

1992, 1996, 2000, 2004, 2008, 2016, 2020 оны УИХ-ын сонгуульд гадаад улсад оршин сууж буй иргэд сонгуулийн эрхээ хэрэгжүүлж чадаагүй. Харин 2012 онд УИХ-ын сонгууль холимог тогтолцоогоор зохион байгуулагдаж, гадаад улсад оршин сууж буй иргэд намын жагсаалтад саналаа өгсөн. Өөрөөр хэлбэл тухайн иргэд тойрогт санал өгөх эрхээ хэрэгжүүлж чадаагүй бөгөөд энэ нь иргэдийн тэгш сонгох эрхийг хөндсөн хэмээн үзэж болно.

Иймд Сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд харшлахгүй гэж үзэв. Харин гадаадад оршин сууж байгаа иргэд сонгуулийн бүх нийтийн зарчмын дагуу тойрогт санал өгөх боломжоор хангах асуудалд анхаарч, иргэдийн сонгох эрх зөрчигдөхөөс сэргийлэх нь зүйтэй.

1.3. Үндсэн хуулийн цэц иргэний үндсэн эрхийг сэргээх нь

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.” гэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэхүү Пактад

6 Report of the Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association A/68/299, Холбоос: <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N13/423/09/PDF/N1342309.pdf?OpenElement>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

7 General Comment No. 25: The right to participate in public affairs, voting rights and the right of equal access to public service (Art. 25) 12/07/96. CCPR/C/21/Rev.1/Add.7, General Comment No. 25. (General Comments), Холбоос: <https://www.equalrightstrust.org/ertdocumentbank/general%20comment%2025.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

8 О.Мөнхсайхан, Р.Очирбал, *Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл*, (УБ, 2021), 165 дахь тал.

9 Дам ишлэв. ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар, Урьдчилсан тайлан, 4.

10 Venice Commission, “Report on Out-of-country voting” (2010), 5, Холбоос: [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2011\)022-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2011)022-e), Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

оролцогч улс бүр ... энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах; эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг нь хөгжүүлэх; эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах үүрэгтэй.” гэж тус тус заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, Цэцээс иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчилтэй холбоотой маргааныг хүлээн авч шийдвэрлэх боломжгүй буюу субъектив үндсэн эрхийн маргааныг харьяалан шийдвэрлэх боломжгүй байна.

Цэцийн нэг гол зорилго нь үндсэн эрхийг хамгаалах явдал юм.¹¹ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын илтгэл, ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг, НҮБ-ийн шинжээчдийн зөвлөмж зэрэгт Монгол Улсад хүний эрх ноцтой зөрчигдөж буй талаар тусгадаг ч эдгээр зөрчлийг шийдвэрлэж чадахгүй байсаар ирсэн. Эрүү шүүлтээс ангид байх, шударгаар шүүлгэх эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх, тэгш эрх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө зэрэг үндсэн эрх зөрчигдөж байгаагийн дийлэнх нь шүүхийн эсхүл захиргааны байгууллагын шийдвэрт гардаг боловч, үүнийг Цэц хүлээн авч шийдвэрлэдэггүй.¹² Тухайлбал, 1992-2020 оны хооронд Цэцээс 296 маргааныг хянан шийдвэрлэсний дийлэнх хувьд нь Үндсэн хуулийн зөрчлийг олж тогтоосон, мөн тэдгээрийн дийлэнх нь үндсэн эрх, эрх чөлөө, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимтай холбоотой шийдвэрийг гаргасан байна.

Үндсэн хуулийн шүүхийн гол чиг үүрэг бол Үндсэн хуулиар хүний үндсэн эрх, үндсэн зарчмыг хамгаалах байдаг боловч, тухайн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж чадахгүй байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаарх маргааныг Цэцээс хянан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой.¹³

Улмаар Үндсэн хуулийн шүүхэд үндсэн эрх нь зөрчигдсөн иргэн уг эрхээ сэргээлгэхээр хандах зохицуулалтыг тусгаж буй нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт нийцэж байна.

Одоог хүртэл Цэцээс хянан шийдвэрлэсэн хэрэг, маргааны ихэнх нь иргэний мэдээллээр (action popularis) үүссэн байдаг. Гэхдээ иргэний мэдээллээр Үндсэн

11 Ж.Амарсанаа, *Үндсэн хуулийн хяналт, түүнийг хэрэгжүүлэх арга зам, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц*, (Ред. Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа, УБ, 2007), 439 дэх тал.

12 О.Мөнхсайхан, *Иргэний өргөдөл мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж*, Монгол Улс дахь Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь судалгааны төсөл, (УБ, 2015).

13 О.Мөнхсайхан, Р.Очирбал, *Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал*, (УБ 2021), 479 дэх тал.

хууль зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэх нь хэд хэдэн сул талтай.¹⁴ Гэсэн хэдий ч, иргэний мэдээлэл нь Үндсэн хууль зөрчсөн хууль тогтоомжийг хүчингүй болгох, өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэсээр байгааг үгүйсгэх боломжгүй. Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн дагуу иргэний мэдээллээр Цэцэд маргаан үүсгэх боломжгүй болохоор байгаа юм. Энэ нь өнөөгийн практикт зөрчилдөөн, хийдэл үүсгэх, Үндсэн хууль зөрчсөн хууль тогтоомжид Цэцээс тавих хяналтыг сулруулах сөрөг үр дагавар үүсгэхийг үгүйсгэхгүй. Иймд Үндсэн хууль зөрчсөн хууль тогтоомжид Цэцээс тавих хяналтыг сулруулахгүй байх үүднээс иргэний Цэцэд мэдээлэл гаргах эрх зүйн үндэслэлийг одоогийн Үндсэн хуульд заасан агуулгаар төсөлд тусгах нь зохистой.

Хуулийн төсөлд ХЭҮК-т Цэцэд хүсэлт гаргах боломж олгосон нь чухал ач холбогдолтой. НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1993 оны 48/134-р тогтоолоор Хүний эрхийн үндэсний байгууллагын нөхцөл байдлын талаарх зарчим /Парисын зарчим/ баталсан. Парисын зарчимд хүний эрхийн байгууллага байгуулахад баримтлах минимум стандартыг дараах хүрээнд тогтоосон байна. Үүнд:¹⁵

- Үндсэн хууль эсхүл бусад хуулиар байгуулах
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах өргөн эрх хэмжээтэй байх
- Үндсэн болон нэмэлт чиг үүргүүдийг хэрэгжүүлэх
- Шаардлагатай бүрэн эрх эдлэх
- Бүрэлдэхүүн томилгоо
- Ажлын албаны бүтэц
- Хараат бус бие даасан байдал.

ХЭҮК-т Цэцэд хүсэлт гаргах эрхийг олгохоор Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд нь Парисын зарчимд заасан “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах өргөн эрх хэмжээтэй байх” шаардлагад нийцэж байна.

1.4. Эвлэлдэн нэгдэх эрх

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 22 дугаар зүйлд эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан. Иргэний болон улс төрийн эрхийн пактын 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуульд зааснаас өөр хязгаарлалт хийж болохгүй” гэж заасан.

Эвлэлдэн нэгдэх эрх нь иргэд эрх, ашиг сонирхлоороо нэгдэж, өөрсдийн нийтлэг асуудлыг шийдвэрлэх тогтолцоо бий болгох боломжийг олгодог. Тухайлбал, олон нийтийг хамарсан жагсаал цуглаанд оролцох, улс төрийн нам байгуулах ... зэргийг нэрлэж болно.¹⁶

14 О.Мөнхсайхан, *Иргэний өргөдөл мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж*, Монгол Улс дахь Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь судалгааны төсөл, (УБ, 2015).

15 Ц.Цэрэндорж, *Хүний эрхийн үндэсний байгууллага: тавигдах шаардлага, чиг үүрэг, Хүний эрх: онол, арга зүйн сэтгүүл*, №1, (УБ, 2016).

16 Report of the Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association A/68/299, Холбоос: <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N13/423/09/PDF/N1342309.pdf?OpenElement>¹⁷ A/HRC/20/27, para. 54, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

НҮБ-ийн тусгай илтгэгчийн тайланд дурдсанаар улс төрийн нам байгуулах иргэдийн тоонд доод босгыг тогтоох боломжтой ч энэ босго нь иргэдийн эвлэлдэн нэгдэх хүсэл зоригийг бууруулахад хүргэж болохгүй гэжээ.¹⁷

оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нам байгуулах, түүнд элсэх эрхтэй холбогдох хэд хэдэн зохицуулалтыг Үндсэн хуульд тусгасны нэг нь улс төрийн “намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулах” шаардлага юм.

оны УИХ-ын сонгуулиар 2,000,624 сонгогч, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар 2,040,556 сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн байна. Дээрх Үндсэн хуулийн холбогдох заалтын дагуу сонгуулийн насны 20 мянган сонгогч нэгдсэн тохиолдолд улс төрийн нам байгуулах шаардлагыг хангана. Бусад улсад улс төрийн нам байгуулахад дээрх төрлийн хязгаарлалтыг тавьдаг тохиолдол бий ч босгын хэмжээ нь ойролцоогоор тухайн улсын хүн амын 0.4 хувьтай тэнцэж байна. Үүнээс үзвэл Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлд заасан сонгуулийн эрх бүхий иргэдийн 1 хувийн шаардлага нь хэт өндөр буюу иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг өргөнөөр хязгаарласан шинжтэй байна.

Иймд иргэний эвлэлдэн нэгдэх эрхийн хязгаарласан тус заалтыг эргэн харж, эвлэлдэн нэгдэх боломжийг илүү хялбар болгох нь Монгол Улсын олон улсын гэрээнд нийцнэ гэж үзлээ.

1.5. Хот, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах байдал

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улсууд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчлахгүйгээр энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй” гэжээ.

Сүүлийн жилүүдэд нийслэлийн хүн амын тоо эрс нэмэгдэж байна. Өнөөгийн өсөлтийн түвшингээр тооцвол 2040 он гэхэд Улаанбаатар хотын хүн амын тоо 2.5 сая болж, Монгол Улсын нийт хүн амын 56 хувь нь нийслэл хотод төвлөрөхөөр байна. Дээр дурдсанаар хот, суурин газрыг чиглэсэн шилжилт, хөдөлгөөн тасралтгүй үргэлжилж байгаа нь боловсрол, эрүүл мэнд зэрэг нийтийн үйлчилгээний хүртээмжээс шалтгаалсан механик өсөлттэй шууд холбоотой. Мөн ажлын байрны хүртээмжтэй байдал, орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх боломж нь хөдөөгөөс хотыг чиглэсэн урсгалд шууд хамааралтай бөгөөд хөдөө, орон нутагт эдийн засгийн эргэлтийн таатай байдал бүрдээгүй байна.

Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн” гэж тодорхойлсон байдаг. Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд дээрх заалтыг “Монгол Улсын төрийн эрх барих байгууллага байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн” гэж өөрчлөхөөр тусгажээ. Дээрх өөрчлөлт нь нийслэлийн төвлөрлийг сааруулах, хөдөө,

17 Report of the Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association A/68/299, Холбооц: <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N13/423/09/PDF/N1342309.pdf?OpenElement>, A/HRC/20/27, para. 54, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгод нийцэж байна хэмээн дүгнэж болохоор байна.

Улмаар, Нийслэл хотыг нүүлгэх эрх зүйн үндэслэл бүрдэнэ гэж зарим судлаач үзэж байна. Уг өөрчлөлт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй зөрчилдөхгүй гэж үзлээ.

II. ДҮГНЭЛТ

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1993 оны 48/134-р тогтоолоор баталсан Хүний эрхийн үндэсний байгууллагын нөхцөл байдлын талаарх зарчим /Парисын зарчим/-д нийцэхээр байна хэмээн дүгнэлээ.

Уг төсөл нь дээр дурдсан Монгол Улсын олон улсын гэрээтэй зөрчилдөөгүй байх боловч төсөлд тусгасан зохицуулалт практикт хэрхэн хэрэгжих нь чухал нөлөөтэй юм.

УИХ-ын гишүүдийн тоог нэмснээр парламентад нийгмийн бүлгийн төлөөллүүд нэмэгдэж, төлөөлөх чадвар дээшлэхээр байна. Ингэхдээ, гишүүдийн тоог нэмэх арга, тооцооллыг оновчтой ашиглах, тойргийн тэнцвэртэй байдлыг хангах, намын нэр дэвшигчдийн жагсаалтын тод байдлыг хангах, суудал хуваарилахад тавигдах шалгуурыг тодорхой болгох зэрэг асуудлыг холбогдох хуулиар нарийвчлан зохицуулахад анхаарах нь зүйтэй. Гадаад улсад оршин сууж байгаа иргэдэд тойргийн болон намын жагсаалтад санал өгөх боломжийг бүрдүүлэх нь сонгуулийн бүх нийтийн зарчмыг хангах зайлшгүй хүчин зүйлд тооцогдоно.

Уг төсөлд Цэц иргэний субъектив эрхийн зөрчилтэй холбогдох маргааныг хянан шийдвэрлэх боломжийг бүрдүүлэхээр тусгасан нь чухал ач холбогдолтой. Гэхдээ иргэний мэдээлэлд үндэслэн хууль Үндсэн хууль зөрчсөн эсэхийг ҮХЦ-ээс хянах эрх зүйн үндэслэлийг хэвээр үлдээх нь зохистой гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, (1948).
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. (1976).
4. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт. (1976).

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл, (УБ, 2021).
2. О.Мөнхсайхан, Иргэний өргөдөл мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж, (УБ, 2015).
3. “Зөвлөлдөн шийдье” Зөвлөх санал асуулга: Асуултын лавлагаа, танилцуулга, (УБ, 2023).
4. Ж.Амарсанаа, Үндсэн хуулийн хяналт, түүнийг хэрэгжүүлэх арга зам, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Ред Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа, (УБ, 2007).
5. Ц.Цэрэндорж, Хүний эрхийн үндэсний байгууллага: тавигдах шаардлага, чиг үүрэг, Хүний эрх: онол, арга зүйн сэтгүүл, №1, (УБ, 2016).

Гадаад хэл дээрх

Хууль тогтоомж

1. НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1993 оны 48/134-р тогтоолоор Хүний эрхийн үндэсний байгууллагын нөхцөл байдлын талаарх зарчим /Парисын зарчим/.
2. General comment adopted by the human rights committee under Article 40, paragraph 4, of the International Covenant on Civil and political rights, https://tbinternet.ohchr.org/_layouts/15/TreatyBodyExternal/Download.aspx?symbolno=CCPR/C/21/Rev.1/Add.7&Lang=en, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
3. Venice Commission, “Report on Out-of-country voting” (2010). [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDLAD\(2011\)022-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDLAD(2011)022-e), Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
4. Report of the Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association A/HRC/20/27, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
5. https://www.ohchr.org/sites/default/files/Documents/HRBodies/HRCouncil/Regul_arSession/Session20/A-HRC-20-27-Add2_en.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.
6. Report of the Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association A/68/299, <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N13/423/09/PDF/N1342309.pdf?OpenElement>, Сүүлд үзсэн огноо: 2023.04.25.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Х.Буянбат Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Б.Сүнжидмаа Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил (ҮХЦ-ийн тухай хуулийн төсөл
боловсруулах ажлын хэсгийн ахлагч).

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.11.17.

АГУУЛГА

УДИРТГАЛ	123
I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	124
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь	124
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	125
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	125
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	126
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	126
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	130
II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	131
III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	133
3.1. Цэцийн гишүүний томилгоо /МУҮХЦТХ-ийн 3-р зүйл/	133
3.2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлага /МУҮХЦТХ-ийн 4-р зүйл/	137
3.3. Цэцийн гишүүний бүрэн эрх /МУҮХЦТХ-ийн 5-р зүйл/	141
3.4. Цэцийн дарга, түүний эрх хэмжээ/ МУҮХЦТХ-ийн 6-р зүйл/	146
3.5. Цэцийн үйл ажиллагааны нөхцөл /МУҮХЦТХ-ийн 7-р зүйл/	148
IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	156
НОМ ЗҮЙ	158

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг 23 зүйлтэй анх баталснаас хойш өнгөрсөн 31 жилийн хугацаанд нийт 11 удаа /1995, 1997, 1999, 2003, 2016, 2005, 2020, 2021, 2022 онд/ нэмэлт, өөрчлөлт орж өдгөө тус хуулийн 12 зүйл хүчин төгөлдөр үйлчилж байна.

УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасан.

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэсэн байна. Үүний хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн 2018 онд хийсэн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгаа хийснээс хойш хэрэгжилтийн үр дагаврын судалгаа хийгдээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлого гэсэн дөрөв дэх бүлгийн “Хараат бус, бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл” хэсгийн 4.4.2 дахь заалтад Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно” гэж тусгажээ.

Мөн түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасанчлан Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа юун түрүүнд тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай.

Иймд хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид бэхжүүлэх шаардлагыг тодорхойлох үүднээс Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг хийх хэрэгцээ шаардлагатай гэж үзлээ.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэв.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр 23 зүйлтэй батлагдсанаас хойш өдийг хүртэл 11 удаа /1995, 1997, 1999, 2003, 2016, 2005, 2020, 2021, 2022 онд/ нэмэлт, өөрчлөлт орж өдгөө тус хуулийн 12 зүйл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Тус хуулийн хэрэгжиж буй 31 жилийн хугацаанд Монгол Улсын улс төр, төр, нийгэм, эдийн засгийн харилцаа ихээхэн шинэчлэгдэж, өөрчлөгдсөн байх бөгөөд энэ хугацаан дахь Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг энэ хууль хэрхэн зохицуулж байгааг үнэлж цаашид өөрчлөн сайжруулах үндэслэл шаардлага бий эсэхийг судалж тогтоох нь зүйн хэрэг билээ.

УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасан. Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлого гэсэн дөрөв дэх бүлгийн “Хараат бус, бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл” хэсгийн 4.4.2 дахь заалтад Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульд ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно” гэж тусгажээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасанчлан Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа юун түрүүнд тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг.

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэсэн байна. Үүний хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн 2018 онд хийсэн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгаа хийснээс хойш хэрэгжилтийн үр дагаврын судалгаа хийгдээгүй байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Судалгааны үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаагаар нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлдог.

Хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх болсон шалтгаантай харилцан уялдаа, хамааралтайгаар тогтоох ба тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг сонгоно. Ингэхдээ хуулийг бүхэлд нь эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Энэхүү судалгаагаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар зохицуулсан үндсэн харилцаа, зохицуулалтуудыг аль болох агуулгын хувьд бүхэлд нь үнэлэхийг хичээж үнэлгээ хийх хүрээг тус хуулийн дараах зүйл заалтуудаар тогтоов. Үүнд:

1. Цэцийн гишүүний томилгоотой холбоотой зохицуулсан тус хуулийн 3-р зүйл;
2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын тухай зохицуулсан тус хуулийн 4-р зүйл;
3. Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан тус хуулийн 5-р зүйл;
4. Цэцийн дарга, түүний эрх хэмжээний тухай зохицуулсан тус хуулийн 6-р зүйл;
5. Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийн тухай заасан тус хуулийн 7-р зүйл;
6. Цэцийн чиг үүрэг, эрх хэмжээ буюу маргаан хянан шийдвэрлэх эрх хэмжээг тогтоосон тус хуулийн 8, 9, 10, 12, 22-р зүйл.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах гурван шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Энэхүү онцлог нь тус судалгааны зорилгод нийцэж буй юм. Мөн зорилгод хүрсэн түвшин нь хэдийгээр харьцангуй хийсвэр ч тус шалгуур шалгуур үзүүлэлт нь хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй байдаг. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаандаа анх батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно. Үндсэн зорилгыг тодорхойлохдоо МУҮндХ-ийн 64-өөс 67 дугаар зүйл, болон Цэцийн тухай хуулийн 1, 2 дугаар зүйлд заасныг баримтална.

II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран, аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгодог. Харьцуулах доор дурдсан хэлбэрүүд байна. Үүнд:

1. байх ёстой ба одоо байгаа;
2. хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
3. хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
4. тохиолдол судлах.

Дээрхээс “байх ёстой ба одоо байгаа” болон “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг энэхүү судалгаанд тохиромжтой гэж үзэж сонгов.

“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулах хэлбэрээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн болон үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага зэрэгт харьцуулах хэлбэрээр тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорив.

“Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт нь өөр өөр нөхцөл буюу тохиолдолд хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэх асуултын хүрээнд гүйцэтгэлээ.

Хүснэгт 4.1. Шалгуур үзүүлэлтийн томьёо

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт		Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлт
	Зорилгод хүрсэн түвшин	Практикт нийцэж байгаа байдал		
Цэцийн гишүүний томилгоо / МУҮХЦТХ-ийн 3-р зүйл/	Цэцийн гишүүний томилгоо нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэх буюу тус томилгоо нь цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэх, мөн тус зүйлийн 3-“Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасанчлан Цэцийн тухай хуулийн холбогдох зүйл нь хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэхийг тогтооно.	Цэцийн гишүүний томилгооны тухай зохицуулсан тус 3-р зүйл нь хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэгэн сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болоод хэрэгжилтэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай салбарын судлаачид хэрхэн үзэж буй талаар судалж тогтооно.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 3-р зүйлээр зохицуулж буй Цэцийн гишүүний томилгоо нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.	1. Цэцийн гишүүнийг томилох тухай зохицуулсан тус хуулийн зохицуулалт нь түүнийг хараат бусаар Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавихад нөлөөлж байгаа эсэх. 2. Тус хуулийн зохицуулалт нь Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэх.
Цэцийн гишүүнд тавигдах шаардлага / МУҮХЦТХ-ийн 4-р зүйл/	Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 1-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд	Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын тухай зохицуулсан тус 4-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болон хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй,	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 4-р зүйлээр зохицуулж буй Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага,	1. Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх мэдлэг чадвар бүхий байхад чиглэгдсэн эсэх.

	<p>нийцсэн эсэх буюу Цэцийн гишүүн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх мэдлэг чадвар бүхий байх, Мөн тус зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэх буюу Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.</p>	<p>үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзсэн байна вэ гэдгийг авч үзнэ.</p>	<p>түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.</p>	<p>2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын тухай зохицуулалт нь Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэх.</p>
<p>Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх/ МУҮХЦТХ-ийн 5-р зүйл/</p>	<p>МУҮндХ-ийн 64-р зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж тусгасан байдаг. Цэцийн гишүүний бие даасан байдал нь түүний бүрэн эрхийн баталгаагаар илэрнэ. Иймд тус хуулийн 5-р зүйл цэцийн гишүүний хараат бус, бие даасан байдлыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.</p>	<p>Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх тухай зохицуулсан тус 5-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт сөрөг үр дагавар гарч байгаа эсэх, хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзсэн байна вэ гэдгийг авч үзнэ. Тодруулбал, Цэцийн гишүүний бүрэн эрхийн байдал практикт хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох, эерэг</p>	<p>“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 5-р зүйлээр зохицуулж буй харилцаа нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.</p>	<p>1. Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх тухай зохицуулалт нь Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэх.</p>

		болон сөрөг үр дагавар, хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдлыг судална.		
Цэцийн дарга, түүний эрх хэмжээ/ МУҮХЦТХ-ийн 6-р зүйл/	МУҮндХ-ийн 65-р зүйлийн 3-т “Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэж, мөн Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2.1-т “Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол улсын Үндсэн хуульд нийцэх хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж тусгасан байдаг. Иймд цэцийн дарга бүрэн эрхийн хугацаандаа бие даасан, хараат бусаар ажиллаж чадаж буй эсэх, түүний баталгааг тус хуулиар хангаж чадаж байгаа эсэхийг судална.	Цэцийн дарга, түүний эрх хэмжээний талаар зохицуулсан тус 6-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгааг авч үзэх буюу Цэцийн дарга эрх хэмжээг хуулиар оновчтой зохицуулсан эсэх, практикт ямар үр дагаврыг гарч байгаа талаар судалж үнэлэлт өгнө.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 6-р зүйлээр зохицуулж буй харилцаа нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.	1. Цэцийн даргын эрх хэмжээ нь Үндсэн хуулийн цэцийн хараат бусаар Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэж буй эсэх. 2. Цэцийн дарга бүрэн эрхийн хугацаандаа хараат бусаар ажиллаж чадаж буй эсэх, түүний баталгааг тус хуулиар хангаж чадаж байгаа эсэх.
Цэцийн үйл ажиллагааны нөхцөл / МУҮХЦТХ-ийн 7-р зүйл/	Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийн тухай зохицуулалт нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 1-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага,	Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон тус зүйлийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 7-р зүйлээр зохицуулж буй харилцаа нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй,	1. Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг тус хуулиар хангалттай зохицуулж чадсан эсэх.

	<p>Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд нийцсэн эсэх буюу Цэц энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг тус хуулиар хангалттай зохицуулж чадсан эсэх, тийнхүү зохицуулахдаа МУҮндХ-ийн тус зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.</p>	<p>хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална.</p>	<p>үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах</p>	<p>2. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэхдээ түүний хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэх.</p>
--	--	---	---	---

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Үндсэн хуулийн эрх зүй, тэр дундаа үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, тус ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн тухай холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Үндсэн хуулийн эрх зүй, тэр дундаа үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, тус ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн тухай холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

Тус судалгаанд ашигласан эх сурвалжийг жагсаавал:

Сурах бичиг, гарын авлага:

- Г.Совд “Шүүх , шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд”, Монголын төр, эрх зүй, Дугаар 02, (УБ,1997).
- Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. (2000).
- Б.Чимид “Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд”, илтгэл /”Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурал, (УБ, 2001).
- Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, (2007).
- Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, (2008).
- Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй (хоёр дахь хэвлэл), (УБ 2021)
- О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь,” Эрх зүй 36, Дугаар 4 (2016).
- Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, МУИС пресс, (2016).
- О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, (УБ, 2021).
- Н.Лүндэндорж, “Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар”, (УБ, 2023).
- ХЗҮХ, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (2023).

Хууль, эрх зүйн акт:

- Үндсэн хууль, (1992);
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992);
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, (1997);
- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 05 өдрийн 78 дугаар тогтоол гэх мэт.

Судалгааны тайлан эмхэтгэл:

- ХЗҮХ, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (Уб, 2023);
- Н.Отгончимэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа” (Уб, 2021);
- ХЗҮХ, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлан. (Уб, 2018);
- ХЗҮХ, “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь, (Уб, 2016) гэх мэт.

Олон улсын гэрээ, конвенци:

- Venice Commission Report; гэх мэт.

Цахим эх сурвалж

1. Арне Мавчич, Үндсэн хуулийн хяналт (Уб, 2014), Мэргэн Их Монгол, 40-42 дахь тал. <https://www.us-rs.si/en/about-the-court/legal-basis/constitutional-court-act/> Сүүлд үзсэн огноо: 2018.12.24.
2. “Д.Сугар ба Цалингийн 30 Хувь”, news.mn
3. <https://www.courts.ca.gov/5367.htm>, 2023.11.16
4. <https://equur.mn/415949/>, 2023.11.13

III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үнэлэх үе шатанд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн зүйл, заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. Цэцийн гишүүний томилгоо /МУҮХЦТХ-ийн 3-р зүйл/

3 дугаар зүйл. Цэцийг байгуулах журам

1.Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонгол хийж зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

2. Цэцийн гишүүнээр томилох хүний тухай Улсын Их Хуралд санал болгохдоо Улсын Их Хурлын дарга зохих байнгын хороодын санал дүгнэлтийг үндэслэн захирамж, Ерөнхийлөгч захирамж, Улсын Дээд шүүх гишүүдийнхээ олонхийн саналыг үндэслэн зохих шийдвэр гаргана.

3. Санал болгосон хүнийг Улсын Их Хурал Цэцийн гишүүнээр томилохоос татгалзсан бол санал оруулсан байгууллага, албан тушаалтан долоо хоногийн дотор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар өөр хүний нэр дэвшүүлнэ.

4. Цэцийн гишүүнийг нөхөн томилохдоо орон гарсан гишүүнийг урьд томилох санал болгосон эрх бүхий байгууллага, албан тушаалтан саналаа арван дөрвөн хоногийн дотор гаргах бөгөөд түүнийг Улсын Их Хурал гуч хоногийн дотор шийдвэрлэнэ.

5. Цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно. Цэцийн гишүүн Засаг захиргаа, нам-улс төрийн болон худалдааны үйл ажиллагаа эрхэлж, үйлдвэрчний эвлэлийн удирдах ажил хийж болохгүй.

6. Цэцийн гишүүн Улсын Их Хурлын гишүүнд буюу Монгол Улсын Ерөнхийлөгчид нэрээ дэвшүүлбэл тухайн сонгуулийн дүн гартал Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ.

7. Цэцийн гишүүн Цэцээр хянан шийдвэрлэх маргаантай асуудал болон Цэцийн хянаж байгаа маргааны талаар Цэцийн шийдвэр гараагүй байхад өөрийн санал, дүгнэлтийг олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цэцийн хуралдааны явцад ямар нэгэн хэлбэрээр урьдчилан илэрхийлэхийг хориглоно.

3.1.1. Зорилгод хүрсэн түвшин

Цэцийн гишүүний томилгоо нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэх буюу тус томилгоо нь цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэх, мөн тус зүйлийн 3-т “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасанчлан Цэцийн тухай хуулийн холбогдох зүйл нь хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэхийг энэ хэсэгт тогтооно.

Цэцийн гишүүнийг томилохтой холбоотой зохицуулалтыг Цэцийн тухай хуульд хуульчлан зохицуулсан зорилго нь Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох процессыг нарийвчлан зохицуулахад оршино. Өөрөөр хэлбэл, цэцийн гишүүнийг томилохтой холбоотой бүхий л харилцааг тодорхой хуульчлан зохицуулах нь Үндсэн хуулийн цэцийн хараат бусаар Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх урьдач нөхцөл болно.

Цэцийн гишүүнийг хэзээ санал болгох нь тодорхой бус. Цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-т “Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонголт хийж зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.” гэж заасан нь цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг тодорхойлсон заалт юм. Цэцийн гишүүн нь энд заасан 6 жилийн хугацаанд л бүрэн эрхээ хэрэгжүүлнэ гэсэн үг.

Гэвч уг заалтад тухайн санал болгох эрх бүхий байгууллагуудаас Цэцийн гишүүнд хэзээ санал болгох нь тодорхой бус байна. Өөрөөр хэлбэл, Цэцийн гишүүдээс хэн нэгнийх нь хугацаа дуусгавар болсон тохиолдолд түүний оронд шинэ Цэцийн гишүүнийг хэдий хугацаанд томилох тухай зохицуулалт тус зүйл болоод тус хуульд огт заагаагүй. Энэ нь хуулийн дагуу бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон Цэцийн гишүүн бүрэн эрхээ тодорхойгүй хугацаагаар хэрэгжүүлсээр байх нөхцөлийг үүсгэсэн байна.

Харин 2021 онд шинэчлэн найруулж батлагдсан Шүүхийн тухай хуулийн 25.8.7-д “Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах” гэж зааснаар тус асуудлыг шүүхийн институтын хувьд шийдвэрлэсэн байна. Хэдийгээр ийнхүү тодорхой зохицуулсан нь зөв зүйтэй хэрэг ч бусад институтээр ийнхүү зохицуулаагүй байгаа нь эрх мэдэл хоорондын тэнцвэрийг хангах, Цэцийн хараат бус байдлыг хангахад сөрөг үр дагавар учруулж болох эрсдэлтэй байна.

Иймд Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө эсхүл дуусгавар болсноос хойш тодорхой хугацааны дотор Ерөнхийлөгч, УИХ, УДШ-ээс тухайн гишүүний орны гишүүнийг санал болгох талаар нэг мөр хуульчлах шаардлагатай.

Цэцийн гишүүнийг УИХ томилох процедур тодорхой бус. Цэцийн гишүүнийг УИХ-аас томилдог. Гэвч одоогоор тус томилгоо хэрхэн явагдах тухай Цэцийн тухай хуульд огт заагаагүй буюу зохицуулсан хэсэг нь хэрэгжих боломжгүй байна.

Доктор, профессор Н.Лүндэндорж МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Үндсэн хуулийг чандлан сахиулж, дээд хяналтыг хэрэгжүүлэх субъектийг тодруул томилоход төрийн эрх мэдлийн аль нэг салааны нөлөөг дангаар бий болгохгүйн үүднээс гурван өөр байгууллагад санал болгох буюу олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулалт явуулан нэр дэвшүүлэх үндсэн дээр нэгэн бүрэн эрхийн хугацаанд зургаан жилийн хугацаанд УИХ томилох”¹ хэмээн тайлбарласан байна. Энд томилгоонд олон нийтийн оролцоог хангах ёстой тухай өгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, Цэцийн гишүүнд санал болгож буй нэр дэвшигч нь Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг хангаж буй эсэх, хэрхэн хангаж буй талаар олон нийт мэдэх, нягтлах шаардлагатай юм. Энэхүү үндэслэлээр 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар тус 3-р зүйлийн 1-дэх хэсэгт “нэр дэвшигчийн сонголт хийж” гэж нэмэлт оруулсан. Ингэснээр Цэцийн гишүүнийг томилоход УИХ-д нээлттэй сонголт хийх болсон. Гэвч Үндсэн хуулийн цэц уг заалтыг Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн «Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна» гэх заалтыг зөрчсөн хэмээн үзэж 2023

1 Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, (Уб, 2022), 977 дахь тал.

оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар дүгнэлтээр 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн. Ингэснээр Цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх процесс ахин хаалттай хэлбэр рүү ороод буй юм.

АНУ-д Дээд шүүхийн шүүгчийг нэр дэвшүүлэхдээ нээлттэй сонголт явуулдаг ба ингэснээр нэр дэвшигч нь шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг нягтлах, шударга² шүүлт хийхэд дэмжлэг үзүүлдэг. Доктор О.Мөнхсайхан Цэцийн гишүүнд томилогдож байгаа нэр дэвшигчид шаардлага хангасан эсэх нь эргэлзээтэй хэд хэдэн хүмүүс сонгогдож ажиллаж байсан талаар онцолж “нээлттэй сонсголоор цэцийн гишүүнд нэр дэвшигч дээр үндсэн хуулийн мэдлэг, хууль тайлбарлах ур чадвар, туршлага, ёс зүй болоод үнэт зүйл дээр нь мэргэжлийн дүгнэлт гаргах эсхүл нэр дэвшигч өмнө нь ноцтой ёс зүйн зөрчил гаргаж байсан тухай мэддэг хүнээр үг хэлүүлэх боломжтой. Мөн нээлттэй сонсголын үеэр УИХ-ын эрх бүхий гишүүд эргэлзээгээ тайлах хүртлээ асуулт асууж болно³.” гэх байр суурийг илэрхийлсэн байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилоход нэр дэвшигчийн сонголт хийх зохицуулалт нь нэр дэвшигчийг уг албан тушаалд тэнцэх эсэхийг шалгаж баталгаажуулахад чухал ач холбогдолтой байна.

Нэгэнтээ Цэцийн тухай хуулиар тодорхой заагаагүй учир бусад хуулиар зохицуулахаас өөр замгүй. Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40.1-т УИХ Цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороо ажлын 5 өдрийн дотор хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.” гэж заасан нь дээр дурдсан Нийтийн сонсголыг зохион байгуулсан ч олон нийт оролцох буюу мэдэх, нягтлах боломжоор хангагдаж амжихааргүй богино хугацаа юм. Иймд Цэцийн гишүүнийг УИХ томилох процедурыг Цэцийн тухай хуулиар тодорхой зохицуулах нь зүйтэй.

Цэцийн гишүүнийг улируулан томилох тухай зохицуулсан нь МУҮндХ-д нийцсэн эсэх нь тодорхой бус. МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасан бол Цэцийн тухай хуульд Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болохоор заасан байсан. Тус хэсгийн «Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно» гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон нь өдгөө хэдэн ч удаа Цэцийн гишүүнээр улиран томилогдож болох нөхцөлийг үүсгээд байна.

Судлаачид МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг харилцан адилгүй тайлбарладаг. Доктор, профессор Н.Лүндэндорж уг заалтыг “Цэцийн гишүүнээр 1 удаа, 6 жилийн хугацаагаар томилогдоно”⁴ гэж тайлбарласан бол Г.Совд, Н.Жанцан нар “Үндсэн хуулийн Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нэг удаагийн томилолтоор хязгаарлагддаггүй”⁵ гэж тайлбарласан байна.

2 Commission on Judicial Appointments, Холбоос: <https://www.courts.ca.gov/5367.htm>, (Сүүлд үзсэн огноо: 2024.11.10)

3 О. Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь”, Эрх зүй 36, Дугаар 4 (2016), 18-20 талд.

4 Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, (УБ, 2022), 977 дахь тал.

5 Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2000), 255 дахь тал.

Үндсэн хуулийн хяналт сайн хөгжсөн гадаадын зарим орны жишээг харвал, ихэнхдээ шүүгчийг улируулан томилохыг хязгаарласан байдаг. Учир нь Цэцийн гишүүн улиран томилогдохын тулд өөрийг нь нэр дэвшүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны ашиг сонирхлын дагуу шийдвэр гаргах магадлалтай тул “улиран томилогдох” талаар хязгаарлалт тавьж гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангадаг. Тодруулбал, улиран томилогдох боломжийг хуулиар олгох явдал нь шүүгчийн хараат бус байдалд харшилна.⁶

1992 оны Үндсэн хуулийг боловсруулах явцад Цэцийн гишүүнийг улируулан томилохыг хориглох заалт оруулах талаар гадны эрдэмтдийн дүгнэлт гарч байсан боловч улируулан томилох асуудлыг илэрхий хориглосон заалт ороогүй учир өдийг хүртэл дахин томилогдсоор иржээ. 1992-2021 оны хооронд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нийт 37 хүн томилогдон ажиллаж байснаас дөрвөн удаа улиран ажилласан 1 гишүүн, гурван удаа ажилласан 1 гишүүн, хоёр удаа улиран ажилласан 4 гишүүн байна.

Хүн ам цөөнтэй манай улсын хувьд Цэцийн гишүүнийн бүрэн эрхт хугацааг 6 жилээр тогтоон нэг удаа томилох тохиолдолд шалгуур хангасан хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй. Тиймээс Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилохыг зөвшөөрч бүрэн эрхийн хугацааг 12 жил байхаар зохицуулбал хүний нөөцийн хомсдолоос сэргийлэхийн зэрэгцээ цэцийн гишүүний хараат бус байдлыг баталгаажуулах боломжтой⁷ хэмээн судлаачид санал нийлдэг.

3.1.2. Практикт нийцэж байгаа байдал

Энэхүү дэд хэсэгт Цэцийн гишүүний томилгооны тухай зохицуулсан тус 3-р зүйл нь хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэгэн сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болоод хэрэгжилтэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай салбарын судлаачид хэрхэн үзэж буй талаар судалж тогтооно.

Цэцийн гишүүнийг хэзээ санал болгох нь тодорхой бус байгаагаас үүдэж УИХ, Ерөнхийлөгч, УДШ-ээс нэр дэвшүүлэх санал гаргахгүй удаж Цэцийн гишүүн бүрэн эрхээ 6 жилээс урт хугацаагаар хэрэгжүүлэх нөхцөл үүссэн. Үүний нэг жишээ нь Цэцийн гишүүн асан Н.Жанцан нь Ерөнхийлөгчөөс дөрвөн удаа санал болгосны дагуу 1992 оны 7 сарын 1-нээс эхлэн томилогдсон тул 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл 24 жил ажилласан байх ёстой. Гэвч тэрээр 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдөр хүртэл Цэцийн гишүүнээр 26 жил ажиллажээ. Өөрөөр хэлбэл, түүний бүрэн эрхийн хугацаа даруй 2 жилээр хэтэрсэн юм. Мөн УДШ-ээс нэр дэвшүүлэх санал гаргах хугацааны зохицуулалт байхгүй үед Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш 2 жил хүртэл санал болгодоггүй тохиолдол гарч байсан.

Цэцийн гишүүнийг УИХ томилох процедур тодорхой бус буюу УИХ-д томилох ажиллагааны хугацааны зохицуулалт хэт богино байгаагаас үүдэн Цэцийн гишүүний талаар олон нийт болоод УИХ хангалттай мэдээлэл авч чаддаггүй. Үүний жишээ нь УИХ-ын 2018 оны 33 дугаар тогтоолын хүрээнд УИХ-ын даргын 2018.05.21-нд

6 Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, (Уб, 2021), 73-74 дэх тал.

7 О. Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь”, Эрх зүй 36, Дугаар 4 (2016): 12-16 дахь тал.

107 тоот захирамж гарган Цэцийн гишүүнд Ш.Солонгыг нэр дэвшүүлсэн бөгөөд 2018.05.22-нд Төрийн байгуулалтын байнгын хороо, 2018.05.23-нд Хууль зүйн байнгын хороо тус тус хэлэлцэж дэмжээд, 2018.05.24-ний 12:11 цагт баталсан 33 дугаар тогтоолоор томилжээ.⁸ Мөн тухайн үед Ерөнхийлөгчөөс Б.Буяндэлгэр, Ц.Нанзаддорж, Г.Туулхүү нарыг Цэцийн гишүүнд санал болгох тухай зарлигийг 2018.05.18-нд гаргасан боловч тус нэр дэвшигчдийн тухай мэдээлэл нийтэд 3 өдрийн дараа ил болж Хууль зүйн байнгын хороо 2018.05.23-нд хэлэлцэн дэмжиж 2018.05.24-ний өдөр УИХ-ын 35 дугаар тогтоолоор томилогдсон. Эдгээр тохиолдлуудад 3 өдрийн дотор Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлж, томилсон байгаа нь олон нийтэд тэдний Цэцийн гишүүний шаардлагыг хангаж буй эсэх талаар мэдээлэл авах, хэлэлцэх боломж гараагүй нь харагдаж байна.

Цэцийн тухай хуульд Цэцийн гишүүнийг улируулан томилох тухай зохицуулсан нь МУҮндХ-д нийцсэн эсэх нь тодорхой бус байдлаас үүдэж тус асуудал практикт үргэлж маргаан дагуулсаар ирсэн. Гэсэн хэдий ч 1992-оос 2021 оны хооронд Цэцийн гишүүнээр нийт 37 хүн томилогдсоноос нэг гишүүн 4 удаа, нэг гишүүн 3 удаа, дөрвөн гишүүн 2 удаа тус тус дахин томилогдсон байна.⁹

3.2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлага /МУҮХЦтХ-ийн 4-р зүйл/

4 дүгээр зүйл.Цэцийн гишүүн

1.Цэцийн гишүүн хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн байх ба Цэцийн гишүүд эрх тэгш байна.

2.Цэцийн бүрэлдэхүүнд шинээр буюу нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхэлж, бүрэн эрхийн хугацаа дуустал үргэлжилнэ.

3.Цэцийн гишүүний бүрэн эрх нь Улсын Их Хурлаас дараагийн гишүүнийг томилсноор дуусгавар болно.

4.Цэцийн гишүүн Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу Цэцийн гишүүний албан тушаалаас чөлөөлөгдөж болно

3.2.1. Зорилгод хүрсэн түвшин

Энэ дэд хэсэгт Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 1-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд нийцсэн эсэх буюу Цэцийн гишүүн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх мэдлэг чадвар бүхий байх, Мөн тус зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэх буюу Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

8 “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл” тойм судалгаа, Хүний эрх Дэвшилтэт бодлогын хүрээлэн, (УБ, 2021), 418 дахь тал.

9 “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл” тойм судалгаа, Хүний эрх Дэвшилтэт бодлогын хүрээлэн, (УБ, 2021), 419 дэх тал.

МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.” гэж заасныг Цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-т “Цэцийн гишүүн хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн байх ба Цэцийн гишүүд эрх тэгш байна.” гэж эрүүгийн ял шийтгэлгүй байх болон Цэцийн гишүүд эрх тэгш байх тухай 2 шаардлагыг нэмж хуульчилжээ. Харин хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй байх тухайд ямар ч нэмэлт агуулгагүй заасан байна.

Венецийн комиссын “CDL-STD (1997) 020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн-Шинжлэх ухаан болон Ардчиллын техник” тайланд үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах шаардлагын тухайд “Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд тавигдах шаардлагад шүүхийн чадварлаг бүрэлдэхүүнийг хангахын тулд хууль зүйн мэргэшлийн шаардлагыг ихэнх тохиолдолд тусгадаг.”¹⁰ хэмээн өгүүлжээ. Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар гүйцэтгэсэн “Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”-нд дурдсанаар сонгон судалсан ХБНГУ, Австри, ОХУ, БНСУ, Латви улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь мэргэжлийн хувьд эрх зүйн дээд боловсролтой байх шаардлага тавигддаг байх бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах шаардлагыг зөвхөн Австри улс Үндсэн хуульдаа, бусад улс нь органик хуульдаа тусгаж зохицуулжээ.¹¹ Эндээс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах эрх зүйн дээд боловсрол, хууль зүйн мэргэшлийн шаардлага нь заавал тавих шаардлагатай болох нь харагдаж байна.

Венецийн комиссын Үндсэн хуулийн эрх зүй, эрх зүйн мэдээллийн тогтолцоо хариуцсан мэргэжилтэн, доктор Арне Мавчич “Үндсэн хуулийн хяналт” номдоо “Бараг бүх улсад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавих шаардлага, ажил мэргэжлийн туршлагын шалгуур өндөр байна. Нэр дэвшигчид зөвхөн эрх зүйн боловсролыг дунджаас дээш түвшинд эзэмшсэн байхаас гадна өөрсдийн шийдвэрийнхээ улс төрийн ач холбогдлыг сайн мэдэрдэг байх шаардлагатай.”¹² хэмээн үндсэн хуулийн шүүгч улс төрийн мэдлэгтэй байх чухлыг онцолсон ч эрх зүйн боловсролыг дунджаас дээш түвшинд эзэмшсэн байх нь суурь шаардлага болохыг дурджээ.

Иймд Цэцийн тухай хууль органик хууль болохын хувьд МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 2-ыг дэлгэрүүлэн Цэцийн гишүүн эрх зүйн дээд боловсролтой, хууль зүйн мэргэшлийн шаардлагыг хангасан байхыг тухайлан заах шаардлагатай байна.

3.2.2. Практикт нийцэж байгаа байдал

Энэхүү дэд хэсэгт Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын тухай зохицуулсан тус 4-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болон хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзсэн байна вэ гэдгийг авч үзнэ.

10 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл, Венецийн комисс, орчуулж эрхлэн гаргасан МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 22 дахь тал.

11 Н.Отгончимэг, Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа, (УБ, 2019), 37 дахь тал.

12 Арне Мавчич, Үндсэн хуулийн хяналт, (УБ, 2014), 43 дахь тал.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Монгол Улсын төрийн түүхэнд урьд нь байгаагүй 1992 оны Үндсэн хуулиар байгуулагдсан шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд ажиллах үүрэгтэйгээр төрийн тогтолцоонд буй болсон цоо шинэ байгууллага юм. Үндсэн хуулийн цэцийг шүүх мөн, биш гэх маргаан нийгэмд хөнддөг. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны шалгуурыг авч үзвэл: Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд хууль-шүүхийн дээд хяналт тавьдаг; энэ үүргээ байцаан шийтгэх ажиллагааны зарчим, журам, арга явцаар хэрэгжүүлдэг; Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянаад хууль хэрэглэж эцэслэн шийдвэр гаргадаг; шийдвэр гармагц Үндсэн хуулийн ёсоор хүчин төгөлдөр болдог; түүнийг холбодог байгууллага, албан тушаалтан хэн боловч заавал биелүүлнэ; ҮХЦ, түүний гишүүн нь гагцхүү Үндсэн хуульд захирагдах, аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байх Үндсэн хуулийн зарчим баримтална. Эдгээр шалгуур нь ҮХЦ-ийг шүүх мөнхийг нотолдог. Үүнээс харахад Үндсэн хуулийн цэц нь шүүх мөн бол Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь шүүгчийн хэмжээнд байх ёстой.

Үндсэн хууль тогтоогчид Цэцэд хэн нэр дэвшиж болох вэ гэдэг дээр өргөн болон явцуу хоёр янзын үзэл баримтлалыг барьж байсан. Өргөн үзэл баримтлалын дагуу хуульч, улс төрч, дипломат, улс төр судлаач, эдийн засагч зэрэг өөр өөр мэргэжлийн хүмүүс Цэцэд нэр дэвших боломжтой гэж үзэж байсан. Үндсэн хуулийн маргаан бол эрүүгийн хууль зөрчсөнтэй адилхан маргаан биш, «... Үндсэн хууль гэдэг маань нийгмийн бүх амьдралыг хамарсан өргөн хүрээний асуудал шийддэг учраас хуульчаас гадна улс төрч, эдийн засагч байх шаардлага гарч болно.» гэж үзсэн. Үндсэн хууль тогтоогчдын зарим нь энэхүү өргөн үзэл баримтлалыг няцааж, зөвхөн хуульчид Цэцэд нэр дэвших эрхтэй байх ёстой гэсэн явцуу үзэл баримтлалыг дэмжиж удаан хэлэлцсэний эцэст Цэцийн гишүүд нэр дэвшигчид тавигдах шаардлагын талаар ерөнхий заалтыг Үндсэн хуульд оруулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2-т «Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.» гэж заасан байдаг ба энэхүү заалт дах хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэх ойлголтыг практикт аль нь ч байж болох мэтээр ойлгодог жишиг тогтсон.

“Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй ...” гэдэг нь “хууль зүй, улс төр” гэсэн хоёр ойлголтын хооронд таслал байгаа тул “эрх зүйч” эсвэл “улс төр судлаач” байж болох нь гэж ойлгож болохгүй. Үндсэн хуулийн шүүх нь Морис Дювержийн шуудхан хэлснээр бүрэлдэхүүнийг томилох ажиллагаа нь улс төрийн дээд институтийн оролцоо, зөвшилцлийг агуулдаг, улс төрийн арга хэрэгслийг ашиглан томилдог, шийдвэр нь Үндсэн хуулийн мөн чанараас хамаарч улс төрийн шинжийг зүй ёсоор агуулдаг, улс төрийн үр дагавар үүсгэдэг нь нууц биш учраас Үндсэн хуулийн цэцийн гишүүн нь шийдвэрийнхээ улс төрийн үр дагаврыг мэдрэх, мэдэх шаардлага зүй ёсоор тулгарна. Үүнээс хамаарч эрх зүйч мэргэжлийн тодорхой чиглэлээр мэргэших байх, ялангуяа Үндсэн хуулийн эрх зүйн маргаан шийдвэрлэх учраас хууль зүй, улс төрийн хосолмол судлагдахуунтай Үндсэн хуулийн эрх зүйгээр академик болон академик бус хүрээнд мэдлэг, чадвар, туршлага, дадал дүйгээ нарийсган, гүнзгийрүүлж, ердийн төвшнөөс дээгүүр, бүрнээ бэлтгэгдсэн байх шаардлага зүй ёсоор тавигдана.

Шүүгч хүн улс төрийн албан тушаалтан биш, шүүх нь улс төрийн хүчнүүдийн төлөөллийн нэгж буюу улс төрийн харилцааг тэнцүүлэх зориулалтаар баримтлан хуулийн ноёрхлыг тогтоож үндсэн эрхийг хамгаалах зориулалттай байгууллага байдаг. Ийм ч учраас шүүгч хүн, энэ тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн гишүүн хүн мэргэжлийн арвин туршлагатай хуульч хүн байх ёстой юм. Цэцийн гишүүний үндсэн мэргэжил нь хуульч байх ёстой нь ойлгомжтой ч зөвхөн хуульч мэргэжлээс гадна улс төрийн зохих боловсрол, дадлага давхар эзэмшсэн байх шаардлагатай.

Монгол Улсад хуульч биш төдийгүй эрх зүйч биш хүмүүс Цэцийн гишүүнээр томилогдож ирсэн. 1992-оос 2021 оны хооронд Цэцийн гишүүнээр томилогдсон 37 хүний 5 нь хуульч бөгөөд эрх зүйч биш байсан ба тэдгээрийн хоёр нь түүхч, хоёр нь геологич, нэг нь дипломатч мэргэжилтэй байжээ. Харин үлдсэн 32 хүн нь эрх зүйч мэргэжлээрээ бараг ажиллаагүй бөгөөд улс төрийн албан тушаал хашиж байв.¹³

Цэцийн хууль тогтоогчдоос бүрдсэн УБХ 1992 оны 5 сарын 8-ний Монгол Улсын Үндсэн Хуулийн цэцийн тухай хуулийг батлахдаа Цэцийн гишүүнд нэр дэвшигчийн талаар өргөн үзэл баримтлалыг баримталсан Цэцийн тухай хуульд Үндсэн хуулийн 65-р зүйлийн 2-т заасан «хууль зүй, улс төрийн өндөр мэргэжилтэй» гэдэг шаардлагыг дэлгэрүүлэн тайлбарлаж тодорхойлоогүйгээс уг хууль үйлчилж эхэлснээс хойш Цэцийн гишүүн нь хуульч төдийгүй бусад мэргэжлийн хүн байхыг зөвшөөрч хууль зүйн салбарт мэргэшсэн бүү хэл хууль зүйн мэргэжлийн байх шаардлага тавьдаггүй практик нэгэнт тогтсон байна.

2012 онд Үндсэн хуулийн цэцэд нэр нэр бүхий иргэн мэдээлэл гаргаж, Цэцийн тухайн үеийн зарим гишүүн хууль зүйн мэргэшилгүй, иймд хуульд заасан шаардлага хангаагүй нэр дэвшигчийг томилсон УИХ-ын тогтоол нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан үзэж шийдвэрлэж өгөхийг хүссэн байдаг. Тухайн үед Цэцийн тухай хууль болон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах хүрээнд, Цэцийн гишүүнд тавих шаардлагыг илүү нарийвчилж зохицуулахаар байсан тул маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж байжээ.¹⁴

Доктор, профессор Ц.Сарантуяа Үндсэн хуулийн процессын эрх зүй номынхоо хоёр дахь хэвлэлд “Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг бусад шүүгчид тавих хуульд заасан болзолтой уялдуулан 2015 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хууль зүйн мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг заахаар санал болгосон боловч тухайн төслийг УИХ эдүгээ хүртэл хэлэлцээгүй” хэмээн дурджээ.

13 “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл” тойм судалгаа, Хүний эрх Дэвшилтэт бодлогын хүрээлэн, (УБ, 2021), 420 дахь тал.

14 Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, (УБ, 2021), 60 дахь тал.

3.3. Цэцийн гишүүний бүрэн эрх /МУҮХЦтХ-ийн 5-р зүйл/

5 дугаар зүйл. Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа

1. Цэцийн гишүүнийг Цэцийн зөвшөөрөлгүйгээр /түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд/ баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн журмаар түүнд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хориглоно.

2. Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагын санал, шийдвэрийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор Цэц хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас төгтөөгдсөн бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.

4.Цэцийн гишүүнийг хувийн хүсэлтээ гаргасан, эрүүл мэндийн улмаас, эсхүл Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусахаас нь өмнө уг албан тушаалаас чөлөөлөх, эгүүлэн татах, өөр ажилд шилжүүлэхийг хориглоно.

5.Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан болон Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрснээс бусад үндэслэлээр Цэцийн гишүүнээс чөлөөлөгдвөл гишүүнээр томилогдохын өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах, эсхүл түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар хангана. Хэрэв тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэлх 6 сарын хугацаанд Цэцийн гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс бууруулахгүйгээр тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байгаа бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж улсын төсвөөс мөн хугацаанд олгоно.

6.Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно. Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно

3.3.1. Зорилгод хүрсэн түвшин

МУҮндХ-ийн 64-р зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж тусгасан байдаг. Цэцийн гишүүний бие даасан байдал нь түүний бүрэн эрхийн баталгаагаар илэрнэ. Иймд тус хуулийн 5-р зүйл цэцийн гишүүний хараат бус, бие даасан байдлыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

Монголын Үндсэн хуулийн 64.2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж тусгаж өгсөн байдаг. Мөн Цэцийн гишүүний хараат бус байдлыг хангах баталгаа нь хууль тогтоомж, цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа, нийгэм эдийн засгийн баталгаа зэрэгт оршдог. Гэвч эрдэмтэд, судлаачид цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа хангалтгүй, дутмаг байна гэж тодорхойлсон байна. Тухайлбал, 2018 оны ХЗҮХ-ийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт” хийсэн үнэлгээний тайланд Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаанд нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангах асуудал зохицуулагдаагүй байна гэж үзсэн байна. Мөн доктор П.Очирбат “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал нь хууль зүй, нийгэм, эдийн засаг, үйл ажиллагааны бусад баталгаагаар хангагдсан байх ёстой ба Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал нь гишүүний хараат бус

байдлын нэг чухал баталгаа болдог. Үндсэн хуулийн цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгааг хангах асуудал хараат бус байдалд чухал ач холбогдолтой бөгөөд энэ талаарх харилцааг зарим улсад тусгайлсан актаар зохицуулах хандлага давамгайлах болсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд ийм баталгаа байхгүй¹⁵ гэсэн байна. Тус зохицуулалт хуулийн зорилго болох хараат бус байдлыг хангаж өгөөгүй байна.

Гадаад улс, орнуудад цэцийн гишүүдийн бүрэн эрх, эдийн засгийн баталгааг дараах байдлаар хуульчилж өгсөн байна¹⁶.

Хүснэгт 4.2. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа зохицуулсан байдал

Улс орнууд	Хуулийн нэр	Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа
Гүрж ¹⁷ Улс	“Үндсэн хуулийн шүүгчдийн нийгмийн баталгааны тухай хууль”	<p>- Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн цалингийн хэмжээг хуулиар тогтоох бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн Дэд ерөнхийлөгч болон Нарийн бичгийн даргын сарын үндсэн цалин нь Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн цалингийн 90 хувиас багагүй, харин гишүүний цалин нь 85 хувиас багагүй байх;</p> <p>- Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн сарын нэмэгдэл цалин нь түүний цалингийн 90 хувиас багагүй, харин Дэд ерөнхийлөгч, Нарийн бичгийн дарга, гишүүний нэмэгдэл цалин нь тэдгээрийн үндсэн цалингийн 50 хувиас багагүй байхаас гадна тэдгээрт ажилласан жил, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох;</p> <p>- Үндсэн хуулийн шүүхийн гишүүдэд жилд 45 хоногийн ээлжийн амралт эдлүүлэх бөгөөд амралт авахаас нь өмнө хоёр сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэх;</p> <p>- Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч гадаад улсад албан айлчлал хийх нөхцөлд цалингийн 50, 40, 35 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт цалин олгох;</p> <p>- Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Нарийн бичгийн дарга, гишүүнийг тэтгэвэрт гарах үед авч байсан цалингийн 100 хувиар тэтгэвэр тогтоох;</p> <p>- Үндсэн хуулийн шүүхийн гишүүн болон гишүүн байсан хүн нас барсан эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд түүгээр тэжээн тэтгүүлж байсан түүний эхнэр, нөхөр болон 18 насанд хүрээгүй хүүхдэд тэтгэврийн хэмжээгээр тэтгэвэр олгох;</p>

15 П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль: хэрэгжилт, хяналт, судалгаа (Мөнхийн үсэг, 2017), 341 дэх тал.

16 Д. Наранчимэг “Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим”, Н.Жанцан нар, “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт (УБ, 2017)”, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 230-231 дэх тал.

17 Мөн тэнд.

		<p>– Үндсэн хуулийн шүүхийн гишүүн болон гишүүн байсан хүн нь албаны чиг үүрэгтэй холбоотойгоор бусдын халдлагад өртөн нас барсан тохиолдолд түүний эхнэр, нөхөр болон хүүхдэд түүний авч байсан цалин, эсхүл тэтгэврийн 10 жилтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг материаллаг бусад тусламж үзүүлснээс үл хамааран олгох;</p> <p>– Үндсэн хуулийн шүүхийн гишүүн нь хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан тохиолдолд түүний 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүлэхээс гадна гишүүний бүрэн эрхийн хугацаанд түүний цалин, бусад хангамжийг бууруулахыг хориглосон байна.</p>
<p>Словени¹⁸ Улс</p>	<p>Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль</p>	<p>- Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч нь Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгчтэй ижил хэмжээний цалин болон нэмэгдэл авах;</p> <p>– Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь Үндэсний Ассамблейн Дэд Ерөнхийлөгчтэй ижил хэмжээний цалин болон нэмэгдэл авах;</p> <p>– Үндсэн хуулийн шүүх Нарийн бичгийн даргын цалинг тогтоох бөгөөд цалингийн хэмжээ нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн цалинтай тэнцүү хэмжээтэй байх;</p> <p>– Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь ээлжийн амралтын хугацаанд, эрүүл мэндийн болон ослын шалтгаанаар чөлөө авсан хугацааны эхний 30 хоногт сарын цалингийн хэмжээтэй тэнцүү хэмжээний цалин авах;</p> <p>– Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид ажилдаа ирэх, буцах унааны зардал, томилолтын зардал, үдийн хоолны зардал, ээлжийн амралтын мөнгө, нүүх зардал, ажлын байр нь байрладаг газраас байнга оршин суудаг газар руугаа ирж, буцах зардал, байнга оршин суудаг газраасаа ажлын байрны ойролцоо газар нүүх зардал, мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал, удаан жилийн нэмэгдэл, тэтгэвэрт гарсны тэтгэмж зэрэг нөхөн олговор авах;</p> <p>– Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь жилд нэг удаа 40 хоногийн ээлжийн амралт, хувийн шалтгаанаар 7 хүртэл хоногийн цалинтай чөлөө авах;</p> <p>– Үндсэн хуулийн шүүгчээр сонгогдохоосоо өмнө аль нэг шатны шүүхэд, эсхүл төрийн аль нэг байгууллагад байнгын ажил, албан тушаал эрхэлж байсан бол бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш өмнөх ажлын байрны тодорхойлолтыг бүрэн хангаж байвал гурван сарын дотор тухайн байгууллагад өмнөх ажилдаа эргэн очих тухай мэдэгдэж, уг ажилдаа эргэн томилогдох;</p> <p>– Үндсэн хуулийн шүүгчээр сонгогдохоосоо өмнө аль нэг байгууллага, олон нийтийн компани, байгууллагад ажиллаж байсан бол бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш гурван сарын дотор уг ажилдаа эргэн томилогдох, эсхүл өөрийн боловсрол, мэргэжлийн түвшинд тохирсон ажил эрхлэх;</p>

18 Арне Мавчич, Үндсэн хуулийн хяналт (УБ, 2014), Мэргэн Их Монгол, 40-42 дахь тал, Холбоос: <https://www.us-rs.si/en/about-the-court/legal-basis/constitutional-court-act/> Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

		<p>– Бүрэн эрхийн хугацаа дууссан ч бодит шалтгааны улмаас өмнө хашиж байсан ажил албан тушаалыг эрхлэх боломжгүй болсон, эсхүл тохирох ажлын байраа олж чадаагүй байгаа Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй бол сарын цалингийн хэмжээтэй тэнцүү хэмжээний нөхөн олговрыг нэг жилийн хугацаанд авах эрхтэй байхаар зохицуулсан байна.</p>
Беларусь ¹⁹ Улс	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	<p>– Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч болон шүүгчдийн цалинг тус улсын Дээд зөвлөлийн дарга, нэгдүгээр орлогч дарга, орлогч дарга нартай ижил хэмжээнд тогтоосон байна.</p> <p>– Мөн орон байргүй, эсхүл нийтийн байранд амьдардаг зэрэг бусад шалтгаанаар амьдрах нөхцөлөө сайжруулах шаардлагатай шүүгчдэд томилогдсон даруй болон ийм шаардлага бий болсон үеэс хойш зургаан сарын хугацаанд багтааж улсын төсвийн хөрөнгөөр Минск хотод орон сууцаар хангах тухай Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд тусгажээ.</p> <p>– Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа тэтгэвэрт гарах, эсхүл хуульд заасан бусад шалтгаанаар хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд шүүгчээр томилогдохоос өмнө эрхэлж байсан ажилдаа, энэ ажил нь үгүй болсон байвал ижил түвшний өөр ажилд томилогдох эрхтэй байхаар зохицуулсан байна.</p> <p>– Харин бүрэн эрхийн хугацаа дууссан болон тэтгэвэрт гарсан шүүгч нь хуульд заасны дагуу ердийн шүүхийн шүүгч нарын нэгэн адил баталгаагаар хангагдахаар байна.</p>
Оросын Холбооны ²⁰ Улс	“Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хангах, шүүгчдэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд төрийн болон нийгмийн баталгаа эдлүүлэх тухай” Ерөнхийлөгчийн зарлиг	<p>– ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нарт зэрэг, цолны нэмэгдлээс гадна гадаад хэлний мэдлэгээ албаны үүргээ хэрэгжүүлэхдээ ашигласны төлөө сар бүрийн цалин дээр мөнгөн шагнал болгон нэмэгдэл олгох,</p> <p>– ОХУ-ын нутаг дэвсгэрийн хүрээнд төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгсэл, таксинаас бусад хот хоорондын тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих, орон сууц, албаны унаа, харилцаа холбооны хэрэгслээр хангагдах, орон сууцны төлбөрийн болон орон сууцны ашиглалтын бүх зардлын 50 хувийг төрөөс хариуцах,</p>

19 Арне Мавчич, Үндсэн хуулийн хяналт (УБ, 2014), Мэргэн Их Монгол, 39 дэх тал.

20 Д.Наранчимэг “Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим”, Н.Жанцан нар, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт (УБ, 2017), Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 231 дэх тал. Холбоос: <http://kremlin.ru/acts/bank/15164>. Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

		– Засгийн газрын тэргүүн, түүний орлогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд тогтоосонтой адил нөхцөл, журмаар нийгэм-ахуй, эмнэлэг, амралт, сувиллын үйлчилгээний аливаа хөнгөлөлтийг Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд адил эдлүүлэх, Үндсэн хуулийн шүүхийн шүүгч тэтгэвэрт гараад нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн гишүүн тус бүрд өндөр насны тэтгэврийн хуулийн дагуу тогтоосон суурь тэтгэврийн хэмжээг 165 хувиар нэмэгдүүлсэн хэмжээтэй тэнцэх мөнгөн тэтгэлгийг сар бүр олгохын зэрэгцээ гэр бүлд нь шүүхийн шүүгчийн 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэлгийг 1 удаа олгох, бэлбэсэн эхнэр, нөхөр болон насанд хүрээгүй хүүхэд нь орон сууцны ашиглалтын бүх зардлын 50 хувийн хөнгөлөлтийг үргэлжлүүлэн эдлэх эрхтэй байх зэрэг олон төрлийн нийгэм, эдийн засгийн баталгааг эдлүүлэхээр тусгасан байна.
--	--	--

Гадаад улс, орнуудад Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааг хуульд нарийвчлан тусгаж өгсөн байхад Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийг ерөнхий байдлаар тусгаж өгсөн нь цэцийн хараат бус байдалд эргээд нөлөөлөх сөрөг дагавар үүсгэх боломжтой. Иймд бусад улсын жишгийг харьцуулан цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааг нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай.

3.3.2. Практикт нийцэж байгаа байдал

Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх тухай зохицуулсан тус 5-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт сөрөг үр дагавар гарч байгаа эсэх, хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзсэн байна вэ гэдгийг авч үзнэ. Тодруулбал, Цэцийн гишүүний бүрэн эрхийн байдал практикт хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох, зэрэг болон сөрөг үр дагавар, хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдлыг судална.

Цэцийн тухай хуулийн 5.5-т цэцийн гишүүн төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн тохиолдолд бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох буюу төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 насанд бүрэн эрхийг хугацаа дуусгавар болгохоор зохицуулсан байна. Цэцийн тэтгэвэрт гарах насыг ажлын ачаалал, өндөр хариуцлага болон хэт өндөр настай байх нь сөрөг үр дагавартай гэж үзэн жинхэнэ албан хаагчийн тэтгэвэрт гарах насыг тогтоосон байна. Гэвч Цэцийн гишүүнийг улираан сонгох хязгаарлалтыг зохицуулаагүй улмаас зарим гишүүд удаа дараа дахин сонгогдож байсан байна.

Тухайлбал Цэцийн гишүүн Ж.Одбаяр 2016 онд цэцийн гишүүнээр томилогдож ажиллаж эхэлсэн бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон ч идэвхтэй ажиллаж байна. Мөн Цэцийн дарга Н.Чинбат 2017 оны 6 дугаар сарын 9-нд Цэцийн гишүүнээр томилогдон ажиллаж эхэлсэн боловч бүрэн эрхийн хугацаа 5 сарын өмнө дуусгавар болсон байна. Цэцийн дарга 67 настай бөгөөд тэтгэвэрт гарах нас нь хэтэрсэн байна.

Үүнээс дүгнэхэд Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйл практикт хэрэгжиж байгааг харахад эргэлзээтэй байна.

3.4. Цэцийн дарга, түүний эрх хэмжээ/ МУҮХЦтХ-ийн 6-р зүйл/

6 дугаар зүйл. Цэцийн дарга, түүний эрх хэмжээ

1. Цэцийн даргаар сонгох хүний нэрийг Цэцийн гишүүд дотроосоо дэвшүүлэн хуралдаанаараа хэлэлцэж, саналыг нууцаар хурааж нийт гишүүний олонхийн санал авсан хүнийг сонгоно.
2. Цэцийн даргад гурав буюу түүнээс дээш нэр дэвшиж, анхны санал хураалтаар хэн нь ч нийт гишүүний олонхийн санал авч чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүний талаар дахин санал хурааж нийт гишүүний олонхийн санал авсан хүнийг Цэцийн даргаар сонгоно.
3. Цэцийн даргын бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.
4. Цэцийн дарга Цэцээс үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах, гишүүдийн төлөөлөлтийн байдлыг тэнцүүлэн Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилох, гишүүдийн ажил үүргийг хуваарилж, гүйцэтгэлийн хяналт тавих, Цэцийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцана.
5. Цэцийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар тогтоол, тушаал гаргана.
6. Цэцийн даргын түр эзгүйд Цэцийн бүрэлдэхүүнд хамгийн удаан ажилласан гишүүн, хэрэв энэ шаардлагыг хэд хэдэн гишүүн нэгэн адил хангасан байвал тэдгээрийн хамгийн ахмад гишүүн Цэцийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэнэ.

3.4.1. Зорилгод хүрсэн түвшин

МУҮндХ-ийн 65-р зүйлийн 3-т “Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэж, мөн Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2.1-т “Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол улсын Үндсэн хуульд нийцэх хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж тусгасан байдаг. Иймд цэцийн дарга бүрэн эрхийн хугацаандаа бие даасан, хараат бусаар ажиллаж чадаж буй эсэх, түүний баталгааг тус хуулиар хангаж чадаж байгаа эсэхийг судална.

Цэцийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргах талаар хуульд зохицуулж өгсөн байдаг. Гэтэл зарим тохиолдолд цэцийн даргын тушаал цэцийн гишүүний хараат бус байдлыг хөндөж байна гэж зарим судлаачид үзсэн байна. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар их хэмжээний хөрөнгө, орлогоо мэдүүлээгүй улмаас зөрчил үүсэж Цэцийн дарга Ж.Амарсанаа “хөрөнгө, орлогын мэдүүлгээ бичихдээ хайхрамгүй хандсан, хөрөнгө орлогын өөрчлөлтөө бүрэн гүйцэт мэдүүлээгүй алдаа дутагдал²¹²²” гарсан гэдгийг тогтоож түүнд албан тушаалын цалин бууруулах шийтгэл оногдуулах тушаал гаргасан байна. Гэвч Цэцийн дарга цэцийн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах бүрэн эрх хуулиар зохицуулагдаагүй байна.

Хэрэв Цэцийн дарга бусад цэцийн гишүүддээ хариуцлага тооцох үйлдэл гаргавал цэцийн хараат бус байдалд халдах эрсдэлтэй байна. Үндсэн хуулийн 64.2-ын “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна” гэж тусгаж өгсөн. Иймд дээрх зүйл заалт тус хуулийн зорилгод нийцэхгүй байна гэдгийг харж болно.

21 Доктор О.Мөнхсайхан, “Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудалд хийсэн дүн шинжилгээ”, *Хууль дээдлэх ёс, Цуврал 2(48), (2014)*

22 “Д.Сугар ба Цалингийн 30 Хувь”, 2014.04.16, Холбоос: www.news.mn, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17

Мөн МУҮндХ-ийн 65.3-т “3.Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхын саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэж зааж өгсөн. Харин Хуульч Н. Отгончимэгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”-нд гадаадын зарим орнуудад цэцийн даргыг өөрсдөө биш өөр хуулийн этгээдээр сонгуулдаг байна.

Тухайлбал, Австрийн Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийг Холбооны Засгийн газрын санал болгосноор Холбооны Ерөнхийлөгч томилно. Оросын Үндсэн хуулийн шүүхийн дарга болон хоёр орлогч даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Холбооны Ерөнхийлөгч томилдог²³ байна. Доорх хүснэгтээс харахад цэцийн даргыг тусдаа “хөндлөнгийн этгээд буюу улсын Ерөнхийлөгч, парламент нь томилдог байна.

Хүснэгт 4.3. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн шүүхийн дарга /ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, томилох²⁴

Улс	Дарга, орлогч	Санал болгох буюу нэр дэвшүүлэх этгээд	Томилох этгээд
ХБНГУ	-Ерөнхийлөгч, -Дэд ерөнхийлөгчтэй. Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд заасан.	Нэр дэвшүүлэх ажлыг Бундестагийн дэргэд байгуулагдах, түүний 12 гишүүдээс бүрдэх Сонгох хороо хийнэ.	Ерөнхийлөгчийг эхний удаад Бундестаг, Дэд ерөнхийлөгчийг эхний удаад Бундестрат сонгоно. Дараагийн удаад Бундестаг, Бундесрат эрхээ солин хэрэгжүүлдэг
Австри	-Ерөнхийлөгч, -Дэд ерөнхийлөгчтэй. Үндсэн хуульд заасан.	Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг Холбооны Засгийн газар санал болгоно.	Ерөнхийлөгч томилно.
ОХУ	-Дарга, -2 Орлогч даргатай	ОХУ-ын Ерөнхийлөгч санал болгоно	Холбооны зөвлөл 6 жилийн хугацаагаар томилно. Дахин томилж болно.
Солонгос	Ерөнхийлөгч	Томилох зөвшөөрлийг Үндэсний ассамблей өгнө	Ерөнхийлөгч томилно.
Латви	Ерөнхийлөгч	Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид дундаас Ерөнхийлөгч санал болгоно	Сеймас (парламент) томилно.

3.4.2. Практикт нийцэж байгаа байдал

Цэцийн дарга, түүний эрх хэмжээний талаар зохицуулсан тус 6-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгааг авч үзэх буюу Цэцийн дарга эрх хэмжээг хуулиар оновчтой зохицуулсан эсэх, практикт ямар үр дагаврыг гарч байгаа талаар судалж үнэлэлт өгнө.

23 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, 23-р зүйл.

24 Н.Отгончимэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”, (УБ, 2021).

Үндсэн хуулийн 6.3-т “Цэцийн дарга бүрэн эрхийн хугацаа хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэж зохицуулсан байна. Цэцийн дарга Н.Чинбат 2019 онд даргаар сонгогдож ажиллаж эхлээд үргэлжлүүлэн ажиллаж байна. Цэцийн даргын бүрэн эрхийн хугацаа 2022 онд дууссан ч хуулийн дагуу нэг удаа улируулан сонгоход бүрэн эрхийн хугацаа асуудалгүй байна. Гэхдээ тус хуулийн 5.5-т “төрийн албан хаах насны дээд хязгаарт хүрснээр цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно” гэж заасан нь Цэцийн дарга тэтгэврийн насанд хүрсэн ч ажлаа үргэлжлүүлэн ажиллаж байна.

Үндсэн хуулийн цэцийн даргын эрх хэмжээгээ хэтрүүлэн хэрэглэж цэцийн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулсан тушаал гаргасан талаар зарим судлаачид цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан гэж үзэж байна. Мөн ҮХЦТХ-д насны дээд хязгаарт хүрснээр цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно гэж хуульчилсан ч зарим тохиолдолд тэтгэврийн нас хүрсэн ч ажлаа үргэлжлүүлэн хийх тохиолдолд гарч байгаа нь тухайн хууль практикт хэрэгжихгүй байгааг илтгэж байна. Иймд цэцийн даргын эрх хэмжээг бусад цэцийн гишүүний хараат бус байдалд халдахгүй байхаар нарийвчлан тодорхойлж өгөх, гадаад орнуудын жишигт цэцийн даргыг цэцийн гишүүний дундаас бус өөр хуулийн этгээдээр сонгуулдаг байна.

3.5. Цэцийн үйл ажиллагааны нөхцөл /МУҮХЦТХ-ийн 7-р зүйл/

7 дугаар зүйл. Цэцийн үйл ажиллагааны нөхцөл

1. Цэц нь ажлын албатай байна. Түүний орон тоог Улсын Их Хурлаас баталсан төсөвт багтаан Цэцийн ажлын албаны дарга тогтооно.
2. Цэц тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн нүүртэй байна. Цэцийн тамгыг Цэцийн дарга барина.
3. Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалингийн хэмжээг Цэцийн даргын санал болгосноор Улсын Их Хурал тогтоож батална.
4. Цэцийн гишүүн өмсгөлтэй байна. Цэцийн гишүүний өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг Улсын Их Хурал батална

3.5.1. Зорилгод хүрсэн түвшин

Энэ хэсэгт Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийн тухай зохицуулалт нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 1-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд нийцсэн эсэх буюу Цэц энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг тус хуулиар хангалттай зохицуулж чадсан эсэх, тийнхүү зохицуулахдаа МУҮндХ-ийн тус зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

Монгол Улсын Үндсэн хуульд “Үндсэн хуулийн шүүхийн бие даасан, хараат бус байдлыг нэгд, төсөв санхүүгийн бие даасан байдал, хоёрт, зохион байгуулалтын асуудлаа шийдвэрлэх эрх, гуравт, боловсон хүчний асуудлаа бие даан шийдвэрлэх тухайд тусгаж зохицуулсан байна²⁵.” Мөн Монгол Улсын “Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат

25 Н.Отгончимэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”, (УБ, 2021).

бус байдлыг хангах, Цэц, түүний гишүүдийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, судалгаа, шинжилгээ, мэдээлэл, лавлагааны асуудлаар дэмжлэг үзүүлэх, хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй²⁶ байна гэж Үндсэн хуулийн цэцийн цахим хуудсан дээр тодорхойлж өгсөн боловч Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйл дээр Үндсэн хууль цэц ажлын албатай байна гэхээс өөр эрх зүйн байдлыг тодорхой тусгаж зохицуулаагүй байна.

Шигтгээ 1²⁷

Үндсэн хуулийн цэцийн ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд тодорхой бүтэц, зохион байгуулалтын нэгжтэй 40 орчим хүнтэй ажиллаж байна. Цэц нь эдүгээ үйл ажиллагаа явуулах нөхцөл хангасан өөрийн байртай бөгөөд түүнийг Үндсэн хуулийн цэцийн ордон гэнэ. Үндсэн хуулийн шүүхийн байр нь төрийн тусгай хамгаалалтад байна. Үндсэн хуулийн цэц өөрийн байртай байх нь нэг талаар Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрх, түүнчлэн Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих, түүнийг сахин хамгаалах чиг үүргээ тасралтгүй, шуурхай хэрэгжүүлэх, түүнчлэн иргэний өргөдөл, мэдээлэл болон эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтийг үндэслэн Үндсэн хууль зөрчсөн гэх маргааныг ямар нэгэн саад бэрхшээлгүй шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

Үүнээс үзэхэд цэцийн тамгын газар нь Цэцийн үйл ажиллагааг явуулахад маш чухал оролцоотой нь харагдаж байна. Иймд хуулийн зорилго болох цэцийн үйл ажиллагааны зарчим, бүрэлдэхүүн болон зохион байгуулалтыг тодорхой хуульд зохицуулж өгөөгүй нь хуулийн зорилгодоо хүрээгүй байгааг илтгэж байна.

Гадаадын орнуудад цэцийн ажлын албаны талаар хэрхэн тусгасан байдлыг авч авч үзье.

Хүснэгт 4.4. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн шүүхийн ажлын алба²⁸

Улс орнууд	Хуулийн нэр	Үндсэн хуулийн шүүхийн захиргаа
ХБНГУ	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нь шүүхийн захиргааны талаар зохицуулалт тусгагдаагүй. Харин Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бүгд хурлаар Шүүхийн процедурын журмыг баталж, түүнд шүүхийн захиргааны талаарх үндсэн зохицуулалтыг оруулжээ. Шүүхийн захиргааны Захирал болон дарга нь танхимын даргалагч шүүгч нарт танхимын үйл ажиллагааг явуулахад туслалцаа үзүүлнэ. Шүүхийн захиргааг Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс Үндсэн хуулийн шүүхийн Захирал удирддаг байна ²⁹ .

26 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, Холбоос: https://www.conscourt.gov.mn/?page_id=625, Сүүлд үзсэн огноо: 2023.11.14

27 ХЗҮХ, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ" судалгааны тайлан.2018

28 Мөн, тэнд

29 ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн процедурын журам (Rules of Procedure of the Federal Constitutional Court), 12 болон 15 дугаар зүйл, Холбоос: https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/GO_BVerfG.html#download=1, Сүүлд үзсэн огноо: 2023.11.14

		<p>Холбооны Үндсэн хуулийн шүүхийн захиргаа нь Шүүхийн захиргаа, Ерөнхий захиргаа, Мэдээллийн технологи, баримтжуулалтын газар, Протоколын газар, Номын сангаас бүрдэнэ.</p> <p>I.Шүүхийн захиргаа/Judicial administration</p> <p>II.Ерөнхий захиргаа/General Administration</p> <p>III.Мэдээллийн технологийн баримтжуулалтын газар/</p> <p>IV.Протоколын газар/Protocol</p>
Австри	<p>Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд шүүхийн захиргааны талаар тусгаагүй.</p>	<p>Харин тухайн шүүхийн цахим хуудсанд шүүхийн Захиргаа нь дараах бүтэцтэй³⁰ гэж тэмдэглэжээ:</p> <p>Шүүхийн асуудал, чанар ба мэдлэгийн менежментийн газар</p> <p>Боловсон хүчний менежмент, хөгжлийн газар</p> <p>Санхүү, эдийн засгийн асуудлын газар</p> <p>Олон улсын харилцаа, протоколын газар</p> <p>Мэдээлэл, харилцаа холбооны технологи газар</p> <p>Номын сан, харилцаа холбооны газар</p> <p>Зохион байгуулалт, төслийн менежмент, архивын газар</p> <p>Хэвлэлийн төлөөлөгч, хэвлэл мэдээллийн бусад асуудал эрхэлсэн газар</p> <p>Шүүхийн захиргааны Ерөнхий захирал удирдаж ажилтнуудын ажлын гүйцэтгэл, дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавина.</p>
ОХУ	<p>Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 111-р зүйлд шүүхийн захиргаа буюу ажлын албаны талаар тусгажээ.</p>	<p>Үндсэн хуулийн шүүхийн дарга нь Үндсэн хуулийн шүүхийн аппарат/захиргаа-ын ерөнхий удирдлагыг хэрэгжүүлж, аппаратын удирдлага болон Үндсэн хуулийн шүүхийн Тамгын газрын даргад нэр дэвшүүлэх, Тамгын газрын журам болон аппаратын бүтцийг батлуулах асуудлыг Үндсэн хуулийн шүүхэд өргөн мэдүүлдэг.</p> <p>1.Үндсэн хуулийн шүүхийн Тамгын газар</p> <p>Тамгын газар нь дараах 11 нэгжээс бүрддэг:</p> <ol style="list-style-type: none"> 1.Нийтийн эрх зүйн Үндсэн хуулийн үндсийг эрхэлсэн газар 2.Хувийн эрх зүйн Үндсэн хуулийн үндсийг эрхэлсэн газар 3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийг эрхэлсэн газар 4.Эрүүгийн хууль тогтоомжийн Үндсэн хуулийн үндсийг эрхэлсэн газар 5.Редакц-бүтээлийн газар 6.Олон улсын харилцаа болон үндсэн хуулийн хяналтын үйл ажиллагааг таниулах ажлыг эрхэлсэн газар 7.Эрх зүйн мэдээлэл эрхэлсэн газар 8.Шүүх хуралдааны зохион байгуулалт эрхэлсэн нэгж 9.Хэвлэлийн мэдээллийн нэгж 10.Иргэдийг хүлээн авах, захидал харилцаа эрхэлсэн нэгж

30 Management, Administration of Justice and Scientific Service, Холбоос: <https://www.vfgh.gv.at/verfassungsgerichtshof/organisation/Management.en.html>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.14

		<p>11.Хэрэг шийдвэрлэх ажиллагааг хангах нэгж</p> <p>II.Төрийн алба ба хүний нөөцийн удирдлагын газар</p> <p>Дараах асуудлыг эрхэлдэг:</p> <p>- Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хангах хүний нөөцийн баримт бичгийг бэлтгэх, ажилтнуудыг томилох, чөлөөлөх, шилжүүлэх бэлтгэл хангах, ажилчдыг магадлан итгэмжлэх шалгалт авах, ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх асуудал,</p> <p>III.Санхүүгийн удирдлагын газар</p> <p>Дараах асуудлыг эрхэлдэг:</p> <p>- Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа, бүтцийн онцлогийг харгалзан, санхүүгийн тогтвортой байдлыг ханган нягтлан бодох бүртгэлийг хөтлөх.</p> <p>IV.Хэрэг эрхлэх удирдлагын газар</p> <p>Дараах асуудлыг эрхэлдэг:</p> <p>- ханган нийлүүлэлт төлөвлөх, зохион байгуулах, материал-техникийн эх үүсвэрээр хангах, кабелийн сүлжээ, холбооны системийн ашиглалтад хяналт тавих, барилга байгууламжийн ашиглалтыг хариуцах, арга хэмжээ, албан ёсны уулзалтыг зохион байгуулах, төлөвлөх, шүүгч нарын нийгэм ахуйн хангамжийг зохион байгуулах.</p> <p>V.Үндсэн хуулийн шүүхийн Москва дахь төлөөлөгчийн газар</p> <p>- Үндсэн хуулийн шүүхэд иргэд хандах нөхцөл бүрдүүлэх, байнгын харилцаа холбоог хангах чиг үүрэгтэй.</p>
БНСУ	<p>Үндсэн хуулийн шүүхийн захиргааны талаар Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 17-р зүйлд тусгажээ</p>	<p>Шүүхийн захиргаа нь Үндсэн хуулийн шүүхийн захиргааны үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй. Шүүхийн захиргааг Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч удирдана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн удирдлага дор шүүхийн захиргааны албан хаагчдыг удирдаж, зохион байгуулдаг. Ингэхдээ Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндэсний ассамблей буюу парламент, Төрийн зөвлөлийн хуралд оролцож Үндсэн хуулийн шүүхийн захиргааны талаар мэдээлэл өгөх бүрэн эрхийг хуулиараа олгосон байдаг. Хэрэв захиран зарцуулах үйл ажиллагаатай нь холбогдуулах Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч захиргааны маргаан үүсгэвэл Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцагч байна гэж хуульчилжээ.</p> <p>Харин орлогч дарга нь Ерөнхий нарийн бичгийн даргад туслах, түүний эзгүйд түүний өмнөөс бүрэн эрхийг нь хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Шүүхийн захиргаа нь ажлын алба, товчоо, хэлтэстэй байна. Тэдгээрийн зохион байгуулалт, ажилтны тоо зэрэг асуудлыг Үндсэн хуулийн шүүх журмаараа шийдвэрлэхээр заасан байна. Шүүхийн захиргааны удирдлага болон албан хаагчид нь төрийн албан хаагчийн хэддүгээр зэрэгтэй алба хаагчдаас томилогдож болохыг Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульдаа тусгасан байна. Шүүхийн захиргаанд ажиллах албан хаагчдыг Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч томилж, чөлөөлдөг. Гэхдээ төрийн албан хаагчийн III зэргээс дээш зэрэгтэй албан хаагчийг томилж, чөлөөлөх асуудлыг Шүүгчдийн зөвлөлийн оролцоотой буюу тэдний саналд үндэслэн шийдвэрлэхээр хуульдаа заажээ.</p>

		<p>Солонгосын зохицуулалтын онцлог нь Үндсэн хуулийн шүүхийн судалгааны асуудалд ихээхэн ач холбогдол өгч “Үндсэн хуулийн судалгааны ажилтнууд” гэсэн тусдаа зүйлд тусгажээ. Үндсэн хуулийн шүүхэд судалгааны ажилтнууд ажиллах ба тэдгээрийн тоог Үндсэн хуулийн шүүхийн журмаар зохицуулдаг. Судалгааны ажилтнууд Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн шийдвэрээр хэргийг шалгах, шийдвэрлэхтэй холбоотой судалгаа, шалгалтын ажилд оролцох чиг үүрэгтэй. Судалгааны ажилтнуудыг Хууль зүйн зөвлөлийн шийдвэрт үндэслэн Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч 10 жилийн хугацаагаар томилох ба дахин томилж болно. Тэд 60 нас хүрмэгц өндөр насны тэтгэвэрт гарах зохицуулалттай. Гэхдээ Үндсэн хуулийн шүүхийн судалгааны ажилтнаар анх томилогдох тохиолдолд эхний 3 жилд судалгааны туслах ажилтан гэсэн статустайгаар ажилладаг байна.</p> <p>Үүний зэрэгцээ Солонгос улсын бас нэг онцлог нь хэрэг маргааныг шалгах, шийдвэрлэхэд мэргэжлийн шалгалт, судалгаа хийх шаардлагатай тохиолдолд Үндсэн хуулийн шүүх тусгай төлөөлөгчийг/commissioner татан оролцуулж болдог байна. Ийм тусгай төлөөлөгчийг 3 хүртэл жилийн хугацаагаар томилж ажиллуулдаг.</p> <p>Үндсэн хуулийн шүүхийн судалгааны ажилтнуудаас гадна тус шүүхийн дэргэд 40 хүртэл тооны ажилтнаас бүрдэх Үндсэн хуулийн судалгааны хүрээлэн ажиллана гэдгийг хуульдаа мөн тусгажээ. Тус хүрээлэн нь Үндсэн хуулийн судалгаа, Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа судалгаа, Үндсэн хуулийн шүүхийн судалгааны ажилтнуудын болон Шүүхийн захиргааны газрын албан хаагчдын сургалтыг хариуцан эрхэлдэг ба шүүхийн Захиргааны газарт харьяалагддаггүй. Үндсэн хуулийн судалгааны хүрээлэнгийн ажилтнуудыг Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч бие даасан томилох бүрэн эрхтэй.</p>
Латви	<p>Үндсэн хуулийн шүүхийн ажлын албаны талаар хуульд нь ямар нэг заалт тусгагдаагүй байх бөгөөд ажлын албаны үндсэн бүтцийг Үндсэн хуулийн шүүхийн журамд тусгасан байна³¹</p>	<p>Үндсэн хуулийн шүүх ажлын албаныхаа бүтэц, журам, зохион байгуулалтыг батална. Үндсэн хуулийн шүүхийн ажлын алба дараах үндсэн бүтэцтэй байна.</p> <p>Канцлер буюу Ерөнхий нарийн бичгийн дарга;</p> <p>Ерөнхийлөгчийн зөвлөх, Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхий нарийн бичгийн даргад шууд захирагддаг төрийн бусад албан хаагчид;</p> <p>шүүхийн туслахууд;</p> <p>Хууль зүйн судалгааны хэлтэс;</p> <p>Захиргаа, протоколын хэлтэс;</p> <p>Хүний нөөцийн хэлтэс.</p>

Гадаад орнуудын жишгийг харахад Үндсэн хуулийн шүүхийн ажлын албаны эрх зүйн байдлыг хуулиар маш нарийн зохицуулж өгсөн байна. Солонгос улсын хувьд Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд шүүхийн захиргаа, зохион байгуулалт, ажилчдын эрх зүйн байдлын талаар хуулийн зохицуулалтыг тодорхой болгож өгсөн байна.

31 Үндсэн хуулийн шүүхийн журам (The Rules of the Constitutional Court), 46-р зүйл. Холбоос: <https://www.lrkt.lt/en/administrative-information/rules-and-regulations/the-rules-of-the-constitutional-court/1296>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.14

Иймд Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны зохицуулалтыг журмаар эсвэл хуульд нэмэлт зүйл заалтаар тодорхой зохицуулж өгөх шаардлагатай харагдаж байна.

3.5.2. Практикт нийцэж байгаа байдал

Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон тус зүйлийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална.

Цэцийн ажлын алба цэцийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад чухал алба гүйцэтгэдэг боловч эрх зүйн байдлыг мөн тодорхойгүй зохицуулж өгсөн байна. Харин бусад гадаад орнуудад цэцийн ажлын албын тодорхой зохицуулж өгснөөр хүний нөөцийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх үндэс суурийг хангасан байна. Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны зохицуулалтыг журмаар эсвэл хуульд нэмэлт зүйл заалтаар тодорхой зохицуулж өгөх шаардлагатай харагдаж байна.

Цэцийн бие даасан байдлыг хангах асуудлын нэг болох цэцийн эдийн засгийн баталгааг хангах, тэр дундаа цэцийн гишүүдийн цалин хангамж, нийгмийн баталгааг хангаж өгөх нь чухал байр суурийг эзэлдэг. Гэвч зарим судлаачид цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалингийн хэмжээг Улсын их хурлаар батлуулахад төсвийг танах асуудал гарах, мөн хараат байдлын талаар болгоомжилсон байна. Иймд цэц болон цэцийн гишүүд албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангахад төр анхаарах шаардлагатай. Цэц болон цэцийн гишүүдийн эдийн засгийн баталгааг баталгаажуулсан зүйл заалтуудыг нэмж хуульчлах шаардлагатай.

3.5.3. Үндсэн хуулийн цэцийн эдийн засгийн бие даасан байдал

Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал тэр дундаа цэцийн эдийн засгийн баталгаанд шүүх үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүрэлцэхүйц хэмжээний төсөвтэй байх, цэц эдийн засгийн хувьд хэнээс ч хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах эрх үндсийг хамааруулна.

Гэвч Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн судалгаанд эрдэмтэд, судлаачид “Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүний цалингийн хэмжээний хувьд зарим талаар Улсын Их Хурлаас хараат байгаа байдал ажиглагдаж байна³²” болон “Цэцийн төсөв нь санхүүгийн хувьд бие даасан байж чиг үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлөөр хангагдах ёстой. Улсын Их Хурал төсөв батлахдаа Цэцийн төсвийг танах, хасах явдал гаргадаг³³” зэрэг асуудал тулгарч байгааг судалгаанд онцолсон байна. Үүнээс харахад цэцийн бие даасан байдлын гол шалгуур болох эдийн засгийн баталгаа буюу төсөв, санхүүгийн байдал Улсын Их Хурлаас хамааралтай харагдаж байна.

32 “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт” хийсэн үнэлгээний тайлан, ХЗҮХ, (УБ, 2018).

33 Д. Наранчимэг “Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим”, Н.Жанцан нар, “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт”, (УБ, 2017).

Харин гадаад орнуудад дараах байдлаар Үндсэн хуулийн шүүхийн төсөв, санхүү хуульд тусгаж өгсөн байна.

Хүснэгт 4.5. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн шүүхийн төсөв, санхүү³⁴

Улс орнууд	Хуулийн нэр	Үндсэн хуулийн шүүхийн төсөв, санхүү
ХБНГУ	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 1-р зүйлийн 1-д “Холбооны Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн бусад байгууллагаас бие даасан, хараат бус байна.” гэж заажээ. Харин Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд шүүхийн төсөв, санхүүтэй холбоотой тухайлсан зохицуулалт тусгагдаагүй байна.
ОХУ	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	<p>Үндсэн хуулийн шүүх холбооны улсын төсвөөс санхүүжиж, санхүүжилт нь үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг бие даан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Жил бүрийн төсөвт Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хангах эх үүсвэрийг бие даасан зүйл болгон тусгах бөгөөд үүнийгээ Үндсэн хуулийн шүүх бие даан зарцуулна. Мөн төсвийг өмнөх жилийнхээс буруулж болохгүй заалттай.</p> <p>Үндсэн хуулийн шүүх нь мэдээлэл, хүний нөөцийн асуудлаа бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэйг мөн хуульчилсан байна.</p> <p>Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд заасан Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны эрх зүй, зохион байгуулалт, санхүү, мэдээлэл, материал-техник, хүний нөөцийн зэрэг нөхцөлийг хязгаарлахыг хоригложээ.</p>
БНСУ	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	“Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны зардлыг улсын төсөвт бие даан тусгана” ³⁵ гэсний зэрэгцээ нөөц хөрөнгийг энэхүү зардалд багтаасан байхаар мөн хуульд заасан байна. Энэхүү төсөв боловсруулах, зардал, нөөц хөрөнгийн асуудлыг Үндсэн хуулийн шүүхийн нийт шүүгчдийн зөвлөлөөр шийдвэрлэхээр заажээ ³⁶ .
Латви	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	<p>Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдал нь бие даасан төсөвтэй байх, зохион байгуулалт, материал-техникийн асуудлаа өөрөө бие даасан шийдвэрлэхэд оршиж байна.</p> <p>Үндсэн хуулийн шүүхийн эрх чөлөө, бие даасан байдал нь хуульд заасан санхүү, материал-техник, зохион байгуулалтын баталгаагаар хангагдана. Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн хяналтын чиг үүргээ бие даан, зохих байдлаар хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжнэ. Үндсэн хуулийн шүүх нь зардлын тооцооллоо өөр өө батлах бөгөөд хуваарилагдсан эх үүсвэрийг бие даан зарцуулна. Түүнчлэн Үндсэн хуулийн шүүх нь мэдээллийн болон зохион байгуулалтын ханган нийлүүлэлтийг чөлөөтэй, бие дааж хэрэгжүүлнэ.</p> <p>Латви улсад Үндсэн хуулийн шүүх нь зардлын тооцооллыг өөрөө батлах бүрэн эрх олгогдсон нь онцлог байна.</p>

Үүнээс үзэхэд гадаадын орнуудад Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдал, эдийн засгийн баталгаа хуулиар баталгаажуулж өгсөн нь шүүгчийг гадны нөлөөнөөс хамгаалах боломжийг олгож байна.

Цэцийн эдийн засгийн баталгаа хангагдах эрх зүйн зохицуулалт практикт хэрэгжихгүй байгаа учир Шүүхийн тухай хуулийн гол баталгаа буюу 5.6. “Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах

34 Н.Отгончимэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”, (УБ, 2021).

35 БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 11 дүгээр зүйл.

36 БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

нөхцөлийг төр хангана. Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” заалтыг нэмж эдийн засгийн баталгаа гаргаж өгөх хэрэгтэй.

Шүүхийн бие даасан байдлыг хангах гэдэг нь хоёр үндсэн утгыг илэрхийлдэг. Үүнд нэг талаас шүүх эрх мэдлийг төрийн бусад эрх мэдэл болох хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс харьцангуй бие даалгах³⁷ нөгөө талаас шүүх эрх мэдлийг шүүх бүр бие даан хэрэгжүүлэх юм³⁸. Үүний ойлгомжтойгоор илэрхийлбэл шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахад шүүхийг гаднаас буюу төрийн эрх мэдлийн бусад субъектээс хамгаалах нөгөө талаар шүүхийг шүүхийн өөрийн удирдлага, захиргаанаас хамгаалах гэж тайлбарлаж болно³⁹.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний эрх хэмжээний гол заалтууд болох ҮХЦТХ-ийн 5 дугаар зүйл “Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа” хэт ерөнхий байдлаар зохицуулсан нь эргээд цэцийн гишүүний хараат бус байдалд халдах эрсдэлийг бий болгож байна. Бусад гадаад орнуудын жишгийг харахад цэцийн гишүүдийн эдийн засгийн баталгаа, эрх зүйн байдлыг тусгайлан тодорхой зохицуулж өгсөн нь хараат бус байдлыг бэхжүүлж өгсөн байна. Иймд цэцийн хараат бус байдлыг хангахын тулд гадаад улсуудын жишгээс судлан цэцийн гишүүний бүрэн эрхийн эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж өгөх шаардлагатай байна.

37 Б.Чимид “Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд”, илтгэл /”Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурал, (Уб, 2001), 56 дахь тал.

38 Г.Совд “Шүүх , шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд”, *Монголын төр, эрх зүй, Дугаар 02*, (Уб, 1997).

39 “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь”, ХЗҮХ, “Шүүхийн шинэтгэлийн эрхийн хэрэгжилт, эрх зүй асуудал”, (Уб, 2016), 72 дахь тал.

IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Цэцийн гишүүний томилгооны тухай МУҮХЦТХ-ийн 3-р зүйлд нь нэн тодорхойгүй буюу бүрэн гүйцэт зохицуулаагүйгээс Цэцийн гишүүнийг томилох процедур бүхэлдээ тодорхой бус явагдаж, нэр дэвшигч санал болгох эрх бүхий институтууд өөр өөрсдийнхөөрөө хөтлөн явуулж байна. Иймд дараах агуулгаар Цэцийн тухай хуулийг шинэчлэх хэрэгтэй гэж үзлээ. Үүнд:

- Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө эсхүл дуусгавар болсноос хойш тодорхой хугацааны дотор Ерөнхийлөгч, УИХ, УДШ-ээс тухайн гишүүний орны гишүүнийг санал болгох талаар нэг мөр хуульчлах;
- Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилоход нэр дэвшигчийн сонсгол хийх зохицуулалт нь нэр дэвшигчийг уг албан тушаалд тэнцэх эсэхийг шалгаж баталгаажуулахад чухал ач холбогдолтой тул нэр дэвшигчийн сонсгол хийх процессыг хуульчлах;
- Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилохыг зөвшөөрч бүрэн эрхийн хугацааг 12 жил байхаар зохицуулах.

2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг МУҮХЦТХ-ийн 4-р зүйлд хэт ерөнхий тодорхойлсноос практикт эрх зүйч бус хүн Цэцийн гишүүн болох жишиг тогтож, үүнээс үүдэж Цэц үндсэн хуулийн шүүх болохын хувьд мэргэшсэн байж чадахгүйд хүрч байна. Иймд Цэцийн тухай хууль органик хууль болохын хувьд тус хуульд МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 2-ыг дэлгэрүүлэн Цэцийн гишүүн эрх зүйн дээд боловсролтой, хууль зүйн мэргэшлийн шаардлагыг хангасан байхыг тухайлан зааж шинэчлэх шаардлагатай.

3. Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх тухай МУҮХЦТХ-ийн 5-р зүйлд хэт ерөнхий байдлаар зохицуулсан нь Цэцийн гишүүний хараат бус байдалд халдах эрсдэлийг бий болгож байна. Иймд Цэцийн хараат бус байдлыг хангахын тулд Цэцийн гишүүний бүрэн эрхийг Цэцийн тухай хуульд нарийвчлан тодорхойлж өгөх шаардлагатай байна.

4. Цэцийн дарга, түүний эрх хэмжээний тухай зохицуулсан МУҮХЦТХ-ийн 6-р зүйл нь зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийн хувьд хангалтгүй байгаагаас практикт тэтгэврийн насанд хүрсэн ч Цэцийн гишүүний бүрэн эрхийг үргэлжлүүлэх, Цэцийн даргын эрх хэмжээгээ хэтрүүлэн хэрэглэж цэцийн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах зэргээр Цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан тохиолдлууд гарсаар байна. Түүнчлэн Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуваарилах, хуралдааны бүрэлдэхүүнийг томилохтой холбогдох харилцааг Цэцийн даргын бүрэн эрхэд хамаарах байдлаар зохицуулсан нь Цэцийн хараат бус байдлын баталгааг алдагдуулж байна. Иймд Цэцийн тухай хуульд Цэцийн даргын эрх хэмжээг бусад цэцийн гишүүний хараат бус байдалд халдахгүй байхаар нарийвчлан тодорхойлж, Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуваарилах, хуралдааны бүрэлдэхүүнийг томилохтой холбогдох харилцааг шүүхийн нийтлэг жишгийн адилаар зохицуулах нь зүйтэй.

5. Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон МУҮХЦТХ-ийн 7-р зүйл нь зорилгод хүрэх түвшин хангалтгүй буюу Цэцийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлдэг ажлын албаны эрх зүйн байдлыг тодорхой заагаагүй,

Цэцийн эдийн засгийн баталгаа, тэр дундаа ажлын албаны алба хаагчид, Цэцийн гишүүдийн цалин хангамж, нийгмийн баталгаа хангагдаагүй байна. Иймд Цэцийн ажлын албаны бүтэц, чиг үүргийг тодорхойлсон зохицуулалтыг, Цэц болон цэцийн гишүүдийн эдийн засгийн баталгааг баталгаажуулсан зүйл заалтуудын хамтаар Цэцийн тухай хуульд тусгайлан заах шаардлагатай байна.

6. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү судалгааны үр дүнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй хэмээн үзэж байна.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992).
3. Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, (1997).
4. Нийтийн сонсголын тухай хууль, (2015).

Гадаад хэлээр:

1. Rules of Procedure of the Federal Constitutional Court/ Германы Үндсэн хуулийн шүүхийн процедурын журам, Холбоос: https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/GO_VVerfG.html#download=1.
2. ОХУ-ын Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
3. Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
4. Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
5. Австри Улсын Үндсэн хууль, Холбоос: https://www.vfgh.gv.at/downloads/VfGH_Broschuere_eng_barrierefrei_Final.pdf.

Ном, сурал бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Г.Совд “Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд”, Монголын төр, эрх зүй, Дугаар 02, (УБ, 1997).
2. Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. (УБ, 2000).
3. Б.Чимид “Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд”, илтгэл /”Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурал, (УБ, 2001).
4. Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, (УБ, 2007).
5. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, (УБ, 2008).
6. ХЗДХЯ, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”, “Үндсэн хуулийн процессын эрх зүй” оюутны гарын авлага, (УБ, 2011).
7. О.Мөнхсайхан, “Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудалд хийсэн дүн шинжилгээ”, Эрх зүй 48, Дугаар 4 (УБ, 2014).
8. Арне Мавчичи, Үндсэн хуулийн хяналт, (УБ, 2014).
9. О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015).

10. О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь,” Эрх зүй 36, Дугаар 4 (Уб, 2016).
11. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, (МУИС пресс, 2016).
12. П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль: хэрэгжилт, хяналт, судалгаа, (Уб, 2017).
13. Д.Наранчимэг “Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим”, Н.Жанцан нар, “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт, (Уб, 2017).
14. Н.Номинчимэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа, (Уб, 2019).
15. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, (Уб, 2021).
16. Н.Лүндэндорж, “Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар”, (Уб, 2023).
17. ХЗҮХ, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (Уб, 2023).
18. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, хоёр дахь хэвлэл, (Уб, 2021).

Гадаад хэлээр:

1. 성낙인, 헌법학, 법문사, 2021.
2. Арне Мавчич, Үндсэн хуулийн хяналт (Уб, 2014), Мэргэн Их Монгол, Холбоос: <https://www.us-rs.si/en/about-the-court/legal-basis/constitutional-court-act/>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.13.
3. “Д.Сугар ба Цалингийн 30 Хувь”, Холбоос: www.news.mn, Сүүлд үзсэн огноо: 2023.11.16.
4. About Commision on Judicial Appointments, Холбоос: <https://www.courts.ca.gov/5367.htm>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.16.

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Үндсэн хуулийн шүүгч нарын томилгоо ба УИХ-ын гишүүдийн хайнга байдал нотлогдов, (2018), Холбоос: <https://ikon.mn/opinion/1a9u>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
2. С.Нарангэрэл, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаарх Академич С.Нарангэрэлийн бичмэл санал”, (2023), Холбоос: <https://ip.ac.mn/c/1013593?Content=37072>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
3. Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” Эрдэм шинжилгээний нийтлэл, Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
4. Д.Одбаярын бүрэн эрх 7 сарын өмнө, Н.Чинбатынх өнөөдөр дууслаа, 2023, Холбоос: <https://eguur.mn/415949/>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.13.

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
----------------	---

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Б.Түмэндэмбэрэл	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)
Р.Хатансайхан	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Г.Болор-Эрдэнэ	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил (ҮХЦ-ийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагч).

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.11.17.

АГУУЛГА

УДИРТГАЛ	163
I.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	164
II.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	165
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд	165
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд	166
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд	166
2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд	166
III.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	168
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	169
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	183
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	195
3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	195
IV.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	197
1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	197
2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	198
3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	198
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	199
НОМ ЗҮЙ	200

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл” буюу 4.4-т хэсгийн Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ гэж заасан.

Энэхүү зорилтын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог сайжруулахын тулд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасан. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг дэргэдээ хуулийн төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгүүдийг ажиллуулж байна.

Үндсэн хуулийн шүүх бол Үндсэн хуулийг бодит тохиолдолд хэрэглэдэг, түүнийг чандлан сахиулдаг институт буюу үндсэн хуульт ёсны баталгаа мөн. Манай улсын хувьд Үндсэн хуулийн шүүхийг “Үндсэн хуулийн цэц” гэсэн оноосон нэртэйгээр анх байгуулснаас хойш 30 гаруй жил болж байна. Энэ хугацаанд Үндсэн хуулийн цэцийн зүгээс Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхээ чамлахааргүй амжилттай хэрэгжүүлж ирсэн. Гэвч өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, мэргэшсэн байдлыг улам бэхжүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийн шүүхийн жишгээр процессжуулах тэргүүтэй тулгамдсан асуудал бодлогын болон практикийн шийдэл хүлээж байна.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ийн дагуу “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль” /цаашид Цэцийн тухай хууль гэх/-ийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оршино.

Цэцийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Журмын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх

I. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Зардал¹
6. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн төслийн Нэр дэвшигчийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журам, Цэцийн бүрэлдэхүүн зохион байгуулалт, маргааныг хуваарилах, Цэцийн зөвлөгөөн ажиллах журам, Цэцийн гишүүний хариуцлагыг дээшлүүлэх, Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгаа, Цэцийн хараат бусаар ажиллах санхүү, Бие даасан байх эрх зүйн зохицуулалтыг тус тус сонгон авч “Зорилгод нийцсэн эсэх”; шалгуур үзүүлэлтийн дагуу /Хуулийн төслийн 6 дугаар зүйл, Хуулийн төслийн 9 дүгээр зүйл, Хуулийн төслийн 10 дугаар зүйл, Хуулийн төслийн 14, 16 дугаар зүйл, Хуулийн төслийн 19 дүгээр зүйл, Хуулийн төслийн 20, 21 дүгээр зүйл/;
2. Хуулийн төслийн Маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх дүгнэлт гаргах, дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргах үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх, Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлага, Цэцийн гишүүнийг нэг удаа томилох, Цэцийн даргын бүрэн эрх, Цэцийн тамгын газар, Тамгын газрын даргын бүрэн эрхийн сайжруулалт, Цэцийн чадавхыг сайжруулах, Нөлөөллийн мэдүүлгийн эрх зүйн зохицуулалтыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн дагуу/ Хуулийн төслийн 3 дугаар зүйл, Хуулийн төслийн 5 дугаар зүйл, Хуулийн төслийн 6 дугаар зүйл, Хуулийн төслийн 7 дугаар зүйл, Хуулийн төслийн 12 дугаар зүйл, Хуулийн төслийн 17 дугаар зүйл/;
3. Цэцийн тухай хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэхэд ойлгомжтой эсэхийг “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу;
4. Цэцийн тухай хуулийн төслийн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй эсэхийг “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн дагуу тус тус үнэлсэн.

1 Журмын төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төслийн зардлын тооцоо сэдэвт судалгаа гүйцэтгэсэн байх тул дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

II. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөөг үнэлнэ.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төслөөс дараах зүйл, заалтын сонголт “зорилгод хүрэх байдал” үр нөлөөг үнэлнэ. Үүнд:

Хүснэгт 5.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
	Хуулийн төслийн зорилго нь “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /цаашид “Цэц” гэх/-ийн бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, хараат бус, үйл ажиллагааны баталгаа, Цэцийн гишүүний эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэх зохицуулалтын үзэл баримтлал, зорилгод нийцсэн эсэх	Хуулийн төслийн 6 дугаар зүйл Хуулийн төслийн 9 дүгээр зүйл Хуулийн төслийн 10 дугаар зүйл Хуулийн төслийн 14, 16 дугаар зүйл Хуулийн төслийн 19 дүгээр зүйл Хуулийн төслийн 20, 21 дүгээр зүйл

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон судалдаг. Тус судалгаанд хуулийн төслийн дараах агуулгын хүрээнд холбогдох зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг тооцсон болно.

Хүснэгт 5.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
	Шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг	Хуулийн төслийн 3 дугаар зүйл Хуулийн төслийн 5 дугаар зүйл Хуулийн төслийн 6 дугаар зүйл Хуулийн төслийн 12 дугаар зүйл Хуулийн төслийн 17 дугаар зүйл

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь үнэлгээ хийх боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томъёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг сонгон авч үнэллээ.

Хүснэгт 5.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл заалт
	Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх	Хуулийн төсөл бүхэлдээ

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалт бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг.

Хүснэгт 5.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл заалт

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл заалт
	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалтыг шалгах	Хуулийн төсөл бүхэлдээ

III. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Хүснэгт 5.5. Шалгуур үзүүлэлт ба тохирох шалгах хэрэгсэл

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 5.6. Үр нөлөөг үнэлэх хэсэг

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 6 дугаар зүйл; Хуулийн төслийн 9 дүгээр зүйл; Хуулийн төслийн 10 дугаар зүйл; Хуулийн төслийн 14, 16 дугаар зүйл; Хуулийн төслийн 20, 21 дүгээр зүйл.	Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлал болон тус хуулийн төслийн холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 3 дугаар зүйл; Хуулийн төслийн 5 дугаар зүйл; Хуулийн төслийн 6 дугаар зүйл; Хуулийн төслийн 12 дугаар зүйл; Хуулийн төслийн 17 дугаар зүйл.	Практикт хэрэгжих байдлыг баримт бичигт дүн шинжилгээ хийх замаар судлах
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Тодорхойлоогүй нэр томъёонуудыг тайлбарлах байдлаар санал болгох, хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх саналыг гаргах
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Харилцан уялдааг судлах, ингэхдээ сантай холбогдох төрийн байгууллагын бүрэн эрхэд дүн шинжилгээ хийх

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд хуулийн төслийн зорилго буюу төслийн 1.1 дэх хэсэг болон хуулийн төслийн бусад зохицуулалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /цаашид “Цэц” гэх/-ийн бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, хараат бус, бие даасан байдлын баталгаа, Цэцийн гишүүний эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.1.1. Нэр дэвшигчийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журмын тухайд /хуулийн төслийн 6 дугаар зүйл/

Хүснэгт 5.7. Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн тухайд

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	3.2. Цэцийн гишүүнээр томилох хүний тухай Улсын Их Хуралд санал болгохдоо Улсын Их Хурлын дарга зохих байнгын хороодын санал дүгнэлтийг үндэслэн захирамж, Ерөнхийлөгч захирамж, Улсын Дээд шүүх гишүүдийнхээ олонхын саналыг үндэслэн зохих шийдвэр гаргана.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл заалт	6.6.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан саналаа Улсын Их Хуралд хүргүүлэхээсээ өмнө тухайн нэр дэвшигч Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг бүрэн хангасан талаарх үндэслэл, танилцуулгыг цахим хуудастаа таваас доошгүй ажлын өдөр байршуулна. 6.9.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг хангах боломжтой хүмүүсийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журмыг энэ хуульд нийцүүлэн баталж, ажлын таван өдрийн дотор цахим хуудсанд даа байршуулна.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Цэцийн гишүүнээр томилох хүний тухай Улсын Их Хуралд санал болгохдоо Улсын Их Хурлын дарга зохих байнгын хороодын санал дүгнэлтийг үндэслэн захирамж, Ерөнхийлөгч захирамж, Улсын Дээд шүүх гишүүдийнхээ олонхын саналыг үндэслэн зохих шийдвэр гаргана” гэж заасан.² Уг хуулийн заалтаас цэцийн гишүүнээр ямар хүнийг нэр дэвшүүлэх, түүнтэй ярилцлага хийх, мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй ил тод байлгах замаар тэдгээрийн болон бусад мэргэжлийн оролцоог хангах журамтай холбоотой зохицуулалт дутмаг байсныг харж болно.

Судлаачдын хувьд, хуульчдын дунд нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага төдийгүй ёс зүй, зан төлөвөөрөө хамгийн шилдэг хуульч, эрх зүйч л Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилгогддог байх нь Үндсэн хуулийн шаардлага гэж үздэг. Нэр дэвшигч ийм шаардлагыг хангаж байгаа эсэхийг мэдэх шалгарсан аргын нэг бол тэднийг нийтийн сонсголоор хэлэлцүүлсний дараа томилох эсэхийг шийдвэрлэдэг болох явдал юм. УИХ-аас 2015 оны 7 дугаар сарын 8-нд баталсан Нийтийн сонсголын тухай хуулийн 10.1-т “Улсын Их Хурлаас албан

2 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992), 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг.

тушаалтныг томилохтой холбогдуулан Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй гишүүд хүсэлт гаргасан бол томилгооны сонсголыг явуулна”³ гэж заасан. Энэ заалт нь Цэцийн гишүүд болон УИХ-аас томилдог бусад албан тушаалд нэр дэвшигчийн талаар нийтийн сонсгол хийх боломж олгож байгаагаараа ач холбогдолтой. УИХ-ын гишүүд Цэцэд нэр дэвшигчийн талаар нээлттэй сонсгол хийж, түүнийг томилох эсэхэд хариуцлагатай хандаж чадвал Цэцийн бүрэлдэхүүн чанаржина.

Сүүлийн 25 шахам жилд нэр хүндтэй хуульчид Цэц рүү томилогдож байсан ч шаардлага хангасан эсэх нь эргэлзээтэй хүмүүс бас томилогдож ирсэн. Тодруулбал 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох чөлөөлөх асуудлыг хэлэлцэн Ерөнхийлөгчөөс 3, УИХ-аас 1 гишүүнийг тус тус томилсон. Гэвч уг томилгоо нийгэмд маргаан болон хардлагыг төрүүлсэн. Учир нь Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг долоо хоногийн дотор дэвшүүлж томилсон.

Өөрөөр хэлбэл, цэцийн гишүүнээр томилохоор сонгогдсон хүнийг өмнө нь эрхэлж байсан ажил болон бусад асуудлыг судлах шаардлагатай. Өмнө нь ажлаа мэргэжлийн түвшинд, үнэнч шударга хийж байсан бол томилогдсоныхоо дараа Цэцийн гишүүний үүргийг тэгж гүйцэтгэнэ гэж үздэг. Өмнө нь асуудалтай байсан бол Цэцийн гишүүнээр сайн ажиллана гэж найдахын хэрэггүй гэсэн үг. Тодруулбал, үндсэн хуулийн маргаан шийдэх мэдлэг, ур чадвартай байхын тулд хууль зүйн дээд боловсролтой байх нь наад захын шаардлага юм. Мөн, хангалттай туршлага хуримтлуулахуйц хугацаанд мэргэжлээрээ ажилласан байх ёстой.

Хууль хэрэглэдэг, хараат бусаар шийдвэр гаргадаг ажлыг хийсэн байх ёстой. Ийм ажлуудын жишээ гэвэл шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуулийн зөвлөх, их сургуулийн хуулийн профессор. Дээрээс нь өөрөө хүлээн зөвшөөрөгдсөн хүн байх ёстой. ҮХЦ-д томилогдох хүн өөрөө тодорхой хэмжээний нэр хүнд бүхий байх ёстой гэсэн үг. Энэ нэр хүндийг олж тогтоохын тулд тухайн хүний бүхий л мэдээллийг олж цуглуулж анализ хийх ёстой болно.⁴

УИХ-ын гишүүд асуулт асуусан болоод өнгөрөх болон судалгаа, мэдээлэл бүхий хүмүүсийг оролцуулсан сонсгол хийх хоёр ихээхэн ялгаатай. Нийтийн сонсголоор үндсэн хуулийн эрх зүйгээр мэргэшсэн судлаач эсхүл эдгээр хүмүүстэй холбоотой фактыг мэддэг хүмүүсээс үнэнийг хэлнэ гэсэн тангараг авч мэдээлэл сонсоно. Жишээ нь үндсэн хууль судлаачид Цэцийн гишүүнд нэр дэвшигч дээр үндсэн хуулийн мэдлэг, хууль тайлбарлах ур чадвар, туршлага, ёс зүй, үнэт зүйл дээр нь мэргэжлийн дүгнэлт гаргаж танилцуулж болно. Эсхүл нэр дэвшигч өмнө нь ноцтой ёс зүйн зөрчил гаргаж байсан тухай мэдээлэл бүхий хүнээр үг хэлүүлнэ. Сонсголын үеэр УИХ-ын эрх бүхий гишүүд эргэлзээгээ тайлах хүртлээ асуулт асууж болно. Энэ бүх мэдээлэл нь УИХ тухайн нэр дэвшигчийг Цэцэд томилох эсэх шийдвэр гаргахад тустай бөгөөд үндэслэл бүхий байвал томилохоос татгалзах боломжтой болно.

3 Нийтийн сонсголын тухай хууль, (2015), 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг.

4 О.Мөнхсайхан, “Үндсэн хуулийн шүүгч нарын томилгоо ба УИХ-ын гишүүдийн хайнга байдал нотлогдов”,(сурв. Ч.Болортуяа) 2018.05.24, Холбоос: <https://ikon.mn/opinion/1aau>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17

Цэцийн гишүүнд нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар төдийгүй зан чанар, ёс зүй гээд бүх талын мэдээллийг хангалтай сонсож, уг албанд тушаалд тэнцэхгүй бол томилохоос татгалздаг байх ёстой. АНУ зэрэг орны парламент дахь нийтийн сонсгол ийм зарчмаар ажилладаг. Жишээ нь 1987 онд тус улсын Ерөнхийлөгч Роналд Реган нь Роберт Борк гэж хуульчийг АНУ-ын Дээд шүүхэд нэр дэвшүүлсэн ч Сенат (парламентын дээд танхим) дахь сонсголоор түүний хуулийн тухай хэт туйлширсан үзэл ил болж, эцэстээ түүнийг батламжлахаас татгалзахад хүрсэн учраас томилогдож чадаагүй. Дээд шүүхийн шүүгч Кларанс Томас нэр дэвшихээсээ 10-аад жилийн өмнө туслахдаа бэлгийн дарамт үзүүлж байсан асуудал нь нээлттэй сонсголын үеэр илэрч бараг томилогдож чадахгүй байдалд хүрч байв. Монголд ийм тохиолдол гарч байгаагүйн нэг шалтгаан нь нийтийн сонсголтой адил тогтолцоог бүрдүүлээгүйтэй холбоотой. Цэцийн гишүүнийг Үндсэн хууль болон бусад хуульд үнэнч, хараат бус байгаасай гэсэн шалтгаанаар ард түмнээр сонгуулдаггүй. Гэхдээ, тэднийг томилох УИХ нь нэр дэвшигч хэн бэ гэдгийг нээлттэй хэлэлцүүлж хангалттай мэдээлэл авсны дараа зөвхөн шаардлага хангасан хүнийг томилдог байхгүй бол мэдлэг, ур чадвар, ёс зүйгүй хүмүүс олноор томилогдож улс болон иргэд хохирно.

Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг нэр дэвшигч хангасан эсэх шүүмж, хэлэлцүүлэг бараг өрнөдөггүй. Үүний үр дагавар болж Цэцийн гишүүнд тавигдах шаардлага хангаагүй хүмүүс Цэцэд томилогддог тохиолдол бий. 2007 оноос хойших Цэцийн гишүүний томилгоог ажиглахад эрх бүхий субъектээс Цэцийн гишүүнд хэнийг нэр дэвшүүлсэн, хэнийг томилсон талаар товч мэдээ хэвлэлд тавигддаг болов ч үндсэн хуулийн маргаантай хэргийн талаар нэр дэвшигч ямар бодолтой вэ, ёс зүй, зан төлөвийн хувьд шаардлага хангасан уу, үндсэн хуулийн талаар ямар мэдлэг ойлголттой вэ зэрэг асуудлыг хөндөж бичиж, ярьсан судлаач байгаагүй. Цэцийн гишүүнд нэр дэвшигчийн талаар судлаачид нухацтай хэлэлцдэггүй учраас улс төрчид өөрсдийн хүссэн нэр дэвшигчийг амархан томилдог, дахин томилдог. Үүний нэг илэрхий жишээ бол мэргэжлийн биш эсхүл шаардлага хангаагүй хүмүүс Цэц рүү томилогдох үед хуульчдаас болон судлаачдаас ямар ч шүүмж гардаггүй явдал. Цэцэд ажиллаж байсан мэргэжлийн бус гишүүдээс цөөнгүй нь улиран томилогдож байсан. Хэрэв судлаач, хуульчид Цэцийн гишүүнд тавигдах шаардлага хангаагүй нэр дэвшигчийг хүчтэй шүүмжилдэг бол ийм хүмүүс Цэц рүү томилогдох, дахин томилогдохоос сэргийлэх, ядахдаа тоог нь цөөрүүлэхэд хувь нэмэр оруулна.⁵

Дээрхээс үзвэл, цэцийн гишүүнээр ямар хүнийг нэр дэвшүүлэх, түүнтэй ярилцлага хийх, мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй ил тод байлгах замаар тэдгээрийн болон бусад мэргэжлийн оролцоог хангах журамтай холбоотой зохицуулалтыг нарийвчлах, нийтийн сонсгол зохион байгуулах эрх зүйн орчныг нэмэгдүүлэх агуулгыг хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.6 болон мөн зүйлийн 6.9 дэх заалт илэрхийлж байна. Ингэснээр Цэцийн тухай хуулийн төслийн зорилгод “бүрэлдэхүүн, зохион байгуулалт, хараат бус байдал, цэцийн гишүүний эрх зүйн байдлыг тогтоох” зорилгод нийцэж байна.

5 О. Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь”, *Эрх зүй 36, Дугаар 4 (2016)*: 16-20 дэх тал.

3.1.2. Цэцийн бүрэлдэхүүн зохион байгуулалт, маргааныг хуваарилах тухайд /хуулийн төслийн 9 дүгээр зүйл/

Хүснэгт 5.8. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн тухай

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа цэцийн тухай хуульд цэцийн бүрэлдэхүүн зохион байгуулалттай холбоотой хэм хэмжээ байхгүй. Харин тус хуулийн 6.2-д “гишүүдийн ажил үүргийг хуваарилах” эрхийг цэцийн даргад олгосон.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	<p>9.2.Цэцэд гурван гишүүний бүрэлдэхүүнтэй Бага суудал гурав, зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй Дунд суудал гурав, нийт гишүүний бүрэлдэхүүнтэй Их суудал нэг байна.</p> <p>9.3.Бага, эсхүл Дунд суудлын бүрэлдэхүүнийг жил бүр шинэчилнэ. 9.4.Цэцийн гишүүн Бага суудлын хоёроос илүү бүрэлдэхүүнд нэгэн зэрэг харьяалагдахгүй.</p> <p>9.5.Цэцийн гишүүн Дунд суудлын хоёроос илүү бүрэлдэхүүнд нэгэн зэрэг харьяалагдахгүй.</p> <p>9.6.Бага эсхүл Дунд суудлын бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд бусад бүрэлдэхүүнээс энэ хуулийн 9.7-д заасан журмын дагуу Цэцийн гишүүнийг томилон ажиллуулж болох бөгөөд үүнд энэ хуулийн 9.4, 9.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй.</p> <p>9.7.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага, Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилахдаа урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор сонгох нөхцөлийг хангах бөгөөд холбогдох журмыг Дэгээр зохицуулна.</p>

Цэцийн тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлд цэцэд маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүнд хамаарах эрх зүйн хэм хэмжээг тусгасан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа цэцийн тухай хуульд цэцийн бүрэлдэхүүн зохион байгуулалттай холбоотой хэм хэмжээ байхгүй. Энэхүү харилцаа нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлд хамаарах эрх зүйн харилцаа юм.

Цэцийн тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлээс үзвэл цэцэд маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүнд хамаарах эрх зүйн хэм хэмжээг шинэчлэн зохион байгуулалтын хувьд цэцэд гурван гишүүний бүрэлдэхүүнтэй бага суудал 3, зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй дунд суудал мөн гурав, нийт гишүүний бүрэлдэхүүнтэй Их суудал нэг байхаар тус тус заасан. Мөн хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтаар цэцийн гишүүнийг бага болон дунд суудлын бүрэлдэхүүнд оруулах хязгаарыг тогтоож өгчээ.

Энэхүү цэцийн зохион байгуулалтаас илүүтэйгээр тус төслийн 9.7 дахь заалт чухал ач холбогдолтой. Учир нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цэцийн тухай хуулийн 6.2-д “гишүүдийн ажил үүргийг хуваарилах” эрхийг цэцийн даргад олгосон. Энэ ч утгаараа 1992-2021 оны хооронд цэцийн хянан шийдвэрлэсэн 3451 маргаан нь цэцийн даргаас бүрэн хамааралтай байж ирсэн бөгөөд тухайн маргааныг аль гишүүнд хуваарилах эсэхийг зөвхөн цэцийн дарга дангаар шийдвэрлэх эрх хэмжээтэй байж ирсэн.

Түүнчлэн, Үндсэн хуулийн цэцээс бусад эрүү, иргэн, захиргааны шүүхийн хувьд шинэчлэлийн явцад дээрх зохицуулалтыг халж, хэргийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор сонгох нөхцөлийг ханган ажиллаж байна. Тодруулбал, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53 дугаар

зүйлийн 53.2-д “Хэрэг, нэхэмжлэлийг шүүгчид хуваарилах журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс батална”⁶, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.4-д “гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс урьдчилан тогтоосон журмын дагуу шүүгчид хуваарилах бөгөөд уг журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байна”⁷ гэжээ. Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19.3-т “хуваарилагдах шүүгчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд дараах шаардлага хангасан программ хангамжийг ашиглана” гэж тус тус хуульчилсан.⁸

Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн шүүх болохын тулд тухайд шүүхэд ирсэн маргааныг цэцийн дарга шийдэх бус хэргийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг бий болгох зайлшгүй шаардлагатай юм.

Судлаачдын хувьд шүүхэд хэрэг хуваарилах журам нь ил тод, үндэслэлтэй, хуваарилагчийн үзэмжээс хамааралгүй байх нь шийдвэр хууль ёсны байх нэгэн баталгаа болдог тул үндсэн хуулийн хууль ёсны хяналтад энэ асуудал чухал байр суурь эзэлнэ гэж үздэг. Монгол Улсын хувьд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн дарга гишүүнд хуваарилдаг. Ийнхүү хуваарилахдаа Цэцийн гишүүний мэргэшсэн чиглэл, ажлын ачааллыг харгалзан хуваарилж байгаа хэдий ч субьектив хүчин зүйлийн нөлөөлөл орж болохыг үгүйсгэхгүй. Тиймээс өргөдөл, мэдээллийг бусад улс орны жишгээр аль болох тохиолдлын шинжээр, тойргийн зарчмаар гишүүдэд ялгаваргүй хуваарилдаг байх нь хараат бус байдлын бас нэг баталгаа болно гэсэн саналыг профессор Д.Наранчимэг дэвшүүлсэн байдаг.

Улс орнууд Үндсэн хуулийн шүүхэд ирсэн гомдол, хүсэлт, өргөдлийг хэн, хэрхэн хуваарилах журмыг хуулиар зохицуулсан байхаас гадна нарийвчилсан хэм хэмжээг Үндсэн хуулийн шүүх өөрөө тогтоосон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс ялгаатай нь ГЕРМАН УЛСЫН Үндсэн хуулийн шүүх 2 танхимтай, нийт шүүгчид нь 2 танхимдаа тэнцүү хуваагдан харьяалагдах хэргийг шийдвэрлэдэг тул Германы Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд юуны өмнө тухайн 2 танхим ямар хэргийг харьяалан шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан байдаг.⁹

Зарчмын хувьд Нэгдүгээр танхим нь “үндсэн эрхийн маргааныг” шийдвэрлэдэг бол Хоёрдугаар танхим нь бусад асуудал буюу тэр дундаа голлон “төрийн үйл хэрэгтэй” холбоотой асуудлыг харгалзан шийддэг. Харин танхим дотроо хэргийг шүүгч нарт ямар зарчим баримталж хуваарилах, бүрэлдэхүүн дэх илтгэгч шүүгч, даргалагч шүүгчийг хэрхэн томилох журмыг 8 шүүгчээс бүрдэх танхим нь тухайн жил эхлэхээс өмнө шийдэж төлөвлөдөг байна. Ийнхүү хэрэг хуваарилагдсан шүүгчийг илтгэгч шүүгч гэх бөгөөд эцсийн шийдвэрээ chamber буюу 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр гаргадаг.¹⁰ (Дийлэнх хэрэг нь ийм бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэгддэг)

6 Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2016), 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэг.

7 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2002), 5 дугаар зүйлийн 5.4 дэх зүйл.

8 Монгол Улсын шүүхийн тухай хууль, (2021), 19 дүгээр зүйлийн 19.3 дахь зүйл.

9 ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-3 дахь хэсэг.

10 ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 15а дугаар зүйл.

Томилогдох илтгэгч шүүгч нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд чухал оролцоотой бөгөөд тэрээр хэргийг хууль зүйн талаас нь дүгнэж, шийдвэрийн саналыг тусгасан санал дүгнэлтээ бичгээр боловсруулж шүүгчийн бүрэлдэхүүндээ танилцуулах, хэргийн процессыг хөтөлж удирдах үүрэг хүлээнэ.¹¹

АВСТРИ улсын Үндсэн хуулийн шүүхэд ирүүлсэн хэрэг бүрд бүртгэлийн дугаар олгож Үндсэн хуулийн шүүхийн дарга нь байнгын илтгэгч шүүгчид хуваарилдаг байна. Хуваарилалт хийхэд ямар нэг тодорхой журам үйлчилдэггүй боловч практикт бол эрх зүйн салбарын ангилал, мэргэшсэн эрх зүйн чиглэл, хэргийн ачаалал зэргийг харгалздаг ажээ.¹²

Урьдчилан судлах, хэргийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг хуваарилан хийж буй шүүгч шаардлагатай бичиг баримтыг гаргуулах, шалгалт, судалгаа, експертиз хийхийг даалгах, мэргэжилтнүүдийн зөвлөгөө авах, асуулга явуулах зэрэг бүрэн эрх эдэлдэг. Илтгэгч шүүгч болон даргалагч шүүгч нь шүүхийн хэлэлцүүлэгт оруулах этгээдүүдийг тодорхойлох бүрэн эрхтэй.¹³

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх 6 төрлийн маргааныг шийдвэрлэдэг. Тэдгээрээс зөвхөн иргэний үндсэн эрх зөрчигдсөнтэй холбоотой маргааны талаар хандвал Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хуралдаанд хуваарилж хүсэлтийг хүлээн авахаас татгалзах эсэхийг урьдчилан шалгуулах ёстой ажээ. Шүүх бүрэлдэхүүнд орсон 3 шүүгч шийдвэрээ санал нэгтэй гаргах ёстой ба ийнхүү гаргаж чадаагүй бол шийдвэрлэх эрх их суудал руу шилжинэ.

Харин бусад төрлийн маргааны хувьд ирүүлсэн хүсэлт шаардлага хангасан эсэхийг даргалагч шүүгч аль нэг өөр шүүгчид хариуцуулан шалгуулж болдог байна.¹⁴ Хэрэг хуваарилах талаар үүнээс өөр тодорхой зохицуулалт хуульдаа тусгаагүй байна. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 31-р зүйлийн 2-т “Даргалагч шүүгч шаардлагатай гэж үзвэл нотлох баримтыг шалгаж шинжлэх үүргийг аль нэг шүүгчид хуваарилж болно” гэж заажээ.

ЛАТВИ УЛСЫН Үндсэн хуулийн шүүх 3 төрлийн хуралдаан хийдэг тухай дээр дурдсан билээ. Түүний нэг болох процессын хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлтгэх, илтгэгч шүүгчид хэргийг хуваарилах асуудлыг шийдвэрлэдэг байна.¹⁵

Хэрэг хуваарилахтай холбоотой бусад асуудлыг Үндсэн хуулийн шүүхийн тухай журмаар зохицуулсан байна. Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч нь шүүгч нарын ажлыг тэнцүү хуваарилах ба овгийн үсгийн дарааллыг үндсэндээ баримтална. Гэхдээ зарим нөхцөл байдлаас шалтгаалан өөр журам баримтлан хэргийг шүүгчид хуваарилж болохоор заажээ.¹⁶ Шүүхийн Ерөнхийлөгч хэргийг урьдчилан шалгуулах зорилгоор шүүгчид хуваарилж, хугацаа товлох ба энэ хугацаа нь ажлын 10 өдрөөс

11 Үндсэн хуулийн шүүхийн ажиллагааны журам (Rules of Procedure of the Federal Constitutional Court), 22-р зүйлийн 3 дахь хэсэг.

12 Австри Улсын Үндсэн хууль, (Constitutional law), Холбооц: https://www.vfgh.gv.at/downloads/VfGH_Broschuere_eng_barrierefrei_Final.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

13 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 49-р зүйл.

14 БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 28-р зүйлийн 5 дахь хэсэг.

15 Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 28-р зүйлийн 1 дэх хэсэг.

16 Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай журмын 79-р зүйл.

хэтрэх ёсгүй.¹⁷

Урьдчилан шалгах ажлыг хийсэн шүүгч тайлбар бэлтгэнэ. Ингээд тухайн өргөдлийг хүлээн авахаас татгалзах эсэх шийдвэрийг процессын хуралдаанаар шийдвэрлэдэг байна.

Улс орнууд Үндсэн хуулийн шүүхэд ирсэн гомдол, хүсэлт, өргөдлийг хэн, хэрхэн хуваарилах журмыг хуулиар зохицуулсан байхаас гадна нарийвчилсан хэм хэмжээг Үндсэн хуулийн шүүх өөрөө тогтоосон байна. ХБНГУ, ОХУ, БНСУ, Латвийн үндсэн хуулийн шүүхэд ирсэн хэрэг маргааныг хэрхэн хуваарилахаар зохицуулсныг дараах хүснэгтэд харьцуулан үзүүлэв:

Хүснэгт 5.9. Хэрэг хуваарилалт

Улс	Хэрэг хуваарилахад харгалзах зүйл	Хэрэг хуваарилалт хийх
ХБНГУ	танхим дотроо хэргийг шүүгч нарт ямар зарчим баримталж хуваарилах, бүрэлдэхүүн дэх илтгэгч шүүгч, даргалагч шүүгчийг хэрхэн томилох журмыг 8 шүүгчээс бүрдэх танхим нь тухайн жил эхлэхээс өмнө шийдэж төлөвлөдөг	Жил бүрийн эхэнд хуваарилалтын зарчмаа <u>танхимаараа</u> шийднэ
ОХУ	Урьдчилан судлуулахаар шүүгчид хуваарилахдаа гол шалгуур нь шүүгчдийн ачааллыг харгалздаг. Харин хэргийг хэлэлцүүлэгт бэлтгэх, шийдвэрийн төсөл боловсруулах ажлыг хуваарилахдаа өмнө нь хуваарилсан хэргийн ачаалал, шүүх хуралдааны хуваарь, хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан хуваарилалт хийдэг .	Урьдчилан судлуулах хуваарилалтыг Үндсэн хуулийн шүүхийн <u>дарга</u> хийнэ. Харин хэргийг хэлэлцүүлэгт бэлтгэх, шийдвэрийн төсөл боловсруулах хуваарилалтыг <u>Үндсэн хуулийн шүүх</u> хийнэ.
Солонгос	Хуульдаа заагаагүй	Иргэний үндсэн эрх зөрчигдсөнтэй холбоотой маргааныг урьдчилан шалгах хуваарилалтыг Үндсэн хуулийн шүүхийн <u>Ерөнхийлөгч</u> хийнэ. Бусад төрлийн маргааны урьдчилан шалгах хуваарилалтыг заавал хийх албагүй. Хуваарилалт хийх бол <u>даргалагч шүүгч</u> хийнэ.
Латви	Хуваарилахдаа овгийн үсгийн дарааллыг үндсэндээ баримтална.	Үндсэн хуулийн шүүхийн <u>Ерөнхийлөгч</u> нь шүүгч нарын ажлыг тэнцүү хуваарилах үүрэгтэй. <u>Процессын хуралдаанаар</u> хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлтгэх илтгэгч шүүгчид хэргийг хуваарилах асуудлыг шийдвэрлэдэг.

Иймд цэцийн тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.7-д заасан Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага, Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилахдаа урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор сонгох нөхцөлийг хангах нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 болон Цэцийн тухай хуулийн төсөлд заасан зорилго, зарчим, чиг үүрэгт бүрнээ нийцэж байна.

¹⁷ Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай журмын 81-р зүйл.

3.1.3. Цэцийн зөвлөгөөн ажиллах журмын тухайд /хуулийн төслийн 10 дугаар зүйл/

Хүснэгт 5.10. Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн тухайд

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Цэцийн тухай хуульд цэцийн зөвлөгөөнтэй холбоотой зохицуулалт байхгүй.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	<p>10.1.Цэцийн нийт гишүүнээс бүрдсэн Цэцийн зөвлөгөөн /цаашид “Зөвлөгөөн” гэх/ ажиллана.</p> <p>10.2.Зөвлөгөөнд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад Цэцийн гишүүн орно. Зөвлөгөөнийг долоогоос доошгүй гишүүн хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуульд өөрөөр заагаагүй бол Зөвлөгөөнд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>10.3.Зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ:</p> <p>10.4.Зөвлөгөөн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол гаргана.</p> <p>10.5.Тамгын газар Зөвлөгөөний хуралдааныг тэмдэглэл хөтлөн баримтжуулж, архивын нэгж үүсгэн хадгална.</p> <p>10.6.Энэ хуулийн 10.3-т заасан дэг, хуваарь, дотоод журам нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд тэдгээрийг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Цэцийн цахим хуудсанд байршуулна.</p> <p>10.7.Зөвлөгөөн ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит Зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус Зөвлөгөөнийг Цэцийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй, эсхүл Цэцийн даргын саналаар хуралдуулна.</p> <p>10.8.Цэцийн гишүүн Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай гурваас доошгүй ажлын өдрийн өмнө урьдчилан танилцах, санал гаргах, хуралдаанд оролцох тэгш боломжоор хангагдана..</p> <p>10.10.Зөвлөгөөний ажиллах журмыг Дэгээр зохицуулна.</p>

Цэцийн тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлд цэцийн зөвлөгөөнд хамаарах эрх зүйн орчныг шинээр бий болгосон. Энэ нь цэцийн үйл ажиллагааг төвлөрсөн удирдлага бүхий цэцийн даргаас салгах, цэцийн хамтын удирдлагын зохион байгуулалт руу шилжих чухал ач холбогдолтой.

Учир нь шүүгчдийн зөвлөгөөн нь шүүхийн удирдлагыг зөвхөн шүүгчид хэрэгжүүлэх, хэрэг маргаанд хамаарах асуудлыг шүүгчид хамтын үндсэн дээр шийдвэрлэх хөрс суурь болдог. Энэ ч утгаараа Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчдийн зөвлөгөөнд хамаарах эрх зүйн хэм хэмжээг тусгайлан заасан.

Тодруулбал, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд шүүгчдийн зөвлөгөөн, түүнийг хэлэлцэн шийдвэрлэх асуудал, шүүхийн хуваарилалтыг зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээд шууд өгөх, ээлжит болон ээлжит бус зөвлөгөөн зарлах, зөвлөгөөний хуралдааны дэгийг тогтоох зэрэг асуудлыг хуульчилсан.¹⁸

¹⁸ Монгол Улсын шүүхийн тухай хууль, (2021), 19 дүгээр зүйл.

Мөн эрүү, иргэн, захиргааны процесс хуульд шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасныг нарийвчлан хуульчилсан. Тухайлбал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчдийн зөвлөгөөн нь тогтоосон хэрэг хуваарилах журмын дагуу хуваарилах¹⁹, шүүхийн харьяаллаар тогтоон шилжүүлэх²⁰, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг шүүгчдийг зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу томилох²¹, шүүгчийг татгалзан гарах хүсэлтийг хянан шийдвэрлэх²², хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэх хугацааг сунгах²³ зэргийг шийдвэрлэдэг. Шүүгчдийн зөвлөгөөний шийдвэрлэх асуудал нь Иргэний болон захиргааны процесс ажиллагааны онцлогоос хамааран ялгаатай боловч шүүхэд заавал байх гэдэгтэй маргахгүй.

Иймд Цэцийн тухай хуулийн төслийн 10 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 болон Цэцийн тухай хуулийн төсөлд заасан зорилгод нийцэж байна. Гэхдээ цэцийн хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй, хамгаалалтай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг өргөдөл, гомдол, хүсэлт гаргасан этгээд мэдэгдэх, шууд өгөх зохицуулалтыг нэмэх нь зүйтэй.

3.1.4. Цэцийн гишүүний хариуцлагыг дээшлүүлэх тухайд /хуулийн төслийн 14, 16 дугаар зүйл/

Хүснэгт 5.11. Хуулийн төслийн 14, 16 дугаар зүйлийн тухайд

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гишүүний хариуцлага, түүнийг дээшлүүлэхтэй эрх зүйн хэм хэмжээ ерөнхий зарчмын хүрээнд зохицуулагдсан бөгөөд тусгайлан нарийвчилсан зохицуулалтгүй.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	14.1.Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийг дээдлэх, шударга, хараат бус, зарчимч, бодитой, үндэслэлтэй хандах, тал үл харах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг чанд баримтална. 16.1.Энэ хуулийн 14.2, 14.3, 14.4-т заасан үүрэг, хориглолт, хязгаарлалтыг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн нь Цэцийн гишүүний албан тушаалыг эрхлэхэд тохирохгүйг харуулсан бол тухайн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл /цаашид “Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл” гэх/ болно.

Цэцийн тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлд Цэцийн гишүүний баримтлах зарчим, хүлээх үүрэг, хориглох, хязгаарлах зүйлийг, 15 дугаар зүйлд Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, 16 дугаар зүйлд Цэцийн гишүүнийг эгүүлэн татах эрх хэм хэмжээг тусгасан.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд цэцийн гишүүний хариуцлагын асуудал нийгэмд шүүмжлэл дагуулсан. Энэ хүрээнд Цэцийн дарга Д.Одбаяр, Цэцийн гишүүн Д.Сугар нарыг үйлдлийг дурдаж болно. Тодруулбал, Д.Сугар нь “хөрөнгө, орлогын мэдүүлгээ бичихдээ хайхрамжгүй хандсан, хөрөнгө орлогын өөрчлөлтөө бүрэн гүйцэд мэдүүлээгүй алдаа дутагдал гаргасан” гэдгийг тогтоож түүнд албан

19 Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2.2-г үзнэ үү, (2017).

20 Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2.5-г үзнэ үү, (2017).

21 Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.3.6-г үзнэ үү, (2017).

22 Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4.2-г үзнэ үү, (2017).

23 Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.3.1-г үзнэ үү, (2017).

тушаалын цалин бууруулах шийтгэл оногдуулсан.²⁴ Энэхүү тушаал нь Цэцийн гишүүнд хариуцлага тооцсон анхны албан ёсны шийдвэр юм. Авлигатай тэмцэх газраас УИХ болон Үндсэн хуулийн цэцэд хүргүүлсэн 01/2676 тоот албан бичигт 2007-2013 оны хооронд Цэцийн гишүүн Д.Сугар 11 ноцтой зөрчлийг удаа дараа гаргажээ.

Уг шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судлаач цэцийн гишүүний хариуцлагын тогтолцоог боловсронгуй болох тухайд Цэцийн гишүүнд сахилгын шийтгэл хүлээлгэх талаар Цэцийн хуульд хангалттай зохицуулалт байхгүйгээс Д.Сугарын гаргасан гэх зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой тодорхойгүй байдал бий болж, улмаар Үндсэн хуулийн суурь зарчмуудыг зөрчиж шийдвэрлэхэд хүрч байна. Тиймээс, Үндсэн хуулийнхаа зарчим болон харьцуулсан үндсэн хуулийн эрх зүйн судалгааны үр дүнд тулгуурлан Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх тогтолцоог оновчтой тодорхойлох шаардлагатай байна гэжээ.²⁵ Үүнд:

А. Цэцийн гишүүн Авлигын эсрэг хууль эсхүл Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль зөрчсөн, ёс зүйн зөрчил гаргасан эсхүл Цэцийн гишүүний үүргээ биелүүлэхгүй бол (1) хаалттай сануулах, (2) нээлттэй сануулах, (3) албан тушаалын цалингийн хэмжээг нэг жил хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, (4) эгүүлэн татах. Эдгээр шийтгэл оногдуулсан нь эрүүгийн эсхүл иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэхээс бус, тухайн Цэцийн гишүүнийг чөлөөлөх үндэслэл болохгүй. Энэхүү агуулгын эхний хэсгийг Цэцийн тухай хуулийн төслийн 14.3 дахь хэсэгт тусгасан бөгөөд цэцийн гишүүний үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээний тухайд хуулийн төсөлд тусгаагүй.

Б. Цэцийн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах ажиллагаа нь зөрчил гаргасан Цэцийн гишүүнд хариуцлага тооцох боломжтой байх төдийгүй Цэцийн гишүүний хараат бус байдалд халдах эрсдэл бий болгож болохгүй. Цэцийн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах эсэхийг тухайн буруутгагдаж буй гишүүнийг оролцуулахгүйгээр Цэц бүрэн бүрэлдэхүүнээрээ (зөвлөгөөнөөрөө) шийдвэрлэх хэрэгтэй. Сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дараах үе шаттайгаар явагдахаар Цэцийн хуульд шинээр зааж болно. Цэцийн гишүүн нь сахилгын шийтгэл хүлээх зөрчил гаргасан талаарх гомдол, мэдээллийг Цэц хүлээн авах бөгөөд Цэцийн дарга эсхүл Цэцийн гурваас доошгүй гишүүн санал нэгдвэл тухайн гишүүний эсрэг сахилгын хэрэг үүсгэнэ. Сахилгын хэрэг үүсгэсний дараа Цэцийн аль нэг гишүүнд уг хэргийг хуваарилах бөгөөд гишүүн нотлох баримт цуглуулах ажиллагаа явуулна. Нотлох баримт бүрэн цугларч дууссаны дараа Цэцийн зөвлөгөө нь зөрчил гаргасан эсэхийг тогтоох, сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг шийдвэрлэх бөгөөд Цэцийн дөрөв эсхүл түүнээс доошгүй гишүүн санал нэгдсэнээр сахилгын шийтгэл оногдуулна. Ноцтой зөрчил гаргасан Цэцийн гишүүнд эгүүлэн татах шийтгэл оногдуулсан тохиолдолд Цэц уг шийдвэрээ УИХ-д хүргүүлэх ба Цэц эгүүлэн татахаас бусад шийтгэлийг өөрөө оногдуулж эцсийн шийдвэр гаргана. Энэхүү агуулгыг хуулийн төслийн 10.3.4, 15.2, 15.3-д дахь хэсэгт тусгасан.

В. Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг дараах байдлаар Цэцийн хуульд нарийвчилсан зохицуулах нь Цэцийн гишүүний хараат бус байдлын нэгэн баталгаа болно. Цэцийн гишүүнийг гэмт хэрэгт холбогдуулан

24 О.Мөнхсайхан, "Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудалд хийсэн дүн шинжилгээ", (2016), 8 дахь тал, Холбоос: <https://legaldata.mn/b/725#!>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

25 Мөн тэнд

мөрдөн шалгахад бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх шаардлагатай бол Улсын ерөнхий прокурор энэ тухай саналаа Цэцэд ирүүлнэ. Энэ агуулгыг хуулийн төслийн 15.1 дэх хэсэгт тусгажээ.

Г. Цэцийн зөвлөгөөн энэ саналыг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Тухайн гишүүнийг гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон эсхүл тухайн хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл түүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ. Уг агуулгыг хуулийн төслийн 15.2-д ажлын арван өдөр болгон хугацааг уртасгаж тусгасан.

Д. Цэцийн гишүүний эсрэг сахилгын хэрэг үүсгэсэн бол Цэцийн зөвлөгөөн тухайн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх хүртэл түүний бүрэн эрхийг түдгэлзүүлж болох бөгөөд ийнхүү түдгэлзүүлэх хугацаа нь нэг сараас илүүгүй байна. Энэхүү агуулгыг хуулийн төслийн 15.5-д заасан бөгөөд хугацааны хувьд эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр гаргах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэхээр заажээ.

Е. Цэцийн зөвлөгөөний бүрэлдэхүүнд бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх хэлэлцэгдэж байгаа Цэцийн гишүүн орохгүй бөгөөд Цэцийн зөвлөгөөн Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх шийдвэрийг нууцаар санал хураан, дөрөв эсхүл түүнээс дээш тооны гишүүн санал нэгдсэнээр гаргана.²⁶ Уг агуулгыг хуулийн төслийн 15.2-д нууц санал хураалтаар шийдвэрлэх тус тус заасан.

Дээрхээс үзвэл цэцийн гишүүний хариуцлагыг дээшлүүлэх эрх зүйн хэм хэмжээ нь цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх тогтолцоог оновчтой тодорхой болгох зорилгод нийцсэн байна.

3.1.5. Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгааны тухайд /хуулийн төслийн 19 дүгээр зүйл/

Хүснэгт 5.12. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн тухай

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл заалт байгаа	5 дугаар зүйл. Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл заалт	19 дүгээр зүйл. Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгаа

Хүчин төгөлдөр үйлчилж буй Цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаанд 6 зүйлийг хамруулан үздэг²⁷ байсныг Цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд 9 болгон нэмэгдүүлсэн. Өөрөөр хэлбэл цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгаа нэмэгдэхийн хэрээр цэцийн гишүүний хараат бус, бие даасан байдал нэмэгдэх ач холбогдолтой.

26 О.Мөнхсайхан, “Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудалд хийсэн дүн шинжилгээ”, (2016), 20-21 дэх тал, Холбоос: <https://legaldata.mn/b/725#!>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

27 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992), 5 дугаар зүйл.

Хүснэгт 5.13. МУ-ын ҮХЦ-ийн бүрэн эрхийн баталгаа

<p>Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй Цэцийн тухай хуульд заасан эдийн засаг, нийгмийн баталгаа</p>	<p>Хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд баривчлах саатуулах, цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татахыг хориглоно.</p> <p>Шүүхийн журмаар түүнд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хориглоно.</p> <p>Цэцийн гишүүнийг хувийн хүсэлтээ гаргасан, эрүүл мэндийн улмаас, эсхүл Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусахаас нь өмнө уг албан тушаалаас чөлөөлөх, эгүүлэн татах, өөр ажилд шилжүүлэхийг хориглоно.</p> <p>Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан болон Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрснээс бусад үндэслэлээр Цэцийн гишүүнээс чөлөөлөгдвөл гишүүнээр томилогдохын өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах, эсхүл түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар хангана. Хэрэв тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэлх 6 сарын хугацаанд Цэцийн гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс бууруулахгүйгээр тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байгаа бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж улсын төсвөөс мөн хугацаанд олгоно.</p> <p>Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно. Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно.</p>
<p>Өөрчлөлтийн төсөлд заасан эдийн засаг, нийгмийн баталгаа</p>	<p>Цэцийн гишүүний албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байна.</p> <p>Цэцийн гишүүний цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.</p> <p>Цэцийн төсвийг батлахдаа гишүүний цалин хөлсний хэмжээг өмнөх жилийнхээс бууруулж болохгүй.</p> <p>Цэцийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг Цэцийн төсвөөс санхүүжүүлнэ.</p> <p>Бүрэн эрхийн хугацаа дуусаж дараагийн гишүүн томилогдсон үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол Цэцийн гишүүнд сүүлийн нэг жилийн албан тушаалын цалингийн дундаж хэмжээгээр тооцон 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж эсхүл тэтгэвэрт гарсан бол холбогдох хуульд заасан тэтгэмжийг улсын төсвөөс олгоно.</p> <p>Бүрэн эрхийн хугацаа дуусаж дараагийн гишүүн томилогдсон үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол гишүүнээр томилогдохын өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах үүргийг тухайн байгууллага, ажил олгогч хүлээх бөгөөд ийм боломжгүй тохиолдолд түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар төр хангана. Тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэлх гурван жилийн хугацаанд Цэцийн гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс бууруулахгүйгээр тэтгэмжийг сар бүр олгоно. Бага цалинтай ажил эрхэлж байгаа бол өндөр насны тэтгэвэрт гарах хүртэл цалингийн зөрүүг улсын төсвөөс сар бүр олгоно.</p> <p>Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний өндөр насны тэтгэврийг Цэцийн гишүүний албан тушаалын цалингийн 60-аас доошгүй хувиар бодож тогтооно.</p> <p>Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хангагдах 3 төрлийн баталгааг заасан.</p>

	<p>Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдсан тохиолдолд 60 сарын, өвчний улмаас нас барсан бол 36 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж ар гэрт нь олгоно.</p> <p>Цэцийн гишүүний бүрэн эрх нь дуусгавар болсон иргэний амь насанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан хохирол учруулсан бол буцалтгүй тусламжийг түүний ар гэрт мөн адил олгоно.</p>
--	---

Дээрх хүснэгтээс үзвэл, Цэцийн тухай хуулийн төслийн Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгаанд хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Цэцийн тухай хуулийн Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааны эрх зүйн хэм хэмжээнд дараах өөрчлөлтийг оруулжээ. Үүнд;

- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 5.1, 5.3, 5.4 дэх заалтыг хассан.
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 5.5 дахь заалтын 6 сар байсныг өөрчлөн 3 жил болгожээ.
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 5.6 дахь заалтыг хэвээр үлдээсэн байна.

Түүнчлэн Цэцийн тухай хуулийн төслийн Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгаанд хамаарах 19 дүгээр зүйлээр дараах асуудлыг шинээр нэмсэн. Үүнд:

- Цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бусаар ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх;
- Цэцийн цалин хөлсний үндсэн бүтэц, нэмэгдэл;
- Төсвийг батлахдаа цалин хөлсний хэмжээг өмнөх жилээс бууруулахгүй;
- Бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг Цэцийн төсвөөс санхүүжүүлэх;
- 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгох;
- Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэж үедээ эрүүл мэнд хохирсон бол 3 төрлийн баталгаа эдлэх;
- Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэж үедээ амь насаа алдсан тохиолдолд 60 сар, өвчний улмаас нас барсан бол 36 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж ар гэрт нь олгох зэргийг шинээр нарийвчлан тусгасан.

Эдгээр нь “цэцийн хараат бус, бие даасан байдлын баталгаа, Цэцийн гишүүний эрх зүйн байдлыг тогтоох” буюу хуулийн зорилгод нийцэж байна.

3.1.6. Цэцийн үйл ажиллагааны баталгаа, цэцийн төсөв санхүүгийн бие даасан байдлын тухайд /хуулийн төслийн 20, 21 дүгээр зүйл/

Хүснэгт 5.14. Хуулийн төслийн 20,21 дүгээр зүйлийн тухай

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт байгаа	Өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд цэцийн төсөв санхүүгийн бие даасан байдлыг нарийвчлан тусгаагүй.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	20.1.Цэц аливаа байгууллага, албан тушаалтнаас бие даасан байж, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлөөр хангагдана. 20.2.Аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн Цэцийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно. 21 дүгээр зүйл. Цэцийн төсөв, санхүүгийн бие даасан байдал.

Үндсэн хуулийн Цэц хараат бус байна гэдэг бол Үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд гаднын ямар нэг байгууллага, албан тушаалтан бусад хүмүүст захирагдахгүйгээр барахгүй Үндсэн хуулийн цэц өөрийн зохион байгуулалт үйл ажиллагааныхаа хувьд ч бусдаас хараат бус байхыг хэлдэг. Цэц тодорхой маргааныг хянан үзэж, дүгнэлт гаргах буюу магадлан шийдвэрлэхдээ хөндлөнгийн ямар ч байгууллага, албан тушаалтны шахалт, дарамт, заавар хөдөлгөөнийг авах ёсгүй. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн элдэв сенсацад ч автагдах учиргүй. Цэц үйл ажиллагаагаа явуулах биеэ даасан төсөвтэй, түүнийг захиран зарцуулах, батлагдсан төсвийн хэмжээнд багтааж аппаратын орон тоогоо өөрсдөө тогтоох эрхтэй.²⁸ Үндсэн хуулийн цэцийн гишүүд бие даасан хараат бусаар шийдвэр гаргахад тэдгээрийн эдийн засаг, нийгмийн байдал чухал үүрэгтэй байдаг.

Үндсэн хуулийн хяналт буюу үндсэн хуулийн шүүхийн хяналтын ихэнх байгууллага нь улсын төсвөөс ангид бие даасан төсөвтэй, бөгөөд үүнийгээ захиран зарцуулахдаа ч бие даасан эрхтэй байдаг. ОХУ, Литва, Беларусь зэрэг улсад сүүлд бий болсон Үндсэн хуулийн шүүх нь өмнө байгуулагдсан шүүхүүдтэй харьцуулахад санхүүгийн асуудлаа илүү нарийвчлан зохицуулсан.²⁹

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуульд энэ тухай нарийвчлан тусгаагүй нь учир дутагдалтай. Бусад орны Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлын талаар авч үзвэл:

Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай шүүх зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хувьд аливаа бусад байгууллагаас хараат бус байхаар Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд заажээ. Үндсэн хуулийн шүүх холбооны улсын төсвөөс санхүүжиж, санхүүжилт нь үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг бие даан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Жил бүрийн төсөвт Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хангах эх үүсвэрийг бие даасан зүйл болгон тусгах бөгөөд үүнийгээ Үндсэн хуулийн шүүх бие даан зарцуулна. Мөн төсвийг өмнөх жилийнхээс буруулж болохгүй заалттай. Үндсэн хуулийн шүүх нь мэдээлэл, хүний нөөцийн асуудлаа бие даан шийдвэрлэх

28 Г.Совд. *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*. (УБ, 2000), 250 дах тал.

29 Арне Мавичи, *Үндсэн хуулийн хяналт*, (УБ, 2014), 31 дэх тал.

бүрэн эрхтэйг мөн хуульчилсан байна. Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд заасан Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны эрх зүй, зохион байгуулалт, санхүү, мэдээлэл, материал-техник, хүний нөөцийн зэрэг нөхцөлийг хязгаарлахыг хоригложээ.

Солонгос улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн Арван нэгдүгээр зүйлд “Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны зардлыг улсын төсөвт бие даан тусгана” гэсний зэрэгцээ нөөц хөрөнгийг энэхүү зардалд багтаасан байхаар мөн хуульд заасан байна. Түүнчлэн төсөв боловсруулах, зардал, нөөц хөрөнгийн асуудлыг Үндсэн хуулийн шүүхийн нийт шүүгчдийн зөвлөлөөр шийдвэрлэхээр заажээ.

Латви улсын Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдал нь бие даасан төсөвтэй байх, зохион байгуулалт, материал-техникийн асуудлаа өөрөө бие даан шийдвэрлэхэд оршиж байна. Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн тавдугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн эрх чөлөө, бие даасан байдал нь хуульд заасан санхүү, материал-техник, зохион байгуулалтын баталгаагаар хангагдана. Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн хяналтын чиг үүргээ бие даан, зохих байдлаар хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжнэ. Үндсэн хуулийн шүүх нь зардлын тооцооллоо өөрөө батлах бөгөөд хуваарилагдсан эх үүсвэрийг бие даан зарцуулна. Түүнчлэн Үндсэн хуулийн шүүх нь мэдээллийн болон зохион байгуулалтын ханган нийлүүлэлтийг чөлөөтэй, бие дааж хэрэгжүүлнэ гэж тусгажээ. Латви улсад Үндсэн хуулийн шүүх нь зардлын тооцооллыг өөрөө батлах бүрэн эрх олгогдсон нь онцлог байна.³⁰

Үүнээс үзэхэд бусад орнууд Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлыг Цэцийн тухай хуулиараа тодорхой тусгасан байна. Манай улсын хувьд эдийн засаг, нийгмийн байдлыг нь тусгайлан Цэцийн тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйлд тусгажээ.

Ингэхдээ цэц бие даасан төсөвтэй байх бөгөөд төсөв нь үйл ажиллагаа явуулахад хангалттай хүрэлцэхүйц байх, цэцийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглох эрх зүйн зохицуулалт нь Цэцийн тухай хуулийн зорилгод нийцсэн. Харин Цэцийн тухай хуулийн төслийн 21.2-т Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалин хөлсний хэмжээг Цэцийн даргын санал болгосноор гэж заасан. Уг хуулийн төслөөр цэцийн зөвлөгөөний эрх зүйн орчныг шинээр бий болгосон. Иймд Цэцийн дарга бус Цэцийн зөвлөгөөн нь Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалин хөлсний хэмжээг Улсын Их Хуралд санал болгох нь зүйтэй.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих эсэхийг үнэлнэ. Энэхүү хүрээнд хуулийн төслийн 3, 5, 6, 7, 12, 17 дугаар зүйлд тус тус заасан зохицуулалтад баримтын судалгааны аргад тулгуурлан дүн шинжилгээ хийлээ.

³⁰ Н.Номинчимэг, *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа*, (2019), 57 дахь тал.

3.2.1. Маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх дүгнэлт гаргаж, дахин хянаж үзэж эцсийн шийдвэр гаргах үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх тухайд /хуулийн төслийн 3 дугаар зүйл/

Хүснэгт 5.15. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн тухайд

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл заалт байгаа	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цэцийн тухай хуульд цэц үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ байхгүй.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл заалт	3.2.5.үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлд Үндсэн хуулийн цэц, түүний бүрэн эрхийг заасан. Тодруулбал, тус хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2.5-д “Үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх”-ээр тусгажээ. Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн биелэлтэд хууль-шүүхийн дээд хяналт тавьж, түүнийг зөрчсөн тухай маргааныг хянаад хууль хэрэглэж эцэслэн шийдвэр гаргадаг Үндсэн хуульд заасан мэргэжлийн бүрэлдэхүүнтэй шүүх юм.³¹ Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих бөгөөд төлөөлөн удирдах болон хүний эрхийг хамгаалах тогтолцооны хэлбэр юм.³² Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” хэмээн заасан байдаг. Үндсэн хуулийн дээрх зохицуулалт нь Цэцийн чиг үүргийг “Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих” гэж тогтоож, уг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ 1/ дүгнэлт гаргах, 2/ маргааныг магадлан шийдвэрлэх гэсэн хоёр арга замаар хэрэгжүүлнэ гэдгийг тодорхойлсон.³³ Энэхүү Үндсэн хуулийн хяналт нь хууль тогтоомж, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах зорилготой.³⁴

Үндсэн хуулийн хяналтын хувьд:

Үндсэн хуулийн шүүхийн хяналт нь хууль тогтоомж, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа нь Үндсэн хуульд нийцэж буй талаар хянахыг зорьдог. Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг хийсвэр хяналт, тодорхой хяналт гэх мэтээр ангилдаг.

Хийсвэр хяналт: Амьдралын тодорхой нэг зөрчил буюу маргаанаас ангид байдлаар эрх бүхий субъектүүдийн хүсэлтээр хэрэгждэг хэм хэмжээний хяналтын хэлбэр. Энэ нь байнга хэрэгждэг бөгөөд Үндсэн хуулийн төрөлжсөн байгууллагад эрх бүхий субъектээс хүсэлт ирүүлснээр үүсдэг тул ямар нэг тодорхой хэрэг, маргаан эсхүл үндэслэлийг шаарддаггүй³⁵

Тодорхой хяналт: Ердийн болон дагнасан шүүхээс өөрийн харьяаллын хэрэг, маргааныг шийдвэрлэх явцад хэрэглэж буй хуулиа үндсэн хууль зөрчиж байна гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд хандах хэм хэмжээний хяналтын хэлбэр. Өөрөөр

31 Б.Чимид, *Үндсэн хуулийн мэдлэг*, (УБ, 2008), 400 дахь тал.
 32 성낙인, *헌법학, 법문사*, (2021), 767 면.
 33 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, (Адмон принт, 2023), 955 дахь тал.
 34 Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, (МУИС пресс, 2016), 138 дахь тал.
 35 Ч.Энхбаатар, *Үндсэн хуулийн эрх зүй*, (УБ, 2007), 280 дахь тал.

хэлбэл зөвхөн эрх зүйн тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх үед хэрэгждэг. Энэ загвар нь Үндсэн хуулийн биелэлтэд шүүхээс хяналт тавьдаг тогтолцоотой оронд байдаг³⁶

Урьдчилсан хяналт: Эрх зүйн актыг хүчин төгөлдөр болохоос нь өмнө хянах хэм хэмжээний хяналтын хэлбэр юм.

Негатив хяналт: Тодорхой асуудлаар хууль гаргахаар Үндсэн хуульд заасан атал хууль тогтоогчоос тэрхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд хэрэгждэг хэм хэмжээний хяналтын хэлбэр юм³⁷. Хэм хэмжээний тодорхой хяналтын хувьд хэрэг, маргааныг шийдвэрлэх явцад Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг тул хүний субьектив эрхийг буюу үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэдэг байна.

Цэц субьектив үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхгүй. Цэц хийсвэр хяналтыг хэрэгжүүлдэг тул иргэн Үндсэн хуульд заасан үндсэн эрхээ сэргээлгэхээр Цэцэд өргөдөл гаргах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, иргэн Цэцэд өөрт шууд хамааралгүй асуудлаар, тухайлбал аль нэг эрх зүйн акт Үндсэн хууль зөрчиж байгаа эсхүл хуульд заасан хэн нэг албан тушаалтан Үндсэн хууль зөрчиж байгаа эсэх асуудлаар хандах боломжтой бөгөөд иргэн Үндсэн хуульд заасан цөөн тооны объектоор Цэцэд хандах эрхтэй байдаг.³⁸ Иймээс Цэц үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаарх өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх чиг үүрэг, бүрэн эрхгүй байх тул хүний эрхийн гол зөрчил шийдвэрлэгдэхгүй байна.³⁹ Цэц нь 1992-2020 оны хооронд 296 маргааныг хянан шийдвэрлэсний дотор дийлэнх хувьд нь Үндсэн хуулийн зөрчлийг тогтоосон, мөн тэдгээрийн дийлэнх нь үндсэн эрх, эрх чөлөө, төрийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг гаргасан байна. Үндсэн хуулийн шүүхийн гол чиг үүрэг бол Үндсэн хуулийг, ялангуяа үндсэн эрхийг хамгаалах байдаг. Гэвч Цэцээс тухайн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлж чадахгүй байгаа шалтгаан нь үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаарх Цэц хянан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүй, Цэцээс ихэнх шийдвэртээ хангалттай сайн үндэслэгээ хийж Үндсэн хуулийг тайлбарладаггүй, Цэцийн хараат бус, бие даасан байдал хангагдаагүйтэй холбоотой талаар эрдэмтэд дурдсан байдаг.

Монгол Улсад үүсэж буй хүний эрхийн зөрчил нь хийсвэр байдлаар бус, харин шүүх, төрийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны явцад гарах нь нийтлэг байна. Тухайлбал, Шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцдаа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын нэмэлт II протоколыг хэрэглэлгүйгээр цаазаар авах ял оногдуулж хүний амьд явах эрх зөрчигдсөн; эрүү шүүлтийн хохирогч болж өөрт учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зөрчигдсөн; Эрүүгийн хуульд үзэн ядалтаас үүссэн гэмт хэргийг хуульчлаагүйн улмаас энэ гэмт хэргийн хохирогч болж тэгш эрх нь зөрчигдсөн; Иргэдийн төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх)-ын тогтоолоор шударга нөхөх олговоргүйгээр хувийн өмчийг дайчлан авсан; Засаг даргын захирамж болон шүүхийн шийдвэрээр хүний үндсэн эрх болох үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй

36 Мөн тэнд.

37 “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”, “Үндсэн хуулийн процессын эрх зүй” оюутны гарын авлага, ХЗДХЯ, Дэлхийн банк, (УБ, 2011), 11-12 дахь тал.

38 Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” Эрдэм шинжилгээний нийтлэл, (УБ, 2002), Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

39 О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, (УБ, 2021), 479 дэх тал.

илэрхийлэх эрх зөрчигдсөн тохиолдолд Цэцэд хандах боломжгүй байна. Цэцээс УДШ-ийн болон ИТХ-ийн шийдвэр нь хүний эрх зөрчигдсөн гэдгийг тогтоосон боловч, хүчингүй болгохоос татгалзаж байсан бөгөөд ийм төрлийн маргааныг хүлээн авдаггүй.⁴⁰ Иймээс иргэний өргөдөл, мэдээллийг илүү өргөн хүрээтэй тодорхойлох шаардлагатай байна.

Гаднын зарим орны туршлагыг харвал, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээдийн үйлдэл, эс үйлдлээр зөрчигдсөн эрх, шүүхийн шийдвэрээр үндсэн эрх сэргээгдээгүй тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гарган шийдвэрлүүлэх эрхтэй байдаг. Энэ жишгийг нутагшуулбал, Цэц иргэний өргөдлөөр үүсгэсэн үндсэн эрхийн маргааныг эцэслэн шийдвэрлэх боломжтой болох бөгөөд тухайн шийдвэрийг УИХ батламжлах шаардлагагүй болно.

Цэц иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхдээ дараах зарчмыг баримталдаг.⁴¹ Үүнд:

Нэг. Цэцээс хууль тогтоомж болон бусад холбогдох шийдвэрт абстракт хяналт хэрэгжүүлдэг боловч, ердийн шүүхийн шийдвэрт Үндсэн хууль зөрчигдсэн эсэх асуудлыг шийдвэрлэдэггүй. Мөн, төрийн өндөр албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянадаг. Зөвхөн эрх бүхий этгээд төдийгүй иргэн цэцийн харьяаллын аль ч асуудлаар мэдээлэл гаргах эрхтэй (*actio popularis*). Хууль тогтоомж болон ҮХЦТХ-д заасан бусад шийдвэрээр үндсэн эрхээ зөрчигдсэн гэж үзвэл иргэн Цэцэд өргөдөл гаргах боломжтой. Гэвч, иргэн шүүхийн шийдвэрээр үндсэн эрх нь зөрчигдсэн эсхүл хамгаалагдаж чадаагүй гэж үзвэл энэ асуудлаар Цэцэд хандах боломжгүй. Тодорхой тохиолдолд зөрчигдсэн үндсэн эрхийн маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй байгаа нь Монгол Улс дахь хүний эрхийн хамгаалалт сул буйн шалтгаан болж байна.

Хоёр. Үзэл баримтлалын хувьд иргэний өргөдөл нь Европын Үндсэн хуулийн шүүхэд байдаг Үндсэн хуулийн гомдолтой адилхан агуулгаар хэрэгжих нь зохимжтой. Энэ үзэл баримтлал бол нэг дэх үзэл баримтлалтай өрсөлдөхүйц төдийгүй Цэцийн үндсэн эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх, Үндсэн хуулийн нэр томьёо, логикт илүү тохирох, Үндсэн хуулийг боловсруулж баталсан түүхээр дэмжигдэж болохуйц, олон улсын сайн туршлагад нийцнэ. Иргэний өргөдлийг Үндсэн хуулийн гомдлоор тодорхойлж, түүнд хүсэлттэй адилхан дүгнэлт гаргах, уг дүгнэлтийг УИХ-аар дахин хянуулах хоёр шатлалтай процедураар шийдвэрлэж болохгүй. Өөрөөр хэлбэл, Цэц өргөдлөөр үүсгэсэн маргааныг нэг удаа эцэслэн шийдвэрлэж, уг шийдвэрээ УИХ-аар явуулахгүй байхаар хуульчлах нь оновчтой хэмээн үзсэн. Мөн иргэний мэдээлэл гэдгийг үндсэн хуулийн маргааныг үүсгэх үндэслэл гэж үзэхгүй харин *amicus curiae* гэсэн агуулгаар ойлгож, нэгэнт үүсгэсэн маргааныг зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой үндэслэл, судалгааг маргааны тал биш иргэнээс авах суваг болгох нь илүү зохистой. Иргэний өргөдөл, мэдээллийн талаар хоёр дахь үзэл баримтлалын дагуу Цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчилбэл Монгол Улс дахь үндсэн эрхийн зөрчил Үндсэн хуулийн болон олон улсын стандартын дагуу шийдвэрлэгдэх боломжтой болно.⁴²

40 Мөн тэнд

41 О. Мөнхсайхан, "Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж", "Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015), 68-80 дахь талыг товчлон оруулав.

42 Мөн тэнд, 64-81 дэх тал.

Иймд Үндсэн хуульд зааснаар Цэцэд иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг хүлээн авч шийдвэрлэх боломжийг нээж, Цэцийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхийг баталгаажуулан, иргэн субъектив үндсэн эрхээ хамгаалуулах Үндсэн хуулийн механизмыг бий болгох шаардлагатай байна.

Цэц нь иргэний үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэснээр Үндсэн хуульд ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг хангах юм. Түүнчлэн хүний субъектив үндсэн эрхийг Цэц хамгаалах явдал нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болно. Энэ нь үндсэн хуулийн шүүхийн хяналтад харьяалагдах субъектийн үйл ажиллагаанд Үндсэн хуулийн заалт нэг бүрийг хэрэгжүүлэхийг шаардах, зөрчил гаргасан тохиолдолд арилгуулах чиг үүрэг гүйцэтгэх явдал юм.⁴³ Тодруулбал, Цэцээс Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх нь Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих улмаар хүний эрхийг хамгаалах хэрэгсэл болно. Зарчмын хувьд иргэний өргөдөл, мэдээлэл нь Үндсэн хуульд заасан субъектив үндсэн эрх хэрэгжих баталгаа байх ёстой.

Гадны зарим орны жишээг харвал, иргэн нь үндсэн эрхээ нийтийн эрх зүйн аливаа субъектийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байдаг. Гэхдээ иргэн, хуулийн этгээд нь Үндсэн хуулийн шүүхэд хандахын өмнө тухайн маргааныг хуульд заасан бусад бүх шүүхийн шат дамжлагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг урьдчилан авсны дараа Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой болдог. Үндсэн эрх нь иргэн өөрт нь хамааралтай байдлаар зөрчигдсөн тохиолдолд л тухайн иргэн Үндсэн хуулийн шүүхэд ханддаг нийтлэг зарчим үйлчилдэг.⁴⁴

Өөрөөр хэлбэл, иргэн зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр Цэцэд шууд хандах боломжийг олгохдоо Цэцийн ачаалал, хэрэг маргаан шийдвэрлэлтийн чанарын асуудлыг анхаарах нь зүйтэй бөгөөд өргөдөл, мэдээлэл гаргах тодорхой “босго”-г тогтоох ёстой. Дээрх үндэслэлд тулгуурлан тандан судалгааны энэхүү хэсэгт “Цэцээс иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхийг Үндсэн хуулиар баталгаажуулах” зохицуулалт оруулах хувилбарыг санал болгож байна. Ингэхдээ, Цэцийн ачаалал, ердийн шүүхийн хяналтын давхардлаас урьдчилан сэргийлэх үүднээс Цэцэд хандахын өмнө гурван шатны шүүхийн урьдчилсан хяналтыг хэрэгжүүлсэн байх шаардлагыг тавьж болно.⁴⁵

43 Ч.Энхбаатар, *Үндсэн хуулийн эрх зүй*, (УБ, 2007), 287 дахь тал.

44 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, Хоёр дахь хэвлэл, (УБ, 2021), 119 дэх тал

45 *Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа*, ХЗҮХ, (УБ, 2023), 9-10 дахь тал.

3.2.2. Цэцийн гишүүнд тавих болзол шаардлагын тухайд /хуулийн төслийн 5 дугаар зүйл/

Хүснэгт 5.16. Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн тухай

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	4.1.Цэцийн гишүүн хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн байх ба Цэцийн гишүүд эрх тэгш байна.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	5.1.1 эрх зүйч мэргэжилтэй, 5.1.2 Цэцийн гишүүнээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй. 5.2.Дараах иргэнийг Цэцийн гишүүнээр томилохыг хориглоно: 5.2.1.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн; 5.2.2.сүүлийн дөрвөн жилийн хугацаанд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлсэн; 5.2.3.албан тушаалаас огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн; 5.2.4.сахилгын зөрчил гаргасны улмаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эсхүл өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь хүчингүй болгосон;

Цэцийн тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлд Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг заасан. Тодруулбал тус хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д эрх зүйч мэргэжилтэй байхаар тусгасан.

Цэцийн тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цэцийн гишүүн хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн байх ба Цэцийн гишүүд эрх тэгш байна.” гэж заасан. Практикт хамгийн төөрөгдөл үүсгэж буй зохицуулалт болох цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэх ойлголтыг зөвхөн хуульч эсхүл зөвхөн улс төрч нь цэцийн гишүүнд нэр дэвших боломжтой мэтээр ойлгож байсан. Энэхүү өөрчлөлтийн төслөөр олон эргэлзээг дагуулж байсныг эцэслэн, төөрөгдөл үүсэхээс сэргийлсэн эрх зүйч мэргэжилтэй гэж тодотгосон зохицуулалт оруулсан байна. Мөн цаашдаа Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын мэргэжлийн талаарх ойлголтыг илүү нарийвчлан авч үзэх болно.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн эрх зүйч мэргэжилтэй байх тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Монгол Улсын төрийн түүхэнд урьд нь байгаагүй 1992 оны Үндсэн хуулиар байгуулагдсан шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд ажиллах үүрэгтэйгээр төрийн тогтолцоонд буй болсон цоо шинэ байгууллага юм. Үндсэн хуулийн цэцийг шүүх мөн, биш гэх маргаан нийгэмд хөнддөг. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны шалгуурыг авч үзвэл:

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд хууль-шүүхийн дээд хяналт тавьдаг; энэ үүргээ байцаан шийтгэх ажиллагааны зарчим, журам, арга явцаар хэрэгжүүлдэг; Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянаад хууль хэрэглэж эцэслэн шийдвэр гаргадаг; шийдвэр гармагц Үндсэн хуулийн ёсоор хүчин төгөлдөр болдог; түүнийг холбодог байгууллага, албан тушаалтан хэн боловч заавал биелүүлнэ; ҮХЦ, түүний гишүүн нь гагцхүү Үндсэн хуульд захирагдах, аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байх Үндсэн хуулийн зарчим баримтална. Эдгээр шалгуур нь ҮХЦ шүүх мөн болохыг нотолдог. Үүнээс харахад Үндсэн хуулийн цэц нь шүүх учир Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь шүүгчийн хэмжээнд байх ёстой.

Үндсэн хууль тогтоогчид Цэцэд хэн нэр дэвшиж болох вэ гэдэг дээр өргөн болон явцуу хоёр янзын үзэл баримтлалыг барьж байсан. Өргөн үзэл баримтлалын дагуу хуульч, улс төрч, дипломат, улс төр судлаач, эдийн засагч зэрэг өөр өөр мэргэжлийн хүмүүс Цэцэд нэр дэвших боломжтой гэж үзэж байсан. Үндсэн хуулийн маргаан бол эрүүгийн хууль зөрчсөнтэй адилхан маргаан биш, "... Үндсэн хууль гэдэг маань нийгмийн бүх амьдралыг хамарсан өргөн хүрээний асуудал шийддэг учраас хуульчаас гадна улс төрч, эдийн засагч байх шаардлага гарч болно." гэж үзсэн. Үндсэн хууль тогтоогчдын зарим нь энэхүү өргөн үзэл баримтлалыг няцааж, зөвхөн хуульчид Цэцэд нэр дэвших эрхтэй байх ёстой гэсэн явцуу үзэл баримтлалыг дэмжиж удаан хэлэлцсэний эцэст Цэцийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлагын талаар ерөнхий заалтыг Үндсэн хуульд оруулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2-т "Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно." гэж заасан байдаг ба энэхүү заалт дах хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэх ойлголтыг практикт аль нь ч байж болох мэтээр ойлгох төөрөгдөл бий болсон. Уг төөрөгдлийн талаарх зарим эрдэмтдийн үзэж буйгаар:

Тэгэхлээр, "Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй,..." гэдэг нь "хууль зүй, улс төр" гэсэн хоёр ойлголтын хооронд таслал байгаа тул "эрх зүйч" эсвэл "улс төр судлаач" байж болох нь гэж ойлгож болохгүй. Үндсэн хуулийн шүүх нь Морис Дювержийн шуудхан хэлснээр бүрэлдэхүүнийг томилох ажиллагаа нь улс төрийн дээд институтын оролцоо, зөвшилцлийг агуулдаг, улс төрийн арга хэрэгслийг ашиглан томилдог, шийдвэр нь Үндсэн хуулийн мөн чанараас хамаарч улс төрийн шинжийг зүй ёсоор агуулдаг, улс төрийн үр дагавар үүсгэдэг нь нууц биш учраас Үндсэн хуулийн цэцийн гишүүн нь шийдвэрийнхээ улс төрийн үр дагаврыг мэдрэх, мэдэх шаардлага зүй ёсоор тулгарна. Үүнээс хамаарч эрх зүйч мэргэжлийн тодорхой чиглэлээр мэргэшсэн байх, ялангуяа Үндсэн хуулийн эрх зүйн маргаан шийдвэрлэх учраас хууль зүй, улс төрийн хосолмол судлагдахуунтай Үндсэн хуулийн эрх зүйгээр академик болон академик бус хүрээнд мэдлэг, чадвар, туршлага, дадал дүйгээ нарийсган, гүнзгийрүүлж, ердийн төвшнөөс дээгүүр, бүрнээ бэлтгэгдсэн байх шаардлага зүй ёсоор тавигдана.

Шүүгч хүн улс төрийн албан тушаалтан биш, шүүх нь улс төрийн хүчнүүдийн төлөөллийн нэгж буюу улс төрийн харилцааг тэнцүүлэх зориулалтыг баримтлан хуулийн ноёрхлыг тогтоож үндсэн эрхийг хамгаалах зориулалттай байгууллага байдаг. Ийм ч учраас шүүгч хүн, энэ тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн гишүүн хүн мэргэжлийн арвин туршлагатай хуульч байх ёстой юм.

Цэцийн гишүүний үндсэн мэргэжил нь хуульч байвалзохилтой. Гэхдээ зөвхөн хуульч гэдэг мэргэжлээс гадна улс төрийн талаар зохих боловсрол, дадлага давхар эзэмшсэн байх шаардлагатай.

Ардчилсан улсууд дахь Үндсэн хуулийн шүүхийн гишүүд нь шүүгчид тавигдах шаардлагыг хангасан байх ёстой гэсэн нийтлэг чиг хандлага бий. Жишээлбэл, ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавих шаардлагын талаар 1949 оны Үндсэн хуульд заагаагүй боловч 1951 оны Германы Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд үндсэн хуулийн шүүгч ердийн шүүгчийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагыг хангасан байх талаар тусгасан. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч хууль зүйн мэргэжилтэй байх шаардлагыг

Үндсэн хуульд эсхүл Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд зааж өгч болдог. Тиймээс Монгол Улсын хувьд “улс төр, хууль зүйн өндөр мэргэшилтэй” гэдгийг хуульч эсхүл эрх зүйч байна, мэргэжлээрээ тодорхой хугацаанд ажилласан туршлагатай байна гэдгийг Цэцийн тухай хуульд тусгаж байна.

Монгол Улсад хуульч биш төдийгүй эрх зүйч биш хүмүүс Цэцийн гишүүнээр томилогдож ирсэн. Цэцийн хууль тогтоогчдоос бүрдсэн УБХ 1992 оны 5 сарын 8-ны Монгол Улсын Үндсэн Хуулийн цэцийн тухай хуулийг батлахдаа Цэцийн гишүүнд нэр дэвшигчийн талаар өргөн үзэл баримтлалыг баримталсан. Цэцийн тухай хууль Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 2-т “хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй” гэдэг шаардлагыг задалж тодорхойлоогүйгээс уг хууль үйлчилж эхэлснээс хойш Цэцийн гишүүн нь хуульч төдийгүй бусад мэргэжлийн хүн байхыг зөвшөөрч ирсэн бөгөөд мэргэшсэн битгий хэл мэргэжлийн байх шаардлага тавьдаггүй практик тогтсон. Зохигчийн тоолсноор 1992 оноос хойш Цэцэд 30 гишүүн томилогдсоноос дөрөв нь хуульч биш, эрх зүйч ч биш байжээ. Цэцийн гишүүдийн дийлэнх нэг хүрэхгүй олон эрх зүйч мэргэжилтэй байж ирсэн боловч гуравны нэг хүрэхгүй нь эрх зүйч мэргэжилгүй улс төрчид томилогдож ирсэн.⁴⁶ Энэхүү байдлыг нэг мөр шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг хуулийн төслийн 5 дугаар зүйлд тусгасан бөгөөд практикт зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай.

3.2.3. Цэцийн гишүүнийг зөвхөн нэг удаа томилох тухайд /хуулийн төслийн 6 дугаар зүйл/

Хүснэгт 5.17. Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн тухай

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	3.1. Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилно.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	6.1. Цэцийн гишүүнээр зөвхөн нэг удаа дахин томилж болно.

Хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр буюу цэцийн гишүүний бүрэн эрхийг хязгаарлах нь гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангах, Үндсэн хуулийн дээд хяналтыг баталгаажуулах зорилготой. Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар тухайн хуулийн төслийн шинэчлэн найруулах үндэслэл нь цэцийн гишүүнээр дахин томилоход ямар нэгэн хязгаарлалт байхгүйгээс үүдэн олон удаа томилогдон цэцийн гишүүний албан үүргийг улиран гүйцэтгэж тэдний хараат бус байдал алдагдаж буйтай холбоотой бөгөөд уг нөхцөл байдлыг арилгахын тулд цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жил хэвээр үлдээж нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох заалтыг Үндсэн хуульд оруулж байгаа. Ингэснээр цэцийн гишүүнээр хэт удаан ажиллахыг хязгаарлах, цэцийн гишүүний хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг нэгээс илүү удаа дахин томилохыг хориглодог эрх зүйт төртэй улсуудын сайн туршлагыг өөрийн улсын Үндсэн хуульд нэвтрүүлэх ач холбогдолтой гэжээ.

Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн

46 О. Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь”, *Эрх зүй 36, Дугаар 4 (2016)*: 4-9 дэх тал

хугацаагаар томилно.” гэж заасан. Тодруулбал, цэцийн гишүүний тоо, тэдгээрийг томилуулахаар санал болгох эрх бүхий этгээд, байгууллагыг тодорхойлохын сацуу бүрэн эрхийн хугацааг Үндсэн хуульд тусгажээ. Цэцийн гишүүний томилгоог хууль тогтоох байгууллагын дураар шийдвэрлэхээс урьдчилан хамгаалсан, хоёр. Гишүүний бүрэн эрхийн хугацааг хуульчилснаар цэцийн гишүүн дахин томилогдохгүй бөгөөд ганц удаа цэцийн гишүүний албан үүргийг гүйцэтгэх хязгаарыг тогтоосон⁴⁷ гэж тайлбарладаг эрдэмтэд байдаг ч ихэнх тохиолдолд дээрх Үндсэн хуулийн заалт нь “улируулан томилох”-ийг хориглосон заалт биш цэцийн гишүүний бүрэн эрхт хугацааг 6 жил байхаар тодорхойлсон заалт гэж ойлгодог. Энэ нь Үндсэн хуульд заасныг органик хуулиар тусгайлан заах шалтгаан хэмээн үзэх боломжтой байж болно.

Цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглосноор гишүүний хараат бус байдал дээшлэх эсэх тухайд

Үндсэн хуулийн хяналт сайн хөгжсөн гадаадын зарим орны жишээг харвал, ихэнхдээ шүүгчийг дахин томилохыг хязгаарласан байдаг. Учир нь цэцийн гишүүн дахин томилогдохын тулд өөрийг нь нэр дэвшүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны ашиг сонирхлын дагуу шийдвэр гаргах магадлалтай тул “дахин томилогдох” талаар хязгаарлалт тавьж гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангадаг. Тодруулбал, дахин томилогдох боломжийг хуулиар олгох явдал нь шүүгчийн хараат бус байдалд харшилна.⁴⁸

1992 оны Үндсэн хуулийг боловсруулах явцад цэцийн гишүүнийг улируулан томилохыг хориглох заалт оруулах талаар гаднын эрдэмтдийн дүгнэлт гарч байсан боловч дахин томилох асуудлыг илэрхий хориглосон заалт ороогүй учир өдийг хүртэл дахин томилогдсоор иржээ. 1992-2021 оны хооронд цэцийн гишүүнээр нийт 37 хүн томилогдон ажиллаж байснаас дөрвөн удаа улиран ажилласан 1 гишүүн, гурван удаа ажилласан 1 гишүүн, хоёр удаа улиран ажилласан 4 гишүүн байна.

Хүн ам цөөтэй Монгол Улсын хувьд ҮХЦ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жилээр тогтоон нэг удаа томилох тохиолдолд шалгуур хангах хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй. Тиймээс ҮХЦ-ийн гишүүнийг нэг удаа улируулан томилохыг зөвшөөрч бүрэн эрхийн хугацааг 12 жил байхаар зохицуулбал хүний нөөцийн хомсдолоос сэргийлэхийн зэрэгцээ цэцийн гишүүний хараат бус байдлыг баталгаажуулах боломжтой⁴⁹ хэмээн судлаачид санал нийлдэг.

Цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглосноор гишүүний хариуцлагыг дээшлүүлэх зорилгын тухайд

Төсөлд цэцийн гишүүний дахин томилогдох боломжийг бүрмөсөн хязгаарлаагүй. Зөвхөн 1 удаа дахин томилогдох боломжтойгоор зохицуулсан. Энэ нь цэцийн гишүүнд дахин 6 жил ажиллах боломжийг олгохын зэрэгцээ эхний бүрэн эрхийн хугацаан дахь үйл ажиллагааг үнэлүүлэх шаардлагыг бий болгож үүгээрээ хариуцлагыг дээшлүүлэх зорилгыг хангаж буй юм. Гэвч нөгөө талаар энэхүү зохицуулалт нь цэцийн гишүүний хариуцлагыг дээшлүүлэх гэхээсээ илүүтэй хараат бус байдлыг дээшлүүлэхэд ач холбогдолтой зохицуулалт байж болох юм.

47 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 970 дахь тал.

48 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, хоёр дахь хэвлэлт, (УБ, 2021), 73-74 дэх тал.

49 О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь”, *Эрх зүй сэтгүүл цуврал 36*, (2016): 12-16 дахь тал.

Түүнчлэн уг өөрчлөлт нь тухайн зорилгынхоо эсрэг үр дүнг үзүүлэх эрсдэлтэй хэмээн үзэж буй судлаачид бас байна. “...Үндсэн хуулийн цэцийн гишүүний хариуцлагатай өндөр албан тушаалыг нэг, хоёр удаагийн “түр зуурын олдошгүй” боломж мэт болгож, хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах “хоноцын” сэтгэхүйг Үндсэн хуулиар хөхиүлэн өөгшүүлж болохгүй бөгөөд харин Цэцийн гишүүнийг Монгол Улсын Үндсэн хуулиа хамгаалахын төлөө шударгаар, тууштай, нэр төртэй хүчин зүтгэж, улам бүр мэдлэг, туршлага хуримтлуулан тогтвор суурьшилтай мэргэшин ажиллуулахыг тэргүүн зэрэгт тавихыг эрхэмлэх нь эх орон, ард түмний язгуур эрх ашигт илүү нийцтэй байх болов уу...”⁵⁰ гэжээ. Иймд цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох өөрчлөлт нь “Зорилгод хүрэх байдал” шалгуурыг хангасан гэж үзлээ.

3.2.4. Цэцийн даргын бүрэн эрх, Цэцийн тамгын газар, Тамгын газрын даргын бүрэн эрх сайжруулалт, Цэцийн чадавхыг сайжруулах тухайд /хуулийн төслийн 11, 12 дугаар зүйл/

Хүснэгт 5.18. Хуулийн төслийн 11,12 дугаар зүйлийн тухай

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл заалт байгаа	6 дугаар зүйл. Цэцийн дарга, түүний эрх хэмжээ
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл заалт	11 дүгээр зүйл. Цэцийн дарга, түүний бүрэн эрх 12 дугаар зүйл. Цэцийн тамгын газар

Цэцийн дарга, түүний бүрэн эрхийн тухайд

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цэцийн тухай хуулийн 6 дугаар зүйлд цэцийн дарга, түүний эрх хэмжээг “Цэцээс үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах, гишүүдийн төлөөлөлтийн байдлыг тэнцүүлэн Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилох, гишүүдийн ажил үүргийг хуваарилж, гүйцэтгэлийн хяналт тавих, Цэцийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцах” хэмээн хуульчилсан.⁵¹

Дээрх хуулийн заалтаас үзвэл цэцийн даргын эрх хэмжээ дараах 5 агуулгатай байна. Үүнд:

1. Цэцээс үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах;
2. Гишүүдийн төлөөлийн байдлыг тэнцүүлэн Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилох;
3. Гишүүдийн ажил үүргийг хуваарилах;
4. Гүйцэтгэлийн хяналт тавих;
5. Цэцийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцах зэрэг болно. Эдгээр эрх хэмжээ нь цэцийн үйл ажиллагаанд цэцийн даргын нөлөөллийг бий болгосон хэмээн судлаачид шүүмжлэлтэй ханддаг.

50 С.Нарангэрэл, *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаарх Академич С.Нарангэрэлийн бичмэл санал*, (УБ, 2023), Холбоос: <https://ip.ac.mn/c/1013593?Content=370727>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

51 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992), 6 дугаар зүйл.

Харин хуулийн төслийн хүрээнд цэцийн даргын бүрэн эрхийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Цэцийг дотоод, гадаадад төлөөлөх;
2. Зөвлөгөөнийг хуралдуулах, даргалах;
3. Төрийн бусад байгууллагатай харилцахдаа Цэцийн бие даасан байдлыг хамгаалах, хангах;
4. Цэцийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
5. Цэцийн тамгын газарт эрх хэмжээнийхээ хүрээнд чиглэл өгөх, хяналт тавих;
6. Хуульд заасан бусад хэмээн тусгажээ.

Хуулийн төсөлд Цэцийн даргын эрхийн талаар тусгасан 11 дүгээр зүйлийг үзвэл Цэцийн даргын бүрэн эрхийг багасгасан болох нь харагдаж байна. Тодруулбал, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар Цэцийн дарга нь гишүүдийн ажил үүргийг хуваарилах, албан тушаалтан байдлаас үл хамааран гүйцэтгэлийн хяналт тавих, гишүүдийн төлөөлөлтийн байдлыг тэнцүүлэх Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилох зэрэг Цэцийн гишүүдийн үйл ажиллагаанд хараат байдалд нөлөөлөх эрх хэмжээ, бүрэн эрхийг хасаж, уг бүрэн эрхийг нэгтгэн зөвлөгөөний хэлэлцэн шийдвэрлэх асуудалд хамруулсан. Өөрөөр хэлбэл Цэцийн үйл ажиллагаа нь цэцийн даргын эрх мэдлээс үл хамааран хамтын буюу зөвлөгөөний зохион байгуулалт руу шилжсэн.

Цэцийн тамгын газрын тухайд

1992 оны Цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Цэц ажлын албатай байна. Түүний орон тоог Улсын Их Хурлаас баталсан төсөвт багтаан Цэцийн ажлын албаны дарга тогтооно” гэснээс өөр нарийвчилсан заалт байхгүй. Өөрөөр хэлбэл 1992 оны Цэцийн тухай хууль нь ажлын алба болон ажлын албаны даргатай холбоотой эрх зүйн хэт ерөнхий зохицуулалттай. Энэ ч утгаараа Цэцийн ажлын албаны гүйцэтгэх чиг үүрэг, Тамгын газрын даргын бүрэн эрх зэрэг хуулийн зохицуулалтгүй явж ирсэн.

Харин Цэцийн тухай хуулийн төсөлд эдгээр асуудыг шийдвэрлэж Цэцийн Тамгын газрын гүйцэтгэх 18 чиг үүргийг тодорхойлон, уг Тамгын газар чиг үүргээ хэрэгжүүлж, зөвлөгөөнд тогтмол тайлагнахаар зохицуулсан. Мөн Тамгын газрын дарга нь төрийн захиргааны албан хаагч байх бөгөөд түүний хэрэгжүүлэх бүрэн эрхийг тусгайлан тодорхойлжээ. Ингэснээр Цэц нь зохион байгуулалтын хүрээнд шинэчлэгдэж ердийн шүүхтэй ижил түвшинд хүрснээр Үндсэн хуулийн цэцийг шүүх мөн эсэх тухай маргаан эцэс болох юм.

3.2.5. Нөлөөллийн мэдүүлгийн тухайд /хуулийн төслийн 17 дугаар зүйл/

Хүснэгт 5.19. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн тухай

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй зүйл, заалт	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цэцийн тухай хуульд нөлөөллийн мэдүүлэгт хамаарах эрх зүйн хэм хэмжээ байхгүй.
Өөрчлөлтийн төсөл дэх тухайн зүйл, заалт	17.5.Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэхүйг тэмдэглэн баталгаажуулах зорилгоор нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.

“Нөлөөллийн мэдүүлэг” гэж шүүгч, шүүх бүрэлдэхүүнд, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдлийг тэмдэглэн баталгаажуулан баримт бичгийг ойлгодог.⁵² Одоо хэрэгжиж буй 1993 оны Цэцийн тухай хуульд цэцийн гишүүний нөлөөллийн мэдүүлгийн талаарх зохицуулалт байдаггүй. Өөрөөр хэлбэл цэцийн гишүүн өргөдөл мэдээлэл хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэл тэмдэглэн баталгаажуулдаггүй байсан. Цэцийн маргааны харьяалал ихэвчлэн улс төрийн шийдвэр гаргадаг, цаашлаад Цэцийн гишүүдийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Улсын Дээд Шүүхээс нэр дэвшүүлдэг, улируулан сонгох эрх зүйн орчныг хязгаарлаагүй. Энэ ч утгаараа цэцийн гишүүний хэрэг хянан шийдвэрлэхэд нөлөөлөх боломж харьцангуй өндөр бөгөөд Цэцийн гишүүн хэрэг хянан шийдвэрлэхэд нөлөөлсөн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах нь зүйтэй.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлд нөлөөллийн мэдүүлэгтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээг тусгасан. Энэхүү зохицуулалтыг Монгол Улсын Шүүхийн тухай хуультай харьцуулан авч үзвэл:

Хүснэгт 5.20. Мэдүүлэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулалт

Цэцийн тухай хуулийн төсөл	Шүүхийн тухай хууль
17.5.Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэхүйг тэмдэглэн баталгаажуулах зорилгоор нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.	45.1.Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон бүх тохиолдлыг тэмдэглэн баталгаажуулж нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.
17.6.Цэцийн гишүүний нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар маргаан үүсгэсэн даруйд тухайн маргааны оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулна.	45.3.Шүүгч нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар хэрэг үүсгэсэн даруйд тухайн хэргийн оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулна.
17.7.Цэцийн гишүүн нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн бол маргааны материалд хавсаргаж, хувийг Тамгын газарт хүргүүлнэ.	45.4. Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн шүүгч нөлөөллийн мэдүүлгийг хэрэгт хавсаргаж, хувийг Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.
17.8.Тамгын газар нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан үйлдлийг шалгуулахаар зохих байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.	45.5.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 45.1-д заасан нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ.

52 Монгол Улсын Шүүхийн тухай хууль, (2021), 3.1 дүгээр зүйлийн 3.1.2 дахь хэсэг.

17.9.Энэ хуулийн 17.8-д заасны дагуу шилжүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэж, нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн Цэцийн гишүүн болон Тамгын газарт хариу мэдэгдэнэ.	45.6.Ерөнхий зөвлөлөөс шилжүүлсэн холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэж, Ерөнхий зөвлөлд хариу мэдэгдэнэ.
17.10.Тамгын газар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	45.7.Ерөнхий зөвлөл эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлнэ.
17.11.Нөлөөллийн мэдүүлгийг хөтлөх, шийдвэрлэх журмыг Дэгээр зохицуулна.	45.2.Энэ хуулийн 45.1-д заасан нөлөөллийн мэдүүлгийн загвар, хөтлөх, шийдвэрлэх журмыг Ерөнхий зөвлөл батална.

Дээрх хүснэгтээс үзэхэд Цэцийн тухай хуулийн төслийн шүүгчийн нөлөөллийн мэдүүлгийн зохицуулалтууд нь Шүүхийн тухай хуультай ижил байна. Тодруулбал Шүүхийн тухай хуульд ‘...’бүх тохиолдлыг тэмдэглэн баталгаажуулна...” гэж заасан бол Цэцийн тухай төсөлд цэцийн гишүүн нь “маргааны явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэхүйг нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө” гэж тодотгож заасан байна. Мөн цэцийн гишүүн болон шүүгчийн нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагавар болон олон нийтэд тухай бүр мэдээлэх зэрэг зохицуулалтууд ижил байна. Харин шүүгчийн нөлөөллийн мэдүүлгийг хянаж, хүлээн авах байгууллага нь Шүүхийн ерөнхий зөвлөл бол Цэцийн гишүүний хувьд Тамгын газар байна.

Өөрөөр хэлбэл Цэцийн гишүүний хараат бус, эрх тэгш байх баталгааг шүүгчийн нэгэн адил Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэхүйг тэмдэглэн баталгаажуулах зорилгоор нөлөөллийн мэдүүлэг хөтлөх зохицуулалтыг тусгасан. Энэ нь Шүүхийн тухай хуулийн дагуу 10 жил хэрэгжсэн сайн туршлага бөгөөд энэ ч утгаараа практикт хэрэгжих боломжтой эрх зүйн хэм хэмжээ юм.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэх мөн логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгах шаардлагатай. Мөн хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ийг баримталсан эсэхийг тусгайлан шалгана. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын Цэцийн тухай хуулийн төслийн нийт 25 зүйл заалтыг “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд уг хуулийн төсөл нь найруулга болон хэл зүйн агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон байна. Мөн логик дэс дараалалтай боловсруулагдсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан. Иймд уг хуулийн төсөл нь “Ойлгомжтой байдал” шалгуурыг хангаж байна.

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг

бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуурын хүрээнд зохицуулалт бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгана.

1. “Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байх”, “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх” гэсэн Үндсэн хуулийн зохицуулалттай нийцэж буй эсэх

Тус хуулийн төсөлд “үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх” гэж заасан байна.

Энэ нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.”, Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэсэн хэсэгтэй зөрчилдөх эсэх талаар маргаан үүсэж болох юм. Гэсэн хэдий ч, Цэц буюу Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн бүлэгт хамааралгүй буюу Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргийнхээ хувьд Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй учир зөрчил үүсэхгүй гэж үзэж болно.

Мөн Цэцийн иргэний үндсэн эрх зөрчигдсөн маргааныг шийдвэрлэхдээ хуулиар шийдвэрлэх журам байгаа тохиолдолд бүх шатны журмаар шийдвэрлүүлсний дараа Цэцэд хандах зарчимтай нийцнэ. Энэ тухай хууль зүйн ухааны доктор, судлаач Ц.Сарантуяа “..Гэхдээ иргэн, хуулийн этгээд нь үндсэн хуулийн шүүхэд хандахын өмнө тухайн маргааныг хуульд заасан бусад бүх шат дамжлагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг урьдчилан авсан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эрхээ хамгаалуулахаар үндэсний эрх зүйн бүх механизмыг эхлээд гүйцээсэн байна...” гэж тодорхойлсон байдаг бөгөөд эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улсад ч ийм жишиг бий. Тийм учраас Цэц болон шүүх эрх мэдлийн байгууллагууд хоорондын эрх мэдлийн болон чиг үүргийн ялгаатай байдлыг танин мэдэж, үндсэн хуулийн эрх зүйн харьцуулсан судалгааны үүднээс ул суурьтай хандах шаардлагатай.

IV. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Тус судалгаагаар Цэцийн тухай хуулийн төслийн Нэр дэвшигчийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журмын тухайд /хуулийн төслийн 6 дугаар зүйл/, Цэцийн бүрэлдэхүүн зохион байгуулалт, маргааныг хуваарилах тухайд /хуулийн төслийн 9 дүгээр зүйл/, Цэцийн гишүүний хариуцлагыг дээшлүүлэх тухайд /хуулийн төслийн 14, 16 дугаар зүйл/, Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгааны тухайд /хуулийн төслийн 19 дүгээр зүйл/, Цэцийн үйл ажиллагааны баталгаа, цэцийн төсөв санхүүгийн бие даасан байдлын тухайд /хуулийн төслийн 20, 21 дүгээр зүйл/ хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь зорилгод нийцэж буй эсэх, Мөн хуулийн төслийн Маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх дүгнэлт гаргаж, дахин хянаж үзэж эцсийн шийдвэр гаргах үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх тухайд /хуулийн төслийн 3 дугаар зүйл/, Цэцийн гишүүнд тавих болзол шаардлагын тухайд /хуулийн төслийн 5 дугаар зүйл/, Цэцийн гишүүнийг зөвхөн нэг удаа томилох тухайд /хуулийн төслийн 6 дугаар зүйл/ Цэцийн даргын бүрэн эрх, Цэцийн тамгын газар, Тамгын газрын даргын бүрэн эрх сайжруулалт, Цэцийн чадавхыг сайжруулах тухайд /хуулийн төслийн 11, 12 дугаар зүйл/, Нөлөөллийн мэдүүлгийн тухайд /хуулийн төслийн 17 дугаар зүйл/ хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь практик хэрэгжих эсэх, түүнчлэн хуулийн төсөл бүхэлд нь ойлгомжтой болон, харилцан уялдаатай эсэхэд дүн шинжилгээ хийж дараах дүгнэлт, зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Цэцийн тухай хуулийн төслийн Нэр дэвшигчийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журмын тухайд /хуулийн төслийн 6 дугаар зүйл/, Цэцийн бүрэлдэхүүн зохион байгуулалт, маргааныг хуваарилах тухайд /хуулийн төслийн 9 дүгээр зүйл/, Цэцийн гишүүний хариуцлагыг дээшлүүлэх тухайд /хуулийн төслийн 14, 16 дугаар зүйл/, Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгааны тухайд /хуулийн төслийн 19 дүгээр зүйл/, Цэцийн үйл ажиллагааны баталгаа, цэцийн төсөв санхүүгийн бие даасан байдлын тухайд /хуулийн төслийн 20, 21 дүгээр зүйл/ -д заасан эрх зүйн хэм хэмжээ нь Үндсэн хууль болон бусад эрх зүйн хэм хэмжээнд заасан агуулга болон зорилгод нийцэж байна. Гэхдээ дараах агуулгыг анхаарах шаардлагатай байна.

- Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.9-д “...цэцийн гишүүнд тавих болзол шаардлагыг хангах боломжтой хүмүүсийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоо зэрэг асуудлыг зохицуулсан журмыг энэ хуульд нийцүүлэн батлана гэж заасан.” Мөн хуулийн төслийн 6.7-д “нэр дэвшигчийн сонсголыг холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулна” гэж заасан. Гэвч 6.9-д заасан энэхүү журам болон 6.7-д заасан журмын ялгаатай байдал болон хоорондын онцлог байдал тодорхойгүй байна. Иймд 6.7 дугаар зүйл болон 6.9 дүгээр зүйлийн ялгааг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй.

- Хуулийн төслийн 10 дугаар зүйлд Цэц хэргийг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй, хамгаалалтай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг өргөдөл, гомдол, хүсэлт гаргасан этгээд мэдэгдэх, шууд өгөх зохицуулалтыг нэмэх нь зүйтэй.

- Цэцийн тухай хуулийн төслийн 21.2-т Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалин хөлсний хэмжээг Цэцийн даргын санал болгосноор тогтоохоор заасан. Уг хуулийн төслөөр Цэцийн зөвлөгөөний эрх зүйн орчныг шинээр бий болгосон. Иймд Цэцийн дарга бус Цэцийн зөвлөгөөн Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалин хөлсний хэмжээг Улсын Их Хуралд санал болгох нь зүйтэй.

2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн Маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх дүгнэлт гаргаж, дахин хянаж үзэж эцсийн шийдвэр гаргах үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх тухайд /хуулийн төслийн 3 дугаар зүйл/, Цэцийн гишүүнд тавих болзол шаардлагын тухайд /хуулийн төслийн 5 дугаар зүйл/, Цэцийн гишүүнийг зөвхөн нэг удаа томилох тухайд /хуулийн төслийн 6 дугаар зүйл/ Цэцийн даргын бүрэн эрх, Цэцийн тамгын газар, Тамгын газрын даргын бүрэн эрх сайжруулалт, Цэцийн чадавхыг сайжруулах тухайд /хуулийн төслийн 11, 12 дугаар зүйл/, Нөлөөллийн мэдүүлгийн тухайд /хуулийн төслийн 17 дугаар зүйл/ холбогдох заалтыг сонгон үнэлгээ хийсэн. Үүний дүнд дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

- Цэцийн тухай хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой.

- Хуулийн төслийн 3.2.5-д Цэц үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэхээр заасан. Өөрөөр хэлбэл иргэд зөрчигдсэн эрхээ сэргээлгэхээр Цэцэд шууд хандах боломжийг олгохдоо Цэцийн ачаалал, хэрэг маргаан шийдвэрлэлтийн чанарын асуудлыг анхаарах нь зүйтэй бөгөөд өргөдөл, мэдээлэл гаргах тодорхой “босго”-г тогтоох ёстой. Дээрх үндэслэлд зарим судлаачдын зүгээс “Цэцээс иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхийг Үндсэн хуулиар баталгаажуулах” зохицуулалт оруулах хувилбарыг санал болгож байна. Ингэхдээ, Цэцийн ачаалал, ердийн шүүхийн хяналтын давхардлаас урьдчилан сэргийлэх үүднээс Цэцэд хандахын өмнө гурван шатны шүүхийн урьдчилсан хяналтыг хэрэгжүүлсэн байх шаардлагыг тавьж болно гэж дурдсаныг анхаарах нь зүйтэй.

- Хуулийн төслийн 5.1-д Цэцийн гишүүн Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлоос гадна дараах шаардлагыг хангана гээд 5.1.1-д эрх зүйч мэргэжилтэй байхыг заасан. Уг заалтыг илүү нарийвчлан тухайн мэргэжлээр тодорхой хугацаанд буюу 3-5 жил тасралтгүй ажилласан байх нөхцлийг нарийвчлан нэмэх нь зүйтэй.

3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд үнэлсэн. Цэцийн тухай хуулийн төсөл нь найруулга болон хэл зүйн агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон байна. Мөн логик дэс дараалалтай боловсруулагдсан бөгөөд хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан. Энэ ч утгаараа уг хуулийн төсөл нь “ойлгомжтой байдал” шалгуурыг хангаж байна.

4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд үнэлсэн бөгөөд дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Тус хуулийн төсөлд “үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх” гэж заасан нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.”, Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэсэн хэсэгтэй зөрчилдөх эсэх талаар маргаан үүсэх эсэхийг анхаарах нь зүйтэй.
- Мөн Цэцийн иргэний үндсэн эрх зөрчигдсөн маргааныг шийдвэрлэхдээ хуулиар шийдвэрлэх журам байгаа тохиолдолд бүх шатны журмаар шийдвэрлүүлсний дараа Цэцэд хандах зарчимтай нийцнэ. Тийм учраас Цэц болон Шүүх эрх мэдлийн байгууллагуудын хоорондын эрх мэдлийн болон чиг үүргийн ялгаатай байдлыг танин мэдэж, үндсэн хуулийн эрх зүйн харьцуулсан судалгааны үүднээс ул суурьтай хандах шаардлагатай.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992).
3. Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, (1997).
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2002).
5. Нийтийн сонсголын тухай хууль, (2015).
6. Монгол Улсын шүүхийн тухай хууль, (2021).
7. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2016).
8. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2017).

Гадаад хэлээр:

1. Rules of Procedure of the Federal Constitutional Court/ Германы Үндсэн хуулийн шүүхийн процедурын журам, (2014 он), https://www.bundesverfassungsgsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/GO_VVerfG.html#download=1
2. ОХУ-ын Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
3. Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
4. Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
5. Австри Улсын Үндсэн хууль, https://www.vfgh.gv.at/downloads/VfGH_Broschuere_eng_barrierefrei_Final.pdf

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. (УБ, 2000).
2. Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, (УБ, 2007).
3. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, (УБ, 2008).
4. ХЗДХЯ, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”, “Үндсэн хуулийн процессын эрх зүй” оюутны гарын авлага, (УБ, 2011).
5. О.Мөнхсайхан, “Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудалд хийсэн дүн шинжилгээ”, Эрх зүй 48, Дугаар 4 (УБ, 2014).
6. Арне Мавчичи, Үндсэн хуулийн хяналт, (УБ, 2014).
7. О. Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015).

8. О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь,” Эрх зүй 36, Дугаар 4 (УБ, 2016).
9. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, (МУИС пресс, 2016).
10. Н.Номинчимэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа, (УБ, 2019).
11. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, (УБ, 2021).
12. Н.Лүндэндорж, “Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар”, (УБ, 2023).
13. ХЗҮХ, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (УБ, 2023).

Гадаад хэлээр:

1. 성낙인, 헌법학, 법문사, (2021).

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. О.Мөнхсайхан, “Үндсэн хуулийн шүүгч нарын томилгоо ба УИХ-ын гишүүдийн хайнга байдал нотлогдов”,(сурв. Ч.Болортуяа) 2018.05.24, Холбоос: <https://ikon.mn/opinion/1a9u>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
2. С.Нарангэрэл, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаарх Академич С.Нарангэрэлийн бичмэл санал”, 2023, Холбоос: <https://ip.ac.mn/c/1013593?Content=37072>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
3. Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” Эрдэм шинжилгээний нийтлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

ЗУРГАА. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ,
ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Б.Энх-Амгалан Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
О.Түвшинсанаа Эрдэм шинжилгээний ажилтан
Э.Сэлэнгэ Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил (ҮХЦ-ийн тухай хуулийн төсөл
боловсруулах ажлын хэсгийн ахлагч).

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.11.17.

АГУУЛГА

УДИРТГАЛ	205
I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	206
1.1 Үнэлгээ хийх шалтгаан	206
1.2 Үнэлгээ хийх хүрээ	209
1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	210
1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр	211
1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох	211
1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	212
II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	213
III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	215
3.1 Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ - Тулгамдсан асуудал	216
3.2 Цэцэд хандах арга, хэлбэр-Тулгамдсан асуудал	219
3.3 Цэцэд маргаан үүсгэх ажиллагаа- Тулгамдсан асуудал	222
3.4 Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн- Тулгамдсан асуудал	225
3.5 Хэргийн харьяалал тогтоох Цэцийн оролцоо - Тулгамдсан асуудал	228
IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	229
НОМ ЗҮЙ	233

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Энэхүү ажлын зорилго нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд үндэслэн дүгнэлт гаргах, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, зөвлөмж боловсруулахад оршино.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.

Монгол Улс 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа баталж, Үндсэн хуулийг чандлан сахиулах, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, түүний биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэг бүхий үндсэн хуулийн шүүх(Үндсэн хуулийн цэц) байгуулсан. Улмаар 1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 1997 онд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг баталснаар Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг зохицуулж байна. Эдгээр хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчим, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэлийн үйл явцтай уялдсан дорвитой өөрчлөлт хийгдэлгүй өдий хүрсэн.

Гэсэн хэдий ч хууль хэрэгжүүлэх явцад үүссэн хүндрэл, бэрхшээл, хийдэл, зөрчлийг даван туулах, зохистой шийдлийн хувилбар тодорхойлоход анхаарч Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргасан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд Цэцийн тухай хууль тогтоомжийг удаа дараа тусгаж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Тухайлбал, Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт “Үндсэн хуулийн хүрээнд төрийн байгууллагуудын бүрэн эрх, харилцан ажиллагааг хангах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох” арга хэмжээг тусгасан бөгөөд 2008 онд энэ хүрээний хэрэгжилтийг дүгнэхдээ “УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч, Шүүх, Прокурор, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, Яам, Агентлагийн тухай, Захиргааны шүүх байгуулах тухай хуулийг шинээр батлан гаргах зэрэг арга хэмжээ авсан боловч эдгээр байгууллагын

харилцан ажиллагаанд бэрхшээл тохиолдсон хэвээр байна”¹ хэмээн онцолсон.

Үүний дараа 2016 онд дүгнэхдээ, 2008 онд Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгдсэнээс хойш тус хөтөлбөрийн “Үндсэн хуулийн хүрээнд төрийн байгууллагуудын бүрэн эрх, харилцан ажиллагааг хангах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох” арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн гэж үзээд, үүнд олон хүчин зүйл шалтгаалсан бөгөөд 2000 онд хийгдсэн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр холбогдох заалтуудыг хүчингүй болгосон нь үндсэн хүчин зүйл болсон² гэж дүгнэсэн байна.

2016 онд хийсэн “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт судалгааны тайланд, ... Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт ямар байгааг дүгнэхдээ, одоог хүртэл хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт тусгагдаагүй байгааг дурдаад, тухайлбал, Үндсэн хуулийн цэц үндсэн эрхийг хамгаалах буюу үндсэн эрхийг шууд үйлчлэх эрх зүй болох талаар дараах дүгнэлт³-ийг онцолжээ. Үүнд:

“...иргэн хүний үндсэн эрх зөрчигдвөл түүнийг Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн нэрийн өмнөөс сэргээх боломж хараахан бүрдээгүй байна. Иймд Үндсэн хуулийн “Хүний эрх” бүлгийн хэрэгжилт бодит байдалд хамгаалалтгүй орхигджээ...”

...Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх асуудалд шүүхийн шийдвэр хамаардаггүй байна... Ингэснээрээ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц төрийн гурван бус, хоёр эрх мэдлийн шийдвэрийг хянадаг. Үндсэн хуулийн шүүх Монголд байгуулагдан Үндсэн хуулийг хэрэглэн эцсийн шийдвэр гаргаж байгаагаараа Үндсэн хуулийг бусад хуулийн адил шууд хэрэгждэг /үйлчилдэг/ эрх зүй болгох үндэс суурь тавигдсан. Гэсэн ч Үндсэн хуульд заасан үндсэн эрх нь зөрчигдсөн хүн цэцэд хандах эрх зүйн орчин бүрдээгүй, иргэн хүн хуульд заасан цөөн тооны объектыг л Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянуулахаар, өөрөөр хэлбэл, өөрт нь хамааралгүй асуудлаар цэцэд хандах эрхтэй байгаа нь үндсэн эрхийг шууд үйлчлэх шинж чанаргүй болгож байна...

Иймээс Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийг бүхэлд нь шүүхийн журмаар хэрэглэн маргааныг эцэслэн шийдвэрлэх боломжийг олгож, Үндсэн хуулийг “шууд үйлчилдэг эрх зүй” хэмээх категорид ойртуулах шаардлагатай. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуульд тавих дээд хяналтыг цаашид боловсронгуй болгон иргэний нийгэмд иргэн хүн үндсэн эрхээ хамгаалуулах боломжийг олгоход анхаарч хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай.”

1 Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, (УБ, 2008), 62 дахь тал.

2 “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, (УБ, 2016), 21 дэх тал.

3 Мөн тэнд, 70-71 дэх тал.

Түүнчлэн “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт судалгаагаар, эрх зүйн шинэтгэлийн цаашдын зорилт, чиглэл, арга хэмжээний талаар байгууллага, эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүд, иргэд, олон нийтээс санал авах, тэдгээрийн оролцоог хангах хандлага баримталж ажилласан. Тухайлбал, Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль зүйн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаачид санал, зөвлөмж өгсөн. Үүний Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг боловсронгуй болгох хүрээний зөвлөмжийн үндэслэлээс Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох хэсгийг тодруулбал:

“...Цэцэд хандаж хүсэлт гаргах этгээдийн хүрээг тодорхойлохдоо хамаарлын зарчмыг баримтлах. Хүсэлт гаргагч нь аль ч маргаантай асуудлаар биш харин тухай маргаантай асуудлаар ашиг сонирхол нь хөндөгдсөн эсхүл ажил үүргийн шугамаар тухайн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх зүй ёсны үндэслэл байгаа тохиолдолд Цэцэд хүсэлт гаргахаар зохицуулах; Хүсэлт гаргагчаас Цэцэд гаргасан хүсэлтийн зүйл болсон маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой зохицуулах; Иргэний өргөдөл, түүгээр үүсгэсэн үндсэн эрхийн маргаан, / үндсэн эрхийн тодорхой зөрчил/-ыг хянан шийдвэрлэх журмыг тодорхой болгож заах; иргэний мэдээлэл, түүний агуулга, ач холбогдлын талаарх зохицуулалтыг шинэчлэх. “Мэдээлэл” гэж маргааныг хянан шийдвэрлэхэд туслах зорилгоор тухайн маргаантай холбоотой асуудлаар маргааны тал биш иргэнээс Цэцэд бичгээр гаргаж өгсөн тайлбарыг ойлгоно гэж заах; Цэцийн харъяаллын бүх маргааныг хянан шийдвэрлэхэд мөрдөх ерөнхий журам болон тухайн маргааны онцлогтой уялдсан тус тусын тусгай журмыг тодорхойлох” санал багтжээ.

“Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” сэдэвт хамтын бүтээлд “Хүний эрхийг хангах үндэсний механизм бүрэлдэн тогтож байна. Гэхдээ Үндсэн хуулийн цэц хүний эрхийн тодорхой зөрчлийн тухай иргэний гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэггүй ... зэргээс болж хүний эрхийн тулгамдсан асуудлууд олон жил амь бөхтэй зууралдсаар байна”⁴ хэмээн Үндсэн хуулийн цэц хүний эрхийг хамгаалах механизмын гол бүрэлдэхүүн болохыг цохон тэмдэглэсэн.

Үндсэн хуулийн цэцийн болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн талаарх үндэсний эрх зүйн онол, практикийн болон харьцуулсан судалгаа нэлээд сайн хийгдсэн бөгөөд судалгааны үр дүнг хэлэлцэх, зөвлөлдөх ажиллагаа өрнөж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх хандлага сайжирсан байгааг онцлох нь зүйтэй.

Ийнхүү хууль тогтоомжид өөрчлөлт ороогүйтэй холбоотойгоор, өмнө хийгдсэн судалгааны эх сурвалжид дурдсан үр дүн өөрчлөгдөөгүй хэвээр байгаа нөхцөл байдал нь Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд дахин үнэлгээ хийх хэрэгцээ, шаардлагыг илтгэнэ.

⁴ Ч.Энхбаатар нар, *Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ* (УБ, 2016), Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, 69 дэх тал.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлого гэсэн дөрөв дэх бүлгийн “Хараат бус, бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл” хэсгийн 4.4.2 дахь заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж тусгасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 84 болон 85-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ ба Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль/Шинэчилсэн найруулга/ -ийн төслийг тус тус тусгасан. Уг үндсэн чиглэлд эдгээр хуулийн төслийг боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны агуулгыг “Үндсэн хуулийн цэцийг хараат бус, бие даасан, мэргэжлийн өндөр ур чадвар бүхий түвшинд ажиллах боломжийг бүрдүүлэх, Цэцэд хандан гомдол, мэдээлэл, хүсэлт гаргах хүрээ хязгаарыг тодорхой болгох, Цэцийг олон улсын жишгийн дагуу шүүхийн хэлбэрээр хөгжих эрх зүйн орчныг бий болгох; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль нь хэт ерөнхий, агуулгын хувьд Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуультай давхардсан зохицуулалт агуулсан, маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиар зайлшгүй зохицуулах зарим харилцааг зохицуулаагүйгээс Цэцийн дүгнэлт, шийдвэрт нөлөөлж байгааг өөрчлөх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийг нарийвчлан зохицуулах” хэмээн тодорхойлжээ.

Иймд Үндсэн хуулийг чандлан сахиулах болон хүний үндсэн эрхийг хамгаалах чиг үүрэгт нь нийцүүлэн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг улам бүр нарийвчлан, шударга, үр нөлөөтэй явагдахаар зохицуулах хэрэгцээ, шаардлагад үндэслэн, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх замаар практикт тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлийг тодруулан, шийдвэрлэх бодлогын хувилбар бүхий судалгаагаар дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж үзэв.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Тус хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн болно.

Ингэхдээ үнэлгээ хийх болсон шалтгаануудтай харилцан уялдаа, хамааралтай байдлыг харгалзаж, хуулийн хэрэгжилтэд гарч буй эерэг, сөрөг нөхцөл байдал,

хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон зохицуулалтыг сонгох учиртай. Үүнд “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 85-д тодорхойлсон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны агуулгыг голлох зарчим баримтлав.

Түүнчлэн энэхүү бодлогын шинжлэх ухааны үндэслэл болсон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны онол, практикийг хөндсөн эрдэмтдийн бүтээл, хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалсан ажлын тайлан, эрдэм шинжилгээний бага хурал, хэлэлцүүлэг зэрэг олон нийтийн зөвлөлдөх ажиллагааны үр дүн, илтгэл, нийтлэл зэрэг эх сурвалжийг судалж, үнэлгээ хийх хүрээ тогтооход ашигласан.

Үүний үр дүнд, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн дараах зохицуулалтыг үнэлгээ хийх хүрээнд хамруулав. Үүнд:

Хүснэгт 6.1. Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл. Хэргийн харьяалал тогтоох	Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.
2	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйл. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ	15.1.Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ. 15.3.Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр үүсгэн явуулна.
3	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйл.Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах	16.1.Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар өргөдөл, мэдээллийг иргэд; хүсэлтийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор гаргах эрхтэй.
4	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйл.Цэцэд өргөдөл, мэдээлэл хүсэлтийг хүлээн авах	21.2.Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ.
5	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн	3.2.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бага суудал 3, дунд суудал 5, их суудал 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан. Үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой.

Аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтээс уг аргачлалын 3.4.1-д заасан “зорилгод хүрсэн түвшин” болон “3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгов. Эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд, тухайн зохицуулалтын хэрэгжилт түүний эерэг, сөрөг үр дагавар болон хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлно. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоох бол, “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3-т заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрээс 3.5.3.4-т заасан “тохиолдол судлах”⁵ хэлбэрийг сонголоо.

Тохиолдол судлах хэлбэрийн хүрээд хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. Ийнхүү бусад улсын хууль тогтоомжийг харьцуулж судлах нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг боловсронгуй болгох ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай гэж үзэв.

Гэхдээ манай улсын тухайн чиглэлээр тэргүүлэх эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүнд хэдийн тодорхойлогдсон асуудлын хувьд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын “Хэрэв шалгуур үзүүлэлтийг томъёолох явцад асуудал тодорхой болсон тохиолдолд цаашид түүгээр мэдээлэл цуглуулах шаардлагагүй. Харин үнэлгээндээ асуудал тодорхой болсныг үндэслэлтэй тайлбарлана.” гэсэн арга зүйг баримталсан.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Энэхүү үнэлгээг хийхдээ Аргачлалын “зорилгод нийцсэн байдал”, “практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож авсан. Эдгээр шалгуур үзүүлэлтийг томъёолж, дараах асуултыг боловсруулав. Үүнд:

- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж, 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр үүсгэн явуулна” гэж тусгасан нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;

5 Хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөл (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт)-д хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар өргөдөл, мэдээллийг иргэд; хүсэлтийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор гаргах эрхтэй.” гэж тусгасан нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ” гэж тусгасан нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бага суудал 3, дунд суудал 5, их суудал 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна” гэж тусгасан нь хэлэлцэж байгаа асуудлыг Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ” гэж тусгасан нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор бодлогын баримт бичиг, эрдэм шинжилгээ, судалгааны эх сурвалжууд уншиж судлах, харьцуулалт хийх аргаар хэрэгцээтэй мэдээлэл олж авсан. Мэдээлэл цуглуулах дараах аргыг ашигласан болно. Үүнд:

Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу “Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах” хүрээнд: Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад баримт бичиг, ном, гарын авлага, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, өгүүлэл, статистикийн тоо баримт цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ холбогдох сэдвийг хөндсөн эх сурвалжийг судалж, мэдээлэл цуглуулсан. Тухайлбал, эрдэмтэн Б.Чимидийн “Үндсэн хуулийн мэдлэг”, Г.Совдын “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, Ч.Энхбаатарын “Үндсэн хуулийн эрх зүй, Н.Лүндэндоржийн “Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар”, Ч.Энхбаатар, Том Гинсбург, П.Амаржаргал, М.Батчимэг, Ц.Даваадулам, О.Мөнхсайхан, Д.Солонго нарын хамтын бүтээл “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” зэрэг бүтээл; “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан”, “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хяналт, шинжилгээ үнэлгээ” зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний хүрээнд Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ; “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх нь” зэрэг судалгааны хүрээнд Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэц, түүний үйл ажиллагааны эрх зүйн орчны өнөөгийн байдлыг дүгнэж, цаашдын чиг хандлагын талаар санал, зөвлөмж өгсөн бодлогын судалгааны тайлан зэрэг эх сурвалж орно.

Үүний зэрэгцээ доктор Ц.Сарантуяагийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт”, О. Мөнхсайхан “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж”, Г.Баясгалангийн “Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”, Н.Болортунгалагийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд” ... зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох бодлогын үндэслэлд дорвитой хувь нэмэр оруулсныг дурдах нь зүйтэй. 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулагдсан “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны онол, практикийн асуудлыг хөндөж, цаашдын хөгжлийн асуудлыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэхүйц, үндэсний хэмжээнд зөвлөлдөх индэр болж чадсан юм.

Дээр дурдсанаас гадна дараах эх сурвалжийг мөн судалж ашиглав. Үүнд:

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль
- Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль
- Шүүхийн тухай хууль
- БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
- ХБНГУ-ын Үндсэн хууль зэрэг хууль тогтоомж

Ном, сурах бичиг, эмхэтгэл

- Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй” Хоёр дахь хэвлэл, (2021).
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Анхны хэвлэл, (УБ, 2007).
- Арне Мавчич, “Үндсэн хуулийн хяналт”, (УБ, 2014).
- Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар, “Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж. /Боть 9/”, (УБ, 2022).
- О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, (УБ, 2021).
- МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), (УБ, 2023).
- МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2020.04.22 Санал № 2022CDL-PI(2020)004 “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”, (УБ, 2023).
- МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2021.02.22 Санал № 1004/2020 CDL-AD(2021)001 “Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”, (УБ, 2023).

Судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл

- О. Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015).
- Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт”, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц: өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл (УБ, 2007), Хууль зүйн үндэсний төв.
- Н.Болортунгалаг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Эрх зүйн зохицуулалтын хүрээнд), Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (2023).
- “Үндсэн хуулийн эрх зүй ба цаашдын чиг хандлага” сэдэвт хуралдааны хэсгээс, Хуульчдын форум- 2018”.
- Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл, (2023).
- Хууль зүй, дотоод хэргийн яам, Н.Отгончимэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орны туршлага судлах харьцуулсан судалгаа, (2019).
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/, (УБ, 2021).

III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд, Аргачлалын “зорилгод нийцсэн байдал”, “практикт хэрэгжиж буй байдал” шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийг үнэллээ.

Хэрэгжилтийн үе шатанд цуглуулж, уншиж судалсан эх сурвалжид тусгагдсан мэдээлэлд үндэслэж, Үндсэн хуулийг чандлан сахиулах болон хүний үндсэн эрхийг хамгаалах чиг үүрэгт нь нийцүүлэн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй зохицуулах шаардлагатай, зарим тулгамдсан асуудлыг хөндлөө. Ингэхдээ шалгуур үзүүлэлтийг томъёолох үе шатанд боловсруулсан дараах томъёоллын агуулгад нийцүүлж дэд бүлгийг нэрлэсэн болно. Үүнд:

Хүснэгт 6.2. Шалгуур үзүүлэлтийн томъёолол

№	Шалгуур үзүүлэлтийн томъёолол	Дэд бүлгийн гарчиг
1	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж, 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр үүсгэн явуулна” гэж тусгасан нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх	Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ- Тулгамдсан асуудал
2	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар өргөдөл, мэдээллийг иргэд; хүсэлтийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор гаргах эрхтэй.” гэж тусгасан нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх	Цэцэд хандах арга, хэлбэр- Тулгамдсан асуудал
3	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ” гэж тусгасан нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх	Цэцэд маргаан үүсгэх ажиллагаа- Тулгамдсан асуудал
4	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бага суудал 3, дунд суудал 5, их суудал 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна” гэж тусгасан нь хэлэлцэж байгаа асуудлыг Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх	Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн- Тулгамдсан асуудал
5	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж тусгасан нь практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх	Хэргийн харьяалал тогтоох Цэцийн оролцоо- Тулгамдсан асуудал

3.1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ - Тулгамдсан асуудал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж, 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр үүсгэн явуулна” гэж, Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.” хэмээн заасан. Ингэхдээ Цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хууль, зарлиг, УИХ, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн ЗГ-ын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- Ард нийтийн санал асуулга, УИХ, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, гишүүн, Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;
- Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.

Үүнээс үзвэл, Цэц нь нэгдүгээрт шийдвэрийг, хоёрдугаарт албан тушаалтны үйл ажиллагааг хянадаг бөгөөд харин иргэний үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлыг хянах эрх зүйн орчин тодорхой бус буюу маргаантай хэвээр байна. Тодруулж хэлбэл, ҮХЦМХШТХ-ийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн заалтыг удирдлага болгож Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл болон бусад зүйлд заасан үндсэн болон түүнтэй адилтгах эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн тохиолдолд сэргээхтэй холбоотой дээд хяналт орхигджээ.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 1.1.1.2-т “Монгол Улсын хууль тогтоомжийг судалж, Үндсэн хуульд нийцүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалыг гуйвалтгүй мөрдлөг болгож, хүний эрхийг зөрчиж байгаа эсэхэд Үндсэн хуулийн цэц, бусад шүүхээс тавих хяналтыг хүч, нөлөөтэй болгоно”, 1.1.3.1.3-т “Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Үндсэн хуульд заасан хүний эрх зөрчсөн тохиолдлыг шийдвэрлэхэд онцгой үүрэгтэй ажиллуулах механизм бүрдүүлнэ.” гэж тус тус заасан ч Цэц субъектив үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэдэггүй хэвээр байна. Ийнхүү үндсэн эрхийн маргааныг хянах үндэслэл, шаардлагын талаар “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” бүтээлд дараах байдлаар дүгнэсэн⁶ нь чухал ач холбогдолтой байна. Үүнд:

6 Ч.Энхбаатар нар, *Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ* (УБ, 2016), Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, 60 дахь тал.

“.... хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээдийн аливаа акт (шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй)-аар үндсэн эрх нь зөрчигдсөн бөгөөд хууль зүйн ердийн арга замаар уг эрхээ хамгаалуулж чадахгүй байна гэж үзвэл тухайн иргэн үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргах эрхтэй байдаг. Энэ журмыг нутагшуулбал Цэц иргэний өргөдлөөр үүсгэсэн маргааныг эцэслэн шийдвэрлэх бөгөөд энэ шийдвэрийг УИХ батламжлах шаардлагагүй. 2003 онд УИХ-аас батлагдсан Монгол Улсад хүний эрхийг хангах хөтөлбөрийн 1.1.2.1.3-т “Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Үндсэн хуульд заасан хүний эрх зөрчсөн тохиолдлыг шийдэхэд онцгой үүрэгтэй ажиллуулах механизм бүрдүүлнэ” гэж заасан нь энэ үзэл баримтлалд тулгуурласан хэрэг.”

Дээр дурдсанаас, Үндсэн хуулийн цэц хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоонд үүрэг гүйцэтгэх ёстой боловч үүргээ ийнхүү биелүүлж чадахгүй байгааг харж болно.

Үндсэн хуулийн цэц хийсвэр хяналтыг хэрэгжүүлнэ гэж ойлгож, тайлбарлаж ирснээс⁷ үүдэн иргэн Үндсэн хуульд заасан үндсэн эрхээ сэргээлгэхээр Цэцэд өргөдөл гаргадаггүй. Иймд иргэд Цэцэд өөрт шууд хамааралгүй асуудлаар, тухайлбал аль нэг эрх зүйн акт Үндсэн хууль зөрчиж байгаа эсхүл хуульд заасан хэн нэг албан тушаалтан Үндсэн хууль зөрчиж байгаа эсэх асуудлаар ханддаг бөгөөд иргэн Үндсэн хуульд заасан цөөн тооны объектоор Цэцэд хандах эрхтэй байдаг.⁸ Иймээс Цэц үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаарх өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх чиг үүрэг, бүрэн эрхгүй байх тул хүний эрхийн гол зөрчил шийдвэрлэгдэхгүй байна гэж үзэж байна.

Цэц 1992-2020 оны хооронд 296 маргааныг хянан шийдвэрлэсний дотор дийлэнх хувьд нь Үндсэн хуулийн зөрчлийг тогтоосон, мөн тэдгээрийн дийлэнх нь үндсэн эрх, эрх чөлөө, төрийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг гаргасан байна. Үндсэн хуулийн шүүхийн гол чиг үүрэг бол Үндсэн хуулийг, ялангуяа үндсэн эрхийг хамгаалах байдаг. Гэвч Цэцээс тухайн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлж чадахгүй байгаа шалтгаан нь үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаар Цэц хянан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүй, Цэцээс ихэнх шийдвэртээ хангалттай сайн үндэслэгээ хийж Үндсэн хуулийг тайлбарладаггүй, Цэцийн хараат бус, бие даасан байдал хангагдаагүйтэй холбоотой талаар эрдэмтэд дурджээ.

Монгол Улсад гарч буй хүний эрхийн зөрчил нь хийсвэр байдлаар бус, харин шүүх, төрийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны явцад гарах нь нийтлэг байна. Тухайлбал, Шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцдаа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг хэрэглэлгүйгээр цаазаар авах ял оногдуулж хүний амьд явах эрх зөрчигдсөн; эрүү

7 Цэц үндсэн эрхийг хамгаалах гол институц учраас ердийн шүүн таслах ажиллагаа дууссаны дараа үндсэн эрх нь зөрчигдсөн хэвээр гэж үзсэн хувь хүн Цэцэд өргөдөл гаргах боломжтой гэж Үндсэн хуулийг батлахдаа АИХ-ын олон гишүүн ойлгож байсан талаар баримтуудыг судлаачид дурдах нь бий. Тухайлбал, Н.Ганбаяр, О.Очиржав, Ц.Элбэгдорж, Л.Цог, УБХ-ын хуралдааны тэмдэглэл (1991.10.18): 29, 85-86, 91-92, 96; Л.Цог, Р.Гончигдорж, Ж.Бямбажав, А.Болат, УБХ-ын хуралдааны тэмдэглэл (1991.10.20): 141, 147, 151, 153-154; Д.Пүрэв, Б.Чимид, Д.Мөнхөө, Л.Цог, Э.Бат-Үүл, С.Зориг, Ж.Оросоо, АИХ-ын хуралдааны тэмдэглэл (1991.12.16): 23, 30-33, 51, 60, 79-80, 85-86; Л.Цог, АИХ-ын хуралдааны тэмдэглэл (1991.12.20): 34; А.Болат, Р.Улаанхүү, Д.Мөнхөө, Б.Чимид, АИХ-ын хуралдааны тэмдэглэл (1991.12.23): 28-29, 32, 39.

8 О.Мөнхсайхан, Р.Очирбал, *Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал. Тулгамдсан асуудал*, (УБ, 2021), 479 дэх тал.

шүүлтийн хохирогч болж өөрт учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зөрчигдсөн; Эрүүгийн хуульд үзэн ядалтаас үүссэн гэмт хэргийг хуульчлаагүйн улмаас энэ гэмт хэргийн хохирогч болж тэгш эрх нь зөрчигдсөн; Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор шударга нөхөх олговоргүйгээр хувийн өмчийг дайчлан авсан; Засаг даргын захирамж болон шүүхийн шийдвэрээр хүний үндсэн эрх болох үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зөрчигдсөн тохиолдолд Цэцэд хандах боломжгүй байна. Цэцээс УДШ-ийн болон ИТХ-ын шийдвэр нь хүний эрх зөрчигдсөн гэдгийг тогтоосон боловч, хүчингүй болгохоос татгалзаж байсан бөгөөд ийм төрлийн маргааныг хүлээн авдаггүй.⁹ Иймээс иргэний өргөдөл, мэдээллийг илүү өргөн хүрээтэй тодорхойлох шаардлагатай байна.

Иргэний мэдээлэл гэдгийг үндсэн хуулийн маргааныг үүсгэх үндэслэл гэж үзэхгүй харин "amicus curiae" гэсэн агуулгаар ойлгож, нэгэнт үүсгэсэн маргааныг зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой үндэслэл, судалгааг маргааны тал биш иргэнээс авах суваг болгох нь илүү зохистой. Иргэний өргөдөл, мэдээллийн талаар хоёр дахь үзэл баримтлалын дагуу Цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчилбэл Монгол Улс дахь үндсэн эрхийн зөрчил Үндсэн хуулийн болон олон улсын стандартын дагуу шийдвэрлэгдэх боломжтой болно¹⁰. Тухайлбал, доктор Ц.Сарантуяа "Монголд иргэн хүн хүсэлт гаргагчийн нэгэн адил, өөрөөр хэлбэл, өөрийнх нь үндсэн эрх зөрчигдөөгүй байхад ханддаг байхаар хуульд туссан учир Үндсэн хуулийн цэц иргэн хүний индивидуаль үндсэн эрхийн бодит байдал дээр зөрчигдсөн тохиолдолд түүнийг шүүхийн журмаар Үндсэн хуулийг хэрэглэн сэргээх боломжгүй байдаг. Зөрчигдсэн эрхийг манайд ч гэсэн ердийн шүүх сэргээдэг, харин үндсэн эрх зөрчигдвөл түүнийг Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн нэрийн өмнөөс сэргээх боломж хараахан бүрдээгүй байна. Иргэн хүн Үндсэн хуульд заасан цөөн тооны объектоор Цэцэд хандах эрхтэй бөгөөд үндсэн эрх энэхүү объектод ордоггүй. Иймд Үндсэн хуулийн "хүний эрх" бүлгийн хэрэгжилт бодит байдалд хамгаалалтгүй орхигджээ"¹¹ гэж үзсэн байна.

Үндсэн хуулийн цэцэд иргэн мэдээлэл гаргах нь тухайн иргэний эрх, ашиг сонирхол нь хөндөгдөөгүй боловч нийтийн буюу бусдын эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд тэдгээрийг төлөөлөн хандаж буй явдал юм. Энэ талаар доктор Ц.Сарантуяа "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргах болсон явдал нь өөрөө шүүхэд хандах зүй тогтолд нийцэхгүй байна. Үндсэн хуулийн цэцэд хандаж мэдээлэл гаргах хүнд ямар ч шалгуур байхгүй байгаа нь заримдаа сөрөг үр дагавар дагуулдаг. Мэдээллийг алдаатай шийдвэрийг мэргэжлийн хүн эсхүл бусад иргэн хянуулахаар гаргаж байгаагаас гадна улс төржүүлэх зорилгоор, эсхүл бусдын захиалгаар гаргаж байна. Энэ мэдээлэл гаргахыг хуулиас гаргавал Үндсэн хуулийн цэц улс төржилгүйгээр үйл ажиллагаагаа явуулах боломжтой байна"¹² гэж үзжээ.

9 Мөнхсайхан, Р.Очирбал, *Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал*, (УБ, 2021).

10 О. Мөнхсайхан, "Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж", "Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015), 64-81 дэх тал.

11 Ц.Сарантуяа, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт", *Ж.Амарсанаа нар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц: өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл*, (УБ, 2007), Хууль зүйн үндэсний төв, 232-233 дахь тал.

12 "Үндсэн хуулийн эрх зүй ба цаашдын чиг хандлага" сэдэвт хуралдааны хэсгээс, Хуульчдын форум (УБ, 2018).

Зарим орны жишээг харвал, иргэн нь үндсэн эрхээ нийтийн эрх зүйн аливаа субъектийн үйлдэл, эс үйлдэхүйгээр зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байдаг. Гэхдээ иргэн, хуулийн этгээд нь Үндсэн хуулийн шүүхэд хандахын өмнө тухайн маргааныг хуульд заасан бусад бүх шүүхийн шат дамжлагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг урьдчилан авсны дараа Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой болдог байна. Үндсэн эрх нь иргэн өөрт нь хамааралтай байдлаар зөрчигдсөн тохиолдолд л тухайн иргэн Үндсэн хуулийн шүүхэд ханддаг нийтлэг зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, иргэн Цэцэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шууд хандах боломжийг олгохдоо Цэцийн ачаалал, хэрэг маргаан шийдвэрлэлтийн чанарын асуудлыг анхаарах нь зүйтэй. Иймд өргөдөл, мэдээлэл гаргахад тодорхой “босго” тогтоох ёстой. Цэцийн ачаалал, ердийн шүүхийн хяналтын давхардлаас урьдчилан сэргийлэх үүднээс Цэцэд хандахын өмнө бусад шүүхийн хяналтыг хэрэгжүүлсэн байх шаардлага тавигдах нь мэдээж.

Ийнхүү Цэц иргэний үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэснээр Үндсэн хуульд ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг хангах юм. Түүнчлэн хүний субъектив үндсэн эрхийг Цэц хамгаалах явдал нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болно. Энэ нь үндсэн хуулийн шүүхийн хяналтад харъяалагдах субъектийн үйл ажиллагаанд Үндсэн хуулийн заалт нэг бүрийг хэрэгжүүлэхийг шаардах, зөрчил гаргасан тохиолдолд арилгуулах чиг үүрэг гүйцэтгэх явдал юм.¹³ Тодруулбал, Цэцээс Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх нь Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих улмаар хүний эрхийг хамгаалах хэрэгсэл болно. Зарчмын хувьд иргэний өргөдөл, мэдээлэл нь Үндсэн хуульд заасан субъектив үндсэн эрх хэрэгжих баталгаа байх ёстой.¹⁴

Дүгнэвэл, Цэцэд иргэний үндсэн эрхийн маргааныг харъяалуулах болон энэ хүрээнд Цэцэд хандах босго, шаардлагыг зохистой тодорхойлох нь Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчлэх чухал хэрэгцээ, шаардлага гэдгийг эрдэмтэн судлаачид дэвшүүлсэн байна.

3.2. Цэцэд хандах арга, хэлбэр-Тулгамдсан асуудал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар өргөдөл, мэдээллийг иргэд; хүсэлтийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор гаргах эрхтэй.” гэснээр Цэцэд хандах субъектийг иргэн, тодорхой нэгэн албан тушаалтан байхыг тодорхойлж эдгээр субъект нь өргөдөл, мэдээлэл, хүсэлт гэсэн хэрэгслийг ашиглан хүсэл зорилгоо илэрхийлэн Цэцэд хандана. Дээрх арга хэрэгслийн төрлөөс үл хамааран Цэцээс бүхэлд нь хянан хэлэлцэхээр заасан боловч, иргэний гаргасан өргөдөл, мэдээллийг Цэцийн маргааны зүйл мөн эсэхийг хууль журамд заасны дагуу урьдчилан шалгаж маргаан үүсгэх эсэхийг тогтоодог ч төрийн өндөр албан тушаалтан, эрх бүхий байгууллагын хүсэлтийг шууд хэлэлцэхээр ялгавартай үзсэн нь Үндсэн хууль дахь хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш байх зарчимд үл нийцэх тул адил процедурыг тогтоож өгөх нь

13 Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, (УБ, 2007), 287 дахь тал.

14 Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн, (УБ, 2023).

оновчтой байж болох юм.¹⁵

Харин Үндсэн хуулийн 66.1 дүгээр зүйлд Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргахаар заасныг УИХ-ын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гэж ойлгож ирсэн учраас УИХ-ын зүгээс Цэцэд хандах эсэх нь УИХ дахь олонхийн санаачилгаас хамаардаг бөгөөд хууль тогтоомж Үндсэн хууль зөрсөн гэж үзвэл уг олонх нь Цэцэд хүсэлт гаргахгүйгээр тухайн хууль тогтоомжийг хүчингүй болгох, өөрчлөх боломжтой¹⁶. Өөрөөр хэлбэл УИХ хууль санаачлан батлахдаа олонхийн саналын дүнд тулгуурлан баталдаг. Үүнтэй адил зарчмаар Үндсэн хуулийн цэцэд хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн асуудлаар хандах нь боломжгүй болж байгаа юм. УИХ олонхийн саналаар баталдаг хууль тогтоомжийн хувьд мөн олонхийн саналаар Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хууль зөрчсөн талаар хүсэлт гаргах шаардлага гарахгүй байгаа юм. Тухайлбал, “Үндсэн хуулийн цэц 1992 оны 7 дугаар сард байгуулагдсанаас 2015 оны 12 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд нийт 2067 өргөдөл, мэдээлэл, хүсэлт хүлээн авчээ. Эдний ихэнх нь иргэдээс ирсэн өргөдөл байна. Харин Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан хүсэлтийг тооны хувьд авч үзвэл Ерөнхий прокуророос 1, Дээд шүүхээс 6, Ерөнхийлөгчөөс 2, нийт 9 хүсэлт хүлээн авсан бөгөөд Улсын Их Хурлаас 24 жилийн хугацаанд хүсэлт ирж байгаагүй байна.” гэсэн статистикийг¹⁷ дурдаж болно. Иймд эрх бүхий албан тушаалтан Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах зарчмыг хэрэгжүүлж, УИХ бус, УИХ-ын гишүүн дээрх асуудлаар хүсэлт гаргадаг байхаар хуульчлах нь зүйтэй гэж үздэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн зохион байгуулалтын бас нэгэн өвөрмөц шинж нь Үндсэн хуулийн 66.3 дугаар зүйлд заасны дагуу түүний шийдвэрийг парламент нэг удаа буцааж болдог явдал юм. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн дагуу Цэц маргааныг хэлэлцэж дүгнэлт гаргаад түүнийг Улсын Их Хуралд оруулдаг. Хэрэв дүгнэлтийг нь парламент хүлээн зөвшөөрөөгүй бол Цэц их суудлаараа дахин хянан үзэж эцсийн шийдвэр болох тогтоол гаргана. Цэцийн тогтоолыг бүх холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд дагаж мөрдөх үүрэг хүлээдэг. Гэвч Улсын Их Хурлаас Цэцийн дүгнэлтийг хэрхэн хэлэлцэх талаар тодорхой журам байдаггүйгээс Цэцийн маргаан шийдвэрлэх хугацаа сунжирч удаашрах нь бий. Дээрх асуудалтай холбогдуулан Ч.Энхбаатар, Том Гинсбург, О.Мөнхсайхан, Д.Солонго нар “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” бүтээлдээ дараах дүгнэлтийг өгсөн. Үүнд:

“...Цэцийн дүгнэлтийг хэрхэн хянаж шийдвэрлэх талаар тодорхой журам байхгүйгээс гадна уг асуудал нь УИХ-ын гишүүнчлэлтэй холбоотой тул Улсын Их Хурал улс төрийн хувьд хүчирхэг хууль тогтоогчдын талд орж Цэцийн дүгнэлтийг буцаах эрсдэл үүсч байна. Бидний үзсэнээр, өөрөө өөрийнхөө асуудлыг шийдэх эрсдэл байгаа тул УИХ-ын гишүүний талаар гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хянах нь зохисгүй юм. Үндсэн хуулиар Үндсэн

15 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар*, (Адмон принт, 2022), 990 дэх тал.

16 О.Мөнхсайхан, *Үндсэн хуулийн цэцийн маргааны харьяалал, бие даасан, мэргэшсэн байдлыг дээшлүүлэх нь*, Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 59 дэх тал.

17 Ч.Энхбаатар нар, *Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ* (УБ, 2016), Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, 176 дахь тал.

хуулийн цэцийг Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, хараат бус байгууллага хэмээн тодорхойлсон. Иймд Үндсэн хуулийн 66.2.3 ба 66.2.4 дэх заалтуудад дурдсан асуудлаар гарах Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэж, зөвшөөрөх эсэх тухай асуудал нь Цэцээс Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрхийг зүй бусаар үгүйсгэж байгаа явдал юм. Бид Улсын Их Хурлын тухай хуульд Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийн хууль зүйн үндэслэлийг хянаж шийдвэрлэх талаар нэмэлт тодруулга оруулахыг зөвлөж байна.”

Түүнчлэн Үндсэн хуулийн цэц нь хүний эрхийг хамгаалах чухал механизм болдог тул Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны уялдааг хангах асуудал хөндөгддөг. Тухайлбал, Монгол Улсын Хүний эрхийг хангах хөтөлбөрийн 1.1.3.2.2-т “Хүний эрхийн үндэсний комисст Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон Засгийн газрын гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний талаархи заалтыг зөрчсөн тухай асуудлаар иргэдээс гомдол гаргахад тэднийг төлөөлөн Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх эрх эдлүүлнэ” гэж заасан арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэхдээ “...Хүний эрхийн үндэсний комисс ҮХЦМХШТХ-ийн 20.1.2-т заасныг үндэслэн иргэдийг төлөөлөн Үндсэн хуулийн Цэцэд хандах боломж бүрэн байна.” гэсэн зөвлөмжийг дэвшүүлж байжээ.

Иймд иргэний үндсэн эрх зөрчигдсөн асуудлаар ХЭҮК мэдээлэл гаргах нөхцөлийг хуульчлан бүрдүүлж, зохистой арга, хэлбэрийг тусгах нь зүйтэй. Үүнээс гадна иргэн өөрөө болон төлөөлөгч этгээдээр дамжуулан өргөдөл гаргах, төрийн бус байгууллагад хандаж иргэний үндсэн эрх зөрчигдсөн талаар мэдээлэл гаргах замаар Цэцэд хандаж эрхээ хамгаалах нөхцөл, боломжийг нэвтрүүлэх боломжтой.

Түүнчлэн Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ” гэж, ҮХЦМХШТХ-ын 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “1.Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар өргөдөл, мэдээллийг иргэд; хүсэлтийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор гаргах эрхтэй.” гэж тус тус заасан. Гэвч практикт “өргөдөл” болон “мэдээлэл”-ийн зааг ялгаа төдийлөн тодорхой биш байгаа бөгөөд Цэц зарим тохиолдолд ялгаа заагийг гаргадаггүй талаар судлаачид шүүмжилсэн байна.¹⁸ Тухайлбал, Судлаач, профессор О.Мөнхсайхан “өргөдлийг үндсэн хуулийн гомдол” гэж, мэдээллийг “action popularis” биш “amicus curiae” буюу тайлбар гэж ойлгох нь зүйтэй¹⁹ гэж үзсэн бол, судлаач, профессор Н.Лүндэндорж “өргөдөл” бол өөрт болон нийтэд хамаатай ямар нэг асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий этгээдэд хувь хүнээс хандаж гаргасан нэрнээс үл хамаарах хүсэлт гуйлт, гомдол юм гэж, харин “мэдээлэл” нь ямар нэг зүйлийн талаар өөрт холбогдуулан хүсэх, гуйх утгыг агуулдаггүй. Харин зохих этгээдэд мэдэгдэх, сонсгох зориулалттай үйлдэл...Үндсэн

18 О. Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015), 66 дахь тал.

19 Х.Сэлэнгэ, Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын объектыг сайжруулах арга зам: Онол, практикийн асуудал, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), (УБ, 2023), 39 дэх тал.

хуулиа цэвэр ариун байлгах, дээдлэн хүндэтгэх үүргийн үүднээс ийнхүү хандаж байгаа учраас өөрт хамаатай асуудлаар өргөдөл гаргагчаас зарчмын ялгаатай... Ийнхүү дээрх хэм хэмжээнд мэдэгдэх, сонсоход шууд чиглэсэн “мэдээлэл” гаргах эрхийг тусгайлан зохицуулсан нь өргөдлийг өөрт хамааралтай асуудлаар гаргах нь гэсэн логик гаргалгаанд зүй ёсоор хүрч байна”²⁰ гэж тайлбарлажээ. Гэтэл Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Өргөдөл нь санал, мэдэгдлийн шинжтэй байж болно” гэж заасан. Үүнээс үзвэл одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид “өргөдөл” болон “мэдээлэл”-ийн ялгаа тодорхой тусгагдаагүй бөгөөд судлаачид ч мөн харилцан адилгүй байр суурьтай байх тул “өргөдөл” болон “мэдээлэл”-ийн агуулгыг тодорхой тусгах шаардлага байсаар байна.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд зааснаар өргөдөл, гомдол, мэдээлэл, хүсэлт хүлээн авч хянан шийдвэрлэдэг. ИТБАТГӨГШТХ-ийн 9 дүгээр зүйлд өргөдөл гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болохоор тусгасныг харгалзан орчин цагийн нөхцөл байдалтай уялдуулан Үндсэн хуулийн цэцэд иргэд, эрх бүхий албан тушаалтан цахим хэлбэрээр хандах хэлбэр мөн анхаарлын гадна үлдэх учиргүй.

3.3. Цэцэд маргаан үүсгэх ажиллагаа- Тулгамдсан асуудал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ” гэж тусгасан.

Маргаан үүсгэх эсэх талаар шийдвэр гаргах хугацаа

Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах нь Үндсэн хуулийн зөрчлийг таслан зогсоох гол хөшүүрэг болоод зогсохгүй, нөгөө талаас ач холбогдолгүй хүнд процесс буюу эрх зүйн үр дагаваргүй хуралдаан хийхээс сэргийлэх, улмаар бусад маргааны талаар үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлдэг.²¹ Өөрөөр хэлбэл, Цэцийн урьдчилан шалгах ажиллагаа нь Цэцэд маргаан хянах шийдвэрлэх ажиллагааны нэгэн чухал хэсэг тул уг ажиллагааг хэрэгжүүлэх субъект, журам, хугацааг нарийвчлан тогтоох нь чухал ач холбогдолтой. Үндсэн хуулийн цэцийн гишүүн иргэний мэдээллийг хүлээн авснаас 14 хоногийн дотор маргаан эсэх талаар шийдвэр гаргахаас хуульд тусгасан ч уг үе шатанд ямар арга хэмжээ авах талаар зохицуулалтгүй. Практикт энэ үе шатанд Үндсэн хуулийн маргаан мөн эсэхийг тогтоохын тулд холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тайлбар, тодорхойлолт, лавлагаа бичгээр авах, ижил төстэй хэргийн лавлагаа, судалгаатай танилцах, судалгаа хийх зэрэг ажиллагааг хийдэг. Гэвч 14 хоногийн дотор дээрх чиг үүргүүдийг гүйцэтгэх хугацаа хангалтгүй байдгаас үүдэн хугацааг сунгах асуудал олон тохиолддог байна. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээллийн 70 гаруй хувийг нэг гишүүний тогтоолоор маргаан

20 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар*, (Адмон принт, 2022), 992-993 дахь тал.

21 Н.Болортунгалаг, *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Эрх зүйн зохицуулалтын хүрээнд)*, Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 115 дахь тал.

хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байдаг бөгөөд тэдгээрийн 40-50 хувьд нь урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хугацааг сунгасан статистик үзүүлэлт бий.²²

Бусад улсад уг хугацааг 30 ба түүнээс дээш хоног байхаар зохицуулсан нь нийтлэг байна. Тухайлбал, ОХУ-д урьдчилсан судалгааг 2 сарын дотор хийдэг бол, Австри, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бусад шатуудын адил тодорхой хугацаа заадаггүй байна. БНСУ-ын тухайд иргэдийн гомдлыг урьдчилан шалгаад 30 хоногийн дотор Бага суудлын бүрэлдэхүүнээс татгалзсан шийдвэр гаргаагүй бол маргаан үүссэнд тооцдог зохицуулалт бий.²³

Ийнхүү урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хугацааг 14 хоногоор тогтоосон нь практикт хүндрэл учруулаад зогсохгүй, судлаачдын шүүмжлэлд өртөж байна.

Үндсэн хуулийн шүүх үр дүнтэй байхын тулд хангалттай тооны шүүгчтэй байх, процедур нь хэтэрхий төвөгтэй биш байх, хувь хүмүүсээс ирүүлсэн Үндсэн хуулийн ноцтой асуудал хөндөөгүй агуулга бүхий гомдлыг шүүх өөрөө хэрэгсэхгүй болгох эрх эдэлдэг байхыг шаарддаг талаар Венецийн комиссоос тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх эсэх талаар шийдвэрлэх ажиллагаа нь хэт төвөгтэй бус байх, мөн Үндсэн хуулийн маргаанд хамаарахгүй асуудлыг хурдан шуурхай хэрэгсэхгүй болгох боломжтой байх нь зүйтэй.²⁴ Өөрөөр хэлбэл, шүүх илт үндэслэлгүй хэргийг хүлээн авахаас татгалзах нь хэргийн буюу шүүхийн хэт их ачааллаас зайлсхийх шүүлтүүр болдог.²⁵ Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэхээс татгалзах үндэслэлийг хуулийн 21 дүгээр зүйлд тусгасны нэг нь гомдол, мэдээлэл, хүсэлт нь хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байх тохиолдол юм. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар иргэн, байгууллага, албан тушаалтан Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

1. Өөрийн нэр, хаяг, оршин суугаа газар, харилцах хэлбэр;
2. Түүний итгэмжилсэн төлөөлөгч буюу өмгөөлөгчөөр оролцох хүний нэр, хаяг, албан тушаал, бусад шаардлагатай мэдээлэл;
3. Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомжийн нэр, батлан гаргасан он, сар, өдөр, дугаар, түүнчлэн Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа албан тушаалтны нэр, хаяг үйл ажиллагааны талаар;
4. Өөрийн шаардлагын үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоо;
5. маргаж байгаа асуудлын талаархи өөрийн байр суурь;
6. Цэцээр шийдвэрлүүлэхээр тавьж байгаа шаардлага;
7. Үндсэн хууль болон энэ хуулийн ямар зүйл, хэсэг, заалтыг үндэслэн Цэцэд хандаж байгаа;

22 Н.Болортунгалаг, *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Эрх зүйн зохицуулалтын хүрээнд)*, Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 115 дахь тал.

23 БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, 72 дугаар зүйл.

24 *Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл*, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 91 дэх тал.

25 Мөн тэнд.

8. Хавсаргасан бичиг баримт болон холбогдох хүмүүсийн нэрсийн жагсаалт, тодорхой хаяг.

Мөн тус зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Цэц нь нэргүй өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээж авахгүй. Практикт дээрх шаардлагыг хангаагүй, илтэд үндэслэлгүй хүсэлт, мэдээлэл олноор ирдэг бөгөөд ирсэн хүсэлт, мэдээлэл бүрийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн хянан шалгадаг байна. Зарим судлаачид Үндсэн хуулийн цэцийн гишүүний ачааллыг бууруулах, холбогдох маргаанд төвлөрөн ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс хэлбэрийн шаардлага хангуулах, түүнийг хянах чиг үүргийг Цэцийн тамгын газар хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэх нь бий.

Маргаан үүсгэх эсэх талаар шийдвэрлэх субъект

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Иргэн, байгууллага, албан тушаалтнаас Цэцэд гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн дарга уг асуудлыг хянан шалгах гишүүнд хуваарилна” гэж, 2 дахь хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, Цэцэд маргаан үүсгэх эсэхийг Цэцийн гишүүн дангаараа шийдвэрлэх бүрэн эрхтэй байхаас гадна Цэцийн гишүүн ийнхүү маргаан үүсгэх эсэхийг шалгахдаа Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан маргаан үүсгэхээс татгалзах 4 үндэслэлээс дурдалгүйгээр маргаан үүсгэхээс татгалзах тохиолдлууд байдаг талаар судлаачид онцлон тэмдэглэжээ.

Бусад улсын туршлагыг судалж үзвэл ихэнх тохиолдолд маргаан үүсгэх эсэх асуудлыг 3-5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж байх бөгөөд уг шүүгчид санал нэгтэй татгалзсанаас бусад тохиолдолд маргаан үүссэнд тооцох зохицуулалт нийтлэг байна.²⁶ Гишүүдийн нэгдсэн саналаар хэргийг хүлээн авахаас татгалзах бөгөөд ийнхүү гаргасан шийдвэрт гомдол гаргах боломжгүй байхаар зохицуулах нь шүүхийн хэт ачааллаас зайлсхийх нэгэн арга байж болохыг дурджээ.²⁷ Иймд хэлбэрийн шаардлагыг хангуулах, хянах чиг үүргийг Тамгын газарт эсхүл тусгай чиг үүрэг бүхий захиргааны ажилтан хэрэгжүүлэх, ийнхүү хэлбэрийн шаардлага хангасан гомдлыг хүлээн авч, бага суудлын хуралдаанаар маргаан үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх, ингэхдээ гишүүд санал нэгтэй татгалзсанаас бусад тохиолдолд маргаан үүссэнд тооцох, ийнхүү гаргасан шийдвэрт гомдол гаргахгүй байх зохицуулалтыг хуульд тусгах нь Цэцийн ачааллыг бууруулах ач холбогдолтой.

26 Н.Болортунгалаг, *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Эрх зүйн зохицуулалтын хүрээнд)*, Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 118 дахь тал.

27 *Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл*, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 93 дахь тал.

Өргөдөл, мэдээллээс татгалзах үр дагаврыг зохицуулах талаар

Хэдийгээр Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах нь иргэний хэрэгжүүлэх эрх боловч иргэн гаргасан өргөдөл, гомдлоосоо татгалзсаны дараа тухайн гомдлыг нийтийн ашиг сонирхлын үүднээс шүүх үргэлжлүүлж хянан шийдвэрлэж болдог.²⁸ Энэ нь гомдол гаргагч улс төрийн дарамт шахалтын улмаас гомдлоосоо татгалзах явдлаас сэргийлэхэд чиглэдэг. Иймд дээрх зохицуулалтыг тодорхой болгох, ийнхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс маргааныг үргэлжлүүлэн хянах эрхтэй байх тохиолдолд нийтийн ашиг сонирхол гэдэгт юуг ойлгох талаар тодруулах нь Үндсэн хуулийн шүүх мөрдөн шалгах чиг үүрэг хэрэгжүүлэхээс зайлсхийнэ.

Дүгнэвэл, Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх эсэхийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан зохицуулах, ингэхдээ өргөдөл, мэдээлэл шалгах хугацааг уртасгах, Цэцэд ирэх гомдлын тоо жилээс жилд ихсэх үзүүлэлттэй байгааг харгалзан хэлбэрийн шаардлагыг шалгах чиг үүргийг Тамгын газарт шилжүүлэх, маргаан үүсгэх эсэх шийдвэр гаргах бүрэн эрхийг Цэцийн 1 гишүүнд олгосныг өөрчилж, бага суудлын хуралдаанаар санал нэгтэй шийдвэрлэхийг шаардах, ийнхүү санал нэгтгэйгээр шийдвэрлээгүй тохиолдолд маргаан үүссэнд тооцох, цаашлаад өргөдөл, мэдээлэл өгсөн этгээдийн тухайн шатанд хүлээх эрх, үүргийг тодорхой болгох шаардлага байсаар байгааг дурдах нь зүйтэй байна.

3.4. Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн- Тулгамдсан асуудал

Тус хуулийн 3 дугаар зүйлийг Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн гэж томъёолсон байх боловч процессын асуудлыг бас агуулсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд Цэцэд харьяалан шийдвэрлэх маргааныг тодорхой жагсаасан. Харин тухайн маргааныг ямар бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх процессын хэм хэмжээг органик хуулиар зохицуулсан. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Цэцийн хуралдааныг дараах бүрэлдэхүүнтэй хийх ба бүрэлдэхүүний тоо нь хэлэлцэх асуудлаас хамаардаг²⁹:

Хүснэгт 6.3. Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн

Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн, нэр	Хэлэлцэх асуудал, шийдвэр гаргах эрх
Бага суудал (3 гишүүн)	<ul style="list-style-type: none"> Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг үндэслэн маргаан үүсгэх эсэх Хэлэлцэж байгаа асуудлыг Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
Дунд суудал (5 гишүүн)	<ul style="list-style-type: none"> Цэцийн хуралдаанд оруулахаар маргаан үүсгэн шалгасан бүх асуудал Хэлэлцэж байгаа асуудлыг Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
Их суудал (7-9 гишүүн)	<ul style="list-style-type: none"> Цэцийн хуралдаанаас гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй, урьд шийдвэрлэсэн маргааны талаар шинэ учир байдал илэрсэн, Цэцийн нийт гишүүдийн олонхийн саналаар дахин хянаж эцэслэн шийдвэрлэх

28 Мөн тэнд, 137 дахь тал.

29 Н.Отгончимэг, *Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орны туршлага судлах харьцуулсан судалгаа*, (УБ, 2019).

<p>Их суудал (7-9 гишүүн)</p>	<ul style="list-style-type: none"> • Хуульд заасан албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх, түүнийг огцруулах болон эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудал Хэлэлцэж байгаа асуудлыг Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гэхдээ Цэц маргааныг дахин хянан үзэж буй бол асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр хувийн саналаар эцэслэн шийдвэрлэнэ.
-----------------------------------	---

Ийнхүү Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Цэцийн бүрэлдэхүүнийг тодорхойлох зорилготой мэт боловч тухайн зүйлд Цэцийн бага, дунд, их суудлын хуралдаанаар асуудал хэлэлцэж шийдвэрлэх харилцааг хамтад нь зохицуулсан байгааг анхаарах нь зүйтэй. Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тусгасан, хэлэлцэж байгаа асуудлыг Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн зарчмыг хангахын тулд бага, дунд, их суудлын хуралдаанаар ямар маргааныг хэрхэн шийдвэрлэх процессын асуудлыг нэг заалтаар бус маргааны төрлөөр нь ялгамжтай, нарийвчлан хуульчлах шаардлага ажиглагдаж байна.

Дээрх зохицуулалтаас үзэхэд, Цэцийн хуралдаанд оруулахаар маргаан үүсгэн шалгасан бүх асуудлыг анхлан шийдвэрлэх хуралдааныг 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэж, 5 гишүүний олонхийн буюу 3 гишүүний саналаар маргаан шийдвэрлэж байгаа нь Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ” гэж заасантай нийцдэггүй. Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ” гэж, мөн хуулийн 66 дугаар зүйлд Цэцээс шийдвэрлэх маргааныг тогтоосон.

Гэвч Үндсэн хуулийн шүүх нь өөрийн бүрэлдэхүүнээрээ ашиг сонирхлын ялгаа бүхий бүлгүүдээс хараат бус байх нөхцөлөө баталгаажуулж, энэхүү олон ургалч үзэл бүхий байдалд сайтар анхаарсан шүүхийн шийдвэрүүдийг бий болгоход хувь нэмрээ оруулах ёстой.³⁰ Үндсэн хуулийн шүүхийн легитм шинж хийгээд түүний шийдвэрүүдийг нийгэм хүлээн зөвшөөрөх эсэх нь тус шүүхээс нийгмийн янз бүрийн үнэт зүйлсийг хэрхэн авч үзэж байгаагаас ихээхэн шалтгаалдаг.³¹ Үндсэн хуулийн цэц 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар хуульд тусгасан атал бодит байдал дээр маргааныг 3 шүүгчийн саналаар шийдвэрлэж байгаа нь дээр дурдсан Үндсэн хуулийн шүүхийн легитм чанарыг алдагдуулах сөрөг үр дагавартай. Бусад улсын туршлагыг авч үзвэл ихэнх тохиолдолд маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүний тоо харьцангуй их байна. Үүнийг тодруулан авч үзвэл:

ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхнийт 16 шүүгчтэй ба тэдгээр нь 8,8 шүүгчтэй хоёр танхимд хуваарилагдан дараах бүрэлдэхүүнтэй харьяаллын асуудлаа шийдвэрлэж байна. Танхим бүр тухайн жил эхлэхийн өмнө 3 шүүгчээс бүрдэх Шүүгчдийн бүрэлдэхүүнүүдийг томилж, маргаан болон гомдлыг хуульд заасан журмын дагуу хуваарилж шийдвэрлүүлдэг. Шийдвэрийг санал нэгтэй тохиолдолд гаргадаг ба хэрэг санал нэгдэж чадаагүй бол тухайн хэргийг 8 шүүгчийн бүрэлдэхүүнтэй Сенат шийдвэрлэдэг. Шийдвэрийг амаар явагдах хуралдаанаар биш, харин бичгээр явагдах процессын үндсэн дээр гаргадаг. Шүүгчдийн бүрэлдэхүүнийг 3-аас илүү жил өөрчлөлтгүй байлгаж болохгүй. Хуралдаанд 6 шүүгч оролцсоноор ирц бүрдэнэ.

30 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 19 дэх тал.

31 Мөн тэнд.

Хуульд заасан зарим маргааныг хуралдаанд оролцсон шүүгчдийн 2/3-ын саналаар, бусад маргааныг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль болон Үндсэн хуулийн шүүхийн дүрэмд хэрэг, маргааныг бага, их танхимаар шийдвэрлэх зохицуулалт байхгүй. Харин 1995 онд баталж мөрдөж байсан Үндсэн хуулийн шүүхийн дүрэмд зааснаар маргааныг 10 болон 9 шүүгч шүүгчээс бүрдэх их, бага танхим харьяалан шийдвэрлэж байсан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулийн шүүхийн дүрмийг 2011 онд баталсан бөгөөд түүнд Үндсэн хуулийн шүүхийг шүүгчдийг танхимуудад хуваарилах зохицуулалт тусгагдаагүй.

Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 4-р зүйлд “Үндсэн хуулийн шүүх нийт шүүгчийн 2/3 байгаа тохиолдолд бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрхтэй” гэж зааснаас үзвэл Үндсэн хуулийн шүүхийн хуралдаан нийт 19 шүүгчийн 13 нь оролцсоноор ирц хүчинтэйд тооцдог байна.

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 3 гишүүнтэй Салбар хуралдаанаар Шүүхэд гаргасан гомдлыг урьдчилан шалгадаг. Гомдлыг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гаргах бүрэн эрхтэй ба энэ тохиолдолд санал нэгтгэйгээр шийдвэр гаргах ёстой. Салбар хуралдаан хүлээн авахаас татгалзсанаас бусад бүх гомдол Их суудлын хуралдаанд (7-9 шүүгчийн бүрэлдэхүүнтэй) шилжинэ. Хүлээн авахаас татгалзах шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаагүй бол гомдол Их суудлын хуралдаанд шилжсэнд тооцдог. Оролцож байгаа шүүгчдийн олонхийн саналаар шийдвэр гаргана. Гэхдээ дараах асуудлыг 6 ба түүнээс дээш шүүгчийн саналаар шийдвэрлэх ёстой. Тухайлбал, хууль үндсэн хуульд нийцсэн эсэх, импичмент, улс төрийн намыг татан буулгах, үндсэн хуулийн гомдлыг хангах, Үндсэн хууль, эсхүл хууль тайлбарласан, хэрэглэсэн Үндсэн хуулийн шүүхийн өмнөх шийдвэрийг хүчингүй болгох асуудал багтдаг.

Латви Улсад Үндсэн хуулийн шүүх хэргийг хамтын зарчмаар хянан шалгах ба тогтоол, шийдвэр, дүгнэлт гаргахдаа нийт шүүгчдийн 2/3-оос доошгүй нь оролцсон байх шаардлагатай. Үндсэн хуулийн шүүхийн тогтоол, дүгнэлт болон тодорхой тогтоол, дүгнэлтийг тайлбарлах тухай шийдвэрийг Үндсэн хуулийн шүүхийн нийт шүүгчийн олонхийн саналаар батална. Үүнээс бусад Үндсэн хуулийн шүүхийн актыг хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхийн саналаар баталдаг.

Иймд Үндсэн хуулийн цэц 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар хуульд тусгасан атал бодит байдал дээр маргааныг 3 шүүгчийн саналаар ч шийдвэрлэж болох байдал нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй гэж үзэж, Цэцийн дотоод бүрэлдэхүүн буюу бага, дунд, их суудлын бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх эсхүл шийдвэр гаргах саналын квотыг нэмэгдүүлэх, шаталсан зарчмаар дахин хэлэлцэж шийдвэрлэх гэх мэтээр гадаад орнуудын сайн туршлагыг нутагшуулж хуульчлах замаар Үндсэн хуулийн шүүхийн легитм чанарыг дээшлүүлэх шаардлага байна гэж үзлээ.

Хэдийгээр иргэдээс ирсэн гомдлыг цөөн тооны гишүүдээс бүрдэх бүрэлдэхүүнээр шийдэж, онцгой чухал асуудлыг шүүх үндсэн бүрэлдэхүүнтэйгээр шийдэхийг хэргийн ачааллыг бууруулах оновчтой арга зам гэж үздэг ч манай улсын хувьд иргэнээс ирүүлсэн мэдээлэл, эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн хүсэлт аль алийг нь дунд суудлын хуралдаанаар шийдвэрлэдэг тул дунд суудлын

хуралдааны бүрэлдэхүүнийг нэмэгдүүлж, ингэхдээ хэргийн хуваарилалтыг аливаа этгээдийн дур зоргоос ангид байлгахад чиглэсэн тохиолдлын журамд суурилах зарчмыг нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

3.5. Хэргийн харьяалал тогтоох Цэцийн оролцоо - Тулгамдсан асуудал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасан. Уг хууль хүчин төгөлдөр болсноос хойш иргэдээс 30 гаруй удаа хэргийн харьяалал тогтоолгохоор хандсан байна. Харин 2005, 2010, 2017 онд холбогдох гомдлын дагуу маргаан үүсгэн Дунд суудлын хуралдаан хийжээ.³² Тодруулбал, Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 03, 2010 оны 08 дугаар магадлалаар тус тус иргэний гомдлын хүрээнд хэргийн харьяалал тогтоох үндэслэлгүй байна гэсэн шийдвэрийг гаргасан байна. Харин 2017 оны 11 дүгээр магадлалаар харьяалал тогтоож, Улсын дээд шүүхээр шийдвэрлүүлэх шийдвэр гаргажээ.³³

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд Улсын дээд шүүх, түүний бүрэн эрхийн талаар тусгахдаа 25.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох” бүрэн эрхийг олгосон. Ингэснээр Дээд шүүхийн бүрэн эрхээр шийдвэрлэх асуудлыг практик дээр, Үндсэн хуулийн цэцэд хэргийн харьяалал тогтоох тухай мэдээлэл ирүүлснээр Үндсэн хуулийн цэц хянаад тус маргаан нь Үндсэн хууль зөрчөөгүй тохиолдолд Цэцийн гишүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхээс татгалзаж Дээд шүүх рүү шилжүүлдэг байна. Өөрөөр хэлбэл нэг асуудлыг хоёр шүүхэд өөр өөр хууль зүйн үндэслэлээр шийдвэрлэж байна. Үүнийг аль нэг шүүхийн бүрэн эрхэд харьяалуулж нэг мөр шийдвэрлэснээр Үндсэн хуулийн цэцийн ачаалал буурч, чиг үүрэгт үл харьяалагдах асуудлаа шийдвэрлэхгүй байх боломжтой юм.³⁴

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасныг хасаж, хууль тогтоомж хоорондын уялдааг хангах нь зүйтэй юм. Ингэснээр Цэц өөрийн чиг үүрэгт хамаарахгүй асуудлыг хүлээн авч шийдвэрлэх шаардлагагүй болж, ажлын ачаалал буурах ач холбогдолтой.

32 Н.Болортунгалаг, *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Эрх зүйн зохицуулалтын хүрээнд)*, Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 122 дахь тал.

33 Мөн тэнд.

34 Н.Болортунгалаг, *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Эрх зүйн зохицуулалтын хүрээнд)*, Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023), 122 дахь тал.

IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийг судалж, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийлээ.

Энэхүү судалгааны хүрээнд, дараах ерөнхий дүгнэлтэд хүрэв. Үүнд:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль одоогоос 26 жилийн өмнө батлагдсанаас хойш дорвитой шинэчлэгдээгүй учир хэт ерөнхий зохицуулалттай, Цэцэд хандах эрх, арга, хэлбэр хязгаарлагдмал, тодорхой бус, өргөдөл, мэдээлэл, хүсэлт хүлээн авах болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр гаргах оролцоог оновчтой, нарийвчилж журамлаагүй зэрэг дутагдал бий. Үүний улмаас тус хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсч, улмаар хүний эрхийн хамгаалал төдийгүй хүний эрх хамгааллын үндэсний механизмд сөрөг нөлөө үзүүлж байгааг олон талын судалгааны үр дүн харуулж байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн талаарх үндэсний эрх зүйн онол, практикийн болон харьцуулсан судалгаа нэлээд сайн хийгдсэн бөгөөд судалгааны үр дүнг хэлэлцэх, зөвлөлдөх ажиллагаа өрнөж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх хандлага сайжирсан байгааг онцлох нь зүйтэй.

Үндсэн хуулийн шүүхийн төдийгүй бусад шүүхийн байгууллагад маргаан хянан шийдвэрлэж буй дэлхий нийтийн чиг хандлага, олон улсын сайн туршлага болон Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн ололт амжилтыг тусган Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсийг шинэчлэн бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага тулгамдаж байгаа бөгөөд үүнийг зохицуулах нөөц боломж байна. Шинжлэх ухаанд суурилж, хууль тогтоомжийн шинэтгэлийг хийх утгаар авч үзвэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, хуулийг шинэчлэх үндэслэл хангалттай байна.

Энэхүү судалгаагаар, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ, Цэцэд хандах арга, хэлбэр, Цэцэд маргаан үүсгэх ажиллагаа, Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн, хэргийн харьяалал тогтоох Цэцийн оролцоотой холбоотой зарим асуудлыг хөндөж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн. Үнэлэх үе шатанд томъёолсон шалгуур үзүүлэлтийн дагуу судалсан үр дүнд тулгуурлан дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав. Үүнд:

Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ - Тулгамдсан асуудлын тухайд

Цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ нь иргэдийн өргөдөл, мэдээлэл болон эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтэд тулгуурладаг. Гэвч энэ хүрээг зохистой тогтоогоогүй, ялангуяа иргэний үндсэн эрхийн хамгааллыг орхигдуулсан бөгөөд үүнийг залруулах шаардлагатай хэмээн эрдэмтэн судлаачид санал нэгджээ. Үүнийг хуульд тусгах замаар ҮХЦМХШАТХ-ийн 15 дугаар зүйлийн 1

дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн заалтыг бодитой хэрэгжүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл болон бусад зүйлд заасан үндсэн болон түүнтэй адилтгах эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээхтэй холбоотой дээд хяналт тавих бүрэн эрхийг баталгаажуулан, иргэн субъектив үндсэн эрхээ хамгаалуулах Үндсэн хуулийн механизмыг бий болгох шаардлагатай.

Үүний зэрэгцээ Цэцэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр хандах боломжийг олгохдоо ердийн шүүхийн хяналтын давхардлаас урьдчилан сэргийлэх, Цэцийн ачаалал, хэрэг маргаан шийдвэрлэлтийн чанарын асуудлыг анхаарах үүднээс тодорхой босго шалгуур, шаардлагыг зохистой тогтоох нь зүйтэй.

Ингэснээр Цэц нь иргэний үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэж, Үндсэн хууль ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг хангах юм. Түүнчлэн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүнийг зөрчсөн тухай маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий, Үндсэн хуулийн шүүх байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болно.

Цэцэд хандах арга, хэлбэр - Тулгамдсан асуудлын тухайд

Цэц иргэдийн өргөдөл, мэдээллийг хянан шийдвэрлэхээс өмнө харьяаллын маргаан мөн эсэхийг урьдчилан шалгах босго тогтоосон бол эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтийг шууд хэлэлцдэг эрх зүйн орчин нь ялгавар бий болгож, улмаар хууль, шүүхийн өмнө хүн бүр тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг зөрчсөн үр дагаврыг үүсгэж байна.

Түүнчлэн УИХ олонхийн саналаар баталсан хууль тогтоомжоо Үндсэн хууль зөрчсөн хэмээн мөн олонхийн саналаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах шаардлага төдийлөн гарахгүй нь практикаар нотлогдсон асуудал юм. Иймд эрх бүхий албан тушаалтан Цэцэд хүсэлт гаргах зарчмыг хэрэгжүүлж, УИХ бус, УИХ-ын гишүүнд Цэцэд хандаж хүсэлт гаргах боломж олгох нь зүйтэй гэсэн судлаачдын байр суурийг дэмжиж байна.

Иргэдийн хувьд төлөөлөгчөөр дамжуулан, тухайлбал итгэмжлэгдсэн төлөөлөгч, түүнчлэн иргэний үндсэн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэдэг байгууллагууд, тухайлбал, ХЭҮК, хүний эрхийн чиглэлээр албан ёсны үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд иргэдийн үндсэн эрх зөрчигдсөн талаар өргөдөл, мэдээллийг гаргах нөхцөлийг хуульчлан бүрдүүлж, зохистой арга, хэлбэрийг тусгах нь зүйтэй.

Түүнчлэн, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд өргөдөл гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болохоор тусгасныг харгалзан, өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан Үндсэн хуулийн цэцэд иргэд, эрх бүхий албан тушаалтан цахим хэлбэрээр хандах боломжийг бүрдүүлбэл Цэцэд хандах субъект төдийгүй Цэцийн үйл ажиллагаанд шуурхай, хялбар, хэмнэлтэй байдал бий болох талтай.

Ийнхүү дээр дурдсан зохицуулалтыг тусгаж Цэцэд хандах арга, хэлбэрийн зохистой хувилбарыг хуульчилснаар, хүний эрхийг хамгаалах чухал механизм болдог утгаараа хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны уялдаа, холбоог хангах Цэцийн үүрэг бодитой биелэх үндэс бүрдэнэ.

Цэцэд маргаан үүсгэх ажиллагаа - Тулгамдсан асуудлын тухайд

Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх эсэхийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан зохицуулах, ингэхдээ өргөдөл, мэдээллийг шалгах хугацааг уртасгах, Цэцэд ирэх гомдлын тоо жилээс жилд ихэсэх үзүүлэлттэй байгааг харгалзан хэлбэрийн шаардлагыг шалгах чиг үүргийг Тамгын газарт шилжүүлэх, маргаан үүсгэх эсэх шийдвэр гаргах бүрэн эрхийг Цэцийн 1 гишүүнд олгосныг өөрчилж, бага суудлын хуралдаанаар санал нэгтэй шийдвэрлэх, ийнхүү санал нэгтгэйгээр шийдвэрлээгүй тохиолдолд маргаан үүссэнд тооцох, цаашлаад өргөдөл, мэдээлэл өгсөн этгээдийн тухайн шатанд хүлээх эрх, үүргийг тодорхой болгох зэрэг олон талын шаардлага практикт тулгамдаж байгааг хуульчлан шийдвэрлэх нь зүйтэй.

Нэг талаас, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа дахь талуудын оролцоо, эрх үүргийг нарийвчлан тодорхойлсон зохицуулалт, нөгөө талаас Цэц шийдвэрээ онолын түвшинд үндэслэл сайтай гаргах нөхцөлийг бүрдүүлж, дэмжлэг болохуйц зохицуулалт үгүйлэгдэж байгааг харгалзан шинэчлэл хийх хэрэгцээ, шаардлагыг хангах учиртай.

Ингэснээр Цэцийн маргаан шийдвэрлэх ажиллагааны төдийгүй иргэдтэй харилцах үйлчилгээний чанар сайжирч, хүний эрхийг хамгаалах чадамж дээшилнэ.

Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн - Тулгамдсан асуудлын тухайд

Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны Үндсэн хуулийн цэц 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар, Бага, Дунд, Их суудлын хуралдааны бүрэлдэхүүн, тэдгээрийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зохион байгуулалт, хэлэлцэж байгаа асуудлыг Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх зарчмыг хуульчилсан. Гэвч уг зарчим хангагдахгүй, улмаар Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байдлыг анхаарч, Бага, Дунд, Их суудлын хуралдаанаар маргаан шийдвэрлэх процессыг маргааны төрлөөр нь ялгамжтай, нарийвчилж хуульчлах шаардлагатай.

Цэцэд маргаан хянаж шийдвэр гаргах хамтын зарчмыг бүрдүүлэх, дотоод бүрэлдэхүүн буюу Бага, Дунд, Их суудлын бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх, улмаар шийдвэр гаргах процесс ажиллагааг тодорхой зохицуулах, ялангуяа Дунд, Их суудлын хуралдааны процесс, шийдвэр гаргах оролцоог нарийвчлах нь зүйтэй.

Энэ нь Үндсэн хуулийн шүүхийн легитм чанарыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийг “Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн” гэж томъёолсон хэр нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны гол харилцааг агуулсан байдлыг анхаарч, хуулийн бүтцэд тавигдах шаардлагын дагуу хууль зүйн техникийг сайжруулах, Үндсэн хуулийн цэцийн тухай хуультай давхардал үүсгэсэн байдлыг залруулах шаардлагатай.

Хэргийн харьяалал тогтоох Цэцийн оролцоо - Тулгамдсан асуудлын тухайд

Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг Үндсэн хуулийн цэц тогтоох(ҮХЦМХШАтХ), хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг Улсын дээд шүүх тогтоох(МУШтХ) эрх зүйн орчин үйлчилж байна. Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасныг хүчингүй болгох; эсвэл уг чиг үүргийг Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад тусгасан “хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг Улсын дээд шүүх хянан шийдвэрлэх” бүрэн эрхтэй уялдуулж, хэрэгжүүлэх процессыг хуульчлах шаардлагатай.

Ингэснээр хууль тогтоомжийн нэгдмэл байдал, уялдаа холбоог хангах, улмаар чиг үүргийн давхардал, хийдэл, зөрчил үүсэхээс сэргийлж, шаардлагагүй ачааллыг багасгах юм.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992).
3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, (1997).
4. Шүүхийн тухай хууль, (2021).
5. БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль.
6. ХБНГУ-ын Үндсэн хууль зэрэг хууль тогтоомж.

Ном, сурах бичиг, эмхэтгэл

1. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, (Уб, 2008).
2. Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, (Уб, 2007).
3. Г.Совд, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, (Уб, 2000).
4. Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй” Хоёр дахь хэвлэл, (Уб, 2021).
5. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, (Адмон принт, 2022).
6. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Анхны хэвлэл, (Уб, 2007).
7. Арне Мавчич, “Үндсэн хуулийн хяналт”, (Уб, 2014).
8. Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар, “Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж. /Боть 9/”, (Уб, 2022).
9. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, (Уб, 2021).
10. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), (Уб, 2023).
11. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2020.04.22 Санал № 2022CDL-PI(2020)004 “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”, (Уб, 2023).
12. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2021.02.22 Санал № 1004/2020 CDL-AD(2021)001 “Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”, (Уб, 2023).

Судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл

1. О. Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (Уб, 2015).

2. Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт”, Ж.Амарсанаа нар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц: өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, Хууль зүйн үндэсний төв, (УБ, 2007).
3. Н.Болортунгалаг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (Эрх зүйн зохицуулалтын хүрээнд), Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, (УБ, 2023).
4. “Үндсэн хуулийн эрх зүй ба цаашдын чиг хандлага” сэдэвт хуралдааны хэсгээс, Хуульчдын форум- 2018”, (УБ, 2018).
5. Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл, (УБ, 2023).
6. Хууль зүй, дотоод хэргийн яам, Н.Отгончимэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орны туршлага судлах харьцуулсан судалгаа, (УБ, 2019).
7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/, (УБ, 2021).

ДОЛОО. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
О.Энххүслэн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
М.Ганди Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил (ҮХЦ-ийн тухай хуулийн төсөл
боловсруулах ажлын хэсгийн ахлагч).

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.11.17.

АГУУЛГА

УДИРТГАЛ	237
I. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	239
II. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	240
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	240
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	240
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	241
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	241
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	242
III. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	243
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	244
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	267
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	277
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	281
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	302
IV. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	305
4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	305
4.2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	305
4.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	306
4.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	307
4.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	309
НОМ ЗҮЙ	310

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.4 дэх хэсэгт “Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлэх” зорилтыг тусгасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх I үе шатанд “Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, ...”, II үе шатанд “Салбарын инновацын үйл ажиллагааг дэмжих хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.” гэсэн чиглэлийг тус тус тодорхойлсон байна.

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.2-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болсон байна.

Дээр дурдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг үндэслэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулж батлуулсан. Уг хуулийн төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн талаарх иргэдийн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүсэлтийг Үндсэн хуулийн цэц хүлээн авах, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг дараах байдлаар дэлгэрэнгүй тусгана гэжээ. Үүнд:

Үндсэн хууль, түүнчлэн хүний үндсэн эрхийг дээдлэн хамгаалах чиг үүрэгт нь нийцүүлэн Цэцийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох зорилгын хүрээнд:

1. Цэцэд хандах эрх бүхий этгээдийн хүрээ, тэдгээрээс Үндсэн хуулийн цэцэд хандах хамаарлын зарчмыг тодорхой болгох,
2. Иргэний үндсэн эрхийн баталгааг улам сайжруулах.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, журмыг нарийвчлан зохицуулах зорилгын хүрээнд:

1. Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах эрх бүхий этгээдийг зааглан тодорхой болгох, түүнчлэн иргэн өөрийн үндсэн эрх зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хандаж өргөдөл гаргах, Улсын Их Хурлын гишүүн хүсэлт гаргах эрхийг хуульчлах, өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн гишүүнд хуваарилах,
2. Хуралдааны бүрэлдэхүүн, даргалагч, илтгэгч гишүүн томилох асуудлыг Цэцийн зөвлөгөөнөөр урьдчилан тогтоосон хуваарь, шударга журмын дагуу шийддэг болгох,
3. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд хамтын зарчмаар шийдвэр гаргах журмыг тусгах,

4. Цэцийн шийдвэрийг онолын түвшинд үндэслэл сайтай гаргах шаардлагын улмаас шийдвэрийн үндэслэл боловсруулах хугацааг уртасгаж, тодорхой болгон хуульчлан тогтоох.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үнэлнэ.” гэж заажээ. Үүний дагуу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/”-ыг баримтлан үнэлгээ хийлээ.

Судалгааны зорилго нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд энэхүү судалгааны зорилго оршино.

“Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар үнэллээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Журмын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

I. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Зардал¹
6. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн төсөлд тусгагдсан цэцэд хандах хэлбэр, маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт, хуралдааны хэлбэртэй холбоотой зохицуулалтууд нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн эсэх;
2. Хуулийн төсөлд тусгагдсан маргаан шийдвэрлэх хугацаа, маргаан хянан шийдвэрлэх зардал, цэцэд хандах хугацаа, өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах зохицуулалт нь практикт нийцсэн эсэх;
3. Хуулийн төсөлд тусгагдсан нэр томъёонууд нь ойлгомжтой эсэх;
4. Хуулийн төсөлд тусгагдсан маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавигдах шаардлага, маргааны оролцогчийн эрх зүйн байдал, өргөдөл, мэдээлэл, хүсэлт, маргааныг хуваарилах болон холбогдох бусад журам, цэцийн даалгаврыг биелүүлэх, Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, цэцийн шийдвэр гаргах, түүнийг мэдээлэх, тусгай журамтай холбоотой зохицуулалт нь шинээр орж ирж буй зохицуулалт учраас хүлээн зөвшөөрөгдөх эсэх;
5. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэг нь давхардсан, зөрчилдсөн, зохистойгоор зохицуулагдсан эсэх зэргийг шалгах;

¹ Журмын төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Үндсэн Хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн төслийн зардлын тооцоо сэдэвт судалгаа гүйцэтгэсэн байх тул дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

II. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөө үнэлнэ.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцно. Үүнд:

Хүснэгт 7.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1	Цэцэд хандах хэлбэр	Хуулийн төслийн 16 дугаар зүйл
2	Маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт, хуралдааны хэлбэр	Хуулийн төслийн 37-49 дүгээр зүйл

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулгын хүрээнд зохицуулалтуудыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

Хүснэгт 7.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1	Маргаан шийдвэрлэх хугацаа	Хуулийн төслийн 5 дугаар зүйл
2	Маргаан хянан шийдвэрлэх зардал	Хуулийн төслийн 7 дугаар зүйл
3	Цэцэд хандах хугацаа	Хуулийн төслийн 17 дугаар зүйл
4	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах	Хуулийн төслийн 19 дүгээр зүйл

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томъёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг сонгон авч үнэллээ.

Хүснэгт 7.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл заалт
1	Үндсэн хуулийн цэцийн дэг	Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг
2	Нэр томъёоны тодорхойлолт	Хуулийн төслийн 3 дугаар зүйл

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй эсхүл шинээр оруулсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтыг сонгон авлаа.

Хүснэгт 7.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заалт

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
1	Маргаан шийдвэрлэх хүрээ	Хуулийн төслийн 4 дүгээр зүйл
2	Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим	Хуулийн төслийн 8-15 дугаар зүйл
3	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавигдах шаардлага	Хуулийн төслийн 18 дугаар зүйл
4	Маргааны оролцогчийн эрх зүйн байдал	Хуулийн төслийн 21-29 дүгээр зүйл
5	Өргөдөл, мэдээлэл, хүсэлт, маргааныг хуваарилах болон холбогдох бусад журам	Хуулийн төслийн 31 дүгээр зүйл

6	Цэцийн даалгаврыг биелүүлэх, Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх	Хуулийн төслийн 33, 34 дүгээр зүйл
7	Цэцийн шийдвэр гаргах, түүнийг мэдээлэх	Хуулийн төслийн 50-55 дугаар зүйл
8	Тусгай журам	Хуулийн төслийн 56-61 дүгээр зүйл

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Тус хуулийн төслийн хүрээнд сангийн талаарх төрийн байгууллагуудын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх нь ач холбогдолтой гэж үзлээ.

Хүснэгт 7.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн сонгосон зүйл заал

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл заалт
1	Хянан шийдвэрлэхэд бусад байгууллага дэмжлэг үзүүлэх	Хуулийн төслийн 32 дугаар зүйл
2	Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Хуулийн төслийн 62 дугаар зүйл

III. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Хүснэгт 7.6. Шалгуур үзүүлэлт ба тохирох шалгах хэрэгсэл

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 7.7. Тохирох шалгах хэрэгсэл

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 16 дугаар зүйл Хуулийн төслийн 37-49 дүгээр зүйл	Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлал болон тус хуулийн хуулийн төслийн холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 5, 6 дугаар зүйл Хуулийн төслийн 7 дугаар зүйл Хуулийн төслийн 17 дугаар зүйл Хуулийн төслийн 19 дүгээр зүйл	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг Хуулийн төслийн 3 дугаар зүйл	Тодорхойлоогүй нэр томъёонуудыг тайлбарлах байдлаар санал болгох, хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх саналыг гаргах
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 4 дүгээр зүйл Хуулийн төслийн 8-15 дугаар зүйл Хуулийн төслийн 18 дугаар зүйл Хуулийн төслийн 21-29 дүгээр зүйл Хуулийн төслийн 31 дүгээр зүйл Хуулийн төслийн 33, 34 дүгээр зүйл Хуулийн төслийн 50-55 дугаар зүйл Хуулийн төслийн 56-61 дүгээр зүйл	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд баримт бичгийн судалгаа хийж дүгнэх
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн 32 дугаар зүйл Хуулийн төслийн 62 дугаар зүйл	Харилцан уялдааг судлах, ингэхдээ сантай холбоотой төрийн байгууллагын байгууллагын бүрэн эрхэд дүн шинжилгээ хийх

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой байдлаар томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг.

Цэцэд хандах хэлбэртэй холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 16 дугаар зүйл нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлд зааснаар цэцэд хандах дараах хэлбэрүүдийг хуульчилсан байна.

- Иргэн өөрийн субъектив үндсэн эрхээ хамгаалахаар цэцэд өргөдөл гаргах;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн төлөөлөн иргэний үндсэн эрх зөрчигдсөн асуудлаар цэцэд мэдээлэл гаргах;
- Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчигдсөн талаар тухайн чиглэлийн төрийн бус байгууллага нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор цэцэд мэдээлэл гаргах;
- Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор чиг үүргийн хүрээнд хүсэлт гаргах;

Судалгааны энэхүү хэсгээр тус цэцэд хандах хэлбэрүүдийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд цэцэд хандах хэлбэрийг доорх байдлаар тодорхойлжээ.

“1. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.

2. Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

1/ хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

2/ ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

3/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;

4/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.”

Үүнийг тодорхойлбол, Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг

- Иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу
- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэдэг².

Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэхээр хандах субъектүүдийг “1/иргэд; иргэд гэдэг ойлголтод Монгол Улсын иргэдээс гадна Монгол улсын иргэдээс гадна Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор оршин сууж байгаа гадаадын харьяат, аль ч улсын иргэн биш хүмүүс хэн ч байж болно. 2/эрх бүхий байгууллага; Үүнд Улсын Их Хурал, Улсын Дээд шүүх хоёр юм. 3/ эрх бүхий албан тушаалтнууд; Эдгээр албан тушаалтнуудад Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Ерөнхий прокурор гурав болно.”³ гэж тодорхойлсон байдаг. Харин Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх, дүгнэлт гаргах актуудад 1/ Улсын Их Хурлаас баталсан хууль, 2/ Улсын Их Хурлын бусад шийдвэр, 3/ Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, 4/ Улсын Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, 5/ Засгийн газрын шийдвэр, 6/ Монгол Улсын олон улсын гэрээ, 7/ ард нийтийн санал асуулгын талаар Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан шийдвэр, 8/ Улсын Их Хурал, түүний гишүүдийн сонгуулийн талаар Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр, 9/ Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр, үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцэд харьяалагддаг албан тушаалтнуудын хувьд 1/ Улсын Ерөнхийлөгч, 2/ Улсын Их Хурлын дарга, 3/ Улсын Их Хурлын гишүүд, 4/ Ерөнхий сайд, 5/ Засгийн газрын гишүүд, 6/ Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, 7/ Улсын Ерөнхий прокурор нар бөгөөд Үндсэн хуулийн Цэцийн үйл ажиллагааны харьяалалд зарим өндөр албан тушаалтнуудын бүрэн эрхэнд халдах үндэслэл байгаа талаар маргаанд дүгнэлт гаргах асуудлын хувьд 1/ Улсын Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэл байгаа эсэх, 2/ Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэл байгаа эсэх, 3/ Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгаа эсэх, 4/ Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх⁴ талаар тус тус хамаарч байна.

Мөн дээрх байдлаар Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалтыг авч үзэхээс гадна дэлхийн нийтлэг жишгийг харах нь зүйтэй. Түүхэн үүднээс авч үзвэл ихэнх тогтолцоонд Үндсэн хуулийн хяналт буюу Үндсэн хуулийн шүүхийн хяналт нь төрийн байгууллага хооронд эрх хэмжээ харьяаллын маргаантай холбогдсон үүссэн байдаг. Орчин үед бусад төрлийн маргаан, эргэлзээтэй асуудал гарч үзсэн тул Үндсэн хуулийн хяналт нь зөвхөн эрх хэмжээг зааглан хязгаарлахаас илүү өргөн хүрээтэй болжээ. Үндсэн хуулийн эрх хэмжээг гадаадын улс, орнуудад нийтлэг байдлаар дараах асуудлыг хамрахаар тодорхойлсон байдаг.

2 Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй”, хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 24 дэх тал.

3 Г.Совд, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, (УБ, 2000), 259 дэх тал.

4 Мөн тэнд.

1. Урьдчилсан хяналт
2. Батлагдсаны дараах буюу хариуцлага хүлээлгэх хяналт
3. Хэм хэмжээний тайлбар хийх
4. Хэм хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хяналт
5. Хууль тогтоомжийн хийдлийг нөхөх асуудал
6. Хууль санаачлах
7. Эрх хэмжээ, харьяаллын маргаан
8. Улс төрийн намын Үндсэн хуульд нийцээгүй үйл ажиллагаа, шийдвэртэй холбогдох асуудлаар
9. Ард нийтийн санал асуулга, хураалт (Ард нийтийн санал хураалт Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлаар)
10. Сонгууль – сонгуулийн үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлаар
11. Төлөөллийн сонгуулийн дүнг баталгаажуулах
12. Хүний эрхийг хамгаалах
13. Албан тушаал эрхлэх чадварын асуудлаар
14. Албан тушаалаас огцруулах эсэх асуудлаар
15. Тусгайлан олгосон эрх хэмжээ
16. Үндсэн хууль болон бусад хуулиар Үндсэн хуулийн шүүхэд харьяалуулсан бусад асуудал⁵

Дээрхээс дүгнэвэл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлд заасан цэцэд хандах хэлбэрүүдийг зохицуулсан зохицуулалт нь Үндсэн хуулийн зохицуулалт, үзэл баримтлал болон олон улсын жишигт нийцэхээр байна. Гэвч тус зохицуулалтын хувьд шинээр тодорхойлсон цэцэд хандах хэлбэрийг тус бүрд нь авч үзэх шаардлагатай.

Иргэн өөрийн субъектив үндсэн эрхээ хамгаалахаар цэцэд өргөдөл гаргах талаар:

Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж тодорхойлсон байна.

Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт заасан хүний эрхийг хамгаалах буюу тухайн зохицуулалтын хэрэгжилтэд дээд хяналт тавих, шийдвэрлэх нь Үндсэн Хуулийн Цэцийн үүрэг юм. Үндсэн хуулийн цэц нь 1992 онд Үндсэн хуульд батлагдсанаас хойш дээрх үүргээ хэрэгжүүлээгүй буюу иргэний үндсэн эрхийн зөрчлийн тодорхой маргааныг шийдвэрлээгүй байна.

5 Арне Мавчич, “Үндсэн хуулийн хяналт”, (Уб, 2014), 50-55 дахь тал

Энэ нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэг⁶ заасан Үндсэн Хуулийн Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд иргэний үндсэн эрхийн зөрчлийг шийдвэрлэх агуулга тусаагүйтэй холбоотой. Энэ талаар судлаачид шүүмжилж Үндсэн хуулийн үзэл баримтлал, зорилготой нийцээгүй хэмээн үздэг.

Энэ тухай хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяа “Өмчлөх, хуульд заасан тохиолдолд эд, мөнгөний тусламж авах зэрэг аль нэг эрх нь нийтийн засгийн аливаа актаар зөрчигдлөө хэмээн үзээд иргэн хүн Үндсэн хуулийн цэцэд хандвал Цэц маргааныг шийдвэрлүүлэхээр бүрэн эрхийнхээ дагуу холбогдох байгууллага, тухайлбал ердийн шүүхэд шилжүүлж энэ тухай өргөдөл мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ. Монголд иргэн хүн Үндсэн хуулийн 66-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгайлан заасан объектуудаар УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын, өөрөөр хэлбэл хүсэлт гаргагчийн нэгэн адил өөрийнх нь үндсэн эрх зөрчигдөөгүй байхаар хуульд туссан учир Үндсэн хуулийн цэц иргэн хүний индивидуаль үндсэн эрх бодит байдал дээр зөрчигдсөн тохиолдолд түүнийг шүүхийн журмаар Үндсэн хуулийг хэрэглэн сэргээх боломжгүй байдаг. Зөрчигдсэн эрхийг манайд ч гэсэн ердийн шүүх сэргээдэг, харин үндсэн эрх зөрчигдвөл түүнийг Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн нэрийн өмнөөс сэргээх боломж хараахан бүрдээгүй байна. Монголд иргэн хүн Үндсэн хуулийн цэцэд өөрт нь шууд хамааралгүй асуудлаар, тухайлбал аль нэг эрх зүйн акт үндсэн хууль зөрчиж байгаа эсхүл хуульд заасан хэн нэг албан тушаалтан үндсэн хууль зөрчиж байгаа эсэх асуудлаар хандах боломжтой. Ийнхүү иргэн хүн Үндсэн хуульд заасан цөөн тооны объектоор Цэцэд хандах эрхтэй бөгөөд үндсэн эрх энэхүү объектод ордоггүй. Иймд Үндсэн хуулийн “Хүний эрх” бүлгийн хэрэгжилт бодит байдалд хамгаалалтгүй орхигджээ. Харин иргэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан объектоор цэцэд өргөдөл, мэдээлэл ирүүлэхэд түүнд үндсэн эрхийн тухай асуудал агуулагдсан байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ аливаа шүүхийн зориулалт амьдралын тухайн нөхцөл байдалд эрхийг сэргээхэд Үндсэн хуулийн шүүхийн зориулалт үндсэн эрхийг сэргээхэд оршдог гэдэг нийтлэг зарчмаас Цэцийн эрх хэмжээ ихээхэн ялгагдаж буйг тэмдэглэе⁷.” гэж өөрийн байр суурийг илэрхийлжээ.

Мөн Үндсэн хуулийг батлах явцад БНМАУ-ын Ардын Их хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар чуулганы 1991 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурал дээр 9-р тойргийн депутат С.Зориг “Бид нар Үндсэн хуульдаа хүний эрхийг баталгаажуулах талаар асар олон заалт оруулсан. Өмнө нь зөрчиж байсан, одоо ер нь зөрчихгүй тийшээгээ хандъя. Тэрийгээ нийгмийнхээ суурь болгоё гэж үзсэн. Гэхдээ энэ хүний эрхийг хамгаалах тэр арга хэрэгслүүдээ бараг өгөөгүй, зөвхөн шүүхэд гомдол гаргах, ганц механизмыг оруулж. Энийг хангахад гурван механизмыг хийж болох юм аа Үндсэн хуульд. Нэгдүгээрт, шүүхэд өөрийнхөө гомдлыг гаргах, хоёрдугаар Их цаазын цэцэд Үндсэн хуулийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж

6 - хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;
- Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.

7 Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” Эрдэм шинжилгээний өгүүлэл, (УБ, 2002), Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?Id=775>. Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

үзэж байгаа юм бол хувь хүн гомдлоо гаргах эрхтэй. Гуравдугаарт, шүүхийн бус нэг механизм болох хүний эрхийн үндэсний комисс байгуулах гэж ийм гурван янзын механизмтай бид нар тэр Үндсэн хуульдаа заасан хүний эрхийг хамгаалах бололцоотой болно. Тэгээгүй тохиолдолд одоо шүүхдээ итгэл итгэл нь буурсан ийм үед тэр механизмуудаа хийж өгөхгүй бол бид нар баталгааг нь гаргаж чадахгүй байх”⁸ гэж хэлж энэхүү санааг дэмжиж байсан.

Түүнчлэн хууль зүйн ухааны доктор, судлаач О.Мөнхсайхан нь иргэний үндсэн эрхийн маргааныг ҮХЦ шийдвэрлэх талаар 2 үзэл баримтлал гаргаж, дараах байдлаар судалсан байна.

“Нэгдүгээр үзэл баримтлал бол ҮХЦТХ болон Цэцийн практикт тогтсон. Цэц хууль тогтоомж болон бусад холбогдох шийдвэрт абстракт хяналт хэрэгжүүлдэг боловч ердийн шүүхийн шийдвэрт Үндсэн хууль зөрчигдсөн эсэх асуудлыг шийдвэрлэдэггүй. Мөн, төрийн өндөр албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянадаг. Зөвхөн эрх бүхий этгээд төдийгүй иргэн цэцийн харьяаллын аль ч асуудлаар мэдээлэл гаргах эрхтэй (*actio popularis*). Хууль тогтоомж болон ҮХЦТХ-д заасан бусад шийдвэрээр үндсэн эрхээ зөрчүүлсэн гэж иргэн гэж үзвэл цэцэд өргөдөл гаргах боломжтой. Гэвч, иргэн шүүхийн шийдвэрээр үндсэн эрх нь зөрчигдсөн эсхүл хамгаалагдаж чадаагүй гэж үзвэл энэ асуудлаар цэцэд хандах боломжгүй. Тодорхой тохиолдолд зөрчигдсэн үндсэн эрхийн маргааныг цэц харьяалан шийдвэрлэхгүй байгаа нь Монгол Улс дахь хүний эрхийн сул хамгаалалтын нэг шалтгаан болж байна.

Хоёрдугаар үзэл баримтлалын дагуу иргэний өргөдөл бол Европын Үндсэн хуулийн шүүхүүдэд байдаг үндсэн хуулийн гомдолтой адилхан агуулгаар хэрэгжих хэрэгтэй. Энэ үзэл баримтлал бол нэгдүгээр үзэл баримтлалтай өрсөлдөхүйц төдийгүй цэцийг үндсэн эрхийн хамгаалагч гэсэн зорилгод нь хүргэх, Үндсэн хуулийн шүүхийн утгаар нь хөгжүүлэх, Үндсэн хуулийн нэр томьёо, логикт илүү тохирох, Үндсэн хуулийг боловсруулж баталсан түүхээр дэмжигдэж болохуйц, олон улсын шилдэг туршлагад нийцэх боломжтойгоороо илүү дээр юм. Өргөдлийг үндсэн хуулийн гомдлоор ойлговол түүнийг хүсэлттэй адилхан дүгнэлт гаргах, дахин хянан үзэх хоёр шатлалтай процедураар шийдвэрлэж болохгүй. Цэц өргөдлөөр үүсгэсэн маргааныг нэг удаа эцэслэн шийдвэрлэж, уг шийдвэрээ УИХ-руу явуулахгүй байхаар хуульчлах хэрэгтэй. Мөн, иргэний мэдээлэл гэдгийг үндсэн хуулийн маргааныг үүсгэх үндэслэл гэж үзэхгүй харин *amicus curiae* гэсэн агуулгаар ойлгож, нэгэнт үүсгэсэн маргааныг зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой үндэслэл, судалгааг маргааны тал биш иргэнээс авах суваг болгох нь илүү зохистой. Иргэний өргөдөл, мэдээллийн талаар хоёрдугаар үзэл баримтлалын дагуу Цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчилбэл Монгол Улс дахь үндсэн эрхийн зөрчил Үндсэн хуулийн болон олон улсын стандартын дагуу шийдвэрлэгдэх боломжтой болно. Улмаар иргэний үндсэн эрхий зүгээр нэг тунхаг төдий биш харин бодитой хэрэгждэг эрх зүй болно.”⁹

8 “Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж. /Боть 9”, Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар, (УБ, 2022), 696 дахь тал.

9 О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015), 64-81 дэх тал.

Ийнхүү Үндсэн хуулийн цэц нь иргэний үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэснээр Үндсэн хуульт ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг хангах юм. Түүнчлэн хүний субъектив үндсэн эрхийг Үндсэн хуулийн цэц хамгаалах явдал нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болно. Энэ нь хяналтад харьяалагдах субъектийн үйл ажиллагаанд Үндсэн хуулийн заалт нэг бүрийг хэрэгжүүлэхийг шаардах, зөрчил гаргасан тохиолдолд арилгуулах чиг үүрэг гүйцэтгэх явдал юм.¹⁰

Иймд Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцэд иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг хүлээн авч шийдвэрлэх боломжийг нээж, Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, иргэд субъектив үндсэн эрхээ хамгаалуулах Үндсэн хуулийн механизмыг бий болгосон энэхүү төслийн зохицуулалт нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэж байна.

Хязгаарлалтын тухайд:

Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргах хязгаарлалтыг зайлшгүй тусгах шаардлага үүсдэг. Тухайлбал, тус төсөлд “Иргэн эрх хамгаалах, сэргээх шүүхийн болон бусад арга замыг дуусгасны дараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй өөрийнх нь үндсэн эрхийг зөрчсөн хэвээр гэж үзэж байгаа бол Цэцэд өргөдөл гаргана.” гэж хязгаарлалтыг тусгасан байна.

Энэ тухай хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяа “Сонгодог утгаараа иргэдийн өргөдөл, мэдээлэл нь Үндсэн хуульд заасан индивидуаль буюу субъектив үндсэн эрх хэрэгжих баталгаа байх ёстой. Иргэн, хуулийн этгээд нь үндсэн эрхээ нийтийн эрх зүйн аливаа субъектийн шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйгээр зөрчигдсөн гэж үзвэл үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байдаг. Гэхдээ иргэн, хуулийн этгээд нь үндсэн хуулийн шүүхэд хандахын өмнө тухайн маргааныг хуульд заасан бусад бүх шат дамжлагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг урьдчилан авсан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эрхээ хамгаалуулахаар үндэсний эрх зүйн бүх механизмыг эхлээд гүйцээсэн байна. Зөвхөн үүний дараагаар л үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой болдог. Учир нь өргөдөл нь үндсэн хуулийн шүүхийн практикт анхдагч бус үүсмэл (субсидиар) шинж чанартай юм.”¹¹ гэж мөн чанарыг тодорхойлсон.

Мөн шүүхэд хандсан, эсхүл хуулийн бусад аргыг хэрэглэсэн ч үндсэн эрх нь сэргээгдээгүй гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргах нь судлаачдын байр сууриас гадна бусад улсын туршлагад тулгуурлан авч үзсэн ч хүлээн зөвшөөрөгдөнө.

Тухайлбал, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 97 дугаар зүйлд зааснаар “Шүүх эсхүл хууль хэрэглэдэг өөр байгууллага тухайн хуулийг хэрэглэж хэрэг шийдвэрлэсэн бол ОХУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргах боломжтой байна.”¹² гэж үүнийг тодорхойлсон байна.

10 Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, (УБ, 2007), 287 дахь тал.

11 Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй”, хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 119 дэх тал.

12 Мөн тэнд, 120 дахь тал.

Мөн БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлд “Төрийн эрх мэдлээ хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлээгүйн улмаас Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх нь зөрчигдсөн аливаа этгээд шүүхээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргаж болно. Гагцхүү бусад хуулиар шийдвэрлэх журам байгаа тохиолдолд бүх шатны журмаар шийдвэрлүүлсний дараа гомдол гаргах боломжтой. Шүүхээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд гэдэгт Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн хуулийг шүүх хэрэглэсний улмаас үндсэн эрх зөрчсөн тохиолдлыг хамааруулахгүй.”¹³ гэж зохицуулсан байна.

Ийнхүү, бусад улсуудад үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хуулийн шүүхээс харьяалан шийдвэрлэх боловч, тодорхой хязгаарлалтыг тавьдаг байна. Өөрөөр хэлбэл, Иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчилд хамаарах маргааны хязгаарлалтын хувьд гадаад улсуудад мөн тодорхой хязгаарлалтыг хийх тохиолдлууд байдаг. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн 4а дугаар зүйлд хүний дараах субъектив үндсэн эрхийг Үндсэн хуулийн шүүх хамгаалах талаар тусгажээ.¹⁴

- Улсын бүх эрх мэдэл ард түмнээс эх үндэстэй байхтай холбоотой зохицуулалт /20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг/
- Үндсэн эрхийг тэгш эдлүүлэх болон нийтийн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зохицуулалт /33 дугаар зүйл/
- Сонгох, сонгогдох үндсэн эрхийн зохицуулалт /38 дугаар зүйл/
- Хуулиас гадуур шүүх байгуулахыг хориглохтой холбоотой зохицуулалт /101 дүгээр зүйл/
- Шударгаар шүүлгэх эрх болон эрүүгийн эрх зүйн шударга ёсны зохицуулалт /103 дугаар зүйл/
- Халдашгүй байх үндсэн эрхийн зохицуулалт /104 дүгээр зүйл/

Иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг авч хэлэлцэх талаар эрх хамгаалах, сэргээх шүүхийн болон бусад арга замыг дуусгасны дараа буюу дотоодын хүний эрхийг хамгаалах механизмаар явсны дараа ханддаг болсон нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн үр дүнтэй зохицуулалт байна. Гэвч үүнээс гадна бусад хязгаарлалтуудыг тусгах шаардлагатай эсэхийг тодорхойлох, хуулийн зохицуулалтад оруулах нь зүйтэй эсэхийг шийдвэрлэх хэрэгтэй.

13 헌법재판소법 ([시행 2022. 2. 3.] [법률 제18836호, 2022. 2. 3., 일부개정]), Холбоос: https://www.law.go.kr/%EВ%B2%95%EB%A0%B9/%ED%97%8C%EB%B2%95%EC%9E%AC%ED%8C%90%EC%86%8C%EB%B2%95?Fbclid=iwar3jwwhw36mp4zdc-0Hy3kzinbxWJJ8HJXur1WLSGsjAQ2o-DE_t3a3aqrq. Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

14 “Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль”, ХЗҮХ, (УБ, 2020).

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн төлөөлөн иргэний үндсэн эрх зөрчигдсөн асуудлаар цэцэд мэдээлэл гаргах талаар:

ХЭҮК¹⁵ нь 2020 оны Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 3.1.1-т зааснаар “Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага.” гэж тусгасан. ХЭҮК нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

15 1991 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зохион байгуулсан шинжээчдийн зөвлөгөөнөөс “Хүний эрхийг дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын эрх зүйн зарчмууд” батлагдсан. Парисын зарчмууд нэршлээр түгсэн энэ баримт бичгийг хожим нь НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993/48/134 тогтоолоор батламжилжээ. “Парисын зарчмууд”-аар хүний эрхийг хангах, түүнийг сахин хамгаалах үндэсний байгууллагуудын бүрэн эрх, үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх наад захын хэм хэмжээг тогтоосон. 1993 онд Вена хотноо зохион байгуулагдсан Хүний эрхийн дэлхийн бага хурлаар олон улсын гэрээ, конвенцод заасан хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийг хүлээн зөвшөөрч, түүнийг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг бүхий хүний эрхийн үндэсний байгууллагыг Парисын зарчмуудад нийцүүлэн байгуулахыг гишүүн улс орнууддаа уриалсан билээ. Хүний эрхийн үндэсний байгууллага нь хараат бус, өргөн хүрээтэй бүрэн эрх олгогдсон, байнгын ажиллагаатай, олон ургальч төлөөллийг хангасан бүрэлдэхүүнтэй, олон нийтэд ойр дөт, үйл ажиллагаагаа явуулах санхүүгийн чадавхтай байх ёстой. Хуулийг дээдлэх, хараат бус, бие даасан байх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг тууштай хамгаалах, ил тод, шударга ажиллах нь хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааны зарчим юм. Эдгээр үзүүлэлтүүдээр нь хүний эрхийн үндэсний байгууллагын үр нөлөөг хэмждэг. УИХ-аас 2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, 2001 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Комиссын анхны гишүүдийг томилсноор Парисын зарчимд нийцсэн хүний эрхийн үндэсний байгууллага Монгол Улсад үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага юм. Энэхүү Комисс нь Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хороонд 2003, 2008, 2014, 2021 онуудад “А” статусаар магадлан итгэмжлэгдсэн, Ази Номхон Далайн Бүс Нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагын Чуулганы бүрэн эрхт гишүүн юм. УИХ-аас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталснаар Комиссын чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, дарга, гишүүний бүрэн эрх, зохион байгуулалт, хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол мэдээллийг шийдвэрлэх ажиллагаа болон хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэсний механизмыг байгуулсан зэрэг томоохон өөрчлөлтийг хийсэн.

- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх;
- Хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах;
- Хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх;
- Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;
- Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх;
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- Хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- Шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийн хэрэгжилтэд энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих;
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулж, УИХ-д хүргүүлэх.

ХЭҮК нь эрх бүхий байгууллага албан тушаалтанд хүний эрх зөрчигдсөн эсэх талаар санал, зөвлөмж, дүгнэлт гаргах, мэдээлэл хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд хяналт тавих, шалгалт хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг хүний эрхийг хамгаалах чухал субъект юм.¹⁶ Гэвч Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1-т заасан Үндсэн хуулийн цэцэд хандах субъектэд ХЭҮК-ыг хамааруулаагүй байгаа нь хүний эрхийн чиглэлээр голчилж үйл ажиллагаа явуулдаг байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлагдмал байдлаар зохицуулж ирсэн. Иймд ХЭҮК нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллага болохын хувьд хүний эрхийг зөрчсөн хууль, эрх зүйн акт, эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийг ҮХЦ-д хандан шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Уг өөрчлөлтийн төслөөр ХЭҮК-оос Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гарган шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж буй явдал нь Үндсэн хуулийн үзэл баримтлал болон өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд бүрэн нийцсэн гэж үзлээ. Иймд ХЭҮК-оос хүний эрхийн зөрчлийн талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах нь Үндсэн хуулийн хяналтын агуулгад бүрэн нийцэж байх бөгөөд зорилгод хүрсэн байх шалгуурыг хангаж байна.

Гэхдээ тус төсөлд “Иргэн эрх хамгаалах, сэргээх шүүхийн болон бусад арга замыг дуусгасны дараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй өөрийнх нь үндсэн эрхийг зөрчсөн хэвээр гэж үзэж байгаа бол Цэцэд өргөдөл гаргана” гээд иргэн зөвхөн өөрийн үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд тухайн эрхээ сэргээлгэхээр өргөдөл гаргахаар тодорхойлсон нь “хуулийн хэрэгжилт дэх иргэний хяналт”-ыг хязгаарласан буюу иргэний мэдээлэл гаргах эрхийг хязгаарласан байна.

16 “Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа”, ХЗҮХ, (УБ, 2023), 11 дэх тал.

Тодруулбал, сүүлийн 23 жилд цэцийн шийдвэрлэсэн маргааны дийлэнх нь иргэдийн өргөдөл, мэдээллээр үүссэн байдаг. 1992 оноос 2007 онд иргэд 1000 гаруй өргөдөл, мэдээлэл гаргасан. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тавигдсан цэцийн шийдвэрүүдийг судалж үзэхэд 1992-2015 оны хооронд цэцийн дунд суудлын хуралдаанаар нийт 164 маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж шийдвэрлэжээ. Эдгээрийн 159 маргаан буюу 97 хувь нь иргэний мэдээллээр үүссэн. Эндээс Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд мэдээлэл чухал үүрэгтэй гэдэг нь харагдаж байна¹⁷.

Мөн түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлтийг авч үзвэл Цэцэд хандсан байдлын 39%-ийг буюу 3451-ээс 1333-ыг мэдээлэл дангаар эзэлж байна¹⁸.

Хүснэгт 7.8. МУ-ЫН ҮХЦМХША-НЫ 30 ЖИЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ


Он	Өргөдөл, мэдээлэл, хүсэлт	Үүнээс				
		Өргөдөл	Мэдээлэл	Гомдол	Хүсэлт	Бусад /УИХТ/
1992	29	24	4	-	-	1
1993	67	26	34	3	2	2
1994	87	62	15	6	2	2
1995	48	30	14	4	-	-
1996	95	76	8	10	-	1
1997	76	67	2	5	2	-
1998	79	65	4	8	2	-
1999	43	36	2	5	-	-
2000	31	27	1	1	-	2
2001	27	22	3	1	-	1
2002	86	74		9	-	3
2003	58	51	2	4	-	1
2004	42	35	6	1	-	
2005	76	66	4	4	-	2
2006	132	101	15	11	3	2
2007	127	84	14	25	-	4
2008	125	5	99	20	-	1
2009	114	90	6	18	-	-
2010	113	8	75	27	1	2
2011	101	80	1	19	1	-
2012	153	98	21	31	-	3
2013	132	90	15	25	-	2

17 О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015), 69 дэх тал.

18 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/, (УБ, 2021).

2014	141	43	78	18	-	2
2015	176	38	90	36	1	11
2016	251	39	159	51	-	2
2017	165	32	94	38	1	-
2018	244	29	175	33	4	3
2019	250	63	137	44	3	3
2020	191	31	121	37	-	2
2021	191	29	133	23	3	3
Нийт	3451	1521	1333	517	25	55

График 7.1. МУ-ын ҮХЦМХША-ны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/



Тиймээс Үндсэн хуулийн цэцэд иргэн энэхүү төсөлд зааснаар иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийн улмаас хандахаас гадна хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан буюу объектоор хандах нь зохистой байж болно.

Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчигдсөн талаар тухайн чиглэлийн төрийн бус байгууллага нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор цэцэд мэдээлэл гаргах талаар:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.2 дахь хэсэгт “иргэн Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчигдсөн талаар тухайн чиглэлийн төрийн бус байгууллагад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хандсан нь үндэслэлтэй бол тухайн байгууллага” мэдээлэл гаргахаар зохицуулжээ.

Ийнхүү зохицуулсан нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан “...Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй...”

гэж заасан эвлэлдэн нэгдэх эрхэд нийцсэн тухайн асуудлаар цэцэд хандах үр дүнтэй арга юм. Мөн тус хуулийн танилцуулгад дурдсанаар “иргэн Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчигдсөн талаар тухайн чиглэлийн төрийн бус байгууллагад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хандсан нь үндэслэлтэй бол тухайн байгууллага Цэцэд мэдээлэл гаргах юм. Энэ нь захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд туссан сайн туршлага юм. Цэцэд мэдээлэл гаргах хүрээг энэ хоёр арга замаар хязгаарласан нь мэдээллийн хүрээнд бий болдог сөрөг талыг багасгах, бусад улсын жишигт ойртох, Үндсэн хуулийн процессын эрх зүйн хандлагад нийцэхэд нэг чухал нөхцөл болох юм.”¹⁹ гэж ач холбогдлыг дурдсан байна. Өөрөөр хэлбэл энэ нь Үндсэн хуулийн цэцэд үүсэх ачааллыг багасгах, цэцэд зохиомлоор хандах хэлбэрийг бий болгох эрсдэлийг бууруулах үр дүнтэй. Тодруулбал, ирсэн өргөдөл, мэдээллийн 10-аад хувьд нь маргаан үүсгэн хянан шийдвэрлэсэн үзүүлэлт байдаг. Бусад 90 хувь нь Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулаагүй, эсвэл бусад байгууллагын эрх хэмжээний асуудал байдаг²⁰.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 1951 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан “Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль”-ийн 35b дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт²¹ төрийн бус байгууллага нь маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцох талаар зохицуулжээ.

Гэвч төрийн бус байгууллага нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор цэцэд мэдээлэл гаргах нь өмнө дурдсанчлан иргэний цэцэд хандаж мэдээлэл гаргах эрхийг хязгаарлах нөхцөл байдлыг бий болгохыг мөн анхаарч үзэх нь зүйтэй.

Мөн төрийн бус байгууллага нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор цэцэд хандах туршлага бий болоогүй байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал Үндсэн хуулийн цэц анх байгуулагдсан 1992 оноос 2021 оныг дуусталх хугацаанд 3500 /3451/ орчим өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч хянасан байна. Харин Үндсэн хуулийн цэцэд хандах эрх бүхий байгууллага, албан тушаалтан болох Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос 25 хүсэлт ирсэн нь нийт хандсан өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлыг 0.7 хувийг эзэлж байна. Үлдсэн 99.3 хувь нь бүгд иргэдийн гаргасан өргөдөл, мэдээлэл, гомдол байна²².

19 Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулга.

20 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/, (УБ, 2021).

21 35(b)-2, Act on the Federal Constitutional Court (Bundesverfassungsgerichtsgesetz – BVerfGG), Холбоос: https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/BVerfGG.pdf?__blob=publicationFile&v=1, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

22 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/, (УБ, 2021).

График 7.2. Цэцэд хандсан тохиолдлын тоо /1992-2021 он/



Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн чиг үүргийн хүрээнд хүсэлт гаргах талаар:

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд УИХ цэцэд хандаж хүсэлт гарган Үндсэн хууль зөрчсөн талаар маргааныг шийдвэрлүүлэх боломжтой. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т “Улсын Их Хурал, Улсын дээд шүүх хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналд үндэслэж гаргана.” гэж хуульчилсан.²³ УИХ-ын тодорхой тооны гишүүн ҮХЦ-д хандах эрхийн зохицуулалт одоогоор байхгүй.

Аливаа парламент Үндсэн хуулийг сахиулахын төлөө ажилладаг байгууллага болохын хувьд Үндсэн хуулийн шүүхэд хандах гол субъектийн нэг байх учиртай. УИХ нь шийдвэрээ хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналаар гаргадаг. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад, Нэгдсэн хуралдаан хуралдаж асуудал нэг бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргахыг зөвшөөрсөн.

Одоо мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эрхтэй ч Үндсэн хуулийн цэцэд хандсан тохиолдол 30 жилийн хугацаанд нэг ч удаа гараагүй байна. Энэ нь Улсын Их Хурал олонхоороо баталсан хууль, шийдвэрийнхээ талаар олонх нь санал нэгдэж Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянуулахаар Цэцэд хандах үндэслэл бараг байдаггүйтэй холбоотой. Иймд Улсын Их Хуралд бүлэг байгуулах тооны гишүүн Үндсэн хуулийн цэцэд хандах буюу цөөнхийн үндэслэлийг харгалзан үзэх боломжийг Үндсэн хуулийн процессын хүрээнд олгох боломжтой юм. Мөн дээр

²³ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, *Төрийн мэдээлэл сэтгүүл*, №3, (1992), Холбоос: <https://www.parliament.mn/nn/12604/>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

дурдсан хамаарлын зарчмаар хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэр, мөн сонгуулийн үр дүн болон мандатад нөлөөлж болох Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн, түүнчлэн эрх бүхий албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн буюу түүнийг огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй гэж үзвэл Улсын Их Хурлаас тодорхой тооны гишүүд хүсэлт гаргаж болохоор тусгаж болно²⁴.

Гэвч УИХ нь Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах бүрэн эрхээ өнгөрсөн 31 жилийн хугацаанд нэг ч удаа хэрэгжүүлээгүй байна. УИХ дахь олонх Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн хуулийг бүрэн эрхийнхээ хүрээнд өөрчлөх, хүчингүй болгох боломжтой тул Үндсэн хуулийн цэцэд хандах шаардлага үүсдэггүй. Иймд парламентын олонхын баталсан хууль нь Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд цөөнх Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж маргаан үүсгэх эрх зүйн үндэслэлийг төсөлд тусгажээ.²⁵

1995 онд тус заалт Үндсэн хууль зөрчсөн талаарх маргаан өрнөсөн. Тодруулбал, "...Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг "Улсын Их Хурал ... хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналд үндэслэж гаргана." гэсэн заалт Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг Улсын Их Хурлын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ." гэсэн заалтыг зөрчсөн талаар мэдээлэл гаргасан. ҮХЦ-ээс уг заалтыг Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж шийдвэрлэсэн ч 1997 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн "Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар уг заалтыг хүчингүй болгожээ. Тус эрх зүйн зохицуулалтын сөрөг талыг "... цэцийн тухай хуулийн уг заалт нь зарим үед парламент дахь улс төрийн тэмцлийг гудамжинд түлхэн гаргах өдөөн хатгалгын үүрэг гүйцэтгэж ч мэдэх юм ..." гэж тайлбарлах нь бий.²⁶

УИХ олонхын саналаар шийдвэр гаргадаг бөгөөд гаргасан шийдвэрээ хамгаалах зүй ёсны сонирхолтой байна. Ардчилсан тогтолцоотой улсуудад харьцангуй цөөн тооны гишүүд хамтран эсхүл намын бүлэг Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байдаг нь парламент алдаагаа өөрөө засах, хууль тогтоох үйл ажиллагаанд хянуур хандах, төрийн тогтвортой байдлыг хангах хөшүүрэг болдог байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлтийг авч үзвэл Улсын Их Хурлаас хүсэлт ирж байгаагүй нь тус үр дүнтэй арга хэмжээ хэрэгжихгүй байгааг харуулж байна²⁷.


24 "Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь" (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, (УБ, 2023), 101 дэх тал.

25 Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, 2 дахь тал.

26 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт "Цэцийн тухай хууль үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар", 1995.01.18, Холбоос: <https://old.legalinfo.mn/law/details/1129?Lawid=1129>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

27 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/, (УБ, 2021).

График 7.3. МУ-ын ҮХЦ-д “хүсэлт” ирсэн 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/



Мөн түүнчлэн үүнтэй холбоотой хүсэлтийг Цэц шийдвэрлэсэн байдаг. 1997 оны Цэцийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын өмнөх хувилбар үйлчилж байх үед буюу 1995 оны 1 дүгээр сарын 18-нд Цэц нь, Цэцийн тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргасан. Мэдээлэл гаргагч нь Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т холбогдуулан мэдээлэл гаргахдаа: “Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т: УИХ... хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхын саналд үндэслэж гаргана гэсэн заалт Үндсэн хууль... зөрчиж байна. Учир нь УИХ шийдвэрээ олонхоор гаргадаг бөгөөд гаргасан шийдвэрээ хамгаалах зүй ёсны сонирхол тухайн шийдвэрийг гаргасан олонход бий. Гэтэл Үндсэн хууль зөрчсөн шийдвэр гарч болох ба энэхүү зөрчлийг шийдвэр гаргасан олонх ямар нэг шалтгаанаар (... тухайн үеийн улс төрийнхөө сонирхолд хөтлөгдөх) олж харанхуй, нэгэнт гаргасан шийдвэрээ цэцээр хянуулахад болохгүй юмгүй тул Цэцэд хүсэлт гаргах сонирхол төрөхгүй. Ийнхүү хуулийн энэ заалт нь Үндсэн хуулийн ... үйлчилгээг хаасан байна. Энэ нь Үндсэн хуулийг дээдлэх хэвийн үйл ажиллагаанд ч муугаар нөлөөлж болно: Төрийн ардчилсан тогтолцоотой улсуудад харьцангуй цөөн тооны гишүүн хамтран эсвэл намын бүлэг Үндсэн хууль зөрчигдсөн тухай маргаан үүсгэж Үндсэн хуулийн шүүхдээ хандах эрхийг хуулиар олгосон байдаг нь парламент алдаагаа өөрөө засах, хууль тогтоох үйл ажиллагаанд нямбай хандах, төрийн тогтвортой байдлыг хангах хөшүүрэг болж өгдөг байна. Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалтыг намын бүлэг, аль эсвэл УИХ-ын тодорхой тооны гишүүн хамтран УИХ-ын хүсэлтийг гаргаж байхаар өргөтгөвөл Үндсэн хуулийн тодорхой заалтын үйлчилгээг хааж байгаа дээрх зөрчил арилна. Ийм боломж нээгдсэнээр УИХ-ын үйл ажиллагаанд хууль дээдлэх хамтран ажиллах явдалд ахиц гарах, төрийн эрхийн төлөө намуудын хооронд улс төрийн тэмцэл илүү соёлтой болох нь дамжиггүй” хэмээн тодорхойлжээ. Цэц үүнийг шийдвэрлэхдээ Цэцийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг УИХ-ын баталсан хуулиуд хийгээд түүний бусад шийдвэрүүдтэй холбон явцууруулж ойлгох нь учир дутагдалтай тул энэ хэсгийн заалтыг Үндсэн

хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй бөгөөд уг хүсэлтийг хангах боломжгүй хэмээн дүгнэсэн байна²⁸.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тусгагдсан УИХ-ын гишүүн цэцэд хандах зохицуулалт нь зорилгод нийцэж байна. Гэхдээ УИХ-ын гишүүн Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргахад “уг тогтоолыг эсэргүүцсэн байх” гэсэн шаардлага тавих нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, УИХ-ын шийдвэрийг дэмжсэн гишүүн Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах нь өөрийн шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй адил агуулгатай.

Маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт, хуралдааны хэлбэртэй холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 37-49 дүгээр зүйл нь зорилгод нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 37-49 дүгээр зүйлд Үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх зохион байгуулалт, хуралдааны хэлбэрийн талаар тусгажээ. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20-33 дугаар зүйлд энэ тухай зохицуулж байна. Дээрх хоёр хуулийн зохицуулалтыг харьцуулж үзье.

Хүснэгт 7.9. 2023 оны ҮХЦМХШтХ болон 1997 оны ҮХЦМХШАтХ харьцуулалт

2023 оны ҮХЦМХШтХ-ийн төсөл	1997 оны ҮХЦМХШАтХ	Өөрчлөлт
37 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт	3 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн	Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааны гишүүдийн тоог хэвээр үлдээсэн бөгөөд дунд суудлын хуралдааны гишүүдийн тоог 5 байсныг 6 болгож, их суудлын хуралдааны гишүүдийн тоог 7-9 байсныг нийт гишүүд буюу 9 болгож өөрчилсөн байна. Өмнөх хуульд тус бүрэлдэхүүний зохион байгуулалтыг 3 дугаар зүйлд нарийвчлан зохицуулж байсан бол тус хуулийн төсөлд Дэгээр зохицуулахаар тусгажээ. Ийнхүү зохицуулах нь зохион байгуулалтыг тогтворгүй болгох сөрөг үр дагаврыг үүсгэж болох юм.
38 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх хуралдааны хэлбэр		Шинэ хуулийн төсөлд маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг аман болон зөвлөлдөх хуралдаанд хуваасан байна. Аман хуралдаан нь өмнөх хуульд тусгагдсан зохион байгуулалттай төстэй бол маргааныг зөвлөлдөх хуралдаанаар хянан шийдвэрлэхэд маргааны оролцогчийг хуралдаанд оролцуулахгүй, хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэх явцад цугларсан тайлбар, баримтад үндэслэн зөвлөлдөх тасалгаанд маргааныг хэлэлцэхээр зохицуулжээ. Тус тохиолдолд иргэн, эсхүл Үндсэн хуулийн цэцэд хандах бусад субъектийн хуралдаанд биечлэн оролцох эрх зөрчигдөж магадгүй тул дахин харах шаардлагатай.

28 Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй”, хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 143-144 дэх тал.

39 дүгээр зүйл. Бага суудлын хуралдаан	21 дүгээр зүйл.Цэцэд өргөдөл, мэдээлэл хүсэлтийг хүлээн авах	Бага суудлын хуралдаанаар маргаан шийдвэрлэх хугацааг уртасгаж 14 хоног байсныг 30 хоног болгож дахин нэг удаа 30 хоногоор сунгах боломжтойгоор зохицуулсан.
40 дүгээр зүйл. Бага суудлын хуралдаанд бэлтгэх		
41 дүгээр зүйл.Маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэх		Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэхдээ маргаан үүсгэхээс татгалзах тохиолдлуудыг хуульчилсан нь үр дүнтэй зохицуулалт болсон.
42 дугаар зүйл. Дунд суудлын хуралдаан		Дунд суудлын хуралдааны талаар тусад нь зохицуулсан байна.
43 дугаар зүйл. Маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл	23 дугаар зүйл. Цэцийн хуралдаанд бэлтгэх 24 дүгээр зүйл. Цэцийн хуралдааныг зарлах	Үндсэн хуулийн маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажиллагаанд өмнөх хуулиас зарим ач холбогдолтой зохицуулалт байсныг (зарим ажиллагаа, хуралдаан зарлах) хассан байна. Тухайлбал, маргагч талуудад өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлын, хуулбарыг гардуулж, маргаанд оролцох итгэмжилсэн төлөөлөгчөө томилох тухай мэдэгдэх, маргагч талуудад энэ хуульд заасан эрх, үүргийг танилцуулж, Цэцэд шинээр нотлох баримт гаргахад нь туслах, маргагч талууд болон тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгчийг асууж, тайлбар, тодорхойлолт гаргуулах болон маргагч талууд, гэрч, шинжээч болон бусад оролцогчдод Цэцийн хуралдаан болох газар, өдөр, цагийг албан ёсоор мэдэгдэх гэх мэт.
44 дүгээр зүйл. Аман хуралдааны дараалал	25 дугаар зүйл. Цэцийн хуралдаанд хүндэтгэл үзүүлэх 26 дугаар зүйл. Цэцийн хуралдааныг нээх 28 дугаар зүйл. Цэцийн хуралдаанд маргаан хянан хэлэлцэх	Хуралдааны үндсэн үйл ажиллагааг шинэчлэн зохицуулсан байна.
45 дугаар зүйл. Аман хуралдаанд хүрэлцэн ирээгүйн үр дагавар	27 дугаар зүйл. Цэцийн хуралдаанд оролцогч тал хүрэлцэн ирээгүйн холбогдол	Оролцогч хүрэлцэн ирээгүйн үр дагаврыг шинэчлэн зохицуулсан байна.
46 дугаар зүйл. Зөвлөлдөх хуралдаан	29 дүгээр зүйл.Цэц шийдвэр гаргахаар зөвлөлдөх	Зөвлөлдөх хуралдаанаар шийдвэрлэх зохицуулалтыг шинэчлэн зохицуулсан байна.
47 дугаар зүйл. Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулах		Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулах талаар нарийвчилж зохицуулсан нь үр дүнтэй байна.
48 дугаар зүйл. Их суудлын хуралдаан		Их суудлын хуралдаанаар шийдвэрлэх асуудлын хүрээ болон бусад зохион байгуулалтын асуудлыг нарийвчлан зохицуулсан нь үр дүнтэй байна.
49 дүгээр зүйл. Маргааныг эцэслэн шийдвэрлэх	30 дугаар зүйл. Маргааныг дахин хянан шийдвэрлэх	Маргааныг эцэслэн шийдвэрлэх болон дахин хянан шийдвэрлэх талаар шинэчлэн зохицуулсан. Гэхдээ маргааныг дахин хянан шийдвэрлэх үндэслэлийг тодорхой дурдаагүй байна. Тухайлбал, шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар тодорхойлоогүй байна.

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэлд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга Н.Болортунгалагийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (эрх зүйн зохицуулалтын хүрээнд)” сэдэвт илтгэлд²⁹ маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалтын талаар дараах асуудлыг хөндсөн ба тус төсөлд асуудлууд шийдвэрлэгдсэн эсэхэд дүн шинжилгээ хийж үзье.

Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах ажиллагааны талаар:

Үндсэн хуулийн цэцийн гишүүн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авч урьдчилан шалгана, харин хүсэлтийг хүлээн авсан гишүүн шууд маргаан үүсгэн шалгана гэж хуульд заасан. Үүнийг Үндсэн хуулийн цэцэд хандаж буй иргэн, нөгөө талаас эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль зүйн боловсрол, мэргэшсэн байдал, ажлын албаны ялгаатай байдалтай холбож тайлбарладаг. Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах ажиллагааг Цэцийн гишүүн 14 хоногийн дотор явуулахаар хуульчилсан. Харин хүсэлтээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа “шууд үүсгэнэ” гэж хуульчилсан нь хүсэлтийг хүлээн авмагц аливаа ажиллагаа явуулахгүй нэн даруй үүсгэх, эсхүл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзахгүй гэсэн агуулгатай эсэх дээр санал зөрөлдөх тохиолдол практикт гардаг. Иймд дээрх “шууд” гэсэн ойлголтын агуулгыг тодорхой болгох шаардлага үүсжээ.

Тус хуулийн төслийн тухайд хүсэлтээр Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үүсгэх үндэслэлийг тусгаагүй бөгөөд өргөдөл, мэдээллийн адилаар бага суудлын хуралдаанаас маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэх учир тухайн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Мөн хуульд заасан дээрх 14 хоногийн хугацаа төдийлөн оновчтой бус буюу богино юм. Өргөдөл, мэдээлэлд тусгасан асуудал нь Үндсэн хуулийн маргаан мөн эсэхийг тогтоохын тулд холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тайлбар, тодорхойлолт, лавлагаа бичгээр авах, ижил төстэй хэргийн лавлагаа судалгаа хийх зэрэг тохиолдолд уг хугацаа хангалтгүй байдаг. Үүнээс шалтгаалан уг хугацааг сунгах тохиолдол олон гардаг бөгөөд нийтлэг заалтыг баримтлан хугацааг сунгадаг нь гомдол, шүүмжлэл гаргах үндэслэл болж байна. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээллийн 70 гаруй хувийг нэг гишүүний тогтоолоор маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байдаг. Эдгээрийн 40-50 орчим хувьд нь урьдчилан шалгах хугацааг сунгасан үзүүлэлттэй байна. Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах нь Үндсэн хуулийн зөрчлийг таслан зогсоох гол хөшүүрэг болоод зогсохгүй, нөгөө талаас ач холбогдолгүй хүнд процесс буюу эрх зүйн үр дагаваргүй хуралдаан хийхээс сэргийлэх, улмаар бусад маргааны талаар үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлнэ. Иймд уг хугацааг нэмэх шаардлагатай юм. Бусад улсад уг хугацааг 30 ба түүнээс дээш хоног байхаар зохицуулсан нь нийтлэг байна. Тухайлбал, ОХУ-д урьдчилсан судалгааг 2 сарын дотор хийдэг бол Австри, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бусад шатуудын адил тодорхой

29 “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, (УБ, 2023), 118 дахь тал.

хугацаа заадаггүй байна. БНСУ-ын тухайд иргэдийн гомдлыг урьдчилан шалгаад 30 хоногийн дотор Бага суудлын бүрэлдэхүүнээс татгалзсан шийдвэр гаргаагүй бол үүссэнд тооцдог зохицуулалт үйлчилдэг.

Тус хуулийн төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт зааснаар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг гардуулснаас хойш долоо хоногийн дараа 30 хоногийн дотор Бага суудлын хуралдааныг хийх ба бага суудлын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд уул хугацааг 30 хоногоор нэг удаа сунгаж болохоор зохицуулсан нь тухайн асуудлыг шийдвэрлэсэн байна гэж үзэж болохоор байна.

Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах шатанд Цэцийн гишүүн чухам ямар ажиллагаа хийх талаар хуульд тодорхой заагаагүй. Иймд тухайн асуудлыг бүрэн дүүрэн, судалгаанд үндэслэн шийдвэрлэхийн тулд холбогдох ажиллагааг Цэцийн гишүүд хийж ирсэн бөгөөд энэ хүрээнд хуралдаанд бэлтгэх явцад хийгдэхээр хуульд заасан ажиллагаануудаас аль шаардлагатайг явуулдаг жишиг тогтоод байгаа. Иймд хуулийн хийдлийг даван туулсан уг практикийг харгалзан, холбогдох журмыг хуульчлах, эсхүл тухайн шатны онцлогт тохирсон ажиллагааг хуульд тодорхойлон тусгах нь зүйтэй байна.

Тус хуулийн төсөлд өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах шат буюу өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах шатанд хамаарах шалгуур үзүүлэлтийг тухайлан авч үзсэн тул тухайн асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэж болохоор байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар Цэцэд хандах эрх бүхий этгээд нь эрх зүйн байдлын хувьд ямар онцлогтой болох, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрх, хүлээх үүрэг нь ялгаатай эсэхийг тодорхойлон хуульчлаагүй. Дээрх хуулийн 18 дугаар зүйлд Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг хуульчилсан боловч Үндсэн хуулийн цэцэд хандах хэлбэр /өргөдөл, мэдээлэл, хүсэлт/-тэй нь уялдуулан авч үзээгүй, нийтлэг байдлаар зохицуулсны зэрэгцээ, шаардлагаасаа аль ч шатанд татгалзах эрхтэй байхаар хуульчилсан.

Тус хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт маргаанд оролцогчийн эрх зүйн байдлын талаар тухайлан зохицуулсан байна. Ингэхдээ үндсэн оролцогч, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх, өмгөөлөгч, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хуралдааны нарийн бичгийн дарга гэх байдлаар оролцогчдын эрх зүйн байдлыг нарийвчлан авч үзсэн.

Өнөөгийн нийгмийн чиг хандлага, тулгарч буй сорилт (цар тахал, цахим хөгжил, техник, технологийн хурдацтай дэвшил гэх мэт/-той уялдуулан дэлхийн бусад улсын туршлагын дагуу Үндсэн хуулийн цэц иргэдээс цахим хэлбэрээр өргөдөл, мэдээлэл, гомдол авах боломжийг хуульчлах шаардлага мөн өсөн нэмэгдэж байна. Өнөөгийн практикт цахим шуудан ашиглан өргөдөл, мэдээлэл хүлээн авч байгаа боловч энэ нь Цэцийн тухай хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөөгүй, иймд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг нийтлэг байдлаар хэрэглэн хүлээн авч байна. Бусад улс оронд Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах хандлага нийтлэг болсон байна. Тухайлбал, ОХУ, БНСУ-д өргөдөл, гомдол хүлээн авах цахим программ нэвтрүүлэн шийдвэрлэсэн байна.

Тус хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг бичгээр, эсхүл цахимаар Цэцэд гаргана.” гэж зохицуулснаас гадна хуралдааныг маргааны оролцогч, эсхүл Цэцийн гишүүний саналыг үндэслэн цахимаар явуулж, эсхүл зайлшгүй тохиолдолд бүрэлдэхүүний зарим гишүүн, маргааны тодорхой оролцогчийг хуралдаанд цахимаар оролцуулж болохоор тусгасан дэвшилттэй зохицуулалт болжээ.

Маргаан үүсгэх эсэх талаарх шийдвэр гаргах талаар:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт маргаан үүсгэхээс татгалзах 4 үндэслэлийг заасан. Гэвч Цэцийн гишүүний маргаан үүсгэхээс татгалзах тухай тогтоолд уг үндэслэлээс дурдаагүй байх тохиолдол байдаг. Энэ нь процессын эрх зүйн онол, чиг хандлагын хүрээнд Үндсэн хууль болон Цэцийн тухай хууль дахь “өөрийн санаачилгаар” гэсэн ойлголтын хүрээнд Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхэд хамаардаг. Тодруулбал, тухайн хандсан асуудал нь хэдийгээр Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарч байгаа боловч Цэцийн гишүүн тухайн асуудлаар урьдчилсан шалгалт хийгээд уг асуудал нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг илт зөрчөөгүй буюу Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулаагүй, маргаан үүсгэх шаардлагагүй гэсэн итгэл үнэмшилд хүрсний үндсэн дээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тохиолдлууд байгаатай холбоотой.

Дээр дурдсан “илт” гэдгийн хэмжүүр, шалгуурыг нэг мөр болгох боломж ярвигтай асуудал. Үндсэн хуулийн хяналт бүхий орнуудын Үндсэн хуулийн эрх зүйн процесс, түүний дотор өргөдөл хүлээн авах, түүнийг урьдчилан шалгах явцад “илт” гэсэн томъёоллыг хэрэглэсэн тохиолдлууд байдаг. Австри, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулиар тухайн асуудал Үндсэн хуулийн шүүхийн харьяаллын бус нь илт, Үндсэн хуулийн маргааны шинжийг илт агуулаагүй байвал өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг буцаах тохиолдол олонтой гардаг байна. Гэхдээ бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд шүүгч дангаараа шийдвэрлэдэг зохицуулалт төдийлөн байдаггүй бөгөөд бүрэлдэхүүнээр шийдвэрлэдэг хандлага тогтсон байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт маргаан үүсгэхээс татгалзах 4 үндэслэлийн хоёр нь хэлбэрийн шинжтэй буюу Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны зүгээс хариу өгч, бүрдүүлбэр хангуулах боломжтой үндэслэл байдаг. Иймд энэ талаарх зохицуулалтыг тодорхой болгох, мөн хуулийн шаардлага хангасан бөгөөд харьяаллын асуудлаар хандсан боловч уг асуудал нь илт Үндсэн хуулийн маргааны шинжгүй бол хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг процессын хуульдаа тусгах боломжтой байна

Хуулийн төслийн 18 дугаар зүйлд уг асуудлыг шийдвэрлэж дараах хоёр объектив шалгуур байхаар тусгасан байна.

- энэ хуулийн 16 /Цэцэд хандах хэлбэр/, 17/Цэцэд хандах хугацаа/, 18 / Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавих шаардлага/ дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;
- Цэцээс урьд өмнө нь хариу өгсөн асуудлаар дахин өргөдөл, мэдээлэл гаргасан бөгөөд түүнийг дахин нягтлан үзэх үндэслэлгүй бол.

Бусад улсын туршлагыг судлан үзэхэд ихэнх тохиолдолд маргаан үүсгэх эсэх асуудлыг 3-5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэдэг бөгөөд санал нэгтэй татгалзсанаас бусад тохиолдолд маргаан үүссэнд тооцдог зохицуулалт нийтлэг байна. Харин Монгол Улсын хувьд өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж байгаа Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах асуудлыг дангаараа шийдвэрлэж байгаа нь Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар шийдвэрлэх ёстой маргааныг орхигдуулах эрсдэлийг дагуулна. Иймд бүрэлдэхүүнтэйгээр буюу Бага суудлын хуралдаанаар маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй юм.

Тус хуулийн төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт зааснаар Цэц өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсхүл хүсэлтийн дагуу маргаан үүсгэх эсэхийг Бага суудлын хуралдаанаар буюу гурван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэхээр тусгасан.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд бэлтгэх шатны талаар:

Маргааныг нэгтгэх, тусгаарлах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох, хуралдаан хойшлуулах зэрэг ажиллагаа болон холбогдох үндэслэлийг нарийвчлан хуульчлах нь зүйтэй байна. Мөн хуралдаанд бэлтгэх явцад маргаан үүсгэх үндэслэл болсон маргааны зүйл өөрчлөгдсөн, үгүй болгох, эсхүл холбогдох албан тушаалтан огцорсон, чөлөөлөгдсөн гэх мэт нөхцөл байдал үүсвэл хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалт хуульд байхгүй тул энэ талаарх хэм хэмжээг хуульчилж эрх зүйн тодорхой байдал бий болгох нь чухал нөлөөтэй юм.

Тус хуулийн төсөлд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох, хуралдаан хойшлуулах ажиллагааг нарийвчлан тусгасан хэдий ч маргааныг нэгтгэх, тусгаарлах талаар нарийвчлан тусгаагүй байгааг анхаарах шаардлагатай.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой тусгаагүй бөгөөд 18 дугаар зүйлд маргагч талуудыг эрх, үүргийг заасан боловч гэрч, шинжээч, орчуулагч зэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдын эрх зүйн байдал, ажиллагааны явцад хэрэгжүүлэх эрх, үүргийг хуульчлаагүй байдаг. Үүний улмаас бусад хуулийн холбогдох хэм хэмжээг хэрэглэх (11 дүгээр зүйлийн дагуу) шаардлага үүсдэг боловч тухайн зохицуулалт Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны онцлогт тэр бүр нийцэхгүй байх нь олонтой. Үүний зэрэгцээ маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийг оролцуулах эсэх асуудал (оролцуулах шаардлага практикт гарах боломжтой) нь маргаан дагуулдаг. Иймд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон бусад оролцогч, гуравдагч этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, тэдний онцлогтой нь уялдуулан холбогдох хэм хэмжээ, журмыг хуульчлах нь Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Өмнө дурдсанчлан хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт маргаанд оролцогчийн эрх зүйн байдлын талаар нарийвчлан зохицуулсан байна. Гэхдээ гуравдагч этгээдийн талаар тусгаагүй байгаа учраас хуулийн төсөлд энэ талаар зохицуулах эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд бэлтгэх хугацааг 30 хоног байхаар хуульчилсан. Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэж байгаа маргааны агуулга, хүрээ өргөн, гаргах шийдвэрийн үр нөлөө их, цаашид жишиг болж нийтэд үйлчилдэг онцлогоос хамаарч Цэцийн хуралдаанд бэлтгэх ажиллагааг бүрэн дүүрэн явуулах нь чухал байдаг. Торуулбал, энэ шатанд Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэх хуулийн шаардлагын үүднээс холбогдох байгууллага, албан тушаалтнаас тайлбар, тодруулга авахаас гадна, бусад нотлох баримт цуглуулах, тухайн асуудлаарх онол, үзэл баримтлалын судалгаа хийж чиг хандлагыг тодорхойлох, түүхчилсэн болон харьцуулсан судалгаа явуулах, ижил агуулгатай шийдвэртэй танилцах, шинжээч томилон дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагааг явуулдаг тул 30 хоногт эдгээр ажиллагааг гүйцэтгэх боломж хомс, сунгах тохиолдол нийтлэг гардаг билээ. Иймд уг хугацааг нэмэх, бусад улсын жишигт ойртуулж 90-180 хоног болгох нь зүйтэй байна.

Тус хуулийн төслийн 43 дугаар зүйлд маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийн талаар зохицуулсан бөгөөд энэ талаар хугацааг тогтоогоогүй байна. Өөрөөр хэлбэл, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэгт маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангагдсан бол илтгэгч гишүүн хуралдааны бүрэлдэхүүнтэй зөвшилцөн хуралдааны товыг тогтоохоор зохицуулжээ. Ийнхүү тогтоосон нь хугацаа бага байх, бэлтгэлийн үр нөлөө муу байх асуудлыг шийдвэрлэж буй шийдэл боловч нөгөө талаас маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулж болзошгүй байна. Иймд энэ талаар анхаарч үзэх хэрэгтэй.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар маргааныг хэлэлцэх энэ шатанд шийдвэрлэвэл зохих олон асуудал үүсдэг. Цэцийн хуралдааны явцад бүрэлдэхүүнийг татгалзан гаргах, хуралдааныг хойшлуулах, маргагч талууд харилцан тохиролцох, хариуцагч тал шаардлагыг хүлээн зөвшөөрөх, маргагч тал шаардлагаасаа татгалзах, шаардлагаа нэмэгдүүлэх, хүсэлт гаргах гэх зэрэг асуудал үүсдэг тул тодорхой зохицуулалтуудыг процессын хуульд тусгах шаардлага зүй ёсоор бий болдог. Тухайлбал, процессын хуулийн 18 дугаар зүйлд Цэцийн хуралдаан зөвлөлдөхөөр завсарлахаас өмнө аль ч шатанд өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх эрхтэй гэж заасан тул маргагч тал хуралдааны явцад хамааралгүй асуудлаар шаардлага, үндэслэл гаргах, шалгаагүй асуудлыг шийдвэрлүүлэхээр шаардлагаа нэмэгдүүлэх тохиолдол гаргадаг нь тодорхой журмыг хуульчлаагүйтэй холбоотой юм.

Тус хуулийн төсөлд маргагч талууд харилцан тохиролцох, хариуцагч тал шаардлагыг хүлээн зөвшөөрөх талаар тусгаагүй ба дээр дурдсан бусад асуудлуудыг зохицуулсан байна. Иймд шаардлагын талаар харилцан тохиролцох, шаардлагыг хүлээн зөвшөөрөх тохиолдолд хэрхэх талаар тусгах эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлтийн талаар:

Сүүлийн жилүүдэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр үндэслэл багатай гарсан гэж шүүмжлэл дагуулах болсон. Үүний үндсэн шалтгаан нь Цэцийн шийдвэр гаргах талаарх эрх зүйн зохицуулалттай холбоотой хэмээн судлаачийн зүгээс үздэг. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Цэцийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг нэн даруй уншин сонсоно.” гэж заасан. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Цэц шийдвэрээ ёсчилсноос хойш 24 цагийн дотор хүргүүлэх

талаар хуульчилсан байдаг. Үндсэн хуулийн цэцийн практикийг судлан үзэхэд хуулийн дээрх заалтын дагуу шийдвэрээ танилцуулахаас өмнө Цэцийн шийдвэр дээр бүх гишүүд гарын үсгээ зурсны дараа Цэцийн хуралдаанд уншиж, сонсгодог. Иймд Цэцийн шийдвэрийн үндэслэлийг боловсруулах цаг хугацаа хуулийн хүрээнд тун бага байна. Тодруулбал, Цэцийн хуралдаанаар маргааныг хянан хэлэлцсэний дараа 2-4 цагт /зарим тохиолдолд 1 цаг/ багтаан шийдвэр гаргахаар зөвлөлдөж, шийдвэрийн үндэслэлээ бичиж ёсчилдог байна. Иймд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэлийг онолын түвшинд, үндэслэл сайтай, ойлгомжтой гаргах шаардлагын үүднээс Цэцийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулснаас хойш тодорхой хугацааны дараа буюу 14-30 хоногийн дараа шийдвэрийг бүрэн хэмжээгээр, бичгээр үйлдэн ёсчлохоор хуульчлах боломжтой. Мөн хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн тусгай болон зэрэгцээ санал гаргах эрхтэй байх, хүсвэл хэвлүүлэх боломжийг хуулиар олгох нь шийдвэрийн чанарыг нэмэгдүүлэх нэг хөшүүрэг болно.

Тус хуулийн төслийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэгт хуралдаан дууссанаас хойш хоёр сарын дотор Цэцийн шийдвэрийг эцэслэн ёсчлохоор зохицуулсан нь дээрх асуудлыг шийдвэрлэсэн хангалттай урт хугацаа болж байна. Мөн түүнчлэн Цэцийн шийдвэрийг ёсчилсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор Цэцийн дүгнэлт, тогтоол, тусгай саналыг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулж, нийтлэхээр тусгасан нь үр дүнтэй зохицуулалт болжээ.

Маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлд маргааныг дахин хянан шийдвэрлэх үндэслэлийг хуульчилсан бөгөөд эдгээр үндэслэлээр хуралдаанд бэлтгэх шатнаас эхлэн дахин хянан шийдвэрлэхээр заасан. Үүнд:

1/Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй;

2/урьд шийдвэрлэсэн маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар Цэцийн гишүүдийн олонхи санал гаргасан;

3/шинэ нөхцөл байдал илэрсэн.

Хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд “Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй” гэх үндэслэл нь ойлголтын хувьд маргаангүй хэрэгжиж байгаа бөгөөд бусад 2 үндэслэл нь агуулгын хувьд тодорхой бус хэрэгжүүлэх журам нь хуульчлагдаагүй тул практикт нэгдсэн жишиг тогтоогүй, маргаантай асуудал хэвээр байсаар байна. Иймд шинэ илэрсэн нөхцөл байдал гэх ойлголтыг өргөн хүрээнд (улс төр, нийгмийн өөрчлөлт, эрх зүйн шинэ орчин бий болгох гэх мэт) авч үзэх эсэх, эсхүл бусад процессын хуулиар тодорхойлсон шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн нотлох баримтад холбогдох явцуу хүрээнд авч үзэх эсэхийг нэг мөр болгох, түүнчлэн “урьд шийдвэрлэсэн маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар Цэцийн гишүүдийн олонхи санал гаргасан” гэх үндэслэлийн хүрээнд “маргааныг дахин хянан шийдвэрлэх шаардлага”-д ямар нөхцөл байдал хамаарах, олонхын саналыг бүрдүүлэх журам, ийнхүү санал, санаачилгыг хэн гаргах, иргэдээс уг асуудлаар хандах эсэх гэх мэт шийдвэрлэх шаардлагатай олон асуудал байгааг энд тэмдэглэж байна. Шийдвэрлэвэл зохих эдгээр асуудлуудын талаар нарийвчилсан

судалгаа хийж, хууль хэрэглээний нэгдсэн байр суурийг тодорхойлох, энэ талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Дээрх байдлаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байсан хэдий ч Цэц шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас маргааныг дахин хянан шийдвэрлэх нь үр дүнгүй зөвхөн ноцтой тохиолдолд л дахин хянан шийдвэрлэх нь зүйтэй гэх зохицуулалт жишиг болж байна.

“Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг дахин сэргээх нь Үндсэн хуулийн шүүхийн хувьд ихээхэн ховор зүйл юм. Мөн 96 дугаар зүйл нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 135.3 дахь хэсэгт тусгагдсан ‘Үндсэн хуулийн шүүх үйл ажиллагаагаа Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд заасан субъектүүдийн санаачилгаар явуулна’ гэсэн заалттай зөрчилдөж байна. Эдгээр субъектүүдийн дунд Шүүх өөрөө байж болохгүй. Хэрвээ шинэ нөхцөл байдал үүсэх, эсхүл шүүх өмнөх шийдвэрээ гаргахдаа үндэслэл болгосон заалтуудад өөрчлөлт орох тохиолдол болгонд өмнөх шийдвэрүүдээ дахин хянах эрхийг Үндсэн хуулийн шүүхэд олговол энэ нь Үндсэн хуульд тогтолцоо дахь тус шүүхийн чиг үүргийг эрсдэлд оруулах болно. Нэмж хэлэхэд, энэ боломж [шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг дахин сэргээх]-ийг хэрэглэх нөхцөл нь юу болох, Үндсэн хуулийн шүүхийн ‘шинэ’ шийдвэр нь өмнөх шийдвэртэйгээ ямар харилцаатай байх, res judicata татгалзлыг хэрхэх вэ гэх мэт хэд хэдэн асуудлыг тодруулах шаардлагатай байна.”

CDL-AD(2002)016 Бүгд Найрамдах Молдова Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөл болон Үндсэн хуульд оруулах холбогдох нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 66.³⁰

Тус хуулийн төслийн 54 дүгээр зүйлийн 54.6 дахь хэсэгт “Гагцхүү Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл тогтоогдсон бол Цэцийн шийдвэрийг баримтлан хэргийг зохих хууль тогтоомжийн дагуу дахин хянаж болно.” гэж зохицуулсан нь дээрх үзэл баримтлалд нийцэж байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих эсэхийг үнэлнэ.

Маргаан шийдвэрлэх хугацаатай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 5 дугаар зүйл нь практикт хэрэгжих эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төслийн танилцуулгад “Өнөөгийн хуулийн хүрээнд өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах хугацааг 14 хоног байхаар заасан бөгөөд хугацааг сунгах талаарх тодорхой зохицуулалт байхгүй, харин Цэцийн хуралдаанд бэлтгэх хугацаа 30 хоног байхаар заасан нь маргааныг бүрэн гүйцэт, бодитой, онолын түвшинд шийдвэрлэхэд оновчтой бус, хэт богино хугацаа юм. Иймд, Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд ирүүлснээс хойш 30 хоногийн

30 “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2020.04.22 Санал № 2022CDL-PI(2020)004, (Уб, 2023), 171 дэх тал.

дотор шаардлагыг хангасан эсэх зэргийг нягтлан үзэж, бүртгэх эсэхийг шийдвэрлэх, бүртгэхээс татгалзсан хариуг маргагч эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор Цэцэд дахин хандаж болох, энэ тохиолдолд уул өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг ажлын таван өдрийн дотор Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж бүртгэхээр зохицууллаа. Цэц маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд тухайн маргаан ээдрээ, төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор хоёр хүртэл удаа сунгаж болно. Энэ нь бусад улсын жишигт нийцэж байгаа юм.” гэжээ.

Хүснэгт 7.10. 2023 оны ҮХЦМХШтХ болон 1997 оны ҮХЦМХШАтХ-ийн ялгаа

2023 оны ҮХЦМХШтХуулийн төсөл	1997 оны ҮХЦМХШАтХ
<p>19.2.Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг ... Цэцэд ирүүлснээс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагчид өгнө.</p> <p>19.4.Ерөнхий бүртгэгчээс өгсөн хариуг маргагч эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд дахин ирүүлж болно.</p> <p>5.1. Цэц энэ хуульд өөрөөр заагаагүй бол маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Хуралдааны бүрэлдэхүүн нь тухайн маргаан ээдрээ, төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор хоёр хүртэл удаа сунгаж болно. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.” гэж заасан.</p>	<p>21.2. Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ.</p> <p>23.2.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэснээс хойш хуралдаанд бэлтгэх ажиллагааг 30 хоногийн дотор гүйцэтгэх бөгөөд маргаан ээдрээ, төвөгтэй шалтгаанаар дээрх хугацаанд дуусахгүй бол Цэцийн дарга 30 хүртэл хоногоор сунгаж болно.</p>

Шийдвэр гаргах хугацаа тогтоосон тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд хэргийг бүрэн шалгах хангалттай хугацаа олгох зорилгоор шийдвэр гаргах хугацаа хэт богино байж болохгүй. Мөн хүний эрхийг Үндсэн хуулийн шүүхээр үр дүнтэй хамгаалахын тулд хэт урт байж болохгүй. Үндсэн хуулийн шүүхийн үр дүнтэй ажиллагааны зүгээс эргийн нарийн төвөгтэй байдал, түүнийг шийдвэрлэхэд шаардагдах хугацааг урьдчилан таамаглах боломжгүй. Иймд Үндсэн хуулийн шүүх зохих боломжит хугацаанд шийдвэр гаргах үүргээ биелүүлэхийн сацуу онцгой тохиолдолд дээрх хугацааг сунгах боломжтой байх ёстой.³¹

Тухайлбал, Армен улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд зааснаар Үндсэн хуулийн шүүх давж заалдах хүсэлтийг бүртгэснээс хойш 6 сараас дээшгүй хугацааны дотор хэргийг шийдэж үндэслэлтэй шийдвэр гаргана. Үндсэн хуулийн шүүх хэргийг хянан шалгах хугацааг 3 сараас дээшгүй хугацаагаар сунгаж болно. Чилид шүүх бүрэлдэхүүний гаргах бараг бүх шийдвэрт хугацааны хязгаарлалт байдаг.

Иймд, Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд ирүүлснээс хойш 30 хоногийн дотор шаардлагыг хангасан эсэх зэргийг нягтлан үзэж, бүртгэх эсэхийг шийдвэрлэх, бүртгэхээс татгалзсан хариуг маргагч эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор Цэцэд дахин хандаж болох, энэ тохиолдолд уул өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг ажлын таван өдрийн дотор Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж бүртгэх, Цэц маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд тухайн маргаан ээдрээ, төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор хоёр хүртэл удаа сунгаж болох зохицуулалт нь бусад улсын жишигт нийцэх, маргааныг бүрэн гүйцэт, бодитой, онолын түвшинд шийдвэрлэхэд оновчтой хугацаа байна.

31 “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2020.04.22 Санал № 2022CDL-PI (2020)004, (УБ, 2023), 48 дахь тал.

Маргаан хянан шийдвэрлэх зардалтай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 7 дугаар зүйл нь практикт хэрэгжих эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлд маргаан хянан шийдвэрлэх зардлын талаар тусгасан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлд мөн зардлын талаар зохицуулжээ.

Хүснэгт 7.11. 2023 оны ҮХЦМХШтХ-ийн төсөл болон 1997 оны ҮХЦМХШАтХ-ийн өөрчлөлт

2023 оны ҮХЦМХШтХуулийн төсөл	1997 оны ҮХЦМХШАтХ	Өөрчлөлт
7 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх зардал	19 дүгээр зүйл.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зардал	Маргаан хянан шийдвэрлэх зардлыг нарийвчлан тусгаж зардлыг хэрхэн тодорхойлох талаар тусгасан байна. Харин өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагч этгээдийн гаргах зардлыг зохицуулаагүй байна.
7.1.Цэцэд маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	1.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагчийн болон бусад шаардлагатай зардлыг улсын төсвөөс төлнө.	
7.2.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх зардалд дараах зүйлийг хамааруулна:	2.Цэцэд маргаан хянан шалгах ажиллагааг үүсгэх үндэслэл болсон өргөдөл, мэдээлэл гаргасан иргэн орон нутагт оршин суудаг бол түүнийг Цэцийн хуралдаанд оролцсонтой холбогдсон зардлыг:	
7.2.1.шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, Цэцийн шийдвэрээр гүйцэтгэсэн ажил үндсэн чиг үүрэгт нь хамаарахгүй бол ажлын хөлс;		
7.2.2.гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;		
7.2.3.хөгжлийн бэрхшээлтэй оролцогчийг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах зардал;	1/уг иргэний өргөдөл, мэдээлэл үндэслэлтэй гэж тогтоогдсон бол Үндсэн хууль зөрчсөн хууль, зарлиг, бусад шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан буюу Үндсэн хууль зөрчсөн албан тушаалтан;	
7.2.4.шаардлагатай бусад ажиллагааг гүйцэтгэсний зардал.		
7.3.Маргаан хянан шийдвэрлэх зардлыг дараах журмаар тодорхойлно:	2/хэрэв өргөдөл, мэдээлэл нь үндэсгүй болж тогтоогдсон бол уг иргэн өөрөө хариуцна.	
7.3.1.шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж байгаа албан томилолтын зардлын хэмжээгээр;		
7.3.2.шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг жишиг үнэлгээг харгалзан тогтоосон хэмжээгээр;		
7.3.3.мэдүүлэг өгөхөөр Цэцэд дуудагдсан хугацаанд гэрч цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар;		

<p>7.3.4.хөгжлийн бэрхшээлтэй оролцогчийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахад шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласны төлбөрөөр;</p>		
<p>7.3.5.бусад зардлыг зохих журмын дагуу.</p>		
<p>7.4.Энэ хуулийн 7.2-т заасан зардлыг тооцож олгох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.</p>		

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн зардлыг зохицуулахдаа өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагч этгээдийн хувьд зардал гарахааргүй улсын төсвөөс бүх зардлыг санхүүжүүлэхээр зохицуулжээ.

Монгол Улсын бусад шүүхийн процессын тухай хуулийн хувьд оролцогч талуудаас зардлыг гаргуулах нь нийтлэг байдаг. Тухайлбал, 2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд дараах зардлыг оролцогчоор төлүүлэхээр тусгажээ.

- шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэсэн ажил үндсэн ажлын чиг үүрэгт хамаарахгүй бол ажлын хөлс;
- гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;
- үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал;
- эд мөрийн баримт хадгалах зардал;
- гэрчийн мэдүүлгийг очиж авсан зардал.

Иймд тухайн зардлыг оролцогчоор төлүүлэх нь зүйтэй эсэхийг гадаад улсуудын нийтлэг жишгээс тодруулах нь зүйтэй.

Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл, гомдол гаргахад зарим улсын хуульд тэмдэгтийн хураамж авахаар зохицуулсан байна. Герман, Австри, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэмдэгтийн хураамжийг хэрхэх талаар тодорхой заалтууд тусгагджээ.

Австри, ОХУ-ын хувьд Үндсэн хуулийн шүүхэд хандахад тодорхой хэмжээний тэмдэгтийн хураамж, төлбөр төлөх зохицуулалттай байхад Герман, Солонгос улсад тэмдэгтийн хураамжгүй байна. Герман болон Солонгос улсад Үндсэн хуулийн шүүхэд хандахад үнэ төлбөргүй байдаг хэдий ч, ийнхүү шүүхэд хандах эрхийг илт урвуугаар ашиглах явдлаас сэргийлж, ийм байдал тогтоогдвол тодорхой хэмжээний мөнгөн төлбөрийн хариуцлага ногдуулах зохицуулалтыг хуульдаа тусгажээ.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 34-р зүйлийн 1-д заасны дагуу Үндсэн хуулийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үнэ, төлбөргүй. Энэ нь санхүүгийн аливаа нэг шалтгаанаар хэн ч үндсэн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулах боломжгүй байдалд орох ёсгүй гэсэн үзэл санаатай холбоотой аж.

Гэхдээ Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 34-р зүйлийн 2-т хэрэв үндсэн хуулийн өргөдөл, эсхүл урьдчилсан шийдвэр гаргуулах өргөдөл гаргахдаа эрхээ урвуулан ашигласан гэж үзвэл 2,600 еврогийн төлбөр ногдуулж болно³² гэж заажээ. Ийнхүү төлбөр тогтоож байгаа нь Үндсэн хуулийн шүүхэд үнэ төлбөргүй хандах эрхийг илт амжилтад хүрэх хэтийн төлөвгүй, үргэлжилж буй ажиллагаанд ямар ч холбоо хамааралгүй өргөдөл гаргах явдлыг эрхээ хариуцлагагүй ашиглаж байгаа байдал гэж үздэгтэй холбоотой байна. Ийм төрлийн хэрэг хэд хэдэн удаа гарч байсан байна. Тухайлбал, санаан зоргоор гомдол, мэдээлэл гаргах, хууран мэхэлсэн мэдэгдэл гаргах зэрэг.

Хэрэв өргөдөл амжилттай болсон тохиолдолд талууд зардлаа, ялангуяа өмгөөлөгчийн хөлсийг нөхөн төлүүлж болдог онцлогтой³³. Үндсэн эрхийн талаарх, мөн Ерөнхийлөгч, шүүгч нарын импичмент (төрийн дээд албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын онцгой журам³⁴)-тэй холбоотой хэрэгт гаргасан өргөдөл нь амжилттай шийдвэрлэгдвэл хянан шийдвэрлэх ажиллагааны үед гарсан зардлыг нөхөн төлдөг байна. Бусад төрлийн хэргийн нөхөн төлбөрийг Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нөхөн төлж болдог ажээ. Хуульчийн төлбөрийн хувьд Хуульчдын цалин хөлсний тухай хуульд заасан хэмжээгээр төлөх ба түүнээс илүү тохирсон хөлсийг нөхөн төлдөггүй. Үүний зэрэгцээ зарим тохиолдолд тухайн өргөдөл нь амжилттай шийдвэрлэгдээгүй ч Үндсэн хуулийн шинжтэй чухал асуудлыг анхаарлын төвд хэлэлцүүлсэн гэх шалтгаанаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан холбогдох зардлыг өргөдөл гаргагчид нөхөн төлөх тохиолдол гардаг байна.

Австрийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 17а-р зүйлд 240 еврогийн тэмдэгтийн хураамж төлөхөөр заажээ. Гэхдээ хэрэглээний үнийн индекс 10-аас дээш хувиар өөрчлөгдвөл энэ хэмжээг зохих байдлаар өөрчлөх бүрэн эрхийг Холбооны канцлер болон Санхүүгийн сайдад олгосон байдаг. Үүний зэрэгцээ зарим орон нутгийн болон төрийн байгууллагыг тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн байдаг. Тэмдэгтийн хураамж төлсөн баримтаа шүүхэд хандах үед өргөдлийн хамт хавсарган эх хувиар өгөх ёстой. Өргөдлийг цахимаар өгөх тохиолдолд тэмдэгтийн хураамжийг цахимаар хэрхэн төлөх талаар мөн хуульдаа зохицуулсан байна.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 38, 39-р зүйлд Үндсэн хуулийн шүүхэд хандахад тэмдэгтийн хураамж төлөхөөр тусгагдсан. Тэмдэгтийн хураамж төлсөн баримтаа Үндсэн хуулийн шүүхэд хандан гаргасан өргөдөлдөө хавсаргасан байна³⁵.

32 ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 34-р зүйлийн (2): The Federal Constitutional Court may charge a fee of up to EUR 2,600 if the lodging of a constitutional complaint or of a complaint pursuant to Article 41 para. 2 of the Basic Law or the application for a preliminary injunction (section 32) constitutes an abuse of rights.

33 ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 34а-р зүйл:

(1) If an application for the forfeiture of fundamental rights (section 13 no. 1), or a motion for the impeachment of the Federal President (section 13 no. 4) or of a judge (section 13 no. 9) proves to be unfounded, the respondent or the accused shall be reimbursed the necessary expenses, including the costs of the defence.

(2) If a constitutional complaint proves to be well-founded, the complainant shall be reimbursed the necessary expenses in full or in part.

(3) In all other cases, the Federal Constitutional Court may order the full or partial reimbursement of expenses.

34 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, Анхны хэвлэл, (УБ, 2007), 229 дэх тал.

35 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 38-р зүйл.

Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргахдаа тэмдэгтийн хураамж төлөх үндэслэл, журам, тэмдэгтийн хураамжийг буцааж олгох, хөнгөлөлт үзүүлэх асуудлыг Үндсэн хуулийн шүүхийн хууль тогтоомжид заасан онцлогийг харгалзан ОХУ-ын татвар, хураамжийн тухай хууль тогтоомжоор зохицуулна³⁶.

Үндсэн хуулийн шүүх өөрийн шийдвэрээр иргэний санхүүгийн байдлыг харгалзан тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, эсхүл хэмжээг нь бууруулах бүрэн эрхтэй.

Төрийн зарим байгууллагын хүсэлт, өргөдлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн зохицуулалтыг мөн хуульдаа тусгасан байна³⁷.

Хэрэв өргөдлийг хүлээн аваагүй, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгосон бол төлсөн тэмдэгтийн хураамжийг буцаан олгодог байна.

Шүүхээс эцсийн шийдвэр гарч хэм хэмжээний акт нь Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн бол өргөдөл гаргасан иргэнд дараах зардлыг Засгийн газраас баталсан хэмжээгээр нөхөн олгохоор шийдвэрлэдэг байна³⁸:

- Төлсөн тэмдэгтийн хураамж;
- Төлөөлөгчөөр төлөөлүүлсэн зардал;
- Шүүхэд ирэхэд гарсан тээвэр, байрны зардал;
- Хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбоотой харилцаа холбооны зардал;
- Цаг хугацаа зарцуулсан зардал³⁹.

Мөн Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргахдаа төлсөн хураамж нь Үндсэн хуулийн зарим шүүхийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийн нэг болдог байна. Гэхдээ тухайн иргэний санхүүгийн чадавхын байдлыг харгалзан Үндсэн хуулийн шүүх уг төлбөрөөс чөлөөлөх буюу хэмжээг нь багасгаж болдог байна. Энэ тухай Оросын Холбооны Улсын 1994 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан байна. Зарим тохиолдолд нэхэмжлэгч нь бүх төрлийн төлбөр болон татвар, хураамж зэргээс бүрэн чөлөөлөгдөж болдог байна⁴⁰.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх зардлыг зохицуулахдаа шүүхэд хандах эрхийг илт урвуугаар ашиглах, илт амжилтад хүрэх хэтийн төлөвгүй, үргэлжилж буй ажиллагаанд ямар ч холбоо хамааралгүй өргөдөл гаргах, өмгөөлөгчийн хөлсийг нөхөн төлүүлэх, Үндсэн эрхийн талаарх, мөн Ерөнхийлөгч, шүүгч нарын импичменттэй холбоотой хэрэгт гаргасан өргөдөл нь амжилттай

36 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 39-р зүйл.

37 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 39-р зүйл: Запросы судов, запросы о толковании Конституции Российской Федерации, ходатайства Президента Российской Федерации по спорам о компетенции, когда он в этих спорах не является стороной, запросы о даче заключения о соблюдении установленного порядка выдвижения обвинения Президента Российской Федерации в государственной измене или совершении иного тяжкого преступления государственной пошлиной не оплачиваются.

38 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 100-р зүйл.

39 Н.Отгончимэг, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа", ХЗДХЯ, (УБ, 2019), 57-59 дэх тал.

40 Арне Мавчич, "Үндсэн хуулийн хяналт", (УБ, 2014), 35-36 дахь тал.

шийдвэрлэгдвэл хянан шийдвэрлэх ажиллагааны үед гарсан зардлыг нөхөн төлөх, хэрэглээний үнийн индекс 10-аас дээш хувиар өөрчлөгдвөл энэ хэмжээг зохих байдлаар өөрчлөх, тэмдэгтийн хураамж төлөх үндэслэл, журам, тэмдэгтийн хураамжийг буцааж олгох, хөнгөлөлт үзүүлэх гэх мэт нөхцөл байдлыг авч үзэхэд илүүдэхгүй.

Цэцэд хандах хугацаатай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 17 дугаар зүйл нь практикт хэрэгжих эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төслийн 17 дугаар зүйлд Цэцэд хандах хугацааг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 7.12. 2023 оны ҮХЦМХШтХ-ийн төслийн 17 дугаар зүйл

ҮХЦМХШТХ	Нөхцөл	Хугацаа
Өргөдөл		
§17.1.1.	Хууль тогтоомж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш	5 жилийн дотор
§17.1.2.	Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-т заасан хууль тогтоомжоос бусад шийдвэр гарсан өдрөөс хойш	1 жилийн дотор
§17.1.3.	Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан сонгуулийн төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш	2 сарын дотор
§17.1.4.	Шүүхийн шийдвэр эсхүл эрх зүйн бусад актыг гардан авснаас хойш	30 хоногийн дотор
§17.2.	Шүүхийн шийдвэрт эсхүл эрх зүйн бусад актад хэрэглэсэн хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцээгүй тухай өргөдлийг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 17.1.1-д заасан хугацаа хамаарахгүй.	Хэдийд ч өргөдөл гаргаж болно.
Мэдээлэл		
§17.3.1.	Энэ зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.3-т заасан асуудлаар тухайн хугацаанд;	5 жил, 1 жил, 2 сарын дотор
§17.3.2.	Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан албан тушаалтан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй гаргаснаас хойш	1 жилийн дотор
§17.3.3.	Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасан асуудлаар	тухайн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд
Хүсэлт		
§17.4.	Хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар	Хэдийд ч хүсэлт гаргаж болно.
§17.5.	Энэ хуулийн 17.4-т зааснаас бусад маргаантай асуудлаар хүсэлт гаргах үндэслэл бий болсон өдрөөс хойш	1 жилийн дотор
§17.6.	Энэ хуульд заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн бол маргагч хугацаа сэргээлгэх саналаа холбогдох баримтын хамт Цэцэд гаргаж болно. Хугацааг сэргээх журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.	

Хүсэлт, өргөдөл гаргах хугацаа янз бүр. Хугацааг хязгаарласнаар тодорхой хугацааны дараа аливаа актын хүчинтэй байдалд хандах боломжгүй болдог тул ийнхүү хугацаа тогтоох нь хууль зүйн тодорхой байдлын зарчмыг (legal certainty)

бүрдүүлдэг.⁴¹

Венецийн комиссын судалгааны тайланд хамрагдсан ихэнх улсад өргөдөл гаргагчид сүүлийн шатны шүүхийн эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 сарын хугацаа олгодог. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргадаг улсуудад (жишээ нь Австри, Хорват, Герман, Серби, Испани) 20 хоногоос 1.5 сар хүртэл арай бага хугацаа тогтоосон байдаг. Нөгөө талаас, гурван сараас нэг жил хүртэлх хугацаа тогтоох нь норматив Үндсэн хуулийн гомдлын механизмтай улсад (жишээ нь, Польш, Литва, Орос, Киргизстан, Украин) байдаг онцлог шинж юм. Эдгээр хугацаа хэт урт байх ёсгүй ч хувь хүн өөрөө гомдол, хүсэлтээ бэлтгэх, эсхүл тухайн хүнийг төлөөлөх үүрэг бүхий хуульчтай болох боломжит хугацаа байх хэрэгтэй. Нэг бүрчилсэн актын хувьд өргөдөл гаргагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаандаа өргөдөл гаргах боломжгүй тохиолдолд шүүх хугацааг сунгах боломжтой байвал зохино гэж Венецийн Комисс зөвлөдөг.⁴²

Хуулийн төслийн танилцуулгад “дагуу одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ҮЦХМХШАтХуулийн дагуу Цэцэд хандаж өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргахад тодорхой хугацаа заагаагүй байдаг. Харин боловсруулж буй хуулийн төсөлд шүүхийн нийтлэг жишгийн дагуу аливаа асуудлаар хандахдаа илүү хариуцлагатай, үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор хандаж буй эрх зүйн акт, маргааны төрлөөс хамаарч тухайлан хугацаа тогтоох чиглэлийг баримталсан” гэжээ.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1.4-т заасны дагуу шүүхийн шийдвэр эсхүл эрх зүйн бусад актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотод өргөдөл гаргахаар заасан байгаа нь олон улсын нийтлэг жишгээс бага хугацаа тогтоосон байна. Мөн хуулийн төслийн 17 дугаар зүйлд гомдол гаргах хугацааг тогтоогоогүй байна.

ҮХЦМХШАтХуульд өргөдөл, мэдээлэл гаргагч нь Цэцийн гишүүний тогтоолыг эс зөвшөөрсөн тохиолдолд ямар хугацаанд гомдол гаргах талаарх зохицуулалтыг тусгаагүй бөгөөд практикт хоёр, гурван жилийн дараа гомдол гаргасан тохиолдол бий. Гэтэл бусад улсын үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд хэлбэрийн шаардлага хангаагүй гэж буцаасан зэрэг шийдвэрт гомдох боломжит хугацааг 60-90 хоног байхаар тогтоосон туршлага байна.⁴³

Иймд хуулийн төслийн 17 дугаар зүйлд заасан цэцэд хандах хугацааны талаарх, зохицуулалтын зарим зүйл заалт (17.1.4) олон улсын нийтлэг жишгээс бага хугацаа тогтоосон байна. Мөн Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрт гомдол гаргах хугацааны хязгаарлалтыг хуулийн төсөлд тусгаагүй байгааг анхаарах хэрэгтэй. “Хугацааны хязгаарлалт нь тодорхой хугацааны дараа актын хүчин төгөлдөр байдал нь маргашгүй болно гэдгийг баталгаажуулдаг тул хууль зүйн тодорхой

41 “Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2021.02.22 Санал № 1004/2020 CDL-AD(2021)001 (УБ, 2023), 24 дэх тал.

42 Мөн тэнд

43 “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, (УБ, 2023), 121 дэх тал

байдлыг хангахад үйлчилдэг”.⁴⁴ Иймд ҮХЦМХШТХуулийн төсөлд гомдол гаргах хугацааны хязгаарлалтыг тогтоох шаардлагатай байна.

Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авахтай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 19 дүгээр зүйл нь практикт хэрэгжих эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Төсөлд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай 1997 оны хуулийн 21 дүгээр зүйлд заасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах зохицуулалтыг өргөжүүлэн, дараах шинэ зохицуулалтыг тусгасан байна.

- Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ хүлээн авна.
- Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг энэ хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Цэц урьд нь тухайн асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг нягтлан үзэж, тухайн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд ирүүлснээс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагчид өгнө. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.
- Ерөнхий бүртгэгч дараах тохиолдолд өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг маргагчид буцаана:
 - энэ хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;
 - Цэцээс урьд өмнө нь хариу өгсөн асуудлаар дахин өргөдөл, мэдээлэл гаргасан бөгөөд түүнийг дахин нягтлан үзэх үндэслэлгүй бол.
- Ерөнхий бүртгэгчээс өгсөн хариуг маргагч эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд дахин ирүүлж болно.
- Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг энэ хуульд заасан шаардлага хангаж, эсхүл түүнийг энэ хуулийн 16.9, 19.4-т заасны дагуу гаргасан бол Ерөнхий бүртгэгч ажлын таван өдрийн дотор Цэцийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарь, Дэгд заасны дагуу Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж, хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэнэ.
- Цэцэд хандах эрхээ урвуулан ашиглаж, эсхүл хариу өгсөн, шийдвэр гарсан асуудлаар удаа дараа хандаж, Цэцийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

Өөрөөр хэлбэл, өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн Тамгын газар хүлээж авч Ерөнхий бүртгэгч бүртгэсэн эсэхийг шийдвэрлэх нь шинэлэг зохицуулалт болж байна. Энэ нь Үндсэн хуулийн цэц хүний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэдэг болсонтой холбоотой үндэслэлгүй өргөдөл гаргаж Цэцийн ачааллыг ихэсгэхээс урьдчилан сэргийлэх юм.

44 European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §32; “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, (УБ, 2023), 50 дахь тал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулгад үүнийг “бусад улс орны хувьд энэхүү урьдчилсан хяналтыг Үндсэн хуулийн шүүхийн тамгын газар, Ерөнхий бүртгэлийн хүрээнд гүйцэтгэдэг жишиг тогтсон байна. Иймд шинэ хуулиар Цэцэд ирсэн өргөдөл, мэдээллийн анхны буюу хэлбэрийн шалгалтыг Тамгын газар, Ерөнхий бүртгэлийн хүрээнд шалгаж, хуулийн шаардлага хангаагүй асуудалд бүртгэгч /хуульч/ нар хариу өгч буцаах, зарим тохиолдолд хуулийн шаардлага хангуулах зэрэг арга хэмжээг авахаар журамлав.”⁴⁵ гэж ач холбогдлыг тодорхойлсон байдаг.

Хувь хүнд Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг өргөжүүлэн олгохтой эсрэгцэх гол үндэслэл нь Үндсэн хуулийн шүүхэд хэт ачаалал учруулж болзошгүй байдал юм. Үндсэн хуулийн иж бүрэн гомдлын хувьд энэхүү ачаалал нэмэгдэх эрсдэл өндөр, учир нь Үндсэн хуулийн шүүхийн харьяалах хэргийн дийлэнх хэсгийг буюу зарим тохиолдолд ачааллын 90 гаруй хувийг иргэний мэдээлэл эзэлдэг. Улмаар, талууд зөвхөн ердийн шүүхийн шийдвэрт сэтгэл дундуур байгаагаас болж Үндсэн хуулийн хүрээнд хамааралгүй олон маргаан ирж Үндсэн хуулийн шүүхэд ачаалал ихсэх боломжтой. Үндсэн хуулийн шүүхэд иж бүрэн гомдол гаргадаг улсууд хэрэг маргааны хэт их ачааллыг шийдэхийн тулд ихэвчлэн хэд хэдэн шалгуур тавьсан байдаг. Тэрчлэн, зарим Үндсэн хуулийн шүүх аль хэргийг бага танхимд хянан хэлэлцэх эсхүл шийдвэрлэх эсэхийг сонгон шүүдэг практиктэй. Үндсэн хуулийн шүүхэд хэт ачаалал үүсгэх эрсдэл болон Үндсэн хуулийн хяналтад үр дүнтэй хандах хувь хүний хэрэгцээ хоёрыг тэнцвэртэй байлгахад анхаардаг. Улс орнууд энэ хүндрэлийг олон аргаар шийдэж ирсэн. Зарим улс хувь хүнд гомдол гаргах боломжийг эхнээс нь олгоогүй. Зарим нь процедурын «шүүлтүүр» нэвтрүүлсэн. Түүнчлэн, ижил төстэй хэргийг нэгтгэх, мөн Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэх хэргээ илүү шүүлтүүртэй сонгох нь шүүхийн ачааллыг хөнгөвчлөхөд тус болж чадна.

Хүний эрхийг хамгаалах баталгаа болох Үндсэн хуулийн шүүхэд хандах арга замыг хялбар байлгахыг Венецийн Комиссоос зөвлөдөг. Үндсэн хуулийн шүүхийг хэт ачаалалтай байлгахгаас сэргийлэх зорилтыг Венецийн Комисс дэмжиж байгаа ч, Үндсэн хуулийн шүүх нь илтэд урвуулан ашигласан өргөдөл биш л бол өргөдлийг хүлээн авахаас татгалзахдаа стандарт хэлбэрээр ч болов үндэслэлтэй шийдвэр гаргаж өгөх ёстой гэж үзэж байна⁴⁶. Үүнд хамааруулан дараах стандарт шүүлтүүрүүдийг тавьдаг байна.

1. Өргөдөл гаргах хугацаа
2. Хууль ёсны төлөөлүүлэх үүрэг
3. Шүүхийн хураамж
4. Бичгэн хэлбэр
5. Илт үндэслэлгүй, хөнгөмсгөөр хандсан, урвуулан ашигласан, давтан гаргасан өргөдөл
6. Эрх зүйн хамгаалалтын бүх арга хэрэгслийг хэрэглэж дуусгасан байх
7. Шууд болон гэнэтийн хор уршиг
8. Хохирол барагдуулах боломж

45 Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулга.

46 “Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2021.02.22 Санал № 1004/2020 CDL-AD(2021)001 (УБ, 2023), 23-25 дахь тал.

9. Урьдчилсан хүсэлтийн шүүлтүүр
10. Ижил төрлийн хэргийг нэгтгэх

Гомдлыг урьдчилан сонгох (шүүлтүүрийн аргыг хэрэглэх) нь ХБНГУ-ын тогтолцоонд илүүтэй хөгжсөн бөгөөд амжилт олох боломж муутай гомдлыг ялгаж Үндсэн хуулийн шүүх тийм гомдлоос татгалзах маневр хийх орон зайг олгодог. Гэхдээ энэ нь зарчмын хувьд Үндсэн хуулийн гомдол гаргах эрхийг хаахгүй байх ёстой. Үндсэн хуулийн шүүхийн өмнө тулгардаг томоохон асуудлын нэг нь ардчилсан тогтолцоонд хүний эрхийг үр нөлөөтэй хамгаалах боломжийг бүрдүүлэх, нөгөө талаас буудайг гурилаас салгаж ялгах амаргүй шаардлага тулгардаг. Мөн, зарим тодорхой тогтолцоонд Үндсэн хуулийн гомдол гаргадаг байх санаачилга нь харьцангуй шинэлэг бол, заримд нь урьдчилан сонголт хийх шаардлага тавигддаг, харин зарим тогтолцоонд ийм боломжийг хүчингүй болгож өөрчлөхөөр яригдаж байх жишээтэй⁴⁷.

Үндсэн хуулийн цэцийн тамгын газар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шалгаж байгаа нь Цэцийн ачааллыг ихэсгэхээс урьдчилан сэргийлэх арга хэдий ч объектив стандарт шалгуурыг удирдлага болгон гомдлыг хүлээн авах эсэх шийдвэрийг гаргах нь зүйтэй байна. Одоогийн хуулийн төсөлд энэ талаар тусгасан хэдий ч шууд болон гэнэтийн хор уршиг, хохирол барагдуулах боломж, урьдчилсан хүсэлт зэрэг шүүлтүүрийг мөн авч үзэх нь зүйтэй. Гэхдээ хамгийн гол нь тухайн иргэний Үндсэн хуулийн гомдол гаргах эрхийг хаахгүй байх нь чухал. Үүний дагуу Үндсэн хуулийн цэцийн тамгын газар, ялангуяа Ерөнхий бүртгэгчийг чадавхжуулах, тэдэнд тавигдах шалгуурыг өндрөөр тогтоох зэргээр бэхжүүлэх хэрэгтэй.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон болон логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгана. Ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг нарийвчлан давхар шалгана.

Үндсэн хуулийн цэцийн дэгтэй холбоотой нэр томъёо буюу хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг нь ойлгомжтой эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны нарийвчилсан журмыг Цэцийн зөвлөгөөнөөс энэ хуульд нийцүүлэн баталсан Үндсэн хуулийн цэцийн дэг /цаашид “Дэг” гэх/-ээр зохицуулна.” хэмээн заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” 85 дугаар зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль нь ... зайлшгүй зохицуулах зарим харилцааг зохицуулаагүйгээс Цэцийн дүгнэлт, шийдвэрт нөлөөлж байгааг өөрчлөх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийг нарийвчлан зохицуулах.” гэсэн үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагатай хэмээн үзжээ. Үүний дагуу төсөлд дээрх зүйл заалтыг тусгасан байна.

47 Арне Мавчич, “Үндсэн хуулийн хяналт”, (Уб, 2014), 65 дахь тал.

Дэг (англ. reglament, ор. регламент) гэдэгт 1. ямар нэгэн төрийн байгууллага түүний бүтцийн үйл ажиллагааны дотоод зохион байгуулалт ба үйл ажиллагааны журмыг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээний акт, 2. хурал, хуралдаан, чуулган ба төлөөлөгчдийн байгууллагын их хурал явуулах журмыг ойлгоно.⁴⁸

Одоо хэрэгжиж буй Үндсэн Хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлд Үндсэн хуулийн Цэцийн дэгтэй холбоотой дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Маргаан хянан шалгах ажиллагаанд оролцогч Цэцийн хуралдааны дэгийг чанд сахих, хуралдаан даргалагчид захирагдах үүрэгтэй.
- Маргаан хянан шалгах ажиллагаанд оролцогч Цэцийн хуралдааны дэгийг дахин зөрчих, Цэц болон түүний гишүүдэд хуурамч бичиг баримт өгвөл Цэцийг хүндэтгээгүй үйлдэл гэж үзэж зохих хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Үүнээс харвал Үндсэн хуулийн Цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны нарийвчилсан журмыг Үндсэн хуулийн Цэцийн Дэгээр зохицуулах тухай зохицуулалт өмнө нь хууль, тогтоомжид тусгаагүй байсан ба хуулийн төслийн 2.2-т заасан зохицуулалт нь Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай зүйл мөн байна.

Нэр томьёоны тодорхойлолттой холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 3 дугаар зүйл нь ойлгомжтой эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.4 дүгээр зүйлд зааснаар хуулийн төсөлд дараах тохиолдолд нэр томьёоны тайлбар хийхээр тусгажээ.

- Нэр томьёо нь олон утгатай бол;
- Нэр томьёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол;
- Шинээр бий болсон ойлголт буюу нэр томьёо нь нийтэд ойлгомжгүй бол.

Түүнчлэн тус хуулийн 30.6 дугаар зүйлд “нэр томьёо нь нэг утга агуулгаар нийт хуулийн хэмжээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг хуулийн “Нийтлэг үндэслэл” гэсэн бүлэгт оруулан заана. Хуулийн төсөлд тодорхойлолт өгсөн хэд хэдэн нэр томьёо байгаа бол тэдгээрийг “Хуулийн нэр томьёоны тодорхойлолт” гэсэн гарчигтай зүйлд нэгтгэнэ.” гэж тодорхойлжээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай 1997 оны хуулийн тухайд дараах нэр томьёоны асуудал үүсэж байсан.

- Нэр томьёоны хувьд иргэний өргөдөл, мэдээлэл, түүнчлэн гомдлын талаар Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг зохицуулсан хоёр хуульд тухайлан тодорхойлоогүй байна. Харин эрх зүйн толь бичгүүдэд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан агуулгаар өргөдөл, мэдээлэл, гомдол гэсэн ойлголтыг тусгайлан тодорхойлсон байна.

48 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, Анхны хэвлэл, (Уб, 2007), 185 дахь тал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл буюу нэр томъёоны тодорхойлолт хэсэгт өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн талаар дараах байдлаар тодорхойлсон байна.

- “мэдээлэл” гэж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс иргэдийг төлөөлөн маргаантай асуудлаар энэ хуульд заасны дагуу Цэцэд хандсаныг;
- “өргөдөл” гэж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг нь зөрчсөн, эсхүл зөрчих нь гарцаагүй гэж үзсэн тухайн иргэн эрх хамгаалах, сэргээх шүүхийн болон бусад арга замыг дуусгасны дараа энэ хуульд заасны дагуу Цэцэд хандсаныг;
- “хүсэлт” гэж Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Цэцэд хандах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас маргаантай асуудлаар өөрийн чиг үүргийн хүрээнд энэ хуульд заасны дагуу Цэцэд хандсаныг тус тус ойлгохоор зохицуулжээ.

Ийнхүү зохицуулсан нь судлаачдын үзэж буйтай агуулгын хувьд нийцэж байна. Тухайлбал, энэ тухай хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяа дараах байдлаар авч үзсэн.

Өргөдөл нь тухайн хүнд өөрт нь хамааралтай асуудлаар эрх бүхий байгууллагад хандах агуулгатай. Жишээ нь иргэн хүнд хамааралтайгаар зөрчигдөх магадлалтай зүйл, заалтууд Үндсэн хуулийн үндсэн эрхийг зохицуулсан бүлэгт байршдаг. Учир нь, иргэн хүн үндсэн эрхийг эдлэгч юм. Үндсэн эрхийн аль нэг нь тухайн иргэний хувьд зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан тодорхой журам, шат дамжлагаар Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой.

Харин мэдээлэл гэдэг нь өөрт хамааралтай байх шинж агуулахгүй. Жишээ нь, Үндсэн хуулийн цэцийн харьяалалд хамаарах дурын асуудлаар, тухайлбал УИХ-аас баталсан ямар нэг хууль Үндсэн хуулийн аль нэг зүйл, заалтыг зөрчиж байна хэмээн хандах ажиллагаа нь мэдээлэл гаргах явдал юм.

Хүсэлт нь Үндсэн хуулийн процессын эрх зүйд өргөдөл, мэдээлэлтэй харьцуулахад хувийн бус, албан шугамаар хандах ажиллагааг илэрхийлдэг. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлд, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурор Цэцэд Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлүүлэх хүсэлтээ бичгээр гаргах тухай заасан байдаг⁴⁹.

Мөн түүнчлэн дараах байдлаар тодорхойлдог⁵⁰.

Хүснэгт 7.13. Өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлтийн тодорхойлолт

Цэцэд хандах хэлбэр	Агуулга, онцлог
Өргөдөл	Иргэн өөрийн эрх, ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөж байна гэж Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандах хэлбэр

49 Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй”, хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 194-195 дахь тал.

50 “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, (УБ, 2023), 111-112 дахь тал.

Мэдээлэл	Иргэн өөрийн эрх, ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдсөнөөс бусад үндэслэлээр буюу нийтийн ашиг сонирхлын үүднээс Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандах хэлбэр
Гомдол	Цэцийн гишүүний маргаан үүсгэх эсэх талаарх тогтоолыг эс зөвшөөрч хандах хэлбэр
Хүсэлт	Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлаар хандах хэлбэр

Дээрхээс дүгнэвэл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд дээрх агуулгаар зохицуулсан нь эрдэмтэн, судлаачдын тайлбартай нийцэж буй хэдий ч “Гомдол”-ын талаар нэр томъёоны тодорхойлолтод тусгаагүй байна. Иймд “Гомдол”-ын талаар нэр томъёоны тодорхойлолтод тусгах шаардлагатай. Түүнчлэн тус хуулийн төсөлд гомдол гаргах эрх зүйн зохицуулалтын талаар төдийлөн тусгаагүйг анхаарч үзэх хэрэгтэй. Мөн “Мэдээлэл”-ийн тодорхойлолтыг “нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс иргэдийг төлөөлөн маргаантай асуудлаар” гэснийг илүү хүлээн зөвшөөрөгдөх тодорхойлолтод ойртуулан өөрийн эрх, ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдсөнөөс бусад үндэслэлээр гэх байдалтай холбогдуулан тайлбарлах нь зүйтэй.

- “Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх эсэх талаарх гишүүний шийдвэр” гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь Цэцийн гишүүний маргаан үүсгэсэн болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан шийдвэрийн аль аль нь хамаарах агуулгыг илэрхийлж байна. Үүнээс улбаалан практикт Цэцийн гишүүний маргаан үүсгэсэн тогтоолд гомдол гаргасан тохиолдлууд гарсан бөгөөд ийнхүү гомдол гаргах нь тухайн маргааныг хянан шалгах ажиллагаанд саад учруулах, хугацаа алдах, Дунд суудлын хуралдаанд бэлтгэх ажиллагааг тасалдуулах, ачаалал үүсэх зэрэг олон сөрөг үр дагавартай. Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар маргаан үүсгэхэд тухайн этгээд өөрөө гомдол гаргасан тохиолдол гарч байсан боловч Бага суудлын хуралдаанаас Цэцийн гишүүний маргаан үүсгэсэн шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн тохиолдол байдаг.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 41.1-т заасан үндэслэлийг магадлалд товч заах бөгөөд магадлал нь маргаан үүсгэх эсэх талаарх эцсийн шийдвэр болно.” гэж зааснаар тухайн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. Гэвч дээр дурдсанчлан гомдлын талаарх эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаагүй нь сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй байна.

- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаарх Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд эс зөвшөөрч гомдол бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.” гэж заасан. Тодруулбал, “маргагч талууд” маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаарх Цэцийн гишүүний шийдвэрт гомдол гаргахаар заасан нь бодит байдалд нийцээгүй. Учир нь маргаан үүссэн тохиолдолд оролцогч талууд нь маргагч тал болох бөгөөд дээрх тохиолдолд маргаан үүсгээгүйтэй холбогдуулан гомдол гаргаж буй тул “маргагч тал” гэх нэр томъёог хэрэглэх нь зохимжгүй юм. Харин уг гомдлыг гаргах эрх нь өргөдөл, мэдээлэл гаргагч иргэнд хадгалагдаж байгаа билээ.

Өмнө дурдсанчлан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд гомдол гаргах талаар тусгаагүйтэй холбоотой маргаан үүсгэсэн шийдвэрт гомдол гаргах нөхцөл байдал арилсан.

Гэхдээ тус хуулийн төсөлд “маргагч” гэдгийг Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлүүлэхээр Цэцэд хандан өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан этгээдийг хэлэхээр зохицуулжээ. Өөрөөр хэлбэл өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан этгээдийн нөгөө талд байх маргалдагч талыг буюу Үндсэн хууль зөрчсөн шийдвэр, үйлдэл гаргасан байж болзошгүй этгээдүүдийг үүнд хамааруулаагүй байна. Энэ нь цаашлаад Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцэх зарчмыг зөрчих магадлалтай тул анхаарч авч үзэх шаардлагатай.

Энэ талаар хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хэлэлцэн шийдвэрлэдэг тул талуудыг маргагч, маргалдагч тал хэмээн нэрлэвэл зохилтой”⁵¹ гэж тодорхойлсон байдаг.

Иймд өмнөх 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тодорхойлсончлон маргагч, маргалдагч тал болгон зохицуулж уламжлалт нэр томъёог хэрэглэн эдгээрийг маргааны үндсэн оролцогч байхаар хуульчлах шаардлагатай.

3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тухайн хууль тогтоомжийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуй, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалт байх тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ.

Маргаан шийдвэрлэх хүрээтэй холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 4 дүгээр зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд маргаан шийдвэрлэх хүрээг дараах байдлаар зохицуулсан байна.

51 Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудлууд”, (УБ, 2005), 183 дахь тал.

Хүснэгт 7.14. Маргаан шийдвэрлэх хүрээтэй холбоотой зохицуулалтын өөрчлөлт

2023 оны ҮХЦМХШтХуулийн төсөл	1997 оны ҮХЦМХШАТХ	Өөрчлөлт
<p>4 дүгээр зүйл.Маргаан хянан шийдвэрлэх хүрээ</p> <p>4.1.Цэц гагцхүү Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх бөгөөд бусад хууль зөрчсөн тухай өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авахгүй.</p> <p>4.2.Цэц энэ хуульд өөрөөр заагаагүй бол хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, эсхүл бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой, Цэцийн харьяалалд хамаарах маргааныг хянан шийдвэрлэнэ.</p> <p>4.3.Хүчингүй болсон хууль тогтоомж, бусад шийдвэр нь Үндсэн хуульд нийцээгүй байсан гэдгийг тогтоолгох ашиг сонирхол өргөдөл гаргагчид бий гэж үзвэл уул маргааныг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 4.2 хамаарахгүй.</p>	<p>15 дугаар зүйл.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ</p> <p>1.Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ.</p> <p>2.Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй.</p> <p>3.Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр үүсгэн явуулна.</p> <p>Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно.</p> <p>4.Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.</p>	<p>Хүчингүй болсон хууль тогтоомж, бусад шийдвэр нь Үндсэн хуульд нийцээгүй байсан гэдгийг тогтоолгох ашиг сонирхол өргөдөл гаргагчид бий гэж үзвэл уул маргааныг хянан шийдвэрлэхээр хуулийн төсөлд зохицуулсан нь үр дүнтэй байна. Өмнөх хуульд зохицуулсан байсан хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болох зохицуулалтыг хуульчлаагүй байна. Мөн түүнчлэн цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх заалтыг хуулийн төсөлд тусгаагүй.</p>

1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх талаар:

1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхгүй байх нь зүйтэй эсэх тухайд Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 4 дүгээр сарын 15-ны дугаар 01 дүгнэлт гарсан байдаг.

Тус шийдвэрийн үндэслэлд “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай

дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.”⁵² гэж тодорхойлсон. Иймд энэхүү зохицуулалт болох «Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.» гэснийг 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн. Гэвч Монгол Улсын Их Хурлын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний 30 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн бөгөөд одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус шийдвэр нь судлаач нарын дунд ихээхэн мэтгэлцээнийг өрнүүлсэн ба өөрийн санал нийлж буй үндэслэлтэй дүгнэлтийг дараах байдлаар авч үзье.

Төрийн байгууллага төдийгүй иргэн бүр тухайн үед мөрдөгдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн зан үйлээ журамлан үйл ажиллагаа явуулдаг. Хэрэв ийнхүү хязгаарлалт тогтоохгүйгээр шинээр батлагдсан хуульд өмнөх хууль үйлчилж байх үеийн нөхцөл байдлыг нийцүүлэх гэвэл эрх зүйн тогтвортой байдал алдагдаж, эмх замбараагүй байдал үүснэ. Ийм учраас хуулийг буцаан хэрэглэхгүй гэсэн нийтлэг зарчим байдаг. ҮХЦМХШАТХ-ийн 15.4 ч “хууль буцаан хэрэглэхгүй байх зарчим”-ыг баталгаажуулсан буюу 1992 оны Үндсэн хуулийг уг хууль үйлчилж эхлэхээс өмнөх харилцаанд буцаан хэрэглэж маргаан шийдвэрлэхийг хязгаарласан байна. Жишээлбэл, Социализмын үеийн үнэн, зөв гэж үзэж байсан зүйл өнөөгийн ардчилсан нийгмийн үнэт зүйлтэй нийцэхгүй байх нь тодорхой. Тэгвэл энэ тохиолдолд Цэц тухайн үед үйлчилж байсан хууль тогтоомж албан тушаалтны үйл ажиллагааг одоогийн Үндсэн хуулиар хэмжиж шийдвэр гаргах нь утгагүй хэрэг болно.

Гэхдээ хуульд заасан хуулийг буцаан хэрэглэж болох ба энэ нь эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, ашиг сонирхолд нийцсэн байх ёстой. Цэц уг уг маргааныг шийдвэрлэхдээ энэхүү зарчмын үүднээс хандах ёстой байсан гэж үзэж байна. Тодруулбал, 1992 онд шинэ Үндсэн хуулийг батлахдаа Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй “БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай” Хавсралт хуулийг баталсан. Тус хуулийн 5.1 дүгээр зүйлд “Монгол улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид дагаж мөрдөнө”, 5.2 дугаар зүйлд “Гагцхүү хуулиар зохицуулж байхаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан харилцааг тэр тухай шинэ хууль батлагдан гаргах хүртэл хугацаанд уул харилцааг зохицуулж ирсэн хууль, эрх зүйн бусад актын заалтаар зохицуулна...”, 5.3 дугаар зүйлд “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөнхүү Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцно” гэж тус тус заасан. Энэ хуулийн зохицуулалтаас үзвэл шинэ Үндсэн хууль мөрдөгдөж эхлэх хугацаанаас өмнө батлагдсан хууль Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр хэвээр мөрдөх боломжтой ба энэ тохиолдолд Цэц Үндсэн хуулийг буцааж хэрэглэх тухай хууль Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах боломжтой.

52 Үндсэн хуулийн цэцийн дугаар 01 дүгнэлт, (УБ, 2020.04.15), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15259>. Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

Цэц 1993 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр 02 дугаар дүгнэлт гаргаж Үндсэн хууль үйлчилж эхлэхээс өмнө батлагдсан хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх маргааныг шийдвэрлэж байсан практик ч байдаг. Гэхдээ одоогийн нөхцөл байдлаас нэг өөр зүйл нь Цэц энэ маргааныг шийдвэрлэх үед ҮХЦМХШАТХууль батлагдаагүй байсан.

Гэвч хууль тогтоогчид ҮХЦМХШАТХуулийг батлах үед Үндсэн хуулийг мөрдөж эхлэхээс өмнө батлагдсан ч хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх хуулиуд байгаа гэдгийг мэдэж байгаа нь эргэлзээгүй болов уу. Тиймээс Цэцийн хянан шийдвэрлэх маргаанд холбогдох хууль тогтоомжийн цаг хугацааны хязгаарлалтыг батлагдсан огноогоор бус, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эсэхээр нь хэмжүүр болгож авч үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, Цэц Үндсэн хууль үйлчилж эхлэхээс өмнө батлагдсан хууль одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тохиолдолд уг хууль Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах боломжтой гэсэн үг. Харин Цэц Үндсэн хууль мөрдөгдөж эхлэхээс өмнөх албан тушаалтны үйл ажиллагааг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах асуудал угаас байх боломжгүй⁵³.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Үндсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдсан эрх зүйн акт, үйлдлийг хянахгүй байх зохицуулалтыг хасаж хуульчилсан ба “Цэц энэ хуульд өөрөөр заагаагүй бол хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, эсхүл бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой, Цэцийн харьяалалд хамаарах маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж зөвхөн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйгээр шийдвэрлэх хүрээг хязгаарласан нь үр дүнтэй зохицуулалт байна.

Хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл хянан шийдвэрлэх талаар:

Тус хуулийн төсөлд хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл хянан шийдвэрлэх талаар зохицуулалтыг тусгаагүй.

Өмнө дурдсанчлан 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлд хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болохоор зохицуулсан нь Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих,...Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болж байсан. Мөн Үндсэн хуулийн цэцийн үр дүнтэй, хэмнэлттэй ажиллах нэг гол арга хэрэгсэл юм.

Өөрөөр хэлбэл, дээрх байдлаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн биелэлтийг хангах онцгой ажиллагааг хуульчилсан. Энд заасан тохиолдол бий болсон бол Их суудлын хуралдаан хийх бөгөөд хялбаршуулсан ажиллагааны журмаар Үндсэн хуулийн зөрчлийг шуурхай таслан зогсоож буй нэг хэлбэр гэж үзэж болохоор байна.

53 П.Баттулга, “Цэцийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ: УИХ Э.Ариунболд нар”, (УБ, 2020), 3-4 дэх тал, Холбоос: <https://legaldata.mn/b/1191>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

Дээрх заалтын талаар “эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээх” гэх ойлголт нь өргөн хүрээг хамарч байх тул цаашид нарийвчлан судалж ойлголтыг нэг болгох шаардлагатай юм. Мөн Цэцийн нэг гишүүний бүрэн эрхийн хүрээнд шууд Их суудлын хуралдаан хийхээр зохицуулсан байгааг эргэн харах, тухайн ажиллагааны журам тодорхой бус байгааг нарийвчлан хуульчлах нь зүйтэй байна гэж судлаачид үздэг⁵⁴.

Энэ талаар Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэлд дараах байдлаар авч үзсэн.

“Өөрөөр хэлбэл, шүүх бүрэлдэхүүн (гомдлыг хүлээж авах шатанд) эсхүл шүүх хуралдаан (хэргийг хэлэлцэх явцад) гомдол гаргагчийн гомдол нь аль хэдийн шийдвэрлэгдсэн маргаантай төсөөтэй гэдгийг ойлгосон бол маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох ёстой. Венецийн хороо нь уг заалт Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг хязгаарлаж байна гэдэг үндэслэлээр дахин өөрчлөн найруулахыг санал болгож байна. Тухайн асуудлаар шийдвэр гарсан байлаа гээд хэргийг дуусгавар болгох, гомдлыг хүлээж авахгүй байх үндэслэл болох ёсгүй юм. Жишээ нь, Шүүх хэм хэмжээний актыг Үндсэн хуульд нийцсэн гэж үзсэн тохиолдолд, тухайн хэм хэмжээний актын талаарх ирээдүйд гарах гомдлуудыг онцгой нөхцөл байдал байхгүй тохиолдолд хүлээж авах боломжгүй гэж зарлах ёстой. Онцгой нөхцөл байдал гэдэгт жишээ нь Үндсэн хуулийн шүүхээс ялгаатай тайлбарыг ердийн шүүх тогтмол хийх явдал байж болох юм. Гэвч, тодорхой хэм хэмжээний актыг Үндсэн хуульд нийцээгүй гэж өмнө нь шүүх үзсэн хэдий ч, тухайн хэм хэмжээг дахин баталсан тохиолдолд, тухайн хэм хэмжээний талаарх гомдлыг шүүх хүлээн авч дахин хянан шийдвэрлэх боломжтой. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр заавал дагаж мөрдөх шинжтэй байх, хууль тогтоогч шийдвэрийг дагаж мөрдөхгүй тохиолдолд асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга хэрэгслээр Үндсэн хуулийн шүүх хангагдах ёстой.

CDL-AD(2014)020, Киргиз Улсын дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 35-38 дах цогцолбор”⁵⁵

Ийм учраас Үндсэн хуулийн зөрчлийг шуурхай таслан зогсоож буй нэг хэлбэр гэж үзэж болохоор зохицуулалтыг тус хуулийн төслөөс хассаныг эргэж харах нь зүйтэй байна. Тус зохицуулалтын хүрээнд дахин сэргээх агуулгыг тодорхойлох, Цэцийн нэг гишүүний санаачилгаар Их суудлын хуралдаан хийдэг байсан нь тухайн зохицуулалтад асуудал үүсгээд байсан учраас бүхэлд нь хасах нь үр дүнгүй юм.

Үндсэн хуулийн цэцийн маргаан шийдвэрлэх харьяаллын талаар:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд Үндсэн хуулийн цэцийн маргаан шийдвэрлэх харьяаллын талаар төдийлөн зохицуулаагүй байна. Өмнөх 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд харьяаллыг дараах байдлаар тодорхойлжээ.

54 “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, (Уб, 2023), 128-129 дэх тал.

55 “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2020.04.22 Санал № 2022CDL-PI(2020)004, (Уб, 2023), 140 дэх тал.

- Цэц Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай дор дурдсан маргааныг хянаж дүгнэлт гаргах бөгөөд шаардлагатай бол дахин хянаж, эцэслэн шийдвэрлэнэ:

1. Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр;
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, бусад шийдвэр;
3. Засгийн газрын шийдвэр;
4. Монгол Улсын олон улсын гэрээ;
5. ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний болон Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр.

- Цэц дор дурдсан албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргана:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч;
2. Улсын Их Хурлын дарга;
3. Улсын Их Хурлын гишүүн;
4. Ерөнхий сайд;
5. Засгийн газрын гишүүн;
6. Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч;
7. Улсын ерөнхий прокурор.

- Цэц дор дурдсан албан тушаалтнуудыг огцруулах болон эгүүлэн татах, Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцсан гэх үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргана:

1. Монгол Улсын ерөнхийлөгч
2. Улсын Их Хурлын дарга;
3. Ерөнхий сайд;
4. Улсын Их Хурлын гишүүн.

- Цэцэд ирүүлсэн маргааны шаардлагын зарим нь Цэцэд, зарим нь өөр шүүх буюу бусад байгууллагад харьяалалтай байвал Цэц зөвхөн өөрийн харьяалалтай маргааны шаардлагыг шийдвэрлээд бусдын харьяалах маргааны шаардлагыг шийдвэрлэхээс татгалзана. Энэ нь тэр маргааныг харьяалах байгууллагаас хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болохгүй.

- Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.”

Үндсэн хуулийн цэцийн маргаан шийдвэрлэх харьяалал болон харьяалал тогтоох ач холбогдлын талаар хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяа дараах байдлаар авч үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хадгалагдаж буй нэг эрх хэмжээ нь хэргийн харьяалал тогтоох явдал юм. Ямар хэрэг, маргааныг шүүх шийдвэрлэхийг тус бүр процессын хуулиар заасан. Тухайлбал, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Хоёрдугаар бүлэг, 12 дугаар зүйлд заасан иргэний хэрэг үүсгэх бүх үндэслэлээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүх харьяалан шийдвэрлэнэ, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт тус шүүхийн харьяалалтай холбоотой асуудлыг зохицуулсан.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлд мөн тус шүүхийн харьяаллыг хуульчилжээ.

Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаар Улсын дээд шүүхийн танхим хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяалал тогтоох, 29 дүгээр зүйлд зааснаар тодорхой хэргийн харьяаллын талаар доод шатны шүүх хооронд гарсан маргааныг хянаж зохих харьяаллыг тогтоох нь давж заалдах шатны шүүхийн бүрэн эрхийн асуудал байхаар хуульчилсан.

Гэхдээ аль шүүхэд хянан шийдвэрлэх нь тодорхойгүй хэрэг, маргаан тохиолдохыг үгүйсгэхгүй үндэслэлээр хэргийн харьяалал тогтоох эрх хэмжээг Цэцэд мөн олгосон байдаг. Энэ нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шийдвэрлэх цэцийн бүрэн эрхэд төдийлөн шууд хамааралгүй чиг үүрэг боловч иргэн, албан тушаалтан, байгууллага, ер нь хэн болгоныг аливаа “чирэгдлээс” хамгаалахад чиглэсэн нэгэн арга зам хэмээн ойлгож ирсэн.

Энэхүү эрх хэмжээнийхээ хүрээнд Үндсэн хуулийн цэц 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр дунд суудлын хуралдаанаар магадлал гаргаж аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны харьяаллыг тогтоосон нэг онцлог жишээг дурдаж болох юм. Утгыг нь товч сийрүүлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 онд 198 дугаар зарлиг гаргаж Шүүх байгуулах тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан давж заалдах болон анхан шатны шүүхийн 409 шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлсөн. Харин 2013 оны 199 дүгээр зарлигаар Ерөнхийлөгч дээрх 409 иргэний 397-г шүүгчийн албан тушаалд буцаан томилохдоо 12 иргэнийг тодорхой шалтгаан заалгүй шүүгчийн албан тушаалд томилоогүй орхигдуулсан талаар хуульчид тухайн үед байр сууриа илэрхийлж байсан.

Энэ асуудлаар холбогдох иргэд Үндсэн хуулийн цэцэд хандаж эрх ашиг нь зөрчигдөж байгаа талаараа мэдээлэл гаргасан. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгосон үндэслэл нь хууль бус эсэхийг шүүхийн шийдвэрээр тогтоохоор зохицуулсан, мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр хуульчилсан үндэслэлээр 12 шүүгчийг албан тушаалд нь буцаан томилоогүйтэй холбоотой эрх нь зөрчигдсөн тухай маргааныг Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд анхан шатны журмаар харьяалан шийдвэрлүүлэхээр Цэц тухайн үед тогтоосон⁵⁶.

56 Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй”, хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 99-101 дэх тал.

Мөн түүнчлэн БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 2 дугаар зүйлд⁵⁷ болон ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 1 дүгээр бүлэгт⁵⁸ тус тус Үндсэн хуулийн шүүхийн харьяаллын талаар тусгажээ.

Дүгнэвэл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль нь процессын хууль болохын хувьд хуулийн төсөлд Үндсэн хуулийн цэцийн маргаан шийдвэрлэх харьяаллын талаар тусгах нь үр дүнтэй, олон улсын жишиг бүхий зохицуулалт болохоор байна. Мөн түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээ болох аль шүүхэд хянан шийдвэрлэх нь тодорхойгүй хэрэг, маргааны харьяаллыг тогтоох талаар зохицуулах нь зүйтэй.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимтай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 8-15 дугаар зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дараах зарчмуудыг тусгажээ.

- Хараат бус байх;
- Хамтын зарчим;
- Ил тод байх;
- Тэгш эрхийг хангах;
- Цэц өөрөө нотлох;
- Маргаан хянан шийдвэрлэх хэл, бичиг;
- Хуралдааныг биечлэн явуулах;
- Хуралдааныг тасралтгүй явуулах.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг дээрх байдлаар тусгахдаа “Цэц өөрөө нотлох” гэж мөрдөн шалгах зарчмыг тусгасан хэдий ч мэтгэлцэх зарчмыг тусгаж өгөөгүй байна.

1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлд мэтгэлцэх зарчмыг “Цэцийн хуралдаанд маргагч талууд, тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгч, өмгөөлөгчид маргаж байгаа асуудлаар харилцан бие биедээ асуулт тавьж, хариулт авах, гомдлын шаардлага, татгалзлалын үндэслэл болсон нотлох баримтуудыг харилцан няцаах, энэ талаарх баримтуудыг зохих журмын дагуу гаргах, батлах зэргээр мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлнэ; Цэц төвийг сахиж, маргагч талуудад чөлөөтэй мэтгэлцэх бололцоо олгоно.” гэж хуульчилсан байна.

Энэ тухай хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяа Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд диспозиц зарчим үйлчлэх ёстой бөгөөд диспозицийн зарчмыг Үндсэн хуулийн процесс ажиллагаанд

57 Constitutional court act of korean, Expand Act No. 15495, Mar. 20, 2018, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47509&lang=ENG, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

58 Courts Constitution Act in the revised version published on 9 May 1975 (Federal Law Gazette I p. 1077), as last amended by Article 8 of the Act of 7 July 2021 (Federal Law Gazette I, p. 2363), Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_gvg/englisch_gvg.html, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

тохируулан авч үзэх шаардлага байдаг⁵⁹ гэж үздэг. Мөн түүнчлэн “хуралд талуудын бүх байр суурийг авч, оролцуулсан байх ёстой. Мэтгэлцэх зарчмаар хэрэг маргаан, хянан шийдвэрлэх ажиллагаа явсан байх ёстой”⁶⁰ гэх байр суурийг судлаачид баримталдаг.

Энэ талаар “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”-д дараах байдлаар авч үзсэн.

“22 дугаар зүйл нь мэтгэлцэх журмыг хуульчилж өгсөн байна. Мэдээж энэхүү журам нь иргэний болон эрүүгийн хэрэгт шууд хамааралтай боловч, Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар нь ялгаатай байдаг. Гомдол гаргагч нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой ашиг сонирхолтой байдаг бол хэргийн нөгөө талыг шууд тогтооход хүндрэлтэй. Хэм хэмжээний актыг тодорхой төрийн байгууллага гаргасан байлаа гээд тухайн төрийн байгууллага нь хариуцагч болно гэсэн үг биш юм. Улс төрийн шалтгааны улмаас, тухайн хэм хэмжээний актын Үндсэн хуулийн зохицлын асуудалд тухайн төрийн байгууллага шууд ашиг сонирхолгүй байж болох юм. Тийм учраас, зарим Үндсэн хуулийн шүүхүүд мөрдөн шалгах зарчмаар ажилладаг. Тодруулбал, Үндсэн хуулийн шүүх өөрөө тухайн хэм хэмжээний акт Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаарх үндэслэл болон эсэргүүцлийг бэлтгэдэг. Бусад мэтгэлцэх журмыг хуульчилсан улсуудад, прокурор нийтийн эрх ашгийг хамгаалж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог.

CDL-AD(2014)017, Тажикстан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 35 дах цогцолбор”

Мөн Венецийн комиссын “Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”-д Үндсэн хуулийн шүүхэд мэтгэлцэх зарчим байх эсэх талаар дараах байдлаар авч үзсэн.

“116. Хувь хүн Үндсэн хуулийн шүүхэд үр дүнтэй хандах, тэдний материаллаг эрхийг баталгаажуулах явдлыг хангахын тулд Үндсэн хуулийн шүүхийн тухай олон хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим баталгааг тусгадаг. Хамгийн түгээмэл нь мэтгэлцэх, шүүхийн нээлттэй ажиллагаа, аман процессын ажиллагаа юм.

1. Мэтгэлцэх систем

117. Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мэтгэлцээний эсхүл инквизицийн хэлбэртэй байж болно. Үндсэн хуулийн шүүхийн тухай олон хуульд шүүхийн өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа мэтгэлцээний журмаар явагдана гэж заасан байдаг (жишээлбэл, Андорра, Австри, Азербайжан, Чили, Чех, Франц, Итали, Гүрж, Литва, Люксембург, Польш, Орос, Сан Марино, Өмнөд Африк, Украин, АНУ).

118. Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх арга ашиглахын давуу тал нь шүүх өөр өөр үзэл бодлыг сонсож, эсрэг талын үндэслэлийг харгалзан үзэх боломжтой болдог. Гэхдээ Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх

59 Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй”, хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 164 дэх тал.

60 Б.Энхбаяр, “Үндсэн хуулийн цэц өөрөө Үндсэн хуулиа зөрчсөн”, Холбоос: <https://itoim.mn/article/A6311/29744>. Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

ажиллагаа нь энэхүү давуу талаа гаргах хэмжээнд хангалттай мэтгэлцээн байнга хийдэггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Венецийн комиссын ажигласнаар төрийн байгууллагууд улс төрийн шалтгаанаар батлагдсан актыг Үндсэн хуульд нийцэж байгаа гэсэн байр суурийг хамгаалахад бодит ашиг сонирхолгүй байж болзошгүй тул тэр бүр тохиромжтой мэтгэлцэгч тал байж чаддаггүй. Иймээс зарим Үндсэн хуулийн хяналтын тогтолцоонд маргаантай заалтыг Үндсэн хуульд нийцсэн, эсхүл нийцээгүй гэх үндэслэлийг тогтооход Үндсэн хуулийн шүүхэд инквизицийн аргыг хэрэглэдэг. Гэсэн ч инквизицийн ажиллагааны явцад ч маргааны анхны талууд, түүнчлэн ашиг сонирхлын бүлгийн төлөөлөгчид, шинжээчид, гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын төлөөлөгчдөд эсрэг байр сууриа илэрхийлэх боломжийг олгож болно. Өөрөөр хэлбэл үнэн мөнийг тогтоохын тулд талуудын гаргасан тайлбараас гадна Үндсэн хуулийн шүүх өөрийн санаачилгаар хянаж, шалгах ажиллагаа явуулж болно.

119. Өргөдөл гаргагч буюу инквизицийн ажиллагааг санаачлагчид Үндсэн хуулийн шүүхэд тайлбар хийх боломж олгох нь чухал гэж Венецийн комисс үзэж байна. Герман, Испанийн хуульд Үндсэн хуулийн гомдол шүүхийн шийдвэрийн эсрэг чиглэсэн байвал тухайн шийдвэр гарсан талд тайлбар хийх боломж болгох ёстой гэсэн зохицуулалтыг Венецийн комисс дэмжиж байна. Харин шүүхийн шийдвэрт шүүхийн байр суурь тусгагдсан байдаг тул хэрэв шийдвэрийг нь хянаж байгаа бол шүүхийн тайлбарыг сонсох шаардлагагүй. Гэхдээ шүүхийг урьдчилсан шатны ажиллагааны талуудтай заримдаа адилтгадаг. (жишээ нь, Австри, Польш, Словак, Словени).

120. Мэтгэлцэх ажиллагааг заавал аман байдлаар хийх албагүй. Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа ихэвчлэн бичгээр явагддаг бөгөөд тал тус бүр тайлбараа бичгээр гаргадаг.⁶¹

Дүгнэж үзвэл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд зарчмыг тусгахдаа мэтгэлцэх зарчмыг тусгаагүй байна. Дээрх зарчим нь өмнөх 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд туссан уламжлалт, үр дүнтэй, бусад улсын туршлага, олон улсын байгууллагын зөвлөмжид тодорхойлсон зарчим учраас үүнийг хуулийн төсөлд тусгах шаардлагатай эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй байна. Ялангуяа тус хуулийн төслөөр хувь хүн үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх болсонтой холбогдуулан тус зарчмыг зайлшгүй авч үзэх нь зүйтэй.

Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавигдах шаардлагатай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 18 дугаар зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төслийн 18 дугаар зүйлд Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тусгах зүйлс болон хавсаргах баримт бичгийг дурдсан байна. Мөн өргөдөлд үндсэн эрхийг зөрчсөн талаар эрх бүхий этгээд, шүүхэд хандаж эцэслэн шийдвэрлүүлсэн боловч зөрчил арилаагүй гэж үзсэн үндэслэл, шүүхийн болон бусад арга замыг гүйцээсэн байх зэрэг нарийвчилсан шаардлагыг тусгасан байна.

61 “Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2021.02.22 Санал № 1004/2020 CDL-AD(2021)001 (УБ, 2023), 38-40 дэх тал.

Хуулийн төслийн танилцуулгад “Иргэдийн өргөдлөөр Үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг Цэц хэрэгжүүлэх болсон нөхцөлд Үндсэн хуулийн процессын эрх зүйн дэлхий нийтийн чиг хандлагын хүрээнд “өргөдөлд” тавигддаг шалгуурыг нарийвчлан тусгав. Тухайлбал, иргэн Цэцэд хандахын өмнө эрх сэргээх, хамгаалах шүүхийн болон бусад арга замыг гүйцээсэн байх зэрэг нарийвчилсан шаардлагыг тогтоосон нь зохиомол ачааллаас хамгаалах, үр дүнтэй бодит Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг нээж, бусад улсын нийтлэг хандлагатай уялдсан зохицуулалт болно.” гэжээ.

Хуулийн төслийн танилцуулга болон хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасныг харвал “өргөдөл” гаргахад шүүхэд хандаж эцэслэн шийдвэрлүүлсэн боловч зөрчил арилаагүй гэж үзсэн үндэслэлийг тусгах, баримтыг хавсаргах тухай зохицуулалт нь одоо хэрэгжиж буй ҮХЦМХШАтХуулиас ялгарч байна.

Латви улсад саяхныг болтол Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй этгээд нь зөвхөн тодорхой байгууллагын төлөөлөл, албан тушаалтан байсан боловч 2019 оны 3 дугаар сарын 21-нд Үндсэн хуульдаа нэмэлт оруулснаар хувь хүн зарим асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх нээгдсэн байна. Ингэхдээ тухайн хууль, шийдвэр нь тухайн хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн байхын зэрэгцээ тухайн хүн хуульд заасан бусад үе шат, арга хэмжээг туулж барагдуулсан байх шаардлагатай ажээ.(Латвийн Үндсэн хууль 106-р зүйл⁶²)⁶³

Түүнчлэн сонгодог онолд заадагчлан, асуудлыг өргөдөл гаргасны үндсэн дээр Үндсэн хуулийн шүүхэд шийдвэрлүүлж байгаа бол, иргэн хүн эрхээ хамгаалуулахаар үндэсний эрх зүйн бүх шат дамжлагыг өмнө нь гүйцээсэн байх ёстой тул, маргааныг наана нь олон шатаар хянасан байдаг хэмээн үздэг.⁶⁴

Иймд хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан өргөдөлд шүүхэд хандаж эцэслэн шийдвэрлүүлсэн байх шаардлага тавьсан зохицуулалт нь Үндсэн хуулийн шүүхийн сонгодог онолд нийцсэн, олон улсын нийтлэг хандлагатай уялдсан зохицуулалт болно.

Маргааны оролцогчийн эрх зүйн байдалтай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 21-29 дүгээр зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Маргааны оролцогч

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд маргааны оролцогч талуудыг заасан байна. Маргагч болон өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд Үндсэн хууль зөрчсөн гэж тусгасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйг гаргасан байгууллага, албан тушаалтан нь үндсэн оролцогч байна. Гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хуралдааны нарийн бичгийн дарга нь бусад оролцогчид хамаарна. Төлөөлөгч, өмгөөлөгч нь маргааны бие даасан оролцогч бус, зөвхөн төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрх олгосон хүрээнд хамгаалж байгаа этгээд мөн.

62 Every person shall have the right to apply to the Constitutional Court concerning the acts specified in the first and second paragraphs of Article 105 if a decision adopted on the basis of these acts has violated the constitutional rights or freedoms of the person and the person has exhausted all legal remedies. The procedure for implementing this right shall be established by the Law on the Constitutional Court.

63 Н.Отгончимэг, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”, ХЗДХЯ, (УБ, 2019), 27 дахь тал.

64 Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, Анхны хэвлэл, (УБ, 2005), 187 дахь тал.

Одоо хэрэгжиж буй ҮХЦМХШАТХуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг дараах байдлаар заасан байна. Үүнд:

- Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан иргэд, эрх бүхий албан тушаалтан, байгууллага, түүнчлэн Үндсэн хууль зөрчсөн гэж маргаан үүсгэсэн хууль, бусад шийдвэрийг гаргасан буюу үйл ажиллагаа явуулсан байгууллага, албан тушаалтан;
- албан тушаалын байдлаар буюу зохих журмын дагуу томилогдсон итгэмжилсэн төлөөлөгч, өмгөөлөгч байна.

Үүнээс харвал, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэж зөвхөн маргагч болон маргалдагч талыг ойлгохоор харагдаж байна. Гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хуралдааны нарийн бичгийн даргыг тус зүйл заалтад дурдаагүй байна. Харин ҮХЦМХШАТХуулийн 18 дугаар зүйлд маргаанд оролцогчийн эрх, үүргийг заахдаа маргагч болон оролцогч тал гэсэн нэр томъёог ашигласан байна.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяа “ҮХЦМХШАТХуулийн 18 дугаар зүйлд Цэцийн хуралдаанд оролцогчийн эрх үүргийг заахдаа маргагч тал болон оролцогч тал гэсэн 2 өөр нэг томъёог ашигласан нь нэг талаас Үндсэн хуулийн маргаанд заавал байдаг идэвхтэй оролцогч субъектийг, нөгөө талаас бусад оролцогчдыг ялган зааглах гэсэн зорилготой.”⁶⁵ гэж үзсэн нь үндэслэлтэй юм.

Хуулийн төсөлд маргагч болон маргалдагч талыг “үндсэн оролцогчид”; гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хуралдааны нарийн бичгийн дарга нь “бусад оролцогчид” хамаарах зааг ялгааг тодорхойлж, эрх, үүргийг заасан нь одоо хэрэгжиж буй ҮХЦМХШАТХуулийн хийдлийг зассан, хууль хэрэглэж буй хүнд ойлгомжтой зохицуулалт болсон байна.

Татгалзан гаргах үндэслэл, журам

Хуулийн төсөлд заасны дагуу Цэцийн гишүүн дараах үндэслэл байвал хуралдааны бүрэлдэхүүнд оролцохоос өөрөө татгалзан гарах үүрэгтэй, харин үндсэн оролцогч уг үндэслэлээр Цэцийн гишүүнийг татгалзан гаргах санал тавих эрхтэй:

- тухайн маргааныг захиргааны байгууллага, шүүхээр хянан шийдвэрлэхэд албан үүргийн дагуу, эсхүл мэргэжлийн үүднээс оролцсон;
- өөрөө, эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээд маргааны “үндсэн оролцогч” бол.

“Бусад оролцогч” дээр заасан үндэслэл эсхүл ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй бусад үндэслэл бий болсон бол өөрөө татгалзан гарах үүрэгтэй бөгөөд тэдгээрийг татгалзан гаргах хүсэлтийг хуралдааны бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

Хууль зүйн шинжлэх ухаанд шүүгчийг татгалзан гарах үндэслэлд дээрхээс гадна өөр үндэслэл байж болно гэж үздэг. Энэ нь тухай улс орнуудын хувьд тухайлбал, шүүгч асуудлыг шударга шийдвэрлэхэд нөлөөлөх бусад хүчин зүйл байж болохыг хэлнэ. Жишээ нь, маргааныг нэг талд шийдвэрлэсэнээр тухай шүүгчид

65 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, Анхны хэвлэл, (УБ, 2005), 189 дахь тал.

ямар нэг ашигтай байдал үүсэж болзошгүй байх явдал үүнд хамаарч болох юм.⁶⁶

Иймд Цэцийн гишүүний татгалзан гарах үндэслэлийг хуулийн төслийн 29 дүгээр зүйлийг 29.1-т зааснаар хязгаарлагдах нь одоо хэрэгжиж буй хуулийн дутагдалтай талыг илрүүлж шинэчлээгүй байгааг илтгэнэ. Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяагийн зөвлөсөнчлөн “маргааныг нэг талд шийдвэрлэснээр тухай шүүгчид ямар нэг ашигтай байдал үүсэж болзошгүй байх явдал” шүүгчийг татгалзан гарах үндэслэлд хамаарч болохоор байна.

Өргөдөл, мэдээлэл, хүсэлт, маргааныг хуваарилах болон холбогдох бусад журамтай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 31 дүгээр зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд шинээр зохицуулагдаж буй харилцаа нь 31 дүгээр зүйл буюу өргөдөл, мэдээлэл, хүсэлт, маргааныг хуваарилах талаар зохицуулалт юм. Тус хуулийн төсөлд дурдсанаар дараах байдлаар хуваарилахаар зохицуулжээ.

- Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилах хуваарийг Цэцийн зөвлөгөөнөөс жил бүрийн 12 дугаар сард батална. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.
- Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилах журам нь урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд дараах шаардлагыг хангасан программ хангамжийг ашиглана:
- Цэц өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлыг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдэд шууд өгөх боломжтой байх;
- Цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү энэ хуульд заасны дагуу татгалзан гаргах, гарах хүсэлтийг үндэслэлтэй гэж үзсэн, эсхүл Цэцийн гишүүн, тухайн хуралдааны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.
- Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан хуваарь, журмын дагуу өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох бөгөөд маргааныг Дунд суудалд хуваарилна.
- Цэцийн дарга оролцсон Их суудлын хуралдаанаа даргална. Цэцийн дарга нь Их суудлын хуралдаанд ороогүй, эсхүл илтгэгч гишүүнээр уг хуралдааны бүрэлдэхүүнд орсон бол аль нэг гишүүн даргална.

Энэ тухай тус хуулийн төслийн танилцуулгад “Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага, Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилахдаа урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор сонгох нөхцөлийг хангав.”⁶⁷ гэж тодорхойлсон.

Энэхүү зохицуулалт нь 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн асуудлыг шийдвэрлэсэн ач холбогдолтой. Тухайлбал дараах асуудлуудыг судлаачдын зүгээс хөндөж байсан.

Цэцийн бие даасан, гишүүний хараат бус, эрх тэгш байдлыг хангах үүднээс шүүхийн нийтлэг жишгийн дагуу Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуваарилах болон Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилохдоо урьдчилан тогтоосон журмын дагуу тойргийн зарчмаар хуваарилах шинэчлэлийг хийх шаардлага тулгарч байна. Энэ нь цэцийн бие даасан, хараат бус байх зармын гол баталгаа болно. Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж Цэцийн нэг гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг дангаараа шийдвэрлэдэг өнөөгийн журам нь дэлхийн бусад улс оронд байхгүй жишиг юм. Иймд процессын эрх зүйн нийтлэг хандлага, Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны ерөнхий зарчмын хүрээнд Цэцийн бага суудлын хуралдаанаар дээрх асуудлыг шийдвэрлэх асуудлыг судлан үзэх нь зүйтэй⁶⁸.

Мөн Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлын талаар дэд профессор Д.Наранчимэг дараах асуудлыг онцолсон байна:

Ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн дарга гишүүнд хуваарилдаг. Ийнхүү хуваарилахдаа Цэцийн гишүүний мэргэшсэн чиглэл, ажлын ачааллыг харгалзан хуваарилж байгаа хэдий ч субъектив хүчин зүйлийн нөлөөлөл орж болохыг үгүйсгэхгүй. Тиймээс өргөдөл, мэдээллийг бусад улс орны жишгээр аль болох тохиолдлын шинжээр, тойргийн зарчмаар гишүүдэд ялгаваргүй хуваарилдаг байх нь хараат бус байдлын бас нэг баталгаа болно⁶⁹;

Энэ талаар Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”-д авч үзсэн бөгөөд бусад улсуудын туршлага, чиг хандлагыг тодорхойлсон.

“Туркийн Үндсэн хуулийн шүүхэд илтгэгч шүүгч чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээрийг хамгийн багадаа таван жил шүүгчээр ажилласан туршлагатай шүүгч, эрх зүйн профессор эсхүл туслах илтгэгчээр таван жил ажилласан эрх зүйн судлаачдаас сонгодог (24.2 дугаар зүйл) бөгөөд шүүгчийн баталгаат байдлыг эдэлдэг (24.4 дүгээр зүйл). Захиргааны зохион байгуулалтын хувьд тэд Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн дор бус зөвхөн Үндсэн хуулийн шүүхийн даргын удирдлага дор ажиллана. Хэрэг маргааныг Үндсэн хуулийн шүүхийн дарга гишүүдэд биш илтгэгч шүүгчдэд хуваарилдаг. Турк Улсын Үндсэн хуулийн шүүхийн илтгэгч шүүгчид тухайн шүүхийн шүүгчидтэй адил баталгааг эдэлдэггүй тул,

67 Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулга.

68 “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, (УБ, 2023), 101 дэх тал.

69 Н.Отгончимэг, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”, ХЗДХЯ, (УБ, 2019), 5 дахь тал.

хэргийг автоматаар хуваарилах системийг оруулж ирэх нь зүйтэй. Энэ систем хэрэглэгдэхгүй байх онцгой тохиолдлуудыг хэргийн материалд тусгаж өгөхөд болно.” “Хэргүүдийг илтгэгч шүүгчид автомат системээр дамжуулан хуваарилах хэрэгтэй.

CDL-AD(2011)040, Турк Улсын Үндсэн хуулийн шүүх байгуулах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль 39 дэх цогцолбор, 104(9).”

“129 дүгээр зүйлд заасан хэргийг автоматаар хуваарилах систем нь Венецийн хорооны зөвлөмжүүдтэй нийцэж байна. Энэхүү өөрчлөлтийг сайшаалтайгаар хүлээж авч байна.

CDL-AD(2013)014, Шүүгчийн бие даасан байдлыг сайжруулах Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн талаарх дүгнэлт болон Украйн Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл 31-32.”

“Шүүхийн даргаар дамжуулан хэргийн хуваарилалтыг хийхийн оронд, ЛСЛП-ийн 17 дугаар зүйл нь илтгэгч шүүгчдэд хэргийг хуваарилах автомат системийг хуульчилж өгсөн байна. Шүүхийн даргын эрх мэдлийг хязгаарлах замаар шүүгчдийн бие даасан, хараат бус байдлыг дэмжиж өгч байх тул уг өөрчлөлтийг сайшаалтайгаар хүлээн авч байна. Хууль зүйн яамны дарга энэхүү систем нь тохиолдлоор хэргийг хуваарилах систем биш бөгөөд шүүгч болгоны хэргийн ачааллыг анхаарч авч үзэж хуваарилдаг систем гэдгийг Венецийн хороонд мэдэгдсэн. Шүүх тухайн системийн программ хангамжийг өөрөө бүрэн удирдаж, хянадаг байх шаардлагатай.

CDL-AD(2016)017, Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 35.”

““Журам эсхүл хуулийн төсөл нь шүүгчдэд хэргийг хуваарилдаг автомат системийг хуульчлах шаардлагатай.”

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор”

“Энэ асуудлыг шийдвэрлэх өөр нэгэн арга зам нь шүүхийн даргад хэргийг хуваарилах эрх мэдлийг өгөхийн оронд, хэргийг хуваарилах урьдчилсан шалгууруудыг тогтоож өгөх явдал юм. Жишээ нь, хэргийн ачаалал болон тухайн эрх зүйн асуудлаар мэргэшсэн байдал зэргээс хамаарч хэргийг хуваарилж болно.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 66.”⁷⁰

Дээрхээс дүгнэж үзвэл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд хэрэг хуваарилах журмыг нарийвчлан тусгаж автомат байдлаар программ ашиглан хуваарилах байдлаар зохицуулсан нь өмнө үүсээд байсан асуудлыг шийдвэрлэсэн сайн жишигт нийцсэн зохицуулалт байна. Гэхдээ

70 “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2020.04.22 Санал № 2022CDL-PI(2020)004, (У6, 2023), 123-125 дахь тал.

ийнхүү хуваарилахад мэргэшсэн чиглэл, ажлын ачааллыг харгалзан хуваарилах, хэрэглэгдэхгүй байх онцгой тохиолдлуудыг харгалзан үзэх зэргээр тухайн программ хангамжид холбогдох урьдчилсан шалгууруудыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай.

Цэцийн даалгаврыг биелүүлэх, Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 33, 34 дүгээр зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Цэцийн даалгаврыг биелүүлэх талаар:

Тус хуулийн төслийн 33 дугаар зүйлд дараах байдлаар Цэцийн даалгаврыг биелүүлэх талаар шинээр хуульчилсан байна.

33.1.Хуралдааны бүрэлдэхүүн маргааны оролцогч эсхүл бүрэлдэхүүний гишүүний саналаар маргааны талаар баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл тодорхой ажиллагаа гүйцэтгэхийг зохих шүүхэд даалгаж болно.

33.2.Энэ хуулийн 33.1-т заасан Цэцийн даалгаварт маргааны товч агуулга, явуулбал зохих ажиллагаа, бүрдүүлэх баримтыг зааж, даалгавар биелүүлэх хугацааг тогтоох бөгөөд энэ хугацаанд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

33.3.Даалгавар хүлээн авсан шүүх тогтоосон хугацаанд түүнийг биелүүлж, хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн баримтыг Цэцэд хүргүүлнэ.

Үүнийг тус хуулийн төслийн танилцуулгад “Маргаан шалгах болон хуралдаанд бэлтгэх явцад хэрэгжүүлэх ажиллагааг улам тодорхой болгов. Тодруулбал, түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох, нотлох баримт цуглуулах, шүүхэд даалгавар өгөх талаарх зохицуулалтыг тусгав.”⁷¹ гэж ач холбогдлыг тодорхойлсон байна.

Тус хуулийн төсөлд зааснаар бусад шүүхэд Үндсэн хуулийн цэцээс даалгавар өгч болохыг зохицуулсан хэдий ч ямар тохиолдолд даалгавар өгч болохыг зохицуулаагүй байна.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх талаар:

Тус хуулийн төсөлд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх талаар дараах шинэ зохицуулалтуудыг 34 дүгээр зүйлд тусгасан.

34.1.Дараах тохиолдолд Цэцийн хуралдааны бүрэлдэхүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ:

34.1.1.Цэц уялдаа холбоо бүхий өөр маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй;

34.1.2.маргааныг хянан шийдвэрлэхэд бусад шүүхээс гарах шийдвэр ач холбогдолтой бол тухайн шийдвэр гарах хүртэл хугацаагаар;

34.1.3.энэ хуулийн 33.2-т заасан ажиллагаа явуулж байгаа.

71 Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулга.

34.2.Энэ хуулийн 34.1-т зааснаас бусад үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

34.3.Түдгэлзүүлэх үндэслэл арилсан тохиолдолд хуралдааны бүрэлдэхүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

34.4.Маргааны оролцогч эсхүл бүрэлдэхүүний гишүүн энэ зүйлд заасны дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, эсхүл сэргээх тухай саналыг хуралдааны бүрэлдэхүүн гаргаж болно.

Венецийн комиссын “Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны талаар бусад улсын зохицуулалт, жишгийг судлан дараах зөвлөмжийг өгсөн байна.

“152. Ердийн шүүгч аль нэг хуулийг Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн бол тухайн хуулийг хэрэглэх албагүй бөгөөд мөн ижил хэрэг дээр Үндсэн хуулийн шүүх уг хуулийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шийдэх ёстой. Үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан асуулт тавьсан үед ердийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэн даруй буюу ердийн шүүхийн шийдвэр гарахаас өмнө түдгэлзүүлэх ёстой гэж Венецийн Комисс үзэж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг ipso iure эсхүл ердийн шүүхийн шийдвэрээр тодорхойлно.”⁷²

2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь процессын хууль болохын хувьд түүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэлийг тус хуулийн төсөлд харгалзаж үзэх хэрэгтэй. Учир нь Үндсэн хуулийн цэц болон Захиргааны хэргийн шүүхийн процессын хувьд ихэнх тохиолдолд хууль бус шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан, нөгөө талд эрх нь зөрчигдсөн этгээдүүд байдаг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх дараах тохиолдлуудыг авч үзсэн байна.

- хэргийн оролцогч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан үед маргаантай байгаа шаардлага болон үүрэг эрх залгамжлагчид шилжих ёстой байвал;
- хэргийн оролцогч онц ба дайны байдал зарласан нөхцөлд цэргийн алба хааж байгаа;
- эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй;
- хэргийн оролцогч хүнд өвчний учир эмчлүүлж байгаа бөгөөд төлөөлөгч томилох боломжгүй;
- хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй тухай асуудлаар Улсын дээд шүүхэд санал оруулсан;
- хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэсэн;

72 “Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2021.02.22, Санал № 1004/2020 CDL-AD(2021)001 (УБ, 2023), 50-51 дэх тал.

- энэ хуулийн 33 /Нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх/, 35 /Шүүхийн даалгавар, түүнийг биелүүлэх/, 40 дүгээр зүйлд /Шинжээчийн дүгнэлт/ заасан ажиллагаа явуулж байгаа.

Дээрхээс хэргийн оролцогч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан үед маргаантай байгаа шаардлага болон үүрэг эрх залгамжлагчид шилжих ёстой байвал, хэргийн оролцогч онц ба дайны байдал зарласан нөхцөлд цэргийн алба хааж байгаа, хэргийн оролцогч хүнд өвчний учир эмчлүүлж байгаа бөгөөд төлөөлөгч томилох боломжгүй, нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх, шүүхийн даалгавар, түүнийг биелүүлэх, шинжээчийн дүгнэлттэй холбоотой тохиолдолд түдгэлзүүлэх үндэслэл болж болзошгүй байна. Мөн бусад маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх боломжтой нөхцөл дахин судалж хуулийн төсөлд тусгах эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй байна.

Цэцийн шийдвэр гаргах, түүнийг мэдээлэхтэй холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 50-55 дугаар зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төслийн Долдугаар бүлэг буюу 50-55 дугаар зүйлд Цэцийн шийдвэр, түүнийг мэдээлэх ажиллагааны тухай зохицуулалт орсон байна. Үүнд зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэх (50-р зүйл); Цэцийн шийдвэрийн үндэслэлийг хэлэлцэн тогтоох (51-р зүйл); Цэцийн шийдвэрийн бүтэц (52-р зүйл); Цэцийн шийдвэрийг заавал биелүүлэх, нийтэд мэдээлэх, хүргүүлэх, нийтлэх (53-р зүйл); Цэцийн шийдвэрийн үр дагавар (54-р зүйл); түр түдгэлзүүлэх тухай магадлал (55-р зүйл) зэрэг ажиллагааг тус тус тусгасан байна.

Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэхтэй холбоотой дараах зохицуулалтууд шинэчлэгдэж, өөрчлөгдөж орсон байна. Үүнд, зөвлөлдөх тасалгаанд зөвхөн тухайн бүрэлдэхүүний гишүүд байлцах буюу нарийн бичгийн даргыг оролцуулахгүй байх (1), Цэцийн шийдвэрийг хамтын зарчмаар бичих (2), тусгай саналыг шийдвэрт хавсаргах эрх (3) зэрэг зохицуулалтууд багтана. Үүнийг дэлгэрүүлэн авч үзье.

1. Зөвлөлдөх тасалгаанд нарийн бичгийн дарга оролцох эсэх ба Цэцийн шийдвэрийг гишүүд хамтран бичих

Одоо хэрэгжиж буй Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Цэцийн хуралдааны зөвлөлдөх тасалгаанд тухайн асуудлыг шийдвэрлэж буй бүрэлдэхүүнээс гадна Цэцийн хуралдааны нарийн бичгийн дарга оролцон тэмдэглэл хөтөлдөг. Шинэчлэн найруулж буй хуулийн төсөлд "...зөвлөлдөх тасалгаанд зөвхөн тухайн бүрэлдэхүүний гишүүд зөвлөлдөн гаргах бөгөөд маргааны оролцогч, бусад этгээдийг байлцуулахгүй", "...Цэцийн шийдвэрийн тогтоох хэсгийн гол агуулгын төслийг илтгэгч гишүүн болон бүрэлдэхүүний бусад гишүүн зөвлөлдөх тасалгаанд хамтран бичиж, гарын үсэг зурна" гэж заасан.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Проф. Ц.Сарантуяа "Үндсэн хуулийн процессын эрх зүй" номдоо "Шүүхийн зөвлөлдөх тасалгаанд нарийн бичгийн дарга оролцох болон хуралдааны тэмдэглэл хөтлөх явдал нь зөвлөлдөх тасалгаанд хуралдааныг хаалттай явуулахад харшилдаг тул Үндсэн хуулийн цэцээс бусад шүүх (ердийн болон дагнасан)-эд эдгээр нь байдаггүйг холбогдох хуулийн зохицуулалтаас харж болно. Ингэх нь зөвлөлдөх тасалгааны нууцыг хадгалах зарчимд харшилдаг

учраас маргааныг шийдвэрлэсэн шүүгчдээс өөр субъектийг зөвлөлдөх тасалгаанд оруулахгүй, хуралдааны тэмдэглэл хөтлөхгүй байхаар хуульчилдаг.⁷³ гэж бичсэн нь үндэслэлтэй байна.

Хуулийн төсөлд заасны дагуу зөвлөлдөх тасалгаанд зөвхөн тухайн бүрэлдэхүүний гишүүд байх бөгөөд шийдвэрийн тогтоох хэсгийн гол агуулгын төслийг илтгэгч гишүүн болон бүрэлдэхүүний бусад гишүүн зөвлөлдөх тасалгаанд хамтран бичиж, гарын үсэг зурах тухай 50.1 болон 50.9 дэх зохицуулалтууд зөвлөлдөх тасалгааны нууцыг хадгалах зарчмыг баримталсан зохицуулалтыг тусгасан нь сайшаалтай байна.

2. Тусгай саналаа нийтлүүлэх эрх

Үндсэн хуулийн цэцийн зөвлөлдөх тасалгаанд олонхтой санал нийлээгүй гишүүн саналаа тусгайлан бичгээр гаргаж, зөвлөлдөөний тэмдэглэлд хавсаргах эрхтэй. Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн эдэлж буй эрхээс энэ нь ач холбогдлын хувьд ялгаатай. “Тусгай санал” гаргах эрх нь сонгодог утгаар, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэлд тухайн тусгай саналыг олонхийн саналаар гаргасан шийдвэрийн хамт хэвлүүлж, нийтийн хүртээл болгох байдлаар хэрэгжих боломжтой. Тусгай саналыг шийдвэрийн эмхэтгэлд хэвлүүлэх нь ямар нэгэн шууд үр дагаваргүй байдаг ч шүүхийн практикийг шинжлэх ухаанжуулах, шүүхийн шийдвэр гаргах ажиллагааг ил тод, нээлттэй болгох, шүүх шийдвэр гаргахдаа хараат бус ажилласан гэдгийг баталгаажуулах зэрэг олон зэрэг үнэлэмжтэй.⁷⁴

Одоо хэрэгжиж буй Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулж зөвлөлдөх тасалгаанд олохтой санал нийлээгүй гишүүн саналаа тусгайлан бичгээр гаргаж Цэцийн шийдвэрт хавсаргах үүрэгтэй байхаар томьёолсон (Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.7) нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхэд хүргэсэн.⁷⁵

Хуулийн төслийн танилцуулгад “... Цэцийн шийдвэрийн үндэслэл, тогтоох хэсэгтэй санал нийлээгүй Цэцийн гишүүн тусгай санал гарган, нийтлүүлэх эрхтэй байхаар заав.” гэж тусгасан.

Доктор, дэд профессор О.Мөнхсайханы хөндөж тавьсан асуудалд “Үндсэн хуулийн Цэцийн гишүүний хараат бус байдлыг илэрхийлэх чухал зүйл нь олонхоос өөр үндэслэл, байр суурьтай гишүүн түүнийгээ нийтэд илэрхийлэхийг зөвшөөрөх явдал. Өөрөөр хэлбэл, Цэцийн бүрэлдэхүүний олонх Үндсэн хуулийг буруу тайлбарлаад буруу шийдчихлээ гэж үзэж буй Цэцийн гишүүн энэ тухай тусгай саналаа нийтлэх эрхтэй байх ёстой. Олон улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч ийм эрхтэй байдаг.”⁷⁶ гэж үзсэн нь үндэслэлтэй юм.

73 Жишээ нь, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дэгийн 25 дугаар зүйлд: “На совещаниях судей могут присутствовать лишь те судьи, которые участвовали в производстве по делу” хэмээн зохицуулсан байдаг.

74 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, Хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 153 дахь тал.

75 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, Хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 153 дахь тал.

76 О.Мөнхсайхан, “*Үндсэн хуулийн өөрчлөлтөд цэцийн асуудлыг авч хэлэлцэх хэрэгтэй*”, 2018.10.11, Холбоос: <https://sonin.mn/news/politics-economy/95927>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

Тусгай (эсэргүүцэх) саналууд нь Үндсэн хуулийн шүүхийг сулруулдаггүй бөгөөд эсрэгээрээ олон тооны давуу талыг үүсгэдэг. Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдвэрийг хэлэлцэх, шүүгчдийн хараат бус байдлыг бэхжүүлэх болон хэргийг хянан шийдвэрлэхэд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгодог. Түүнчлэн түдгэлзүүлэх болон тусгай санал нь олонхын үндэслэлийг яагаад хүлээн зөвшөөрөхгүй вэ гэдгээ тайлбарлах ёстой болдог тул шүүхийг шийдвэрүүдийн үндэслэлийг сайжруулж байдаг ач холбогдолтой.⁷⁷

Иймд хуулийн төслийн 51 дүгээр зүйлийн 51.1-т заасан зохицуулалт буюу зөвлөлдөх тасалгаанд олонхтой санал нийлээгүй гишүүн саналаа тусгайлан бичгээр гаргаж Цэцийн шийдвэрт хавсаргах эрхтэй байхаар заасан нь Цэц хараат бус байх нөхцөлийг бүрдүүлсэн, Олон улсын Үндсэн хуулийн шүүхийн жишигт нийцсэн байхаас гадна Үндсэн хуулийн судлаачдын дунд хүлээн зөвшөөрөгдсөн зохицуулалт болсон байна.

Тусгай журамтай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 56-61 дүгээр зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Тус хуулийн төслийн 56-61 дүгээр зүйлд шинээр Үндсэн хуулийн цэцэд хянан шийдвэрлэх зарим маргааныг тусгай журмаар шийдвэрлэхээр зохицуулсан байна. Тодруулбал дараах маргаанууд үүнд хамаарч байна.

- Хууль, бусад шийдвэрт холбогдох маргаантай асуудал
- Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр үүссэн маргаантай асуудал
- Албан тушаалтанд холбогдох маргаантай асуудал
- Үндсэн эрхийн маргаан
- Сонгох, сонгогдох эрхийн маргаан
- Ард нийтийн санал асуулга, сонгуульд холбогдох маргаантай асуудал

Дээрх байдлаар тусгай журмаар шийдвэрлэх нь БНСУ-ын 2018 онд батлагдсан Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн зохицуулалттай төстэй байна. Тус хуулийн 4 дүгээр хэсэгт үүнийг “Шүүхийн тусгай журам” гэж хуульчилсан байх ба нийт 7 бүлэг асуудлыг зохицуулсан.

IV ХЭСЭГ. ШҮҮХИЙН ТУСГАЙ ЖУРАМ

1-р бүлэг. Үндсэн хуульд нийцэх тухай шийдвэр

- 41 дүгээр зүйл (Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шийдвэрлэх хүсэлт)
- 42 дугаар зүйл (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)
- 43-р зүйл (Бичгээр хүсэлт гаргах асуудал)
- 44 дүгээр зүйл (талуудын санал)
- 45 дугаар зүйл (Үндсэн хууль зөрчсөн тухай шийдвэр)
- 46 дугаар зүйл (Бичгээр шийдвэр гаргах)
- 47 дугаар зүйл (Үндсэн хууль зөрчсөн тухай шийдвэрийн үр нөлөө)

⁷⁷ “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2020.04.22 Санал № 2022CDL-PI(2020)004, (УБ, 2023), 130 дахь тал

2-р бүлэг. Импичментийн тухай шийдвэр

- 48-р зүйл (Импичментийн байгууллага)
- 49 дүгээр зүйл (Импичментийн комиссар)
- 50 дугаар зүйл (Бүрэн эрхээ хэрэгжүүлэхийг түдгэлзүүлэх)
- 51 дүгээр зүйл (Шүүх хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)
- 52 дугаар зүйл (Ирээгүйн ач холбогдол)
- 53 дугаар зүйл (Шийдвэр)
- 54 дүгээр зүйл (Шийдвэрийн хүчин төгөлдөр байдал)

3 дугаар бүлэг. Улс төрийн намыг татан буулгах тухай шийдвэр

- 55 дугаар зүйл (Улс төрийн намыг татан буулгах тухай шийдвэр гаргах хүсэлт)
- 56-р зүйл (Бичгээр хүсэлт гаргах)
- 57 дугаар зүйл (Түр захирамж)
- 58 дугаар зүйл (Хүсэлтийн мэдэгдэл)
- 59 дүгээр зүйл (Шийдвэрийн хүчин төгөлдөр байдал)
- 60 дугаар зүйл (Шийдвэр гүйцэтгэх)

4-р бүлэг. Эрх мэдлийн маргааныг хянан шийдвэрлэх

- 61 дүгээр зүйл (Хүсэлт гаргах үндэслэл)
- 62 дугаар зүйл (эрх мэдлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны ангилал)
- 63 дугаар зүйл (Хүсэлт гаргах хугацаа)
- 64-р зүйл (Бичгээр хүсэлт гаргахад анхаарах зүйлс)
- 65 дугаар зүйл (Түр захирамж)
- 66 дугаар зүйл (Шийдвэр)
- 67 дугаар зүйл (Шийдвэрийн хүчин төгөлдөр байдал)

5-р бүлэг. Үндсэн эрхийн талаарх гомдлыг шийдвэрлэх

- 68 дугаар зүйл (Хүсэлт гаргах үндэслэл)
- 69 дүгээр зүйл (Гомдол гаргах хугацаа)
- 70 дугаар зүйл (Шүүхээс томилогдсон өмгөөлөгч)
- 71 дүгээр зүйл (Бичгээр хүсэлт гаргахад анхаарах зүйлс)
- 72 дугаар зүйл (Урьдчилсан хяналт)
- 73 дугаар зүйл (Бүрэлдэхүүнд шилжүүлэх шийдвэр гаргах)
- 74 дүгээр зүйл (Сонирхсон байгууллагаас санал өгөх)
- 75 дугаар зүйл (Хамгаалан үлдээх шийдвэр)⁷⁸

Мөн төсөөтэй зохицуулалтын тухайд авч үзвэл Бүгд Найрамдах Эстони Улсын 2002 оны Үндсэн хуулийн процессын тухай хуулийн 2-р бүлэгт “Хууль тогтоох актыг үндсэн хуулийн хяналт”, 3-р бүлэгт “Рийгикогу, Бүгд Найрамдах Эстони Улсын ерөнхийлөгчийн зөвлөлийн тогтоол, шийдвэрийн эсрэг гомдол”, 4-р бүлэгт “Албан тушаалтныг удаан хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй гэж зарлах, Рийгикогу гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох, БНЭсУлсын Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Рийгикогу даргад зөвшөөрөл олгох”, 5-р бүлэгт “Улс төрийн намын үйл ажиллагааг дуусгавар болгох”, 6-р бүлэгт “Сонгууль зохион байгуулагчийн үйл

78 Constitutional court act of korean, Expand Act No. 15495, Mar. 20, 2018, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47509&lang=ENG, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

ажиллагаа, сонгуулийн хорооны шийдвэр, актын эсрэг гомдол, эсэргүүцэл⁷⁹ гэх тусгай журмуудыг тус тус зохицуулжээ.

Ийнхүү тусгай журам болгон зохицуулсан нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт тулгуурласан, процессыг оновчтой байдлаар тодорхойлсон үр дүнтэй, эрх зүйн хөгжил өндөр улсын жишигт нийцсэн зохицуулалт байна. Гэхдээ БНСУ болон БНЭсУлсын зохицуулалтад тусгай журмаар шийдвэрлэхдээ хүсэлт гаргахаас эхлээд шийдвэр биелүүлэх хүртэл процессыг бүхэлд нь авч үздэг болохыг харгалзан нийтлэг журамтай харьцуулан хийдэл үүсгэхгүй байх тал дээр анхаарах нь зүйтэй. Түүнчлэн тухайн улсын зохицуулалтаас үүсээд буй сөрөг үр дагаврыг тухайн улсын мэргэжилтнүүдээс асууж тодруулан судалж алдааг давтахгүй байх үүднээс зохицуулах шаардлагатай.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж хуулийн төслийн үр нөлөөг үнэлснээр хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж, тухайн хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулна.

Хянан шийдвэрлэхэд бусад байгууллага дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 32 дугаар зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх, захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, холбогдох этгээд шаардлагатай баримт, мэдээллийг Цэцэд саадгүй гаргаж өгөх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд үйл ажиллагаа, эх сурвалжаараа дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.” гэж тусгасан. Өмнөх 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Байгууллага, албан тушаалтан, иргэн Цэцийн гишүүний шаардсан бичиг баримтыг хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.” гэж зохицуулсан байсныг дээрх байдлаар өргөжүүлэн зохицуулсан байна.

Тус хуулийн төсөлд шинээр бүх шатны шүүх Цэцэд дэмжлэг үзүүлэх болон даалгаврыг биелүүлэх үүрэг хүлээсэн хэдий ч хэрхэн тухайн үүргийг хэрэгжүүлэх талаар нарийн зохицуулаагүй байна. Мөн түүнчлэн шүүх нь тогтолцооны хувьд анхан шатны, давж заалдах шатны, хяналтын шатны гэх байдлаар, дагнасан шүүхийн хувьд эрүү, иргэн, захиргааны хэргийн гэх байдлаар тус бүрийн онцлогтой эрх хэмжээтэй тул Цэцэд дэмжлэг үзүүлэх, даалгаврыг биелүүлэх харилцаа нь өөр байна.

Иймд бүх шатны шүүхийн зүгээс Цэцэд дэмжлэг үзүүлэх, даалгаврыг биелүүлэх тохиолдолд Цэцтэй хэрхэн харилцах талаар тухайн холбогдох эрх зүйн актад (Шүүхийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль) эсвэл тус хуулийн төсөлд энэ талаар нарийвчлан тодорхойлох талаар авч үзэх хэрэгтэй.

79 Constitutional Review Court Procedure Act of Estonia, Entry into force 01.07.2002, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/528062017007/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалт болох хуулийн төслийн 62 дугаар зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төслийн 62 дугаар зүйлд заасны дагуу Цэцийн хуралдаанд оролцогч, эсхүл бусад этгээд хуралдааны дэгийг зөрчсөн, дэгийг сахих талаарх шийдвэрийг үл биелүүлсэн, эсхүл Цэцийг үл хүндэтгэсэн бол сануулах, тухайн хүнийг Цэцийн хуралдааны танхимаас албадан гаргах, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ. Цэц, түүний гишүүнийг маргаан хянан шийдвэрлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт, дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг оролдсон, Цэцийн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, байгууллага, албан тушаалтан, бусад этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Цэцэд хандах эрхээ урвуулан ашигласан, эсхүл хариу өгсөн, шийдвэр гаргасан асуудлаар удаа дараа хандаж хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Шинжээч, гэрч санаатайгаар худал дүгнэлт гаргасан, мэдүүлэг өгсөн, мэдүүлэг өгөхөөс хууль бусаар зайлсхийсэн, татгалзсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Одоо хэрэгжиж буй Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7-д “Маргаан хянан шалгах ажиллагаанд оролцогч Цэцийн хуралдааны дэгийг дахин зөрчих, Цэц болон түүний гишүүдэд хуурамч бичиг баримт өгвөл Цэцийг хүндэтгээгүй үйлдэл гэж үзэж зохих хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан.

Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газрын Хууль зүйн газрын дарга Н.Болортунгалагийн байр суурь: “Цэцийн бие даасан, Цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан, хуралдааны хэвийн ажиллагааг алдагдуулсан иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуульд тусгаагүй орхигдуулсан байгааг тодорхой болгон холбогдох /Зөрчлийн тухай хууль/ хуульд тусгах хэрэгтэй байна. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч буюу маргалдагч талууд Цэцийн хуралдааны дэгийг зөрчих, Цэц болон түүний гишүүдэд хуурамч баримт бичиг өгөх, Цэцийг хүндэтгээгүй үйлдэл гаргавал хэрхэн шийдвэрлэх, ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхой бус байгааг анхаарах хэрэгтэй.”⁸⁰

Хуулийн төслийн 62 дугаар зүйлд заасан хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг дараах байдлаар хуулийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 7.15. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Хууль зөрчсөн үйлдэл	Сануулах	Албадан гаргах	Зөрчлийн тухай хуулиар	Хуульд заасан хариуцлага
Цэцийн хуралдаанд оролцогч, эсхүл бусад этгээд хуралдааны дэгийг зөрчсөн, дэгийг сахих талаарх шийдвэрийг үл биелүүлсэн	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
Цэцийг үл хүндэтгэсэн	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	

80 “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй хянах нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, (УБ, 2023), 127 дахь тал

Цэц, түүний гишүүнийг маргаан хянан шийдвэрлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт, дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг оролдсон			<input checked="" type="checkbox"/>	
Цэцийн шийдвэрийг биелүүлээгүй			<input checked="" type="checkbox"/>	
Цэцэд хандах эрхээ урвуулан ашигласан, эсхүл хариу өгсөн, шийдвэр гаргасан асуудлаар удаа дараа хандаж хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан			<input checked="" type="checkbox"/>	
Шинжээч, гэрч санаатайгаар худал дүгнэлт гаргасан, мэдүүлэг өгсөн, мэдүүлэг өгөхөөс хууль бусаар зайлсхийсэн, татгалзсан				<input checked="" type="checkbox"/>

Хуулийн төсөлд Цэцийн хуралдаанд оролцогч, эсхүл бусад этгээд хуралдааны дэгийг зөрчсөн, дэгийг сахих талаарх шийдвэрийг үл биелүүлсэн, Цэцийг үл хүндэтгэсэн, Цэц, түүний гишүүнийг маргаан хянан шийдвэрлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт, дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг оролдсон, Цэцийн шийдвэрийг биелүүлээгүй, Цэцэд хандах эрхээ урвуулан ашигласан, Цэцийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан, Шинжээч, гэрч санаатайгаар худал дүгнэлт гаргасан, мэдүүлэг өгсөн, мэдүүлэг өгөхөөс хууль бусаар зайлсхийсэн, татгалзсан гэх хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын төрлийг тодорхой тусгажээ.

Одоо хэрэгжиж буй Зөрчлийн тухай хуульд Үндсэн хуулийн дэгийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг зохицуулаагүй байна. Иймд хуулийн төсөлд тусгасан хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид (Зөрчлийн тухай хууль) уялдуулан тусгах шаардлагатай байна.

IV. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Тус судалгаагаар Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн зохицуулалт, агуулгын үр нөлөөг судалж, одоо хэрэгжиж буй Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль болон бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн туршлага, олон улсын жишиг, Үндсэн хуулийн эрх зүйн судлаачдын бүтээлтэй харьцуулан дүн шинжилгээ хийсний үндсэнд дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлд заасан цэцэд хандах хэлбэрийн талаар зохицуулалт нь Үндсэн хуулийн зохицуулалт, үзэл баримтлал болон олон улсын жишигт нийцэхээр байгаа хэдий ч

1-д иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчлийг авч хэлэлцэх талаар төсөлд тусгаснаас бусад хязгаарлалтуудыг тусгах шаардлагатай эсэхийг тодорхойлох, хуулийн зохицуулалтад оруулах нь зүйтэй эсэхийг шийдвэрлэх;

2-т Үндсэн хуулийн цэцэд иргэн үндсэн эрхийн тодорхой зөрчлийн улмаас хандахаас гадна хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан буюу объектоор хандах нь зохистой байж болох талаар авч үзэх;

3-т төрийн бус байгууллага нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор цэцэд мэдээлэл гаргах нь өмнө дурдсанчлан иргэний цэцэд хандаж мэдээлэл гаргах эрхийг хязгаарлах нөхцөл байдлыг бий болгох, цаашлаад нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор цэцэд хандах туршлага бий болоогүй байгааг харгалзан үзэх;

4-т УИХ-ын гишүүн цэцэд хандах зохицуулалт нь зорилгод нийцэж байгаа боловч Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргахад “уг тогтоолыг эсэргүүцсэн байх” гэсэн шаардлага тавих нь зүйтэй эсэхийг тодорхойлох зэргийг анхаарч үзэх нь зүйтэй байна;

- Тус хуулийн төслийн 37-49 дүгээр зүйлд тусгасан маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт, хуралдааны хэлбэртэй холбоотой зохицуулалт нь зорилгод нийцсэн буюу өмнөх хуулийн зохицуулалтад тулгамдаад буй асуудлуудыг ерөнхийд нь шийдвэрлэсэн байна. Гэхдээ зарим асуудлуудыг шийдвэрлээгүй орхисон байна. Тухайлбал, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох, хуралдаан хойшлуулах ажиллагааг нарийвчлан тусгасан хэдий ч маргааныг нэгтгэх, тусгаарлах талаар нарийвчлан тусгаагүй, гуравдагч этгээдийн эрх зүйн байдлын талаар тусгаагүй, шаардлагын талаар харилцан тохиролцох, шаардлагыг хүлээн зөвшөөрөх талаар тусгаагүй зэргийг анхаарч авч үзэх хэрэгтэй.

4.2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Маргаан шийдвэрлэх хугацааны талаарх зохицуулалтын тухайд шийдвэр гаргах хугацаа тогтоосон тохиолдолд үндсэн хуулийн шүүхэд хэргийг бүрэн

шалгах хангалттай хугацаа олгох зорилгоор шийдвэр гаргах хугацаа хэт богино байж болохгүй. Мөн хүний эрхийг үндсэн хуулийн шүүхээр үр дүнтэй хамгаалахын тулд хэт урт байж болохгүй. Армен улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд зааснаар Үндсэн хуулийн шүүх давж заалдах хүсэлтийг бүртгэснээс хойш 6 сараас дээшгүй хугацааны дотор хэргийг шийдэж үндэслэлтэй шийдвэр гаргана. Хуулийн төсөлд Цэц маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд тухайн маргаан ээдрээ, төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор хоёр хүртэл удаа сунгаж болох зохицуулалт нь бусад улсын жишигт нийцэх, маргааныг бүрэн гүйцэт, бодитой, онолын түвшинд шийдвэрлэхэд оновчтой хугацаа мөн байна.

- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх зардал буюу хуулийн төслийн 7 дугаар зүйлд тусгасан зохицуулалт нь нарийвчилсан, үр дүнтэй зохицуулалт байна. Гэвч шүүхэд хандах эрхийг илт урвуугаар ашиглах, илт амжилтад хүрэх хэтийн төлөвгүй, үргэлжилж буй ажиллагаанд ямар ч холбоо хамааралгүй өргөдөл гаргах, өмгөөлөгчийн хөлсийг нөхөн төлүүлэх, Үндсэн эрхийн талаарх, мөн Ерөнхийлөгч, шүүгч нарын импичменттэй холбоотой хэрэгт гаргасан өргөдөл нь амжилттай шийдвэрлэгдвэл хянан шийдвэрлэх ажиллагааны үед гарсан зардлыг нөхөн төлөх, хэрэглээний үнийн индекс 10-аас дээш хувиар өөрчлөгдвөл энэ хэмжээг зохих байдлаар өөрчлөх, тэмдэгтийн хураамж төлөх үндэслэл, журам, тэмдэгтийн хураамжийг буцааж олгох, хөнгөлөлт үзүүлэх гэх мэт бусад улсуудын сайн жишиг болсон зардлын талаар зохицуулалтыг анхаарч үзэх шаардлагатай.

- Цэцэд хандах хугацаатай холбоотой зохицуулалтын тухайд Венецийн комиссын судалгааны тайланд дурдагдсанаар ихэнх улсад өргөдөл гаргах хугацаа нь сүүлийн шатны шүүхийн эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 сарын хугацаа байдаг. Хуулийн төслийн 17 дугаар зүйлд заасан цэцэд хандах хугацааны талаарх, зохицуулалтын зарим зүйл заалт (17.1.4) олон улсын нийтлэг жишгээс бага хугацаа тогтоосон байна. Мөн Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрт гомдол гаргах хугацааны хязгаарлалтыг хуулийн төсөлд тусгаагүй байгааг анхаарах хэрэгтэй. “Хугацааны хязгаарлалт нь тодорхой хугацааны дараа актын хүчин төгөлдөр байдал нь маргашгүй болно гэдгийг баталгаажуулдаг тул хууль зүйн тодорхой байдлыг хангахад үйлчилдэг”. Иймд ҮХЦМХШтХуулийн төсөлд гомдол гаргах хугацааны хязгаарлалтыг тогтоох шаардлагатай байна.

- Үндсэн хуулийн цэцийн тамгын газар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шалгаж байгаа нь Цэцийн ачааллыг ихэсгэхээс урьдчилан сэргийлэх арга хэдий ч объектив стандарт шалгуурыг удирдлага болгон гомдлыг хүлээн авах эсэх шийдвэрийг гаргах нь зүйтэй байна. Одоогийн хуулийн төсөлд энэ талаар тусгасан хэдий ч шууд болон гэнэтийн хор уршиг, хохирол барагдуулах боломж, урьдчилсан хүсэлт зэрэг шүүлтүүрийг мөн авч үзэх нь зүйтэй. Түүнчлэн энэ нь хамгийн гол нь тухайн иргэний Үндсэн хуулийн гомдол гаргах эрхийг хаахгүй байх нь чухал. Үүний дагуу Үндсэн хуулийн цэцийн тамгын газар, ялангуяа Ерөнхий бүртгэгчийг чадавхжуулах, шалгуурыг өндрөөр тогтоох зэргээр бэхжүүлэх хэрэгтэй.

4.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Үндсэн хуулийн Цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны нарийвчилсан журмыг Үндсэн хуулийн Цэцийн Дэгээр зохицуулах тухай ойлголтыг одоо хэрэгжиж буй Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тусгаагүй. Харин төслийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Маргаан хянан шийдвэрлэх

ажиллагааны нарийвчилсан журмыг Цэцийн зөвлөгөөнөөс энэ хуульд нийцүүлэн баталсан Үндсэн хуулийн цэцийн дэг /цаашид “Дэг” гэх/-ээр зохицуулна.” хэмээн заасан нь хууль хэрэглэж буй этгээд болон хэргийн оролцогчдод илүү ойлгомжтой байх ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илүү тодорхой болгож байна.

- Хуулийн төсөлд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гэх нэр томъёог тодорхойлсон нь судлаачдын тайлбарт нийцэж буй хэдий ч “Гомдол”-ын талаар тухайн нэр томъёоны тодорхойлолтыг хийгээгүй байна. Иймд “Гомдол”-ын талаар нэр томъёоны тодорхойлолтыг зохицуулах шаардлагатай. Түүнчлэн тус хуулийн төсөлд гомдол гаргах эрх зүйн зохицуулалтын талаар төдийлөн тусгаагүйг анхаарч үзэх хэрэгтэй. Мөн “Мэдээлэл”-ийн тодорхойлолтыг “нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс иргэдийг төлөөлөн маргаантай асуудлаар” гэснийг илүү хүлээн зөвшөөрөгдөх тодорхойлолтод ойртуулан өөрийн эрх, ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдсөнөөс бусад үндэслэлээрх гэх байдалтай холбогдуулан тайлбарлах нь зүйтэй.

- Тус хуулийн төсөлд “маргагч” гэдгийг Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлүүлэхээр Цэцэд хандан өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан этгээдийг хэлэхээр зохицуулжээ. Өөрөөр хэлбэл өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан этгээдийн нөгөө талд байх маргалдагч талыг буюу Үндсэн хууль зөрчсөн шийдвэр, үйлдэл гаргасан байж болзошгүй этгээдүүдийг үүнд хамааруулаагүй байна. Иймд өмнөх 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тодорхойлсончлон маргагч, маргалдагч тал гэж тодорхойлон уламжлалт нэр томъёог хэрэглэн эдгээрийг маргааныг үндсэн оролцогч байхаар хуульчлах шаардлагатай.

4.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төслийн 4 дүгээр зүйл маргаан шийдвэрлэх хүрээтэй холбоотой зохицуулалтыг тусгахдаа Үндсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдсан эрх зүйн акт, үйлдлийг хянахгүй байх зохицуулалтыг хасаж хуульчилсан ба энэ нь зөвхөн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, үйлдэл, эс үйлдэхгүйгээр шийдвэрлэх хүрээг хязгаарласан нь үр дүнтэй зохицуулалт байна. Тийм боловч Үндсэн хуулийн зөрчлийг шуурхай таслан зогсоож буй нэг хэлбэр болох маргаантай актыг агуулгаар нь дахин сэргээсэн тохиолдолд хянан шийдвэрлэх зохицуулалтыг тус хуулийн төслөөс хассаныг эргэж харах нь зүйтэй байна. Мөн тус хууль нь процессын хууль болохын хувьд хуулийн төсөлд Үндсэн хуулийн цэцийн маргаан шийдвэрлэх харьяаллын талаар тусгах нь үр дүнтэй, олон улсын жишиг бүхий зохицуулалт болохоор байна. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээ болох аль шүүхэд хянан шийдвэрлэх нь тодорхойгүй хэрэг, маргааны харьяаллыг тогтоох талаар зохицуулах нь зүйтэй.

- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд зарчмыг тусгахдаа мэтгэлцэх зарчмыг тусгаагүй байна. Дээрх зарчим нь өмнөх 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд туссан уламжлалт, үр дүнтэй, бусад улсын туршлага, олон улсын байгууллагын зөвлөмжид тодорхойлсон зарчим учраас үүнийг хуулийн төсөлд тусгах шаардлагатай эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй. Ялангуяа тус хуулийн төслөөр хувь хүн үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх болсонтой холбогдуулан тус зарчмыг зайлшгүй авч үзэх нь зүйтэй.

- Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавигдах шаардлагатай холбоотой зохицуулалтын тухайд “өргөдөл” гаргахад шүүхэд хандаж эцэслэн шийдвэрлүүлсэн боловч зөрчил арилаагүй гэж үзсэн үндэслэлийг тусгах тухай зохицуулалт нь одоо хэрэгжиж буй ҮХЦМХШАТХуулиас ялгарч байна. Түүнчлэн сонгодог онолын дагуу асуудлыг өргөдөл гаргасны үндсэн дээр үндсэн хуулийн шүүхэд шийдвэрлүүлж байгаа бол, иргэн хүн эрхээ хамгаалуулахаар үндэсний эрх зүйн бүх шат дамжлагыг өмнө нь гүйцэтгэх ёстой тул, маргааныг наана нь олон шатаар хянасан байх шаардлагатай гэж үздэг. Иймд хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан өргөдөл тавих шалгуур үзүүлэлтийн хүрээнд шүүхэд хандаж эцэслэн шийдвэрлүүлсэн байх зохицуулалт нь Үндсэн хуулийн шүүхийн сонгодог онолд нийцсэн, олон улсын нийтлэг хандлагатай уялдсан зохицуулалт болно.

- Маргааны оролцогчийн эрх зүйн байдалтай холбоотой зохицуулалтын тухайд хуулийн төсөлд маргагч болон маргалдагч талыг “үндсэн оролцогчид”; гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хуралдааны нарийн бичгийн дарга нь “бусад оролцогчид” хамаарах зааг ялгааг тодорхойлж, эрх, үүргийг заасан байна. Одоо хэрэгжиж буй хуулиас ялгарч байгаа тал нь Цэцийн гишүүнийг татгалзан гаргах үндэслэл, журам байна. Гэхдээ хуулийн төсөлд заасан Цэцийн гишүүнээс татгалзах 2 үндэслэл нь одоо хэрэгжиж буй хуулийн хийдлийг арилгаж чадаагүй байна. Тодруулбал, маргааныг нэг талд шийдвэрлэснээр тухай шүүгчид ямар нэг ашигтай байдал үүсэж болзошгүй байх явдал гарч болно. Иймд Цэцийн гишүүний татгалзан гарах үндэслэлийг анхаарах нь зүйтэй байна.

- Тус хуулийн төсөлд хэрэг хуваарилах журмыг нарийвчлан тусгаж автомат байдлаар программ ашиглан хуваарилах байдлаар зохицуулсан нь өмнө үүсээд байсан асуудлыг шийдвэрлэсэн сайн жишигт нийцсэн зохицуулалт байна. Гэхдээ ийнхүү хуваарилахад мэргэшсэн чиглэл, ажлын ачааллыг харгалзан хуваарилах, хэрэглэгдэхгүй байх онцгой тохиолдлуудыг харгалзан үзэх зэргээр тухайн программ хангамжид холбогдох урьдчилсан шалгууруудыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай.

- Тус хуулийн төсөлд тусгагдсан маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухайд хэргийн оролцогч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан үед маргаантай байгаа шаардлага болон үүрэг эрх залгамжлагчид шилжих ёстой байвал, хэргийн оролцогч онц ба дайны байдал зарласан нөхцөлд цэргийн алба хааж байгаа, хэргийн оролцогч хүнд өвчний учир эмчлүүлж байгаа бөгөөд төлөөлөгч томилох боломжгүй, нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх, шүүхийн даалгавар, түүнийг биелүүлэх, шинжээчийн дүгнэлттэй холбоотой тохиолдолд түдгэлзүүлэх үндэслэл болох боломжтой. Мөн бусад маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх боломжтой нөхцөл дахин судалж хуулийн төсөлд тусгах эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй байна.

- Цэцийн шийдвэр гаргахтай холбоотой зохицуулалтын тухайд Шүүхийн зөвлөлдөх тасалгаанд нарийн бичгийн дарга оролцох болон хуралдааны тэмдэглэл хөтлөх явдал зөвлөлдөх тасалгаанд хуралдааныг хаалттай явуулахад харшилдаг. Хуулийн төсөлд зөвлөлдөх тасалгаанд зөвхөн тухайн бүрэлдэхүүний гишүүд байх бөгөөд шийдвэрийн тогтоох хэсгийн гол агуулгын төслийг илтгэгч гишүүн болон бүрэлдэхүүний бусад гишүүн зөвлөлдөх тасалгаанд хамтран бичиж, гарын үсэг зурах тухай 50.1 болон 50.9 дэх зохицуулалтууд зөвлөлдөх тасалгааны нууцыг хадгалах зарчмыг баримталсан зохицуулалт байна.

Цэцийн шийдвэрийг мэдээлэхтэй холбоотой зохицуулалтын тухайд одоо хэрэгжиж буй хуульд зөвлөлдөх тасалгаанд олохтой санал нийлээгүй гишүүн саналаа тусгайлан бичгээр гаргаж Цэцийн шийдвэрт хавсаргах үүрэгтэй байхаар томъёолсон нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхэд хүргэсэн.⁸¹ Олон улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч тусгай саналаа нийтлэх эрхтэй байдаг. Иймд хуулийн төслийн 51 дүгээр зүйлийн 51.1-т заасан зохицуулалт буюу зөвлөлдөх тасалгаанд олохтой санал нийлээгүй гишүүн саналаа тусгайлан бичгээр гаргаж Цэцийн шийдвэрт хавсаргах эрхтэй байхаар заасан нь Цэц хараат бус байх нөхцөлийг бүрдүүлсэн, Олон улсын Үндсэн хуулийн шүүхийн жишигт нийцсэн зохицуулалт болно.

- Хуулийн төсөлд тусгай журмын талаар зохицуулсан нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт тулгуурласан, процессыг оновчтой байдлаар тодорхойлсон үр дүнтэй, эрх зүйн хөгжил өндөр улсын жишигт нийцсэн зохицуулалт байна. Гэхдээ бусад улсын зохицуулалтад тусгай журмаар шийдвэрлэхдээ хүсэлт гаргахаас эхлээд шийдвэр биелүүлэх хүртэл бүтнээр нь процессыг авч үздэг болохыг анхаарч үзэн нийтлэг журамтай харьцуулан хийдэл үүсгэхгүй байх тал дээр анхаарах нь зүйтэй. Түүнчлэн тухайн улсын зохицуулалтаас үүсээд буй сөрөг үр дагаврыг тухайн улсын мэргэжилтнүүдээс асууж тодруулан судалж алдааг давтахгүй байх үүднээс зохицуулах шаардлагатай.

4.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Тус хуулийн төсөлд шинээр бүх шатны шүүх Цэцэд дэмжлэг үзүүлэх болон даалгаврыг биелүүлэх үүрэг хүлээсэн хэдий ч хэрхэн тухайн үүргийг хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулаагүй байна. Иймд бүх шатны шүүхийн зүгээс Цэцэд дэмжлэг үзүүлэх, даалгаврыг биелүүлэх тохиолдолд Цэцтэй хэрхэн харилцах талаар тухайн холбогдох эрх зүйн актад (Шүүхийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль) эсвэл тус хуулийн төсөлд энэ талаар нарийвчлан тодорхойлох талаар анхаарч үзэх хэрэгтэй.

- Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалтын тухайд одоо хэрэгжиж буй Зөрчлийн тухай хуульд Үндсэн хуулийн дэгийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг зохицуулаагүй байгаа нь Үндсэн хуулийн судлаачдын хөнддөг асуудлуудын нэг мөн. Харин хуулийн төсөлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын төрлийг тодорхой тусгасан байна. Иймд хуулийн төсөлд тусгасан хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид (Зөрчлийн тухай хууль) уялдуулан тусгах шаардлагатай байна.

81 Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй*, Хоёрдахь хэвлэл, (УБ, 2021), 153 дахь тал.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, (1997).
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992).
4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2016).
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2002).
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017).
7. Хууль тогтоомжийн тухай хууль, (2017).
8. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулга, (УБ, 2023).
9. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, (УБ, 2023).

Гадаад хэлээр:

1. Act on the Federal Constitutional Court (Bundesverfassungsgerichtsgesetz – BVerfGG).
2. Federal constitutional law no. 1-fkz of July 21, 1994 on the constitutional court of the Russian Federation (with the Amendments and Addenda of February 8, 2001).
3. Constitutional court act of Korea, Expand Act No. 15495, Mar. 20, 2018.
4. Constitutional Review Court Procedure Act of Estonia, Entry into force 01.07.2002.

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Г.Совд, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, (УБ, 2000).
2. Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар, “Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж. /Боть 9/”, (УБ, 2022).
3. О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж”, “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: Одоо ба ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2015).
4. Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, (УБ, 2007).
5. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, Хоёрдахь хэвлэл, (УБ, 2021).
6. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, Анхны хэвлэл, (УБ, 2005).
7. ХЗҮХ, “Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль”, (УБ, 2020).

8. ХЗҮХ, “Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа”, (Уб, 2023).
9. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны 30 жилийн тоон үзүүлэлт /1992-2021 он/, (Уб, 2021).
10. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны хүрээлэн, “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” (Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл), (Уб, 2023).
11. Хууль зүй, дотоод хэргийн яам, Н.Отгончимэг, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”, (Уб, 2019).
12. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Анхны хэвлэл, (Уб, 2007).
13. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2020.04.22 Санал № 2022CDL-PI (2020) 004 “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан судалгааны эмхэтгэл”, (Уб, 2023).
14. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Венецийн комисс Страсбург 2021.02.22 Санал № 1004/2020 CDL-AD (2021) 001 “Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрх шинэчилсэн тайлан”, (Уб, 2023).
15. Арне Мавчич, “Үндсэн хуулийн хяналт”, (Уб, 2014).

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” Эрдэм шинжилгээний өгүүлэл, (Уб, 2002), <https://legaldata.mn/buteel/pdf?ld=775>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, №3, (Уб, 1992), <https://www.parliament.mn/nn/12604/>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт “Цэцийн тухай хууль үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар”, 1995.01.18, <https://old.legalinfo.mn/law/details/1129?Lawid=1129>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
4. Үндсэн хуулийн цэцийн дугаар 01 дүгнэлт, 2020.04.15, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=15259>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
5. П.Баттулга “Цэцийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ: УИХ э. Ариунболд нар (2020)” (2020), <https://legaldata.mn/b/1191>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
6. Б.Энхбаяр, “Үндсэн хуулийн цэц өөрөө Үндсэн хуулиа зөрчсөн”, <https://itoim.mn/article/A6311/29744>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

Гадаад хэлээр:

1. 헌법재판소법 ([시행 2022. 2. 3.] [법률 제18836호, 2022. 2. 3., 일부개정]), Холбоос: <https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%97%8C%EB%B2%95%EC%9E%AC%ED%8C%90%EC%86%8C%EB%B2%95?Fbclid=iwar3jwwhw36mp4zdc-0Hy3kzinbxWJJ8HJXur1WLSGsjAO2o-DE>

- t3a3aqpq, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
2. Act on the Federal Constitutional Court, (Bundesverfassungsgerichtsgesetz – BVerfGG), Холбоос: https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/BVerfGG.pdf?__blob=publicationFile&v=1, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
 3. Federal constitutional law, no. 1-fkz of July 21, 1994, on the constitutional court of the Russian Federation (with the Amendments and Addenda of February 8, 2001), Холбоос: https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/wtaccrus48_leg_73.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
 4. Korean Constitutional Court act, Act No. 15495, Mar. 20, 2018, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47509&lang=ENG, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.
 5. Constitutional Review Court Procedure Act, Entry into force 01.07.2002, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/528062017007/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.17.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ**Нэгдүгээр зүйл**

Монгол Улсын Үндсэн хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.”

2/Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.”

Хоёрдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “томилно” гэснийг “томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно” гэж, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр” гэснийг “Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

Гуравдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөвдүгээр зүйл**Дагаж мөрдөх хугацаа**

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /цаашид “Цэц” гэх/-ийн бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, хараат бус, бие даасан байдлын баталгаа, Цэцийн гишүүний эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Цэцийн тухай хууль тогтоомж

2.1.Цэцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль /цаашид “Үндсэн хууль” гэх/,¹ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль болон Үндсэн хуулийн цэцийн дэг /цаашид “Дэг” гэх/-ийн дагуу хянан шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл.Үндсэн хуулийн цэц, түүний бүрэн эрх

3.1.Цэц Үндсэн хуулийг чандлан сахиулах, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа болж, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх Үндсэн хуулийн шүүх мөн.

3.2.Цэц энэ хуулийн 3.1-д заасан бүрэн эрхээ дараах замаар хэрэгжүүлнэ:

3.2.1.хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх маргаантай асуудлыг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах;

3.2.2.ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх маргаантай асуудлыг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах;

1 Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

3.2.3.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлыг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах;

3.2.4.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх маргаантай асуудлыг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах;

3.2.5.үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх.

3.3.Энэ хуулийн 3.2.1, 3.2.2-т заасан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана.

4 дүгээр зүйл.Цэцийн үйл ажиллагааны зарчим

4.1.Үндсэн хуульд захирагдах, хууль дээдлэх, судалгаанд үндэслэх, тал үл харах, хараат бус, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны зарчим мөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЦЭЦИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5 дугаар зүйл.Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлага

5.1.Цэцийн гишүүн Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлоос гадна дараах шаардлагыг хангана:

5.1.1.эрх зүйч мэргэжилтэй;

5.1.2.Цэцийн гишүүнээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй.

5.2.Дараах иргэнийг Цэцийн гишүүнээр томилохыг хориглоно:

5.2.1.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

5.2.2.сүүлийн дөрвөн жилийн хугацаанд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлсэн;

5.2.3.албан тушаалаас огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн;

5.2.4.сахилгын зөрчил гаргасны улмаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эсхүл өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь хүчингүй болгосон;

5.2.5.эрүүгийн хариуцлага хүлээж байсан.

6 дугаар зүйл.Цэцийн гишүүнийг томилох

6.1.Цэц есөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүх /цаашид “эрх бүхий байгууллага, албан тушаалтан” гэх/-ийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно. Цэцийн гишүүнээр зөвхөн нэг удаа дахин томилж болно.

6.2.Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон өдрөөс хойш 45 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг хангасан иргэнийг нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд энэ хуулийн 6.6-д заасан үндэслэл, танилцуулга, холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ.

6.3.Улсын Их Хурал Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгохдоо дараах журмыг баримтална:

6.3.1.Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор, хэрэв чуулганы чөлөө цагт эдгээр нөхцөл бий болсон бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийг тэнцвэртэйгээр, аль ч нам, эвсэл олонх болоогүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийг авсан суудлын тоогоор нь хувь тэнцүүлж бүрдүүлсэн 9 гишүүн бүхий ажлын хэсэг байгуулна. Нам, эвслийн бүлэг ажлын хэсгийн гишүүнээ өөрөө сонгоно;

6.3.2.Ажлын хэсэг байгуулагдсан өдрөөсөө хойш 30 хоногийн дотор нийт гишүүнийхээ гуравны хоёрын саналаар Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг сонгоно.

6.4.Ерөнхийлөгч Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгох тухай захирамж гаргана.

6.5.Улсын дээд шүүх хяналтын шатны шүүхийн шүүгчдээс Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг нийт шүүгчийнхээ олонхын саналаар нууц санал хураалтаар сонгоно. Улсын Их Хурал хяналтын шатны шүүхийн шүүгчийг Цэцийн гишүүнээр томилсноор Улсын дээд шүүхийн шүүгчийн бүрэн эрх нь дуусгавар болно.

6.6.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан саналаа Улсын Их Хуралд хүргүүлэхээсээ өмнө тухайн нэр дэвшигч Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг бүрэн хангасан талаарх үндэслэл, танилцуулгыг цахим хуудастаа таваас доошгүй ажлын өдөр байршуулна.

6.7.Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо энэ хуулийн 6.2-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийн сонголыг холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулна.

6.8.Нэр дэвшигчийг Улсын Их Хурал томилохоос татгалзсан бол санал гаргасан байгууллага, албан тушаалтан энэ зүйлд заасны дагуу өөр нэр дэвшигчийг санал болгоно.

6.9.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг хангах боломжтой хүмүүсийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журмыг энэ хуульд нийцүүлэн баталж, ажлын таван өдрийн дотор цахим хуудсандаа байршуулна.

7 дугаар зүйл.Цэцийн гишүүний бүрэн эрх эхлэх, үргэлжлэх, дуусгавар болох

7.1.Цэцийн гишүүний бүрэн эрх томилогдсон өдрөөс эхэлж энэ хуулийн 7.2-т заасан үндэслэлээр дуусгавар болох хүртэл үргэлжилнэ.

7.2.Цэцийн гишүүний бүрэн эрх дараах үндэслэлээр дуусгавар болно:

7.2.1.нас барсан;

7.2.2.бүрэн эрхийн хугацаа дуусаж дараагийн гишүүн томилогдсон;

7.2.3.бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тухай хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурал чөлөөлсөн;

7.2.4.Монгол Улсын иргэний харьяаллаас гарсан;

7.2.5.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Цэцийн гишүүнийг эгүүлэн татах тухай Улсын Их Хурлын шийдвэр гарсан;

7.2.6.гэмт хэрэг үйлдсэн талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

7.3.Цэцийн гишүүнээр томилогдсоноос хойш төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн нь тухайн гишүүний бүрэн эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.

8 дугаар зүйл.Цэцийн гишүүний тангараг

8.1.Цэцийн гишүүн томилогдсоноос хойш 30 хоногийн дотор “Үндсэн хуулийн цэцийн гишүүн би Монгол Улсын Үндсэн хуулийг чин үнэнчээр хамгаалж, маргааныг гагцхүү Үндсэн хуульд захирагдан тал үл харж, хараат бус, шударгаар хянан шийдвэрлэж, Цэцийн гишүүний үүргээ чандлан биелүүлэхээ тангараглая” хэмээн Цэцийн хуралдааны танхимд Үндсэн хуульд тангараг өргөнө.

8.2.Цэцийн гишүүний тангараг өргөх журмыг Дэгээр зохицуулна.

9 дүгээр зүйл.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн

9.1.Цэц маргааныг Бага, Дунд, Их суудлаар хянан шийдвэрлэнэ.

9.2.Цэцэд гурван гишүүний бүрэлдэхүүнтэй Бага суудал гурав, зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй Дунд суудал гурав, нийт гишүүний бүрэлдэхүүнтэй Их суудал нэг байна.

9.3.Бага, эсхүл Дунд суудлын бүрэлдэхүүнийг жил бүр шинэчилнэ.

9.4.Цэцийн гишүүн Бага суудлын хоёроос илүү бүрэлдэхүүнд нэгэн зэрэг харьяалагдахгүй.

9.5.Цэцийн гишүүн Дунд суудлын хоёроос илүү бүрэлдэхүүнд нэгэн зэрэг харьяалагдахгүй.

9.6.Бага эсхүл Дунд суудлын бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд бусад бүрэлдэхүүнээс энэ хуулийн 9.7-д заасан журмын дагуу Цэцийн гишүүнийг томилон ажиллуулж болох бөгөөд үүнд энэ хуулийн 9.4, 9.5-д заасан хязгаарлалт

хамаарахгүй.

9.7.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага, Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилахдаа урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор сонгох нөхцөлийг хангах бөгөөд холбогдох журмыг Дэгээр зохицуулна.

10 дугаар зүйл.Цэцийн зөвлөгөөн

10.1.Цэцийн нийт гишүүнээс бүрдсэн Цэцийн зөвлөгөөн /цаашид “Зөвлөгөөн” гэх/ ажиллана.

10.2.Зөвлөгөөнд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад Цэцийн гишүүн орно. Зөвлөгөөнийг долоогоос доошгүй гишүүн хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуульд өөрөөр заагаагүй бол Зөвлөгөөнд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

10.3.Зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ:

10.3.1.Үндсэн хуулийн цэцийн дэгийг батлах;

10.3.2.Бага, Дунд суудлын бүрэлдэхүүний хуваарийг жил бүр батлах;

10.3.3.Цэцийн төсвийн талаар санал гаргах, төсвийн гүйцэтгэлтэй танилцах;

10.3.4.Цэцийн даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;

10.3.5.Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх;

10.3.6.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэхийг тогтоох, энэ тухай шийдвэрээ Улсын Их Хуралд хүргүүлэх;

10.3.7.Цэцийн тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дотоод журмыг батлах;

10.3.8.Цэцийн даргын саналаар Цэцийн тамгын газрын дарга, Цэцийн судалгааны төвийн эрхлэгчийг, Цэцийн гишүүний саналаар түүний судлаачийг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл оногдуулах;

10.3.9.Цэцийн тамгын газрын үйл ажиллагааны тайлан, мэдээлэл сонсох, чиглэл өгөх;

10.3.10.Цэцийн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн санал болгосон асуудал;

10.3.11.хуульд заасан бусад.

10.4.Зөвлөгөөн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол гаргана.

10.5.Тамгын газар Зөвлөгөөний хуралдааныг тэмдэглэл хөтлөн баримтжуулж, архивын нэгж үүсгэн хадгална.

10.6.Энэ хуулийн 10.3-т заасан дэг, хуваарь, дотоод журам нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд тэдгээрийг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Цэцийн цахим хуудсанд байршуулна.

10.7.Зөвлөгөөн ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит Зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус Зөвлөгөөнийг Цэцийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй, эсхүл Цэцийн даргын саналаар хуралдуулна.

10.8.Цэцийн гишүүн Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай гурваас доошгүй ажлын өдрийн өмнө урьдчилан танилцах, санал гаргах, хуралдаанд оролцох тэгш боломжоор хангагдана.

10.9.Зөвлөгөөний шийдвэр үндэслэл бүхий, нийтэд ил тод, нээлттэй байх бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль², Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай³ хуульд заасан шаардлагыг хангана.

10.10.Зөвлөгөөний ажиллах журмыг Дэгээр зохицуулна.

11 дүгээр зүйл.Цэцийн дарга, түүний бүрэн эрх

11.1.Цэцийн даргыг гишүүд дотроосоо гурван жилийн хугацаагаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.

11.2.Цэцийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн нууцаар санал хурааж нийт гишүүний олонхын санал авсан хүнийг Цэцийн даргаар сонгоно. Цэцийн даргад гурав эсхүл түүнээс дээш гишүүн нэр дэвшиж, анхны санал хураалтаар хэн нь ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр гишүүний нэрээр дахин санал хурааж нийт гишүүний олонхын санал авсан гишүүнийг Цэцийн даргаар сонгоно.

11.3.Цэцийн дарга нь гишүүний бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.3.1.Цэцийг дотоод, гадаадад төлөөлөх;

11.3.2.Зөвлөгөөнийг хуралдуулах, даргалах;

11.3.3.төрийн бусад байгууллагатай харилцахдаа Цэцийн бие даасан байдлыг хамгаалах, хангах;

11.3.4.Цэцийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

11.3.5.Цэцийн тамгын газарт эрх хэмжээнийхээ хүрээнд чиглэл өгөх, хяналт тавих;

11.3.6.хуульд заасан бусад.

11.4.Цэцийн дарга бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж, тушаал гаргана.

2 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

3 Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

11.5.Цэцийн даргын түр эзгүйд Цэцийн бүрэлдэхүүнд хамгийн удаан ажилласан гишүүн, хэрэв энэ шаардлагыг хэд хэдэн гишүүн нэгэн адил хангасан байвал тэдгээрийн хамгийн ахмад гишүүн Цэцийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэнэ.

12 дугаар зүйл.Цэцийн тамгын газар

12.1.Цэц Тамгын газартай байна:

12.2.Цэцийн Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ дараах чиг үүргийг хэрэгжүүлж, Зөвлөгөөнд тогтмол тайлагнана:

12.2.1.Цэцийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, аюулгүй явуулах, ажиллах нөхцөлөөр хангах, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

12.2.2.Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлт, саналыг хүлээн авч, бүртгэх;

12.2.3.маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээллийг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, тодорхой маргааны насжилт зэрэг үзүүлэлтээр гаргах, хяналт-шинжилгээ хийх, нийтэд мэдээлэх;

12.2.4.маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа хийх, мэдээлэл, судалгаа, хууль тогтоомжоор хангах, ийм санг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлж, тогтмол шинэчлэх, номын сангийн үйлчилгээ үзүүлэх;

12.2.5.Цэцийн хуралдаан, Зөвлөгөөнийг зохион байгуулах бэлтгэл ажиллагаа, техникийн болон бусад бэлэн байдлыг хангах, хуралдааны товыг нийтэд мэдээлэх, тэмдэглэн хөтөлж, хадгалах;

12.2.6.Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх, хүргүүлэх, цахим хуудаст байршуулах, эмхэтгэн хэвлэх, хайлт хийх боломжтой цахим сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх;

12.2.7.маргааны материал, баримтыг хадгалах, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх;

12.2.8.Цэцийн тээвэр, холбоо, мэдээлэл шинжилгээ, программ хангамж, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах, тэдгээрийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг зохион байгуулах, түүнийг хэрэглэх мэргэжилтнээр хангах;

12.2.9.Цэцийн гадаад харилцааны асуудлыг хариуцан шаардлагатай баримт бичиг бэлтгэх, гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх зочин, төлөөлөгчдийг хүлээн авах бэлтгэл хангах, тэдгээрт үйлчлэх;

12.2.10.Цэцийн цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчлэх;

12.2.11.Цэцээс хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохион байгуулах;

12.2.12.Цэцийн бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг эрхлэх;

12.2.13.Цэцийн аж ахуй, санхүүг хөтлөн явуулах, төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулах, санхүүгийн нэгдсэн тайлан, мэдээг гаргах, судлах, боловсруулалт хийх;

12.2.14.Цэцийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг авах;

12.2.15.Цэцийн байрны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журам баталж, мөрдүүлэх;

12.2.16.Цэцийн гишүүн, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах;

12.2.17.Цэцийн хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавих;

12.2.18.хуульд заасан бусад.

12.3.Тамгын газар тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

12.4.Тамгын газрын дарга Төрийн албаны тухай хуульд заасан шаардлага хангасан төрийн захиргааны албан тушаалтан байна.

12.5.Тамгын газрын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.5.1.Тамгын газрыг өдөр тутмын удирдлагаар хангах;

12.5.2.Цэцийн төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

12.5.3.Цэцийн төсвийн төслийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороогоор хянуулахаар хүргүүлэх, хянасан төсвийн төслийн эцсийн хувилбарыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, шаардлагатай бол Улсын Их Хурлаар Цэцийн төсвийг хэлэлцэх үед үг хэлэх;

12.5.4.Цэцийн гишүүний саналыг үндэслэн түүний туслахыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл оногдуулах;

12.5.5.Энэ хуулийн 12.5.4-т зааснаас бусад Тамгын газрын ажилтныг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл оногдуулах;

12.5.6.хуульд заасан бусад.

12.6.Тамгын газрын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана.

12.7.Цэцэд Ерөнхий бүртгэгч, бүртгэгч ажиллах бөгөөд тэдгээр нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан байна.

12.8. Ерөнхий бүртгэгч нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасны дагуу өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шаардлага хангасан эсэх, Цэц урьд нь тухайн асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг нягтлан үзэж, тухайн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагч этгээдэд өгөх чиг үүрэгтэй. Ерөнхий бүртгэгч энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд бүртгэгч тусална.

12.9.Цэцийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий судалгааны төв, номын сан болон зохион байгуулалтын бусад нэгж ажиллана.

13 дугаар зүйл.Цэцийн гишүүний туслах, судлаач

13.1.Цэцийн гишүүн нэг туслахтай байна.

13.2.Туслах нь эрх зүйч байх бөгөөд Цэцийн гишүүний удирдлага дор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

13.3.Цэцийн гишүүн энэ хуулийн 13.1-д зааснаас гадна Цэцийн гишүүний удирдлага дор маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой судалгаа хийх чиг үүрэг бүхий гурав хүртэл судлаачтай байна. Судлаач нь харьцуулсан эрх зүйн судалгаа хийх чадвартай, энэ хуулийн 5.2-т заасан шаардлага хангасан эрх зүйч байна.

13.4.Цэцийн гишүүн нь их, дээд сургууль, төрийн бусад байгууллагын удирдлагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн байгууллагын албан хаагчийг Цэцийн гишүүний судлаачаар хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.

13.5.Энэ хуулийн 13.4-т заасан албан хаагч өөрөө, эсхүл Цэцийн гишүүний хүсэлтээр анх илгээсэн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно. Албан хаагчийг сэлгэн ажиллуулахдаа эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс, зэрэг дэвийг бууруулахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙ ХАРИУЦЛАГА

14 дүгээр зүйл.Цэцийн гишүүний баримтлах зарчим, хүлээх үүрэг, хориглох, хязгаарлах зүйл

14.1.Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийг дээдлэх, шударга, хараат бус, зарчимч, бодитой, үндэслэлтэй хандах, тал үл харах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг чанд баримтална.

14.2.Цэцийн гишүүн албан үүргээ хараат бусаар гүйцэтгэх бөгөөд бусад гишүүний хараат бус байдалд хүндэтгэлтэй хандана.

14.3.Цэцийн гишүүн Авлигын эсрэг хууль⁴ болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд⁵ заасан үүрэг, хориглолт, хязгаарлалтыг дагаж мөрдөнө.

14.4.Цэцийн гишүүнд Төрийн албаны тухай хуулийн 39.1-д зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:

14.4.1.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулах, албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор ашиглах;

4 Авлигын эсрэг хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 35 дугаарт нийтлэгдсэн.

5 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

14.4.2.Цэцэд хянан шийдвэрлэж байгаа маргаан эсхүл ойрын ирээдүйд Цэцийн шийдвэрлэвэл зохих асуудлын талаар саналаа нийтэд урьдчилан илэрхийлэх;

14.4.3.өөрийн, эсхүл гэр бүлийн гишүүний эрх, ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдыг төлөөлөх, хууль зүйн зөвлөгөө өгөх;

14.4.4.багшлах болон судалгааны ажил гүйцэтгэхээс бусад албан үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

14.4.5.улс төрийн, худалдааны, эсхүл хараат бус, тал үл харах байдалд нь харшлах бусад үйл ажиллагаа эрхлэх, оролцох;

14.4.6.хуульд заасан бусад.

15 дугаар зүйл.Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх

15.1.Цэцийн гишүүнд холбогдуулан үүсгэсэн гэмт хэргийг мөрдөн шалгах явцад уул гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагатай гэж үзвэл энэ тухай саналаа Улсын ерөнхий прокурор Цэцэд хүргүүлнэ.

15.2.Зөвлөгөөн энэ хуулийн 15.1-д заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын арван өдрийн дотор Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэн нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

15.3.Бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг хэлэлцэж байгаа Цэцийн гишүүн Зөвлөгөөний хуралдаанд үг хэлэх эрхтэй бөгөөд санал хураалтад оролцохгүй.

15.4.Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал бүрэн тогтоогдоогүй гэж Зөвлөгөөн үзвэл уул гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхээс татгалзана.

15.5.Зөвлөгөөнд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал бүрэн тогтоогдсон гэж үзсэн бол Цэцийн гишүүний бүрэн эрхийг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

15.6.Дараах тохиолдолд Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсэн хугацааны албан тушаалын цалинг бүхэлд нь нөхөн олгоно:

15.6.1.Цэцийн гишүүнд холбогдуулан үүсгэсэн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон;

15.6.2.Цэцийн гишүүнийг гэм буруугүйд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

15.7.Зөвлөгөөн Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзсэн бол уул шийдвэр гарсан өдрөөс тухайн гишүүний бүрэн эрх дуусгавар болох хүртэл Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн байцаалтын хугацаа зогсоно. Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болсон өдрөөс уг хугацааг сэргээн шалгана.

15.8.Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх журмыг Дэгээр зохицуулна.

16 дугаар зүйл.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах

16.1.Энэ хуулийн 14.2, 14.3, 14.4-т заасан үүрэг, хориглолт, хязгаарлалтыг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн нь Цэцийн гишүүний албан тушаалыг эрхлэхэд тохирохгүйг харуулсан бол тухайн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл /цаашид “Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл” гэж/ болно.

16.2.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлыг Зөвлөгөөн энэ тухай гомдлын дагуу хянан шийдвэрлэнэ. Уул асуудалд холбогдсон Цэцийн гишүүн Зөвлөгөөний хуралдаанд үг хэлэх эрхтэй бөгөөд санал хураалтад оролцохгүй.

16.3.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй тухай шийдвэрийг Зөвлөгөөнд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар гаргах бөгөөд нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

16.4.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй тухай шийдвэр гаргасан бол ажлын таван өдрийн дотор уг шийдвэрийг Улсын Их Хурал болон тухайн гишүүнийг анх илгээсэн байгууллага, албан тушаалтанд хүргүүлж нийтэд мэдээлнэ. Анх илгээсэн байгууллага, албан тушаалтан Зөвлөгөөний шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор саналаа Улсын Их Хуралд хүргүүлнэ.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасны дагуу Зөвлөгөөний шийдвэрийг Улсын Их Хурал чуулганы үеэр хүлээн авсан бол ажлын таван өдрийн дараа 14 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Зөвлөгөөний шийдвэр, анх илгээсэн байгууллага, албан тушаалтны саналыг үндэслэн Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл бий эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

16.6.Анх илгээсэн байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 16.4-т заасан хугацаанд Улсын Их Хуралд саналаа ирүүлээгүй бол тухайн асуудлаар тусгайлан өгөх саналгүй гэж үзэн Цэцийн гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

16.7.Энэ хуулийн 16.1-д заасан асуудлыг шийдвэрлэх журмыг Дэгээр зохицуулна.

Тайлбар:Энэ зүйлд заасан “анх илгээсэн байгууллага, албан тушаалтан” гэдэгт энэ хуулийн 6 дугаар зүйлийн дагуу Цэцийн тухайн гишүүнийг санал болгосон эрх бүхий байгууллага, албан тушаалтныг ойлгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙ ХАРААТ БУС, ЦЭЦИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ****17 дугаар зүйл.Цэцийн гишүүний хараат бус байдал**

17.1.Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хараат бус байна.

17.2.Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд эрх тэгш байна.

17.3.Цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан, дордуулсан эрх зүйн акт гаргахыг хориглоно.

17.4.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч Цэцийн гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно.

17.5.Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэхүйг тэмдэглэн баталгаажуулах зорилгоор нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.

17.6.Цэцийн гишүүний нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар маргаан үүсгэсэн даруйд тухайн маргааны оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулна.

17.7.Цэцийн гишүүн нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн бол маргааны материалд хавсаргаж, хувийг Тамгын газарт хүргүүлнэ.

17.8.Тамгын газар нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан үйлдлийг шалгуулахаар зохих байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.

17.9.Энэ хуулийн 17.8-д заасны дагуу шилжүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэж, нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн Цэцийн гишүүн болон Тамгын газарт хариу мэдэгдэнэ.

17.10.Тамгын газар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

17.11.Нөлөөллийн мэдүүлгийг хөтлөх, шийдвэрлэх журмыг Дэгээр зохицуулна.

18 дугаар зүйл.Цэцийн гишүүний халдашгүй байдал

18.1.Цэцийн гишүүний амь бие, орон сууц, ажлын байр, тээвэр, холбооны хэрэгсэл, захидал харилцаа халдашгүй байна.

18.2.Албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, техник, тээврийн хэрэгсэл, бие хамгаалах тусгай хэрэгслээр Цэцийн гишүүнийг хангана.

18.3.Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, эгүүлэн татах, өөр ажилд шилжүүлэхийг хориглоно.

18.4.Цэцийн гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд Цэцийн зөвлөгөөний шийдвэргүйгээр түүнийг баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн журмаар Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хориглоно.

18.5.Цэцийн гишүүн, эсхүл түүний гэр бүлийн гишүүний амь нас, аюулгүй байдалд аюул занал учрах нөхцөл үүссэн бол цагдаагийн байгууллага таслан зогсоход чиглэсэн арга хэмжээг нэн даруй авна.

18.6.Цэцийн гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд аливаа албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

19 дүгээр зүйл.Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгаа

19.1.Цэцийн гишүүний албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байна.

19.2.Цэцийн гишүүний цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.

19.3.Цэцийн төсвийг батлахдаа гишүүний цалин хөлсний хэмжээг өмнөх жилийнхээс бууруулж болохгүй.

19.4.Цэцийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг Цэцийн төсвөөс санхүүжүүлнэ.

19.5.Энэ хуулийн 7.2.2-т заасан үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол Цэцийн гишүүнд сүүлийн нэг жилийн албан тушаалын цалингийн дундаж хэмжээгээр тооцон 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж эсхүл тэтгэвэрт гарсан бол холбогдох хуульд заасан тэтгэмжийг улсын төсвөөс олгоно.

19.6.Энэ хуулийн 7.2.2-т заасан үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол гишүүнээр томилогдохын өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах үүргийг тухайн байгууллага, ажил олгогч хүлээх бөгөөд ийм боломжгүй тохиолдолд түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар төр хангана. Тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэлх гурван жилийн хугацаанд Цэцийн гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс бууруулахгүйгээр тэтгэмжийг сар бүр олгоно. Бага цалинтай ажил эрхэлж байгаа бол өндөр насны тэтгэвэрт гарах хүртэл цалингийн зөрүүг улсын төсвөөс сар бүр олгоно.

19.7.Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний өндөр насны тэтгэврийг Цэцийн гишүүний албан тушаалын цалингийн 60-аас доошгүй хувиар бодож тогтооно.

19.8.Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд дараах баталгаагаар хангагдана:

19.8.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол авч байсан цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгох;

19.8.2.хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, авч байсан цалин хөлсний зөрүүг олгох;

19.8.3.хиймэл эд, эрхтэн хийлгэх бол түүний зардал, түүнчлэн гишүүнд туслалцаа, үйлчилгээ үзүүлэх ажилтны хөлс олгох.

19.9.Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдсан тохиолдолд 60 сарын, өвчний улмаас нас барсан бол 36 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж ар гэрт нь олгоно.

Тайлбар: Цэцийн гишүүний бүрэн эрх нь дуусгавар болсон иргэний амь насанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан хохирол учруулсан бол энэ хуулийн 19.9-т заасан буцалтгүй тусламжийг түүний ар гэрт мөн адил олгоно.

20 дугаар зүйл.Цэцийн үйл ажиллагааны баталгаа

20.1.Цэц аливаа байгууллага, албан тушаалтнаас бие даасан байж, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлөөр хангагдана.

20.2.Аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн Цэцийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

20.3.Цэц тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Цэцийн тамгыг Цэцийн дарга барина.

20.4.Цэц өөрийн бэлгэдэлтэй, Цэцийн гишүүн өмсгөл, энгэрийн тэмдэгтэй байх бөгөөд эдгээрийн загвар, хэрэглэх журмыг Дэгээр зохицуулна.

20.5.Цэц, түүний гишүүний болон хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах, хуралдааны дэг сахиулах үүргийг төрийн тусгай хамгаалалтын байгууллага гүйцэтгэх бөгөөд холбогдох журмыг Тамгын газрын дарга, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга хамтран батална.

21 дүгээр зүйл.Цэцийн төсөв, санхүүгийн бие даасан байдал

21.1.Цэц бие даасан төсөвтэй байх бөгөөд төсөв нь үйл ажиллагаагаа явуулахад хангалттай хүрэлцэхүйц байна.

21.2.Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалин хөлсний хэмжээг Цэцийн даргын санал болгосноор Улсын Их Хурал тогтоож, батална.

21.3.Цэцийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.

21.4.Цэцийн төсвийг боловсруулж батлахад дараах журмыг баримтална:

21.4.1.Цэц өөрийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг төлөвлөн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх;

21.4.2.Цэц Хууль зүйн байнгын хороогоор хянасан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт тусгуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх;

21.4.3.Засгийн газар Цэцийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

21.4.4.Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Цэцийн санал, тайлбарыг сонсох, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх.

22 дугаар зүйл.Цэцийн байр

22.1.Цэц үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангасан өөрийн байртай байна.

22.2.Цэцийн байрны аюулгүй байдлыг төрийн тусгай хамгаалалтын байгууллага хариуцна.

ТАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

23 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг эсхүл бусад гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гарсан бол Тамгын газар энэ талаар баримтжуулж, эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

24 дүгээр зүйл.Дагаж мөрдөх журмын зохицуулалт

24.1.Энэ хууль батлагдахаас өмнө томилогдсон Цэцийн гишүүнд энэ хуулийн 5.1, 5.2, 6.6, 6.7-д заасан шаардлага хамаарахгүй.

25 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

25.1.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилго**

Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль /цаашид “Үндсэн хууль” гэх/ зөрчсөн талаарх иргэдийн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтийг Үндсэн хуулийн цэц хүлээн авах, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хууль тогтоомж

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /цаашид “Цэц” гэх/-д маргаан хянан шийдвэрлэх хууль тогтоомж нь Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны нарийвчилсан журмыг Цэцийн зөвлөгөөнөөс энэ хуульд нийцүүлэн баталсан Үндсэн хуулийн цэцийн дэг /цаашид “Дэг” гэх/-ээр зохицуулна.

3 дугаар зүйл.Нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“иргэн” гэж Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

3.1.2.“маргагч” гэж Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлүүлэхээр Цэцэд хандан өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан этгээдийг;

3.1.3.“маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа” гэж маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх, дахин хянан үзэх, эсхүл үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх ажиллагааг;

3.1.4.“маргаантай асуудал” гэж Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлыг;

3.1.5.“мэдээлэл” гэж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс иргэдийг төлөөлөн маргаантай асуудлаар энэ хуульд заасны дагуу Цэцэд хандсаныг;

3.1.6. “өргөдөл” гэж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг нь зөрчсөн, эсхүл зөрчих нь гарцаагүй гэж үзсэн тухайн иргэн эрх хамгаалах, сэргээх шүүхийн болон бусад арга замыг дуусгасны дараа энэ хуульд заасны дагуу Цэцэд хандсаныг;

3.1.7. “үндсэн эрх” гэж Үндсэн хуулийн Арван зургадугаар болон бусад зүйлд заасан үндсэн болон түүнтэй адилтгах эрх, эрх чөлөөг;

3.1.8. “үндсэн эрхийн маргаан” гэж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй өргөдөл гаргагчийн өөрийнх нь үндсэн эрхийг зөрчсөн эсэх маргааныг;

3.1.9. “хүсэлт” гэж Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Цэцэд хандах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас маргаантай асуудлаар өөрийн чиг үүргийн хүрээнд энэ хуульд заасны дагуу Цэцэд хандсаныг;

3.1.10. “хуралдаан” гэж Бага, Дунд, эсхүл Их суудлын хуралдаан /Цэцийн хуралдаан/-ыг.

4 дүгээр зүйл. Маргаан хянан шийдвэрлэх хүрээ

4.1. Цэц гагцхүү Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх бөгөөд бусад хууль зөрчсөн тухай өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авахгүй.

4.2. Цэц энэ хуульд өөрөөр заагаагүй бол хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, эсхүл бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой, Цэцийн харьяалалд хамаарах маргааныг хянан шийдвэрлэнэ.

4.3. Хүчингүй болсон хууль тогтоомж, бусад шийдвэр нь Үндсэн хуульд нийцээгүй байсан гэдгийг тогтоолгох ашиг сонирхол өргөдөл гаргагчид бий гэж үзвэл уул маргааныг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 4.2 хамаарахгүй.

5 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх хугацаа

5.1. Цэц энэ хуульд өөрөөр заагаагүй бол маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Хуралдааны бүрэлдэхүүн нь тухайн маргаан ээдрээ, төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор хоёр хүртэл удаа сунгаж болно. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

5.2. Дараах маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг даруй хангана:

5.2.1. онц болон дайны байдал зарласан, түүнчлэн цэрэг хөдөлгөх шийдвэртэй холбогдсон;

5.2.2. иргэний үндсэн эрх болон нийтийн ашиг сонирхолд ноцтой үр дагавар бий болох эрсдэлтэй, эсхүл ийм эрсдэл үүсэхээс сэргийлэх зайлшгүй шаардлага бий болсон.

5.3. Энэ хуулийн 5.2-т заасан тохиолдолд хэд хэдэн илтгэгч гишүүнийг томилж болно.

6. дугаар зүйл.Хугацаа тодорхойлох, тоолох

6.1.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хуанлийн жил, сар, гариг, хоног, ажлын өдөр, цаг, минутаар тодорхойлно.

6.2.Хугацааг тоолохдоо тогтоосон он, сар, өдрөөс, эсхүл уг хугацаа улиран өнгөрсөн буюу үйл явдал болж өнгөрсний дараах өдөр, цагаас эхлэн тоолно.

6.3.Тоолох хугацааны эцсийн өдөр ажлын бус өдөр байвал түүний дараагийн ажлын өдөр уг хугацаа дуусна.

6.4.Үүргийг гүйцэтгэх бол зохих журмаар тогтоосон тухайн байгууллагын ажлын өдөр дуусах эцсийн цагийн дотор гүйцэтгэнэ.

6.5.Баримт бичгийг тогтоосон хугацааны эцсийн өдрийн хорин дөрвөн цагийн дотор шуудан, харилцаа холбооны байгууллагад шилжүүлсэн бол түүнийг хугацаанд нь гүйцэтгэсэн гэж үзнэ.

6.6.Цаг хугацааг тоолохдоо хуанлийн жилийг арван хоёр сараар, хагас жилийг зургаан сараар, улирлыг гурван сараар, хоногийг хорин дөрвөн цагаар тоолно.

6.7.Хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно.

6.8.Жил, хагас жил, улирал, сараар тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах сарын мөн өдөр дуусах бөгөөд хугацаа дуусах сарын мөн өдөр байхгүй бол уг хугацаа тухайн сарын эцсийн өдөр дуусна.

6.9.Хуанлийн жил нь 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусна.

6.10.Долоо хоног, хоногоор тогтоосон хугацаа уг хугацаа дуусах өдрийн мөн цагт, гаригаар тогтоосон хугацаа тухайн товлосон гариг дуусах эцсийн цагт, цагаар тогтоосон хугацаа уг хугацаа дуусах цагийн мөн хоромд дуусна.

7 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх зардал

7.1.Цэцэд маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.2.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх зардалд дараах зүйлийг хамааруулна:

7.2.1.шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, Цэцийн шийдвэрээр гүйцэтгэсэн ажил үндсэн чиг үүрэгт нь хамаарахгүй бол ажлын хөлс;

7.2.2.гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;

7.2.3.хөгжлийн бэрхшээлтэй оролцогчийг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах зардал;

7.2.4.шаардлагатай бусад ажиллагааг гүйцэтгэсний зардал.

7.3.Маргаан хянан шийдвэрлэх зардлыг дараах журмаар тодорхойлно:

7.3.1. шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж байгаа албан томилолтын зардлын хэмжээгээр;

7.3.2. шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг жишиг үнэлгээг харгалзан тогтоосон хэмжээгээр;

7.3.3. мэдүүлэг өгөхөөр Цэцэд дуудагдсан хугацаанд гэрч цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар;

7.3.4. хөгжлийн бэрхшээлтэй оролцогчийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахад шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласны төлбөрөөр;

7.3.5. бусад зардлыг зохих журмын дагуу.

7.4. Энэ хуулийн 7.2-т заасан зардлыг тооцож олгох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

8 дугаар зүйл. Хараат бус байх

8.1. Цэцийн гишүүн аливаа байгууллага, албан тушаалтан, иргэнээс хараат бус байж, гагцхүү Үндсэн хуульд захирагдан маргааныг хянан шийдвэрлэнэ.

8.2. Байгууллага, албан тушаалтан, иргэн, хэн боловч Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт, дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

8.3. Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тал үл харах бөгөөд Цэцэд хянан шийдвэрлэж байгаа маргаан эсхүл ойрын ирээдүйд Цэцийн шийдвэрлэвэл зохих асуудлын талаар саналаа нийтэд урьдчилан илэрхийлэх, зөвлөгөө өгөхийг хориглоно.

8.4. Судалгаа, сургалт, эсхүл мэргэжлийн зорилгоор Үндсэн хуулийн эрх зүйн маргаантай нийтлэг асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх нь энэ хуулийн 8.3-т заасан хориглолтод хамаарахгүй.

9 дүгээр зүйл. Хамтын зарчим

9.1. Цэц нь аливаа асуудал, маргааныг хамтын зарчмаар хэлэлцэж, хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

9.2. Цэцийн гишүүн асуудал, маргааныг хянан шийдвэрлэхэд санал өгөхөөс татгалзах, хуралдаанд оролцох болон бусад албан үүргээ хэрэгжүүлэхээс зайлсхийхийг хориглоно.

10 дугаар зүйл. Ил тод байх

10.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Цэц маргааныг ил тодоор хянан шийдвэрлэж, шийдвэрээ нийтэд мэдээлнэ.

10.2. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол аман хуралдааныг нээлттэй явуулна.

10.3. Төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэл /цаашид “хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээлэл” гэх/, эсхүл хүний аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатай тухай маргааны оролцогч эсхүл хуралдааны бүрэлдэхүүний гишүүний саналыг бүрэлдэхүүн үндэслэлтэй гэж үзвэл хуралдааныг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаалттай явуулна.

10.4. Хаалттай хуралдааны явцад илэрхий болсон, түүнчлэн албаны чиг үүргийн хүрээнд мэдсэн хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээллийг Цэцийн гишүүн, хуралдаанд оролцогч, Цэцийн Тамгын газрын албан хаагч, бусад этгээд задруулахыг хориглох бөгөөд шаардлагатай тохиолдолд хуулийн дагуу нууцын баталгаа гаргуулан авна. Бүрэлдэхүүн хаалттай хуралдаанд оролцохыг тодорхой этгээдэд зөвшөөрч болно.

10.5. Хуульд өөрөөр заагаагүй бол аман хуралдааны явцыг дууны болон дуу-дүрсний бичлэгээр зохих журмын дагуу баталгаажуулж, архивт хадгална.

10.6. Цэцийн шийдвэр, нээлттэй хуралдааны тэмдэглэлийг маргааны оролцогч, бусад этгээд өөрийн зардлаар хувилан авах эрхтэй.

11 дүгээр зүйл. Тэгш эрхийг хангах

11.1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсрол, эсхүл бусад шинжээр нь ялгаварлаж үл болох бөгөөд эрх тэгш байх зарчмыг баримтална.

11.2. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхэд Цэц дэмжлэг үзүүлнэ.

12 дугаар зүйл. Цэц өөрөө нотлох

12.1. Цэц маргааныг Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн гүйцэд, бодитой хянан шийдвэрлэхэд шаардлагатай ажиллагааг явуулж, ач холбогдол бүхий баримтыг цуглуулах, үнэлэх үүрэгтэй.

12.2. Цэц маргааныг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтыг хүн, албан тушаалтан, байгууллагаас гаргаж өгөхийг шаардах эрхтэй ба холбогдох этгээд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

12.3. Маргааны үндсэн оролцогч нь маргаан хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой, үнэн, хуульд заасан арга, хэрэгслээр олж авсан баримтыг Цэцэд гаргаж өгнө.

12.4. Цэц шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон үйл баримтыг үндэслэн шийдвэр гаргаж болно.

13 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх хэл, бичиг

13.1.Цэц маргааныг монгол хэлээр хянан шийдвэрлэж, төрийн албан ёсны бичгээр хөтөлж баталгаажуулна.

13.2.Маргааны оролцогч монгол хэл мэдэхгүй бол өөрийн эх хэл буюу мэддэг хэл, бичгээр, хэрэв хөгжлийн бэрхшээлтэйн улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан тайлбар, баримт гаргаж өгөх эрхтэй.

13.3.Цэцийн хуралдаанд энэ хуулийн 13.2-т заасан этгээдээс гаргасан тайлбар, баримтыг тухайн бүрэлдэхүүн болон маргааны бусад оролцогчид, түүнчлэн тухайн этгээдэд хуралдааны явц, бусад тайлбар, баримтыг зохих харилцааны хэрэгсэл, эсхүл орчуулагч, хэлмэрчээр дамжуулан танилцуулах бөгөөд холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

14 дүгээр зүйл.Хуралдааныг биечлэн явуулах

14.1.Цэцийн хуралдааныг хуулиар тогтоосон журмын дагуу томилсон бүрэлдэхүүн эхнээс нь дуусах хүртэл биечлэн явуулна.

14.2.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй бол түүний оронд Цэцийн өөр гишүүнийг томилж, хуралдааныг эхнээс нь явуулах бөгөөд холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

15 дугаар зүйл.Хуралдааныг тасралтгүй явуулах

15.1 Цэцийн хуралдааныг амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

15.2.Хуралдаанаар маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол бүрэлдэхүүн уг нөхцөл байдал арилах хүртэл боломжит хугацаагаар хуралдааныг хойшлуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЦЭЦЭД ХАНДАХ ХЭЛБЭР, ХУГАЦАА, ТАВИХ ШААРДЛАГА

16 дугаар зүйл.Цэцэд хандах хэлбэр

16.1. Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг бичгээр, эсхүл цахимаар Цэцэд гаргана.

16.2. Иргэн эрх хамгаалах, сэргээх шүүхийн болон бусад арга замыг дуусгасны дараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй өөрийнх нь үндсэн эрхийг зөрчсөн хэвээр гэж үзэж байгаа бол Цэцэд өргөдөл гаргана.

16.3.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар дараах этгээд иргэдийг төлөөлөн Цэцэд мэдээлэл гаргана:

16.3.1.иргэнээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20.1-т заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан асуудал

иргэний үндсэн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй бол түүнийг тогтоолгохоор Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн;

16.3.2.иргэн Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчигдсөн талаар тухайн чиглэлийн төрийн бус байгууллагад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хандсан нь үндэслэлтэй бол тухайн байгууллага.

16.4.Энэ хуулийн 16.3.2-д заасан төрийн бус байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

16.4.1.мэдээллийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх;

16.4.2.дүрмийн зорилгын дагуу сүүлийн таваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх.

16.5.Иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл зарим буюу бүрэн бус чадамжтай, түүнчлэн эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан иргэний үндсэн эрхийг зөрчсөн талаарх өргөдлийг түүний хууль ёсны төлөөлөгч Цэцэд гаргаж болно.

16.6.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд энэ хуульд заасны дагуу хүсэлт гаргана:

16.6.1.Ерөнхийлөгч;

16.6.2.Ерөнхий сайд;

16.6.3.Улсын Их Хурлын гишүүн;

16.6.4.Улсын дээд шүүх;

16.6.5.Улсын ерөнхий прокурор.

16.7.Хууль тогтоомжоос бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргахдаа уг шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан, тухайн шийдвэрийг хүчингүй болгох эрх бүхий этгээд, шүүхэд хандаж шийдвэр, хариу авсан байна.

16.8.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан маргаантай асуудлаар Цэцэд мэдээлэл гаргахдаа тухайн албан тушаалтныг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандаж шийдвэр, хариу авсан байна.

16.9.Энэ хуулийн 16.7-д заасан этгээдэд хандах нь тухайн иргэний эрх, эрх чөлөөнд залруулах боломжгүй ноцтой үр дагавар бий болгохоор бол өргөдлийг Цэцэд шууд гаргаж болно.

17.дугаар зүйл.Цэцэд хандах хугацаа

17.1.Үндсэн эрхийг нь зөрчсөн гэж үзэж байгаа иргэн дараах хугацаанд өргөдөл гаргана:

17.1.1.хууль тогтоомж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн дотор;

17.1.2.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-т заасан хууль тогтоомжоос бусад шийдвэр гарсан өдрөөс хойш нэг жилийн дотор;

17.1.3.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан сонгуулийн төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш хоёр сарын дотор;

17.1.4.шүүхийн шийдвэр эсхүл эрх зүйн бусад актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор.

17.2.Шүүхийн шийдвэрт эсхүл эрх зүйн бусад актад хэрэглэсэн хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцээгүй тухай өргөдлийг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 17.1.1-д заасан хугацаа хамаарахгүй.

17.3.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтад заасан асуудлаар дараах хугацаанд мэдээлэл гаргана:

17.3.1.Энэ зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.3-т заасан асуудлаар тухайн хугацаанд;

17.3.2.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан албан тушаалтан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй гаргаснаас хойш нэг жилийн дотор;

17.3.3.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасан асуудлаар тухайн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд.

17.4.Хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар хэдийд ч хүсэлт гаргаж болно.

17.5.Энэ хуулийн 17.4-т зааснаас бусад маргаантай асуудлаар хүсэлт гаргах үндэслэл бий болсон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүсэлт гаргаж болно.

17.6.Энэ хуульд заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн бол маргагч хугацаа сэргээлгэх саналаа холбогдох баримтын хамт Цэцэд гаргаж болно. Хугацааг сэргээх журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

18 дугаар зүйл.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавих шаардлага

18.1.Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд дараах зүйлийг тусгана:

18.1.1.өргөдөл, мэдээлэл гаргагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, байгууллага бол түүний нэр, оршин байгаа хаяг, эсхүл хүсэлт гаргагчийн нэр, албан тушаал, хаяг;

18.1.2.өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчийн утасны дугаар, цахим хаяг;

18.1.3.Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, эрх зүйн акт, түүний заалт, эсхүл Үндсэн хууль зөрчсөн, эсхүл огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй хэмээн үзэж байгаа албан тушаалтны нэр, шийдвэр,

үйлдэл, эс үйлдэхүйн талаарх мэдээлэл;

18.1.4.зөрчигдсэн гэж үзэж байгаа Үндсэн хуулийн зүйл, заалт, түүний үндэслэл, нотолгоо;

18.1.5.Цэцээр шийдвэрлүүлэх маргааны шаардлага;

18.1.6.өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагчийн цахим эсхүл ердийн гарын үсэг, огноо.

18.2.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд дараах зүйлийг хавсаргана:

18.2.1.маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр дамжуулан оролцох бол бүрэн эрхийн хүрээг тодорхойлж, төлөөлөх эрх олгосон баримт бичиг, эсхүл итгэмжлэл;

18.2.2.маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр төлөөлүүлж байгаа бол төлөөлөх эрх олгож, бүрэн эрхийн хүрээг тодорхойлсон баримт бичиг;

18.2.3.Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, эрх зүйн акт, түүний заалтын хуулбар, эсхүл Үндсэн хууль зөрчсөн, огцруулах, эгүүлэн татах үндэслэл болсон үйлдэл, эс үйлдэхүйн нотолгоо;

18.2.4.монгол хэлээс өөр хэл дээрх баримт бичгийн албан ёсны орчуулга.

18.3.Энэ хуулийн 18.1, 18.2-т зааснаас гадна өргөдөлд үндсэн эрхийг зөрчсөн талаар эрх бүхий этгээд, шүүхэд хандаж эцэслэн шийдвэрлүүлсэн боловч зөрчил арилаагүй гэж үзсэн үндэслэл, эсхүл шүүхийн харьяалалд хамаарахгүй шийдвэрийн талаар Цэцэд шууд хандаж байгаа тайлбараа тусган, холбогдох шийдвэр, баримтыг хавсаргана.

18.4.Энэ хуулийн 18.1, 18.2-т зааснаас гадна мэдээлэлд нийтийн ашиг сонирхлыг төлөөлж Цэцэд хандсан зорилго, хүрэх боломжтой үр нөлөөг тусган, энэ хуулийн 16.4-т заасан эрх бүхий этгээд болохыг нотолсон баримт бичгийн хуулбарыг хавсаргана.

19 дүгээр зүйл.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах

19.1.Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ хүлээн авна.

19.2.Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг энэ хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Цэц урьд нь тухайн асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг нягтлан үзэж, тухайн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд ирүүлснээс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагчид өгнө. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

19.3.Ерөнхий бүртгэгч дараах тохиолдолд өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг маргагчид буцаана:

19.3.1.энэ хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

19.3.2.Цэцээс урьд өмнө нь хариу өгсөн асуудлаар дахин өргөдөл, мэдээлэл гаргасан бөгөөд түүнийг дахин нягтлан үзэх үндэслэлгүй бол.

19.4.Ерөнхий бүртгэгчээс өгсөн хариуг маргагч эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд дахин ирүүлж болно.

19.5.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг энэ хуульд заасан шаардлага хангаж, эсхүл түүнийг энэ хуулийн 16.9, 19.4-т заасны дагуу гаргасан бол Ерөнхий бүртгэгч ажлын таван өдрийн дотор Цэцийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарь, Дэгд заасны дагуу Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж, хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэнэ.

19.6.Цэцэд хандах эрхээ урвуулан ашиглаж, эсхүл хариу өгсөн, шийдвэр гарсан асуудлаар удаа дараа хандаж, Цэцийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

20 дугаар зүйл.Цахим бүртгэл хөтлөх

20.1.Тамгын газар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, цахим сан үүсгэнэ.

20.2.Цэцийн шийдвэрийн хуулбар, эсхүл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах баримт бичгийг маргааны оролцогчдод цахимаар хүргүүлнэ.

20.3.Маргааны оролцогч Цэцийн шийдвэр, холбогдох баримт бичгийг бичгээр авах хүсэлт гаргасан, эсхүл цахим үйлчилгээ үзүүлэх боломжгүй тохиолдолд маргааны оролцогчид шийдвэр, баримт бичгийг шуудангаар хүргүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МАРГААНЫ ОРОЛЦОГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

21 дүгээр зүйл.Маргааны оролцогч

21.1.Маргагч болон өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд Үндсэн хууль зөрчсөн гэж тусгасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхгүйг гаргасан байгууллага, албан тушаалтан нь үндсэн оролцогч байна.

21.2.Гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хуралдааны нарийн бичгийн дарга нь бусад оролцогчид хамаарна.

21.3.Төлөөлөгч, өмгөөлөгч нь маргааны бие даасан оролцогч бус, зөвхөн төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрх олгосон хүрээнд хамгаалж байгаа этгээд мөн.

22 дугаар зүйл.Үндсэн оролцогчийн эрх, үүрэг

22.1.Үндсэн оролцогч нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах эрх эдэлнэ:

22.1.1.маргаж байгаа асуудлаар байр сууриа илэрхийлж, тайлбар гаргах, баримт гаргаж өгөх, баримт гаргуулах санал гаргах;

22.1.2.энэ хуульд заасны дагуу гэрч оролцуулах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилуулах, Цэцийн хуралдааныг хойшлуулах тухай санал гаргах;

22.1.3.өргөдөл, мэдээлэл, хүсэлт, холбогдох тайлбар, цугларсан баримттай танилцах, хуулбарлан авах, тэмдэглэл хийх, хариу тайлбар өгөх;

22.1.4.маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой Цэцээс гаргасан шийдвэрийн талаар мэдэх, хуулбарлан авах;

22.1.5.биечлэн, эсхүл төлөөлөгчөөр дамжуулан хуульд заасны дагуу хуралдаанд оролцох, оролцогчоос асуулт асуух;

22.1.6.хуралдааны бүрэлдэхүүн, эсхүл бусад оролцогчоос хуульд заасан үндэслэлээр татгалзах санал гаргах;

22.1.7.өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах;

22.1.8.хуульд заасан бусад эрх.

22.2.Үндсэн оролцогч маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах үүрэг хүлээнэ:

22.2.1.Цэцээс товлосон цагт хүрэлцэн ирэх;

22.2.2.Цэцийн шаардсан баримтыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх;

22.2.3.Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлт, тайлбар нь бодит байдалд нийцсэн, үнэн байх;

22.2.4.маргаан хянан шийдвэрлэх явцад олж мэдсэн хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх;

22.2.5.хуралдааны дэг, журмыг сахих;

22.2.6.хуульд заасан бусад үүрэг.

22.3.Өргөдөл, хүсэлт гаргагч нь маргааныг Бага, Дунд суудлын хуралдаанд шилжүүлэхээс өмнө шаардлагаа ихэсгэх эсхүл багасгах, бүрэн эсхүл хэсэгчлэн татгалзаж болох бөгөөд энэ нь маргааныг дахин хянан шийдвэрлэх үндэслэл болохгүй.

22.4.Нийтийн ашиг сонирхлын үүднээс мэдээлэл гаргасан этгээд маргаан үүсгэснээс хойш шаардлагаасаа бүрэн, эсхүл хэсэгчлэн татгалзахыг хориглоно.

22.5.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэд хамтран оролцож байгаа бол Цэц тав хүртэл төлөөлөгчийг хуралдаанд оролцуулах ба төлөөлөгч нь үндсэн оролцогчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

22.6.Цэц үндсэн оролцогчид эрх, үүргийг нь танилцуулж, адил боломжоор хангана.

23 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх

23.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол маргааны үндсэн оролцогч хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн хуульчид итгэмжлэл олгох замаар төлөөлүүлж болно.

23.2.Улсын Их Хурал аль нэг гишүүнээрээ, Улсын Их Хурлын гишүүн өөрөө, эсхүл хуульчаар төлөөлүүлэн Цэцийн аман хуралдаанд оролцоно.

23.3.Засгийн газар, эсхүл Ерөнхий сайдыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл Ерөнхий сайдын итгэмжилсэн этгээд төлөөлнө.

23.4.Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор, эсхүл бусад байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу, эсхүл хуульчаар төлөөлүүлэн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

23.5.Хууль тогтоомж, бусад шийдвэр болон үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд, эсхүл түүний итгэмжилсэн хуульч маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлнө.

23.6.Байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд нь өөрийн албан тушаал, эрх хэмжээгээ нотлох баримт бичиг, бусад этгээд нь түүнд олгосон итгэмжлэлийг Цэцэд гаргаж өгнө.

23.7.Итгэмжлэл нь дараах шаардлагыг хангасан байна:

23.7.1.итгэмжлэлд төлөөлүүлэгч өөрийн нэр, регистерийн дугаар, утасны дугаарыг бичиж, гарын үсэг зурсан байх, байгууллагын итгэмжлэлд тухайн байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх;

23.7.2.олгосон огноог заах;

23.7.3.хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх;

23.7.4.ямар маргаанд хэрхэн оролцохыг тодорхой заах;

23.7.5.итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах.

23.8.Энэ хуулийн 23.7-д заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна.

23.9.Хугацаа заагаагүй итгэмжлэл нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа дуусах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

23.10.Маргааны оролцогч, эсхүл түүнийг итгэмжлэлээр төлөөлөгч маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

23.11.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажиллагааг хуулийн хүрээнд явуулж, төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийн хүрээнд энэ хуульд заасан маргааны оролцогчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

23.12.Дараах этгээд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцохыг хориглоно:

23.12.1.гэрчээр оролцсон этгээд;

23.12.2.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар, эсхүл ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор.

23.13.Төлөөлөл дараах үндэслэлээр дуусгавар болно:

23.13.1.төлөөлөгч итгэмжлэлээс татгалзсан;

23.13.2.төлөөлүүлэгч өөрийн олгосон итгэмжлэлийг хүчингүй болгосон;

23.13.3.хууль, эсхүл гэрээнд өөрөөр заагаагүй бол төлөөлүүлэгч нас барсан, эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон;

23.13.4.төлөөлүүлэгч байгууллага татан буугдсан.

23.14.Төлөөлүүлэгч итгэмжлэлээ хүчингүй болгох, төлөөлөгч итгэмжлэлээс татгалзах эрхтэй. Энэ тухай Цэцэд даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдэгдээгүйгээс гарах үр дагаврыг төлөөлүүлэгч хариуцна.

24 дүгээр зүйл.Өмгөөлөгч

24.1.Маргааны оролцогч маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авч болно. Өргөдөл, мэдээлэл гаргагч аман хуралдаанд өмгөөлөгч оролцуулах үүрэгтэй.

24.2.Маргаан хянан шийдвэрлэхэд оролцох өмгөөлөгчийн эрх нь хууль зүйн туслалцаа авч байгаа талтай байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно.

24.3.Өмгөөлөгч нь маргаан хянан шийдвэрлэхэд оролцохдоо дараах эрх эдэлнэ:

24.3.1.маргааны баримт, материалтай танилцах, тэмдэглэл хийх, шаардлагатай баримтыг өөрийн зардлаар хувилж, хуулбарлан авах;

24.3.2.маргаан хянан шийдвэрлэх явцад баримт гаргаж өгөх, маргаанд ач холбогдол бүхий баримт, бусад байдлыг шалгуулах, шинжээч томилуулах санал гаргах;

24.3.3.хуульд заасан үндэслэл байвал татгалзан гаргах санал гаргах;

24.3.4.аман хуралдаанд оролцож маргааны оролцогчид асуулт тавих, үйлчлүүлэгчийнхээ гаргаж байгаа тайлбарыг тодруулах, нэмэлт тайлбар хийх;

24.3.5.хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, холбогдох саналаа бичгээр гаргах;

24.3.6.хуульд заасан бусад эрх.

24.4.Өмгөөлөгч маргаан хянан шийдвэрлэхэд оролцохдоо дараах үүрэг хүлээнэ:

24.4.1.хууль зүйн туслалцаа авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцох;

24.4.2.Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон өмгөөлөгч, хуульчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

24.4.3.өмгөөллийн үйл ажиллагааны явцад олж мэдсэн хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх;

24.4.4.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх;

24.4.5.үйлчлүүлэгчийн хууль бус шаардлагаас татгалзах;

24.4.6.Цэцээс товлосон хугацаанд Цэцийн хуралдаанд хүрэлцэн ирэх;

24.4.7.хуульд заасан бусад эрх.

25 дугаар зүйл.Гэрч

25.1.Маргаан хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдал, үйл баримтыг мэдэж байгаа этгээдийг илтгэгч гишүүн эсхүл хуралдааны бүрэлдэхүүн гэрчээр оролцуулж болно.

25.2.Гэрч нь товлосон цагт хүрэлцэн ирж, маргаантай холбогдсон асуудлаар үнэн мэдүүлэх үүрэгтэй бөгөөд шаардлагатай тэмдэглэл, баримт бичиг, мэдээ сэлтийг ашиглаж болно.

25.3.Гэрч санаатайгаар худал мэдүүлэг өгсөн, мэдүүлэг өгөхөөс хууль бусаар зайлсхийсэн, татгалзсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар сануулж, Дэгд заасны дагуу баримтжуулна.

26 дугаар зүйл.Шинжээч

26.1.Үндсэн оролцогчийн саналаар, эсхүл өөрийн санаачилгаар илтгэгч гишүүн эсхүл хуралдааны бүрэлдэхүүн маргааныг хянан шийдвэрлэхэд тусгай мэргэшил, мэдлэг зайлшгүй шаардсан асуудлаар уг маргаанд ашиг сонирхлын зөрчилгүй этгээдийг шинжээчээр томилж, дүгнэлт гаргуулж болно.

26.2.Энэ хуулийн 26.1-т заасан шийдвэрт шинжээчийн дүгнэлт гаргуулах шаардлагатай асуудлыг тодорхойлон заана.

26.3.Шинжээч нь Цэцийн товлосон цагт хүрэлцэн ирэх, тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн, үндэслэл бүхий дүгнэлт гаргах үүрэгтэй.

26.4.Шинжээч санаатай худал дүгнэлт гаргах, дүгнэлт гаргахаас хууль бусаар зайлсхийсэн, татгалзсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар сануулж, Дэгд заасны дагуу баримтжуулна.

26.5.Мэргэшил, мэдлэг тохирохгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол шинжээч дүгнэлт гаргахаас татгалзаж болно.

26.6.Шинжээч дүгнэлт гаргахад шаардлагатай бол маргааны материалтай танилцах, нэмэлт баримт авах хүсэлтээ Цэцийн гишүүнд гаргах эрхтэй.

26.7.Шинжээч өөрийн хийсэн ажиллагаа, шинжилгээ, түүний үндсэн дээр хүрсэн дүгнэлтээ тодорхойлохын хамт Цэцийн гишүүнээс тавьсан асуултад нэг бүрчлэн үндэслэл бүхий тодорхой хариулт өгч дүгнэлтээ бичгээр үйлдэнэ.

26.8.Шинжээч Цэцийн гишүүний тавьсан асуултад тусгагдаагүй боловч маргааныг шийдвэрлэхэд зайлшгүй ач холбогдолтой байж болох нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар дүгнэлтдээ тусгаж болно.

26.9.Хэд хэдэн этгээдийг баг болгон шинжээчээр томилсон бол тэд санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж гарын үсгээ зурах бөгөөд харин аль нэг шинжээч санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусдаа гаргаж болно.

27 дугаар зүйл.Орчуулагч, хэлмэрч

27.1.Маргааны үндсэн оролцогч монгол хэл мэдэхгүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэйн улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол түүний саналын дагуу орчуулагч, хэлмэрчийг илтгэгч гишүүн эсхүл бүрэлдэхүүн томилж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.

27.2.Орчуулагч, хэлмэрч товлосон цагт хүрэлцэн ирж, өргөдөл, мэдээлэл, хүсэлт, тайлбар, мэдүүлэг, баримттай танилцах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Цэцийн шийдвэрийн агуулгыг үнэн зөв, бүрэн орчуулж, хэлмэрчлэх үүрэгтэй.

27.3.Орчуулагч, хэлмэрч нь тодруулах асуулт тавьж болно.

27.4.Маргааны оролцогч нь орчуулагч, хэлмэрчийн үүрэг давхар гүйцэтгэхийг хориглоно.

27.5.Орчуулагч, хэлмэрч санаатайгаар худал орчуулсан, хэлмэрчилсэн, орчуулга хийх, хэлмэрчлэхээс хууль бусаар татгалзсан, зайлсхийсэн тохиолдолд түүнд хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай сануулж, Дэгд заасны дагуу баримтжуулна.

28 дугаар зүйл.Хуралдааны нарийн бичгийн дарга

28.1.Цэцийн хуралдааны нарийн бичгийн дарга нь маргааны оролцогчдод маргаан хянан шийдвэрлэхэд оролцох эрх, үүргийг танилцуулан баталгаажуулах, хуралдаан явуулах нөхцөлийг хангах, маргааны оролцогчдод товыг мэдэгдэх, тэдний ирцийг бүртгэж, танилцуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнд гарын үсэг зурж, даргалагчаар баталгаажуулж маргааны материалд хавсаргах, шаардлагатай бусад ажиллагааг гүйцэтгэнэ.

29 дүгээр зүйл.Татгалзан гаргах үндэслэл, журам

29.1.Цэцийн гишүүн дараах үндэслэл байвал хуралдааны бүрэлдэхүүнд оролцохоос өөрөө татгалзан гарах үүрэгтэй:

29.1.1.тухайн маргааныг захиргааны байгууллага, шүүхээр хянан шийдвэрлэхэд албан үүргийн дагуу, эсхүл мэргэжлийн үүднээс оролцсон;

29.1.2.өөрөө, эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээд маргааны үндсэн оролцогч бол.

29.2.Үндсэн оролцогч энэ хуулийн 29.1-т заасан үндэслэлээр Цэцийн гишүүнийг татгалзан гаргах санал тавих эрхтэй бөгөөд саналаа бичгээр гаргаж, татгалзан гаргах үндэслэлийг тодорхой заана.

29.3.Цэцийн гишүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн хуралдааны бүрэлдэхүүн уг гишүүнийг байлцуулахгүйгээр шийдвэрлэх ба санал тэнцвэл татгалзан гаргаагүйд тооцно.

29.4.Маргааныг хянан шийдвэрлэхэд Цэцийн хоёроос дээш тооны гишүүн татгалзан гарах, гаргахыг хориглоно. Цэцийн гишүүн татгалзан гарснаар, эсхүл гаргаснаар хуралдааны бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болох тохиолдолд татгалзан гарах, эсхүл гаргахыг хориглох бөгөөд Цэцийн гишүүн энэ хуулийн 29.1-т заасан үндэслэл үүссэн эсэхээс үл хамааран чиг үүргээ хэрэгжүүлнэ.

29.5.Энэ хуулийн 29.1-т зааснаас бусад үндэслэлээр Цэцийн гишүүнийг татгалзаж үл болно.

29.6.Энэ хуулийн 29.1-т заасан эсхүл ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй бусад үндэслэл бий болсон бол орчуулагч, хэлмэрч, шинжээч, хуралдааны нарийн бичгийн дарга өөрөө татгалзан гарах үүрэгтэй бөгөөд тэдгээрийг татгалзан гаргах хүсэлтийг хуралдааны бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

29.7.Энэ хуулийн 29.1, 29.6-д заасан татгалзан гарах үндэслэл байвал Цэцийн гишүүн, орчуулагч, хэлмэрч, шинжээч, хуралдааны нарийн бичгийн дарга Цэцийн хуралдаан эхлэхээс өмнө тухайн хуралдаан даргалагчид бичгээр, эсхүл татгалзан гарах үндэслэл хуралдаан эхлэх хүртэл мэдэгдээгүй, хуралдааны явцад илэрсэн бол энэ тухайгаа мэдсэн даруй хуралдаан даргалагчид мэдэгдэж, татгалзан гарах үүрэгтэй.

29.8.Илтгэгч гишүүнийг татгалзан гаргасан бол нөхөн томилогдсон гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулах ба шаардлагатай гэж үзвэл зарим ажиллагааг дахин буюу шинээр явуулж болно.

29.9.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон илтгэгч гишүүнээс бусад гишүүнийг татгалзан гаргасан, эсхүл татгалзан гарсан бол өөр гишүүнийг нөхөн томилж, хуралдааныг шинээр эхлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хуралдааныг хойшлуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ**МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ****30 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх үндэслэл**

30.1. Цэц гагцхүү энэ хуульд заасан журмын дагуу гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг үндэслэн маргааныг хянан шийдвэрлэнэ.

30.2. Тусгай журам тогтоосноос бусад тохиолдолд маргааныг энэ хуульд заасан нийтлэг журмаар хянан шийдвэрлэнэ.

31 дүгээр зүйл. Өргөдөл, мэдээлэл, хүсэлт, маргааныг хуваарилах болон холбогдох бусад журам

31.1. Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилах хуваарийг Цэцийн зөвлөгөөнөөс жил бүрийн 12 дугаар сард батална. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

31.2. Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилах журам нь урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд дараах шаардлагыг хангасан программ хангамжийг ашиглана:

31.2.1. Цэц өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлыг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдэд шууд өгөх боломжтой байх;

31.2.2. цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү энэ хуульд заасны дагуу татгалзан гаргах, гарах хүсэлтийг үндэслэлтэй гэж үзсэн, эсхүл Цэцийн гишүүн, тухайн хуралдааны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.

31.3. Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан хуваарь, журмын дагуу өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох бөгөөд маргааныг Дунд суудалд хуваарилна.

31.4. Цэцийн дарга оролцсон Их суудлын хуралдаанаа даргална. Цэцийн дарга нь Их суудлын хуралдаанд ороогүй, эсхүл илтгэгч гишүүнээр уг хуралдааны бүрэлдэхүүнд орсон бол аль нэг гишүүн даргална.

32 дугаар зүйл. Хянан шийдвэрлэхэд бусад байгууллага дэмжлэг үзүүлэх

32.1. Бүх шатны шүүх, захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, холбогдох этгээд шаардлагатай баримт, мэдээллийг Цэцэд саадгүй гаргаж өгөх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд үйл ажиллагаа, эх сурвалжаараа дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

32.2.Бүх шатны шүүх, захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтны гаргаж өгсөн эх баримтыг тэдний бичгээр гаргасан саналын дагуу маргаан хянан шийдвэрлэж дууссаны дараа буцаан өгч болно. Эх баримтыг буцаан өгсөн тохиолдолд хуулбар болон зохих журмын дагуу бэхжүүлсэн хувилбарыг маргааны материалд хавсаргана.

33 дугаар зүйл.Цэцийн даалгаврыг биелүүлэх

33.1.Хуралдааны бүрэлдэхүүн маргааны оролцогч эсхүл бүрэлдэхүүний гишүүний саналаар маргааны талаар баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл тодорхой ажиллагаа гүйцэтгэхийг зохих шүүхэд даалгаж болно.

33.2.Энэ хуулийн 33.1-т заасан Цэцийн даалгаварт маргааны товч агуулга, явуулбал зохих ажиллагаа, бүрдүүлэх баримтыг зааж, даалгавар биелүүлэх хугацааг тогтоох бөгөөд энэ хугацаанд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

33.3.Даалгавар хүлээн авсан шүүх тогтоосон хугацаанд түүнийг биелүүлж, хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн баримтыг Цэцэд хүргүүлнэ.

34 дүгээр зүйл.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх

34.1.Дараах тохиолдолд Цэцийн хуралдааны бүрэлдэхүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ:

34.1.1.Цэц уялдаа холбоо бүхий өөр маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй;

34.1.2.маргааныг хянан шийдвэрлэхэд бусад шүүхээс гарах шийдвэр ач холбогдолтой бол тухайн шийдвэр гарах хүртэл хугацаагаар;

34.1.3.энэ хуулийн 33.2-т заасан ажиллагаа явуулж байгаа.

34.2.Энэ хуулийн 34.1-т зааснаас бусад үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

34.3.Түдгэлзүүлэх үндэслэл арилсан тохиолдолд хуралдааны бүрэлдэхүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

34.4.Маргааны оролцогч эсхүл бүрэлдэхүүний гишүүн энэ зүйлд заасны дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, эсхүл сэргээх тухай саналыг хуралдааны бүрэлдэхүүн гаргаж болно.

35 дугаар зүйл.Маргааныг хэрэгсэхгүй болгох

35.1.Цэцийн хуралдааны бүрэлдэхүүн дараах нөхцөлд маргааныг хэрэгсэхгүй болгоно:

35.1.1.өргөдөл гаргагч нас барсан бол;

35.1.2.Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан биш;

35.1.3.тухайн тодорхой асуудлаарх Цэцийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа;

35.1.4. өргөдөл, хүсэлт гаргагч маргааны шаардлагаасаа татгалзсан;

35.1.5. маргаан бүхий хууль тогтоомж, бусад шийдвэр хүчингүй болсон.

35.2. Маргаан үүсгэсэн асуудал нь нийтийн ашиг сонирхолд хамааралтай гэж үзвэл энэ хуулийн 35.1.1, 35.1.4, 35.1.5-д заасан нөхцөл үүссэн эсэх, маргагч байгаа эсхээс үл хамааран маргааныг үргэлжлүүлэн хянан шийдвэрлэж болно.

36 дугаар зүйл. Аман хуралдааны тэмдэглэл

36.1. Аман хуралдааны явцыг нэг бүрчлэн бичиж тэмдэглэнэ.

36.2. Аман хуралдааны тэмдэглэлд дараах зүйлийг тусгах бөгөөд мэдээллийн технологийн хэрэгсэл ашиглаж болно:

36.2.1. тэмдэглэлийн нэр, хуралдаан болсон огноо, газар, байр, хуралдаан эхэлсэн, дууссан цаг, минут;

36.2.2. хуралдаан даргалагч, хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүд, нарийн бичгийн даргын нэр;

36.2.3. хэлэлцэх маргааны агуулга;

36.2.4. маргааны оролцогчийн нэр, ажил, албан тушаал, холбогдох бусад мэдээлэл;

36.2.5. маргааны оролцогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан шаардлага, тайлбар, түүний хариу болон бусад тайлбар, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тэдгээрийн санал, хүсэлт, асуулт, хариулт болон хуралдааны бусад явц бүрэн хэмжээгээр;

36.2.6. хуралдааны явцад гарсан асуудлыг шийдвэрлэсэн аман магадлал, түүнчлэн шийдвэрийн агуулга;

36.2.7. Дэгд заасан бусад зүйл.

36.3. Аман хуралдааны тэмдэглэлд тухайн хуралдааны явцад гадаад хэлээр өгсөн тайлбар, мэдүүлэг, бусад мэдээллийн хувьд орчуулагчийн яриаг бичгээр буулгаж, төрөлх хэлээр ярьсан хэсгийг давхар тусгахгүй. Маргаан хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой бол гадаад хэлээр гаргасан тайлбар, мэдүүлгийг Цэцийн хуралдааны тэмдэглэлд хавсаргаж болно.

36.4. Аман хуралдааны тэмдэглэлийг хуралдаан дууссан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор бичгээр үйлдэж, хуралдаан даргалагч болон нарийн бичгийн даргын гарын үсэг зурж баталгаажуулан маргааны материалд хавсаргана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

МАРГААН ХЯНан шийдвэрлэх зохион байгуулалт, хуралдааны хэлбэр

37 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт

37.1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Бага, Дунд, Их суудлаар зохион байгуулна. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

37.2.Бага суудал гурав, Дунд суудал зургаа, Их суудал нийт гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар энэ хуульд заасны дагуу маргааныг хянан шийдвэрлэнэ.

38 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх хуралдааны хэлбэр

38.1.Хуралдаан нь аман эсхүл зөвлөлдөх хэлбэртэй байна.

38.2.Маргааныг аман хуралдаанаар хянан шийдвэрлэхэд үндсэн оролцогч, шаардлагатай тохиолдолд бусад оролцогчийг хуралдаанд оролцуулан, хуралдааны бүрэлдэхүүн оролцогчдоос асуулт асууж, хариулт авах, тайлбарыг сонсох, гэрч болон бусад оролцогчийн мэдүүлэг, дүгнэлттэй танилцах, баримтыг шинжлэн судлах зэргээр хуралдааны танхимд маргааныг хэлэлцэнэ.

38.3.Маргааныг зөвлөлдөх хуралдаанаар хянан шийдвэрлэхэд маргааны оролцогчийг хуралдаанд оролцуулахгүй, хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэх явцад цугларсан тайлбар, баримтад үндэслэн зөвлөлдөх тасалгаанд маргааныг хэлэлцэнэ.

38.4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол маргааныг зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

38.5.Хуралдааны бүрэлдэхүүн дараах тохиолдолд аман хуралдаан явуулахаар шийдвэрлэж болно:

38.5.1.үндсэн оролцогчийн тайлбарыг биечлэн сонсох, гэрч эсхүл бусад оролцогчийн мэдүүлэг, дүгнэлттэй хуралдаан дээр танилцах, тодруулга авах нь маргааныг бүрэн гүйцэд, бодитой шийдвэрлэхэд шаардлагатай;

38.5.2.маргаан нь Үндсэн хуулийг тайлбарлахад зарчмын ач холбогдолтой, хуралдаанаас гарах шийдвэр нийтэд нөлөөтэй.

38.6.Хуралдааныг маргааны оролцогч, эсхүл Цэцийн гишүүний саналыг үндэслэн цахимаар явуулж, эсхүл зайлшгүй тохиолдолд бүрэлдэхүүний зарим гишүүн, маргааны тодорхой оролцогчийг хуралдаанд цахимаар оролцуулж болно.

39 дүгээр зүйл.Бага суудлын хуралдаан

39.1.Цэц өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсхүл хүсэлтийн дагуу маргаан үүсгэх эсэхийг Бага суудлын хуралдаанаар шийдвэрлэнэ.

39.2.Бага суудлын хуралдаан зөвлөлдөх хэлбэртэй байна.

39.3.Бага суудлын бүрэлдэхүүн Цэцэд маргаан үүсгэх эсэх эсхүл энэ хуульд заасан бусад асуудлыг олонхын саналаар шийдвэрлэж, магадлал гаргана.

39.4.Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах хугацааг сэргээлгэх саналыг Бага суудлын хуралдаанаар түүнийг Цэцэд ирүүлснээс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

40 дүгээр зүйл.Бага суудлын хуралдаанд бэлтгэх

40.1.Энэ хуулийн 19.5-д заасны дагуу өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг

гардуулснаас хойш долоо хоногийн дараа 30 хоногийн дотор Бага суудлын хуралдааныг хийнэ. Бага суудлын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд уул хугацааг 30 хоногоор нэг удаа сунгаж болно.

40.2.Бага суудлын хуралдаан даргалагч нь бүрэлдэхүүний бусад гишүүнтэй зөвшилцөн хуралдааныг товлож, захирамж гаргана.

40.3.Өргөдөл, мэдээлэл, хүсэлт нь Цэцэд хянан шийдвэрлэж байгаа өөр маргаантай уялдаа холбоотой, эсхүл нэмж судлах шаардлагатай гэж үзвэл Бага суудал хуралдааныг хойшлуулна.

41 дүгээр зүйл.Маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэх

41.1.Бага суудлын бүрэлдэхүүн доор дурдсан үндэслэл байвал маргаан үүсгэхээс татгалзаж магадлал гаргана:

41.1.1.Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудал биш;

41.1.2.өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах эрх бүхий этгээд биш, эсхүл түүнийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гаргасан;

41.1.3.эрх зүйн бүрэн чадамжгүй хүн өргөдөл гаргасан, эсхүл түүнийг төлөөлөх этгээд байхгүй;

41.1.4.өргөдөл, мэдээлэл, хүсэлт нь энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй;

41.1.5.энэ хуульд заасан хугацаа өнгөрсөн;

41.1.6.хуульд заасан урьдчилан шийдвэрлүүлэх журмыг зөрчсөн;

41.1.7.Цэцийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа;

41.1.8.Үндсэн хуулийн эрх зүйн маргааны шинжийг агуулаагүй;

41.1.9.Үндсэн хуулийн суурь ач холбогдолгүй;

41.1.10.өргөдөл, мэдээлэл гаргагч маргааны шаардлагаасаа татгалзсан.

41.2.Энэ хуулийн 41.1-т заасан үндэслэлийг магадлалд товч заах бөгөөд магадлал нь маргаан үүсгэх эсэх талаарх эцсийн шийдвэр болно.

41.3.Маргаан үүсгэснээс хойш ажлын таван өдрийн дотор энэ тухай цахим хуудас болон бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

41.4.Маргаан үүсгэсэн тохиолдолд энэ хуулийн 31.2-т заасан журмын дагуу илтгэгч гишүүнийг томилно.

42 дугаар зүйл.Дунд суудлын хуралдаан

42.1.Хуульд өөрөөр заагаагүй бол маргаан үүсгэж шалгасан маргаантай асуудлыг Дунд суудлын хуралдаанаар олонхын саналаар шийдвэрлэж, дүгнэлт гаргана.

42.2. Дунд суудлын бүрэлдэхүүн энэ хуулийн 42.1-т зааснаас бусад асуудлыг зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэж, магадлал гаргана.

43 дугаар зүйл. Маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл

43.1. Илтгэгч гишүүн маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангаж, шаардлагатай бол дараах ажиллагааг явуулна:

43.1.1. холбогдох байгууллага, албан тушаалтан, бусад этгээдээс маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой тайлбар, лавлагаа, бусад баримтыг гаргуулах;

43.1.2. гэрчээр дуудах;

43.1.3. шинжээч томилон дүгнэлт гаргуулах;

43.1.4. маргаан үүсгэсэн магадлалыг үндсэн оролцогчдод танилцуулах, маргаанд холбогдуулан тайлбар, нэмэлт тодруулга авах;

43.1.5. маргаантай адил агуулга бүхий өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нэгтгэн шалгах, нэг хуралдаанаар шийдвэрлэх боломжгүй шаардлагыг тусгаарлах санал гаргах;

43.1.6. энэ хуулийн 34.1-т заасан үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээх санал гаргах;

43.1.7. энэ хуулийн 35.1-т заасан үндэслэлээр маргааныг хэрэгсэхгүй болгох санал гаргах;

43.1.8. энэ хуульд заасан үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх хугацааг сунгуулах санал гаргах;

43.1.9. хуульд заасан бусад ажиллагаа явуулах.

43.2. Энэ хуулийн 43.1.5, 43.1.6, 43.1.7, 43.1.8-т заасан илтгэгч гишүүний саналыг бүрэлдэхүүн зөвлөлдөх хуралдаанаар шийдвэрлэнэ.

43.3. Маргааны үндсэн оролцогч энэ хуулийн 43.1-т заасан ажиллагаа явуулах саналыг илтгэгч гишүүнд гаргах эрхтэй. Илтгэгч гишүүн уул саналаас татгалзсан тохиолдолд маргааны үндсэн оролцогчийн гомдлоор хуралдааны бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

43.4. Маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангагдсан бол илтгэгч гишүүн хуралдааны бүрэлдэхүүнтэй зөвшилцөн хуралдааны товыг тогтооно. Бүрэлдэхүүний шийдвэрт хуралдаан болох газар, огноо, цаг, хуралдаан нээлттэй, эсхүл хаалттай хийх болон зөвлөлдөх, эсхүл аман хэлбэрээр явуулахыг тодорхойлно.

43.5. Илтгэгч гишүүн цугларсан баримтыг хуралдаан болохоос 21-ээс доошгүй хоногийн өмнө хуралдааны бүрэлдэхүүнд хуулбарлан тараана. Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн маргааны материалтай танилцах эрхтэй.

43.6.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн энэ хуулийн 43.5-д заасны дагуу баримтыг хүлээн авснаас хойш ажлын арван өдрийн дотор нэмэлт ажиллагаа хийлгэх санал гаргаж болох бөгөөд тухайн бүрэлдэхүүн уг саналыг хүлээн авсан бол энэ хуульд заасны дагуу хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэх хугацааг сунгана.

43.7.Аман хуралдаан болохоос арваас доошгүй ажлын өдрийн өмнө хуралдаан болох газар, огноо, цагийг маргааны оролцогчдод мэдэгдэж, Цэцийн цахим хуудас болон бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

43.8.Энэ хуулийн 5.2-т заасан тохиолдолд аман хуралдаан болохоос таваас доошгүй ажлын өдрийн өмнө энэ хуулийн 43.7-т заасны дагуу мэдэгдэж, мэдээлнэ.

44 дүгээр зүйл. Аман хуралдааны дараалал

44.1.Цэцийн аман хуралдааныг Монгол Улсын төрийн сүлд, далбааг байрлуулсан, хэлэлцүүлэг хийх шаардлага хангасан танхимд явуулна.

44.2.Хуралдааны танхимд байгаа хүн бүр Цэц болон оролцогчдод хүндэтгэлтэй хандах, хуралдааны дэгийг сахих, хуралдаан даргалагч /цаашид “даргалагч” гэх/-д захирагдах үүрэгтэй.

44.3.Даргалагч хуралдааныг нээх бөгөөд оролцогчдын ирцийн талаар хуралдааны нарийн бичгийн даргаас тодруулж, хэлэлцэх маргааны агуулгыг зарлан мэдэгдэнэ.

44.4.Даргалагч маргааны оролцогчдоос эрх, үүрэгтэй танилцсан эсэхийг тодруулж, хүлээх хариуцлагыг тайлбарлана.

44.5.Даргалагч тухайн хуралдааны бүрэлдэхүүнийг зарлан, бусад оролцогчийг танилцуулж, тэдгээрийг татгалзан гаргах эрхтэй болохыг үндсэн оролцогч нарт тайлбарлана.

44.6.Даргалагч хуралдааны танхимд баримтлах журмыг танилцуулж, хуралдааны дэгийг сахих, даргалагчид захирагдах үүрэгтэйг маргааны оролцогчид болон танхимд байгаа бусад хүнд сануулна.

44.7.Илтгэгч гишүүн илтгэлээ танилцуулах бөгөөд илтгэлд өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн агуулга, хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэх явцад явуулсан ажиллагааны талаар товч мэдээлнэ.

44.8.Хуралдааны аль ч үе шатанд тухайн бүрэлдэхүүнд орсон Цэцийн гишүүн маргааны оролцогчдоос асуулт асууж, хариулт авах эрхтэй.

44.9.Маргааны үндсэн оролцогч Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт, тайлбар гаргасан дарааллыг баримтлан, маргааны зүйлийн талаарх өөрийн байр суурь, түүний эрх зүйн болон бусад үндэслэлийг тайлбарлана.

44.10.Маргааны үндсэн оролцогч гагцхүү хэлэлцэж байгаа маргаантай холбоотой асуудлаар тайлбар хийж, асуулт асууна.

44.11.Шинжээч хуралдаанд оролцож байгаа бол дүгнэлтийг өөрөө уншиж сонсоно.

44.12.Шинжээчээс тухайн хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүд болон маргааны оролцогч дүгнэлттэй нь холбогдуулан асуулт асууж болох бөгөөд шинжээч хариулах үүрэгтэй.

44.13.Гэрчийг хуралдаанд мэдүүлэг өгөхөөс өмнө хуралдааны танхимаас тусгаарлана.

44.14.Гэрч нь тухайн хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн болон маргааны оролцогчийн асуултад үнэн хариулах үүрэгтэй.

44.15.Хэргийн баримтад авагдсан, маргааныг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, бичгийн болон бусад нотлох баримтыг Цэцийн хуралдаанаар шинжлэн судална.

44.16.Хуралдааны төгсгөлд үндсэн оролцогч Цэцэд хандан үг хэлж болох бөгөөд хуралдаанаар шинжлээгүй баримт бичиг, бусад баримтыг иш татахгүй.

44.17.аргалагч маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, маргааныг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шийдвэрлэх, оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, эрх тэгш байх зарчмыг хангах, хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй.

44.18.Цэцийн хуралдааны аюулгүй байдлыг хангах, даргалагчийн даалгаснаар хуралдааны дэг сахиулах үүргийг төрийн тусгай хамгаалалтын албан хаагч гүйцэтгэнэ. Энэ талаарх журмыг Цэцийн тамгын газрын дарга Төрийн тусгай хамгаалалтын газрын даргатай хамтран батална.

44.19.Аман хуралдаан явуулах нарийвчилсан журмыг Дэгээр зохицуулна.

45 дугаар зүйл. Аман хуралдаанд хүрэлцэн ирээгүйн үр дагавар

45.1.Аман хуралдааны товыг маргааны оролцогчдод албан ёсоор мэдэгдсэн боловч хуралдаанд хүрэлцэн ирээгүй нь энэ хуулийн 45.2-т зааснаас бусад тохиолдолд хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

45.2.Маргааны оролцогч хүндэтгэн үзэх шалтгаанаар аман хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бөгөөд хуралдаанд биечлэн оролцох хүсэлтээ хуралдаан болохоос хоёроос доошгүй ажлын өдрийн өмнө бичгээр мэдэгдсэн бол бүрэлдэхүүн хуралдааныг хойшлуулж болно.

45.3.Энэ хуулийн 45.2-т заасан үндэслэлээр хоёр ба түүнээс дээш удаа хүсэлт гаргасан нь маргааныг хянан шийдвэрлэхэд санаатай саад учруулахаар байна гэж тухайн бүрэлдэхүүн үзвэл хуралдааныг хойшлуулахгүй.

45.4.Гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүй тохиолдолд хуралдааныг үргэлжлүүлэх эсэхийг хуралдааны бүрэлдэхүүн хэлэлцэн шийдвэрлэнэ.

45.5.Орчуулагч, хэлмэрч хүрэлцэн ирээгүй нь хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

46 дугаар зүйл.Зөвлөлдөх хуралдаан

46.1.Зөвлөлдөх хуралдааныг энэ хуулийн 50, 51 дүгээр зүйлд заасны дагуу явуулна.

47 дугаар зүйл.Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулах

47.1.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлыг хянан шийдвэрлэж гаргасан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулна.

47.2.Маргаантай асуудлыг хянан шийдвэрлэж Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлт гаргаснаар тухайн хууль, бусад шийдвэр, тэдгээрийн холбогдох зүйл, хэсэг, заалтын үйлчлэлийг Цэцийн эцсийн шийдвэр гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд түдгэлзүүлсэн зохицуулалтын үйлчлэлийг сэргээхийг хориглоно.

47.3.Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл Улсын Их Хурлын чуулганы чөлөөт цагт дүгнэлт гарсан бол Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор хуульд заасан журмын дагуу хэлэлцэж, тогтоол гаргана.

47.4.Онц болон дайны байдал зарласан, цэрэг хөдөлгөх шийдвэртэй холбогдсон асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хойшлуулшгүй хэлэлцэх бөгөөд үүнд энэ зүйлийн 47.3-т заасан хугацаа хамаарахгүй.

48 дугаар зүйл.Их суудлын хуралдаан

48.1.Их суудлын хуралдаанаар дараах маргааныг хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэнэ:

48.1.1.Улсын Их Хурал энэ хуулийн 47.3, 47.4-т заасан хугацаанд Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл уул хугацаанд зохих шийдвэр гаргаагүй бол;

48.1.2.Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль, бусад шийдвэрийн заалтыг шууд, эсхүл агуулгаар нь дахин сэргээсэн эсэх асуудлаар гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн дагуу Бага суудлын хуралдаан маргаан үүсгэсэн бол;

48.1.3.Үндсэн хуулийн тодорхой зүйл, заалтын талаарх Цэцийн эрх зүйн байр суурийг өөрчлөх, шинээр тогтоох шаардлага үүссэн гэж Дунд суудлын хуралдаанд оролцсон гишүүдийн гурваас доошгүй нь үзсэн;

48.1.4.энэ хуулийн 59.1, 60.3-т заасан маргаан.

48.2.Их суудал Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан маргаантай асуудлыг аман хуралдаанаар олонхын саналаар шийдвэрлэнэ.

48.3.Их суудлын хуралдааныг Цэцийн нийт гишүүний бүрэлдэхүүнтэй хийх бөгөөд хуульд заасан үндэслэлээр татгалзсан, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар оролцох боломжгүй болсон бол Их суудлын хуралдааныг долоогоос доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй явуулж болно.

49 дүгээр зүйл.Маргааныг эцэслэн шийдвэрлэх

49.1.Энэ хуулийн 48.1-т заасан үндэслэл бүрдсэн бол Их суудлын хуралдааны товыг тогтооно.

49.2.Маргааныг Их суудлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэх, хэлэлцэхэд энэ хуульд заасан Дунд суудлын хуралдааны нийтлэг журмыг баримтална.

49.3.Их суудлын хуралдаан энэ хуулийн 48.1.1-т заасан үндэслэлээр маргааныг дахин хянан үзэж, эцсийн шийдвэр гаргана.

49.4.Их суудлын хуралдаанаас Үндсэн хууль зөрчсөн тухай шийдвэр гаргавал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй Улсын Их Хурлын шийдвэрийг хүчингүй болох, эсхүл Үндсэн хууль зөрчөөгүй тухай шийдвэр гаргавал Цэцийн дүгнэлтийг хүчингүй болгоно.

49.5.Их суудлын хуралдаанаар энэ хуулийн 48.1.2, 48.1.4-т заасан маргааныг хэлэлцэж, олонхын саналаар эцэслэн шийдвэрлэнэ.

49.6.Их суудлын хуралдаанаар энэ хуулийн 48.1.3-т заасан маргааныг хэлэлцэж, олонхын саналаар дүгнэлт гаргаж, энэ хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд оруулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ЦЭЦИЙН ШИЙДВЭР ГАРГАХ, ТҮҮНИЙГ МЭДЭЭЛЭХ

50 дугаар зүйл.Зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэх

50.1.Аман, эсхүл зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэж байгаа маргааны талаарх шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд зөвхөн тухайн бүрэлдэхүүний гишүүд зөвлөлдөн гаргах бөгөөд маргааны оролцогч, бусад этгээдийг байлцуулахгүй.

50.2.Зөвлөлдөх хуралдааныг даргалагч удирдан явуулах бөгөөд бүрэлдэхүүн, маргааны гол агуулгыг танилцуулж хуралдааныг нээнэ.

50.3.Хэлэлцэх асуудлын агуулга, үг хэлэх болон асуулт асуух дараалал, санал хураалтын дүнгийн талаарх зөрүүтэй саналыг тухайн хуралдааны бүрэлдэхүүн олонхын саналаар шийдвэрлэнэ.

50.4.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүд асуудал шийдвэрлэхэд тэгш эрх эдэлнэ.

50.5.Бүрэлдэхүүнд орсон гишүүн илтгэгч гишүүнээс зөвлөлдөх хуралдааны аль ч үе шатанд асуулт асууж, хариулт авч болно.

50.6.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн зөвлөлдөж байгаа асуудлаар саналаа заавал өгөх үүрэгтэй ба саналыг илээр хураана.

50.7.Цэцэд хамгийн цөөн жил ажилласан гишүүнээс эхлэн хамгийн олон жил ажилласан гишүүн хүртэлх дарааллаар саналаа хэлэх бөгөөд ажилласан жил тэнцүү бол хамгийн залуу гишүүн нь эхлэн саналаа хэлнэ. Даргалагч саналаа хамгийн сүүлд хэлнэ.

50.8.Цэцийн гишүүд санал хэлж дууссаны дараа даргалагч шийдвэрийн талаарх саналыг нэгтгэн томъёолж санал хураалтыг дараах журмаар явуулна:

50.8.1.Эхний санал хураалтын дараа цөөнх саналын үндэслэлээ гарган дахин үг хэлж болно. Шаардлагатай бол олонх болсон гишүүн хариу хэлж болно;

50.8.2.Цэцийн гишүүд саналаа харилцан хэлж дууссаны дараа даргалагч хоёр дахь санал хураалт явуулна. Энэ санал хураалтаар өмнөх саналын томъёоллыг өөрчлөхгүйгээр санал хураалтыг явуулах бөгөөд олонхын санал дэмжигдвэл шийдвэр гаргана;

50.8.3.Хоёр дахь санал хураалтаар өмнөх цөөнх олонх болбол Цэцийн гишүүд дахин үг хэлж саналын үндэслэлээ тайлбарласны дараа гурав дахь санал хураалт явуулж гишүүдийн олонхын дэмжлэг авсан саналаар шийдвэр гаргана.

50.9.Санал хураалт дууссаны дараа Цэцийн шийдвэрийн тогтоох хэсгийн гол агуулгын төслийг илтгэгч гишүүн болон бүрэлдэхүүний бусад гишүүн зөвлөлдөх тасалгаанд хамтран бичиж, гарын үсэг зурна.

50.10.Зөвлөлдөх тасалгаанд Цэцийн гишүүний хэлсэн үг, тайлбар, үндэслэл, гаргасан санал нь нууц байна. Зөвлөлдөх хуралдааны нууцыг бусдад мэдээлэх, задруулах, тараахыг хориглоно.

50.11.Маргааныг Цэцийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн бол шийдвэрийн тогтоох хэсгийн гол агуулгыг маргааны оролцогчдод бүрэлдэхүүний тогтоосон хугацаанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

51 дүгээр зүйл.Цэцийн шийдвэрийн үндэслэлийг хэлэлцэн тогтоох

51.1.Цэцийн шийдвэрийн үндэслэх болон бусад хэсгийн төслийг хуралдааны бүрэлдэхүүний олонхоор дэмжсэн саналд үндэслэн хуралдаан болсноос хойш 14 хоногийн дотор илтгэгч гишүүн эсхүл бүрэлдэхүүний томилсон өөр гишүүн бичиж хуралдааны бүрэлдэхүүнд танилцуулна. Бүрэлдэхүүний бусад гишүүн саналаа бичиж, танилцуулах эрхтэй.

51.2.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн бүр энэ хуулийн 51.1-т заасан төсөлд холбогдуулан саналаа бичгээр өгөх үүрэгтэй.

51.3.Энэ хуулийн 51.1-т заасан төслийг танилцуулснаас хойш 14 хоногийн дотор Цэцийн шийдвэрийн үндэслэх болон бусад хэсгийг Зөвлөлдөх хуралдаанаар эцэслэн хэлэлцэнэ.

51.4.Энэ хуулийн 51.1-т заасан төсөлтэй танилцсан гишүүдийн талаас доошгүй нь Цэцийн шийдвэрийн үндэслэх болон бусад хэсгийн төслийг дахин боловсруулах, нэмэлт судалгаа хийх, эсхүл үндэслэлд зарчмын өөрчлөлт оруулах санал гаргасан бол Зөвлөлдөх хуралдааныг 14 хүртэл хоногоор хойшлуулж болно.

51.5.Зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцсэн агуулгын дагуу илтгэгч гишүүн эсхүл бүрэлдэхүүний томилсон өөр гишүүн Цэцийн шийдвэрийг бусад гишүүнийг оролцуулан боловсруулж, Цэцийн шийдвэрийн үндэслэлийг эцэслэн бичиж, хуралдааны бүрэлдэхүүн ёсчилно.

51.6.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүдийн олонхын саналаар Цэцийн шийдвэрийн үндэслэх болон бусад хэсгийн агуулгыг тодорхойлно.

51.7.Цэцийн шийдвэрийн үндэслэх, тогтоох хэсэгтэй санал бүрэн, эсхүл хэсэгчлэн нийлээгүй гишүүн энэ тухай тусгай саналаа бичгээр гаргах, нийтлэх эрхтэй. Цэцийн гишүүн тусгай санал бичих тухайгаа бүрэлдэхүүний бусад гишүүнд Цэцийн шийдвэрийг ёсчлохоос өмнө аль болох эрт мэдэгдэнэ. Тусгай саналыг маргааны материалд хавсаргана.

51.8.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн бүр Цэцийн шийдвэрт гарын үсэг зурах үүрэгтэй.

51.9.Цэцийн шийдвэр, түүний үндэслэл гаргахаар зөвлөлдөх болон шийдвэрийг ёсчлох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

52 дугаар зүйл.Цэцийн шийдвэрийн бүтэц

52.1.Цэцийн дүгнэлт нь доор дурдсан агуулгатай удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ:

52.1.1.удиртгал хэсэгт Цэцийн шийдвэрийн нэр, дугаар, огноо, хуралдаан хийсэн газар, хуралдааны бүрэлдэхүүн, маргааны оролцогчийн нэр, хэлэлцсэн маргааны агуулгыг тусгана;

52.1.2.тодорхойлох хэсэгт маргаан үүсгэсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн товч утга, маргааны оролцогчдын тайлбар, шаардлагатай бусад мэдээлэл, баримтын гол агуулгыг тусгана;

52.1.3.үндэслэх хэсэгт маргааныг хянан шийдвэрлэхэд үндэслэл болсон Үндсэн хуулийн зүйл, заалтыг зааж, түүний утгыг тайлбарлаж зөрчсөн эсэх үндэслэлийг бичих бөгөөд хууль зүйн болон бусад баримт, мэдээллийн учир холбогдлыг тодорхойлно;

52.1.4.тогтоох хэсэгт дүгнэлтийн удирдлага болсон хуулийн нэр, түүний зүйл, заалт, маргааныг хянан шийдвэрлэж гаргасан шийдвэрийг хоёрдмол утгагүй, тодорхой заана. Үндсэн хууль зөрчсөн тухай шийдвэр гаргасан бол хууль, бусад шийдвэрийн зүйл, заалтыг түдгэлзүүлж эхлэх хугацааг заавал тусгана.

52.2.Цэцийн тогтоол нь дор дурдсан агуулгатай удиртгал, тодорхойлох, хянах, тогтоох хэсгээс бүрдэнэ:

52.2.1.удиртгал хэсэгт энэ хуулийн 52.1.1-т зааснаас гадна Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай Улсын Их Хурлын шийдвэрийн нэр, дугаар, эцэслэн хэлэлцсэн маргааны товч агуулгыг тусгана;

52.2.2.тодорхойлох хэсэгт энэ хуулийн 52.1.2-т зааснаас гадна Цэцийн дүгнэлт болон түүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай Улсын Их Хурлын шийдвэрийн агуулга, үндэслэлийг тусгана;

52.2.3.хянах хэсэгт Цэцийн дүгнэлт болон түүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэлтэй, эсхүл үндэслэлгүй гэж үзсэн талаарх үндэслэл, түүнчлэн шаардлагатай бол маргааныг эцэслэн шийдвэрлэхэд үндэслэл болсон Үндсэн хуулийн зүйл, заалтыг зааж, түүний утгыг тайлбарлаж зөрчсөн эсэх үндэслэлийг бичих бөгөөд хууль зүйн болон бусад баримт, мэдээллийн учир холбогдлыг тодорхойлно;

52.2.4.тогтоох хэсэгт тогтоолын удирдлага болсон хуулийн нэр, түүний зүйл, заалт, Цэцийн дүгнэлтийн талаарх Улсын Их Хурлын шийдвэр эсхүл бусад шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох эсэх талаар гаргасан шийдвэрийг хоёрдмол утгагүй зааж, хүчингүй болгох хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр бүхлээрээ буюу тэдгээрийн зөрчилтэй зүйл, хэсэг, заалтыг тодорхой тусгана.

52.3.Цэцийн шийдвэрт үг, үсэг, тооны зэрэг илэрхий алдаа гарсан бол тухайн шийдвэрийг гаргасан хуралдааны бүрэлдэхүүн залруулга хийж болно.

52.4.Бага суудлын хуралдаанаас гаргах магадлал нь энэ хуулийн 52.1-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд үндэслэх хэсэгт маргаан үүсгэх эсэх талаарх үндэслэлийг товч тусгана.

52.5.Маргааныг хэлэлцээд хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэвэл хуралдаанаас магадлал гаргах бөгөөд уг магадлалын бүтэц нь энэ хуулийн 52.1-т заасан шаардлагыг хангасан байна.

52.6.Маргааныг хянан шийдвэрлэх явцад хуралдаанаас гаргасан магадлал нь тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэх бөгөөд шийдвэрлэсэн асуудлын хүрээнд агуулгыг тодорхойлно.

53 дугаар зүйл.Цэцийн шийдвэрийг заавал биелүүлэх, нийтэд мэдээлэх, хүргүүлэх, нийтлэх

53.1.Цэцийн шийдвэр гармагцаа эсхүл хуралдааны бүрэлдэхүүн шийдсэн тохиолдолд цахим хуудаст нийтэлснээр хүчин төгөлдөр болно.

53.2.Цэцийн шийдвэрийг нийт байгууллага, албан тушаалтан, иргэн, хэн боловч заавал биелүүлэх үүрэгтэй.

53.3.Хуралдаан дууссанаас хойш хоёр сарын дотор Цэцийн шийдвэрийг эцэслэн ёсчилно.

53.4.Шаардлагатай гэж хуралдааны бүрэлдэхүүн үзсэн тохиолдолд Цэцийн шийдвэрийг нийтэд танилцуулах өдрийг товлож, шийдвэрийн агуулгыг Тамгын газар нийтэд мэдээлнэ.

53.5.Олон нийтийг мэдээллээр хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тайлбарлах зорилгоор Цэцийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлнэ.

53.6.Цэцийн шийдвэрийг ёсчилсноос хойш ажлын таван өдрийн дотор маргааны оролцогч болон Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

53.7.Цэцийн дүгнэлт, тогтоолыг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.

53.8.Жил бүрийн нэгдүгээр сард багтаан өмнөх жилд маргаан хянан шийдвэрлэсэн дүгнэлт, тогтоолыг бүрэн эхээр нь Цэцийн шийдвэрийн эмхэтгэлд нийтэлнэ. Цэцийн гишүүн шаардлагатай гэж үзвэл тусгай саналаа тогтоол, дүгнэлтийн хамт Цэцийн шийдвэрийн эмхэтгэлд нийтлүүлнэ.

53.9.Цэцийн дүгнэлт, тогтоол, тусгай саналд дурдсан маргааны оролцогч, түүний төлөөлөгч, эсхүл бусад этгээдийг тодорхойлсон мэдээллийг дараах тохиолдолд нийтлэхгүй:

53.9.1.хуульд тусгайлан заасан бол;

53.9.2.тухайн этгээдийн ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай.

53.10.Цэцийн шийдвэрийг ёсчилсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор Цэцийн дүгнэлт, тогтоол, тусгай саналыг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулж, нийтэлнэ.

53.11.Энэ хуулийн 52.5, 55.1-т заасан магадлалыг энэ зүйлд заасны дагуу нийтэд мэдээлж, хүргүүлж, Төрийн мэдээлэл болон Цэцийн шийдвэрийн эмхэтгэлд нийтлэх бөгөөд цахим хуудаст байршуулна.

54 дүгээр зүйл.Цэцийн шийдвэрийн үр дагавар

54.1.Маргааныг эцэслэн шийдвэрлэсэн Цэцийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр болсноор Үндсэн хууль зөрчсөн хууль, бусад шийдвэр, түүний холбогдох зүйл, хэсэг, заалт хүчингүй болох бөгөөд хүчингүй болгох хугацааг тухайлан заана.

54.2.Хууль зүй, эдийн засаг, зохион байгуулалтын үр дагаврыг харгалзан хууль тогтоомж, бусад шийдвэр, түүний холбогдох зүйл, заалтыг хүчингүй болгох хугацааг шийдвэр гарснаас хойш байхаар тогтоох, эсхүл Цэцийн шийдвэрийг биелүүлэх арга, журмыг Цэцийн шийдвэрт тусган тодорхойлж болно.

54.3.Цэц захиргааны актын үндэслэл болж буй хууль, эсхүл түүний заалтыг хүчингүй болгосон бол тухайн захиргааны акт, эсхүл түүний заалт нэгэн адил хүчингүй болно.

54.4.Хууль, бусад шийдвэр, тэдгээрийн холбогдох зүйл, хэсэг, заалт Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн шийдвэр гарснаар нийгмийн харилцаа зохицуулалтгүй орхигдохоор бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн нийгмийн харилцааг Үндсэн хууль, Цэцийн шийдвэрт нийцүүлэн өөрчлөх буюу шинээр зохицуулах шийдвэр гаргах үүрэгтэй бөгөөд Цэц шийдвэртээ хугацааг зааж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд үүрэг хүлээлгэж болно.

54.5.Үндсэн хуульд нийцээгүй хууль, бусад шийдвэр, тэдгээрийн холбогдох зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон нь тэдгээрийн улмаас учирсан хохирол болон бусад үр дагаврын асуудлыг шийдвэрлэх шууд үндэслэл болохгүй.

54.6.Гагцхүү Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл тогтоогдсон бол Цэцийн шийдвэрийг баримтлан хэргийг зохих хууль тогтоомжийн дагуу дахин хянаж болно.

54.7.Үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэж Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн шийдвэр гаргасан бол энэ хуулийн 54.6-д заасны хүрээнд холбогдох эрхээ сэргээн эдлэх үндэслэл болох бөгөөд иргэний үндсэн эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйгээ Үндсэн хуульд нийцүүлж, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг биелүүлнэ.

55 дугаар зүйл.Түр түдгэлзүүлэх тухай магадлал

55.1.Дунд эсхүл Их суудлын хуралдааны бүрэлдэхүүн маргаан хянан шийдвэрлэх явцад нийтийн ашиг сонирхолд ноцтой хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдалд заналхийлж буй хүчирхийллээс хамгаалах, эсхүл үндсэн эрхээ эдэлснийх нь төлөө иргэнийг яллах ажиллагааг зогсоохын тулд нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай бол маргаан бүхий хууль, бусад шийдвэрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр түдгэлзүүлэх тухай магадлал гаргаж болно.

55.2.Цэц хууль, бусад шийдвэрийн үйлчлэлийг түр түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ аман хуралдаан хийж болно. Нэн яаралтай тохиолдолд Цэц маргааны үндсэн оролцогчид, эсхүл бусад эрх бүхий этгээдээс тайлбар авахгүйгээр энэ магадлалыг гаргаж болно.

55.3.Түр түдгэлзүүлэх тухай магадлал гаргасан шийдвэрээ үндэслэл дурдахгүйгээр олон нийтэд мэдээлнэ. Энэ тохиолдолд магадлалын үндэслэлийг тусад нь маргааны үндсэн оролцогчид заавал хүргүүлнэ.

55.4.Түр түдгэлзүүлэх тухай магадлал нь зургаан сарын хугацаанд хүчинтэй байх бөгөөд уг магадлалыг хуралдааны бүрэлдэхүүний гишүүдийн дийлэнх олонхын саналаар дахин гаргаж болно.

55.5.Нэн яаралтай тохиолдолд Дунд, эсхүл Их суудлын ирц хүрэхгүй бол Цэцийн гурван гишүүн санал нэгтгэйгээр гаргасан магадлалаар хууль, бусад шийдвэрийг түр түдгэлзүүлэхээр шийдвэрлэж болно. Ийнхүү гаргасан магадлал нэг сарын хугацаанд хүчинтэй байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ЖУРАМ

56 дугаар зүйл. Хууль, бусад шийдвэрт холбогдох маргаантай асуудал

56.1.Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхий сайд энэ хуульд заасны дагуу хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шийдвэрлүүлэх хүсэлтийг Цэцэд гаргаж болно.

56.2.Улсын Их Хурлын гишүүн, эсхүл Ерөнхийлөгч нь энэ хуульд заасны дагуу Монгол Улсын соёрхон батлах, эсхүл нэгдэн орох олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцсэн эсэх хүсэлтийг тийнхүү соёрхон батлах, эсхүл нэгдэн орох тухай хууль гарахаас өмнө Цэцэд гаргаж болно.

56.3.Энэ зүйлд заасан маргааны үндсэн оролцогч зөвшөөрсөн бол Цэц тухайн маргаантай асуудлыг Зөвлөлдөх хуралдаанаар хянан шийдвэрлэж болно.

56.4.Энэ зүйлд заасан хүсэлтээр үүссэн маргаантай асуудлыг хянан шийдвэрлэхдээ тухайн асуудлаар тайлбар гаргах боломжийг Улсын Их Хурал, Засгийн газарт олгоно.

56.5.Улсын Их Хурал, Засгийн газар нь маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд оролцож болно.

56.6.Дунд суудлын хуралдаан энэ зүйлд заасан хүсэлтийн дагуу маргаантай асуудлыг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтийг Улсын Их Хуралд энэ хуулийн 47 дугаар зүйлд заасан журмын дагуу оруулж, 48 дугаар зүйлд заасан тохиолдолд тухайн маргаантай асуудлыг дахин хянан үзэж, эцсийн шийдвэр гаргана.

57 дугаар зүйл.Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр үүссэн маргаантай асуудал

57.1.Шүүх нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, саналаа Улсын дээд шүүхийн холбогдох танхимд гаргах бөгөөд тухайн танхимын нийт шүүгчийн гуравны нэгээс доошгүй нь энэ саналыг үндэслэлтэй гэж үзвэл Цэцэд хүсэлт гаргана.

57.2.Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаан нь хэрэг, маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, уг хуулийн талаарх хүсэлт Цэцэд гаргана.

57.3.Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 73.2-т заасны дагуу Цэцэд хүсэлт гаргуулах саналаа Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Цэцэд хүсэлтийг гаргана.

57.4.Энэ хуулийн 57.1, 57.2-т заасны дагуу Цэцэд хүсэлт гаргаагүй бол тухайн эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцсон яллагчийн саналаар Улсын ерөнхий прокурор тухайн хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх хүсэлтийг Цэцэд гаргаж болно.

57.5.Энэ хуулийн 57.1, 57.2, 57.4-т заасан санал, хүсэлт нь тухайн хэргийн үйл баримтад уг хуулийг хэрэглэснээр Үндсэн хууль зөрчигдөнө гэж үзсэн үндэслэлийг тодорхой тусгана.

57.6.Энэ хуулийн 57.1, 57.2, 57.3, 57.4-т заасан хүсэлтийг энэ хуулийн 56.3, 56.4, 56.5, 56.6-д заасны дагуу хянан шийдвэрлэнэ.

57.7.Маргааны оролцогч иргэн хуулийн заалтыг үндсэн эрх зөрчсөн гэж үзэн Цэцэд өргөдөл гаргасан эсэхээс үл хамааран Улсын дээд шүүхийн танхим, эсхүл Улсын ерөнхий прокурор нь тухайн заалтын талаарх хүсэлтийг энэ зүйлд заасны дагуу гаргаж болно.

57.8.Цэц нь Улсын дээд шүүхийн холбогдох танхим, эсхүл санал гаргасан шүүхийн явуулж байгаа хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид тайлбар гаргах боломж олгоно.

57.9.Шүүхийн хянан шийдвэрлэж байгаа хэрэг, маргааны аль нэг тал нь энэ хуулийн 57.1-т заасан санал, хүсэлтийг гаргах талаар тухайн шүүхэд, энэ хуулийн 57.2-т заасан хүсэлтийг гаргах талаар хяналтын шатны шүүх хуралдааны бүрэлдэхүүнд тус тус хандах эрхтэй.

58 дугаар зүйл.Албан тушаалтанд холбогдох маргаантай асуудал

58.1.Улсын Их Хурлын гишүүн дараах маргаантай асуудлаар Цэцэд хүсэлт гаргаж болно:

58.1.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй Үндсэн хууль зөрчсөн эсэх;

58.1.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд Үндсэн хууль эсхүл бусад хууль зөрчсөн нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл болох эсэх.

58.2.Энэ хуулийн 58.1-т заасан хүсэлтэд Үндсэн хууль зөрчсөн, огцруулах, эсхүл эгүүлэн татах талаарх үндэслэл, нотолгоог тусгана.

58.3.Цэцийн аман хуралдаанд энэ хуулийн 58.1-т заасан албан тушаалтныг оролцуулна. Тухайн албан тушаалтан хуралдаанд өөрийн биеэр оролцох боломжгүй талаар санал гаргавал Цэц төлөөлөгч оролцуулахыг даалгах, эсхүл хуралдааныг хойшлуулах шийдвэрийг гаргаж болно.

58.4.Цэц энэ хуулийн 58.1-т заасан хүсэлтээр үүсгэсэн маргааныг хянан шийдвэрлэж Үндсэн хууль зөрчсөн эсэх, эсхүл огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх тухай дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.

58.5.Цэц дүгнэлтдээ дараах асуудлын үндэслэлийг тодорхой бичнэ:

58.5.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор нь шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйгээрээ Үндсэн хууль зөрчсөн эсэх;

58.5.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд Үндсэн хууль эсхүл бусад хууль зөрчсөн нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл болох эсэх.

59 дүгээр зүйл.Үндсэн эрхийн маргаан

59.1.Үндсэн эрхийн маргааныг Их суудлын хуралдаанаар хянан шийдвэрлэнэ. Энэ хуулийн 38.5-д зааснаас бусад тохиолдолд хуралдаан нь зөвлөлдөх хэлбэртэй байна.

59.2.Цэц нь холбогдох этгээд тодорхой хугацааны дотор өргөдөлтэй холбогдуулан тайлбар гаргах боломж олгоно.

59.3.Өргөдөл нь хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг хөндөж байгаа бол Улсын Их Хурал, Засгийн газарт тайлбар гаргах боломж олгоно.

59.4.Өргөдөл нь шүүхийн шийдвэрт хэрэглэсэн хууль Үндсэн хуульд нийцээгүй, эсхүл хуулийг хэрэглэхдээ үндсэн эрхийг хязгаарласан, буруу тайлбарласан тухай бол тухайн шийдвэр өөрийнх нь талд гарсан этгээдэд тайлбар гаргах боломж олгоно.

59.5.Үндсэн эрхийн маргааныг аман хуралдаанаар шийдвэрлэхээр бол энэ хуулийн 59.3, 59.4-т заасан этгээд хуралдаанд оролцож болно.

59.6.Цэц өргөдлийг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тухайн шийдвэртээ хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны ямар шийдвэр, эрх зүйн акт, үйлдэл, эс үйлдэхүй нь Үндсэн хуулийн аль заалтаар хамгаалагдсан үндсэн эрхийг зөрчсөн тухай үндэслэлийг тодорхой заана. Үндсэн хууль зөрчсөн хэмээн шийдвэрлэсэн шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйг давтан гаргасан тохиолдол бүр нь Үндсэн хуулийн зөрчил болно хэмээн Цэц шийдвэртээ зааж болно.

59.7.Шийдвэр Үндсэн хууль зөрчсөн талаар гаргасан өргөдлийг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол Цэц хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны уг шийдвэрийг хүчингүй болгох ба уг асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэн дахин шийдвэрлүүлэхээр харьяалах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ. Шүүхийн шийдвэрийн үйчлэлийг түдгэлзүүлэн Үндсэн хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т зааснаар Улсын дээд шүүхэд шилжүүлнэ.

59.8.Энэ зүйлийн 59.7-д заасан шийдвэрийг хүлээн авсан шүүх, эрх бүхий байгууллага, албан тушаалтан иргэний үндсэн эрхийг сэргээх, эсхүл хуулийн дагуу зүй ёсоор хэрэгжүүлэх, цаашид зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээ авч, холбогдох шийдвэрийг бүрэн эрхийнхээ хүрээнд гаргах үүрэгтэй.

59.9.Хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн талаар гаргасан өргөдлийг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тухайн хууль тогтоомжийг Цэц хүчингүй болгоно.

59.10.Хэрэв энэ хуулийн 59.7-д заасны дагуу хүчингүй болгосон шийдвэр нь Үндсэн хууль зөрчсөн хууль тогтоомжид үндэслэн гарсан бол тухайн хууль тогтоомжийг мөн адил хүчингүй болгоно.

60 дугаар зүйл. Сонгох, сонгогдох эрхийн маргаан

60.1.Сонгуулийн эрх бүхий иргэн дараах үндэслэл бүхий өргөдлийг дангаараа, эсхүл бусад иргэнтэй хамтран Цэцэд гаргаж болно:

60.1.1.сонгуулийн төв байгууллагын шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйн улмаас тухайн иргэний сонгох эрх нь зөрчигдсөн;

60.1.2.нэр дэвшигчийг бүртгэх, эсхүл намын нэрийн жагсаалтыг зөвшөөрөх эсэх зэрэг асуудлаарх сонгуулийн төв байгууллагын шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй тухайн иргэний сонгогдох эрхийг зөрчсөн.

60.2.Энэ хуулийн 60.1-т заасан өргөдөл нь тойрогт явуулсан сонгуультай холбоотой бол зөвхөн тухайн тойргийн сонгогч өргөдөл гаргах эрхтэй.

60.3.Энэ хуулийн 60.1-т заасан өргөдлөөр маргаан үүсгэснээс хойш дөрвөн сарын дотор Их суудлын хуралдаанаар хянан шийдвэрлэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

60.3.1.энэ хуулийн 60.1.1-т заасан маргааныг хэлэлцэхэд сонгох эрх зөрчигдсөн нь тогтоогдсон бөгөөд энэ нь сонгуулийн дүн, суудал хуваарилалтад нөлөөлсөн тохиолдолд тухайн сонгуулийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох;

60.3.2.энэ хуулийн 60.1.2-т заасан маргааныг хэлэлцэхэд сонгогдох эрх зөрчигдсөн нь тогтоогдсон бөгөөд энэ нь сонгуулийн дүн, суудал хуваарилалтад нөлөөлсөн тохиолдолд тухайн сонгуулийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох;

60.3.3.сонгох, эсхүл сонгогдох эрх зөрчигдсөнийг тогтоох;

60.3.4.маргааныг хэрэгсэхгүй болгох.

61 дүгээр зүйл.Ард нийтийн санал асуулга, сонгуульд холбогдох маргаантай асуудал

61.1.Улсын Их Хурлын гишүүн нь ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний, эсхүл Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх маргаантай асуудлаар Цэцэд хүсэлт гаргаж болно.

61.2.Энэ хуулийн 61.1-т заасан хүсэлтийг санал асуулга, эсхүл тухайн сонгуулийн дүнг танилцуулсан өдрөөс хойш хоёр сарын дотор гаргана.

61.3.Энэ хуулийн 61.1-т заасан хүсэлтийг дараах үндэслэлээр гаргана:

61.3.1.ард нийтийн санал асуулга, эсхүл сонгуулийг бэлтгэх, явуулах, дүнг гаргах явцад нийтээрээ, тэгш, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах Үндсэн хуулийн зарчмыг зөрчсөн нь Улсын Их Хурлын суудал хуваарилалт, Ерөнхийлөгчийн сонгуулийн, эсхүл ард нийтийн санал асуулгын дүнд нөлөөлсөн;

61.3.2.нэр дэвшигчийг, эсхүл намын нэрийн жагсаалтыг бүртгэхтэй холбогдсон сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн.

61.4.Дунд суудал аман хуралдаан хийх шаардлагагүй гэж үзвэл энэ хуулийн 61.1-т заасан маргаантай асуудлыг Зөвлөлдөх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

61.5.Цэц энэ хуулийн 61.1-т заасан хүсэлтээр маргаан үүсгэснээс хойш дөрвөн сарын дотор хянан шийдвэрлэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

61.5.1.энэ хуулийн 61.3.1-т заасан маргаантай асуудлыг хэлэлцээд сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөнийг тогтоох бөгөөд шаардлагатай тохиолдолд сонгуулийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох;

61.5.2.энэ хуулийн 61.3.2-т заасан маргаантай асуудлыг хэлэлцээд Үндсэн хуулийн зөрчлийг тогтоох бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын гишүүний суудал хуваарилалтыг зөвтгөх, эсхүл тухайн тойргийн сонгуулийг хүчингүй болгох;

61.5.3.маргаантай асуудлын хүрээнд Үндсэн хууль зөрчигдсөн гэдгийг тогтоох;

61.5.4.маргаантай асуудлыг хэрэгсэхгүй болгох.

61.6.Энэ хуулийн 61.1-т заасан хүсэлтийг энэ хуулийн 56.3, 56.6-т заасны дагуу хянан шийдвэрлэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

62 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

62.1.Цэцийн хуралдаанд оролцогч, эсхүл бусад этгээд хуралдааны дэгийг зөрчсөн, дэгийг сахих талаарх шийдвэрийг үл биелүүлсэн, эсхүл Цэцийг үл хүндэтгэсэн бол сануулах, тухайн хүнийг Цэцийн хуралдааны танхимаас албадан гаргах, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

62.2.Цэц, түүний гишүүнийг маргаан хянан шийдвэрлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт, дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг оролдсон, Цэцийн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, байгууллага, албан тушаалтан, бусад этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

62.3.Цэцэд хандах эрхээ урвуулан ашигласан, эсхүл хариу өгсөн, шийдвэр гаргасан асуудлаар удаа дараа хандаж хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

62.4.Шинжээч, гэрч санаатайгаар худал дүгнэлт гаргасан, мэдүүлэг өгсөн, мэдүүлэг өгөхөөс хууль бусаар зайлсхийсэн, татгалзсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

65 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

63.1.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг